

Херманн Шрайбер

АТТИЛА БА ХҮННҮЧҮҮД

ХҮННҮ ГҮРНИЙ 2220 ЖИЛИЙН ОЙД ЗОРИУЛАВ

„Түүх бол эхэндээ үлгэр байдаг. Баримт бол дээд талд нь усан дээр хөвж буй лугаа адил тогтож байдаг. Ус нь урсч үгүй болохоор баримт л үлддэг.“

ГӨТЭ 1811 он, Риймэр

Түүх, тууль хоёр шүргэлцэж буй тэр цэг түүх судлаачийн хувьд маш сонин байдаг. Энэ цэг олонхидоо судалгааны нөр их ажлын хамгийн сайхан зүйл нь байдаг.

ГӨТЭ

Өнгө будгийн сургаалийн түүх

Говь цөлийн газар төрж өсөөд эз хийгээд азын мөнхийн тойрогт эргэлдэж байдаг нүүдэлчин улс түмний хувь тавиланг урьдчилан тааварлах аргагүй агаад бодгалийн амьдралд тохиолддог элдэв адал явдалтай зүйрлүүштэй. Тэдний түүх бол нэлэнхүйдээ туульсийн зохиол мөн.

ТИЕРРИ

Аттилагийн хөвгүүд ба залгамжлагчид

АГУУЛГА

ӨМНӨХ ҮГ

I.НОМ : ИХ АЮУЛ

- 1.“Хэрэн давхилдах үй түмэн зэрлэг морьтнууд”
2. Бурхны авшиг авсан онгон бүсгүйчүүд
3. Ертөнцийн төгсгөл ирэхүй дор
4. Хатан хаадын мөргөх цагаар

II.НОМ : ТЭД ХААНААС ГАРЧ ИРСНИЙГ ХЭН Ч ҮЛ МЭДНЭ

- 1.“Аймшигт үр удам”
2. Муу харваачдыг цаазаар аваачих нь
3. Моодун ба Хятадын хатан хаан
4. Он цагийг дамнасан холын аян

III.НОМ : АТТИЛАГИЙН АРД ТҮМЭН

- 1.Нэгэн аянгын үр дагавар
2. Бүргэд, илд, бөө
3. Эртний ертөнцийн алт эрдэнэс
4. Эмэгтэйчүүдэд хамаагүй ертөнц

IV.НОМ : АТТИЛАГИЙН АМЬДРАЛ БА ЗАСАГЛАЛ

1. Өвөө
2. Эсрэг этгээд
3. Ард түмэн хэдэн удаа мөхдөг вэ?
4. Аттилагийн амь насанд халдахыг завдсан нь

V.НОМ : АТТИЛА ТЭНГЭР ХАЛЬЖ ИРД ХУВИЛГААН ДҮРИЙГ ОЛСОН НЬ

1. Аттила хааны өргөөнд
2. Шампан нутаг тэднийг залгижээ
3. Хуримын шөнө тохиосон үхэл
4. Европынхон Аттилагийн тухай домог хууч зохиосон нь

НЭРСИЙН ХЭЛХЭЭС БА ТАЙЛБАР

I.HOM

йНЛ□ ou

„Хэрэн давхилдах үй □ү□□□ зэрлэг морьтнууд“

Тэд дөрвөн зүг найман зовхисоос чимээгүйхэн, бараг үзэгдэж харагдалгүй гарч ирэв. Дунай мөрний хөндийд хөшилдсэн манан дотор эхлээд жижиг жижигхэн хар цэгүүд мэт байснаа манан хөөрч талын дээгүүр өнгийх нарны алтан туяа цэргүүдийн хуяг дуулга, зэр зэвсгээс ойн гялсхийх тэрхэн мөчид Ромын хилийн хана хэрмийн өмнө цэлийх уужим тал газар гэв гэнэтхэн тэдгээр муу ёрын халдаар ирэгсэд язганах нь харагдав. Тэд мориныхоо дэл рүү бөхийн давхих тул хүн морь хоёр нэгэн цул болж бие галбир, хөдөлгөөн нь бараг ялгагдахгүй ажээ. Намхан хирнээ бахим морин дээрээ бат сууж хийсгэх агаад тохиолдох саад хоригийн өмнө хэд хуваагдаж таран байрлаж, дөрөө шүргэм өвсөн дундуур салхи мэт хурдлахыг ажихад хараа үл гүйцэх аж.

Ромын цэргийн ангид аль хэдийн түгшүүр зарлажээ. Хэдэн зуун хос нүд энэ хэсэгтээ урсгал дөлгөөн мөрний өргөн мандал дээгүүр хүчлэн хараавчилна. Тэр цагт Истер хэмээн нэрлэгдэж асан Дунай мөрөн Ромын эзэнт гүрний хувьд хэдэн зууны турш халхавч хамгаалалт болж, өмнөд эрэгт нь Ромын эзэмшлийн цэрэг байрлаж байв. Хэдийгээр өмнө нь ийм юм болж мэдэх нь гэдгийг зөгнөж ярьж байсан ч энэ нь сандрал бачимдлыг нь хөнгөлсөнгүй. Дунайн хойд эрэгт ахуй тоо тоймгүй тэдгээр морьтойгоо нэгэн цул болсон хүн хар саарал кентаврууд өргөн эгнээгээр ус руу харайлган орох мөчид мөрний битүү хүрхрэх чимээнээс нэгэн их гай зовлон юу юугүй гэтэн ирж яагаад ч хориглож саатуулах аргагүй болсон нь мэдрэгджээ.

„Үүгээр түүгээр хэрэн давхилдах үй олон зэрлэг морьтнуудын хамт шинэ гай гамшиг нөмрөн ирсэн агаад тэдний ийн аюумшиг тарьж, түйвээн сүйтгэж эзэрхийлж хүчирхийлэх нь зэрлэг бүдүүлэг овог аймгуудын дотроо ч хэтийдсэн зэрлэг гэхээр байлаа“ хэмээн хүннүчүүд Дунай мөрний доод бие хавьд анх үзэгдэх үеийг дүрслэн Клермоны хамба ламтан, эрдэмд нэвтэрсэн яруу найрагч, бичгийн хүн Солиус Аполлинарис Модестус Сидониус бичиж байв. Түүний энэ олон нэрнээс зөвхөн хоёрдахь болоод дөрөвдэх нь л сүүлд өөрт нь үлдсэн билээ. Улс оронд нь халдан ирсэн хүннүчүүдийн тарьсан тэр аюумшиг Каталонийн тал нутагт эцэс болох үед тэрбээр хорин гуравтай байв. Гэхдээ түүний хүүхэд нас хэдэн зууны турш амгалан тайван амьдарч ирсэн Европ тэрхүү их аюул заналыг ерөөс ойлгох чадваргүй байсан тэрхүү гамшгийн цаг үед тохиожээ.

Мөнөөхөн Сидониус Аполлинарис хүннү нарын тухай бичихдээ „Шинэ төрсөн нялх хүүхдийнх нь нүүр царай хүртэл эрэмдэг зэрэмдэг, нэг л хэлбэр дүрсгүй хэсэг

бөөрөнхий юм шовойж байх нь толгой агаад духных нь дор хоёр нүх гялайж гялтайх ч юмгүй байх нь нүд ажээ. Магнайд нь тусах өдрийн гэрэл нүдээ аниагүй байлаа ч ялгаагүй тээр цаана байх хүүхэн хараанд нь хүрч тусахгүй. Ухархай нь өчүүхэн жижиг ч нүд нь эргэн тойрны юмыг сайн харах агаад хүүхэн хараа нь жижиг хэдий ч хараа хурц тул тэртээ холын гүн гүнзгий ангал, нүх сүв, ганга жалганд буй юмыг ч сайтар ялган харж чадна. Хамар нь нүүрнээсээ урагш илүү гардаггүй, дуулганы унжлага дор багтаахын тулд хамрыг нь боолтоор ороож дарах ажээ. Ийм байдлаар эх нь хүүгээ зөвхөн л цэрэг дайны хэрэгсэл болгох гэж л зэрэмдэглэх бөгөөд учир нь хамрыг урагшаа товойж ургахыг нь зогсоох учир нүүр нь өргөн хавтгай юм болдог ажээ“ хэмээжэхүй.

Хүннүчүүдээс хэд гурав нь элч төлөөлөгчөөр ч юм уу, ер нь л сайн санаа өвөрлөн ирсэнсэн бол тэдний гадаад төрх тэгтлээ жигшил зэвүүцэл төрүүлэхгүй байсан байж мэднэ. Огт өөр өнгө төрхөнд дассан гоо сайхан ром бүсгүйчүүдийн гайхал, бас инээдийг хүргээд л өнгөрөх байсан биз. Гэвч үй олон морьтон хүннүчүүд аюумшгийг тарьж гай гамшиг авчирсны учир тэдний харь төрх нь тэрхүү аюумшигтай сүлэлдсэн хэрэг билээ. Хүннү нарын эхчүүд дуулганы унжлагад тааруулахын тулд хөвгүүдийнхээ хамрыг зориуд дарж навтайлгадаг гэсэн домгоос үүдсэн санаа тэдний энэ өнгө төрхөөс харагдаж буй гэж гоотуудын түүхийг туурвигч их Иорданес үзэж байв.

„Дайн тулаанд өөрсдөөсөө илт давуу биш овог аймгуудыг хүннүчүүд гадаад төрх байдлаараа л аюумшигт автуулж тэд нь өөрсдийнх нь үзэшгүй муухай тэр дүр төрхөөс айж сүрдээд бушуухан зугтдаг байв. Хүннүчүүд пад хар арьстай. Нүүр нь болохоор хүний нүүр гэж хэлэхэд бэрх, нүдний оронд байх хоёр жижиг цэг бүхүй хэлбэр дүрсгүй хэсэг мах. Тэдний ийм эрэмдэг зэрэмдэг төрх авир араншинг нь илтгэнэ. Тэд шинээр мэндэлсэн эрэгтэй хүүхэддээ хүртэл хэрцгий хандана. Хүүхдийнхээ хацрыг илдээр зүсч эсгэх бөгөөд ийнхүү тэд нь эхийн сүү амлахаас өмнө л шарх сорвитой болдог. Ингээд залуу хөвгүүд сахал үсгүй өсөх бөгөөд учир нь илдээр сараачсан нүүр нь сахал ургуулах аргагүй болдог байна...“

Шарх сорви болсон нүүр царай, онигор нүд, навтгар хамар, бас дээр нь цоргих мэт хурц харц, амьтан араатны шинжийн хөдөлгөөнтэй эд ер нь хүн мөн үү. Энэ асуултыг тавьсан эхний хүнд түүндээ хариулах зав гараагүй нь тодорхой. Учир нь хүннүчүүд Хар тэнгисийн умар этгээдийн нам дор газраас гарч Дунай, Карпатын дундуур Европ руу нэвтрэх зам өнгөрдөг үүд хаалгаар нэгэнт ороод ирсэн байв. Тэд Дунай мөрнийг гаталж, Ромын бэхлэлтийн байгууламжууд, тухайлбал өнөөгийн Свитошт хотын ойролцоо Дунайгаас чанх хойшоо Карпатын өмнөд хормой дахь Питешт орчмын нутаг руу татсан Каракаллын хэрэм болон түүний цаад талд өнөөгийн

Никопольд цутгах Альт хэмээх жижиг голын дээрх Хадрианы Лимээс баруугаар өнгөрөх нөгөө нэг хэрмийг давж орж ирэх ёстой байсан юм.

Хүннүчүүд тэдгээр хэрмийг хэзээ, хаагуур нэвтэрснийг хэн ч яг таг хэлж чадахгүй. Нүдээр үзсэн гэрч амьд үлдсэнгүй, хил дээр сууж байсан хүн ам бачимдан айж зугтан одсон хийгээд Ромд хүрч очсон мэдээ сэлт будлиан зөрчил дүүрэн, түүгээр ч зогсохгүй хэн нэгэн этгээд гоо үзэсгэлэнт хүмүүс гэж ярьсан ч байдаг .

Анхны арай гайгүй мэдээг хүргэсэн нь Бага Азийн Антиохиа хотоос гаралтай Аммианус Марчелинус гэгч боловсролтой гэрэг хүн агаад тэрээр хүчирхэг ромчуудын анд нөхөр, хань хамсаатан явсны учир байлдаан тулаанд оролцож явсан тул тэгтлээ их айж бачимдаагүй байжээ.

Хүннүчүүд нүүр царайгаа юуны учир хутгаар зүсч зориудаар эрэмдэг болгодогийг тэр ойлгосон бөгөөд харин хожим нь Иорданэс илдээр шархлуулсан болгожээ. Гэвч тэрхүү сахал ургах аргагүй болгодог, түүгээр ч барахгүй Аммианусыг хүннүчүүдийг сахал үсгүй тайган нартай зүйрлэхэд хүргэсэн шарх сорви нь гэрэгүүдэд тэрхүү хачин морьтнуудын эр чадал, дайчин чанарыг олж харахад саад болоогүй ажээ:

„Тэд бахим хүчирхэг бие цогцостой, бухан хүзүүтэй, харахад жигшмээр, хоёр хөлтэй араатан мэт муухай, жишвээс хаа сайгүй л байх гүүрийн хоёр талд бүдүүн хадухандуу цавчиж босгосон байдаг болхи бааз дүрс лугаа адил. Хэдийгээр хүн төрхтэй харагдавч бие махбодь нь айхавтар хатуужсан учир чанаж болгож амталсан хоол унд хэрэглэдэггүй, харин өвс ногооны үндэс болоод амьтны шүүрхий махыг өөрийнхөө гуя, мориныхоо нурууны завсар хавчуулж бүлээсгээд иднэ... Тэд хатуужил ихт, болхи толхи мориныхоо нуруунд хадагдчихсан мэт байнга давхиж явна. Тэд мрин дээрээ авгайчуудын адил хажуулдан сууж явах бөгөөд чингэж явахдаа дадаж сурсан морьтны эрдмээ үзүүлнэ. Тэд өдөр шөнийг ялгалгүй морин дээрээ өнгөрүүлж, тэндээ идэж ууж, арилжаа наймаа хийж, зүүд нойрондоо ч морины нарийхан хүзүүг дэрлэн бөх унтаж явна...”

400 оноос өмнө хүмүүс хүннүчүүдийн талаар ийм л зүйл олж мэдсэн агаад Аммианус ч удаан насалсангүй бололтой ажээ. “Рах Romana” буюу Ромын хэв ёсны энх журам тогтносон хэдэн зуун жилд дайтаж байлдахаас төсөөрөөгүй хэдий ч дайныг мартаж амжаад байсан тэрхүү ертөнцийг дайрлага дайрсан мэт болсон агаад эдүгээчилбэл нэг л өдөр сансрын уудмаас дайсан этгээд халдаар ирьеэ гэж бодвол бид хэрхэхээ төсөөлөөд үзэж болно. Итгэж найдаж явдаг хамгаалалтын зэвсэг маань ямар ч нэмэргүй болоод огт өөр ертөнцөөс хүрч ирсэн, хүн гэж нэрлэхэд бэрхтэй, хэл амаа ч

ололцохгүй тэдгээр халдан довтолгосдыг хараад л өгүүлшгүй жигшил зэвүүцэл төрөхөөр яах ч билээ дээ!

Их эзэнт гүрний хил хязгаараас элдэв цуу яриа дэгдэж яван явсаар нийслэл хотод хүрэв. Хаа газрын зэрлэгүүдийг аль хэдийн таньж мэдчихээд хамжлага цэрэг болгож байлдуулж сурчихсан, эзэнт гүрний өнцөг булан бүрээс авчирсан боолчууд гудамжаар нь гүйлдэж, харь газрын хачин үзэсгэлэнт боол хүүхнүүд дээдсийн тансаг зоог, зугаа цэнгээг чимэглэж асан Тибр мөрөн дээрх их хотынхон энэхүү халдан довтолж ирэгсэд бол үе үе түрээд ирэхээр нь бутцохичоод дараа нь албандаа авч цэрэг тариачин болгож зүтгүүлдэг тэдгээр нүүдэллэн явагч зэрлэг овог аймгуудын мухар сохор давалгаанаас нэг л өөр зүйл юм байна шүү гэдгийг ойлгож эхэлжээ.

Тэдгээр харь холын хүмүүс газар хагалж тариа тарьсангүй, орон байр гэдгийг мэдэхгүй. Тэднийг тэгэхлээр яаж орон суурин болгох вэ. Тэдэнд хэрэгцээ гэж байсангүй, хөрөнгө хогшил гэх юмгүй. Юугаар тэднийг татах вэ. Тэдэнд хэл гэж байсангүй, харин зугтаж яваа амьтан шиг богино богино огцом дуу гаргах ажээ. Тэдний эсрэг Ромын дипломат албаны уран тансаг хэл ч хүчин мөхөсдөнө.

Тэд хаанаас гарч ирснийг хэн ч үл мэднэ. Тэд өөрсдөө бол бүр мэдэхгүй. Нэг мэдэхэд тэд газар сайгүй тарж, мянга мянган цусан гольдрол бүхүй энэ үерийн их давалгааг тогтоон барих далан хаалт байхгүй мэт ажээ.

2.

з □□□□ □□у □□□□□□ □□□□ □А□А□А□А□

Хүннүчүүдийн хүрч ирсэн ертөнц бол шилжилтийн үедээ явж байсан юм. Ром хэдийгээр тэнгэрийн эзэн Юпитер, Гэрэгийн охин тэнгэр Артемид, галын бурхан Вулкан хийгээд дайны бурхан Марс зэрэг бурхдыг албан ёсоор шүтсээр байсан хэдий ч Ромын эзэнт гүрний мандан бадарч явах аугаа үеийн эдгээр шашнаас огт өөр зүйлийг хүмүүсийн сэтгэл зүрх хүсч мөрөөдөж, шүтэж бишрэх болсны улмаас эдгээр хуучин бурхад нь энэхүү ертөнцийг орхихоор зэхэж байсан цаг амой.

Эзэнт гүрний харьяа алс дорнод нутагт сууж асан цэрэг дайчид гэрэл гэгээний бурхан Митрагийн шүтлэгийг өрнөдөд авчирчээ. Тэд цэргийн хуаранд сууж ахуйдаа мөнхөд гийгүүлэх ялагдаж дийлдэшгүй гэрэлт нарыг шүтэж бишрэх болсон ажээ. Ингэснээр Митрад сүслэх явдал эзэнт гүрэн даяар дэлгэрч, түүнд эзэн хаан ч өөрөө татагдан оржээ. Иордан гол дээрх цөөн бүл жүүд нарыг захиран суусан Ромын амбан захирагчийн цэргийн жижиг бүлгээс ийн нэгэн хачин мөргөл Ром хүрч, улмаар Галли

хүртэл дэлгэрээд их хотын борчууд, нутаг оронгүйчүүд хийгээд бүр цэрэг дайчдыг ч татжээ.

Эзэнт гүрний хил хязгаарыг хүннү нар давж түрэн ирсэн нь тэнгэрийн гэсгээл юм гэдэг нь тэдний тухай сонссон бүх хүнд тодорхой байлаа. Нөмрөн ирсэн аюул гамшгийг гагц энэ талаас нь тайлбарлах бас аргагүй байв. Гэвч тэнгэр хэнийг ч ялгалгүй гэсгээн цээрлүүлжээ. Сайн, муу ялгаагүй л бүх юм хүннүчүүдийн агт морьдын туурайд талхлагдаж, буруу номтнууд, христүүд, митрагийн шүтлэгтнүүд болон жүүд, за тэгээд хүүхэд шуухад, өвгөд өтгөс хэн алингүй л автагдав.

Ромын нэгэн язгууртны залуу бэлэвсэн эхнэр христ мөргөлд орж, библи судрын ариун газруудыг үзэхийг хүсчээ. Энэ бол гайхмаар ер бусын зүйл биш байлаа. Ромын эзэнт гүрний хүмүүс их л бядан явдаг байсан нь нэг л хэл бүх үүд хаалгыг онгойлгож, нэг л мөнгө газар сайгүй хэрэглэгдэж байсных бөгөөд энэ гүрэнд ромын эрчүүд, хүүхнүүд элит хэсгийг бүрдүүлж, Испаниар аялж явна уу, Хар тэнгисийн эрэгт очно уу ялгаагүй, хаа ч анхаарал хүндлэл хүлээнэ гэдэгт итгэж байсан цаг билээ.

Дурдсан бэлэвсэн эхнэрийг Паула хэмээх агаад таван хүүхдийнхээ нэгийг алсын аянд авч явсан нь охин Юстохиум байжээ. Уг эхнэрийн холын аяны замын хань өөрөөс нь насаар ах бус ч ихийг үзэж туулсан, христ мөргөлийн нэр хүнд бүхий нэгэн багш байв. Түүнийг Хиеронимус гэх агаад христ мөргөлт чинээлэг айлд төрсөн, Ромд эрдэм номд суралцаад Мозель гол дээрх Ромын харьяаны Трийр хотыг зорьж явахдаа гэлэн болж амьдрахаар шийдээд Бага Азиар аялан явж, бас даяанчлан амьдарч амжаад эцэс сүүлд нь Аммианусын сууж асан Антиохи хотноо хүрч санваартан болжээ. Ийнхүү эл хотод гэрэг хүн Аммианус, Далмац нутгийн Стридоны Хиеронимус гэх энэ хоёр хүн хүннүчүүдийн агт морьдын төвөргөөнд газар дэлхий доргихын цагт их аюумшгийг амсчээ.

„Эмэгтэй хүн байрлуулчихмаар газар эрж явтал гэнэт энд тэндээс баахан элч довтолгон ирэв. Тэднийг ийнхүү ирмэгц гүрний дорнод нутаг тэр аяараа сүрдэн чичрэв. Тэртээ алс Хар тэнгисийн дорно этгээд, Днестр мөрөнд ахуй маэогийн газар орноос гарсан хүннүчүүд бөөн бөөнөөрөө нөмрөн ирж буй тухай мэдээг тэдгээр элч авчирсан хэрэг. Ази тийш нэвтрэх үүд хаалга болсон тэр нутагт Их Александрын байгуулсан бэхлэлтүүд наран жаргах зүгийн орнуудыг дээрэмч тонуулчдын сүргээс хамгаалж, Кавказын цавчим уулс ч мөн халхавч болж ирсэн билээ. Гэвч догшин сүртэй морьдоо унасан хүннүчүүд тал тал руугаа үсчиж, аллага таллагын аюумшигт үйлийн үрээ хаа сайгүй тарьсаар аялан явж буй аж. Тэр цаг Ромын их цэрэг дотоодын иргэний дайнд татагдан орж өөр тийш анхаарал хандуулах боломж муутай байсан үе билээ.“ хэмээжээ.

Дөрөвдүгээр зууны үеийн гэгээнтнүүдийн дотор сүмийн их багш, эрдэмт хүн гэгдэж байсан тэрбээр зургаан зууны настай цайз бэхлэлтүүдийн бат бэх автагдашгүйд итгэж байв. Тэрээр Газар дундын тэнгис хавийн соёлын давуу хүч хийгээд өөрийн биеэр сурч мэдсэн зүйл, өөрийнх нь номын санд хуримтлагдсан их мэдлэг ухааны бүтээл, өөрийнхөө сургаж номлож байсан хийгээд бичиж туурвисан бүхэн үхэшгүй мөнх гэдэгт бат итгэж байв. Тэрбээр болж буй үйл явдлыг хүмүүс яагаад ч ухаж ойлгож чадахгүй байсны гэрч, айдас хүйдэст автагдаж, хэмжээлшгүй зовлон тохиолдож, яах ч учраа олохоо больж уймарч үймэрсэн цагийн гол гэрч нь байлаа.

„Исүс тэдгээр зуйгуул амьтсыг Ромын гүрнээс хол байлгах болтугай. Яагаад ч хүрч чадахгүй дээ гэхээр газар оронд ч хүртэл тэд хүрээд очиж байлаа. Туйлын хурдан гавшгай учир аливаа хэл мэдээ, дам яриа бусад газар оронд хүрч амжихаас урьтаад л тэд оччихсон байдаг байлаа. Шашин мөргөл тэдний хувьд юу ч биш, тэдэнд өөрсдөд нь тийм юм байхгүй. Тэд настан буурайг ч, нялх балчирыг ч үл хэлтрүүлнэ. Дөнгөж мэндэлсэн нялзрай амьтныг ч үхэл рүү илгээнэ. Гэтэл хөөрхий тэр нялх амьтад өөрсдөд нь ямархан аюумшигт хувь тавилан заналхийлж буйг үл мэдрэхийн учир алуурчид шүүрч аваад л илдээ далайж байхад ч мушилзан инээвхийлж л байна.

Уг нь тэдний хүрэхээр зорьсон газар нь Иерусалем хот гэлцэх агаад алт эрдэнэст улайран тэмүүлэх тэдний ханаж цадахыг мэдэхгүй шунал тийш хөтлөх ажээ. Тиймээс хүмүүс энх амгалан цагт тарвалзаж ахуйдаа хайхраагүй хаясан хотынхоо хана хэрмийг яаруу сандруу бэхэлж гарав. Хүннүчүүд Антиохи хотыг бүслэн авав. Тирүс хотынхон Александртай сөргөлдөж асан урьдын хэдэн зууных шигээ дахиад л эх газраас зугтаж арал дээр орогнохыг оролдож байв.

Биднийг Тирүст байхад энэ бүхэн болсон хэрэг бөгөөд хотынхон лугаа адил бид ч гэсэн дайсан ойртоод ирвэл тэнгисийн эрэгт аргамжаатай буй хөлөг онгоцонд суун далайд гарахад бэлэн байв. Хэдийгээр салхи догшрон шуурга дэгдэхээр бид айж эмээж байсан ч тэр маань зэрлэгүүдээс айж сүрдэхээс илүү нь юу байхав. Бид өөрсдийн өчүүхэн амь биеийн төлөө бус, харин бага залуу охид бүсгүйчүүдийн ариун нандин бие цогцсын төлөө айж түгшиж байсан билээ“

Тэрхүү аюумшиг зовлонгийн тухай туурвигч түүхч, үйл явдлыг нүдээр үзсэн гэрчүүд дэлхий ертөнц тухайн үедээ талцаж хуваагдсан байсныг өөрсдөө илтгэн харуулдаг. Зарим нь эртний онго шүтээнтний ертөнцийг төлөөлж байв. Тэд хүннү нарыг зөвхөн гадна төрхийг нь гол болгон дүрсэлж байв. Хүннү нарын байлдах ур чадвар, үзэгдэж харагдаагүй харь гарлын зэр зэвсэг, агт морьдынх нь хурдан гавшгай байдал тэдэнд их сэтгэгдэл төрүүлжээ. Нөгөө хэсэг нь христ мөргөлтнүүд юм. Тэд хүннү нарыг аль л бузар муу бүхний амилсан дүр гэх бөгөөд хүннү нарын халдан довтолж ирсний

зорилго нь алив нүглээс ангид цэвэр ариун охид бүсгүйчүүдийг эзэмдэх явдал гэх агаад тэднийг даллаж дуудсан өөр нэг зүйл нь алт эрдэнэс гэж дэлхийг таньсан Хиеронимус дурдсан байдаг.

Гэвч ядаж үүгээр тэдний сэтгэл ханадаг бол ч яая гэхэв! Нүгэлт ертөнцийн нандин сайхан зүйлс Хиеронимус гэгч энэ даяанч санваартны сэтгэлийг тэртэй тэргүй нэг их татаж байсангүй. Энэхүү мөхөж буй бөө мөргөлийн ертөнцийн төгсгөлийг сануулж мөхлийн харанга дэлдэж буйд тэрбээр нэг их юм бодоогүй нь магад биз. Гэвч хүннүчүүдийн дайран өнгөрсөн газар бүртээ үйлдсэн харгислал хэрцгийллийн тухай хэл яриа нь алт эрдэнэсийн тухай гэхээсээ илүү эмс охидын тухай ажээ. Тэгээд тэр их алт эрдэнэс нь хаана ч байгаа юм билээ?! Эхнэр хүүхэн бол хаа яагүй л байгаа. Христ мөргөлтнүүд энд тэндгүй сүм хийд байгуулсан болохоор хүннүчүүд өөрсдөд нь зориулж яг хүссэн юмыг нь цуглуулсан мэт намхан хэрмийн цаадах ямар ч өмгөөлөл хамгаалалгүй эхнэр хүүхнүүд, эр хүн гээчийг огт үзээгүй охид бүсгүйчүүдийг үзэн гайхаж байсан ажээ. Ёс заншил, цэвэр ариун бүхнийг дээдлэх Хиеронимус эдний л тухай санааширч, хамбатны сэтгэлийг он цагийн уртад амирлуулах ёстой нэгэн захидалдаа хүннү нарын тухай, тэдний холбоотнуудын тухай өгүүлжээ.

„Эрэн цаг маань мөхөж буйг бодохоор зүрх чичирч сэтгэл эмтэрнэ. Константинополь хотоос Юлийн Альп хүртэлх газар оронд ромчуудын цус өдөр алгасалгүй урссаар хорин илүү жил боллоо. Скифүүдийн орон (Өмнөд Орост ахуй), Тракий, Македон, Тессалий, Эпирүс хийгээд Паннонийг тэр чигээр нь гоот, сармат, куад, алан, хүннү, вандал, маркоманнууд халдан хүчирхийлж эвдлэн сүйтгэж цөлмөн хоосолжээ. Хэчнээн олон эмэгтэйчүүд, бурхны авшиг хүртсэн охид бүсгүйчүүд, хэчнээн олон эрдэнэт хүний амь нас энэ дайны хөлд өртөж, хэчнээн нь доромжлогдож гутаагдав?. Хамба ширээт нар олзлогдож, гэлэн хувраг, шашин мөргөлийн хэргэмтнүүд хороогдов. Сүм хийд сүйтгэгдэж, зарим нь агтны жүчээ болж, зовлон эдлэгчдийн ариун нандин шүтээн эд юмс үрэгдэж алга болов“ хэмээн өгүүлжээ.

Ийн ахуйд түүнд огт санаандгүй зүйл хэрэг болов. Тэгээд тэрээр өөрийн ром, гэрэг, жүүдийн гүн гүнзгий боловсрол, хуучны онго шүтээн, олон хэл мэддэгийн ачаар уншаад зогсохгүй чөлөөтэй хэрэглэж дадсан жүүдийн сургааль судруудаас нийлүүлэн латин судар Вулгата (*Хуманистуудын нийтэд тархсан шинэхэн латин орчуулгаас ялгахын тулд Вулгата хэмээн нэрлэсэн Гэгээн Хиеронимусын христ шашны ариун судрын орчуулга агаад энэ нь яваандаа урьдын хуучин латин орчуулгуудыг шахан байрыг нь эзэлжээ. Вулгата нь IV зуунд бий болж Триестийн сүмийн хийдийн их чуулганаас хүлээн зөвшөөрөгдсөн байна. Орч.*)-г бүтээжээ.

„Газар сайгүй хүмүүс уйлж унжиж, айж сүрдэж, үхэл зовлон гэгч нь олон өнгө төрхийг олж байна хэмээн Вергил (*Латинаар Вергилиус хэмээгч эртний Ромын*

алдарт яруу найрагч, христийн тооллын өмнөх 70 онд мэндэлж, 19 онд насан эцэслэжээ.Орч.) „Аенеис“ хэмээх найрагтаа шүлэглэжээ. Ромын дэлхийн эзэнт гүрэн нуран унаж байлаа ч бид сэтгэл алдрахгүй, итгэл дүүрэн байна. Коринт, афин, лакедаймон, аркадчууд хийгээд өнөөдөр зэрлэгүүд ноёлж захирч байгаа бүх Гэрэг орны зүрх сэтгэл ямар байх вэ гэж чи бодож байна? Хэчнээн олон сүм хийд эзлэгдэв? Хэчнээн гол мөрөн хүний цусаар бялхав? Бүр Антиохиа хүртэл автагджээ. Вергилий юу хэлж буй билээ? Шүлэг найргаараа би (зуун хэл, зуун хоолойтой байлаа ч) энэ бүхнийг дүрслэхийг үл хүснэ. Алтан гургалдайн хоолой ч байгаад хэрэггүй...”

Ийнхүү алдрын титэмт найрагчид, улирч өнгөрсөн цагийн алдар суу, шүлэг найраглалын санаа дагасан мөн чанар, эртний Гэрэгийн зургаан мөртүүд (Хомер)-ийн ганган хэлхээст дулдуйдсан нь хэдий сэтгэл татам ч гунигт инээд, гашуун эмгэнэл хосолсон явдал байсан агаад Хиеронимусын ухаарч ойлгосноор эдгээр нь хэдэн арван барилгын засмал чулуун хавтангууд, үнс нурамд дарагдаж үлдсэн хэдэн хотхон болоод хүннүчүүд, гоотуудаас амь зулбан зугтахад барагдаж өгөхгүй Ромын урт гудамнуудын хамтаар үлдэж хоцрох цөөхөн зүйл байжээ.

Хэдийгээр эзэнт гүрний энэ хэсгийн газар орон хүннүчүүдэд автагдсан ч ер нь л энэ дэлхий тэр чигээрээ сүйрч ч болох юм гэдгийг сүмийн их багш хэдийнээ зөнгөөрөө мэдэрч ойлгож байв. Сүүлд христ мөргөлд тэрсэлсэн тэр их хүний хэлснээр нурж унах зүй тогтолтой юмыг түлхэж л орхих ёстой байв. Энэхүү таягдаж хаях үйл нь нь одоо ирж буй ажээ. Энэ үйл хэзээнээсээ аврал ирсээр асан тэр л дорно зүгээс ирсэн хийгээд тэр нь христ мөргөлтнүүдийн аврал, Митрагийн архадуудын авчирсан гэрэл гэгээ билээ.

Аяны замын үзүүрт байрлах цуут Антиохиа хот асар их эд баялагтай, амьдрал нь баяр баясгалантай хэдий ч хүннү нарыг сөрөн зогсох хүч чадалгүй билээ. Газар дундын тэнгисийн буурал эртний ертөнцөд хүрэх үүд хаалга болсон энэ хот хүннү нарын гарт оржээ. Тэд энэ үүд хаалганы учир холбогдлыг ерөөс ухаж эс мэдэх агаад уулаас тэд хана хэрэм, байшин барилга, зам гудмыг мэдэхгүй явсан билээ.

Христ мөргөл хийгээд Митрагийн шүтлэг, Дорно ба Өрнө, Ром болон Ази бие биетэйгээ учрах энэ хот ганц шөнийн дотор л шинэ эзэдтэй болжээ. Баян чинээлэг худалдаачид цагаа олж зугтаж амжсан нь тэдний урт хөлт хурдан тэмээдийн ач агаад хүннү нарын жижиг давжаа морьд тэсвэр хатуужил сайтай ч тэд хойноос нь нэхэж цөлийн зүг довтолгосонгүйн учир нь юуны өмнө хүннүчүүд эхний өдөр л тонож дээрэмдэж амжихгүй юм бол хамаг юмнаас хоцрох байсан билээ.

Сирийг захирагч Ромын амбан сайдын суух Селойкос Никаторын үндэслэн байгуулсан энэ хотноо баяр баясгалан унтарч аюумшиг ноёрхов. Зургаан зуун алхам урт баганат танхимууд хоёр талаар нь эгнэсэн гол гудамжаар хүннүүд зугтагсдын замыг хаахын тулд гантиг хавтан дээгүүр морьтойгоо жирийлгэнэ.

Энэ хотод Петрус хамбаар долоон жил сууж, сүмийн арван удаагийн хурал энд болсон ч онго шүтээнт Антиохиагийн гялалзсан өнгө төрх ч, шинээр тогтнож асан христ мөргөлийн ариун билиг тэмдэг ч дөрөв дахин хуваагдаж, дөрөв дахин бэхлэгдсэн энэ хотыг авран хамгаалж чадсангүй.

„Хаанаас гарсныг нь огт мэдээгүй байтал л тэд нэгэнт энэ хүрээд бидний дунд ороод ирсэн байлаа“ хэмээн хагархай самбар дээр хэн нэгэн бичиж үлдээсэн байсан агаад уг хүн чингэснийхээ дараа нэг их удаан нартыг халиагаагүй бололтой. „Тэд бурхдын худгаас морио усалж, сүмийн шатан дээр эхнэрүүдийг хүчирхийлж байв. Үр хүүхдийг маань хотын баганууд руу тархиар нь савж байлаа. Антиохиагийн охид бүсгүйчүүдийг тэд урдуураа дүүрээд давхин одож байлаа. Тэдэнтэйгээ хэзээ ч дахин уулзахгүй нь ээ“.

Цэвэр ариуны тухай энэхүү үзэл санаа нь дөрөвдүгээр зуунд тохиосон тэрхүү аймшигт явдлыг улам гүнзгий, улам зовлон зүдүүртэй болгох гэж л дэлхий ертөнцөд ирсэн мэт ажээ. Хуучин ертөнц нь дэлхийн эзэнт гүрний голт зүрх, сая хүний орон гэр Ром хотноо эргэл мөргөлийн үйлээ мөрдөж байсан санваартан бүсгүйчүүд болох весталинчууд (*Эртний Ромын айл гэрийн гал голомтын охин тэнгэрийг ийн хэлэх бөгөөд түүнд зүтгэгч санваартан эмэгтэйчүүд сүмд сууж, улс гэрийн гал голомтыг манаж хамгаалдаг байжээ. Орч.*) буюу бурхны албат бүсгүйчүүдээс цэвэр ариун байхыг хатуу шаарддаг байжээ. Харин идэр залуу христ мөргөл бол колонийн шашин, дорноос ирсэн шашин агаад эзэнт гүрний төвөөс алслагдсан тэндхийн цэргийн ангиудад эхэлж цэцэглэж хөгжсөн агаад эзэнт гүрний нийслэлийн ёс заншлыг уландаа гишгэн завхруулж буй явдлууд, эзэн хаадын садар самуун байдал, Ромд ч, Антиохиад ч ялгаагүй жаргалдаа ташуурах ордны тансаг амьдралын тухай христ мөргөлт эмэгтэйчүүд дуулж мэдсэн болохоор сүмийнхээ дүрэм журмыг ягштал дагаж мөрдөх бөлгөө.

Эдгээр христ мөргөлт эмэгтэйчүүд Диоклетианы (*Латинаар Гайус Аурелиус Валериус Диоклетианус бол христийн тооллын 243 оны орчим төрсөн, Ромын сүүл үеийн эзэн хаан, харгислан дарангуйлагч байсан агаад христ шашинтнуудыг хамгийн ихээр мөрдөн хавчиж байсан хүн юм. Орч.*) мөрдлөг хавчилгаас арай гэж нэг мултрав уу үгүй юу, тэр дороо л зэрлэгүүдийн идэш болжээ. Тэр үе бол эзэнт гүрэн бүхэлдээ шинэ шашин руу илэрхий хандаж, үдшийн орны дээгүүр арай энэрэнгүй

бурхны гэрэл гэгээ гийж эхэлсэн цаг билээ. Өмнөх хэдэн зууны үеийн хувраг санваартан, сүмийн багш нар шавь нартаа энэ бүхний учрыг тайлбарлан цор ганц, бүхнээс хүчирхэг бурхан яагаад ийм байдалд хүргэсний учрыг таниулах гэж ихэд хичээсэн болой.

„Хичээл зүтгэлтэй сайн сайн лам нар зэрлэгүүдийн илдэнд амь үрэгдлээ гэж чи хэлж байна. Сүнснийг биенээс нь салгасан зүйл нь ужиг халуун уу, илд байна уу, юуны ялгаа байх вэ? Бурхны хувьд шавь нар нь юуны учир амиа алдав гэдэг нь гол бус, харин ямар байдлаар амьдралтай тооцоо дуусч, өөрт нь ирж буй нь чухал билээ“ хэмээн Хиппогийн хамба ламтан 409 онд Викториан гэгч гэлэнд илгээсэн захидалдаа бичиж байв.

Энэхүү Хиппогийн хамба гэгдэгч нь хүннүчүүдийн халдаар ирэхээс даруй хорин жилийн өмнө буюу 354 онд төрж, Каталауны тулалдаанаас хорин жилийн өмнө буюу 430 онд насан эцэслэсэн, Карфагенд боловсрол олж, Миланы хамба Амброзиусыг христ мөргөлд оруулсан Нумидийн Аурериус Аугустинус мөн байсан бөгөөд 396 оноос Ромын эрхшээлд байсан Умард Африкийн Хиппо Региус хотноо хамбаар сууж байсан тэр л хүн мөн бөлгөө. Улс түмнүүдийн их нүүдлийн үймээн самуунд автагдсан хуучин ертөнцийн мөхөл нь түүнийг бурхны мөхөшгүй улсын тухай өгүүлсэн *De civitate dei* (Бурханы төрийн тухай энэ бүтээлийг дээрх 354-430 онд амьдарч байсан Аугустинус 413-426 онд туурвижээ. Тэрээр христ шашин дэлгэрсэн Ромын эзэнт гүрнийг Исүсийн номлосон бурхан шашинтай төр улс мөн гэх христ мөргөлтнүүдийн дунд тархсан үзлийг Ром 410 онд өрнөд гоотуудад эзлэгдсэний дараа үгүйсгэх үзэл тархаж, улмаар онго шүтлэгт түлхэц өгөх хандлага хүчтэй болсонтой холбогдуулан туурвиж нийт 22 боть бүтээлдээ бурхан шашинтай төр улс /*civitas dei, civitas caelestis*/ нь жирийн төр улс /*civitas terrena*/-аас эрс ялгаатай тухай үзэл санаагаа тайлбарласан байна. Орч.) хэмээх алдарт бүтээлээ туурвихад хүргэсэн билээ. Түүний захидлууд дэлхий ертөнцийн мөхлийг зөгнөж сануулсан мэт тохиосон тэр их үймээн самууны дундуур сүсэгтнүүдэд бага ч болов тайвшрал авчирч байжээ. Бурхны хүлцлийн үр үндсийг олох хийгээд ямар ч гэм зэмгүй хүн амьтны зовлон гачаалын учир шалтгааныг тайлбарлах нь үнэхээр амаргүй байсныг харь дайсанд олзлогдсон христ эмэгтэйчүүдийн хувь тавилангийн тухай өгүүлэхдээ Аугустинусийн заримдаа бага зэрэг хөвөлдсөн бүрхэгдүү мэт санагдах этгээд үг хэллэгүүд илтгэнэ. „Бүхнээс хүчирхэг, нигүүлсэнгүй бурхан олзлогдсон эдгээр эмэгтэйчүүдээр дамжуулж зэрлэгүүдийн оронд яаж нөлөөлж, ямар гайхамшгийг үзүүлэх гэснийг бид яахин мэднэ?“ хэмээн хамбатан асуугаад олзлогдон боол болж буруу номтнуудын оронд очсон христ мөргөлт нэгэн бүсгүйн түүхийг өгүүлжээ. Зарцлагдаж байсан айлынх нь хүмүүс хүнд өвчинд нэрвэгдэхэд тэднийг аварч энэрэхийг гуйн мөнөөх бүсгүй бурханд мөргөжээ. Чин ариун сэтгэлийн угаас гарсан тэрхүү мөргөл бурхны сонорт хүрсний

ачаар айлын хүмүүс бүгд бие илааршсаны хойно христ бурхны хүч чадлыг нотлон харуулсан боол бүсгүйн шашинд айлынхан өөрсдөө орцгоож, ачийг нь хариулж бүсгүйг суллан тавьж явуулсанд төрөл садандаа эгэж ирсэн ажээ.

Иймийн учир харьд олзлогдон одсон эмэгтэйчүүдийн хувь заяа хэрхсэн талаар сураглах хэрэгтэй (!), мөргөл үйлдэх учиртай. Хэрвээ тэд сүсэг мөргөлдөө үнэнч л байх юм бол бурхан тэднийг ивээлдээ байлгаж, „дайсны бузар шунал тачаалыг тэдний ариун бие цогцост халдаахгүй агаад аргагүйдээд халдаалаа гэхэд нэгэнт л тэдний өөрсдийнх нь дур тачаал, хүсэл сэтгэлийн дуудлагаар бус, харин харгис хар үйлийн хүчээр хийгдсэн тэрхүү нүгэл нь хүчирхийлэгчдийн өөрсдийнх нь хар толгой дээр л бууна. Учир нь уул бүсгүйчүүд өөрсдөө зөвшөөрч шившиг амсаагүйн учир оюун сэтгэл нь буртаглагдахгүй тул энэ нь бие мах бодоо ял зэмээс хамгаална” хэмээжээ. (*Corpus scriptorum ecclesiasticorum Latinorum /товчоор CSEL/-Австрийн шинжлэх ухааны академийн комиссоос эрхлэн гаргасан манай эрний эхний зуунуудын латин сүм хийдийн зохиолчдын бүтээлийн эмхэтгэл, Вена 1866, 34/III/656*)

3.

□□□ □□□□□□ □ □□□□□ □□□□**A**□□

Ромчуудын зэрлэгүүд хэмээн хэнийг нь ч ялгалгүй, гэхдээ тун онож нэрлэдэг улс түмнүүдээс хүннү нар анхных нь ч биш юм. Христийг мэндлэхээс аль өмнө хэсэг бусаг нүүдэлчин овог аймгууд умраас Ромын эзэнт гүрний нутагт түрэн орж хэсэг зуур зэрлэг догшин авираа гаргаж олз омог олсны хойно хүчээр давуу, сайн зэвсэгтэйн дээр удирдлага сайтай, нутаг орноо сайн мэдэх ром цэргүүд тэрэг чарга, эхнэр хүүхдээ чирч түүндээ түүртэн явах герман голдуу аймгуудыг дайран орж бутниргэх бөлгөө. Өнөөгийн Марсель хотноо Мариус хэмээх нэр их тааралддаг нь тэртээ алсын Ромд ямар ч аюул учруулахааргүй байсан хэдий ч сэргийлэн хамгаалах үүднээс хэдэн арван мянган германчуудыг Аиксын тал нутагт эхнэр хүүхэдтэй нь хүйс тэмтрэн устгасан Ромын жанжныг дурсаж үр хүүхэддээ өгч байсан хэрэг болой.

Харин хагас мянган жилийн дараа бүх зүйл өөрчлөгджээ. Ромд түрэн ирэх ард түмнүүд өөр хоорондоо олзлолдон булаалдаж, бие биеийг түрж шахах амой. Тэд эгэж буцах газаргүй бөгөөд гол мөрнийг гаталж, цайз бэхлэлтүүдийг давж үхэн хатан тэмүүлэхийн учир нь ромын хилийн шугамыг л давах л юм бол цаана нь энэ аугаа эзэнт гүрний нутагт аюул осолгүй амьдарч болох, бас ч сул чөлөөтэй нутаг их байсных юм. Харин араас нь Өмнөд Оросын тал нутгаас үй олон аймшигт овог аймгууд түрэн ирж буй. Араас нь гэзэг даран хөөх энэ их аюумшигт хүчийг тэд л ромчууд руу хөтлөн

авчирч байлаа. Гэтэл ромчууд нь Мариус, Сулла, аль эсвэл Цезарийн үеийнхээсээ огт өөр болж хэдийнээ төрөл арилжчихаад байлаа.

Хүн ардын ихээхэн найдлага тавин харж асан тухайн цаг үеийн их сэтгэгч, мэргэдийн ихэнх нь христ мөргөлтнүүд байлаа. Эрдэм боловсролыг өөртөө агуулж тээж асан Христийн нэг л бурхныг шүтэх илүү өндөр түвшний шашин нь эрдэм боловсролынхоо хүчээр хуучны Ромын хүүхдэрхүү гэнэн хонгор, онигоонд өгүүлдэгчлэн хөвсөргөн олон бурхдын ертөнцөөс хол илүү шинэ нөхцөлд таарч тохирч байв. Хуучны их гүрэн үеэ өнгөрөөсөн нь түүнийг авч явах шашин үгүй болж, чингэснээр ноёлж засаглах үндэс суурь байхгүй болсонтой холбоотой гэдэгт тэдгээр мэргэд огт эргэлзэхгүй байв. Бараг л мянган жилийн өмнөөс хүлцэн захирагдсан, дарлагдсан ард түмнүүдэд ямар үзэл санаа суулгах ёстой байв?

Сүмийн багш, эрх мэдэлтнүүд хийгээд Бага Ази, Умард Африк, Галлигийн хамба санваартнуудын хүсэн хүлээж байсан зүйл нь Ромын эзэнт гүрэнд христийн үзэл санааг соёолуулж ургуулах, чингэхдээ хүмүүний оюун ухаанд оршоор ирсэн хуучны харанхуй манан буданг сарниулж, Христийн цовдлуулан амиа алдсан тэрхүү загалмайн шинэ билэг тэмдгийн дор дэг журам, соёл боловсрол, нийгмийг хэвээр хадгалж үргэлжлүүлэх үүрэг зорилтыг тээж явах тийм л үзэл санааг бүрэлдүүлэх явдал байсан юм. Энэхүү гүн сүсэг, магад ч үгүй бага зэрэг гэнэн хонгор хүсэл мөрөөдлийн ертөнцөд нь харь ард түмнүүд эрээ цээргүй, өршөөл энэрэлгүйгээр халдан ирсэн бөгөөд харин тэднийг ийнхүү араас нь түлхэж хөөж, бүх юмыг орвонгоор нь эргүүлсэн, христ үзлээр жинхэнэ чөтгөрүүд бол хүннүчүүд байлаа. Аймшигт гай зовлон газар сайгүй нөмрөн ирэхийн цагт зүй нь хүн төрөлхтний аугаа өвийн хувьд улс түмний хүсэл мөрөөдөл байх учиртай их эзэнт гүрэн хэсэг бусаг болж задран христ бурхныг хүлцэж дагахаасаа наана буруу номт тамын ертөнцөд унах нь дээр мэт байжээ.

„Дайн тулаан, өлсгөлөн гуйланчлал, түйвээл сүйтгэл хаа сайгүй тохиолдож байна“ хэмээн Аугустинус бичиж байв. „Нэг гүрэн нөгөөгөө залгиж, газар дэлхий гуйвж дайвалзаж, зовлон түгшүүр, уур хилэн газар авч, хайр сэтгэл хөрж, муу муухай юмс дэлгэрч байна...“ хэмээжээ. Гэвч дараа нь огт санамсаргүй байтал эзлэн захирахыг санаархсан энэ дэлхийгээс салж одох шинэ эргэлтийн үе ирэв. „Дэлхийн төгсгөл ирж буй бол сэтгэл санаа хоргодоод байх хэрэггүй, зайлан одох хэрэгтэй...Дэлхийн төгсгөл хэдийчинээ ойртоно, төөрөгдөл төдийчинээ ихэсч, шударга бус явдал нэмэгдэж, итгэл үнэмшилгүй байдал гаарна...“

Ром-Христийн ертөнцийн хот, тосгодод орж ирээд хүннү нарын аяглаж аашлах нь зорьсон үйлээ гүйцэлдүүлээд эндээс дахин хэзээ ч эгэж харихгүй мэт ажээ. Тэд тохь тух эрж хүч түрж орж ирэхгүй. Байшин барилгад амьдарч суухыг хүсэхгүй. Тэд нэгэнт л

ялж дийлэгсэд юм болохоор хүн амьтны бодож ойлгож заншсан утгаар ноёлж захирах юм болов уу гэтэл тэгсэнгүй. Гэхдээ хүмүүсийг сайн муу, өндөр нам, хөгшин залуу хэмээн ялгаварлаж үзэхгүй болохоор хүмүүст гэсгээн цээрлүүлэгч бурхны шүүх мэт үзэгдэж байжээ. Тиймээс ч хүмүүс тэдний хамгийн алдарт хаан Аттилаг тэнгэрийн ташуур хэмээн нэрийдсэн агаад нийтийн ухамсарт түүнийг ийнхүү дээд тэнгэрийн гар хөл гэх санаа бодол бүрэлдэн тогтжээ.

Эрт урьдын цагт усан галав юүлсэн гэдэг бол одоо хүннүүд гол цөм нь болсон үй түмэн морьтон ард түмний үер нөмрөн ирсэн хэрэг бөгөөд хүмүүн төрөлхтнийг ийнхүү хөнөөн устгаж буй нь нүглийнх нь тулам дүүрснээс залхаалт гэсгээл ирж буй хэрэг хэмээн сэтгэж байв. Ромын эзэн хаадын ноёрхлын дөрвөн зууны дараа хүмүүсийн дэндүү сайн мэдэх болсон буруу номт ромчуудын нүгэл хилэнц, христ мөргөлд шинээр орсон хэдий ч оюун санаа нь сулбагар залхуугийн эрхээр буруу номт бие махбодь нь нүглээс ангид амьдрах их хүсэл эрмэлзэлд нь саад тотгор болж байсан нүгэл хилэнц бий билээ. Нум сум агсаж, бугуйл ганзаглаж шавилхан жижиг морьд хүлэглэсэн өшөө хорслын тэдгээр сахиулсан тэнгэр огт өөр ертөнц, ер доод тивийн амьтас мэт харагдаж байжээ.

„Тэд газар сайгүй хэсэг бүлгээрээ хэрцгий догшин авирлаж газар сайгүй хэрэн явах агаад тэдэнд автагдагсад айж сүрдсэнээсээ болоод тулалдахаасаа аль өмнө л газар тэврэн хөсөр унах билээ“ хэмээн өөрийгөө Паулинос хэмээсэн нэгэн хувраг шүлэгчийн 400 орчим оны үед Өмнөд Францад бүтээгдсэн болов уу гэмээр сургааль шүлэгт өгүүлэх бөгөөд хүннүүдийн талаар түгэж тархсан мухар сүсгийн айдаст ташуур өгч, хүннүүдийг хүмүүн төрөлтөн бус, чөтгөр шулам хэмээн сүрдэж айх сэтгэл нь эсэргүүцэн тулах аливаа зориг эрмэлзлийг мохоож байлаа. „Хэрэв бид биеийг чандлан барьж, ухаалгаар бодож сэтгэн, ухаан бодол маань мунхагийн харанхуйгаас салж, зүрх сэтгэл маань христ бурхны өмнө нээгдэн, хуучны нүгэл хилэнцийн хүнд ачаанаас салж чадах л юм бол христ бурхны шавь нар хүчирхийлэлд өртөхгүй, хаа холын алс дорнын тэрхүү морьтнуудын нум сум биднийг нэвт харвахгүйсан“.

Үүнээс илүү тодорхой хэлэх аргагүй бөгөөд хүннү нар хүчээр хэчнээн давуу байсан нь хойч үеийн бидэнд эндээс тодорхой байна. Хүчээр эн зэрэгцэхүйц дайсныг бол хүн хэзээ ч гэсгээн цээрлүүлэх шүүгч, хувь тавилангийн эрхшээл, бурхны зарлигийг гүйцэтгэгч гэх мэтээр үзэхгүй бөлгөө. Ийн хүчээр хамаагүй дутуугийн учир тулалдааны аз од эргээгүйсэн бол мөнөөхөн Паулинос ихээхэн гутрангуйгаар дараах мөрүүдийг бичихгүй байсан биз. „Илд сэлэм ч, өлсгөлөн зүүдүүр ч, өвчин зовлон ч, ер нь юу ч тус болсонгүй. Бид ямар л байсан тэр хэвээрээ байна. Нөгөө л нүгэл хилэнцийн боолчлолд байсан хэвээрээ, бидний гэм бурууд эцэс төгсгөл гэж алга“ хэмээжүхүй.

Энэ бол сүсэгтэн хүний уруу дорой сэтгэл санаа, гэмшил билээ. Гэвч хүн болгон л бурханд сүсэглээд байсангүй. Олон хүн шинэ бурханд дайсагнаж байлаа. Тэдэнтэй нэр нь үл мэдэгдэх нэгэн найрагч дуу хоолойгоо нэгтгэж, 415 онд бурхны адистидийн /бошгийн/ тухай нэгэн дуу зохиожээ. Уг дуу нь гашуун хошигнол дүүрэн агаад бидэнд Брехтийг өөрийн эрхгүй санагдуулах учир нь хожим зарим нэг хүн иш татаж асан мөнөөхөн бурхны бошиг нь тэр үедээ мэдээж ойлгохуйяа бэрх зүйл байв.

„Хөөрхий нялх балчир хүүхдүүд ямар буруутай юм бэ? Ахар богино амьдрал нь муу юм амсах амжил өгөөгүй охил бүсгүйчүүд ямар муу үйл хийсэн юм бэ? Гал мэсийн аюул бурхны сүмийг яагаад түйвээн сүйтгэв? Ариун мөргөлийн сангийн бойпор юуны учир бузарлагдах болов? Эрд гараагүй хонгор охидын ариун онгон биеийг ч, бурханд бие сэтгэлээ харамгүй зориулсан бэлэвсэн эхнэрүүдийг ч сахил санваар нь өмгөөлж хамгаалсангүй. Зэлүүд газрын агуйд даяанчлан сууж бурханд өдөр шөнөгүй наманчлан залбирагсад ч ялгаагүй эгэл нүгэлт хүмүүний адилаар хүчирхийлэлд өртөн амиа алдаж байна. Мөнөөх догшин шуурга сайн муу ялгалгүй бүх юмыг хаман авч явлаа. Хатуу ширүүн цохилтод өртөж, гал усны гашуун зовлонд унаж гар хөл хүлээстэй энэлэн шаналан байна...“

Энэ бүхэн дэлхий ертөнцийг хамарсан айдас хүйдсийн давалгааны талаарх цөөн бүлэг гэрч агаад тухайн үеийн ертөнц гэдэг нь Ромын эзэнт гүрэн ба түүнийг нөмрөн ирсэн ухаарч төсөөлөхийн аргагүй алс холын оньсого мэт үл ойлгогдох, түнэр харанхуйн ертөнц хоёр л байсан юм. Тиймийн учир нөгөө тал огт чимээгүй, таг дуугүй. Ялж дийллээ ч гэх юм уу, эсвэл үгүй худлаа гэнээ гэх мэдээ занги ч, өнөө бидний үед бол ямагт хатуу ширүүн өрнөх аливаа дайн байлдааны үйл явдал бидний өдөр тутмын нэгэн хэвийн амьдралд хүч түрэн орж ирдгийн адил тийм элдэв мэдээ сурвалжлага, маргаан няцаалт, гоёчилж чимсэн мэдээ сэлт ч тэр үед байсангүй. Юу болж буйг хэн ч ойлгож ухаарч чадахгүй байв. Мэргэдүүд эртний онго шүтээнт зөнч нарын үгсийг иш татаж „Дэлхий ертөнц уруудан доройтож өтөл насандаа ойртлоо (Аугустинус)“. “Сүсэг бишрэлдээ гуйвшгүй үнэнч, бат нот итгэл үнэмшилтнүүдийн хувьд ертөнцийн нөгөө тал бол энэ талын нэгэн адил бодитой агаад магад ч үгүй бүр илүү үнэн бодитой ч байж болно. Харин өчүүхэн ард түмэн нийтээрээ хүмүүн бидний хүсэл зоригт үл захирагдах тэрхүү үхлийн аюулын амьсгаа давагдашгүй их айдас хүйдэст автан чичирч сууна. Бүхий л биений цус царцаж, толгойтой үс өрвийн босч, зөвхөн л „бидэнд хэзээ нэгэн цагт тохиолдох айсуу цагийн сайн сайхан энэ цагийн зовлон зүдүүртэй зүйрлэшгүй их“ хэмээн сэтгэлээ тайвшруулан бувтнаж сууна“ (Аугустинус) хэмээж байв.

Зовлонгийн түргэн, жаргалын удаан /зовлонгийн төгсгөл нь эцэс төгсгөлгүй аюумшгаас дээр/ гэх үг яриа нь нэг их урт настай биш юм. Цөс ихт төрхгүй эр, Пруссийн хошууч, насаараа сайн дурын дайчин явсан Шилл францчуудтай байлдахын өмнөхөн 1809 онд Эльба мөрний дээрх Арнебүргт байхдаа сайн дурын партизан цэрэгтээ

хандаж энэ үгийг хэлсэн байж таарна. Ийнхүү түүх судлаачдын хэзээнээс инагш тайлахаар оролдсоор ирсэн түүхийн нэгэн оньсого мэт шийдэл буюу тоо тоймгүй олон хүннү нар халдан ирэхийн өмнө гоотуудын хаан Эрманрих амиа хорлосны учрыг тайлах хожмын нэгэн гарамгай герман гэрч олдсон хэрэг.

Нэгэн чухал дохио болсон эл үйл явдлын талаар хуучны эх сурвалжуудын өгүүлэмж илэрхий ядмаг агаад өөрөө офицер, тэгээд ч хүннүчүүдтэй дайтаж явсан нь эргэлзээгүй, тэдний талаарх цэргийн дээд удирдлагын мэдээ сэлтэд ойр байсны хувиар Аммианус Марчеллинуc бол мэдээж хамгийн найдвартай нэр хүнд бүхий эх сурвалж болно.

„Хүннү нар дорнод гоотуудтай хаяа хатган суудаг алануудын нутагт цөмрөн орж, тэднийг олноор нь хядах үед үлдсэн аланууд ялагчидтай холбоо байгуулж амь хэлтрэхээр шийджээ. Хүннү нар алануудын тусламжтайгаар улам зоригжиж гэнэтийн эрчимтэй цохилтоор Эрманрихийн ил задгай уудам хязгаар нутагт цөмрөн оржээ. Эрманрих бол гарамгай дайчин, өдий төдий эрэлхэг баатарлаг үйлээрээ хөрш зэргэлдээ айл аймгуудыг айлган чичрүүлсэн хаан байсан билээ. Тэрбээр хүннү нар хийгээд алануудын нэгдсэн дайралтыг удтал эсэргүүцэн тэмцсэн юм. Гэвч гэнэт нөмрөн ирсэн энэхүү гай зовлонгийн асар их хүчний өмнө тэрбээр хүчин мөхөсдөж, дараалан ирэх дам цуу яриа, сураг чимээнээс угтан буй үйл тавилан хэчнээн хэцүү зовлонтой гэдгийг мэдэрч ойлгоод сайн дураар үхлийг сонгож заналхийлэн буй гай гамшгаас урьтахаар шийджээ.“

Нэгэн дайчин баатар хаан алдар суугаа дуурсгасан урт удаан амьдралынхаа эцэст Германы овог аймгуудын эрх ашгийн төлөө онцгой гавьяа байгуулан амиа золиосолж нөгөө ертөнцөд валькирууд (*Валькирууд нь умард германчуудын шүтлэг ёсоор ялалт хийгээд ялагдлын аль нэгийг авчрагч, амь эрсдсэн баатруудыг сүүлчийн газарт нь хүргэгч охин тэнгэрүүд болой. Орч.*) хийгээд эрт урьдын эрэлхэг баатруудын хамтаар элбэг тансаг идээ ундаанд умбаж эрхэмсэг оршихуйн тавилан эдлэх заяа тохиосон хэдий ч сүүлчийн тулаанаа хийж зүрхлээгүй нь Аммиануст өөрт нь ч нэг л ойлгомжгүй, хачин санагдаж байсан болов уу гэмээр мэдээ сэлтийг он цагийг дамнуулан илгээсэн байдаг.

Тэрхүү ухаант гэрэг хүнд төрсөн дээрх эвгүй сэтгэгдлийг ойлгохын тулд Эрманрихийн тухай мэдэгдэж буй бага сага зүйлийг иш татах хэрэгтэй болно. Эрманрих бол амальчуудын эрт урьдын үлгэр домгийн цаг үеэс эхээ авсан гоотын хаадын удмын хүн бөгөөд энэхүү хаадын дотор Эрманрихээс гадна ард түмнүүдийн их нүүдлийн үед алдар суугаа хамгийн ихээр дуурсгасан Их Теодорих, Винитариус болон бусад олон хаад байсан юм.

Сүүлд амелунгууд хэмээн нэршсэн амальчууд Эрманрихээр толгойлуулан наад зах нь арав дахь үе дээрээ острогоотуудыг захирч иржээ. Острогоотуудыг хялбарчилж остгоотууд хэмээсэн бөгөөд „остро“ гэдэг үг нь вестгоотуудыг нэрлэж заншсан „визи” гэдэг үгийн нэгэн адил ертөнцийн зүг чигтэй ямар ч хамаагүй бололтой байдаг. Эдгээр засаглагчдаас Гаут ч, Хүлмүл ч, эсвэл Хисарна, ер нь өөр бусад хэн нь ч ялгаагүй захирч байсан овог аймгуудаа жинхэнэ гүрний хэмжээнд аваачсан нь үгүй ажээ. Ийнхүү аль дивангарын элэнц хуланцын тэр цаг үед хүний хүч чадлаас хол давсан гэж үзэж болох асар их хүч чармайлтыг гагц Эрманрих л гаргаж чаджээ. Тэрбээр эхлээд дорнод гоотын овог аймгууд хийгээд өөрийнхөө захирч байсан нутаг оронтой айл аймаг хөршүүдээ эрхэндээ оруулсан төдийгүй бас слав, финн, угор, удалгүй балтийн ард түмнүүдийг дагуулаад христийн тооллын дөрөвдүгээр зууны дундуур урьд нь ямар ч герман хүний эзэрхийлэн хурааж чадаагүй их гүрнийг захиран суух болжээ. Түүний захирсан улсын нутаг Финнийн булангаас Хар тэнгис хүртэлх газар орныг дамнан оршиж байв. Мөн өнөөгийн Орос орны Европын хэсгийн ихэнхийг байлдан дагуулсан байлаа.

Балтийн тэнгисээс Крым хүртэлх германчуудын эзэнт гүрнийг, зургаан зуун жил шахмын дараа тунхагласан германы ард түмний амьдрах орон зай буюу Хитлэрийн тэгтлээ их хүсч мөрөөдсөн мянган жилийн настай тэрхүү эзэнт гүрнийг Эрманрих танк, их буугүй, элдэв хэл амгүйгээр хэдхэн арван жилээр ч атугай цогцлуулж чадсан амой. Эрманрих өөрөө бол бараг зуу насалсан, зарим эх сурвалжаар зуун арав хүрсэн гэдэгт заавал итгэх албагүй л дээ.

□□□□□□ □□□□□□ □□□□ □□□□□
(□□□□□□□□□□□□ □□□□)

□□□□□□

□ү□□үү□□

□□□□□□□□

□□□□□□□□□□

□□□□□□□□

□□□ □□ **y**□ □□□□□□□□ □□□□

□□□□□□□□□□

□□□□□**y**□□

□□□□□□□□□□

376 □□□ □□□ □**e**□□□□**e**□

□□□□□□□□□□

□□□□□□□□□□

□**y**□□**y** □□□□□ □□□□ □□□□□□□□□□□□

□□□□□□□□

□□**y**□□□□□□

□□□□□□□□

□□□□□□□□ □□□□□□

□□□□□□ □□□□□□ □□□□

□□□□□□□□□□□□


□□ □□□□□□□□□□

454-526

□□□□□□□□□□

□□□□□□□□□□ □**yy**□**y**□□**y**□

□□□□□□□□□□



Гэхдээ энэ өтгөс үнэхээр долдоон голтой нэгэн байсан байж таарах бөгөөд учир нь энэ нь түүний ийн нөгөө ертөнц рүү сайн дураар одсон оньсого мэт явдлыг германчуудын хэрхэн тайлбарладагт онцгой үүрэгтэй агаад ер нь энэ явдалд Эрманрихийн амьдрал үйлийг мэддэг хэн бугай ч итгэж чаддаггүй юм. Дайн байлдааны дунд өсч бойжин энэ л замаар анхны эзэнт гүрнээ байгуулсан хаан эзэн, цэргийн жанжин энэ хүн илд сэлмээ хүн нарын цээж рүү чиглүүлэхийн оронд өөр рүүгээ хандуулна гэж байх уу? Хүннү нарын эсрэг этгээдийн хувиар тэрбээр „хүннү нарын аюумшигт үйлийн талаарх элдэв мэдээ яриа“-г тэртэй тэргүй мэдэх ёстой байсны учир харин ч сөрөн босч эрэлхэгээр дайтан амиа өргөх байсан бус уу? Нөмрөн айсуу хүннүчүүдийн их аюулын чимээ нэгэнт холын холд тарж, тэдний аллага хядлага хүн ардад аюумшигт учруулж байсны учир их хааныхаа ийм төгсгөлд хэн ч итгэхгүй байсан болой. Их хааных нь үхэл германчуудын хувьд өөр л учир шалтгаантай байсан байж таарна. Баттай нотолгоогүй хэдий ч хаан эзнийхээ үйлийг зөвтгөдөг ард түмнийх нь үг яриаг түүхчид үлгэр домог хэмээдэг. Домог, хууч ярианы аль аль нь аливаа ард түмний хувьд хоосон зайг дүүргэж, хэрэгцээг нь хангаж байдаг. Гэхдээ цагаан толбыг тодруулж, хэрэгцээг хангахын тулд домог хууч нь ор үндэсгүй зүйл байж болохгүй билээ. Үлгэрийг бол хэн ч хүүрнэж чадах шүү дээ. Тодорхой үүрэг зорилгыг биелүүлэх ёстой юм нь хүмүүст итгэгдэхээр, ядаж л тодорхой хэд хэдэн баримттай зохицолдож байх ёстой.

Хүчирхэг эзэн хаан Эрманрих хэмээгч гарамгай бодгалийн тухай үүссэн домог яриа нь хүннү нарыг авч үзэхэд ихээхэн тустай. Дайн байлдааны тухай түүхийн ямар ч баримт мэдээ сэлтгүй үе буюу хүннүчүүд, гоотуудын анхны тулгаралтын талаар бидэнд зөвхөн эртний зохиогчдын зарим товч мэдээ буй. Германы баатарлаг туульсууд дөрөвдүгээр зууны тэрхүү аварга үйл явдлын хажуугаар өнгөрөөгүй байна. Эрманрихийн тухай шүлэглэсэн бүтээл бидэнд аман зохиолын хэлбэрээр умардын хувилбараар дамжин ирсэн нь Эрманрихийн ордонд сууж асан Сунильда гэгч дагаар орсон Розомон гэх аймгаас гаралтай залуу гоо бүсгүйн тухай өгүүлнэ. Түүний авааль нөхөр гоотын хааны ордонд розомонуудын байнгын элч маягтай сууж байсан агаад Эрманрих розомонуудыг дотночлон үзэж буйн тэмдэг болгон түүнийг хааны зарлиг гүйцэтгэгчээр буцаан явуулсан бөгөөд энэ хооронд Сунильда хааны ордонд элдэв хавчилга хаалтгүй сууж, хааны нойрсох танхимд айж ичих юмгүй хөл тавьдаг байжээ. Учир нь Эрманрих бусад ард түмнүүдийн хувьд хүссэн юмаа л хийдгийн адил хүүхнүүдтэй ч чингэх бүлгээ. Тэр бол хаан эзний учир хүссэн юмаа авч байж л сална.

Сунильда хүүхний тухай Свонхильдийн түүхэнд элдэв домог хууч, тайлбарын бичвэрүүд бий бөгөөд тэдгээрт Эрманрих өөрийн охиныг ч хайрлаж байгаагүй, учир нь тэр нь нэгэн нууц амраг татвар эмээс төрсөн хэмээн өгүүлдэг. Свонхильдийн түүхэнд нэрийг нь өөрөөр бичсэн тэрхүү Сунильда нь гоо үзэсгэлэн төгсөөр барахгүй ухаалаг, бас ч заль мэхтэй ч нэгэн байсан гэх. Тэрээр хаанд шадарлахын учир ойртож дотносох цаг мөчийг ашиглан түүнийг туршиж тагнуулддаг байсан ажээ. Эзэн хааны зөвлөхүүдтэйгээ ярьсан яриаг нууцаар чагнан тогтоож аваад нарийн ширийнийг нь тайлж төрөлх ард түмнийхээ хэрэгт ашиглаж байсан агаад тэд нь ийм байдлаар аль эрт бэлтгэсэн бослогоо эхлэх таатай цагийг олж мэджээ.

Гэвч розомончуудын хуйвалдаан Эрманрихийн их гүрэнд гарч байсан бусад олон бослогын нэгэн адилаар дарагдаж, хаан эзний хувиар ч бус, бас эр хүний хувьд сэтгэл ихэд гутарсан Эрманрих гагцхүү өөрийг нь туршин тагнаж, итгэл олохын тулд л биеэ тушаасан үзэсгэлэнт Сунильдаг онц харгисаар цаазалжээ. Залуу бүсгүйг чармаа нүцэглэж дөрвөн догшин азраганд тохсон эмээлийн бүүрэгнээс дөрвөн мөчөөр нь тэлж уяжээ. Тэгээд л азрагануудыг ташуурдсанд дөрвөн тийш огло харайн азгүй муу хүүхнийг Эрманрих хийгээд ордныхны нүдэн дээр тасчин хаяжээ.

Энэ явдал яг л үлгэрийн юм шиг, итгэмээргүй санагдах авч, цаазын энэ арга нь өөрөө эл өгүүлэл түүхэн үндэстэй, үйл явдал үнэн бодитойн гэрч болой. Учир нь энэхүү түүхийг бусад домог яриагаар нэмж тодруулан бидэнд хүргэсэн хүн нь түүхч Иорданес юм. Тэрбээр тухайн үедээ сүүлд меровингүүдийн *(Манай эрэний тавдугаар зуунд тогтнож асан Франкийн анхны хааны удмынхан, овгийг үндэслэгч Меровея хэмээгчийн нэрээр нэрлэгдсэн, гол төлөөлөгч нь Хлодвиг болно. Орч.)* газар хатан хаан Брунехаут зэрэг урван тэрсэлсэн сайн язгуурт хүүхнүүд эн тэргүүнд ийм л байдлаар үхлийн хаалгыг татах болно гэдгийг мэдэх ямар ч боломжгүй. Энэхүү цаазын харгис аргыг бурбонууд франкуудаас уламжлан авч арван наймдугаар зуунд олны хайрыг татсан XV Людовикийг чичлүүр хутгаар хөнгөн шархдуулсных нь төлөө Дамьен хэмээгч золгүй амьтныг мөн ийм байдлаар тамлан зовоож нөгөө ертөнцөд илгээсэн билээ

Свонхильдийн дурдсан Сунильда нь ийнхүү тэр үедээ мэдээж хэрэг олны анхаарал ихэд татсан, гэхдээ гоотуудын ерөөс хэрэглэж заншаагүй аргаар цаазлагджээ. Учир гэвэл уул бүсгүй хаан эзний гэр бүлийн гэхээр, ойр дотнын хүрээний хүн байсан агаад ийн урвагчийн үхлээр үхэж, чингэхдээ германчуудын хувьд ариун гэгээн амьтан гэгдэж асан агт морины хөлд үрэгдсэн юм. Харин розомончууд түүний өшөөг авахаар шийджээ. Тэд хэдийгээр дарлалын гинжинд дахин орсон ч нэр төрөө хамгаалахаар шийджээ. Сунильдагийн ах нар Сарус, Аммиус хоёр Сунильдагийн авааль нөхөр байсан бололтой байдаг өөр нэг хүний хамтаар Эрманрихийг зорьжээ. Замдаа тэр хүн сэтгэлээ нээж Сунильда өөрөөс нь салж Эрманрихтэй дэр нийлүүлсэн

явдлыг эхлээд тэвчиж, дараа нь бүр өөгшүүлж байснаа ярихаар нь ихэд уурсаж хилэгнэсэн ах дүү хоёр нэгэнтээ нэр төрөө уландаа гишгэсэн, бас урваж тэрслэхээс буцахгүй гэж үзсэн сайх өчүүхэн эрийг алжээ.

Дараа нь тэд ордонд нэвтрэн ороод элчийн маягаар зүсээ хувиргаж (энэ тухайд тайлбарууд хоорондоо зөрчилддөг байна) Эрманрихад ойртож очоод нуусан зэвсгээрээ хүнд шархдуулсан ажээ. Иорданесийн бичсэнээр эзэн хаан нэг зуун арван насны сүүдэр зэрэгцсэн ахуйдаа эрэмдэг зэрэмдэг амьтан мэт болж зэвсэг агсаж ард түмнээ удирдан хүннү нарын аюулыг сөрөн довтлох чадалгүй болсон байв. Тиймээс амальчуудын удмаас шинэ эрэлхэг зоригтой жанжин идэр залуу хааныг гарган ирж замыг нь засах үүднээс хаан сайн дураар үхлийг сонгосон гэх.

Херодотын үеэс эхлүүлээд бид сонин хачин, хийсвэр, ер бус, аль эсвэл бүр оргүй худал гэх зэрэг маш олон янзын түүх, домог, хууч, дам яриа уншсан нь мэдээж. Хүннүчүүдтэй байлдахын өмнөхөн Эрманрих хааны хүнд шархадсан тухай өгүүлэл нь үнэхээр Сунильдатай холбоотой юу, аль эсвэл өөр учир шалтгаан байна уу гэх мэт олон зөрчил агуулж буй. Олон улс түмнийг хураан захирсан хүчирхэг эзэн, хаан хүний эргэн тойрон олон алуурчин эргэлдэж байдаг нь ёс билээ. Нөгөө ертөнцөд ийн одсоны тайлагдашгүй учир явдал нь хүннү нарын аюул гамшиг улс түмнүүд, ард иргэд, лам хувраг, эрдэмтэн мэргэдийг дэндүү их айлган цочоож болох ч дайн тулаанд хатуужсан их хааныг чингэж чадахгүй нь тодорхой.

Херманн Шнайдер эртний германы талаарх судалгаандаа Эрманрихийн домгийг маш эртнийх хэмээн тодорхойлоод хэтэрхий „ардын аман ярианы шинж“-тэй хэмээжээ. “Энэ домог Эрманрихийн их гүрэн хийгээд нэгэн дарлагдсан овгийн бослого дэгдээгээд амжилт олоогүй явдлыг л бидэнд өгүүлж байна. Өшөө хорсолдоо шатсан ах дүү нар Эрманрихийг охин дүүгээ хороосон алуурчин хэмээгээд зогсохгүй мөн улс төрийн дайснаа гэж үзсэн ажээ. Энэхүү дэндүү ардач гэхээр учир шалтгааныг бид хуучирчээ гэж үзнэ. Германы бүх домог туульсын баатар гоотуудын их хааны хар бараан дүр төрх бол харь герман овог аймгуудыг эзлэн захирсан гоотуудын эзэн эрх ноёрхож асан үеийн Эрманрихийн улс төрийн дайснуудынх нь бүтээсэн дүр зураг болой”. хэмээсэн байна.

4.

□□□□ □□□□ □□□□ □□□□

Манай зууны дундуур Финландаас Хар тэнгис хүрсэн фронт (*Дэлхийн II дайны үеийн Германы фронтыг хэлжээ.Орч.*) хэрхэн нурж унасныг бид мэднэ. Энэ фронт нурж унах нь зүй ёсны хэрэг байв. Энэ фронт 1942-1943 онд Зөвлөлтийн давшилт,

улаан армийн хүчтэй цохилтын улмаас нурж унасан билээ. 42-43 онд биш гэхэд тав, зургаан жилийн дараа ялгаагүй л нэг их байлдаантай байлдаангүй нурж унах байсан нь тодорхой байсан. Учир шалтгаан нь энгийн, энэ фронт хэт урт, бас тэгээд маш таагүй цаг уур бүхий газар нутгийг дамнан тогтож байсан юм.

Тэгвэл Эрманрих яг ийм фронтыг Финландаас Хар тэнгис хүртэл тогтоон барьж байсан билээ. Эрманрихийн фронт бол гоотуудаас зургаан зуун жилийн дараа тэнд очсон германууд шиг яг тийм ямар ч нүх сүв, зай завсаргүй бус, харин оочин цоочин, арал маягтай, эзлэн дагуулсан нутгийн үндэстэн ястанд түшиглэсэн фронт байсан юм. Эрманрих өтөлж, бүр зарим нэгийнх нь үздэгээр зөнөглөхийн цагт үүрэглэж байсан тал нутгийн аварга хүч сэрч, Дон мөрний чанадад мал сүргээ адуулж явсан хүннү нар суусан газраасаа дэрхийн босч хөдөлжээ.

Сэргийлэн хамгаалах дохио өгөх тоног төхөөрөг гэх юм тэр үед байсангүй, зөвхөн дам цуу яриа л амнаас ам дамжин тархаж байлаа. Хүннү нарын талаарх аюумшигт мэдээ хурдан хүлэг морины хурдаар дам ярианаас ч хурдан, худалдаачнаас худалдаачинд дамждаг мэдээ зангиас ч түргэн таржээ. Хүннүчүүд ийм гавшгай хөдөлж, энэ тухай мэдээ ийн хурдан тарсны учир нь хүннү нар өлсөлөнд автсан явдал л байлаа. 374-өөс 375 онд шилжих өвөл цаг тун хатуурч хээр тал нутагт хавар орой болтол цас хайлсангүй. Газар тэс хөлдүү, мал сүрэг өвс тэжээлгүй, шинэ гарсан төл толгой дараалан үхэж, хүмүүс үхсэн малын мах идэж л амь зогоож байжээ.

Энэхүү тун чухал, тов тодорхой мэдээг Аугуст хаанаас эхэлж 410 онд Ром унаж буйгаар төгсдөг, Ромын их эзэнт гүрний мөхлийг онго шүтээний бурхдаас нүүр буруулснаас болсон хэмээн тайлбарладаг зургаан боть *Nea Historia* (*Эртний Гэрэг-Ромын хожмын үеийн Гэрэгийн түүхч Зосимос тавдугаар зууны сүүлийн хагас, зургаадугаар зууны эхээр онго шүтээний үзэл санаа, өнгө аяс ихээхэн шингэсэн Nea Historia* буюу *Шинэ түүх хэмээх түүхийн томоохон бүтээл туурвижээ.Орч.*) хэмээх бүтээлээрээ гэрэгийн түүхч Зосимос бидэнд өгч буй. Хүннү нарын халдаар ирснийг Зосимос мэдээж тал нутагт өлсгөлөн болсонтой холбон тайлбарладаг агаад өлсгөлөн нь хүн амьтныг ямар ч гарцгүй байдалд оруулдагийг нэг их ойлгож ядах юмгүй. Өнөөдөр ч гэсэн өлсч зовсон нүүдэлчин аймгууд наад зах нь ус байгаа газар руу тэмүүлдэг. Ган гачиг тохиолдох үед Бразилийн зүүн хойд нутгийн суугуул тариачид өөр газар нүүж буудаг агаад өнгөрсөн зуунд тэндхийн тариалангийн эзэдтэй цус урсган тулалдаж байлаа.

Тэгэхээр хүннү нар ямар ч сонголтгүй, мөн цаг алдаж болохгүй байжээ. Энэ нь л чухамдаа тэдний ийнхүү гэв гэнэт эрс ширүүн халдан ирсний тайлбар агаад учир нь өвс тэжээлгүй тэсгим хүйтэн тал нутгийг тэд ийнхүү дуртайяа хаян одсон ажээ.

Зосимос бичихдээ „Тэр үед зэрлэгүүд Истер (Дунай мөрөн) мөрний чанадад суух скифүүдийг дайрчээ. Ингээд урьд өмнө огт мэдэгдэж танигдаагүй овог аймаг гэв гэнэт гарч иржээ. Энэ аймгийг хүннү нар хэмээн нэрлэх аж. Энэ нэр скифийн хаанаас эх авсан эсэх нь тодорхойгүй, Дунай мөрнөөс дорно тийш аж төрдөг бич дүртэй, ихээхэн дайнч ард түмэн мөн эсэх нь ч бүү мэд. Эдгээр хүннү нар чухам тэр үед л Азиас Европ руу ирж, Маэогийн (Азовын тэнгис) балчиг намаг газрын цаана амар тайван сууж байсан ч байж магад. Тана (Дон мөрөн) голын урсгалаар түрэгдэн ирсэн элс шороо хуримтлагдсаар тэрхүү намаг бүхий хошуу газраар хүзүүвч (өнөөгийн Керчийн хүзүүвч) үүссэнээр хүннүчүүдэд Европ руу нэвтрэх боломж олгожээ

Ямар ч болов тэд морь мал, эхнэр хүүхдийн хамтаар авч явж болох аль байдаг хөрөнгө хогшлоо тээсээр Истер мөрний газар амьдрах скифүүдэд (остгоотууд) халдан довтолжээ. Гэхдээ хүннү нар скифүүдтэй явганаар зууралдан тулалдсангүй, яагаад гэвэл тэд мориноос хэзээ ч буудаггүй учир газар буухаар ийн үзэлцэж чадахгүй байсан биз. Тэд ихэнх цагаа морины нуруун дээр өнгөрүүлж, унтаж, ууж идэж, тулааны цагт тун чадамгай гэнэт дайрах ажээ. Тэд скифүүдийн (гоотуудын) давшилтаас чадварлаг зайлсхийх агаад харин жигүүрээсээ үүл мэт нүүгэлтсэн суман мөндөр буулгаж, дайснаа цусан далайд умбуулах ажгуу. Үүнийгээ хэдэн удаа давтахад л скифүүдийн амь гарсан нэг нь унасан газар угаасан усаа орхихоос аргагүй болж ийн хүннү нарт тавьж өгөв“ хэмээжээ.

Германы остгоотуудыг скифүүд хэмээн нэрлэж буй нь эртний түүхчдийн хэзээний уужим сэтгэлийг мэдэхийн учир биднийг үл гайхуулна. Амьдрал өөрөө шаардаад ирэхээр л тэд зэрлэг овог аймгуудыг өөр хооронд нь ялгаж сурсан билээ. Өөр бусдаар бол остгоотуудыг хүннүчүүдтэй адилсгасанд дайрч доромжилсон зүйл үгүй бөгөөд эртний гэрэгүүд Өмнөд Оросын скифүүдийг нэг их ухаалаг хүмүүс гэж үздэггүй байсан агаад иймийн учир удалгүй Афин болон гэрэгийн бусад хотуудад (Гэрэгийн хотууд Крымийн хойг, Хар тэнгисийн умар этгээдэд ч байсан) цагдаа ажиллуулах болсон ажээ. Гэвч он цагийн уртад бүх зэрлэг овог аймгуудыг нийтэд нь скиф хэмээн хочлох нь бусад иймэрхүү үнэлэлт дүгнэлтийн нэгэн адил буруу зүйл гэдэг нь нотлогджээ. Өдөр тутмын хэрэглээний хийгээд гоёл чимэглэлийн зүйлс, археологийн олдворууд, арилжаа наймааны бараа таваараас бидний гайгүй мэдэх скифүүдийн урлан бүтээсэн эд өлгийн зүйл нь хөгшин Европын дэлхийд гайхуулахаар хамгийн сэтгэл татам, хамгийн сонин урлагт хамаарна. Тийм ч учраас зөвлөлтийн хөрс судлаачид скифийн олдворуудыг эрж хайхад ихээхэн хүчин чармайлт гаргасан юм. Тэр бүхнийг Хар тэнгисийн умард этгээдэд гэрэгүүдийн үр тарианы сан болсон хар шороот нутаг хөрсөн дороо агуулж байв. Энэ бол Оросын анхны төр улс үүссэн нутаг болох

тул судалгааны болон археологийн кампанит ажил үр дүнгээ өгчээ гэж өнөө дүгнэж болно.

Амгалан тайван амьдарч байсан хүннү нар гэнэт л энэхүү Гэрэг-Скифийн соёлын хүрээний газар орныг хөндлөн гулд туулан өрнө зүг тэмүүлсэн бөлгөө. Остгоотууд эхлээд Кубаниас өмнө тийш орших уулсын орон руу дайжихын зэрэгцээ бас Крым дэх Таврийн уул нуруудын зүг зугтан зайлсан агаад тэдний ул мөрийг олон зууны дараа олж тогтоосон байна. Остгоотуудын өөр нэг хэсэг нь Эрманрихийг үхсэний дараа ч эсэргүүцлээ тууштай үргэлжлүүлж, Винитариус, эсвэл Витимирич ч гэх хааны удирдлага дор тэмцэж байсан ба тэр нь амаль хүн, гэхдээ Эрманрихийн хүү биш (Өөр угийн бичиг байхгүйн учир Иорданесын хийсэн амальчуудын ургийн бичигт итгэхээс аргагүй) юм.

Энэ дайн тулаан гоотуудын хувьд ер бусын зэрлэг ширүүн тэмцэл байв. Хүннү нар тэдний урьд өмнө нь байлдаж дадсан дайснуудаас нь огт өөр хүмүүс байв. Хүннү нар хүн амьтныг олзолж аваад золиосны мөнгөөр солих, аль эсвэл боол болгон зарах боломжтой байсан хэдий ч чингэхгүй байжээ. Тэд эмэгтэйчүүдийг ч, хүүхдийг ч өршөөн хэлтрүүлэхгүй агаад зөвхөн хүйс тэмтрэн устгахын л дон туссан мэт байсан нь гоотуудын хувьд тайлагдашгүй оньсого мэт байсны учир бүр ч их аюумшигт автагджээ. Хүннү нар ходоод хоосны улмаас өлөн хоосон байлдаж явсан учир аль нэг улс орныг байлдан эзлэх нь л чухал болохоос тулалдаанд амиа алдана уу, эсвэл өлбөрч үхнэ үү гэдэг нь тэдний хувьд ямар ч ялгаагүй байсныг гоотуудад хэн тайлбарлах билээ!. Дайн тулаан нь хүннүчүүдэд наад зах нь нүүдэлчний соргог нүд хармагцаа л ихэд таалж сэтгэл татагдах тийм газар орныг эзэлж авах ховор боломж олгож байжээ.

Тэд хуучны аргаар байлддаг, хаад ноёд нь байлдаан тулааны бужигнаан дунд явдаг байсан агаад өөрөөр ч байх аргагүй байсан нь тодорхой. Хүннү нар тушаал зарлигийг зөвхөн харцаараа л ойлгож мэддэг байсан хэрэг. Хаан өмнө нь байлдаж явбал байдал сайн байгаа хэрэг, хэрвээ тэр харагдахгүй л бол зугтжээ хэмээн ухаарах агаад тэр нь бушуу түргэн хаанаасаа ч хурдан зугтаа гэсэн үг болно.

Харин амаль хүн Винитариус зугтсангүй. Тэрээр сөрж байлдахаар давшин ирэхэд нь энэ тулалдаанд хувь заяагаа нэгэнт даатгасан хүннү нар түүний өөдөөс хаан эзнээ тавьжээ. Энэхүү оньсого мэт учир битүүлэг ард түмний нэг ч атугай хааны нэрийг мэдэж авах завшаан ийнхүү тохиож буй бөгөөд тэрхүү хаан нь Баламбер хэмээх дайнч маягийн, хэнгэрэгийн нижигнээн мэт хатуу дуулдах нэртэй ажгуу.

Баламберын агссан зэвсэг Винитариусынхаас хавьгүй давуу байв. Баламберын сум нь ямар ч жаднаас хамаагүй хол тусах нум Винитариусынхаас хол давуу тул хаан

хүнд зориулж хийсэн түүний хүнд сум Винитариусын толгойд тусч тэрбээр мориноос унаж үхэв.

Морьтой дайснаасаа хээр тал руу буруулан зугтана гэдэг гарцаагүй үхэхийн цондон билээ. Тиймийн учир хүннү нарын дараагийн олз болох нь гэдгээ ухаарсан ост, вестгоотуудын зарим овог аймаг яаран сандран Балканы уулс, эртний Тракийн зүг хөдөлжээ. Үүний улмаас ромчуудтай байгуулж олон жил мөрдсөөр ирсэн гэрээгээ зөрчиж Дунай мөрнийг гатлах хэрэгтэй болжээ. Ромчууд хэсэг тээнэгэлзсэний эцэст ийн гатлахыг зөвшөөрсөн байна. Урьд хожид тохиогоогүй гай зовлон гоотуудын араас нүүгэлтэн дөхөж яваа болохыг тэд тааварлаж, хориглон хамгаалах цаг ирэхэд зэвсэг барих чадалтай гоот хүн бүр хэрэгтэй гэдгийг ухаарчээ.

Үнэхээр ч хүннү нар амсхийж зогссонгүй. Тэд гоотуудын нутгийн дийлэнх хэсгийг эрхэндээ оруулжээ. Крымийн хойг хийгээд Трансильваанийн завсар олон зуун мянган нүүдэлчид элбэг багтах атар сайхан нутаг байх агаад тэнд хэн ч өлсөж суухгүй нь магад. Гэвч нүүдэлчид цус үзэн улайрсан байв. Тэдний шуналыг даллан дуудсан олон зүйл гоотуудад байхыг олж мэдэв. Тэд ямар ч хамгаалалтгүй болсон тосгодод дайран орж гоотуудын орон байрыг цөлмөн эхнэр хүүхнүүдийг хүчирхийлээд авч явахдаа хаа нэгтээ хаях буюу эсвэл алж орхих гэдэг юутай таатай болохыг ойлгож мэджээ. Хүннү нар ийнхүү дэлхий ертөнцийн эзэд болох нь тэр. Бусад улс түмэн мөхөж үгүй болохыг тэд харж байв. Өмнө нь олон улс үндэстэн, олон олон хот тосгод, урьд өмнөхөөс ч илүү их алт эрдэнэс, эхнэр хүүхнүүд тосч буйг тэд тааварлаж байлаа.

Баламбер Эрманрихийн зээ болох бүсгүйтэй дэр нэгтгэсэн байна. Тэр нь Баламберын анхны эхнэр ч биш байж, сүүлчийнх нь ч биш болно гэдэг нь мэдээж. Гэхдээ энэ бүсгүй амальчуудын хааны удмын гоот гүнж байсан бөгөөд Баламбер дайтаж бас зугтааж буй эдгээр ард түмэн зарим зүйлээр, тухайлбал хаад ноёд, хийгээд тэдний овгийнхны удам судар гэдгээрээ хоорондоо ижил төстэй хийгээд тэдэнтэй ураг барилдах нь чухал гэдгийг гүйлгэн ухаанаараа ухаж ойлгожээ. Тиймээс ч Баламбер гоот бүсгүйтэй гэрлэж, түүнийг их морьтны хурдаар жирэмслүүлж төрсөн хөвгүүнд Хүнимүнд хэмээх гоот нэр өгчээ. Энэ нэрнээс л бүх зүйл ойлгомжтой.

Ийн дээрэм тонуулын цаг ирэв. Морь унаж давхих, дээрэм тонуул хийх нь хүннү нарт үнэхээр сайхан. Хүннү нарын дараагийн бай нь хуучны хотууд, баян худалдаачид бүхий Сири, Палестин болох байсан ч тэд шийдэж хөдөлсөнгүй. Боол болох юм уу, эсвэл хүйтэн шороонд булагдсанаас Хүнимүндийн удирдлага дор сул чөлөөтэй явахыг илүүд үзсэн төрөл садан гоотууд тэдэнтэй нийлж явсан бололтой байдаг.

Ийнхүү хүннү нар дөрвөн цагийн улиралд дураар нүүх нутагтай болов. Тэд Европт уугуул хээр тал нутагтаа байгаа мэт нааш цааш дураар хэрэн давхилдах болж байгалийн байдал нь Хар тэнгис юм уу, Дон мөрний хавийн газар нутагтай төстэй Дунай мөрний хойд биений Паннон нутагт гар газар, хөл хөсөр тавин суух болжээ.

Сул дорой нь болох Дорнод Ромын эзэнт гүрэн хүннү нарын шуналыг асаасаар тэд нэг л мэдэхэд Тракий нутаг, тухайлбал Өмнөд Булгаарт цөмрөн ороод тэнгисийн хоолойг (Босфор) зүглэжээ.

Ийнхүү аян дайныг эхэлж, уулсын оронд амжилт муутай байлдсан хүннүчүүдийн анхны хааныг Үлдин хэмээх бөгөөд дараах хааныг Ругила хэмээнэ. Тэднийг энэ үеэс Дорнод Ромын он дарааллын гэрэг түүхчид гайгүй мэдэх болсон бөгөөд хүннүчүүд Дорнод Ромынхонтой алба авах, олзлогдогсдыг солилцох асуудлаар хэлэлцээ хийж, барьцааны хүмүүсийг солилцож байлаа. Ругила нь Үлдинээсээ илүү бяр тэнхээтэй, бас эв дүйтэй хүн байв. Тэрбээр Паннонийг зүүн өмнө, баруун өмнө, баруун зүг халдан довтлох тун сайн түшиц газар болох юм гэж үзэж байжээ. Ийн зүүн өмнө талд нь гялалзаж тун ч ихээр даллан дуудах Византийн эзэн хааны хотыг дайлж эхэлсэн Ругила ч нэг их бүтэлтэй явсангүй.

„Хүннүчүүдийн хаан Ругила Истер мөрөнд Ромын өмгөөлөлд орсондоо баярлан суух хэд хэдэн аймаг ард түмнийг дайлахаар шийдсэнийхээ дараа Эсла нэрт нэгэн хүнийг ромчуудад элчээр заржээ. Энэхүү Эсла уг нь Ром, хүннү нарын хоорондын хэрүүл маргааныг дэвэргэж суудаг хүн байв. Харин одоо тэрбээр хэрвээ зугтаж очсон хүмүүсийг Ром бүгдийг нь буцаан өгөхгүй бол эвийн гэрээг сахиж чадахгүй шүү хэмээсэн Ругилагийн заналхийлсэн хилэнт үгсийг ромчуудад хүргэжээ. Тэгэхээр нь ромчууд Ругилад элч төлөөлөгч илгээхээр шийджээ“ хэмээн түүхчид бичжээ.

Түүхчид 425 юм уу 426 оныг зааж бичихдээ зөвхөн орчин цагт л хэрэглэгдэж эхэлсэн хэмээгддэг амирлуулж тайвшруулах дипломат арга ажиллагааг ромчууд тэр үед явуулж байсан гэжээ. Хүннүчүүдийн ноёнтон харилцаж сурсан, тэгээд л Ругилагийн сануулга заавар бас заналхийллийг хүргэхээр итгэл ихэд олсон бололтой байдаг тэрхүү Эслагийн тухай өөр бусад зүйлийг олж мэдэх нь тун ч ач холбогдолтой.

Гэвч гайхалтай авьяаслаг дипломат хүн ч заримдаа ямар ч аргагүй байдалд орох нь бас бий. Эсла Ругилагийн тавьсан зорилгыг биелүүлээгүй бололтой. Ром дүрвэгсдээс багаахан хэсгийг нь алгуурлаж байж буцааж өгсөн ажээ. (Оргож боссон хүмүүстэй хэрхэн харьцдагийг хэн хүнгүй мэдэх учир яаж дуртай өгөх билээ дээ). Товчоор хэлбэл Ругила Эслагийн авчрах мэдээг хүлээлгүйгээр цэргээ хөдөлгөсөн агаад Эсла ийн яаж ч чадсангүй учир одоо бурхны таалал л мэдэх хэрэг болов.

Хаан II Теодосиус айхавтар хүч нөлөөтэй хүчирхэг эзэн захирагч байгаагүй ажээ. Тэрээр эхлээд өөрийн бие хамгаалах торгон цэргийн нэгэн ахмадад цэрэг өгч хүннүүдийн эсрэг илгээжээ. Дараа нь дүү бүсгүй Пулхериа, эцэст нь хатан хаан Евдокиаг ч явуулжээ. Эр нөхөр Теодосиус нь Ругилаг ялах шинжгүй тул хатан хаан улс орныг нь авран хамгаалахыг дээд тэнгэрээс мөргөн гуйжээ.

„Нүүдэлч скифүүдийн ноён Ругила их цэргээ удирдан Истер (Дунай мөрөн)-ийг гатлан Тракийд цөмрөн орж цөлмөн хоослохын цагт Византийн нийслэлийг аюул нөмөрчээ. Ругила Византийн нийслэлийг хурдавчилсан маршаар явуут эзлэн авч түйвээх нь үү гэмээр байлаа. Гэвч байдал ингэж даамжрахаас өмнө амжиж бурхан тэнгэр аянга цахилгаанаа илгээж Ругилаг ниргэн их цэргийг нь тэр чигээр нь сөнөөжээ.“

Сүм хийдийн түүхийн ийм мэдээ зангийг яг таг ойлгож хүлээж авах хэрэггүй ч гэлээ хүннү нар мухар сүсэг, зөн совинд (үүгээрээ Чингис хаан тэдэнтэй төстэй) ихээхэн автагдсан хүмүүс тул хүчтэй аадар бороо, эсвэл ер бусын аянга буух, аль эсвэл өөр бусад золгүй явдал тохиолдох нь тэр цагт Ругилаг бачимдуулж сандраах, түүгээр ч үл барам буцаж няцахад ч хүргэж болох явдал байжээ. Ямар ч болов Ругила 434 онд Византийг эзэлж чадалгүй нас барсан агаад дүү Октар, Мүндзүх нарынх нь талаар тэр үед хэн ч юу ч сонсоогүй ажээ. Харин Ругилагийн үеэл Мүндзүх ноёны хөвгүүн удалгүй аливаа ярианы гол сэдэв болсон ажгуу. Түүний нэрийг Аттила хэмээнэ.

II. ЛН

с □ □ НЛЛ □ ЛЛ □ МП □ □ й □ □ □ й □ М

Н □ □ □ У □ □ □ □ □ □

1.

„Аймшигт үр удам“

Хүннү нарын нэр хийгээд уг гарвалын тухай асуудлыг лавтай барьж ажиллах үедээ би хэдэн арван авьяас билэгт судлаачид энэхүү хүчир ажилд насан туршийн амьдралаа зориулсан, эл асуудал яагаад өнөөг хүртэл шийдэгдээгүйн учрыг ухаарч эхэлсэн юм. Хүннү нар дэлхийн олон улсад ихээхэн нэрд гарсан ард түмэн байж мэднэ. Учир нь хүн бүр л хэзээ нэгтээ цагт хаа нэгтээ тэдний тухай сонссон байдаг ч үнэн хэрэгтээ тэд дэлхийн бүх улс түмэн дотроос хамгийн танигдаж мэдэгдээгүй нь бөгөөд учир нь тэд өөрсдийгөө хэн болох, хэний хэлээр ярьдаг, үхэгсдээ ямар ёс заншлаар оршуулдаг гэдгээ бараг л мэдэхгүй, за тэгээд хаанаас ирснээ бүр ч мэдэхгүй билээ. Нүүдэллэн байнга буурь сэлгэж явах дуртай учраас заримдаа хүннү нар төрсөн эхээ ч мэдэхгүй, энэ замбуутивийн гэгээг хаана анх харснаа ч гадарлахгүй. Үр хүүхэд нь эцгийн булшийг олох аргагүй...

Уран зохиолын барьцтай гэхээр зүйл, өөрөөр хэлбэл бичгийн дурсгалаас эхлээд авч үзье. Чингэвэл Ромд боловсрол олсон, гоотын түүхийг туурвигч Иорданесын дор өгүүлэх түүх хэн хүнийг гайхуулж алмайруулна.

„Хүннү нарын гарал үүслийн тухай эртний домогт гоотуудын тавдугаар хаан Филимер Скандинав арлаас гарч яваад скифүүдийн оронд ард түмнийхээ хамт буужээ. Тэнд тэрбээр албат нарынхаа дунд *“haljarunae”* хэмээн нэрлэгдэх ид шидийн ухаанд нэвтэрсэн олон эмс хүүхэн байгааг олж мэджээ. Тэд өөрийг нь болон ойр дотных нь хүмүүсийг хорлож магадгүй хэмээж эмээхдээ Филимер хаан тэднийг их цэргээс холдуулж зайлуулахыг тушаасныг ёсоор болгосонд тэд харь нутгийн эзгүй зэлүүд газарт тэнэж бэдэрч явах болсон аж. Бөглүү зэрлэг газар хэрэн тэнэх эдгээр эмсээс шуламсын сүнс сүлд тодорч гарсан нь анзаарагдалгүй өнгөрсөнгүй. Тэд гоотуудтай нийлж аймшигт муухай үр удмаа үлдээсэн агаад тэд нь эхлээд балчиг намаг газар амьдран сууж байжээ. Энэ бол намхан заггар, жигшмээр муухай дүртэй, ухаан муутай, ерийн хүнтэй адил төстэй юм бараг үгүй хүмүүсийн овог байсан бөгөөд хүнээс гарах дуу авиаг санагдуулам төдий хэлээр ярилцдаг байжээ.

Эдгээр хачин амьтдаас хүннү нар үүссэн агаад тэд гоотуудын нутгийн хязгаарт гэнэт гарч иржээ. Түүхч Прискүсийн мэдээлсээр ийм байдлаар бий болсон хүннү нарын овог Маэогийн (Азовын тэнгисийн эргийн) намаг газрын зах, тэнгисийн дорно эрэгт оршин сууж байжээ. Тэд ажил хийж дадаагүйн учир хэсэг хугацаанд ан гөрөө хийн амьдарч байгаад бие даасан ард түмэн болж өсч үржсэнийхээ дараа хөрш ард түмэн, овог аймгуудад халдан дээрэм тонуул хийж амар суулгахгүй болжээ.

Нэгэн удаа хүннү нараас хэдэн анчин урьдын адил Маэогийн намгийн захад ан хөөж яваад нэгэн согоо намагт орж ирсэн байхыг гэнэт харжээ. Буга урагшаа хэд алхаад л зогсч хүннү нарыг араасаа дагахыг урин дуудах мэт мөн л хэд алхаад л зогтусах ажээ. Анчид ч бугын араас дагаж явсаар далай тэнгисийн адил гэтлэх аргагүй гэж үздэг байсан Маэогийн намгийг гаталжээ. Ийн удалгүй тэдэнд скифүүдийн үл таних газар орон (Өмнөд Орос) үзэгдмэгц буга ч алга болжээ“.

Энэ хэсэгт хамгийн сонирхолтой нь шидэт эмс, шуламсыг заадаг *haljaruna* гэдэг гоот үгийг иш татсан явдал бөгөөд учир нь энэ үг герман хэлний *Alraune* (*мандрагора гэх манжингийн төрлийн үндэстэй ургамал байдаг агаад герман чигийн мухар сүсэгт их үүрэгтэй байдаг байна. Орч.*) гэдэг үг байна гэдгийг түвэггүй ойлгож болох бөгөөд энэ үг II Рудольф хаанаас эхлээд Ханнс Хайнц Эвэрсийг (*1871-1943, Германы зохиолч, кино найруулагч, дэлхийгээр аялагч байв. Орч.*) хүртэл манай ард түмний гүн шөнийн зүүд нойр, зөн совинд их үүрэг гүйцэтгэж ирсэн билээ. Иорданес хүннү нар яагаад гоотуудад халдаар ирж, тэднийг эзэрхийлэн дарлав гэдгийн учрыг дээр өгүүлсэн гоотуудын хаан шуламсуудыг гутаан доромжилж, хөөж явуулснаас болсон явдал хэмээн тайлбарлахыг боджээ.

Иорданес цааш нь өгүүлэхдээ „Хүннү нарын өвөг дээдэс болох тэрхүү муу сүнс буга согоог скифүүдийн (Хүннүгийн довтолгоонд өртсөн эхний ард түмэн, удалгүй хүннүчүүдийн холбоотон болсон алануудыг хэлжээ) эсрэг илгээсэн гэж бодож байна“ хэмээжээ.

Ийн анчид өөрсдөө ч мэдэлгүй туршуулууд болсон агаад тэдний авчирсан мэдээ баримтад түшиглэн хүннү нар тэр чигээрээ намгийг гаталж, Хар тэнгисийн умард хязгаарт орших гэрэгүүдийн үр тарианы орон болсон скифийн нутгийг эзэлж авахаар хөдөлсөн ажээ. Ард түмнүүдийн их нүүдэл нь ийнхүү Прискүс, Иорданес нарынхаар бол гоотуудын хаан ид шидтэй эмсийг үзэн ядсанаас үүдэлтэй агаад хүннүчүүд уулаас хүн бус, харин дэндүү дур гутам ураг барилдлагаас үүсч бий болсон намгийн шуламсын үр удам ажээ.

Юуны учир ийм шинжлэх ухаанч бус, утгагүй зүйлийг энд иш татаад байгаа юм бэ хэмээн хэн нэгэн асуувал Прискүс, Иорданес нар хийгээд эртний бусад олон түүхчдийн өгүүлж буй эдгээр мэдээ занги нь хүннү нарын талаарх түүхийн гол эх сурвалжууд юмаа л гэдгийг хэлэх байна. Ихээхэн буурь суурьтай эрдэмтэд ч тэднээс иш татаад зогсохгүй тэдний үг бүрийг дэнсэлж, өгүүлбэрүүдийг нааш цааш хөрвүүлж элдвээр авч үзэж, зарим нэг үгийн утгыг янз бүрийн утгаар шүүн хэлэлцдэг юм. Эртний түүхчид онигоо ярьж хошигнохдоо дуртай байсан нь мэдээж. Тиймгүйсэн бол дэлхийн утга зохиол олон сонирхолтой сайхан зүйлээр дутах байсан биз ээ. Өөрийн гэсэн онолд тулгуурлаж л байвал буурьтай авч үзэх, харин хэн нэгний үзэл баримтлалд таарахгүй бол хийсвэр санаа, үлгэр хэмээн үзэж хаяхын аль аль нь буруу биз ээ. Хуучны эдгээр бүх эх сурвалж түүхийн талаас нь үзвэл үнэн бодит зүйл хийгээд уран зөгнөлийн хольц юм. Тэнд төөрөгдөл ч их буй. Учир шалтгааны ухааны үүднээс үзвээс өөрөөр яагаад ч байж боломгүйн учир бол худалдаачид, цэргийн дарга, бичээч, бядан явагчдын аман мэдээ занги бол эртний түүхийн чухал эх сурвалж, гол гэрчүүд юм. Тийм ч учраас өөр эх сурвалж байхгүйн улмаас тэдгээрийг авч үзэх, бүр буурьтай авч үзэх ёстой юм. Афины иргэн түүхч Дексиппосын “Скиф ертөнц” (*Публиус Хэрэнниүс Дэксиппүс 210 оны хавьд төрж 275 онд нас нөгчсөн, гуравдугаар зууны Ромын гэрэг хэлтэй улс төрч, түүхч хүн агаад түүний бүтээлүүдээс хэсэг бусаг нь л үлдсэн ч тухайн үеийн томоохон түүхч гэгдэж явсан. Дээрх бүтээл нь германчуудын дайн байлдааны түүхийн талаар өгүүлжээ. Дексиппосын эл бүтээлийг өмнө дурдсан түүхч Зосимос “Шинэ түүх”-ээ туурвихдаа эх сурвалж болгон ашиглаж байсан ажээ. Орч.*) гэх мэтийн хуучин цагийн түүхэн найруулал үрэгдэлгүй бидний гар дээр ирсэнсэн бол хүннү нарын халдаар ирэхийн яг өмнөх цаг үеийн талаарх бидний төсөөлөл хийгээд мэдлэгийг үндсээр нь өөрчлөх байсан ч байж мэднэ. Гэвч бидэнд тэр нь алга. Питеас (Массилиагийн Питеас нь эртний Гэрэгийн худалдаачин, газар зүйч, далайгаар аялан явж шинэ газар орон нээж байсан хүн болой. Орч.)-ын Английг тойрон дарвуулт хөлгөөр аялсан тухайгаа өгүүлсэн “Далайн тухай ном” хийгээд хуучны шинжлэх ухааны үнэлж баршгүй олон туурвил бүтээлүүд ч мөн л мэдээ сэлтээр хомс болой.

Тэгэхээр бидний иш үндсэн болгож буй зүйл маань хэврэг, баттай бус юм. Хэрвээ хэн хүн энэ байдлыг ухамсарлах аваас нэг их сүйдтэй юмгүй. Харин үүнийгээ эцсийн үнэн гэж бодож, хүн амьтны сонсох буюу уншья гэж хүссэн зүйлийг нь л гаргаж тавих юм бол тэр тун ч аюултай. Өнөөдөр хүннү судлалд гүн гүнзгий зөрчил ноёрхож, түүгээр ч барахгүй хүннү нарын гарал үүслийн тухай асуудлыг эрдэмтдийн маргаан тэмцлийн талбар болгосонд дээр дурдсан найдвар муутай эх сурвалжаас гадна маргашгүй үнэнийг хэлж амрах гэсэн сонирхол ч буруутай.

„Ямар ч болов хүннү нар монголчуудаас үүссэн гэдэг нь тодорхой байна“
(Хомайер)

„...Хэл хийгээд ардын зан заншил нь түрэг гэдэг нь эргэлзээгүй хүннү нар...“
(Альтхайм I, 22)

„Дорноос ирсэн монгол-түрэг гарлын нүүдэлч овог аймгуудын холбоо болох хүннү нарыг христийн тооллоос өмнөх сүүлчийн зуунд Хятадад мэддэг байв“ (Филип)

*„At any rate, until the experts reach some agreement, the student of the later Roman Empire is best advised to say nothing about the Hsiung-no“ (Thompson) **

*Attila with his vast host of Mongols and subject Germans invaded central Gaul...”
(Gordon) ***

“Хан гүрний хамгийн аюултай гадаад дайсан бол хэзээнээс л Дорнод Азийн хүннү нар (Hsiung-nu) байсан юм. Тэд христийн тооллын дөрөвдүгээр зууны Европт товойн гарч ирсэн Аттилагийн хүннү нартай адил эсэх, хэрэв тэд нэг л ард түмний үр сад юм бол хэр зэрэг адил вэ гэдэг нь ихээхэн маргаантай асуудал болой. Хүннү (Hsiung-nu) нарыг ямар хэлний аймагт хамааруулах нь ч тодорхой бус. Хятадуудын мэдээ сэлтэд дурдагдсан хүннү хэлний үгс шинэхэн судалгаа урьд өмнийн таамналаас зөрж буй нь түрэг хэлнүүдтэй төрөл бус, харин Сибирийн хэлнүүдтэй (кет, самоед) төрлийн холбоотой гэдгийг зааж буй. Хүннү (Hsiung-nu) нар нь малчид, морьтон нүүдэлчид байсан баримтыг хүннү нар хэн бэ гэдэг асуудалтай холбон авч үзэж болохгүй. Талын нүүдэлчдийн аж ахуйн хэлбэрийг аль нэг тодорхой ард түмэнтэй холбон авч үзэх аргагүй...Эцсийн дүнд Евразийн түүхэнд гарч ирсэн тал нутгийн эзэнт гүрнүүд нь хүн амын хувьд холимог алаг цоог шинжтэй байсныг дурдах хэрэгтэй. Түүхэн хөгжлийн явцад барагтай л бол эргэлзэж тээнэгэлздэггүй германчууд, гоотуудын аль аль нь Аттилагийн хүннү нарын захиргаанд орж байсны адилаар тал нутагт бий болсон холбоод нь олон зүйл ард түмнийг хамарч байсан юм”. (Франке/Трауцеттел)

Эдгээр зөрчлүүд нь нэр хүнд бүхий судлаачдаас зарим нь судалгааны ажлынхаа явцад тухайлбал Европын хүннү нар монгол хүннү (Hsiung-nu) нараас гаралтай гэх асуудалд хандах хандлагаа өөрчилснөөс болж улам нарийн түвэгтэй болж байсан агаад энэ нь шинжлэх ухаанч чин шудрага байр суурь, үнэний төлөөх хайр найргүй тэмцлийн онцгой илрэл билээ.

*”Экспертүүд санаа бодлоо нэгтгэж чадаагүй цагт Ромын эзэнт гүрний сүүл үеийн түүхийг судалж буй хүн хүннү (Hsiung-ni) нарын тухай ерөөс юу ч ярихгүй байсан нь дээр”.

**”Аттила монголчууд болон эзлэгдсэн германчуудаас бүрдсэн томоохон армийн хүчээр Дундад Галлид дайран оров”.

Ийм судлаачдын тоонд “Сүүл үеийн Ромын эзэнт гүрний түүх” (*History of the Later Roman Empire*) хэмээх суурь бүтээл туурвисан Ж.Б.Бери багтах бөгөөд тэрбээр уг бүтээлдээ хүннү нарын гарал үүслийн тухай асуудлыг хөндөхдөө “*It is a moral leap from the kingdom of the northern Zenghi to the steppes of Russia, and he who takes it is supported on the wings of fancy, not on the ground of fact*” * хэмээжээ.

Ийнхүү бид хүннү нарын урт түүхэн замналыг цааш лавшруулан үзэхдээ “*wings of fancy*” буюу зөн совинд хөтлөгдсөн учир явдлыг нь судлан үзэхгүйгээр цааш ахих аргагүй, тиймээс яагаад заавал ганц таамналыг бусдаас илүүд үзэх ёстойг хүлээн зөвшөөрөх ёстой болно. Яахав Бэри Европт ирсэн хүннү нар нь Хятадын Хан гүрэнтэй өрсөлдөн тэмцэлдэж байсан Niung-ni-тэй ураг төрлийн холбоотой гэдгийг амьдралынхаа сүүл хэрд зөвшөөрөх маягтай байсан, гэвч бараг яг тэр үед Альтхаймын ачаар судалгаа нь “цагаан хүннү” нар хэмээгдсэн хүннү нарын газар орноор өргөжсөнөөр мөнөөхөн гарал үүслийн тухай асуудалд шинэ аспектиуд гарч ирсэн юм. Гэлээ гэхдээ бид тэндээс ч, мөн төрөлжсөн судалгаанаас ч сэтгэл ханахаар шийдэл олоогүй хэдий ч хүннүчүүд хэмээгдэгч ард түмний шинж байдлын талаар хэд хэдэн тайлбар сэлт олсон билээ.

Христийн тооллоос өмнөх хүннү нар буюу тэдний түүхийн Азийн үеийн талаар Германы хятад судлаач Ж.Ж.М. де Гроотын эх сурвалжуудын гайхалтай сайхан товхимол байдаг бөгөөд Европт ирсэн хүннү нар хийгээд Төв Азид байсан Niung-ni нарын талаарх маргаан мэтгэлцээнд ерөөс оролцоогүйгээрээ тун онцлог, бас таатай. Зохиогч үүнийгээ “Уул нь зохиогч хүннү нарын ард түмэнтэй холбогдох энд тэнд гарсан бага сага зүйл болон мөн энд боловсруулж ашигласан (хятад эх сурвалжуудыг хэлж байна) эх сурвалжуудад бичигдсэн зүйлүүдийг дурдах буюу хэлэлцэхээс зайлсхийсэн билээ. Чингэснээрээ тэрбээр эл асуудлын талаарх зохиол бүтээлүүдийг сайн судалж эзэмшээгүй юм уу даа гэсэн хардлагыг төрүүлж болох юм. Гэвч энэ хардлага нь өөрт дэндүү утгагүй, ямар ч үндэслэлгүй мэт санагдах нэгэн цагийн санаа бодлын амьдрах насыг уртасгахын тулд герман хүний нягт нямбай чанараар ажиллав шив дээ хэмээн дотроо өөрийгөө зэмлэж гэмшиж байснаас хамаагүй дээр. Их бичигдсэн зүйлийг аль

болохоор хурднаар мартагнуулах явдал ялангуяа шинжлэх ухаанд тун ч хүсүүштэй зүйл юм” хэмээн бяцхан ёжтой дуулдах үндэслэлээр тайлбарлажээ.

Де Гроот ийн дэндүү даруу гэхээр аягласан хэдий ч хятад эх сурвалжид “Hung-no” (бусад галиглалаар Hiung-nu, Hsiung-nu гэх мэт) хэмээн нэрлэх тэрхүү ард түмэн нь үнэн хэрэгтээ хятад авиа зүйн дүрмийн дагуу “Hungnor”, “Hunoch” эсвэл “Hunor” гэх зэргээр нэрлэгдэж байжээ гэдгийг тодруулж тайлбарлахаас зайлсхийсэнгүй. Хятадууд г, мөн ch-гийн алиныг ч дууддаггүй, бас тэмдэглэх үсэг байдаггүй учир “Hung-no” гэж бичих ёстой байв. Мөн тэд мэдээж дундад гүрний зүгээс авч үзэхэд умрын хэмээгдэх зэрлэгүүдийг нийтэд нь богино хэлбэрээр үл ойшоосон муу утга оруулан “хү” (Hu) хэмээн хааяа нэрлэдэг.

Энэхүү гайхалтай хялбар уншигдах гурван зуун хугас хуудас бүхүй түүхийн үнэт бүтээл биднийг христийн тооллын өмнөх хоёрдугаар зуун руу буцаан оруулна. Тэнд “Хүннү нар. Тэдний овгийн анхны удирдагч нь Хиа-гийн хаадын удмын хүн бөгөөд түүнийг Шүн-үй хэмээнэ” гэж тэмдэглэжээ.

Энэ хувилбар өнө эртнийх агаад Азовын тэнгисийн дорно этгээдийн балчиг намаг газрын шуламсуудын зэрлэг хүчирхийллийн тухай дэндүү хийсвэр түүхээс хамаагүй өөр дуулдана. Хиа нар нь хятадын олон династийн нэг болой.

**”Умард Зэнгийн хаант улсаас Оросын тал нутаг руу огт үл мэдэх газар орныг зорин очино гэдэг нь үхлийн аюул дагуулсан хэрэг бөгөөд чингэж буй хүн бодит баримтад тулгуурлахаас илүүтэй зөн совинд хөтлөгдөж буйгаас ялгаа юун”.*

Хиа нар христийн тооллоос өмнөх 2250 оны үед засгийн эрхэнд орж мөн христийн тооллын өмнөх 1850 оныг хүртэл төр барьсан бололтой. Хааны гэр бүлээс хамгийн танаггүй нь гэгдсэн нэгэн жонон ордныг орхиж зэрлэгүүдийн газрыг зорьж очоод тэднээс илүү мэдлэг чадвартайн учир эзэнт гүрэн биш ч гэлээ ямар ч болов нэгэн төвлөрсөн захиргааг тогтоожээ. Шүн-үй хэмээгдэх тэрхүү жонон ямар хэрэг едүүлж хар толгойдоо булуу хураасныг хятад сурвалжуудаас бид мэднэ. Эцэг Кие нь Хиа гүрний сүүлчийн хаан байв. Түүнийг тэнгэр халихад мөнөөх жонон хааны олон эхнэрүүдийг хураан авсан нь хятадуудын заншлаар түмний хараал идэх гэмт явдал едүүлсэн хэрэг болсон тул тэрээр орон гэрээсээ дайжсан ажээ. Харин хүннү нарын хувьд ийм явдал бол тогтсон ёс заншил нь байв...

Хиагийн хаадын удмын сүүлчийн хүн болох Шү-нүй христийн тооллоос өмнөх 1800 оны үед амьдарч байжээ. Тэр үеийн хятад бичгээр хүннүг тэмдэглэх үсэг нь умрын гурав, дөрвөн зэрлэг ард түмний нэртэй бага зэрэг төстэй байжээ. Тэдгээрийн нэрний “хүн” (hun) гэдэг үсэг бүгдэд нь адил байв. Тухайн үед ноёрхогч гүрэн байгаад мөхөх замдаа орсон Хиагаар дамжуулан хүннү нартай ураг барилдсан хятадууд хүннү нарыг сонирхон заншлах болжээ. Чингэхээс ч аргагүй байсны учир бол хү буюу хүннү нарын зэрлэгүүд Дундад гүрний зах хязгаар нутаг, худалдааны замд ахин дахин халдан довтолж хятадуудыг тун ч хүнд байдалд оруулж байсан явдал болно. Хүннү нарын тухай хятадын анхны мэдээ баримтуудад:

“Тэдний мал сүрэг адуу, үхэр, хониноос голчлон бүрдэнэ. Мөн гэрийн тэжээмэл бусад амьтад tokto (тэмээ?), илжиг, луус (тайлбарлах аргагүй өөр гурван амьтныг ч бас нэрлэжээ) арай ховор тохиолдоно. Тэд өвс усны сайныг эрж нааш цааш нүүж явна. Хэрмээр хүрээлүүлсэн хот суурин буюу байнга суух орон суурингүй, газар тариалан эрхэлдэггүй. Гэсэн хэдий ч хүн бүр хэсэг хэсэг газрыг эзэмшин сууна.

Тэдэнд бичиг үсэг байхгүй (тун харамсалтай!). Элдэв тохиролцоо хэлцлийг амаар хийнэ. Хүүхдүүд нь хонь мал унаж, нум сумаар шувуу, бас үен, харх агнаж чадна. Арай том нь үнэг, туулай агнаж хүнсэндээ хэрэглэнэ.

Нум сумаар харвахдаа гойд чадамгай учир цэрэг дайчид нь хүчтэй. Тэд бол хуягласан морьтон дайчид юм. Ёс заншлын хувьд тайван цагт малынхаа аясаар нүүдэллэн явна. Чингэхдээ шувуу болон бусад амьтан агнаж амьдрал ахуйдаа нэмэр болгоно. Аюул учрахын цагт эрчүүд нь дайнд бэлтгэж сургууль хийнэ. Тэд гэнэт дайрах, довтлон орохдоо шаламгай. Энэ нь тэдний зан чанартай холбоотой. Урт зэвсэг (холын тусгалтай) нь нум сум, богино зэвсэг нь илд, жад болно. Байдал ашигтай бол тэд давшиж байлдана. Харин таагүй бол ухарч, бүр зугтахаас ч сийхгүй, чингэхдээ таатай байрлал бүхий газар руу (эргэж байлдахын тулд) буруулж явна.

Амьдралын дүрэм журам, зүй ёс, үүрэг хариуцлага гэх мэтийн тухайд тэд юу ч мэдэхгүй. Ноёд, жонон ч, тэдний албат нар ч мах идэж, арьс үсэн хувцас өмсч, дээгүүр нь үстэй дээл хэдрэнэ. Идэр залуу хүмүүс өөхтэй тарган мах зэрэг сайн хоолыг идэх агаад өтөл настангуудад хоолны үлдэгдэл өвдөл цөвдөл ногдоно. Үүнээс үзвэл залуу чадалтай хүмүүсийг ихэд үнэлж үзэх ба насан өтөл буурай нар болон сул дорой хүмүүсийг дорд үзэж тоохгүй. Эцэг үхвэл хөвгүүд нь түүний бага эхнэрүүдийг авч суух ба ах үхвэл дүү нар нь түүний эхнэрүүдийг мөн авна. Эгэл хүн зөвхөн өөрийн ганц нэртэй, хүндэтгэх үүднээс нэрийг нь дуудахаас цээрлэх (Хятадад заншсаны адилаар) ёсон тэдэнд байхгүй. Овог болон хоёрдахь нэр байдаггүй” хэмээн өгүүлнэ.

Хятадууд гэрлэхээрээ хоёрдахь нэр авдаг бол нүүдэлчин хүннү нар эхнэр авахыг байдаг л зүйл, тэглээ гээд эр хүний нэрийг өөрчлөх хэрэг байхгүй гэж үздэг байв.

Эдгээр нь хүннү нарын талаарх анхны, нэн эртний мэдээ баримт бөгөөд бусад олон мэдээ сэлт бий ч цаг зай хэмнэх үүднээс бид иш татаагүй бөгөөд тэдгээр нь гайхмаар дэлгэрэнгүй, бас оновчтой юм. Хятадын эзэн хаадын умрын зэрлэгүүдийн талаар авч байсан мэдээ сэлтийг мянган жилийн хойно Херодот мэтийн алдарт түүхч зохиол бүтээлдээ эртний хязгаар нутгийн соёлуудын тухай тусгасан мэдээ зангитай харьцуулан үзвээс хятадуудын бодит баримтыг чухалчлан үзэх хандлага ихэд хөгжсөн учир хийсвэр сэтгэлгээнд нэг их итгэдэггүй байсныг хэлэх хэрэгтэй. Дундад их гүрэн өөрийгөө найдвартай хамгаалах, дээрмийн халдлагыг цаг алдалгүй няцааж байхын тулд гаднаас нь харахад энгийн тайван амьдарч мал сүргээ адуулан явах хөршүүдээ байнга ажиглаж, энэ тухайгаа дээш нь зохих ёсоор мэдээлж байдаг өнөөгийн хэлээр бол тагнуулын албыг маш сайн зохион байгуулсан нь харагддаг.

Эдгээр үнэлж баршгүй мэдээ занги бидний үеийг хүрч, түүний ач холбогдлыг зохих ёсоор үнэлж эх сурвалж болгон ашиглаж байгаа нь мэдээж үнэхээр азтай хэрэг билээ. Уг язгуур гарал нь христийн тооллын өмнөх 1121 он хавиас эхтэй сайн язгуурт гэр бүлээс гаралтай их Күнз зөвхөн философич, шашин үндэслэгч байсангүй, тэрээр өөрөө ард түмнийхээ анхны их багш нь болж ард түмнээ түүхийн тавцанд гаргах арга замыг ихээхэн сонирхож сурвалжилж байсан хүн бөлгөө. Тэрбээр христийн тооллын өмнөх 500 оны үед өмнөх үеийн бичгийн дурсгал, баримт мэдээг цуглуулж эхлээд хуучны эдгээр бичвэрээс сонгож эмхэтгэсэн бүтээл нь өнөөг хүртэл Хятадын түүрүү үеийн түүхийн талаарх хамгийн үнэт эх сурвалж болж байна.

Энэхүү эмхэтгэл нь хүннү нарын ахуй амьдралын тухай анхны мэдээ зангийн зэрэгцээ хүннү нарын нүүдэлчдийн заншлаар тогтсон хил хязгааргүй гүрний гол гол газар нутгийн тухай олон чухал мэдээ агуулж буй. Нэн эртний эх сурвалжийн мэдээгээр хүннү хэмээх нэгэн нэрийн дор нэгтгэсэн зэрлэг ард түмнүүдийн олон овог аймгийн бэлчээр нутаг, үйл ажиллагааны талбар нь Долоон мөрний бэлчир хэмээгдэх газрын Или голоос Монгол Улсын нутгийн гүн дэх Орхон гол хүртэлх газар орныг дамнан оршиж байв. Хүннү нарын эсрэг явуулсан цэрэг дайны ажиллагааны тухай тайлан мэдээнд Орхон голыг хамгийн их дурдсан байдаг бөгөөд Монголын өнөөгийн нийслэл Улаанбаатарын суурин дээр байсан Өргөө хотыг эзэгнэхийн төлөө байнга тэмцэлдэж байжээ.

Хятад эх сурвалжуудын хүннү нарын улс хэмээн тоймлон үзүүлж буй газар орон нь нүүдэлчиддээ ч томдохоор асар өргөн удам нутаг юм. Сычуань орчмын хятадын их хэрмийн баруун хойд хязгаараас Семипалатинск хүртэл 1800 орчим километр, Балхаш нуур орчмын Долоон мөрний газраас Орхон гол хүртэл ойролцоогоор 3000 километр зайтай болой. Гэвч эдгээр тоо баримтад эргэлзэх хэрэггүй, учир нь хэдийгээр тухайн ард түмний өөрийгөө нэрлэдэг нэрийг нь үл ойшоон хятадууд өөрийн дураар өгч байсан нэрс итгэл муутай ч газар орон, гол мөрний нэрсийг хялбархан шалгаж нэмэлт мэдээ баримтаар бататгах боломжтой.

Умрын дайнч, эсвэл дээрэмч гэх нь бараг илүү тохирох ард түмнүүд Хятадын эзэнт гүрний өрнө тийш нэвтрэх гарц өндөр уул нуруу бүхүй байгалийн халхавч хамгаалалтгүй ил задгай жигүүрийг нумлан сууж байв. Орхоны хөндий бол Хятад руу цөмрөн орох хамгийн зүүн жигүүрийн хаалга байв. Абакан, Кызылийн завсар уул нуруудыг нэвтрэн орох дараагийн боломж нээгдсэн бөгөөд Зүүн гар нь хоёрын зэрэг өргөн хөндийгөөр, тухайлбал өнөөгийн аж үйлдвэрийн хот орших Хар Эрчис мөрний дагуу болон мөн Алаг хөл, Эв нуурын завсраар Зүүн гарын хаалгаар өрнө рүү гарах гарц нээж байв. Түүнчлэн өнөөгийн аж үйлдвэр, уул уурхайн төв Алма Ата хот орших Илийн хөндийгөөр явж намхавтар давааг давж Өвөр Зүүн гарт онцын бэрхшээлгүй хүрч болох байв.

Дундад гүрний баруун нутаг ийнхүү илт зэрлэг газар орон байсан бөгөөд хятадууд үүнийгээ Умард хэмээн нэрлэж байсны учир нь нүүдэлчдийн эсрэг холуур сунасан хил сахих цэргийн хувьд дайсан этгээд дандаа л умраас ирдэгтэй холбоотой. Өрнийн орнуудад хүрэх зам, Хятадын эзэнт гүрэн, Ромын эзэнт гүрэн хоёр хоорондоо холбоо тогтоож болмоор зам мөрийг умрын гэх эдгээр зэрлэгүүд гаргасныг зөвхөн дээд зиндааны, юмны учир явдалд нэвтэрсэн түшмэдүүд аль эрт олж мэджээ.

Ямар ч болов хоёр эзэнт гүрэн холбогдох үйлс бүтсэн нь бараг л гайхамшиг гэхээр байсан бөгөөд харин энэ зам хэдхэн арван жил болоод л hung-но, сүүлд хүннү нарын балгаар хаагдсан бөгөөд hung-но нь хүннү нарын цус нэгтэй удам гэдэг утгаар ч байна уу, аль эсвэл өв залгамжлагчийн хувиар ч байна уу ялгаагүй л баян чинээлэг Хятадад хүннү нараас ч илүү дайсагнаж, байнга байлдаж дайтсаар Дундад гүрнийг асар их хүч хөрөнгө дайчлахад хүргэж байв. Эл их хүч чармайлтын хамгийн тод жишээ нь Хятадын их хэрэм агаад түүнийг зөвхөн нүүдэлчдийн халдлага довтолгооноос хамгаалахын тулд л байгуулсан билээ. Европ нь Хятад шиг ийм эв нэгдэлтэй байж, нэг л хаанд захирагдаж байсансан бол зүүн жигүүртээ сайтар бэхэлсэн хана хэрэм барьж

хүннү нарын довтолгоон хийгээд мөн ард түмнүүдийн их нүүдлээс өөрийгөө найдвартай хамгаалж болох байсан ч байж магад...

Гэвч бэхлэлт хэрэм зэрэг төхөөрөмж нь ямар нэг байдлаар аюул ослоос найдвартай хамгаалагдаж болох мэт хуурмаг сэтгэгдэл төрүүлэх агаад тэгээд ч уул байгууламж нь 2500 километр урт бол хамгаалах цэрэг суулгаж сайтар бэхэлж авахад асар том арми шаардлагатай учир Хятадын их хэрэм мэтийн барилга байгууламжийг зүгээр ч нэг жишээ нотолгоо болгосонгүй. Германчууд бид олон жилийн өмнөөс хуучин нийслэлийн маань дундуур барьсан ханын хоёр талаар амьдарч ирсэн болохоор хана хэрэм гэдэг зүгээр нэг хуурмаг үзэгдэл гэхээсээ илүү бүр чухал билэгдэл гэдгийг мэдэх юм. Элчилгүй уудам тал нутгийн мухар сүсэгт нүүдэлч түмний хувьд манай эрэний өмнөх гуравдугаар зуунд цогцлуулсан энэ аврага том хамгаалалтын төхөөрөмж үнэхээр гайхалтай зүйл байсан бөгөөд тэд уулаас хана хэрэм байтугай байшин барилга гэдгийг ерөөс мэдэхгүй улс билээ. Энэ гайхалтай үйл явдал тэрхүү ханын цаана дайсан этгээдийн, өөрсдөөс нь давуу ертөнц байгаа гэдгийг тэдэнд мэдрүүлэх бөгөөд ийн тал нутгийн морьтон дайчид урьд нь бодох санах юмгүй зүгээр л баяр хөөр болон дайраад ордог байсан нь хумигдах тийшээ ханджээ.

Ийнхүү шинэ арга барил, чиг баримжаа хэрэгтэй болсныг хүннү нарт нэхэл хатуутай ойлгуулж, эцэст нь тэднийг өрнө зүгт хандуулсан шийдвэрлэх түлхэлтийг ойлгохын тулд монгол, эсвэл түрэг нүүдэлч ард түмнийг суусан газраас нь босгож хөдөлгөсөн газар орны байгалийн шинж байдлыг бид эдүгээчилж авч үзэх ёстой. Байгаль дэлхий нь өнөө хүртэл бараг өөрчлөгдөөгүй, өнөөдөр хүннү нарын хуучин нутгийн нэг хэсэг нь Зөвлөлт Холбоот Улс, нөгөө хэсэг нь Бүгд Найрамдах Монгол Ард Улс, гуравдахь хэсэг нь Хятадын нутаг болсон хэдий ч эдгээр орны засаг захиргаа байгаль орчны байдал төрхийг танигдахгүй болтол өөрчлөхөөр ажил хараахан хийгээгүй байна. Энэ нутаг хэдэн сая шоо метр талбайтай учир нэг хиймэл нуур, нэг засмал зам, аль эсвэл төмөр зам байгууллаа гээд байгалийг нэг их өөрчилж чадахгүй.

“Хаалганаас цааш зам толгодын дундах даваан дээгүүр өнгөрнө” хэмээн зуу орчим жилийн өмнө Монголыг дайран өнгөрсөн шотланд хүн Александр Микигийн аялалын тэмдэглэлд өгүүлнэ. “Зургаан цаг явсны дараа газар орон хоёр мянган тохой (фүүт буюу 30,48 сантиметр) болж өргөгдөж ирэх агаад цаашаа явж далайн түвшнээс дээш таван мянган тохой өндөрлөг газар хүрнэ. Хятадууд говь цөлийн хязгаар хүртэл түрэн ирж, цуцашгүй хөдөлмөр зүтгэлээрээ энэхүү үржил шимгүй газар тариалан эрхлэн сууна. Цаг уурын тогтвортой нөхцөл гэж энд үгүй тул найдах юмгүй. Байнга тохиолдох ган гачиг, элсэн шуурга, хар салхи болон догшин аадар бороо ихээхэн хохирол учруулна. Иймээс үр тариа гэмтэж ургац алдсанаар голдуу өлсгөлөн болно. Ийнхүү хятадуудын түрэн ирсэнд монголчууд тун дургүй” хэмээжээ.

Дайсагнал, зөрчил ийнхүү хэвээр үлдсэн агаад харин Хятадын хүн ам асар хурдан өсч дотооддоо ихээхэн дарамт бий болсноор өнгөрсөн хоёр мянган жилд цохилтын чиглэл нь өөрчлөгджээ.

“Нар өдөржин энэрэлгүй шарж байсан ч орой майхнаа босгож байхдаа Микигийн гар сүх барьж гадас шааж чадахгүй болтлоо бээрчээ. Энэ бол найман сарын 26-ны өдөр умард өргөрөгийн 41 градуст болж буй хэрэг...Цэцэг навч алагласан нов ногоон нугад адуу, үхэр идээшилж явна. Тэдгээрийг ойр хавьд нутаглах монгол малчид адуулах бөлгөө. Тэдний гуугалах дуун саруул тунгалаг агаарт холын хол дуурсана. Мики ийнхүү бөмбөгөр гэрүүдийн нутагт ирж, аливаа соёлоос таслагджээ. Түүний үзсэн монгол сүмээр чулуу, шохойгоор бүтсэн барилга байшин дуусах нь энэ. Тэрээр өвс ногооны оронд ирсэн байлаа”.

Өвс ногооны энэ оронд Микигийн үзсэн эхний барилга байгууламж бол Хятадын их хэрэм байлаа. Микигийн замын анд цааш бичсэн нь:

“Микигийн дайрч өнгөрсөн Монгол орны тэр хэсэгт тал газар, эмзэг хэврэг өвс ногоо үелзсэн хээр тал нутаг ээлжлэх бөгөөд заримдаа газар тэгш бус, доворхуу болох ч бүхэлдээ тал нутаг далай тэнгис мэт сэтгэгдэл төрүүлнэ. Энэ тал нутгийн мандалд мод юм уу, өөр түүнтэй төстэй ямар ч юм олж үзэхгүй. Нүдний хараа тогтох зүйл мал сүрэг, гэрээс өөр юу ч үгүй. Намуухан давалгаалах тэнгис мэт тал нутагт нар мандах, жаргах үед энэхүү төөрөгдөл улам ихсэх бөгөөд тэмээг “Цөлийн хөлөг онгоц” хэмээн нэрлэсэн нь тун ч оносон гэлтэй...Цаашлах тусам аажмаар өвс ногоо үзэгдэхээ больж газар цөлөрхүү болж ирнэ. Адуу, тэмээдэд өвч тэжээл бараг олдохоо болих нь хөөрхийлөлтэй. Багширсан адуу, үхэр сүрэг хаана ч үзэгдэхгүй...Монголчуудын говь цөлийн газар зүг чигээ тун ч хялбархан олох чадвар нь Микигийн гайхлыг байнга төрүүлнэ. Шөнөжин явсны эцэст өглөө болоход тэд хаа байгаагаа яв цав мэдэж л байдаг. Тал нутагт хол хол орших цөөн худгийг тэд ямар ч таних тэмдэггүйгээр түвэггүй олно. Нүүдэлчний төрөлх мэдрэхүй нь тэдэнд зүг чигээ зөв олж явахад тусалдаг байна”.

Хятадын нэгэн их хаан христийн тооллоос өмнөх гуравдугаар зууны сүүлчээр тухайн үед аюул осолд нэрвэгдэхээр газруудад барьсан тус тусдаа хэдэн жижиг бэхлэлтээс бүрдэж байсны учир хялбархан тойроод гарчихаж болохоор байсан хятадын их хэрмийг хооронд нь холбож нэгэн их хэрэм болгосноор нүүдэлчний энэхүү төрөлх мэдрэхүйд хязгаар тавьжээ. Хүннү нарыг ч гэсэн ихээхэн хүч дайчлахад хүргэсэн санаандгүй энэ саад бэрхшээл нь тэдний цохилтын хүчийг чангаруулснаар барахгүй хоорондын эв нэгдлийг нь ч бэхжүүлжээ.

Хэрэм байгуулсан тэр цаг үед төр барьж байсан анхны хааныг хүннү нарын өвөг дээдэс hung-по нарт бус харин хүннү нарт хамаатай гэдгийг лавтай хэлж болох агаад тэр хаан бий болсон шинэ нөхцөл байдлын улмаас ард түмнээ чанд зохион байгуулалтад оруулсан байна. Түүнийг Түмэн гэх бөгөөд хятад он дарааллын бичигт түүний цол хэргэмийг шаньюй хэмээн тэмдэглэснийг үндсэндээ хаан хэмээн орчуулж болох юм.

Рахул Шанкритаяана “Төв Азийн түүх” хэмээх бүтээлдээ тэмдэглэсэн хаадын нэрсийн жагсаалтаар Түмэн нь христийн тооллын өмнөх 250 оны орчим төрсөн байна. Насан өндөр болсон хойноо нэгэн залуу бүсгүйтэй дэр нэгтгэсэн бөгөөд түүндээ амь тавьдаг байсан аж. Тэгээд хэзээ хойно холбогдсон энэ хүүхнээс төрсөн хөвгүүнийг хаан ширээнд суулгах атгаг санаа бүхий төлөвлөгөө зохиожээ. Ингээд ахмад хөвгүүн жонон Моодуныг “гоац” хэмээх нүүдэлчин аймагт барьцаанд суулгахаар явуулжээ. Моодуныг гоацийн хааны ордонд хүрэлцэн ирж байх үеэр эцэг Түмэн нь гоацуудыг довтлохдоо хаан ор залгах учиртай ууган хөвгүүнээ гоацуудын гараар үгүй хийх санаа агуулсан ажээ.

Гэвч тухайн үед харь газар барьцаанд очигсод зарим хүний боддогоос огт өөрөөр хувь заяаныхаа жолоог эргүүлж чаддаг байжээ. Аетиус үүнийг нийт Европын өмнө нотлон харуулсан бөлгөө. Түүнчлэн Аттила ч өөрөө нэгэн цагт барьцаанд байсан байдаг. Магад тэрээр Моодун үхлийн аюулаас хэрхэн мултарч чадсаныг өвөг дээдсийнхээ түүх домгоос мэдэж байсан ч байж болох. Эцгээ цэрэглэн ирэх үеэр Моодун гоацуудын адуунаас аргамаг хүлэг барьж унаад зугтан гарч эцгийн зүг тэмцэн очсон бөгөөд хаан эцэг нь сэтгэл уярч тэврэн авчээ. Ийм мундаг хөвгүүнийг алуулах гэж байдаг!

Моодун юу чаддагаа ийн нотлон харуулаад цэрэг захирах болж, хятад эх сурвалжид өгүүлснээр цэрэг дайчдаа сургаж боловсруулахдаа тун ч чанд хатуу байжээ.

“Чингээд Моодун дуут сумууд хийлгээд өөрийнх нь харвасан болгоныг нэгэн зэрэг харвах тушаалыг морьтон харваачдадаа өгөөд чингээгүй хүний толгойг авна хэмээжээ. Ингээд анд явахдаа дуут сумаа тавьсан анг харвалгүй тушаалыг нь зөрчсөн нэгэн цэргийн толгойг даруй авчээ. Дараа нь Моодун өөрийн хайртай хүлэг морио харвасанд бараа бологсдоос зарим нь эзний хайртай хүлгийг харваж зүрхлээгүй тул тэдний толгойг мөн авчээ. Удалгүй Моодун хайртай хатнаа мөнөөхөн сумаар харвасанд энэ удаа ч мөн шадар дагуулуудаас зарим нь харвах зүрх хүрсэнгүй аж. Моодун тэдний толгойг авахуулав. Түүнээс хойш нэг их удалгүй ав хомрогын үед эцгийн авд унадаг аргамаг хүлгийг дуут сумаараа харвахад дагалдагсад бүгд нэгэн зэрэг харвасны дараа л тэрбээр цэрэгтээ бүрэн найдаж болно гэдгээ мэдэж авчээ.

Ингээд бүх юм бэлэн болсны хойно тэр эцгийн хамт авлаж явахдаа дуут сумаар эцгийг харвасанд бүх цэрэг нэгэн зэрэг харваж ийн шаньюйг хөнөөсөн ажээ. Дараа нь Моодун хойд эх (хааны залуу эхнэр), дүү болон өөрт нь захирагдахыг хүсээгүй бүх сайд нарыг хороож өөрөө шаньюй болжээ”.

Үүнийг уншихад хятадын эртний туурь унших буй мэт сэтгэгдэл төрөх ч энэ бол түүх, зарим нарийн ширийн зүйл нь, тухайлбал дуут сум гэгч юу болох талаар янз бүрийн үзэл бодол байж болно. Цэргийн анхаарлыг татаж төвлөрүүлэхийн тулд сумны ёзоорт хэдэн өд хатгаж, шүгэл хийхэд л сум дуутай болно гэж таамаглаж болно. Ийн Хүннүгийн цэргийн хатуу чанд сургууль эхэлсэн мэт бөгөөд тэр нь гоотуудтай байлдахад хүннү нарт илт давуу байдал олгосон морин дээрээс хурдан гавшгай, ончтой харвах чанд сургууль хийгээд мөн хүннү нарын нэг шинж төлөв гэж хэлцдэг ямар ч эргэлзэж тээнэгэлзэж, эрээлж бараалах юмгүйгээр хүн алах сургууль байжээ. Эртний олон зохиогчдын үлдээсэн гэрчлэл нотолгоог уншихад энэ тухайд ямар ч эргэлзээ төрөхгүй.

Эх сурвалж болон хятад хэлнээс орчуулж буй хүний ямар үндэстэн гэдгээс хамаарч Моодуны нэрийг янз бүрээр бичиж буй. Жишээлбэл энэтхэг түүхч Шанкритаяана түүнийг Маудун гэж нэрлэж байхад хятадууд түүнийг Бордур (!) гэж дуудаж байна гэж тааварлан тэр маягаар галиглажээ. Учир нь тэд хүннү нарын авиа дуудлагыг бичгээр буулгаж чадаагүй байна. Мөн Вильям Монтгомери Макговерн “*The Early Empires of Central Asia*” (Төв Азийн түрүү үеийн эзэнт улсууд) хэмээх томоохон бүтээлдээ Моодуны нэрийг тун ч сонин байдлаар бичвэрлэсэн бөгөөд Моодунг эртний “Мао” болгож Маодун хэмээжээ.

Ингээд христийн тооллын өмнөх хоёрдугаар зууны байдлыг тоймлож үзье. Ром их гүрний хэмжээнд очоод байсан ч дэлхийд ноёрхлоо хараахан бүрэн тогтоож амжаагүй байв. Мисир орон Александрын Гэрэг-Азийн гүрнийг залгамжлагчийн хувиар дорно, өрнийн хоорондын гүүр болж, Улаан тэнгисийн боомтууд хийгээд бас Александриа хотод худалдаачид, хөлөг онгоцны эзэд сууж, Газар дундын тэнгис болон Энэтхэгийн далайг мэддэг болсон цаг байв. Харин Азийн цээжинд өөрийгөө дэлхийн төв хэмээн хэзээнээс үзсээр ирсэн Дундад гүрэнд умрын болон өрнийн ард түмнүүдийг бас ч бүгдийг толгой дараалан зэрлэгүүд (barbarian) гэж үзэж болохгүй юм байна гэсэн ойлголт сүүмэлзэх болжээ.

Моодун эхлээд бие хамгаалах торгон цэргийн харваач алуурчдыг өөртөө татаж хуйвалдан ямар ч өрсөлдөгчгүйгээр ганцаар дарангуйлж төр барихын тулд хаан эцгээ алаад зогсолгүй гэр бүлийг нь хүйс тэмтэрсэн нь харгис хэрцгий үйл байсан боловч

ямар нэг байдлаар айсуй цагийн их хүн өөрийгөө зарлан тунхаглаж буй хатуу зорилго мөрдсөн зэрлэг догшин үйлийн дохио байлаа.

“Maodun (=Motun) can in fact be considered as great as conqueror as Cyrus, Darius and Alexander” (Моодун бол Сайрус, Дариус (эртний Персийн их хаад. Орч.), Александр нартай эн зэрэгцэх их байлдан дагуулагч байсан) хэмээн Шанкритаяана 1964 онд Калькуттад хэвлэгдсэн бүтээлдээ тэмдэглээд “Моодун Хятадын эзэн хаан Вэнти-д илгээсэн захидалдаа: Би татаарын бүх овог аймгийг нэгтгэж малчдын их гүрнийг байгуулав. Миний улсыг хүрээлэн оршиж буй хорин зургаан улс орон захиргаанд минь нэгэнт орж алба барьж буй. Хэрвээ чи миний албат нараар их хэрмээ сэт татуулахыг эс хүсэх ахул хэрмийн цаанаас миний газар орон руу зүглэхгүй байхыг хятадууддаа цаазлан хориглосугай гэж бичсэн амой. Эл захидал христийн тооллоос өмнөх 169-156 оны хооронд бичигдсэн байна” хэмээн өгүүлжээ.

3.

Н □□□□ □□ Н □□ □□ □□ □□ □□ □□

Ийнхүү бид их Моодун, гэр хийгээд малчдын их гүрний гайхалтай хааны талаар үндсэндээ түүний дайснууд болох хятадуудын эх сурвалжаас олж мэдэв. Гэвч энэтхэгийн түүхч Рахула Шанкритаяанагийн дээрх харьцуулалт нэг их хэтрүүлж даваадуулсан хэрэг биш гэдэг нь тодорхой. Түүний нэрлэж буй хүмүүсээс эхнийх нь болох Сайрус бол дэлхийн гүрэн Персийг үндэслэн байгуулсан хүн. Дариус бол эртний дорно дахины энэхүү аугаа их хаант улсын амилсан дүр. Александр бол гайхамшигт эр зориг, бадрангүй үзэл санаагаараа бидний сэтгэл зүрхийг ярих тоолонд эзэмдэн дагуулдаг хэдий ч зэрлэг (barbarian) ард түмний төлөөлөгч Моодун бол түүнээс хатан зориг хийгээд буурь сууриараа арай л илүү байжээ гэдэг нь тодорхой агаад тэрбээр дэлхийн бөмбөрцгийн энэ хэсгийн асар өргөн уудам нутгийн төрүүлж өсгөсөн хөвгүүн нь учир түүнийгээ байлдан дагуулж захирах ч учиртай байв.

Ази тивд урьд хожид үзэгдээгүй хамгийн том гүрэн Моодуны уугуул нутаг, түүний үйл ажиллагааны төв болж байсан яг тэр газар нутгаас бүрэлдэн тогтсон юм. Хубилай хаан Моодунаас бүтэн хагас мянган жилийн хойно арван гуравдугаар зуунд Ижил мөрнөөс Хятадын тэнгис, Сибириэс Суматра арал хүртэлх газрын олон ард түмэн, овог аймгуудыг хураан захирч байлаа. Их хааны залуу анд, Венецийн худалдаачин Марко Поло эзэн хааны талбин олгосон алтан пайзыг халаасалж дэлхийн хагасыг тойрон Европт эгэж ирэхдээ их хааны эзэнт гүрний жинхэнэ хэмжээ дамжааг үзэж ойлгосон бөлгөө. Мэдээж Моодуныг шашин, гүн ухаан сонирхогч Хубилай сэцэн хаантай харьцуулах аргагүй. Мөн түрүү үеийн hung-no нар монгол байсан бол Моодун түрэг

овгийн цустай байсан байж мэдэх бөгөөд нүүдэлчдийн ноёд олон эхнэр авдаг байсны учир энэ бол гайхах зүйл биш. Нүүдэлчдийн ноёрхлоо тогтоосон нутгуудаар ноёд тайж нарт богтлон өгөх хөөрхөн хүүхнүүдийг эрж хайж явцгаадаг, мөн харгис ширүүн залхаан цээрлүүлэх ажиллагааны дараа амьд үлдсэн эмс хүүхнүүдийг нь эхлээд заавал хаад ноёдод авчирдаг байсан тухай найдвартай эх сурвалж өгүүлэхийн учир Төв Азийн угсаат хаад ноёд арьс өнгө, үндэс угсааг нэг их чухалчилдаггүйн учрыг даруй ойлгоно. Иймээс эхнэр хүүхний асуудал онцын үүрэг гүйцэтгэх нь үгүй. Варягууд орос эхнэр авснаар өөрсдөө орос болсон бол хятад гүнж нар зэрлэг догшин түрэг нүүдэлчдэд ахуй амьдралын эерэг зөөлөн хэв маяг авчирч, бодлогоширч санааширсан хөвгүүд төрүүлдэг байсан бол иран буюу кавказ гарлын үзэсгэлэнт татвар эм багширсан их сүргийн баян эзэндээ эрт урьдын их соёлынхоо өвийг сэтгэл зүрхээрээ мэдрэхийн учир огт санаанд оромгүй цоо шинэ амьдралыг хүсч мөрөөдөх хөвгүүн төрүүлж өгөх нь байв.

Тиймээс Моодун-Бордурыг үйл хэргээр нь, эзэрхэг түрэмгий үйл ажиллагаа хийгээд байгуулсан ялалт амжилтын жагсаалтаар нь, түүний дараах хүннү нарын зарим их удирдагчдын ажил үйлсээр дүгнэх нь зүй. Энэ хүнд мөнөөхөн увайгүй балмад авир, арга заль хийгээд нүүдэлчний хэзээний дийлдэшгүй бахархал зэрэгцэн оршиж байсан агаад замд нь тулгарах аливаа саад тотгор түүний хувьд улангассан бухыг улаан алчуураар даллах лугаа адил байнгын дуудлага сорилт болж байсан юм. Бас Моодун, түүний аугаа залгамжлагч Аттила хоёрын амьдрал хийгээд ажил үйлс олон зүйлээр гайхмаар адил байдаг нь хэн бугайн нүдэнд тусна. Аль аль нь нэг талаас нүүдэлчдийн байнга гуйвж дайвах хөрс суурьт үндэслэсэн хүчирхийллийн засаг, нөгөө талаас эртний эзэнт гүрнүүдэд хэзээнээс инагш төлөвшиж тогтсон эрх засаг хоёрыг хооронд нь холбож урт удаан хугацааг дамнан амьдрах чадвартай засаглал бий болгохыг хичээж байсан байдаг. Аттила III Валентиниан хааны дүү бүсгүй Грата Юста Хонориаг эхнэр болгон авах гэж хүчлэн оролдож бүтэхгүй болохоор хилэгнэн заналхийлж байснаа хэдэн зуун мянган хүнийг хөдөлгөсний адил сүй тавьж ураг барилдах хүслийг нь Лю овгийн хатан хаан Као-Лю няцаасны төлөө Моодун Хятад гүрний эсрэг асар олон хүний амь насыг үрсэн утга учиргүй дайн хийж байсан билээ.

Хоёр гүрэн аль аль нь хөгжлийн түрүү үе шатанд байсан бөгөөд хүннү гүрний эзэн захирагчид ч, морин цэргийн нэгэн генералаас үүсэлтэй дөрвөн зуун жилийн турш Хятадыг захиран суух, алдар суу нь цууриатсан Хан гүрний эзэн хаадын хувьд ч ид бяр нь амтагдаж байсан үе юм. Хан гүрний хатан хаан Као-Лю Моодун лугаа адил авир араншинтай хүн байсан нь тов тодорхой бөгөөд харин хятад хүн болохоороо мэдээж Моодунаас илүү хурц соргог ухаанаар асуудалд ханджээ. Авааль эр нь нас нөгчих үед ширээ залгамжлагч хунтайж Хяо Хуй дөнгөж арван долоотой байсны учир Као-Лю хөвгүүний өмнөөс төр барьж байжээ. “Хүүхдийн эзэмшлийн эд хөрөнгө бүгд хаан эцэг, эсвэл бэлэвсэрсэн хатан эхийн өмч мөн хэмээх ариун зарчим Као-Лю хатанд ийм эрх

олгож буй бөгөөд эзэнт гүрэн ч, ер газар дэлхий тэр чигээрээ тэнгэрийн хөвгүүний хувийн өмч мөн билээ”. (де Гроот). Эцгийн насан эцэслэснээс долоон жилийн дараа мөнөөх хөвгүүн Хяо Хуй нас барснаар хатан хаан Као-Люгийн захиргаа нэлээдгүй хохирчээ.

Гэвч овсгоо самбаатай хатан хэрхэхээ сайн мэдэж байсан агаад бас ч мэргэн зөвлөхүүдтэй байжээ. Тэнгэр хальсан хуучин эзэн хаан нь Као-Лю хатнаас гадна өөр бусад эхнэрүүдтэй байсан нь мэдээж. Гэвч энэхүү олиггүй нөхцөл байдал Као-Люгийн хувьд аврал болсон аж. Тэрээр хамгийн сүүлд төрсөн жононг эрж сурвалжилсаар эзэн хааны бага хатны арав орчим насны балчир хөвгүүнийг хаан ширээнд залснаар өөрийн эрх засгийг хангаж чадсаны учир нь “Бага хатны хүүхэд бүх хөрөнгө хогшилтойгоо их хатны өмч болно” хэмээх сонгомол зарчим үйлчилж байсан хэрэг болой”.(Де Гроот)

Ийм байдлаар ноёрхлоо бататгасан Као-Лю хатан өөрийн ач, Хяо Хуйгийн хөвгүүнийг нас биед хүрч хаан ширээнд залах аятай цагийг хүлээн амгалан тайван суух болжээ. Өмнө нь тэрбээр хаан ширээг хэлбэрийн төдий эзэлж байсан бага хатны хөвгүүнийг өөрийн биеэр хороосон ажээ. Үүнээс үзвэл Хятадын эзэн хааны ордны ёс заншил нүүдэлч хүннү нарын гэрийнхээс нэг их ялгарахааргүй байсан агаад хагас мянган жилийн хойно ч Византи, Ром юм уу, Аттилагийн орд хүрээний байр байдал ч дээрхээс онцын ялгаагүй байсан ажээ.

Энэхүү өндөр төрөлт хэрцгий гайхалтай Моодун дэр нэгтгэхийг хүсэхдээ энэ нь түүний хувьд асар их эрсдэлтэй аян дайнаас ч илүү аюултай явдал гэдгийг тухайн үедээ тааварласангүй ажээ. Као-Лю хатанд илгээсэн түүний захидал егөөдөл хийгээд эр хүний бардам түрэмгий араншингийн илэрхийлэл байв. “Гоонь эр би ганцаар амьдрах гэж энэ орчлонд төрөөгүй. Гол мөрөн, нуур тойромын дунд төрж тэнүүн тал нутагтаа морь малын дунд өсч өндийсөн би хил хязгаарын нутаг орноороо явж байхдаа Дундад гүрэнд очиж үзэхийг хүсч л байлаа. Эрхэмсэг хатан та тэнд ганцаар бэлэвсрэн сууж ахуйд би энд орь ганцаар байж ядаж сууна Чи бид аль аль нь эзэн хаад нар, гэтэл чи тэнд хуучин ордондоо ганцаар сууж ахуйд би энд ийнхүү баяр баясгалангүй аж төрсөн маягтай сууна. Чи бид хоёрт үнэхээр баясал хөөр авчрах юм юу ч алга даа. Үүний учир чи эзэмшин суугаа юмсаа өөрт байхгүй юмаар соливол яасан юм бэ хэмээн миний бие сэтгэнэм” гэжээ.

Хятадын эзэн хаадын хар багаас сурч дадсан номхон дагамхай, гоёмсоглосон найруулгатай харьцуулж үзвэл эл захидал ямархан шазруун, бараг л жигшмээр өнгө аястай байсныг цэгнэж үзэж болох юм. Хятад хийгээд Энэтхэгт хөгжүүлсэн Азийн дипломатын арга барил ч Моодунгийн захидалдаа бичсэн шиг юмыг чингэж шууд хэлэх арга барилаас мэдээж эрс ялгардаг билээ. Хатан хаан Као-Лю эхлээд ихэд хилэгнэж

бүх нийтийн цэрэг дайчилгаа зарлаж, Моодун хийгээд түүний зэрлэг түмний эсрэг хөдөлгөх гэсэн тухай хятад он дарааллын бичигт дурдсан байна. “Тэрээр дээрх захидлыг хүргэж ирсэн элчийн толгойг даруй авах эсэх, дараа нь эрчүүдийг зэвсэглэж хүннү нарыг дайлах эсэх асуудлыг шийдэхээр гүрний захиргааны хэргийг эрхлэгч Цэн Пинийг Фан Куай болон бусад хүний хамтаар дуудан ирүүлжээ. Эхлээд Фан Куай саналаа хэлж ‘Буман хүнтэй армиар хүннүчүүдийн нутгийн гүнд дайран оръё’ хэмээжээ. Дараа нь хатан хаан Ки Пүгээс саналыг нь асуусанд. ‘Фан Куайгийн толгойг авбал таарна! Тэр саяхан 320 мянган хүнтэй армийн хүчээр Тайд гарсан бослогыг дарах цагийг ашиглаж хүннүчүүд манай эзэн хааныг нийслэл хот Пинцинд бүслэн хаасныг бид мэднэ. Гэтэл Фан Куай тэднээс хол давуу хүчтэй байж бүслэлтийг сэтэлж хааныг аварч чадаагүй билээ. Одоо дэлхийгээр нэг:

Пинцинд их гамшиг тохиолоо.

Хоол унд ч үгүй долоо хонолоо.

Гэтэл Фан Куай тэндээс зайлж явлаа.

Ганц ч сум тавилгүй холдон одлоо.

хэмээн дуулцгааж байна. Энэ дууны цуурай арилж амжаагүй, шархадсан хүмүүс бараг илааршаагүй, хэвтрээс ч босоогүй байна. Гэтэл одоо Фан Куай зуухан мянган хүнтэйгээр Хүннү гүрнийг хөндлөн гулд туулж байлдана гэж эзэнт гүрний амар амгаланг эвдэж, үймүүлж хөдөлгөх гэж байна. Энэ бол эрхэмсэг хатан хаан Таныг нүүрэн дээр тань бялангадаж хуурах л гэсэн арга заль. Эдгээр ху нарын зэрлэгүүдийг мал мэт үзэх хэрэгтэй. Энэ бол тэдний шазруун бүдүүн хадуун үгсэд уурсах хэрэггүйн адил найрсаг үгэнд нь ч баясах албагүй л гэсэн үг юм’ гэж Ки Пү хэлжээ.

Түүний үгс хатан хаанд ихэд таашаагджээ. Тэрээр ‘тун сайн байна’ хэмээгээд захидалд хариу өгөхийг зочид хүлээн авах ажил эрхэлдэг ахлах түшмэдэд зарлиг болгожээ. “Шаньюй миний муу оромжийг мартаагүй, захидал ирүүлж гялайлгажээ. Миний муу оромж одоо айж ичихийн зовлонд автаад буй. Насны наран хэвийн хүч чадал орхин одохын энэ цагт элдэв бодол сэтгэлд минь буух юм. Насан өтөл болж амьсгалахад ч амаргүй болжээ. Үс цайж, шүд унаж алхаж гишгэхэд түвэгтэй болов. Шаньюй намайг буруугаар ойлгосон бол уурсаж бухимдахын хэрэг юун. Миний муу нурж унах дөхсөн оромж ч үүнд буруугүй. Өршөөн хэлтрүүлэх болтугай. Бэлэвсэн эхнэр би таны өршөөл энэрэлийг эдлэх тавилангүй. Гэвч надад дөрвөлсөн морьтой эзэн хааны сүйх тэрэг хоёр буй. Чи үнэхээр босч сууж чадахааргүй болсон бол хөлөглөж явахад чинь зориулж тэдгээр сүйх тэрэгнүүдийг өгье л дөө” хэмээн захидалд бичсэн байжээ.

Би ийнхүү гарамгай хятадач де Гроотын туйлын оновчтой нь ямар ч эргэлзээгүй орчуулгыг иш татав. Тэрбээр орчуулгаа улам баталгаатай болгохын тулд Моодуны

захидал хийгээд хатан хааны хариуг хятад эхээр нь бүрэн хавсаргажээ. Хятадуудын гурвын зэрэг баримт бичгийн эмхэтгэлд энэхүү онигоо маягийн түүхийг өгүүлсэн буй бөгөөд мөн их сайд Ки Пүгийн цадигт ч бас агуулагдаж буй. Үүнээс үзвэл ямар нэг байдлаар эргэлзэх нь зохисгүй мэт бөгөөд харин захидлын эх нь зөвхөн сүүлд гоёчилсноор чимэг хольцтой болсон байж мэднэ.

Моодун зальтай хүн учир хатан хааны няцаалтыг тэвчиж өнгөрүүлээд товчхон захидал бичиж түүндээ өнөөг хүртэл хятад харьцааны арга маягийг сурч чадаагүйдээ уучлал хүсчээ. Тэрбээр ийнхүү өршөөл эрж агт морьд бэлэг болгон илгээсний дараа эвлэрэл дахин ирсэн мэт байлаа. Као-Лю өөрийн ач охиныг Моодунд гэргий болгон илгээсэн бөгөөд тэр нь хатан хааны хүү, нэгэн татвар эмийн дундаас төрсөн бүсгүй бөгөөд явахынх нь өмнө бэлгийн үнэ цэнийг нь өргөхийн тулд яаравчлан гүнжийн зэрэгт дэвшүүлсэн ажээ.

Гэвч хүннү нар шалмаг хөдөлж, эхлээд хоёр удаагийн дээрмийн аян дайнаар хятадын хязгаар нутагт халдаар орж юуны түрүүн баахан хүнийг олзлон авсан агаад дараа нь Моодон шаньюй Төв, Дундад Азийн улсуудыг эзлэн дагуулах их аян дайн хийж үнэхээр дэлхийн түүхэнд орох хэмжээний байлдан дагуулагч болохоо харуулан хэмжээ дамжаагаараа мөнөөхөн хүннү нарын Европт дэгдээсэн улс түмний их нүүдлээс дутахааргүй ард түмнүүдийн их нүүдлийг Азид өдөөсөн байна.

Ястан үндэстнүүдийг яг таг тодорхойлох ажил энх цагт ч тун амаргүй, тэгээд ч тэр нь бөглүү зэлүүд нутаг, аль дивангарын цаг үеийг хамарч буй бол бүр ч хэцүү байдаг бол ард түмнүүд хэзээ хөдөлгөөнд орж, хэзээ дайн байлдаан хийж буй болон аль нь ирж, аль нь явж буйг тодорхойлох ямар ч аргагүй байдаг.

Моодунгийн цаг үе бол соёл, түүхийн хувьд Азийн түүхийн хамгийн сэтгэл татам үе болно. Месопотам болон Ганга мөрний завсар хаа сайгүй Македонийн Александрын халдлага довтолгооны тухай дурсамж шинэхэн хэвээрээ байв. Гэрэгээр ярьж бичдэг ноёд хаан ширээнд сууж, нутгийн бичигтэй зэрэгцэн гэрэг бичиг зоосон мөнгөн дээр дурайж, урлаг Гандхара (*өнөөгийн Афганистаны дорнод хэсэг, өнөөгийн Пешавар хотын орчмын Пакистаны зүүн хойд нутагт буддийн шашинт Гандхарагийн эзэнт гүрэн оршиж, нөлөөгөө тогтоосон нутаг нь Кабулаас Исламабад хүрч, Пешавараас хойшхи Сватын хөндий ч багтаж байсан, энэ гүрэн 1-5 дугаар зуунд шашин, соёлын хөгжлийн оргилдоо хүрч байсан. 2001 онд талибууд энэ соёлын нэг дурсгал Бамианы хөндий дэх бурхан буддагийн хөргүүдийг дэлбэлж устгасан билээ. Орч.*)-гийн эрэн үе хэмээх нэгэн нэрийн дор нэгтгэгдэж тусгай ухагдахуун үүссэн байв.

Гэвч энэ соёлыг тээж явсан ард түмнүүд, тэдний хувь тавилан хийгээд үйл ажил нь Европт ч нөлөөлсөн бөгөөд бид тэдгээр ард түмнийг тун муу мэдэх агаад голчлон хятад эх сурвалжаас зарим ойлголт авсан бөлгөө. Моодун хятадуудын Юе-чи хэмээн нэрлэдэг нэгэн ард түмнийг довтолсон бөгөөд энэ нэрийн дор бидний мэдэх ямар ард түмэн нуугдаж байна вэ гэдэг нь өнөө хүртэл тодорхой бус байна. Рэнэ Грүссэ энэ ард түмнийг христийн тооллоос өмнөх сүүлчийн зуунд алс дорно руу ихээхэн гүнзгий нэвтэрч суурьшсан энэтхэг-европчуудын нэгэн салаа хэмээдэг. Тэд удтал амьдран суусан Таримын сав газрын баян бүрдээсээ хятад, хүннү нарын хоорондын сөргөлдөөн тэмцлийн улмаас шахагдан гарчээ. Тэд Моодунаас удаа дараа хүнд цохилт амссан агаад Моодуны хөвгүүд, их байлдан дагуулагчийг залгамжлагчид тэдэнд улам ч аймшигт хувь тавилан ногдуулжээ. Моодун, нөгөөх хятадын гүнж хэмээгдсэн бүсгүй хоёрын дундаас ч төрсөн байж мэдэх Лао Шан гэгч Юе-чигийн хааныг алж түүний гавлын ясаар аяга хийлгэсэн гэдэг (!). Уул ард түмэн баян бүрд дэх эх нутгаа эгнэгт орхиж өрнө зүг өнөөгийн Афганистаны нутаг руу зугтан зайлахаас аргагүй болсон бөгөөд харин Юе-чигийн бүх овог аймаг бүгд тэнд эсэн мэнд хүрсэн гэхэд хэцүү.

Афганистаны умард хязгаар нутаг бол Бактрийн (*Бактри нь өнөөгийн Афганистан, Узбек, Туркмены завсрын Амударья мөрний дунд, дээд биений дагуу оршиж байсан түүхт нутаг, манай эрэний өмнөх нэгдүгээр мянган жилийн эхний хагаст боол эзэмшигч нийгэм байсан, нийслэл нь Бактра хот, манай эрэний өмнөх 6-4 дүгээр зуунд Ахеменидуудын улс, дараа нь Македоны Александрын улсын мэдэлд байгаад 3 дугаар зуунаас Гэрэг-Бактрийн хаант улс болсон, манай эрэнээс өмнөх 2 дугаар зуунд тохаруудад эзлэгдэн Тохаристан хэмээгдэж байв.*Орч.) гэрэгүүдийн гүрэн хийгээд Ферган дахь өнө эртний худалдааны хотын хамтаар хүн ам шигүү суурьшсан соёлт орон байсан бөгөөд хүн амьтан их ирж очдог, тал хээр ч үгүй, хүнгүй эзгүй газар ч үгүй нутаг билээ. Гэтэл Юе-Чи-гээс эхэлсэн хөдөлгөөн өөр нэгэн хөдөлгөөнийг өдөөв. Хүннү нар буюу хүмүүсийн нэрлэдэгээр зэрлэг хү нар ийн бүх юмыг хөдөлгөөнд оруулав. Эртний Европ үхлийн цохилт амсахаас наана Гэрэгийн сүүлчийн эзэнт улсууд болон Парфийн (*эртний перс хэлээр Парфава гэх агаад Каспийн тэнгисээс зүүн өмнө тийш орших нутагт байсан Ираны морьтон ард түмэн, христийн тооллоос өмнөх 250 оны орчим Сэлжүгийн гүрнээс тасран гарч 500 жилийн турш улс орноо сэлжүгүүд хийгээд ромчуудаас амжилттай хамгаалж байсан, хүч чадлын оргилдоо хүрч байх үед газар нутаг нь Тигр, Евфрат мөрний сав газраас Инд мөрөн хүрч байв. 224 оноос сасанидуудын улсын бүрэлдэхүүнд оржээ.* Орч.) гүрэн хүнд цохилтод өртөж, Хайберын даваа, Инд мөрний наад талын эллинчлэгдсэн (гэрэгийн соёлыг авсан) нутаг орон сүрдэн чичирч байлаа.

“Бидний өгүүлж буй бүхий л түүхийн явцад ийм л байх болно. Хээр тал нутгийн аль нэг хязгаарт өчүүхэн чичиргээ үүсэхэд л тэр нь энэхүү нүүдэл суудлын асар өргөн

уудам нүтгийн дөрвөн зүг найман зовхист урьдчилан тааварлах аргагүй үр дагавар дагуулна”. (Рэнэ Грүссэ)

Тэрхүү “урьдчилан тааварлах аргагүй үр дагавар” гэдэг нь хэтрүүлж даваадуулсан зүйл байсан бөгөөд Хан гүрний хаадын бичээчийн бийрийн үзүүрээс бол хэзээ ч гарах зүйл биш байсан болов уу. Үүнд Грүссэ буруутай бус, хэргийн учир есөн зуун хуудас бүхүй бүтээл дээр ажиллахдаа ганц нэг бүдэрч доголдож болох орчуулагчид л буй. Гэхдээ хэрэг дээрээ энэхүү доктрин гуйвшгүй агаад өршөөлгүй үнэн бөгөөд Ази тивийн үргэлжлэл, хойг болох Европ, асар хүчирхэг их биеийн сэртэн гэхээр алгын чинээ энэ газар их нүүдлийн зорих цаад хязгаар, тэмүүлэн очих сүүлчийн цэг болохын учир нүүж суухын тухайд түүхэн шийдвэр гаргах хэрэгтэй байсны учир говь талын хязгаар хярхаггүй өргөн уудам нутгаас Европ руу нүүн ирэгсдийг уул нурууд, арал хойг, далайн тохой булан болсон зай завсар муутай давчуу энэ нутагт нэг бол ялж дийлэх, аль эсвэл үхэж үрэгдэх хувь тавилан хүлээж байсан агаад гуравдахь зам үгүй бөлгөө.

4.

л □

Моодуны хөвгүүн, хятадуудын нэрлэдэгээр Лао-Шан хэмээгчийг европчууд бид нэг их сайн мэдэхгүй ч түүний аугаа цаг үетэй бол сайтар танилцсан бөлгөө. Лао-Шан дайсан этгээдтэйгээ ангийн олз лугаа адил харьцаж байсан тэр цаг үед Ромын эзэнт гүрэн анхны хямралаа амсаад ах дүү Граккусын (*Гайус Семпрониус Граккус Ромын төрийн зүтгэлтэн, христээс өмнөх 153 онд төрж 121 онд ардын дээд төлөөлөгчөөр дахин сонгогдож чадаагүйн учир амь насанд нь аюул учирснаар нэгэн боолдоо тушаал өгч өөрийгөө алуулжээ. Түүний дүү Тибэриус Семпрониус Граккус Ромын улс төрч явсан, христээс өмнөх 162 онд төрж, 122 онд алагдсан. Ах дүү Граккус нар газрын шинэчлэл хийж жижиг тариачдад газар олгож, томоохон газар эзэмшигчдийн газрын хэмжээг тогтоож өгч байснаар олон дайсантай болсон ажгуу. Орч.*) үед шинэчлэлийг үзжээ. Лао-Шан хосгүй ялалтуудаа үргэлжлүүлсээр байсан тэр цагт Юдас Маккабеус (*Христийн тоолоос өмнөх хоёрдугаар зуунд жүүдүүдийн эрх чөлөөний төлөө тэмцэж байсан хүн.Орч.*) Палестин дахь селюкидуудын (*Македоны Александрыг нас барсны дараа үүссэн, Ойрхи Дорнодод ноёрхож байсан Диадохены улсуудын нэг. Диадохены улсуудын нутаг дэвсгэр Европын Булгаарын өмнөд нутаг Тракийгаас эхлээд өнөөгийн Түрэг, Сири, Ливан, Ирак, Кувейт, Иран, Афганистан, Армен, Тажикистан, Туркменистан, Израиль, Палестины нутгийг хамарч байв.Орч.*) ноёрхлын эсрэг явуулсан жүүдүүдийн эрх чөлөөний тэмцэлд оройлон оролцож амиа өгч байв. Ромын шог зохиолч Теренц “Тайган” хэмээх үзтэл мэдээжийн нэртэй хошин

өгүүллээр үзэгчдийн инээдийг барж байх тэр цагт энэ ертөнцийн юм бүхнээс амсаж хүртэж амжихыг зорилгоо болгосон Лао-Шан Хятадаас энхрий ялдам гүнж авчруулаад зогссонгүй, бас хардаж сэрдэхээргүй шадар хүмүүсээр хүрээлүүлж, нэгэн тарган тайганыг дэргэд нь тавьжээ.

Лао-Шан шаньюй зөвхөн эрчүүдийг л захирч заншсан, ордны тайгантай тэр бүр ойр харьцахгүй учир уул хүн Хүннүгийн хааны ордонд улам бүр нөлөөтэй болж иржээ. Нөгөөтэйгүүр тэрбээр хүннүгийн хүчирхэг ард түмний эмзэг сул талын талаар шаньюйгийн санаанд ороогүй зүйлийг шаньюйд тайлбарлаж Хүннүгийн цэрэгт мянга мянган жилийг дамнан энэ дэлхий ертөнцийн хаана ч явлаа гэсэн ялгаагүй оршсоор байх сул дорой чанарын талаар Лао-Шаны нүдийг нээж өгчээ. “Чи бол их хаан” хэмээн тэрбээр Лао-Шанд өгүүлж “Гэвч Хятад бол чиний дэргэд дэндүү баян улс. Хятадын эд баялгийн тавны нэгээр л чиний бүх цэргийг худалдаж авч болно. Чингэвэл чи ямар ч хүч чадалгүй гэсэн үг шүү дээ” хэмээжээ.

Эр хүний гэх юмгүй болсон энэ тайган цэрэг дайчдыг нэг их тоож үздэггүй байсан агаад улиран өнгөрөх зуунууд түүний зөв гэдгийг харуулах болно. Хүннү нар аян дайны олз омогтоо түүртэж, уг нь ялж дийлэх байсан зарим тулалдаандаа ч ялагдах болно. Арабчууд Пуатье (*Баруун Францын түүхт нутаг.Орч.*)-гийн дэргэд тун муу байлдаж, хамаг олз омгоо хадгалсан гэр майхнаа хамгаалах гэж тулалдсаар Европыг алдах болно. Испаничууд Кортес (*Испанийн конкистадор, Ацтекийн эзэнт гүрнийг байлдан дагуулсан, 1521-1530 онд Шинэ Испанийн жанжин захирагч байв.Орч.*)-ын удирдлагаар бүслэгдсэн Мексико хотоос гарч уур хилэн нь дүрэлзсэн ацтекүүдтай тулалдаж, мөн л олзны асар их алтнаасаа болж далайн буланд хөөрхийлөлтэйгээр сөнөх болно. Хөвөн даавуун дүрэмт хувцас эгэлдрэглэж, яс арьс болсон бууч цэргүүдийг тулалдаанд оруулсан Германы 1918 оны хаврын давшилт холбоотны фронтын жигүүрээс довтлон сэт татахын оронд англи, америкчуудын хамаг нөөцөө хадгалж байсан агуулахуудад саатан зогсох болно...

Төв Азид хэдэн мянган жилээр баян, ядуу улс орнууд зэрэгцэн оршиж, баян бүрд болон гол мөрний хөндийгөөр бие биеэс тусгаалагдахаасаа илүү холбогдож амьдарч ирсэн билээ. Хүннү нар баян, соёлт орнуудад ойр дөт, хөрш зэргэлдээ хэрнээ бусдаас дор ядуу зүдүү амьдардаг хэвээр байгааг хятадууд дээш нь мэдээлэхдээ хүн сайн анч нохойгоо хэзээ ч цадтал хооллодоггүйн адилаар хүннүчүүд байнга өлөн хоосон явдгийн учир эрэлхгээр байлдаж тулалддаг, сайн дайчид байдаг гэжээ.

“Хүннү нар малынхаа махыг идэж шөл ууж, арьсаар нь хувцас хунар хийж өмсөнө. Малд нь өвс ус сайтай бэлчээр хэрэгтэй учир тэд улирлын аясаар өөдөө сөөргөө нүүдэллэн явна. Аюул учрахын цагт сайн морьт цэрэг, дадлага сургууль сайтай

харваачид болж хувирна. Харин аюул ослыг давмагцаа нөгөө л эрх дураар тайван амьдралдаа умбана. Тэгэхээр энэ ард түмний хийх үйл, гүйцэтгэх үүрэг нь хүнд хүчир бус, харин хөнгөхөөн гүйцэлдүүлэхээр бөгөөд хааны зүгээс сайд нартайгаа харьцах харьцаа нь ч энгийн жир, дасч дадсан маягаар явагдах агаад сайд зөвлөхүүд нь нэг их өөрчлөгдөөд байхгүй.

Нийт гүрний зохион байгуулалт нь нэгэн цул бие махбодь лугаа адил. Эцэг, хүү, эсвэл дүү нь нас барах тохиолдолд амьд үлдсэн эрчүүд эхнэр хүүхнүүдийг нь өвлөн авч эхнэрээ болгох ба энэ нь овог аймагт нь учрах аливаа хохирол тэдэнд тун ч дарамттай байдгаас шалтгаалж буй. Хүннү нарт элдэв гай гамшиг бишгүй л тохиолдож байсан ч шинэ шинэ овог аймаг (өөрөөр хэлбэл хүчний шинэ төвүүд) бүрэлдэн бий болж байсан явдал нь үүгээр тайлбарлагдана.

Дундад гүрэнд эцгийн юм уу ахын бэлэвсэрсэн эхнэрийг хүү, дүү нь авч суудаггүй байсан агаад үүнээс үүдэн садан төрлийн хүмүүс дотроо ямар ч эв нэгдэлгүй хэдэн тийш харсан, хэрүүл тэмцэл гарах нь маш их байснаас бүр хүний аминд хүрэх, өөр овог аймагт зайлан одох ч бишгүй явдал гарч байв. Хятадуудын аж амьдралын тогтсон журам (өөрөөр хэлбэл ёс заншил) доройтож муудсан нь дээдсүүд суудлаа олоогүйгээс доод албатууд нь гүйдлээ олохгүй болж харилцан бие биеийг үзэн ядаж дайсагнахад хүргэж байв. Хятадад хүмүүсийн хамаг хүч чадлыг орон байр барих ажилд хэтэрхий ихээр дайчилж байсан ажээ. Түүнээс гадна хүмүүс өмсөж зүүх, идэж уухын тулд тариа тарих хийгээд торго үйлдвэрлэхэд (хүр хорхой үржүүлэх) хамаг хүч чадлаа барж байжээ. Түүнчлэн өөрсдийгөө хамгаалахын тулд хана хэрэм, хот балгас барихад хүчээ шавхаж байлаа. Үүнээс болж аюул занал учрах цагт ард түмэн тэмцэл тулаанд хэзээ ч бэлтгэл сургуультай байсангүй, энх цагт ийнхүү ядарч туйлдах нь их байсан учир мэргэжлийн ажил үйлдээ хүч чадлаа бүрэн дайчилж чаддаггүй байжээ.”

Ийнхүү эрх танхил болж ямбандаа дийлдэж гүйцсэн хятадуудыг зэмлэж буруушаасан өнгөтэй, бараг л түүхч Тацитусын (*Ромын түүхч, манай эрэний 55 онд төрж 120 онд нас барсан, алба хаагч түшмэдийн замыг туулсан, жижиг тэмдэглэлүүдийн зэрэгцээ, христийн тооллын 16 оноо 96 оны үеийг хамарсан “Он дарааллын түүх”, “Түүх” зэрэг бүтээл туурвисан, түүний “De origine et situ Germanorum” хэмээх бүтээл германчууд хийгээд тэдний соёлыг таньж мэдэх хамгийн чухал эх сурвалж болно. Орч.*) ромчуудыг дүрсэлсэнтэй дүйх дүр зураг агаад эзэн хаан Хяо-Вэнээс хүннү нарын хүчирхэг ноён Лао-Шаныг хаан ор суусных нь дараахан ёсыг бодож гүнжийнхээ хамтаар илгээсэн мөнөөхөн тайганаас гарсан үгс юм. Гүнж барьцаанд сууж амь биеэ золиослох энэ хувь тавилангаа наран жаргах зүгийн орнуудад төрийн үйл хэргийн тусын тулд тэнэг мангуу, тэмбүү яртай, эсвэл эр хүний ажлаа хийх чадваргүй болсон хаад ноёдын өвөрт орох хувь заяа тохиосон өдий төдий гүнж нарын нэгэн адилаар нэр төртэй үүрч явахын цагт харин мөнөөхөн тарган тайган

Цүн-Хан-Жю гэгч өөрийгөө цөлөгдсөнд тооцож ихэд хорсохдоо хүчирхэг хүннү нарын ноёны зөвлөх болж хятадуудад чадах ядахаараа хор хүргэнэ хэмээн хаан эзнээ занаж байжээ.

Тиймээс хятадуудад хилэгнэн зэвүүцэж тэднийг шүүмжилсэн нь магад хэтрүүлсэн, дэндүү хатуу байж болох ч Корнелиус Тацитус “Germania” хэмээх зохиолдоо мөн л эрх ямбандаа баригдаж, жаргал цэнгэлдээ ташуурч танхил зөөлөн болсон нутаг нэгтнүүддээ германчууд өөрсдөөс нь юугаар давуу, яагаад тэд ромчуудыг хэзээ нэгэн цагт ялж дийлэхийн учрыг тайлбарласан зүйлтэй агаар нэгэн буй. Ерөөс энэхүү урьд өмнийн түүхийн бүх баримтын адилаар үүнийг иш татаж буйн учир нь дээр өгүүлсэн зүйл сүүл үеийн хүннү нар Европтой учрах тэрхүү анхны уулзалтад ч нэгэн адил хамаарах бөгөөд Хятадын болон Ромын эзэнт улсын ааш араншин, ажил хэрэг адил төстэй байсан нь илэрхий байна. Нүүдэлчдийн аж төрөх ёс, тэмцэл тулаанд байнга бэлэн байх чадвар, элдэвлэж тансаглах эрэлт хэрэгцээ үгүй, бүдүүн борог амьдрал нь хүннү нарт давуу байдал олгож, халдлагад нь өртсөн улс орнууд сайн зэвсэгтэй, ухаалаг удирдлагатай цэргийг тэдний өөдөөс тавьж байсан хэдий ч хүннү нарын мөнөөх давуу тал давагдашгүй хүчин зүйл болж байсан юм.

Хүннү нар Хятадын нутагт дахин дахин гүнзгий нэвтэрч, хотуудын хооронд ямар ч саадгүй тонон дээрэмдэж явах цагт Хан гүрний эзэн хаанд энэхүү гай гамшгийг илбэн тохинуулж, цөлөгдсөн тайган Цүн-Хан-Жюгийн Дундад гүрэнд хийсэн хараалыг хариулах нэгэн мэргэн зөвлөх гарч иржээ. Тэр хүнийг Цао-Цо гэх агаад он дарааллын бичигт түүнийг “угсаа залгамжлах жононгийн гэр бүлийн хэргийг эрхлэгч” хэмээн нэрлэсэн нь буй агаад тэрээр мөн “эрдэм мэдлэгээр дүүрсэн уут” хэмээсэн утгатай хоч нэртэй байжээ. Гэхдээ эл өндгөн толгойт эрхэм бусдаас илүү онолч гэгдэхээр хүн байж дайран дээр давс нэмэхийн адил ажлаа эхэлжээ. Хятадуудын хүннү нараас сул дорой байгаа нь өөрсдийнх нь агт морьдоос болж буй, хятадуудын адуу үржил шимгүй, өвс тэжээл муутай газар бол хүннү нарын хүлэг морьдоос хол дутуу, өчүүхэн нам даваа ч давах тэнхээгүй, дороо л туйлдаж зогсдогийг тэр дурдав.

Хятад цэргүүд байлдах чадвараар хүннү нараас хол дутуу, өчүүхэн өлсч цангахыг даадаггүй, халуун, хүйтэн, элсэн шуурга, цасан шамрагад тэсвэргүй. Хятадууд хөвөн хуяг, урт жад, холын тусгалтай нум зэрэг илүү сайн зэвсэгтэй атлаа зөвхөн ил задгай газар арав дахин илүү хүчтэй байж, морин цэргээс гадна тулалдааны хөнгөн тэрэг, эгнээ эгнээгээр явж илд жадаар байлдаж чадах явган цэргийг оруулбал сая нэг юм амжилтад хүрч чадна.

“Хүннү нараас зугтан манай гүрэнд дүрвэн ирсэн мянга мянган зэрлэгүүдийг улс орныхоо өмнөөс байлдуулах цаг ирлээ. Тэд бол хүннү нарын дайтаж байлдах ур

чадварыг сайтар эзэмшсэн хүмүүс болно. Түүний дээр бид тэдэнд онц сайн хятад зэвсэг агсуулж, сумнаас хамгаалах зузаан хөвөнтэй цэгдэг өмсгөнө. Бид тэднийг холын тусгалтай нумаар зэвсэглэж, хил хавийн нутгаас гаралтай хичээнгүй сайн хятад дарга нараар удирдуулж, тэдний дэргэд зэрлэгүүдийн дундаас хүннү нарын араншин, ёс заншил, байлдах арга туршлагыг сайн мэдэх туслахууд сонгож тавина” хэмээн “эрдмийн уут” хаанд барьсан санамж бичгээ өндөрлөжээ.

Энэхүү “эрдмийн уут” Цао-Цо цааш нь өгүүлэхдээ хүннү нарын нутгийн хил дээр зэвсэгт тариачдыг суулгахаар зөвлөсөн нь мөн л тэр үеэс Оросын хаад болон Хабсбүргийнхэн яг ийм нөхцөлд ихээхэн амжилттай хэрэглэж байсан арга билээ.

“Цин гүрний үеэс (Христийн тооллын өмнөх 300 он) ялтан, боолчууд, элдэв хог шаар болсон амьтсыг тийш илгээж заншсаныг нэн даруй зогсоовоос зохилтой агаад ийм хүмүүс зөвхөн үймээн самуун үүсгэж зодолдож тэмцэлдэх араншинтай байдаг учир дайсныг сөрөн байлдаж няцаахад туслахын оронд хил дээрх тайван бус, тогтворгүй байдлыг улам гааруулна. Үе үе халаагаа өгдөг цэргийн ангиудыг тэнд байлгаж байх нь үрлэгэн, зардал их шаардах тул зохистой шийдэл бус, харин сайн дурын хүмүүсийг тэнд суурьшуулж, албан татвар хийгээд хамжлагын хөдөлмөрөөс чөлөөлбөл ийм хөнгөлөлтүүд нь тэдний төрөл садан анд нөхдийг хил рүү татаж, ийн дайсныг сөрөн тулалдах чадвартай, хаанд үнэнч тариачдын овог, бүлэг бүрэлдэж, хувийн тариан талбайгаа ч, Дундад гүрнийг ч хамтад нь хамгаалах болно” хэмээн Цао-Цо зөвлөжээ.

Энэхүү онцгой ухаалаг арга хэмжээний үр дүн нь бараг л дэлхийн түүхэнд орохоор ач холбогдолтой байжээ. Хятадын тэрхүү зэвсэгт тариачид нь нутгаасаа хөөгдсөн зэрлэгүүд (хүннү нар) байсныг бид эх сурвалжаас мэдэх бөгөөд тэд эхлээд шинэ зэвсэг, хуяг дуулгаа ашиглан хүннү нарт алдаж орхисон зарим зүйлээ буцаан авах оролдлого хийж байсан бөгөөд хэрэв чингээгүйсэн бол өөрсдөд нь даалгасан үүргийг биелүүлж хүчрэхгүй гэдгээ харуулах байсан юм. Энэ нь богино хугацааны хурцадмал байдал үүсгэж, хүннү нар ч хилэгнэн зэвүүцэж байв. Яг энэ үед Хятадын эзэн хаан хүннү нарын хаанд уран тансаг үгтэй захидал бичжээ. Он жилээр ухааны хатуужлыг олсон мэргэн цэцэн хаан хүн шинэ туршлагагүй залуу хүнийг сургаж ухааруулж буй мэт аястайгаар, хуучны их Хятадын сүр хүчийг дахин нэг бадруулж, арга заль, ухааны уужим, санааны цэцнийг хослуулан бас ч өршөөн нигүүлсэх өнгөөр аргадан тайвшруулсан эл захидалд:

“Та бид хоёр хуучны элдэв хэрүүл маргааныг хойш тавилаа. Чамаас зайлж зугтаад манайд ирж баригдсан хүмүүсийг би чамд буцаан өгч буй. Чи ч надад Цан-ни болон түүний нөхдийн тухай ярихаа больж буй. Хуучин цагийн их эзэн хаадын байгуулсан гэрээнүүд яруу тодорхой агаад нарийн хийгдсэн, тэд өгсөн амаасаа

буцдаггүй байсныг би мэднэ. Энэ нь бас хүннүчүүдийн хааны хүсэл зориг мөн учир бидний хооронд ийнхүү эвийн харьцаа тогтсоны хойно тэнгэрийн дор бүх нийтийн энх амгалан ноёрхох болсон цагт Хан гүрний эзэн хаан өөрөө эхэлж зөрчихгүй” хэмээн өгүүлжээ.

Хүннү нар цаашдаа бусад фронтоор ч ялж дийлсээр хятадуудаас тутрага, торго, хоргой, аму тариагаар алба авч сэтгэл ханаж байв. Хүннү нар оргон зайлсан хүмүүсийг буцаан авахыг ихэд чухалд үзэж байсныг сүүлд Аттилагийн Ром, Византитай явуулж байсан захидал бичгийн харилцаа бас нотлоно. Өөрөөр хэлбэл энэ бодлого таван зуун жилийн турш огт өөрчлөгдөөгүй байна. Тиймээс ч энэхүү хүннү нар үнэхээр Аттилагийн хүннүчүүдийн өвөг дээдэс нь үү, эсвэл сургагч багш нар нь байв уу гэдгээс эхлэх хэрэгтэй байв.

Харин Хан гүрний хаад Таримын сав газраар өнгөрдөг аян жингийн зам амгалан тайван болсныг ашиглан улмаар түүнийг өвөрмөц нэгэн байгууламж болгожээ, Урьд нь далай тэнгисийн худалдааны зам нэгэнт тогтсон байсан бол хятадууд хуурай газраар дэлхийн худалдааны замыг гаргасан агаад говь цөлийн хөлөг онгоц гэгдсэн жингийн тэмээд Их Хятадын хэрмийн ногоолин хаалганаас Евфрат мөрөн хийгээд Газар дундын тэнгисийн эрэг дэх Сирийн боомтууд хүрэх холхи газрын дардан замыг туулах болжээ. Ийнхүү Хятад Европыг, Европ Хятадыг таньсан билээ. Хан гүрний хаад өрнийн улс түмнүүдийн тухай маш дэлгэрэнгүй мэдээ занги авч, Сирийн худалдаачид торгоны эх орны тухай, тийш хөтөлж очих замын талаар ихийг олж мэдсэнээр Тирүсийн Маринус (*Эртний Гэрэгийн газар зүйч, манай эрэний 1 дүгээр зууны сүүл, 2 дугаар зууны эхээр амьдарч байсан.Орч.*) гэгч газар зүй сонирхогч нэгэнд өдий төдий сонирхолтой мэдээ сэлт болон аян замын тайлбар дүрслэлийг өгсөн бөгөөд тэдгээр материал нь сүүлд газар зүйн бүх үеийн хамгийн алдар цуутай бүтээл болох Клаудиус Птолемаеус (*Манай эрэний 100 оны орчим төрсөн, Гэрэгийн математикч, газар зүйч, одон орон судаач, зурхайч, хөгжмийн онолч, гүн ухаанч. Орч.*)-ийн “Газар зүй” хэмээх зохиолд бараг тэр чигээрээ оржээ.

Христийн тооллын өмнөх 115 оны үед Хятадын бүхий л үеийн хамгийн аугаа хаадын нэг болох Ү-Ти нэгэн ихээхэн боловсролтой туршуулыг өрнө дахин руу илгээжээ. Түүнийг Чан-Кин гэх агаад харамсалтай нь тэрбээр бидний үед зөвхөн дэлгэрэнгүй ишлэлүүд хэлбэрээр хүрч ирсэн баруун орнуудын тухай томоохон бүтээл туурвисан ажээ. Тэрээр юуны өмнө Хятадтай хил залгаа, өнөөгийн Афган, Персийн нутгийн тухай, түүнчлэн Балхаш нуур, Арал тэнгис, Каспийн тэнгисийн завсрын тал нутгийн тухай өгүүлсэн байна. Тэндхийн ард түмнүүдийг тоочиж, тоог нь баримжаалж, эдийн засгийн чадавхи боломжийг нь бараг л орчин үеийн эдийн засагчийн нүдээр харж

дүгнэсэн ажээ. Чан-Кин өргөн дэлгэр мэдээ занги, худалдааны нэлээд гэрээ хэлэлцээрийг эзэн хаан Ү-Тид авчирсан байна.

Тэмээн жингийн худалдааг хүннү нар нэг их үймүүлж түйвээсэнгүй, энэ худалдаа Хятадаас Зааны орон (Энэтхэг), Персээр дамжин Евфрат хүрч, өрнийн орнуудтай хэдэн арван жилийг дамнан явагдсаар байжээ. Энэ бол өвөрмөц ач холбогдол бүхүй зааг үе байсан бөгөөд тухайлбал хятад судлаач гарамгай эрдэмтэн Фрийдрих Хирт Дундад гүрний түүхийг христийн тооллын өмнөх 115 оноор зааглаж үзэхийг санал болгосны учир нь урьд нь Хятад бусад дэлхий ертөнцөөс ангид тасархай оршиж ирсэн бол энэ цаг (115 оноос) үеэс эргэн нийлсэн юм гэж үзэж байв.

Христийн тооллын өмнөх 25 оны орчим буюу барагцаалбал гурван үеийн хойно хуучны тайван бус, тогтворгүй цаг үе эргэн иржээ. Хятадын сул дорой хаад хүннүчүүд болон бусад нүүдэлчдийг баян бүрдийн зам харгуйгаас ангид хол барьж байлгаж чадахгүй болж, түүнээс бүр доогуур өмнө этгээдээр өнгөрөх говь цөлийн зам тэмээн жинд туулахад ихээхэн хүндрэлтэй болох нь харагджээ. Гэхдээ ямар ч болов хүний амьдралын хэдэн үеийг дамнан өрнө зүг нэгэн цонх нээгдэж гүүр тавигдсан байсан агаад тэр нь мянга илүү жилийн хойно Монголын их хаадын үед тэдний гарамгай зохион байгуулалт бүхүй өртөө шуудангийн замын ачаар дахин нээгдсэн бөлгөө. Хүннүчүүд чөтгөрийг чөтгөрөөр нь хөөлгөж (хорыг хороор дарах) гаршсан этгээд буюу нэгэн дайсантай учирчээ. Европт харин тэрхүү чөтгөрийн эрэл бүтэлгүйтэх нь магад байв.

III. □лн

ЛсйиЛМй□□ Л□□ сшн □□

1.

□□□□ □□□□ □ **A** □□□□□□

Бид Европт байлдаж буй хүннү нарыг христийн тооллын 434 оны орчимд орхисон билээ. Хатан хаан Евдокиа бурхан тэнгэрт мөргөн гуйж хүннү нарын хаан Ругилад Визант хотод аюул занал учруулж амжихаас нь өмнө завдан аянга цахилгаан буулгасны хүчээр тэрбээр тамд одсон байв. Дорнод Ромын нийслэл Визант хотод наран жаргах зүгийн өөр бусад аль ч хотоос илүүтэй хууран мэхлэх, садарлаж самуурах, матаж ховлох, хөрөнгө мөнгө үрэн таран хийх ажил явдал ихэд дэлгэрсэн бололтой байдаг агаад дараагийн мянган жилд ч үүнийгээ тавилгүй, эцэст нь хүннү нарын холын хамаатан османууд 1453 онд энэ бүхнийг эцэслэн цэг тавьж Визант хот эздээ солих үеийг хүртэл үргэлжилжээ.

Ругила амьдралынхаа сүүлийн жилүүдэд хүннү нарыг ганцаар захирч ирсэн агаад түүнтэй хамтран төр барьж асан дүү Октар нь хэдэн жилийн өмнө нас баржээ. Энэ хоёрын дараа мөн л ах дүү нар Бледа, Аттила хоёр засгийн эрхэнд гарсан нь Мисир оронд нэг хэсэг эгч дүү хоёр төр барьж асан, мөн өнөөдөр ч Сан Марино хэмээх усан үзмийн мод ургасан налуу ухаа толгодоос тогтсон энэ бяцхан үзэсгэлэнт оронд хоёр капитан-регент (*capitani reggenti*) төрийг захирч буйн адилаар Хүннү гүрэнд хоёр хаан төр барих засаглалын тун сонин хэлбэр заншсан байжээ гэсэн таамаглал төрж буй юм.

Гэвч хуучны хятадын Хүннү гүрний хаадын нэрсийн жагсаалтад хоёр хааны засаглалын ийм тогтолцооны талаар христийн тооллын өмнөх 127 оны хавьд Ихизэ хэмээх нэгэн хаан эцгээс бус ахаасаа хаан ор залгамжилсан тухай дурдсаныг эс тооцвол өөр ямар нэг барьцтай зүйл олдоогүй. Хүннү нар олон эхнэр авдаг байсны учир хааны шууд удам угсаа эрэгтэй талаасаа хангалттай байсан нь тодорхой бөгөөд

тиймээс хаан ширээ хааны ах буюу дүүд шилжиж байв. Гэхдээ хүннү нарын нас нөгчсөн хоёр хаан Ругила, Октар хоёрт бас өөр хоёр ч дүү, тухайлбал Мүндзүх, Оебарсиус нар байсан бөгөөд Ругилаг нас барах үед (Түүний нас барсан жил 448 он болох нь мэдэгдэж буй) лав л Оебарсиус нь амьд байсан нь бидэнд мэдэгдэж буй тул будлиан үүсч байгаа хэрэг. Энд хааны дүү, бүр нэгээр тогтохгүй хэрэв Мүндзүх бас амьд байсан бол хоёр ч дүүгээс нь жонон нарыг илүүд үзсэн хэрэг болж буй.

Энэ бүх будлианы цор ганц боломжийн тайлбар нь хүннү нар аливаа чухал шийдвэр гаргахдаа гагцхүү нарийн учир холбогдлыг л хатуу мөрдлөг болгодог байсан явдал болой. Бледа, Аттила хоёр авга ахыгаа нас нөгчиж суудал нь эзгүйрэх үед нусаа гоожуулсан жаалууд байсангүй. Тэр хоёр хоёул хэдэн арван тулалдаан хийсэн, нийт ард түмэндээ танигдсан байсан нь эргэлзээгүй. Тиймээс ч энэ үед магад хэдийн жаран насны босгыг алхчихсан хэн нэг авга ахыг нь тэднээс илүүд үзэх учир шалтгаан үгүй. Тэр үед Аттила гучин естэй, Бледа түүнээс арай ах байсан бололтой байдаг агаад тэд засгийн эрхийг авч мөнөөхөн Октар, Ругила нарын адилаар эрх засгаа хувааж авахдаа эрх үүргийн дагуу бус, харин газар зүйн орон зайг голчилсон нь мөн л зүй ёсны хэрэг байв. Жинхэнэ хоёр хаан төр барих уламжлалт ёс тогтнож буй үед жишээлэхэд Аттила их цэргийн жанжин, Бледа дээд тайлгач болох ч юм уу, эсвэл нэг нь дайн тулаанд, нөгөөх нь энх цагт ард түмнийг удирдах ёс байж болох байв. Ийм ёс Германы зарим нэг овог аймгуудад байсан бололтой байдаг. Гэвч энэ нь хүннү нарын хувьд дэндүү хуурмагласан (*sophisticated*) хэрэг болох бөгөөд юуны өмнө тэд энэ завсар хэтэрхий их газар нутаг эзлэн дагуулаад байсан юм. Энэ нүдний хараа цуцам асар өргөн уудам газар нутгийг хуваахаас амархан юмгүй.

Аттила, Бледа хоёр эртнээс инагш хүннү нарын үе үеийн хаадыг төрүүлсээр ирсэн нэг л овгоос, нэг л гэр бүлээс гаралтай, бүх эрчүүд нь үндсэндээ нэг л адилхан хүсэл санаархалтай байжээ гэдэгт эртний бүх эх сурвалж санал нийлдэг. Үнэхээр ч зөвхөн хамгийн шилдэг, хамгийн хүч чадалтай нь юм уу, өөрөөр хэлбэл хамгийн өршөөл энэрэлгүй, харгис хатуу нь төрийн эрхийг авч байжээ. Өдий төдий ах дүүс, ач гуч нар, татвар эмсийн хүүхдүүд, аль эсвэл хаан эзний суудалд санаархагч өөр бусад олон хүн ганц хүннүгийн улс ч бус, ер нь хаа сайгүй л маш хурдан үхэж үрэгдэж алга болж байсан билээ. Ийм явдал эртний Мисир оронд заншиж тогтсон л байсан, Британийн хааны удмынхны ийм жишээ ч дэлхийн утга зохиолд хачин сонин сэдэв болж байлаа.

Аттила, Бледа хоёрын аль аль нь үүнийг мэдэж байсан, гэхдээ эевэргүү зөөлөн, баяр баясгалантай хэмээн дүрслэгддэг Бледа нь Аттилагийн хувьд аюултай хүн биш байв. Түүн шиг гэм зэмгүй хүнийг замаасаа зайлуулна хэмээн Блеагийн санаанд ороогүй байж магад. Гэвч Бледа өөрөө хүнийхээ хувьд гэмгүй, өөрөө бол ямар ч аюул

осол учруулахгүй байсан хэдий ч шаргуу шийдмэг Аттилагаас тусгаарлаж салахыг хүсэгч хүннүчүүдийн аль нэг бүлэг дуртай цагтаа түүний нэрийг барьж ашиглаж болох байсан учир үхэх л учиртай байлаа.

Юстинианы (*Византи буюу Дорнод Ромын гүрний эзэн хаан. Орч.*) төрийн сайд, Иллир нутгаас (*Балканы хойгийн баруун өмнөд нутаг, Аппенинийн хойгийн зүүн өмнөд этгээдэд нутаглаж байсан эртний энэтхэг-европ гарлын овгууд, тэднийг христийн тооллоос өмнөх нэгдүгээр зуунд ромчууд эзлэн дагуулсан. Орч.*) гаралтай Марчеллинуc Комес Дорнод Ромын эзэнт гүрний он дарааллын түүх бичиг хөтөлж байсан агаад түүндээ 379-534 оны хооронд болсон олон чухал үйл явдлын он цагийг гайхалтай нарийн тодруулж бүрдүүлсэн байв. Бледаг хороосон үе нь 445 оны хавар агаад аян дайны тухай болон элчин төлөөлөгчийн мэдээ зангид дурдсан бүх баримтад тулгуурласан судалгаатай тохирч байгаа бөгөөд цаашдаа ингэж орсон байна. Аттила үнэхээр нийтээр үздэгээр 395 онд Дорнод Европын хаа нэгтээ мэндэлсэн юм бол бүх хүннүчүүдийг ганцаар захирах болсон үедээ тэрбээр тавин насны сүүдэр зооглосон байсан хэрэг. Тэр хүртэл Аттила өмнө нь Октары удирдаж байсан өрнийн аян дайныг, Бледа нь Ругилагийн адил дорнын аян дайныг удирдаж байсан хэрэг билээ. Эцэстээ ганцаар засаглах болсон Ругилагийн жишээ дэргэд нь өсч бойжин удирдлагад нь он удаан жилээр байлдаж явсан Аттила авга ахын нэгэн адилаар хүннү нарыг бүгдийг нэгтгэн захирч улмаар бүх Европыг захиргаандаа оруулах хүсэл шуналыг нь төрүүлсэн байж таарна. Учир нь хэдийгээр Ругилагийн үхлийн улмаас хүннү нарт хүнд гарз хохирол тохиосон ч тэдэнтэй дангаараа сэргэлдөж давах хүч тэр үед Европт хараахан байсангүй. Энэ нь хүннүгийн дайснууд эв нэгдэлгүй, нөгөөтэйгүүр хүннү нар өөрсдөө байнга холбоотонтой, тэднийгээ зөв сонгодог байсантай холбоотой байжээ.

Авга Мүндзүх нь амьд ахуй үедээ, мөн Оебарсиус авга нь ганцаар ноёрхох, эрх мэдлийг гартаа бүрэн оруулахын төлөө жолоо цулбуургүй мэт мятарч няцахгүй тэмцэж явсан энэ ноёны замд хөндөлдөх гэж хуруугаа ч хөдөлгөөгүй бөгөөд ийн төвийг сахисныхаа ачаар Оебарсиус авга нь хүннү нарын байнгын дайн тулаан дунд өнгөрдөг амьдралын хатуу ширүүн нөхцөлийг харгалзан үзвэл нэлээд уртад тооцогдох жар илүү нас сүүдэр зооглосон ч байж мэднэ. Харин Мүндзүхийн талаар 434 оноос хойш ерөөс ямар ч сураг чимээ гараагүй байх юм.

Энэ бүхний эцэст Аттила нь их Моодуныг төрийн толгойд гарахад тус дөхөм болсон тэр л зан чанарыг агуулсан хүн байжээ хэмээн бидэнд дүрслэгдэж байгаа бол харин хүннү нарын ахуй амьдралын нийгмийн хэлбэр нь Орхон гол, Долоон мөрний завсрын нүүдэлчний тэрхүү амгалан амьдрал лугаа адил тийм ч бүдүүн борог байсангүй ажээ.

Авга ах, ач нарын хүрээ хийгээд эрх засаг бидний анхлан танилцсан тэрхүү Баламберээс Үлдин хийгээд бидэнд төдийлөн танил бус хаан Донатус, Харатон нарт ямар нэг саад тотгоргүйгээр шилжсээр эцэстээ шууд удмын хүмүүс болох Үлдиний хөвгүүн Октар, Ругила нарт буцаж ирсэн зэрэг нь хүннүгийн дээд язгууртнууд эрт урьдын бат бөх үндэс суурьтай ноёлогч нэг овогт багтаж байсан, тэд овгийнхоо хүрээнд эрх засгаа цаашаагаа саадгүй шилжүүлсээр ирсэн гэдгийг харуулж буй. Хөндлөнгийн этгээд эрх засагт нэвтрэн орох ямар ч боломжгүй байсан агаад засгийн эрхийг хүчээр булаан авлаа ч ноёрхогч овгийн бат бэх эв нэгдэлтэй тулгарч толгойгоо алдаж байсны учир бол хэдийгээр хожим хойно ах дүүсээ хийгээд эцгээ алах явдал мэр сэр гарч байсан ч гаднын өнгөлзлөгийн эсрэг бол эцгүүд, хөвгүүд Үлдиний ах дүүс төмөр мэт эв нэгдэлтэй хатуу зогсож байсан ажгуу.

Хүннү нарын түүхийн зөвхөн Европын үеийг л аваад үзэхэд тэд цэрэг дайчны амьдралаар амьдарч байнга булаан эзэлж түйвээн сүйтгэж явдаг болохоор хүннү нарын дээд язгууртан ангид зөвхөн эрчүүд багтдаг байсан гэж ойлгож болох юм. Гэтэл тийм биш ажээ. Тухайлбал Бледа Зерко хэмээгч нэгэнд хүннү нарын нэгэн „сайн язгуурт“ гэр бүлээс гаралтай бүсгүйг эхнэр болгон өгсөн гэх агуулгатай эртний сурвалж байна. Тэр бүсгүй урьд нь хааны ордонд сууж байсан хатан хүн (!), хааны хатан, өөрөөр хэлбэл Бледагийн их хатны дэргэдийн хүн байсан гэжээ. Дараа нь тэр бүсгүй бяцхан алдаж эндсэний учир ордноос зайлуулагдсан гэх ажээ. Энэ явдал нь Зерко хэмээгчийн хувьд бол яав ч ихээхэн өршөөл ивээл үзүүлж буйн нотлогоо байсан ба харин дурдсан бүсгүйд бол шийтгэл болсон биз. Учир нь Зерко Блеагийн ордны алиа салбадай агаад тэнэгдүү этгээд байсан ажээ.

Эртний Гэрэг, Ромын элчүүдийн мэдээ тайлангаас олж танилцаж буй Европт ирсэн хүннү нарын нийгмийн амьдрал дахь тэрхүү харьцаа нь мал сүргээ адуулж, бэлчээрийн аясаар нүүдэллэн амьдрагч Азийн хүннү нарын дүр төрхтэй нийцэхээ больсон ажээ. Аттилагийн үеийн хүннү нарын нийгмийг хэрхэн дүгнэх вэ?. Тэдний зэрлэг бүдүүлэг байдал нь ямар хэмжээнд байв?. Тэр цаг үед зэрлэг хэмээгдэж байсан бусад ард түмнүүдтэй яг адилхан байв уу, эсвэл тэднээс давуутай болсон байв уу?.

Саяхны хэдэн зууныг хүртэл бүхэнд илэрхий, энд ишлээд байх ч шаардлагагүй цор ганц санаа бодол түүх бичлэгт ноёрхож байв. Азийн үй олон зэрлэг нүүдэлчдийг Германы үндэсний социалист (*Хитлэрийн фашист нам. Орч.*) намынхаар зогсохгүй, бусад түүх бичлэгт ч ялгаагүй зөвхөн түйвээн сүйтгэгч хэмээн хочилж, өөрийн гэх дэг журам, нийгмийн байгууллыг бий болгоогүй, ямар ч үнэт зүйл, үнэлэмжийг хүлээн зөвшөөрдөггүй гэж дүрсэлдэг бөлгөө. Энэ нь жишээлбэл славчуудыг төр улс хийгээд хот орон байгуулах ямар ч чадваргүй гэх нотолгоогүй үнэний (аксиом) нэгэн адилаар хавтгайруулсан дүгнэлт юм. Дараа нь славчуудын бий болгосон төрийн мөн чанарыг

харгалзан үзэхээс өөр аргагүй болоод ирэхийн цагт түүнийг германчуудаас энд тэнд хэсэн явагч овсгоот элитүүдтэй холбон үздэг байв. Дундад зууны эхэн үед олон улсын худалдаа өрнүүн явагдаж байсан славчуудын цэцэглэн хөгжсөн хотуудыг мөнөөхөн зөрүүд толгойтнуудын бүлэг энгийн бүдүүн борог зээлийн газар болгон дордчилж, германы хаад ноёдоос хэн нэг нь гар бие оролцсон л бол тэдгээр нь цэцэглэн хөгжсөн хотын зэрэгт нэг юм хүрдэг байж.

Ийм маягийн түүх бичлэгийг эсэргүүцэгчид мөн л онилсон байгаа бараг л давуулчихсан нь илэрхий бөгөөд хүннү нар зэрлэг бүдүүлэг оршихуйн сүүлчийн бөгөөд дээд шатанд гарсан байсан бөгөөд ийнхүү баатарлаг туульсын цаг үед амьдарч байсан гэрэгүүд буюу Троя хотыг бүслэн байлдаж асан гэрэгүүдтэй эн зэрэгцэхүйц хэмжээнд очсон хэмээн Фридрих Энгельсийн бичсэнийг үзэж болно. Дайны хэргийг мэдэж захирах хаан, дээд зөвлөл, ардын их хурилдай зэрэг нь аль алинд нь цэргийн ардчиллын шинж төрхийг цэргийн аргаар бүрдүүлж байсны учир нь дайн хийгээд түүнд бэлтгэх явдал бол тухайн ард түмний ердийн, өдөр тутмын, бараг л цор ганц ажил үйлс нь байсан хэрэг юм. Энгельс цааш нь өгүүлэхдээ, хөршүүдийнх нь эд баялаг шуналыг нь өдөөж, түүнийгээ дээрмийн дайнаар хангаж байсан бөгөөд ийнхүү дээрэм тонуул нь бүхэл бүтэн ард түмний хувьд ердийн, байх ёстой зүйл агаад эн тэргүүнд аж төрөх хамгийн эгэл жир хэлбэр болж үзэгддэг байна гэжээ. Уугуул оршихуйн хэлбэр нь хүннү нарын хувьд бол нүүдэлчин ахуй, гэрэгүүдийн хувьд газар тариалан байсан нь мартагдан үгүй болжээ.

Мэдээж Энгельс хүннү нарын тухай өгүүлээгүй, тэрбээр Одиссейн үеийн гэрэгүүдийг хүннү нар гэж тодорхойлохын тулд л хүннү нарыг дүрслэн үзүүлсэн хэрэг. Зөвлөлтийн эрдэмтэд буурьтай агаад хичээнгүй аргаараа Агамемнон (*Гэрэгийн домогт гардаг эртний Микэнэгийн хаан, Микэнэ нь өнөө балгас хот, Хомер Микэнэ Агамемноны төрөлх нутаг хэмээсэн, энэхүү Микэнэ нь христийн тооллоос өмнөх хоёрдахь мянган жилд тогтнож байсан Микэнэгийн соёлын голомт байсан гэдэг. Агамемнон хаан гэрэгүүдийг Трояны дайнд удирдсан бөгөөд хатан нь түүнийг дайнаас буцаж ирэхэд нь нууц амраг Эгистүстэй нийлж алсан гэдэг домог бий. Орч.*), Аттила хоёрыг зэрэгцүүлэн тавьж, ийм байдлаар хүннү нарын үнэ цэнийг өргөж өгсний учир бол хүннүчүүдийг наад зах нь газар зүйн талаасаа өнөөгийн зөвлөлтийн ард түмнүүдийн өвөг дээдэст хамруулан үзэх учир шалтгаан байгаа болоод л тэр юм.

Хүннүчүүдийн байдлыг юуны өмнө археологийн талаас нь тодорхойлохоор ЗХУ-д хийж буй түүхийн сүүлийн үеийн шинэ судалгаа ихээхэн гавьяатай бөгөөд хүндрэлтэй байдлаас гарах диалектик гарцыг олсон билээ. Хүннү нар нь хэдийгээр эртний Гэрэгийн дээрэмч дайнч хаадын нийгэмтэй нэг шатанд байгаагүй ч өнө эртний гэрэг дахинаас

шат ахисан нь илэрхий бөгөөд учир нь тэд Газар дундын тэнгисийн сав газрын боолын нийгмийг үгүй болгоход шийдвэрлэх түүхэн түлхэц өгсөн хэмээжээ.

Ийм явдал түүхэнд мэдээж их байсан бөгөөд хүннү нар чухамхүү нэг нийгмийн формацийг устгаснаар өөр шинэлэг, сүүл үеийн формацийг бий болгоход тус дөхөм үзүүлсэн нь үйл явдлын зүй ёсны өрнөлд нийцэж буй.

Асуудлыг ингэж эргүүлсэн А.Н.Бернштамд нэг их гомдоод байх учир шалтгаан бага агаад тэрбээр хэрэв ЗХУ-ын баатар үгүй юм гэхэд ямар ч болов хүннү нарын тухай судалгааны баатар болох байсан нь дамжиггүй бөгөөд тэрбээр үхлүүд өвчтэй байхдаа ч сүүлчийн амьсгалаа хураатал хээрийн судалгааны хүнд хүчир ажилд бие сэтгэлээ зориулсаар байсан болой.

Хэрвээ Энгельсийн зөв байгаагүй юм бол олз омог, мөнгөөр авах алба татварын төлөөх хүннү нарын ханаж цаддаггүй шуналыг тэдний нүүдэлчин өв удмын үүднээс тайлбарлаж, „Капитал“-ынхаа нэгдүгээр ботид „Нүүдэлчин ард түмнүүдийн бүхий л эд хогшил нь хөдлөх хэлбэрээр, үүний учир шууд зарж борлуулах хэлбэрээр тогтнож байдаг, тэдний аж төрөх ёс нь өөрсдийг нь өөр бусад харь улс түмнүүдтэй хэлхээ холбоонд байнга оруулдаг, тиймээс ч бүтээгдэхүүн солилцоход хүргэдэг учраас тэд эхлээд л мөнгөний хэлбэрийг хөгжүүлдэг байна. Хүмүүс хүнийг өөрийг нь боолын хэлбэрээр мөнгөний уугуул материал болгон ашигласан бөгөөд харин газрыг бол хэзээ ч чингээгүй юм“ хэмээсэн Марксыг бол эсэргүүцэж маргалдах хүн гарахгүй биз.

Хүннү нарыг мөнгөнд тэглээ шунан тачаадуулж, харь өөр бусадтай шүргэлцэж холбогдохыг үхэн хатан тэмүүлэхээс өөрийг бодохгүй болгосон зүйл юу вэ? Аттилагийн хувьд бол „бараа бүтээгдэхүүн солилцох“ явдал амин чухал үйл байсан болой. Харин Агамемнон бол гэртээ амар тайван сууж байж болох байсан, учир нь Хеленаг (*Гэрэгийн домгийн Зевс, Леда хоёрын охин. Орч.*) орлох хүн мэдээж түүнд олдох л байсан биз.

2.

з А□□□, □□□, □□□

Одиссей он удаан жилээр Газар дундын тэнгисээр бэдэрч төөрч замаа олохгүйгээс шадар хүмүүсийнхээ хамтаар орон гэртээ эгэж ирж чадахгүй байсан бол үүнд тэр үед луужин байгаагүй нөхцөл байдал буруутай бус, харин түүний хувь заяаны талаар бурхад нэгдмэл санаа бодолд хүрч чадахгүй хэрүүл маргаанаа Одиссейд үүрүүлснээс болсон хэрэг бөлгөө.

Хүннү нар үнэхээр Троя хотыг байлдан дагуулагчидтай ерөнхийдөө соёлын нэг түвшинд байлаа ч гэсэн тэд хүний сэтгэлийг соронздон татах бурхдын чуулгыг бүрдүүлж бүтээж чадаагүй нь эргэлзээгүй бөгөөд тиймээс ч их, бага чөтгөр шулмас гэх мэтхэн ядуухан зүйлээр аргацааж байжээ. Тэд мухар сүсэгт автагдсан байсан нь ямар ч эргэлзээгүй бөгөөд бурхад ч байна уу, чөтгөр шулмас ч байна уу ялгаагүй аль аль нь амьдралын замыг заагч хүч нөлөөтэй хэмээн үздэг байсны учир энэ талаар яриад байх зүйл нэг их биш. Хэдэн тэрбум элсэн ширхэгийг хуйлруулан шуугих салхи шуурга ч, уулсын хавцал халилд улих хар салхи ч тэр ялгаагүй газар дэлхий ертөнц, агаар тэнгэрийн шулмасын дуу хоолой гэж үзэх бөгөөд эртний Гэрэг, Ромын зохиогчдын буруутган бичдэгээр тэдний хувцас хунараа ерөөс угаадаггүй нь усны шулмасыг гутааж доромжлохгүй гэсэн гүн учир шалтгаантай байв.

Аянганд цохиулан амиа алдсан Ругилагийн үхэл бол ердийн муу ёр зөгнөсөн явдал байсан агаад, ийм л байдлаар хүмүүст ойлгогдож, улмаар энэ үйл явдал урт удаан хугацаагаар бэлтгэсэн аян дайныг зогсооход хүргэж буцах шийдвэр гаргахад хангалттай үндэс болжээ. 1241 онд их хаан Өгөөдэй гэнэт тэнгэр хальсан явдал үүнээс өмнөхөн Лигницийн дэргэд Герман-Польшийн хөлөг баатруудын армийг ялсан ч гэсэн үндсэн цөм нь монголчуудаас бүрдсэн их цэргийг буцаахад хангалттай шалтгаан болж өгчээ. Чингис хаан нэгэн учир битүүлэг мэргэ төлөг бодож олсон нь бөө нар хамаг ур чадлаа шавхан байж их цэргийн өмнө эрдмээ үзүүлж, бурхан тэнгэр тэдний ялалтыг ивээн тэтгэж байгааг тулалдааны өмнө бүх дайчдад харуулах явдал байсан бөлгөө.

Тиймээс ч мөнөөхөн аяндын дараа тэнгэр бурхан өршөөж ивээн тэтгэсэн хэвээр буйд итгэх итгэлийг морьтон дайчдад эгүүлэн олгох ямар нэг зүйл тун удалгүй тохиолдох нь Ругилаг залгамжлагч Бледа, Аттилад хоёрт өөрсдөд нь төдийгүй хүннүгийн бүх ард түмэнд ч чухал байжээ.Тиймээс л дайны тэнгэрийн илдтэй холбогдсон нэгэн явдал тохиосон бөгөөд түүхч Иорданес энэ тухай өгүүлсэн нь:

„Аттилагийн бахим чийрэг бие, өргөн ханхар цээж, данхар тэргүүн, жижигхэн нүд, хяруу буусан армаг тармаг сахал, навтгар хамар, бараан зүс царай энэ бүхэн түүний гарал үүслийг илтгэнэ. Түүний төрөлхийн өөртөө бүрэн итгэлтэй хатуу чанга зан чанар дайны бурхан марст зориулсан ариун илдийг олсны дараа улам ч хатуужжээ. Энэхүү илдийг скифүүд *(энд хүннү нар гэдэг утгаар.Орч.)* эрт галавын үеэс ариун хутаг оршсон зүйл гэж шүтэж иржээ.

Нэгэн удаа мал хариулж явсан хүн сүргийнх нь нэг охин бяруу сүрхий доголж явахыг хараад яахаараа ингэж айхавтар шарх олсны учрыг ер ухсангүй, тэгээд цус гоожсон мөрийг хичээн дагаж явсаар шороонд булаастай нэгэн илд хэвтэж байхыг харж, бяруу идшилж явахдаа уг илдэн дээр халт гишгэснээс гэмтсэнийг олж мэджээ.

Тэрбээр илдийг газраас ухаж аваад даруй Аттилад авчирч барьжээ. Аттила түүний энэ бэлэгт туйлаас баярлаж дайны тэнгэр марсын илдийг ийнхүү олж авсан явдал нь өөрөө дэлхийд ноёрхож, бүхий л дайн тулаанд ялан дийлж явахын одонд төрсөн хүн мөн гэдгийн баталгаа гэж үзсэн нь түүнийг нэр төрд хэчнээн дуртай хүн байсныг илтгэнэ.

Энэ тухай Аттилагийн дэргэд хэдэн долоо хоногийн турш сууж асан Византийн элч Прискүсийн тэмдэглэлд Хүннүгийн хаанд Ромоос хүндэт цол хүртээх ёслолын дараахан таталгасан нэгэн нэмэлт бичвэр бий. Ромын эзэнт гүрнээс олгосон тэрхүү хүндэт цол нь “Magister Militum” (*Энд цэрэг дайны удирдагч хэмээх утгаар хэрэглэжээ. Эрт цагт хөлөг баатруудын журмын холбооны тэргүүн нар голдуу Магистр хэмээгдэж байсан нь хэвээр, тухайлбал Мальтын журмын холбооны тэргүүнийг өнөө ч ийн нэрлэнэ. Түүнчлэн эрдмийн зэрэг, Master of Arts, Master of Science хэмээнэ. Орч.*) хэмээх агаад энэ цолыг өмнө нь Аларих (Вестгоотуудын анхны хаан, Герман анхны хаан, Ромыг байлдан эзэлсэн хүн.Орч.) ч хүртсэн ажгуу. Эл цолыг их хэмжээний мөнгөн шагнал тогтмол дагалддаг байсан бөгөөд ийн ромчууд Аттилад шууд ч алба гэхэд хараахан боломгүй, нэг үгээр хэлбэл цэргийн даргын цалин хөлс маягаар алба барьж байсан хэрэг юм. Гэвч Аттила энэ цолонд сэтгэл ханасангүй хэмээн Прискүс өгүүлээд „Аттила ромчуудын өндөр их хүндлэл хэмээгээд буй тэрхүү цолыг нь таягдаж хаячихаад “Магистер Милитум” гэхийн оронд эзэн хаан хэмээн хүчээр цоллуулах болно доо гэж буй. Ромын эзэн хааны цэргийн жанжнууд бол зөвхөн хааны л албат нар. Харин өөртэй нь Ромын эзэн хаад л зэрэг дэвийн хувьд зэрэгцэж очино. Эрх засгаа улам өргөтгөн тэлэхэд хэдийхэн цаг хугацаа орох аж. Тэнгэр (дайны) өөрөө үүнийг гэрчилж, он удаан жилээр алга болж олдохгүй байгаад саяхан нэгэн малчны олсон скифийн хаадын хувилгаан чадалд нь шүтэж, дайны бурхан хэмээн дээдэлж ирсэн Аресын (*Зевс, Хера нарын хөвгүүн, Гэрэгийн аллага хядлага дагуулсан зэрлэг тулалдааны тэнгэр. Орч.*) илдийг газрын мухраас түүнд гаргаж өглөө хэмээж буй“ гэжээ.

Прискүс үүнд эргэлзээд байхааргүй ухаалаг хүн байв. Аттила энэ үйл явдлыг хэчнээн их чухалчилж ихээхэн ач холбогдолтойд үзэж буйгаас л хүннү нарын хаан энэ хүн болоод түүний албат ардууд иймэрхүү билэгдлийн чанартай зүйлд ямар их итгэж, дайн тулааны үйлдээ яс удирдлага болгодог байсныг харж болно. Үүнийг чухамдаа дандаа дээрмийн шинж чанартай байсан аян дайнаас нь харж ойлгож болно. Учир нь хүннү нарыг хэн ч хаанаас нь ч дайрч довтолж байсангүй. Тэдэнд хамгаалаад байхаар тогтож суусан орон зай байсангүй, тэд Төв Азиас гарсан цагаасаа л дайн байлдаанаар аж төрж байв. Далайн дээрэмчид нэг л өдөр гэв гэнэт дээрэм тонуулаас дур гутаж, амьдралынхаа наран жаргах цагийг хүлээн амар жимэр суух аль нэг эзэнгүй арлыг зорин далбуур хийсгэн оддогийн адилаар аливаа хохирол хийгээд бүтэлгүйтэл эсвэл мэргэнд буусан таагүй төлөг зэрэг нь энэ нэгэн их ард түмний хэдэн мянган

километрийг даялсан асар их түлхэлт, өрнийг зорьсон байлдан дагуулах их аян дайныг нь нэг л өдөр бүх нийтийн ухралт болгон хувиргаж ч чадах байв.

Тиймээс ч бөө нар онцгой үүрэг хариуцлагатай байсан бөгөөд тэд хаадын эрх засагт ч халгаатай байж мэдэхээр эрх мэдэлтэй байсныг ойлгож болох зүйл байв. Хүннү нарын бөө нар нь хаан эзнийг тойрон хүрээлсэн язгууртнуудтай эн зэрэгцэхээр байр суурьтай байсан бөгөөд ихээхэн хүндлэл хүлээдэг байсныг түүхийн мэдээ баримт гэрчилдэг. Тэд галд түлсэн үхрийн далны ясанд гарсан ан цаваар мэргэлдэг учир мэрэг төлөг нь эгэл жирийн ард олонд ойлгогдохооргүй зүйл байв. Заримдаа цэвэрлэж янзлаагүй, чанаж түлээгүй малын гэдэс дотор болон ясаар ч мэргэлдэг байжээ. Энэ бол тухайн цаг мөч юуг шаардаж байна, түүнийг нь гаргаж ирэх нууц далд ухаан байсан бөгөөд хэрэв таагүй төлөг буух юм бол хаан уг төлөгчийг бусдад худалдагдсан, аль эсвэл чадваргүй хэмээн буруутгаж алуулах юм уу, өөр хэн нэг үгэнд оромтгой, уян хатан хүнээр солих явдал байв.

Нүүдэлчид малыг ийн ихээхэн чухалд үздэг, малын яс ирээдүй төлөвийг унших толь болдог учирт гайхах хэрэггүй. Хүннү нарын бүхий л оршин тогтнох үндэс нь мал юм. Дайн байлдаан хэдийгээр дасал болсон туслах чанарын үйл боловч онцгой нөхцөл юм. Нүүдэлчдийн ёс заншил, дэг журам уугуул бэлчээр нутагт хэдэн зуун жилийн туршид бүрэлдэн тогтножээ.

Хүннүчүүдийн ахуй амьдралын байнгын хүрээнд хамаардаггүй зэрлэг ан амьтныг чөтгөр шулмастай холилдож оршдог, эсвэл чөтгөр шулмас тэдний дүрээр оршдог хэмээн үзэх бөгөөд буга, янгир ямаа зэрэг гэм хоргүй амьтад хүннү нарын ардын сүсэг бишрэлд ихээхэн нөлөөтэй байдгийн учир бол хүнд тустай сайн сүнс сүлднүүд эрх дураар амьдрах хэдий ч хүнд гэм хоргүй эдгээр амьтдыг зориуд сонгон тэдний дүрд хувирсан байдаг хэмээн үзэх бөлгөө.

Газрын олдвор буюу археологийн гэрч баримт болох зүйлүүд өнөөг хүртэл хүннү нарын шашин шүтлэгийн талаарх бидний мэдлэгт нэг их нэмэр болж чадаагүй ч тэдний явж өнгөрсөн замын дагуу тэр чигтээ хүрэл болон бусад металлаар хийсэн амьтны дүрс олддог бөгөөд тэдгээрийг бөө нарын эдэлж хэрэглэдэг байсан зүйлс гэж үздэг. Онголж сэтэрлэсэн малын дүр бүхий жижиг металл дүрснүүд нь мэрэг төлөг болон бусад шившлэгийн үйлийн үед сайн төрлийн сүнсний ач тусыг дуудаж, чөтгөр шулмасуудыг хол байлгах ба мөн хорт илбэ жатгаас хамгаалдаг гэх учир сахиус маягаар зүүж явах ажгуу.

Мөн Аттилагийн өөдөлж дэвшсэн амьдралын замналтай нягт холбогдсон онго шүтээн хийгээд билэгдлийн амьтан бол бүргэд юм. (Бүргэдийн сэдэв) нь „энд авч үзсэн

нүүдэлч морьтон ард түмний элементүүдийн нэгэн адилаар өргөн дэлгэр тархсан байсан бөгөөд хүннү нарын засаг төрийн байгуулалд зонхилогч давхрагад хамаарах эрчүүд хийгээд эмэгтэйчүүдийн булшны аль алинд нь элбэг тааралдана. Булшинд *парс про томо* (латинаар *pars pro toto* гэх тогтсон хэллэг нь нэгэн цогц юмны аль нэг бүрдэл хэсгийг хэлэх бөгөөд гал тогооны өрөөгөөр жишээ авбал зуух нь байх жишээтэй. Орч.) болгон ихэнхдээ махчин шувууны толгойг дүрсэлсэн байх агаад шувууг бүтнээр дүрсэлсэн байх нь тун ховор...Ийм олдворын учир шалтгаан нь мөнөөхөн хүннүчүүдийн нийгмийн зонхилогч давхрагын нууцлаг дүр зурагт бүргэд хэзээнээс асар их үүрэгтэй байснаар тайлбарлагдах бөгөөд Казахстанас Венийн сав газрыг хүртэл тархсан хүннү нарын хаад ноёдын оршуулга дотроо агуулах эд өлгийн зүйлээрээ бүгд адилхан юм". (Иоахим Вэрнэр)

Мюнхэний нэрт эрдэмтний энэхүү мэдээнд хамгийн сэтгэл догдлуулам зүйл нь энэхүү олдворын тархсан газрын нэр юм. Казахстан бол Зүүн гарын хаалгын наад этгээдэд Байгаль (*Зохиогч эндүүрсэн болов уу. Балхаш нуур байх. Орч.*) нуурыг тойрон орших нутаг агаад эндээс асар удам тал нутаг эхэлж Венийн сав газар, Венийн ойгоор бүрхэгдсэн уулсад тулж дуусна. Тал нутаг холхи газраас энэ хүртэл ийн цэлийж, энэхүү нүд алдам удам хээр талд цуцашгүй эрч хүч агуулсан мэт энэ ард түмэн ноёрхох бөлгөө. Тал нутаг удам тэнүүн байх тусам энэ ард түмэн өөрийн бурхдын ивээлийг авч, зөвхөн тэдэндээ л захирагдана хэмээн үзэх ажгуу.

Түүнээс гадна Иоахим Вэрнэр Одер, Висла мөрнүүдийн завсар орших энэ нутгаас гадна олдсон хүннү нарын ноёрхол Балтийн тэнгис хүрч байсныг баталж буй эд өлгийн зүйлүүдийг судалж, хүннү нараас бүргүндчүүдтэй хийсэн дайн байлдаан хийгээд Луар (*Францын хамгийн урт гол, Шэвэннээс эх авч Нанн хотын хавьд Атлантын далайд цутгана.Орч.*)-ыг чиглэсэн тэдний аян дайнаас түүхэн эх сурвалжаа авсан байж таарах Райн мөрний хавь нутгийн булшнаас гарсан эд өлгийн зүйлүүдээр нотолж буй. Хүннү нар хаа хүрч, хэзээ байлдаж тулалдаж явснаас үл хамааран эзэнт гүрнийх нь голомт хээр тал нутаг байсаар, тэдний дээд давхрагын онго шүтээний шувуу, бидний үздэгээр өндөр уулсаар нутагтай махчин шувуу болох бүргэд хэвээр үлдсэн нь хачирхалтай.

Бүргэд мянга таван зуун жилийн хойно үндэсний социалист үзэл сурталчдын (*Германы фашист үзэл суртлыг хэлж буй. Орч.*) дэлхийд ноёрхох хийсвэр мөрөөдлын билэг тэмдэг болж байсны адилаар нүүдэлчин хүннү нарын удирдагчид дээрхийн нэгэн адил шалтгаанаар энэ амьтны сүр хүчинд автсан нь тодорхой юм. Энэхүү билэг тэмдэг нь өөрийгөө хэт дөвийлгөсөн дэврүүн санаархал, хаан эзний гэхээр шунал тачаал, зөвхөн л ноёд язгууртны үзэл бодол, давуу хүчээр түрий барьж зөвтгөж болох эд хогшил, эзэмшил нутгийн төлөө үхэн хатан тэмцэлдэх эрмэлзлийн илэрхийлэл болж байв.

Аммианус Марчеллинуc эдгээр бүргэдийн тухай дурдаагүй ч шашин мөргөлд огт баригдаагүй, харин мухар сүсгээр жигүүрлэсэн улс төрийн бодлогын дээрмийн шунал хүсэл, харгис хэрцгий мөн чанарыг тааварлаж байсан билээ. Бүргэдийг дээдлэн шүтэж байсан нь тодорхой боловч бүргэдийг хэн дуртай захын хүн ашиглаад байх ёсгүй байв. Бүргэдийг зэр зэвсэг, бүснээс гадна бас хөмөлдрөг дээр дүрсэлж байсан нь алс холыг зорьсон байлдан дагуулах аян дайнд энэ нь хэчнээн чухал болохыг сайн мэддэг байсан хэрэг юм.

Энэ бүхний дотроос бүргэдийн сэдэв бусдаас илт илүү давтагдах нь сонин юм. Янз бүрийн угсаа гаралтай түрэг ард түмнүүд болон монголчуудтай холилдож мөн айл хөрш сууж байсан Төв Азийн эх нутагт нь бүргэд ерөөс зонхилж байгаагүй. Эдгээр ард түмний үлгэр домог, хууч ярианд хэрээ, үнэг, туулай, бар, могой зэрэг амьтан бүргэдээс хамаагүй олон тааралдана. Үүнээс улбаалан бүргэд нь хүннүчүүд өрнө дахин руу их байлдан дагуулах аян дайндаа мордсоноос хойш л хүннү нарын дээд давхрагын зонхилох амьтан, хамгийн дуртай билэг тэмдэг нь болсон байна хэмээн дүгнэх байна. Эртний дорно дахины соёлууд хийгээд Ромын дэлхийн эзэнт гүрэнд бүргэд нь жигүүртний хаан болохын хувьд ноёрхлын билэг тэмдгийн шинж чанарыг олсон байв. Бүргэд бол дээд тэнгэр бурхдын мэдлийн амьтан гэх бөгөөд жигүүртний хаан энэ шувуу Энэтхэгийн Индра, Вишнү хийгээд эртний Персийн бурхад, эн тэргүүнд Ахура Маздаст хамаатайн нэгэн адилаар Зевс, Марс бурхдад ч харьяалагдах амьтан билээ. Бас энэ шувуу вэдийн (санскрит үг, энэтхэгчүүдийн эртний шашны уран зохиолыг хэлж буй. Орч.) домогт гардаг Энэтхэг-арийн бурхдын ертөнц дэх галын бурхан Агнигийн хайртай амьтан нь болно.

Эртний ард түмнүүд бүргэдийг аянга цахилгаантай онцгой харьцаатай хэмээн үздэг байжээ. Бүргэд аянга цахилгааныг зэр зэвсэг хэлхчихсэн мэт савартаа базаад нисч байдаг, өөрөө бол аянганд хэзээ ч ниргүүлдэггүй, бүргэдийн хошуу нь аянгын ямар ч өтгөн хар үүлийг нэвтлэн гялалзан харагдаж байдаг хэмээн ардын хууч ярианд өгүүлдэг. Догшин хар салхи, аадар бороог гэртээ хоргодож өнгөрүүлдэг халхавч хамгаалалтгүй талын ард түмэн хүннү нар салхич шувууныг онцгой, чухамхүү бурхны шувуу гэж үзэх нь ойлгомжтой. Ийн хүннү нар хүчийг олоод зэлүүд тал дээгүүр аянга тээсэн догшин аадар хуйлруулан өнгөрөхийн адилаар Европын хүн ам нягт суурьшсан хотуудыг дайран орохын цагт тэднийг сөрөн босч тулалдаанд орсон ромын легионууд өөрсдийнх нь адил бүргэдийн тэмдэгтэй байжээ.

Аттила өөрийгөө эзэн хаадтай нэгэн эгнээнд тавьж, энэ цол хэргэмийг өөрт нь хүртээхээс хойш суухгүй болох цаг мөчийн тухай мөрөөдөж байх үе хэргийн учир нь зөвхөн эзэн хааны хэргэм зэрэгт бус, харин бүргэд хэмээх энэ жигүүртэн зөвхөн хамгийн хүч чадалтайд нь л ямагт үйлчилж байх тавилантай гэдэгт л байлаа.

„Аттилагийн үеийн олдворуудад ганц бүргэд л зургийн сэдэв болон хэрэглэгдэж байсан нь энэхүү хаан шувуу дээд тэнгэр, сансар огторгуйг бүтээгчийн амилсан дүр хэмээсэн ойлголт төсөөллийн ертөнц тогтнож байсны хамгийн жинтэй нотлогоо юм“.
(Вэрнэр)

Хэрвээ бүргэд нь ноёрхлын цор ганц билэг тэмдэг байсан л юм бол, хэрвээ хүннү нарын дээд давхрага, хаад ноёд, удирдагч толгойлогч нар энэхүү аз жаргал хийгээд ялалт амжилт авчрагч амьтны дүрээр гоёж чимэх эрх эдэлж, эцэст нь түүгээр нөгөө ертөнцөд одох замаа заалгаж байсан гэж бодоход эгэл жир ард түмэн ямар билэгдэлтэй, ямар сахиус тэнгэртэй байсан хэрэг вэ? Хүннү овогтны мах цусанд төрсөн, моринд эрэмгий энэ хүн ард орчлон ертөнц, дэлхийн гарал үүсэл, тэнгэр бурхдын тогтолцооны талаар нэг их юм бодож санааширдаггүй байсан гэх нь үндсэндээ онох биз. Гэвч хүннү нар өөрсдийн хаад ноёдын нэгэн адилаар дэлхийг байлдан дагуулах шуналтай мөрийтэй тоглоомонд татагдан орсон юм. Хүннүчүүд харь холын газар оронд, өдөр тутам үхлийн аюул нүүрлэж асан ертөнцөд очоод байлаа. Хүннү нарын хоёрдахь үед хамаарч, их нүүдлийн тоосон дунд ертөнцөд мэндэлсэн тэд уугуул эх орноосоо, эцэг эхээсээ ямар янзын билэгдэл, ямар баталгаа авч гарсан байх вэ?

Үүний хариулт амаргүй, бид хуучны Аттилагийн эзэнт улсын археологийн судалгааны хувьд (бичгийн дурсгалуудын үг үсэг, толгой эргүүлсэн оньсого таавар мэт зүйлтэй зууралдахтай харьцуулахад үр дүн нь дээр) ерөнхийдөө нааштай эерэг хөрс суурьтай ч гэсэн Мажаар, Зөвлөлтийн археологчдын хамтарсан үйл ажиллагаагаар хүннү нарын шашин мөргөлийн үйлээ хэрхэн явуулдаг байсан талаар нэг их олон тайлбар тайлал олж чадаагүй.

Гэхдээ л тодорхой нэг анхаарал татахуйц бүлэг олдвор, тухайлбал зэр зэвсэг, эн тэргүүнд илд, чинжаал хутганд зүүсэн ч зэвсгээ авч явах хадгалахад ямар ч ач холбогдолгүй нь жижигхэн сувд, чулуун бөмбөлгүүд илэрсэн юм. Судалгаагаар эдгээр чимгийг илдний шидэт зүүлт гэж үзсэн. Илд бол зөвхөн Зийгфрийд (*Нибэлүнгийн дуулал хэмээх Германы болон умрын ард түмнүүдийн баатарлаг туулинд гардаг Нибэлүнгийн газрыг сахин хамгаалагч баатар эр. Энэ тууль 1200 оны орчим Дунайн бэлчир нутагт бүтээгдсэн хэмээгддэг. 2400 дөрвөн мөртөөс бүрддэг. Германы нэрт хөгжмийн зохиолч Рихард Вагнер „Нибэлүнгийн бөгж“ хэмээх дуурийн цувралын нибэлүнгийн дуунд Зийгфрийдийг дүрсэлсэн. Орч.*) ч юмуу, ер Германы баатарлаг туулиар ч тогтохгүй өөр онцгой учир холбогдолтой байсан гэдгийг бид дээр өгүүлсэн бэлчээрийн газраас олдсон илдний түүхээс нэгэнт мэдэх билээ. Хүннү нарын гол зэр зэвсэг бол илд, агт морь бөгөөд илд нь нум сумны хамтаар тэдний аж амьдрал хийгээд

тэмцэл тулалдааны гол хэрэгсэл байсан ба энэ нь дайн тулаан, дээрэм тонуулаар амь зуухаар шулуудсан бүхэл бүтэн ард түмний оршин тогтнох үр үндэс нь болж байжээ.

Илдний тэрхүү ид шид агуулсан зүүлтийг хийхэд хэд хэдэн материал онцгой тохиромжтой байсан ажээ. Зүүлтийг төрөлх нутаг Төв Азийнх нь уул нуруудынх болов уу гэмээр жирийн саарал боржин чулуугаар ч хийж байж. Бас илдний зүүлт нь заавал өнө эртнийх байх албагүй, зүгээр өлбөн сувд, хиймэл ч байж болох байж. Харин хэргийн учир холбогдол нь мөнөөхөн зүүлт илдний эзнийг хамгаалах эсэхэд юм уу, аль эсвэл илдэнд өөрт нь, бас байлдаан тулалдаанд ямар нэг таатай нөлөө үзүүлэх үү үгүй юү гэдэгт бус, гол нь тайлгачийн үйлддэг жинхэнэ юм уу, аль эсвэл билэгдлийн аль нэгэн болох аравнайлах үйлэнд л байжээ. Эртний Гэрэг-Ромын зохиогчдын урьд өмнө мэдээлж байсан зүйлүүд жишээлбэл гаж хэлбэртэй гавлын яс, эмээлийн дээр дэлхийн талыг туулахдаа авч явахад ер эвдэрч гэмтээгүй металл толь зэрэг хүннү нарын очиж байсныг гэрчлэх зүйлүүд элбэг таардаг нутаг оронд мөнөөхөн илдний зүүлтүүд ч хаа сайгүй олддог. Эдгээр олдвор нь он цагийн хувьд найман зууныг дамнан Моодун болон түүний алс холын байлдан дагуулах аян дайны үеийг хамардаг бөгөөд газар зүйн хувьд Зөвлөлтийн Оренбург мужид ч, Мажаарын Сэнтэш-Киштөкэд ч ялгаагүй л тааралддаг байна. Өмнөд Уралын Магнитогорскийн хавьд илдний манан зүүлт олдсон ба энэ нь урт илднийх байсан бөгөөд Астрахань мужид олдсон нумны дэргэд өлбөн сувдан зүүлт хэвтэж байжээ. Альт-Ваймарт мана чулуун бариул бүхий 115 см урт илдний дэргэдээс шилэн зүүлт олдож байв. Түүнчлэн Казахстан, Умард Кавказ, Крым, Краков, Вроцлав, Мажаар, Вена, Доод Австри, Райн мөрний дагуух Хэссэн, Дорнод болон Умард Францын нутгууд олдворын тухай мэдээ зангид дурдагдаж байв.

Ийн бүргэдийн бурхандаа сүсэглэгч хаад ноёдынхоо удирдлага дор өвөртөө буй бяцхан сахиусандаа хувь заяагаа даатгасан нэгэн ард түмэн бүх дэлхийг туулан байлдаж явлаа. Хүннүчүүд Аммианусын бодож байсан, эсвэл хүнээс дуулсан шиг огт сүсэг бишрэл, итгэл үнэмшилгүй ард түмэн биш байв. Гэхдээ энэ ард түмний сүсэг бишрэл нь дайн, итгэл үнэмшил нь тэмцэл тулаан байсан бөгөөд энэ ард түмэн оршихуйн утга учрыг ялалт амжилт, олз омог хоёроос олж хардаг байсан юм. Чухамхүү энэ л зорилгоо биелүүлэхэд нь тэдэнд зэр зэвсэг хэрэгтэй байсан бөгөөд өнгөрсөн хугацаанд энд тэндээс олдсон хүннү дайчдын авч явсан нь ямар ч эргэлзээгүй уран гоёмсог хийцтэй илднүүдийг бүгдийг нь Казахстанд дархалсан гэх үндэсгүй. Хятад эх сурвалжуудад илдний тухай олонтаа өгүүлсэн байдаг нь мэдээж, гэхдээ хятад зэвсэг хэрэгсэл хүннү нарынхаас хамаагүй илүү хэмээдэг. Хүннү нарын Европт очихдоо авч явсан гаргууд сайн зэр зэвсэг, түүний дотор тэдний онц эрхэмлэн дээдлэхийн учир өөрсдийн сахиус болон аз хийморь авчирдаг гэх бусад зүйлийг бариулд нь зүүдэг байсан, ариун нандин гэж үздэг тэдгээр үнэт илднүүдийг нэн эртний зэр зэвсгийн үйлдвэрлэлийн дадал туршлага бүхий Ойрын Ази, эртний Ираны дархны газруудад урласан байх магадлалтай.

Нүүдлийн амьдралын ядуу зүдүү, болхи толхи нөхцөлд ийм илд нь онцгойлон эрхэмлэх нэн үнэ цэнэтэй зүйл байсан бөгөөд учир нь их үнэ цэнэтэйгээр тогтохгүй бас ялалт амжилт, олз омогт хүрэх хүч чадлыг эзэндээ хайрладаг хэмээн үздэг байжээ. Ийн илд нь хар мөр дагуулсан, цус урсгах зориулалттай хэдий боловч нүүдэлч дайчны амьдралыг ариун гэгээн шүтээн лүгээ адилаар гийгүүлж эхэлжээ.

Наран жаргах зүгийн улс орнуудад эртний герман илд, хожим хойно зандалчны цаазын илд онцгой ариун хүндтэйд тооцогдож байв. Ийм илд нь өөрийн гэсэн амьдрал туулах учиртай гэж үздэг байсны учир дархлах арга барилыг нь болон түүнийг урладаг дархныг ч онцгойлон үздэг байжээ. Тухайлбал Исландад дундад зууны сүүл үеийн ардын хүй нэгдэлд дархан хүн байгалиас заяасан удирдах бодгаль гэж үзэгддэг байж хамба зэрэг шашны өндөр хэргэмт санваартны хувьд нэг маягийн буруу номын сөрөг дүр болж байжээ.

Тиймээс хүннү нарын хувьд илд, гал, дархан гурав нь онцгой хүч чадал шингээсэн шүтлэгийн үнэт зүйл болж бие биедээ сүлэлдэн уусч, хаанаасаа өөр хэнийг ч, юуг ч хүлээн зөвшөөрдөггүй, ийм юм санаанд нь багтдаггүй хүннү нарын ерийн амьдралд нь биш гэхэд сүсэг бишрэлд нь дайн байлдаанд оройлон орох удирдагч, металл урлагийн нууцыг эзэмшигч, хөнөөгч болд зэвсгийг бүтээгч хувилгаан чадалтан болсныг ойлгож болно. Аттила өөрөө илд дархалдаг гэвэл хүннү нараас итгэх хүн гарахгүй нь тодорхой. Харин хаад нь тэрхүү илд хэмээгч зэвсгийн талаарх мэдлэгийг сахин хамгаалагч бөгөөд энэхүү нууцлаг зэвсэгтэй онцгой харьцаатай байдаг, чухамдаа илдийг эзэмшиж байж л өөрсдөө ихийн зэрэгт хүрч, бусдад аюумшиг төрүүлэх хүч болсон гэдэгт хүннү нар бат нот итгэж байсан ажгуу.

3.

Н□□□□ □□□□□□□□ □□□□□□

Гол цөм нь Ромын эзэнт гүрэн болж, хэдэн зуун жилээр амгалан тайван оршин амьдарч асан хуучин ертөнцөд хүннү нар цөмрөн ирсэн бөлгөө. Хүннү нарын үе буюу 410 он хүрч байж германчууд Ромыг эзлэн авсан байдаг. Аттила амьд сэрүүн, дайн байлдааны ялгуусан үйлээ бүтээж явах тэр цагт л Ромын эзэнт гүрний хязгаар нутгуудад гүн гүнзгий өөрчлөлтүүд гарсан юм. Ганцхан хүннү нар л ялгуусан байлдан дагуулагчийн хувиар Европын нийт газар нутгийг дорноос өрнө тийш хөндлөн туулсан бөгөөд тэд мөн зүүн өмнө, өмнө зүгт аян дайн хийж байлаа.

Хүннү нар хийгээд тэдний герман холбоотнууд хүний санаанд багтахааргүй түйвээл сүйтгэлийнхээ үр дүнд Ромын дэлхийн эзэнт гүрний эд баялгийг хаман авсан бололтой бөгөөд учир нь тэднээс өмнө Ромын алт эрдэнэс байнга урсч байсан ганц зам нь дорныг, Аравийн хагас арлыг зүглэж байсан юм. Ромчууд улам бүр баяжсаар байсан Аравийг “Arabia felix” (*Аз жаргалын өлгий Арав газар хэмээх утгатай, эртний газар зүйчид Аравийн хагас арлын өмнөд хэсгийг өнөөгийн Йеменийг оруулан нэрлэж байв.Орч.*) хэмээн нэрлэж байсан бөгөөд Аравийн хойгт тэр үед хараахан газрын тос гаргаж байгаагүй ч Ромын гоо сайхны барааны үйлдвэрлэл нь Өмнөд Аравийн элдэв зүйл үнэртний түүхий эдэд түшиглэж байсан учир асар их мөнгө тийш цутгаж байсан хэрэг.

Гүгэл (зандан модны давирхай), хүж зэрэг ариун үнэртнийг тээвэрлэн явах замаар наад зах нь зургаан зууны туршид жил бүр үнэт давирхай, тос, бас Аравийн өмнөд нутгийн амттан, чинжүү зэргийн бусад амтлагч тээсэн тэмээн жингийн цуваа Газар дундын тэнгисийн эргийн Петра хэмээх худалдааны хотыг дамжин ирж байсан бөгөөд Ромын хатад хүүхнүүд хийгээд Ромын мужуудын баячууд Сири, Мисир болон заримыг нь Ромд боловсруулж байсан түрхлэг, тосон эм, үнэрт ус, шингэн эм, хүж, үнэртний зүйлд асар их мөнгө зарж байв.

Дорно зүгийг зорих алтны энэхүү урсгалын хариуд арабууд Ромоос бараа таваар худалдаж авах нь их биш байв. Нөхцөл байдал өнөөгийнхтэй бараг адил нь илэрхий байсан агаад тэр үед Хадрамаут (Хадрамаутын бүс нутаг нь Йемений зүүн өмнөд нутаг агаад өмнө талаараа Адены булан, зүүн талаараа Оман, умард этгээдэд Руб ал-Халигийн цөлөөр хүрээлэгдэн оршино.Орч.)-ын шэйхүүд хуримтлуулсан хуучин венецийн алтан зоосоороо Ромын эдлэн газрууд хийгээд бас Газар дундад тэнгисийн хамгийн үзэсгэлэнт газруудад орд харшууд худалдаад авчихаж чадах байсан юм. Харин чингээгүйн учир бол Ромын тэр их алтыг арабчууд хэрхэхээ мэдэхгүй байхад нь нэг л өдөр буцаагаад булаагаад авчих санаа ромчуудад төрснөөс болсон хэрэг. Ийнхүү Аелиус Галлус хэмээгч нэгэн бүтэлгүй генерал дээрмийн аян дайнд мордсон ч ромчууд цөлд төөр ч балардагийн даваан дээр армийнхаа өчүүхэн хэсгийг арайхийн мэнд эгүүлж авчирсан агаад түүнээс хойш үнэндээ хэн ч Аравийн эд баялгийг ийн хүчээр булаахыг оролдоогүй билээ.

Ромын эд баялгаас ийм байдлаар алдагдсан нэлээд хэсгийг нь эс тооцвол энэхүү колонийн их гүрний хуримтлуулсан алт эрдэнэс, эн тэргүүнд хувийн хэрэгцээний эд зүйлс, үндсэндээ зарж үрдэггүй эд юмс, тухайлбал гоёл чимэглэл, гэр ахуйн үнэтэй цайтай эд бараа, соёлжсон ромчуудын гэр орондоо болон мужууддаа хурааж хуримтлуулах дуртай урлагийн үнэт бүтээлүүдийн ихэнх нь хүннү нарын гарт оржээ. Үй олон хүннүчүүд эдгээр олз омгийг хуваахдаа хэрхэж байсан нь тодорхойгүй, мөн энэ

тухайд нийтэд хамаатай тогтсон журам дүрэм байсан гэдэг нь юу л бол. Харин нэг л үндсэн зарчмыг хэлбэрэлтгүй сахиж байсан мэт бөгөөд түүнийг зөрчих ахул хүнд ялд унахаа мэдэж байсан бололтой. Алтны зүйл, алтан зоос, алтан эдлэл хэрэглэлийг хүннү нар хаад ноёдодоо даруй тушаах үүрэгтэй байв. Алтан эдлэл, энэ металлаар хийсэн өчүүхэн гоёл чимэг зэрэг олдвор агуулсан эгэл жирийн хүннү хүний ганц ч булш байдаггүй хэрнээ харин Хүннүгийн ноёдын гэгдсэн булшинд алт, үнэт чулуун эд зүйлээр асар баялагаараа онцлог байдаг. Эдгээр булшинд мэдээж дан ганц хаад ноёд, эсвэл ихэнхэд нь хаадыг оршуулаагүй нь тодорхой. Гэвч археологийн судалгаа цэрэг дайчдын булшийг ялгаж олоход алтыг шалгуур болгож заншсан бөгөөд чингэхдээ жирийн цэргийн булшнаас бол их л бол нэг хүрэл толь ч юм уу эсвэл бага сага мөнгөн хэрэгсэл олддог хэмээн тайлбарладаг.

Тиймээс алт эзэмшинэ гэдэг бол бусдаас давуу тал, ялгарах шинж тэмдэг байжээ. Алт нь хүннү нарын хувьд зөвхөн олз гэдгээр тогтохгүй гэдэг нь эргэлзээгүй үнэн бөгөөд тэд бусад ард түмний үздэгийн нэгэн адил нарны алтан сацрагийг биедээ гүн шингээсэн мэт санагдах, он цагийн урсгалд өнгөө үл алдах, дайн тулааны аюул осол, хүнд хүчрийг хэд нугалж нөхөж чадах тийм л эрдэнэсийг эзэмшиж буй мэт сэрэл мэдрэхүйг эзэндээ өгдөг, металлуудаас хамгийн толгой, хамгийн ариун нь юм.

Хүннүчүүдийн Европт богино хугацаанд ноёрхохдоо Ромын эзэнт гүрнээс авсан алт нь герман ард түмнүүдийн Ромоос авсан алтыг нийлүүлснээс хэд дахин илүү нь тодорхой буй. Энэ нь хүннүчүүдийн алтанд үхэн хатан дурлах шуналтай холбоотой агаад үүгээрээ түүхэнд шинэ дэлхий ертөнцөд Испанийн байлдан дагуулагчид хийгээд хорт хийгээр утаж устгасан хүмүүсийн цогцосноос алтан шүдийг нь суга татуулж явсан эсэсийн дүрэмт хувцаст эмгэнэлт сармагчингуудыг ч хол давжээ. Фердинанд, Изабелла (*Католик шашныг мандуулагч хэмээгдсэн II Фердинанд нь 1479-1516 онд амьдарч байсан Испанийн их хаан, эхлээд Арагоны хаан байгаад Кастилийн Изабеллатай гэрлэсний дараа Кастилийг ч эзэгнэх болсон. Мавруудыг Испаниас үлдэн хөөж, Неаполь, Наваррийг эзэлж, Америкийг нээснээр Испанийг их гүрний хэмжээнд хүргэсэн хүн. Орч.*) нарт морь нохой мэт зүтгэж явсан христ шашны үнэн сүсэгт албатууд хийгээд Аушвиц, Бэлзэн (*Польш, Германы нутагт байсан фашистын бөөнөөр хорих газрууд. Орч.*)-ий алтны ангуучидтай харьцуулахад хүннү нар нь бараг л уран нарийн гэхээр арга барилыг хэвшүүлсэн байв. Тэд Ромд аюул занал учруулалгүй, энх амгалан суусныхаа төлөө Ромоор ихээхэн алба бариулаад зогссонгүй, олзны ромчуудыг суллаж эх оронд нь буцаахдаа хүн нэг бүрээр тооцож тогтсон барьцааны мөнгийг алтаар төлүүлж байжээ.

Энэхүү барих алба нь хэдий хэмжээтэй байсныг Визант, Аттила хоёрын хоорондын хэлэлцээг биечлэн эрхлэн явуулж байсан хүний хувьд Прискус яс тоо

баримт мэдээлсний учир бид яв цав мэдэх билээ. Үүгээр Дорнод Ромын эзэнт гүрнээс Ругилатай байгуулсан алба барих тухай гэрээгээр Визант жил бүр 120 килограмм орчим алт тушаахаар тогтоожээ. 435 онд Бледа, Аттила хоёрт энэ албыг хоёр дахин ихэсгэхээс илүү чухал үйл байсангүй. Найман жилийн хойно орчин цагийн Галлиполь хэмээх нэр нь дэлхийн нэгдүгээр дайны үед хэдэн сараар сонины эхний нүүрээс салахгүй байсан Херсонесийн хойгт болсон тулалдаанд ромчууд хүннүүдэд дийлдэв. Сүүлд Чөрчилль германчуудыг ялах аз тохиосон тэр газарт ромчууд хүннү нарт ялагдсанаар тэдэнд жилд долоон зуун кило алт тушаах болсон агаад дээр нь хүннүүдийн тооцоолсноор тушаагдалгүй өр болж үлдсэн хоёр мянган кило алтыг ч бас нөхөж өгөх ёстой байв!

Гагц албан ёсоор тогтоосон энэ албаас Аттила, Бледа нар хийгээд тэдний садан төрөлд 430, 450 оны хооронд 9000 кило алт цутгаж ирсэн хэрэг бөгөөд дээр нь элч төлөөлөгчдөд нь барих бэлэг сэлт, тэднийг хахуульдах мөнгө бас нэмэгдэнэ.

Ромын жирийн цэргийг олзноос чөлөөлж авахад барьцааны мөнгө дээр дурдсан хугацаанд нэг хүнд нэг солидус (*Цул гэсэн латин үг, Ромын эзэнт гүрний хаан Их Константины христийн тооллын 309 онд нэвтрүүлсэн хожмын үеийн ромын алтан зоос, Византийн эзэнт гүрэн ч авч нэвтрүүлсэн. Орч.*)-оор бодож төлж байсныг нэмэгдүүлж 12 солидус болгожээ. Нэг солидус нь 4,48 грамм цэвэр алт болно. Хүннү нар ромчуудаас давуу хүчтэй байсны учир олзлогдогсдыг суллаж авахад төлөх барьцааны мөнгөний хэмжээг алив монополь эрхтэй, сөрөг үйл хийх вий гэж эмээх юмгүй этгээдийн жишгээр ёстой л дур зоргоороо тогтоож байжээ. Гэхдээ хүннү нарын зэрлэг араншин, бүдүүлэг авираас мэдэгдэх юм юу ч үгүй. Харин ч хүннү нар гойд нарийн тооцоотой хүмүүс байсан нь харагдана. Бас хааяа эрсдэл дүүрэн дайн байлдаан хийх ямар ч хүсэлгүй үедээ „хөзөрдөж“ (хэлэлцээ хийж) наймаалцалдах бөгөөд ийн гайхамшиг бүтнэ. Төв Азийн дайчин, малчин, уран чадмаг бугуйлч, эгэл боргил хүннү нар юм үзэж, нүд тайлж дол цохисон Левантийн (*Итали хэлээр өглөөний орон буюу мандах нарны орон гэсэн үг, Газар дундын тэнгисийн дорно хэсгийг нумлан Тигр, Евфрат мөрнийг шүргэн орших улс орныг хэлнэ. Нарийн ярьвал Бага Ази, Сири, Мисир орны эрэг хавийн нутаг болно. Орч.*) дипломатуудыг ийн „хөзрийн наадгай“-д ч давж гарах бөлгөө.

Гэвч алт хүннү нарын гарт орсны хойно тун ч хачин явдал, бараг л гэнэн томоогүй хүүхдийн ааш гэмээр үйл болно. Хүннү нар алба хийгээд барьцааны мөнгийг алтан зоосоор аваад энэ их хөрөнгийг гүйлгээнд оруулж эргүүлэн ашиг олохыг ерөөс бодохгүй. Афин, Ром, Визант, Александриа болон бусад хотууд хагас мянган жилийн тэртээгээс сайтар зохион байгуулсан мөнгөний институтүүдтэй байв. Барааны биржүүд, хөлөг онгоцны даатгалын газрууд, нягт нямбай зохион байгуулагдсан дэлхийн

худалдааны тогтолцоотой байв. Гэтэл хүннү нар ромын цэвэрхэн гэгч нь цохиж цутгасан алтан зооснуудыг хайлуулдаг байжээ. Ромын эзэн хаадын дүр бүхий хангинасан зооснуудыг хайлуулж энэ ариун нандин металлыг хэсэг бусгаг зөөлөн бөөн цул болгоод гоёл чимэглэлийн эд зүйлс хийлгэдэг байжээ. Гэхдээ ром дархчууд ч юм уу, Газар дундын тэнгисийн гар урлалын сонгомол арга барилаар ч хийлгэдэггүй, харин өөрсдийнхөө гоо зүйн мэдрэмжээр, өөрсдийн амьдрал, хувцас хунар, өөрсдийг нь хүрээлэн буй ертөнцийн дадал заншлаар хийлгэдэг байж.

Гар нь тохойгоо хүртэл хүний цусанд будагдсан зориг баатарлаг ч хүүхдэрхүү гэнэн зантай хүдэр эрчүүд эхнэр хүүхнүүддээ хүнд алтан титэм, овоодой урлуулж, хүнд алтан ээмэг, зүүлтээр гоёод алт илүү гарвал байлдааны үнэнч нөхөр хүлэг мориндоо алтан ялтаст цээживч авах юм уу, эсвэл зузаан зузаан алтан бөмбөлөгөн чимэгтэй горхи бүхий бүс авч гоёно.

Тиймээс ч Мажаарын Маруш голын өмнө бие, хүннү нарын эзэмшилд байсан Виминациум (*Гэрэг-Ромын үед Ромын цэргийн зэрлэг ард түмнүүдээс хамгаалах чухал түшиц газар байв. Өнөөгийн Дорнод Сербийн Позаревагийн ойролцоо байсан.Орч.*) хотоос умар этгээдэд буй Нодьсентмиклуш (*Их хутагт Николайн газар хэмээх утгатай, хуучны Мажаарын хаант улсын нутаг байсан, өнөөгийн Румыны баруун хязгаарын Банат мужийн хот, эндээс дундад зууны түрүү үеийн алтан сав суулгын үнэт цуглуулга олдсон.Орч.*) хэмээх газраас 1791 онд олдсон алт эрдэнэсийг өнөө хүртэл Аттилагийнх гэж үзсээр ирсэн нь мэргэжлийн талаасаа нэг их сайн судалгаа биш ч гэсэн гайхах зүйл биш. Гэвч бүргэдийг ихээхэн тод дүрслэн чимэглэж цэвэр алтаар урласан хорин есөн ширхэг сав суулга нь Аттилагаас өөр хэн ингэж урлуулж, алт гэдэг утгаар нь аваад үзэхэд өөр хэн ингэж жинхэнэ эзэн хааны билэг тэмдгээр өөрийгөө хүрээлүүлж зүрхлэх билээ хэмээн Вена хотын урлагийн түүхийн музейд хадгалагдаж буй тэдгээр уран нарийн хийцтэй үзмэрүүдийг олж харахад л бодогдоно.

Мэдээж хээ угалз, овгор товгор дүрс, уран нарийн зураасны урлагийн үнэ цэнээр бодоход үнэхээр гайхалтай агаад үүнийг гэрэгийн эх бичгүүд Аттила хийгээд түүний цаг үед яг шууд хамааруулахгүй байгаа. Мөнөөхөн алтан сав суулган дээр байгаа рүни бичээсүүдийг Франц Альтхайм 1948 онд туурвисан бүтээлдээ хүннү нарынх хэмээн тодорхойлсон байдаг. Мөн янз бүрээр шүүн хэлэлцэж буй Нодьсентмиклушийн алт эрдэнэсийн зүйлс нь хурааж цуглуулсан олз омог бус, харин зориуд захиалж хийлгэсэн эд бөгөөд зоогийн ширээний хоёр иж бүрэн хэрэглэлийн рүни бичээстэй нь хаанд өөрт нь, нөгөөх нь хатанд нь зориулагдсан бололтой хэмээн Дьюла Ласло тайлбарласан байдаг.

Хийсэн алт нь ямархан хувь тавиланг амссан болохыг аль нэг алтан домбыг хараад л шүүн тунгааж болох эсэхийг би мэдэхгүй юм. Харин жаахан овжин арга сүүхээлж, тухайлбал Нодьсентмиклушаас олдсон алтан бүргэдийн биеэн дээр химийн уусмал түрхэх юм уу, радиографын аргаар туршиж үзэх арга олдвол цаанаас нь ромын зоосны алт дурайж харагдана гэдэгт мөрийцөхөд ч бэлэн байна.

Гэвч ганц Аттила юм уу, түүний хамгийн ойрын хүрээний хүмүүст л хамаг алба татвар, барьцааны мөнгө, мөнөөхөн шунал болсон алтаар хийсэн олзны эд зүйлс урсаад байгаагүй нь ойлгомжтой. Хаад ноёдын булш хэмээгдсэн бүхий л бүлшинд алтан эдлэлүүд заавал байх бөгөөд тэдгээрийг урласан хүмүүс нь гэрэгүүд бус, харин Хүннүгийн армийн ар талын албаны алтны дархчуул бөлгөө. Тэд Өмнөд Оросын алт мөнгөний дарханы урлагийг Мажаарт аваачин хөгжүүлж ард түмнүүдийн их нүүдлийн цаг үеийг давуулан хадгалсаар ирсэн нь Булгаарын ч юм уу, Мажаарын дундад зууны урлагийн бүтээлийг байлдан дагуулах аугаа аян дайнд цэргийг захирах жанжнуудад зориулан бүтээсэн үй олон урлаг соёлын хийгээд хэрэглээний эд зүйлсээс яв цав ялгаж танихад амаргүй болгожээ.

Жишээлэхэд Тисса голын доод биений Сэгэд-Нодьсэдшүшийн дэргэд орших нэгэн ноёны булшнаас гоё алтан аяга олдсон бөгөөд түүний цоорсон хэсгүүдийг нь анхандаа өөр материал, Ойрын Азийн алдаршсан арга барилаар магадгүй зөвхөн шил юм уу, эсвэл хагас үнэт чулуугаар чигжсэн байжээ. Ер нь Хүннүгийн алтны дархчууд чулуун сийлбэр хийхдээ тун дуртай, сайн ч хийдэг байжээ.

Эдгээр бусад хаадын хэмээн нэршсэн булшнууд нь Аттилагийн үеийн цэргийн дарга нар өөрсдийн эд хөрөнгийг биедээ авч явдаг байж, эд хөрөнгө, алт эрдэнэсээ зөвхөн амиа алдахын цагт л алдагдахаар тийм газарт, жишээлбэл илд, чинжаал хутга, бусад зэр зэвсгэндээ хадгалах нь харьцангуй найдвартай байжээ. „Аттилагийн үеийн урт илднүүд л гэхэд бариул нь шинэлэг зүйл байсан төдийгүй бас алт, хагас үнэт чулууг илдний бариул, хуйг чимэглэхэд өргөн хэрэглэж байсан нь хэмжээ дамжаагаараа урьд өмнө үзэгдэж харагдаагүй зүйл байв“ хэмээн Иоахим Вэрнэр бичжээ.

Илдний төрлийн зарим олдворууд ийнхүү асар их үнэ цэнээрээ ихээхэн шуугиан дэгдээн музейнүүдийг чимэглэж, бас Хүннүгийн судалгаанд тэртэй тэргүй үе үе гарах болсон маргаан мэтгэлцээний сэдэв болжээ. Чийгтэй газар сайн илд сэлэм ч зэвэрч муудах агаад ийн хэврэгшсэн сэлэмнүүдийг дахин сэргээн засварлах техникийн боломж нь тун саяхных бөлгөө. Иймээс Райн мөрний баруун эргийн Альтлуссхайм тосгонд „энэ үеийн хамгийн гайхамшигтай тансаг зэвсгийн нэг жинхэнээрээ олдсон,, (Вэрнэр) нь их аз юм. 1932 оны 12 сард Германы хүн хамгийн шигүү суурьшсан газрын нэгэнд ажилчид нэгэн урт илд огт санамсаргүй олжээ. Өнөө Хоккенхаймын тойруу замаар авто хөсгийн дуун нүргэлэх тэр газарт хүннүгийн үеийн нэгэн ноёны булшинд

илд, гоёлын хийгээд зэр зэвсгийн зүйлс, хувцас хунарын тасархай хэн нэгэн олохыг хүлээх мэт анир чимээгүйн дунд хэвтсээр бүтэн хагас мянганыг үджээ. Эзэн нь бурханы оронд одоодоо ч биенээсээ салгахыг үл хүссэн, алт, үнэт чулууг харамгүй зарсан уран гоё хийц бүхий бүтээлүүд олджээ.

Нодьсэнтмиклушийн Аттилагийн хэмээгдэх алт эрдэнэсийн олдворуудаас хорин гурван алтан сав суулга, Майнц, Шпайер, Маннхаймын завсрын амралт зугаалгын нутагт буй Альтлуссхаймын үнэт эрдэнийн илд болон олон зууны турш дайран өнгөрөх цэргийн хөлд талхлагдсан дэлхийн бөмбөрцгийн алгын чинээ хэсгийн нэгээхэн тасархай энэ нутгийн бусад олон олдвор нь өнөөдөр ч хэл ам таталсаар буй эрдэнэсийн эрэлчид хийгээд булш ухагчдыг өөр талаас нь харуулж буй. Мухар сүсэгт маанаг гайхлууд гэгдэн удтал элэглүүлж явсан тэдний дотроос ухаалаг зарим нь олон түмэнд нэг их илэрхий биш ч гэлээ маргашгүй олон баримтыг, тэдгээр нь ямар үр дагавартайг таниулж ойлгуулж буй болой.

Эхний баримт нь тэдний хайж олсон хаад ноёдын бүх булшнаас бүрэн бүтэн, өөрөөр хэлбэл тоногдоогүй булш бараг нэг ч байгаагүй явдал болой. Газрын хөрсөнд өөрсдийг нь хүлээн хэвтэх алтан олдворуудыг аливаа мэдээ сэлтийг сайтар цэгнэж байгаад бөө нарын ид шидийг хариулчихаад л ямар ч эрсдэлгүй авч өөрт шингээх овсгоо самбаатай хүмүүс хэзээд байдаг.

Хоёрдахь баримт гэвэл хүннүчүүдийн эгэл жир цэрэг эрс буюу эсвэл тэдний талд байлдаж явсан дайчдын бараг бүх булшийг системтэй ухах кампанийн явцад гар хүрэлгүй зүгээр л орхисон явдал болно. Энэ нь эрдэнэсийн эрэлд мордож булш ухаж хоослогчдын хаана ухахаа сайн мэддэг, арга нь ч нарийн байсныг илтгэж буй.

Эцэст нь гуравдахь баримтыг бид өнөөдөр зөвхөн алт л булшнаас юм уу, газар шорооноос олдох үнэт олдвор хэмээн үзэх аргагүй гэдэг өнцгөөс харж болно. Түүхийн хувьд их үймээн самуун дэгдээсэн тэрхүү ард түмнүүдийн их нүүдлийн үеийн эд өлгийн зүйлсийг сонирхох олон мүзей болон түүх соёлын эд өлгийн зүйл цуглуулдаг олон нийтийн газрууд булшны ямар ч олдвор, ямар ч эд өлгийн зүйлсэд үнэ хайрлахгүй болжээ. Нэхмэл эд зүйл, морины тоног зэрэг арьс ширэн эдлэлийн хэсэг бусаг нь өнөөдөр дахин сэргээх аргагүй металл эд өлгийн зүйлээс судалгааны хувьд илүү ач холбогдолтой агаад учир нь нэхмэл зүйл нь орчин үеийн багаж хэрэгсэл ашигладаг археологч хүнд үнэ цэнэтэй мэдээ баримт өгдөг явдал болой.

Тиймээс 1950-иад онд Францын радиогийн сонсогчдод хандаж алт эрдэнэс байж болзошгүй газарт хамтарсан экскурс хийхийг уриалж Роберт Шарро зэрэг түүх сонирхогч зохиогчид нэрд гарсан нь гайхмаар явдал биш байв. Хатагтай ноёдууд ч түүний уриалгыг яаран дагаж эртний олдвор байж болзошгүй газраар баахан хэрж

тэнэжээ. Хэдийгээр Франц зэрэг оронд эртний булш бунхан шигүү байрладаг, нөгөөтэйгүүр Францын олон нийт түүхийн хувьд Германы радио сонсогчдоос хавьгүй илүү бэлтгэлтэй ч энэ нь Шарро хийгээд түүний дагуулуудад нэмэр болсонгүй, шуугиан тарихаар сүйдтэй юм олоогүй ажээ. Гэхдээ эртний цайзуудаар тэнэж элдэв хөсрийн ястай таарч, зэвэрсэн дэнлүүний суурь, хуучны хуяг дуулганых гэхээр хэдэн хадаас, эрэг мэтхэнийг олж зугаацаж явах нь дээрх эрхмүүдэд зугаатай байжээ. Мүзейн үзмэрийн танхимд тавиулж чадахгүй гэхэд хөлс хүчээрээ олсон эдгээр үнэт зүйлсээ гэрийнхээ шилэн шүүгээнд залчихсан сууж байхад бас ч зүгээр.

Ийн зарим хүн үүгээр түүгээр бэдрэн олдвор хайж, өөрийгөө болон өөр бусдыг шоолж байхад бусад зарим нь эрэлч болж энд тарианы талбайгаас юм уу, тэнд хэсэгхэн ойгоос мундаг олдвор олж сэтгэлийн цэнгэл эдлэхийг найдана. Яагаад гэвэл Аттила хаан үүгээр аялж, түүний дайчин эрчүүд Германы гол мөрний хөндийгөөр агт морьдоо туун өрнийг зорин аялж, мөн л энэ нутгаар дорно руугаа буцаж явсан баримт бэлээхэн байгаа билээ. Бараг л тэр чигээрээ хээр тал, хүн харьцангуй сийрэг суурьшсан тал нутагтай Мажаарт ихээхэн баялаг олдвор бүхий хэдэн арван газар, булш, оршуулгын газрууд, эрдэнэсийн сан илэрсэн билээ. Германд газар хэдэн үеийн турш ухагдаж төнхөгдөн, малтлага дахин дахин хийгдсээр байсан бөгөөд ард түмнүүдийн их нүүдлийн үе нь хойчийн олон үеийнхний хувьд нэгэнт улирч өнгөрсөн цаг болсон нь үнэн билээ. Гэвч алт зэвэрдэггүй, үнэт чулуу автомашины хурдны зам, төмөр замын дор орж алга болдоггүй. Хүннү нарынх ч байж тун болзошгүй Нибэлүнгийн гэгдэх дармал алт эрдэнэсийн тухай домог гарснаас хойш эрдэнэсийн сангийн тухай сураг чимээ намдаагүй агаад нэг л гэгээн цагаан өдөр гэнэтийн сонин мэдээ тарахыг үгүйсгэх аргагүй. Гэвч харамсалтай нь өнгөрсөн хэдэн арав, бүр хэдэн зуун жилд дармал алт эрдэнэс олсон хүмүүсээс түүхийн хийгээд шинжлэх ухааны ач холбогдлыг ойлгон үзэж, тэрхүү булш юм уу, дармал эрдэнэсийг гар хүрэлгүй орхиж, холбогдох хүмүүст нь мэдэгдэж байсан жишээ хуруу дарам цөөхөн байжээ. Булшнаас гарсан хамгийн үнэ цэнэтэй эд өлгийн зүйлс тэр дороо л оносон эзнээ олчихдогийг ярихаа байя гэхэд хүннүчүүдийн өдий төдий булшны олдворын байдлын тухай тойм төдий мэдээ сэлт ч байхгүй.

Орчин үеийн судалгаа, сайн төхөөрөмжилсөн зонд, хэт ягаан туяаны гэрэл зургийн арга болон бусад туслах арга хэрэгслээр хүний нэгэн үеийн амьдралтай тэнцэх хугацааны өмнө бол үл гүйцэлдэх зүйл гэгдэх байсан зүйлийг өнөөдөр хийж чадаж байна. Археологийн шинжлэх ухаан өнөөдөр ийм туслахуудтайгаар тодорхой газар нутаг, газрын гадаргуу болон орон суурингийн бүс нутгуудын өрнүүн хөгжил, хурдан өөрчлөлттэй уралдан амьсгаа ч бараг авах завгүй ажиллаж байна. Хүрз барьсан булш ухагчийн нүдэнд тусах зүйлийг экскаваторч огт мэдрэхгүй нь олонтаа. Тиймээс бид хөгшин Европын газрын хөрсөн дор хаа сайгүй тархан оршиж буй өнгөрсөн үеэс өнөөгийн бидэнд явуулсан нууцлаг илгээлтийг хэзээ ч бүхэл бүтнээр таньж мэдэж

чадахгүй билээ. Тал нутаг зах хязгааргүй хийгээд дүлий дүмбэ. Энэ л их тал нутгаар хүннүчүүд, аварчууд Ойрын Азийн азийн уран нарийн хийцтэй зэвсгээ агссаар ирж, Ромд он удаан жилээр хэвтэж асан энэ дэлхийн алт Альп, Балканы уулсыг даван хүннү нарын хаад ноёдын зоогийн ширээ болон тэдний зэр зэвсэг, гоёл чимэглэлийн зүйлс, байлдан дагуулагч овгуудын эд хэрэгсэл рүү урсан ирэх замаа олжээ.

„Юуны өмнө торго болон бусад нэхмэл эдлэл хадгалагдаж үлдээгүй, тэгээд ч энэхүү ямар ч системгүй цуглуулсан булшны олдворуудад дулдуйдан хийж буй ишлэл ямархан тохиолдлын чанартай гэдгийг бодож үзэх юм бол Аттилагийн гүрэн улсын дээд давхрагынхны зардал сүйтгэл хийгээд хөрөнгө хогшлын талаар хаад ноёдын булшнуудын өгч буй дүр зураг нь бодит байдлын зөвхөн нэг бүдэг тусгал л юм“ хэмээн Иоахим Вэрнэр бичжээ.

4.

□□□□ □□AA□□ □□□□□γ□ □□□□

Хүннү нарын талаар бидэнд буй мэдээ сэлтээс тэд эрчүүд зонхилж манлайлсан ертөнцөд амьдарч байсан нь харагдана. Ах, эрэгтэй дүү нар эхнэр хийгээд бэлэвсэн эхнэрээс хамаагүй илүү эрхтэй байжээ. Бага эхнэрүүд нь боолоос нэг их ялгарахааргүй тавилантай байсан агаад зөвхөн хаан ширээг залгамжлахаар тодорсон хөвгүүний эх болох их эхнэр л бидний наран жаргах зүгийн орнуудад гэргий нартаа ногдуулж заншсан үүрэгтэй харьцангуй ойролцоо байр суурь эзэлдэг байжээ.

Эмэгтэйчүүдийн нийгмийн хувьд ач холбогдолгүй байр суурийн уг үндэс нь гүн гүнзгий байсан агаад энэ нь сүсэг бишрэл юм уу, эсвэл хууль зүйгээс үүдэж буй бус, харин нүүдэлчдийн ахуй амьдралын нөхцөлдүүлдэг эмэгтэйчүүдийн уугуул хязгаарлагдмал оршихуйгаас шалтгаалж буй юм. Хүннүчүүд байшин барилга, хашаа саравч гэж мэддэгүй, мал сүргээ сул чөлөөтэй бэлчээж, Америкийн зэрлэг өрнийнхний заншлаар морь малаа бугуйл, уургаар барих учир гэр, тэрэг л эмэгтэйчүүд, бүсгүйчүүдийн бүхий л амьдралын тойрог хүрээ нь болж байжээ. Бид үүнийг бараг л орой болгон зурагт радиогоор гарах зэрлэг өрнийн сэдэвтэй цуврал сүүдэр шийгээс хардаг бөгөөд тэнд үе үе эмэгтэй хүнийг тоглоомонд оруулах агаад тэрхүү агт морь, зэр зэвсэг хийгээд эрчүүдийн ертөнцөд бүсгүй хүнийг нэвтрүүлэх нь кино зохиолчийн дур зоргын хэрэг болой. Харин хүннүчүүд эмэгтэйчүүдийн гэхээр уламжлалт ажил үйлсийг хатуу зааглаж хязгаарласан байв. Бидний үед хэдэн арваараа хүрч ирсэн асар том тогоонуудад хоол ундаа хийж нийтээрээ нэг тогооноос хооллодог, Европын эзэд болсон хүннүчүүд Францын газар шороонд хөл хавьж байхдаа ч хамгийн эгэл боргил хоол унд хэрэглэсээр байжээ гэдгийг мэдэх болсон. Хүүхдүүд ч ялгаагүй нийтийн хувь зохиолыг

хуваалцаж байсан бөгөөд Аттила эхээ бус эцгээ л мэддэг, мөн хаана хэдийд энэ дэлхийд мэндэлснээ ч хэлж чаддаггүй байсан гэх утгагүй гэмээр баримт эндээс эхтэй. Магадгүй тэрээр төрөлхөөсөө европ хүн байсан байж мэднэ. Эхийн талаасаа өнө эртний аль нэг гүрж гэр бүлийн кавказ цус холилдсон байж ч болно. Эсвэл эхийн талаасаа монгол овгоос гаралтай хүн байсан ч байж магадгүй. Бид үүнийг мэдэхгүй! Түүний эцэг, ах дүүсийг бид нэрээр нь мэднэ, мөн ахыг нь ч мэднэ, Аттилагийн хөвгүүдийн талаар ч мөн хангалттай мэдээ сэлт бий...

Хүйсийн хоорондын харилцаа нь аливаа нийгмийн хамгийн тогтвортой байнгын хэмжүүр байдгийн учир нь нэг үе нөгөөгөөр солигдоход дагаж өөрчлөгддөггүй, түүгээр ч үл барам амьдрах орон зай Азиас Европт шилжиж солигдоход ч хувирч өөрчлөгддөггүй байнгын чанартай байдаг бөлгөө. Энэ нь хүннү нарын Ази дахь өвөг дээдэст ч нэгэн адил хамаарах бөгөөд тэдний нэг Моодун хаан гэхэд л наад зах нь эхнэр хүүхнүүдэд хандах байр сууриараа Аттилагаас, Европт ирсэн хүннүчүүдээс ялгарах юмгүй байжээ. Түүнийг хаан ширээнд суухын цагт өөрсөдтэй нь адил нэгэн дайнч аймаг болох Тун-ху нар хүч чадлынхаа оргилд хүрээд байж, тэгээд л залуу хааны ирийг мохоож омгийг дарья гэж боджээ. Тийн Моодунд эхлээд элч илгээж, хурд хүчээрээ хүннү нарын хил хязгаараас хальж алдаршсан хурдан хүлэг морио бэлэг болгон ирүүлэхийг хүсчээ. Моодуны шадар сайд нар хилэгнэн зэвүүцэж уг хүсэлтийг няцаахыг санал болгосонд Моодун „Хөрш улсаас, энх амгалан байхаас ганц морийг илүүд үзэж болно гэж үү? Хүссэн морийг нь илгээ“ хэмээн зарлиг буулгажээ.

Өдөөж хатгасан хүсэлт нь ёсоор болсонд эрэмшсэн Тун-ху нарын нүүдэлчид улам цаашилж, хайртай хатнаа өг хэмээн Моодунаас шаарджээ.

„Одоо ч дайтахаас өөр арга алга даа“ гэж сайд нар нь өгүүлсэнд Моодун „Яалаа гэнээ! Эхнэр хүүхний төлөө хөрш оронтойгоо дайтах хэрэг үү? Морь өгч болсон юм, нэг эхнэрийг бол өгч бололгүй дээ...“ хэмээгээд эхнэрээ өгч явуулжээ. Ийнхүү эвийг сахиж чаджээ хэмээнэ.

Хятад он дарааллын бичээч нарын онигоо маягаар хөөрч өгүүлсэн уг түүхээс асуудал яг дээр өгүүлснээр өрнөсөн эсэхийг мэдэх аргагүй. Гэхдээ хятадууд хүннү нарыг нэлээд гайгүй мэддэг байсны учир хүннүчүүдийн зан үйлд харш гэхээр ямар нэг зүйлийг даапаалж элэглэхээсээ наана тэдний байнгын дайсны даварсан үйлдлийг даажигнаж шоолсон байж таарна.

Харин хятадууд гүнжүүдээ хүннү нарын хаадад богтлон өгч эхэлсэн үеэс зарим нэг өөрчлөлт гарсан байдаг. Энэ бол төрийн эрх ашгийн үүднээс хийж байсан хэрэг бөгөөд цаашдаа нүүдэлчдийн ноёдтой дэр нэгтгэж тэдний амьдралаар амьдрах тавиланг олсон тэдгээр бяцхан хээнцэр хатагтай нарт хүн атаархаад байх юм юу ч

байгаагүй нь мэдээж. Хятад газар ахуй амьдралыг нь чимж байсан хамаг юм, хичээл ном, харьцаж байсан эрдэмтэн мэргэд, яруу найрагчид хийгээд ордны орчин ахуй зэргээсээ тэд хагацах ёстой байсан бөгөөд хэдийгээр ганц нэг зарц шивэгчин нь бараа болж дагалдан явж, магад ч үгүй ганц нэг найз нь сайн дураараа тэрхүү үл мэдэгдэх алс холын орон руу дагаж явсан ч сэтгэл тайтгаруулах юм тун хомс байсан биз ээ.

Харин хүннүчүүдээс зэрлэг бүдүүлгийн туйлд тоологдох этгээдүүд ч дундад гүрний эрхэмсэг хийгээд боловсролтой хүүхнүүдэд нэлэнхүйдээ тун хүндэтгэлтэй ханддаг байсан агаад тэд нийт дундаа дундад гүрний эвлэршгүй дайсан байсан хэдий ч Хүннүгийн хаад ноёдын хэлүүлсэн үгс, илгээсэн захидалд хүний амьдралын хамаг л нарийн ухаан, харьцааны эвлэг урьхан дадал заншил болсон дао-г төсөөлөхгүйдээ гэмшсэн харамсал илэрч тодордог байжээ.

Ийн хүннү нар тал хээрийн зэлүүд бөглүүд ахуй гэртээ өдий төдий үр ач нараараа хүрээлүүлэн бага хатад, татвар эмсийн морь нохой мэт үнэнчээ илэрхийлэх харцан дор нам жим сууцгаах үес эрхэмсэг хятад гүнж нар зөвхөн хийсвэл мөрөөдөлдөө дарагдан санааширч бодол санаа нь уян налархай шүлэг найргийн мөрүүдэд шилжих ажгуу. Алд бие нь золиос болсон ийм оршихуйн сэтгэл шимшрүүлэм гэрч өнөөг хүрч ирэхдээ хэдэн зуун мянган хятад шүлэг найргийн доторх нэгэн бүдэгхэн дуу хоолой болж оржээ.

„Баруун талын номин хаалгаар
Баахан зүрх алдсаар хөл тавьж
Бүдэг алсыг зорьсон билээ л.
Өнөө би санаашран алсыг ширтэж
Өндөр хөх уулсын чанад ахуй
Өнийн сайхан нутгаа санагалзмуй.
Цаг хугацаа, харуусал гуниг
Цаглашгүй хөх огторгуй лугаа хязгааргүй.
Оломгүй гүн их мөрнүүдийн чанад
Хязгаар хярхаггүй их тал нутгийн тэртээ
Элбэрэлт эцэг эх
Элгэн нутаг Цин минь алсарна“.

Тэдгээр хатад гүнж нарын нэрс Байгаль нуурын тэртээх өргөн уудам нутагт уусан алга болж, тэдний турьхан бие цогцос Туркестан, Казахстаны газар шороонд эгнэгт шингэжээ. Тэднээс Хятад гүрэнд үеийн үед талархагдах үйл бүтээсэн хэд гурав нь он дарааллын бичигт нэр заагдан орсон байдаг. Тухайлбал, Ван-Цао-Киюн хэмээгч гүнж „Ху нарын зэрлэгүүдийг түвшитгэсэн хатан“ хэмээн тэмдэглэгджээ. Энэ гүнж боглгодон очсон хаан эзнээ ихээхэн амирлуулж түвшитгэсэн гэгдсэн агаад ер нь хатад

эхнэрүүд хаан эзэндээ ийн нөлөөлж байсны олон жишээ голдуу домог хуучид гардаг болой.

Энэ дашрамд бид хүннү нарын олон эхнэрийн доторх зэрэглэлийн талаар сонин зүйл олж мэднэ. Хүннүгийн хаанд Цуан-кү гэж нэгэн хатан (хятадуудын нэрлэдэгээр) байсан гэх агаад тэрээр хааны хамгаас хайртай, хааны ивээлийг олсон хатан нь байжээ. Тэхдээ тэр нь их хатан буюу их эхнэр нь биш байсан гэх. Их эхнэр нь тэрхүү хааны хайртай хатнаас насаар залуу байсан гэх агаад өөр нэг домогт түүний төрсөн дүү нь байсан гэгддэг. Тэгэхээр олон эхнэрийн доторх зэрэглэлийг хааны тааллаар тогтоож байжээ гэж ойлгогдоно. Мөн хөвгүүдийн хувьд ч байдал яг л ийм байжээ. Ахмад хөвгүүн хааны хайртай хөвгүүн нь байх албагүй, хаан ширээгээ заавал түүнд залгамжлуулна гэх юмгүй байжээ. Гэхдээ хаан эзний тааллаараа гаргасан ширйдвэрийг нь түүнийг насан өөд болсны дараа өөрчлөх явдал бишгүй байжээ.

„Цуан-кү хатан бол хааны хамгийн хайртай хатан, Цү-Бок-Кү хамгаас хайртай хөвгүүн нь байлаа. Ийн Хү-Хан-Са хаан бие чилээрхэн хэвтэрт ороод үхлийн ирмэгт очоод байхдаа Цү-Бок-Кү-г хаан ор эзлэх ёстой хэмээн захижээ. Гэвч хөвгүүний эх Цуан-кү хатан өгүүлэв. Хүннү гүрэн арав гаруй жил үймээн самууны хөлд дарагдаад байна. Энэ самуун толгойн үс лүгээ нэмэгдсээр амуй. Хааны засаг тогтож энхжингийн цаг ирэхийн наана ард түмэн дахиад л хэрүүл тэмцэлд татагдан орно. Ард түмнийг номхроож захирна гэхэд Цү-Бок-Кү өнөө дэндүү балчир буй учир гүрэн улсад дахин хор хөнөөл ирнэ. Их хатан бид хоёр нэг гэр бүлийн хүмүүс тул түүний үр хүүхэд минийх л гэсэн үг. Тиймээс (нэгэнт нас бие гүйцсэн) Цяо-То-Бок-Ко хаан ширээнд суух нь дээр“ хэмээжээ.

Ийн их хатан хийгээд хайртай хатан эгч дүү хоёр хэсэг хэлэлцсэний эцэст мэргэн шийдвэрт хүрсэн нь Цяо-То-Бок-Ко-г хаан ор эзлүүлэх, чингэхдээ тэрбээр (эцэг нэгтэй) дүү Цү-Бок-Кү-д сүүлд хаан ширээгээ талбин өгөх үүрэг хүлээжээ. Ийм л нэг хачин ах дүүсийн эрхт ёсон байж түүнд нь эн тэргүүнд эхнэрүүд зүг чигийг гаргаж байжээ. Тогтсон нэг л нутаг бэлчээрийн дунд элж улирах урьд өмнийн, нүүдэлчин амьдралын эл нөхцөл байдлын хувьд байлдан дагуулах аян дайн нь зөвхөн гадна талын өнгөц хувьсал өөрчлөлт авчирчээ. Хүннүчүүд өвөлжөө, хаваржаа, намаржааны хооронд элээсэн дасал болсон нүүдлийн замыг орхиж, нутаг сэлгэж даялсаар алс өрнөд хүрч иржээ. Хүннү нар аль эртнээс урлаг соёлын нөлөө нь тал нутагт нэвтрэн ирсээр асан Ойрын Азийг өөрсдөө таньж мэдээд дараа нь цус асгаруулсан аян дайнаар хөндлөн гулд туучин гарчээ. Хүннүчүүдийн нэг салаа нь Персийн эртний соёлт оронд ноёрхон сууж эфталит гэх цагаан хүннү нар болоод Аттилагаас хойш хэдэн зууныг дамнуулан засаглан суужээ.

Нөгөө нэг салаа нь их тал хээрийг туучин цаашлан байлдаж явсаар энэхүү хачин жижиг давчуу ч гайхалтай сонин Европ газрыг тэмцэн хүрсэнд дайснуудынх нь ирүүлсэн элч нараас нутгийнх нь ноёдын эхнэрүүдээс ч илүү чамин сайхан үнэр ханхлах агаад хүмүүс нь байшинд сууж орон байр нь их том учир зарц шивэгчин худалдан авдаг заншилтай ажээ.

Эд баялаг эмзэг мэдрэмтгий болгодог гэх үг хүннү нарын хуучны зүйр үг биш ч гэлээ энэ нь нүүдэлчин ард түмнүүд чинээлэг газар орныг байлдан дагуулах явцдаа олж мэдсэн нэг зүйл туршлага юм. Нутгийнхны эсэргүүцэл тэмцэл алаг цоог мөргөлдөөн, ганц нэг том тулалдаанаар хязгаарлагдаж байв. Хүннүчүүдийн өөдөөс өнөөдөр бол партизаны тактик гэхээр сунжирсан урт тэмцлийг эзлэгдсэн ямар ч ард түмэн хийж зүрхлээгүй билээ. Тиймээс ч эхнэр хүүхний хувьд хүннү дайчин эр татвар эмсийн хүрээлэнд байгаа адил ямар л ямыг дуртай цагтаа дуртай газраасаа сонгож авах боломжтой байжээ. За тэгээд өөрийнх нь сонгосон хүүхэн үнэнхүү ундууцаж дургүйцэх ахул хөх инээд нь хөдөлж гижиг нь хүрэх ажгуу.

Аян дайны үеийн ийм зуршил нь хүннүчүүд хийгээд бусад нүүдэлчдийг баахан дураар аашлах авиртай болгох нь мэдээж, тэгээд л тэд энхийн цаг хийгээд шинээр эзэлж улс орон эзлэж авангуутаа эхнэр хүүхнүүдэд шунан тачаадах бүлгээ. Хаад ноёд цэрэг эрчүүдийнхээ дур тачаалыг хангахын тулд хэрхэж байсан талаар бид хааяа нэг тохиолдлын мэдээ сэлттэй таардаг билээ. Ануширван хочит I Хосроес хаан (*Перст 531 оноос хаан суусан I Хосроес Ануширваны үед Сасанидийнхны гүрэн үлэмж хүчирхэгжиж байв. Орч.*) „Эфталитуудыг дийлснийхээ дараа Хорасанд байсан аварчуудыг цэнгүүлэхийн тулд хоёр мянган христ шүтлэгт онгон охидыг өөрийн хишиг хэмээн илгээе гэж шийдсэн“ гэлцдэг. (Альтхайм II боть, 272 дугаар тал)

Хүннүчүүд дан онгон охидод унаж тусаад ч байсангүй бололтой агаад мөн тэд дандаа л христ мөргөлт хүүхнүүдийг онцлоод илүүд үзээд байсан эсэх нь батлагдаж нотлогдсон зүйл бус. Ямар ч болов тэд дайны олз омог хийгээд олзлогдсон хүмүүсээс ихээхэн ашиг унагаж байлаа. Эрчүүдийг нь буцаагаад ромчууд, византийнханд алтаар арилжиж байв. Олзлогдсон эрчүүдийг дагуулан авч яваад байх нь осолтой байв. Нүүдлийн орчин ахуйд тэднээр ажил хийлгэхэд хэцүү, хүннүчүүдийн эрх дураар тарвалзах амьдралын нөхцөлд тэд оргож босох нь амархан байжээ. Тэгэхээр тэднийг нэг хэсэг чанд харгалзаж байгаад тэгсхийгээд ашигтай арилжаалах нь дээр байв. Харин эхнэр хүүхнүүдийг бол боол болгож, арай зөөлөн хэлбэл олон талаар ашиглаж болох байв. Энэ тухайд сүм хийдийн толгой лам нар сэтгэл шимшрэн өгүүлж байсан бол Византийн элчүүд ч мөн л сэтгэл их л өвдсөн байдалтай мэдээлж байв.

Тэдний нэг нь уран илтгэхийн ухаанд нэвтэрсэн Прискүс байсан агаад түүний тэмдэглэл Аттила хийгээд түүний орд өргөөний талаарх гол эх сурвалж бөлгөө. Тэрбээр хүннүүдийн хааны энх цагийн амьдрал үйлийн тухай нүдээр үзсэн харсан зүйлдээ тулгуурлан маш сонирхолтой, гол нь найдвартай эх сурвалжид тулгуурласан мэдээ зангийг үлдээсэн билээ. Түүний 472 оны хавьцаа туурвисан бүтээлээс Прискүс болон бусад дипломатууд Аттилатай дахин яриа хэлэлцээ хийх аятай боломжийг хүлээн түүнд бараа болж харьяат газар нутгаар нь аялан явсан тухайгаа өгүүлснийг иш татъя. Энэ нь 448 оны хавьд болсон үйл явдал болой.

„Эхлээд бид зэрлэгүүдтэй хэсэг зуурхан хамт аялж явсны дараа скиф (хүннү) газарч нар биднийг өөр замаар явахыг тушаав. Аттила энэ хооронд нэгэн тосгонд буудалласан нь тэндхийн санваартны охиныг эхнэр болгон авах гэсэн хэрэг байжээ. Уг нь тэрбээр хүннү нарын заншлаар олон эхнэртэй хүн л дээ. Тэндээс бид арай гайгүй замаар үргэлжилсэн их талыг туулж усан онгоц хөвж явмаар олон гол мөрнийг гатлав. Томоохон нь Дунайгаас гадна Дрекон, Тигас, Тифизас байлаа. Энэ гурван голыг тэр хавьд нутагладаг овог аймгуудын хэрэглэж заншсан модон завиар гатлав. Бусдыг нь салаар гаталсан бөгөөд зэрлэгүүд салыг тэргэн дээр ачиж балчиг намаг газрыг туулж явах бөлгөө. Хоол хүнсээ бид тосгодоос авч байсан ба буудайн оронд арвай маягийн нэгэн зүйл будаа, дарсыг нутгийнхны хэрэглэдэг зөгийн балаар нэрсэн ундаагаар орлуулж явлаа. Бас зарц нар маань шар будаа олж ирдэг байсан бөгөөд түүгээр зэрлэгүүд өөрсдөө *камон* хэмээн нэрлэх нэгэн зүйл ундаа хийнэ. Ийн их л хол газрыг туулж, үүр хаяарах хэрд хавийн тосгодынхны амны усаа авдаг нэгэн том нуурын захад буудаллав. Гэнэтхэн тэнгэр муудаж хүчтэй салхи шуурга дэгдэж үе үе аянга цахиж аадар бороо хувингаар цутгах мэт асгаж муу майхныг маань хуу хамж хамаг ачаа бараатай хажуугийн нуур руу хийсгээд явчихлаа. Бид ч хамаг юмыг маань хамж одсон аянгат аадар, салхи шуурганаас үхтлээ айж цочров. Ингээд тэрхүү муу ёрын газраас бушуухан зайлахдаа бие биеийг олж харахаа ч байж түнэр харанхуй, усан бороон дунд төөрч замаа эрж бэдэрлээ... Энэ их үймээн шуугианд скифүүд ч (Аттилагийн дагалдах баг) айж сүрдсэн байв. Тэдэнд хөтөч нар маань салхи шуурганд хэрхэн хэлмэгдсэнээ тайлбарласанд биднийг зочирхгоор хүлээж аваад хуурай зэгсээр их гал өрдөв. Тосгоны захирагч хатагтай Бледагийн олон эхнэрийн нэг байсан аж. Тэрбээр бидний ирснийг дуулаад хоол унд илгээж, бас биднийг эр биеийн таашаал эдлэг гэж сайхан хүүхнүүдийг ч явуулжээ. Скифүүд зочдоо ингэж хүндэлж тойлдог ажээ“.

Херодотын шавь эрдэм номд боловсорсон, уран илтгэгч Прискүс уг нь „зочныг садарлуулах“ хэмээх муухай үгээр тодорхойлоод ч утга санааг нь бүрэн гүйцэд гаргаж үл чадах хүүхэн өгч зугаацуулдаг хуучны энэ заншлыг сайн мэдэх л учиртай. Уул нь хүннү нарын хувьд бол энэ заншил үл ялих, хэвийн л явдал байжээ. Тиймээс боол хүүхнүүд хүрэлцээтэй, мөн тэртэй тэргүй өөрсдийнх нь мэдэлд байх тосгоноос залуу

хүүхнийг зочиндоо явуулах нь тэдний хувьд ерийн зүйл байв. Марко Поло Төв Азиар аялж явахдаа эх нутагтаа үлдсэн хүннүчүүдийн удам угсааныхны „зочныг хүүхнээр зугаацуулах“ энэ заншлыг бишгүй л үзэж мэдэж явсан ажээ. Тэнд гэрийн эзэн зочиндоо эхнэрээ хэрэглүүлдэг заншил байсан бөгөөд үүнээс татгалзах нь хүнд доромжлол гэгддэг байжээ. Хүннү нараас огт өөр, угсаа гарал, аж төрөх ёсны хувьд эрс ялгаатай хуучны Ирландад хөлөг баатруудын халз тулаан дийлэгдсэн этгээдийн эхнэрийн өвөрт дуусдаг байж. Ялсан баатар эр нөхрөөс нь хэр зэрэг илүү гэдгээ өрсөлдөгчийнхөө эхнэрт нь ч бас үзүүлэх заншил байжээ. Тэгээд христийн дундад зуун хүрч байж энэ эртний ёс заншил бага зэрэг хөнгөрч, зочныг уг айлын зарц хүүхнүүд, эсвэл охид, заримдаа бүр айлын эзэгтэй өөрөө найрсгаар хүлээн авч халуун усанд оруулж ямбалуулж зугаацуулдаг болсон ажээ. Вольфрам фон Эшенбахын „Парцифаль“ (*Парцифаль нь В.Эшенбахын ийм нэртэй туулийн баатар бөгөөд уг туульд зэлүүд бөглүү нутагт төрж өссөн нэгэн олон адал явдал туулж, хааны ордны ном ёсонд суралцаж, ариун гэгээн үйлс бүтээж, шашин номын ёсонд нэвтэрснээр гэгээн хаан болж буй тухай өгүүлдэг. Рихард Вагнер „Парцифаль“ дууриа энэхүү туульд түшиглэн бүтээжээ. Орч.*) бол Ромын гэгээн хутагтын элч Паоло Сантониногийн Кэртэн нутагт (*Австрийн баруун өмнөд муж. Орч.*) үзсэн хүндлэл соёрхлын баримт нотолгоо, уран сайхны гэрчилгээ мөн.

Шөнөөр баахан бэдэрч ядарсан хийгээд арвай, шар будаахнаар өл залгасан нь хүүхнүүдтэй самуурч хонох өчүүхэн дур сонирхлыг ч үл өдөөх учир Прискүс, түүний дагуулууд хоол унд илгээсэнд талархаад охид хүүхнүүдийг уран тачаангуйн увдисыг нь туршин үзэлгүйгээр буцаажээ.

„Бид майхан сав, ачаа бараагаа хатааж бүтэн өдрийг тосгонд өнгөрөөв. Салхи шуурга намдаж тэнгэр ч цэлмэв. Тэгээд бид морьд, хөллөгөөний шарнууддаа өвс тэжээл тавьж өгөөд хатны (Аттилагийн ах Бледагийн дээр дурдсан эхнэр) амрыг эрэхээр очив. Тэгээд зочилж дайлсанд нь талархаж гурван мөнгөн таваг, улаан будагтай арьс, жагар газрын чинжүү, фөникийн нанжин чавга, зэрлэгүүдийн амсаж үзээгүйн учир ихэд шимтэх элдэв амттан сэлтийг бэлэг болгон барив. Найрсгаар хүлээн авч зочилсонд дахин талархаад сайн сайхныг ерөөж мөнхүү тосгоноос хөдөлж явсан болно“.

Тосгоны охид хүүхнийг үл ойшоосон Прискүсийн өгүүлснээр зан харьцаа боловсон, эелдэг найртай гэдэг нь илэрхий Бледагийн хатныг тодорхой дүрслэн өгүүлээгүй нь харамсалтай. Гэхдээ ямар ч гэсэн дээрхээс бид Аттила нь ах Бледагийн адил хэд хэдэн эхнэртэй байсан, тэдний дунд ромчууд болон византийнхны хатан хааны хэмжээнд үзэж харьцаж байсан хатад байсан, учир нь тэд зэрлэг ахуй нөхцөлөөсөө товойн ялгарч байсныг мэдэж авч болно.

Прискүсийн өгүүлснийг унших тусам Аттила охид хүүхнүүдэд тун ч дуртай, юуны түрүүн удаан хугацаагаар сууж байсан газар бүртээ аль болох олон эхнэр хүүхнээр өөрийгөө хүрээлүүлж байсан нь тодорхой болно. Аттила үе үе саатан морилж гоёмсог байшинд өргөөлдөг тосгондоо очихдоо „нимгэхэн цав цагахан алчуур“ нөмөрсөн олон гоо охидоор угтуулдаг байсан бөгөөд угийн зэрлэг бүдүүлэг хэмээгддэг түүнтэй Германы хаан, Францын вангийн ийм ёслолд бол хамгийн нарийн тансаг алчуур ч байддаггүйг үл мэдэх нэгэн л мөчөөрхөх байсан буй заа. Энэхүү угтах ёслолын дараа Аттила Онегесиусын (Урьд энэ нэр эр хүний оноосон нэр байсныг үл мэдэх нэгэн өнөө бол албан тушаал юм уу хэргэм зэрэг гэж ойлгож мэднэ) өргөөнд дөхөж ирнэ. Энэхүү Онегесиус хэмээгч нь Аттилагийн хамгийн дотнын зөвлөх, итгэлийг нь олсон хүн байсан нь ямар ч эргэлзээгүй.

„Аттилагийн өргөө хүрэх зам Онегесиусын байрны хажуугаар гарна. Аттила ийн ойртож явахуй дор Онегесиусын гэргий өдий төдий зарц шивэгчний хамтаар өөдөөс нь тосон ирж, идээ зууш, сархад барих бөгөөд энэ нь скифүүдийн хувьд зочинд үзүүлж буй дээд зэргийн хүндлэл болно. Ийн тэрхүү хатагтай Аттила угтан мэндлээд найрсгаар тавтай морилохыг билэгдэн ерөөж идээ унднаас амсахыг урина. Хаан итгэлт хүнийхээ гэргийд тал үзүүлж буйгаа харуулж морин дээрээсээ идээ унднаас амсах болоход бараа бологсод нь мөнгөн цартай идээг өргөн барина. Дараа нь Аттила дугарааны сархадыг хүртээд өргөө рүүгээ явна“.

Энэ нь хэдий бага зэрэг хөдөх маягтай ч үдшийн орны ёс заншлыг санагдуулах ч манийг үл гайхуулах учир нь Хитлэр ч бас Карин хэмээх өргөөнийхөө шатны хажууд мерседес машинаасаа бууж ирэхэд мөнгөн цар мэт зүйл барьдаггүй ч мөн л иймэрхүү маягаар угтдаг заншилтай байсан юм. Аттила харин хэлэлцээ яриа, бараалхал ёслол хийгээд бусад олон үйл явдлын үеийнх лүгээ адил эмээл дээрээ цэх шулуун сууж байх ажгуу.

Ийн эмэгтэйчүүд зохих ёсны байр суурь эзэлж, элч төлөөлөгчид хүлээн авч, хаан эзнээ өргөөндөө морилоход нь угтан ёсолдог, хаанд ямар ч урьдчилж туршиж амсах хүнгүй, ёслолын даргыг оролцуулалгүй биечлэн идээ ундаа барих эрхтэй байж. Прискүсийн дүрслэн өгүүлж буй дүр зураг нь эхнэр хүнийг жигшин дорд үздэг, тэднийг далд хол байлгадаг тийм нийгэмд бол сэтгэшгүй зүйл юм. Ийм ёслолын зан үйл нь жишээлэхэд лал шашинт дорнын ертөнцөд бол ерөөс байх аргагүй, мавруудын эзэгнэж байсан Испанид бол „патио“ (*эртний Ромын орон сууцны барилгын дотоод олон баганаар хүрээлэгдсэн тэгш өнцөгт дөрвөлжин талбай.Орч.*)-д хийгдэх зүйл байлаа. Хүннү нарын хувьд орд өргөөний үүдний шатан дээр үдийн нарны нүд гялбам хурц гэрэлд олны нүдэн дээр гэрийн эзнээ угтан зогсох уг эмэгтэй бол зарц шивэгчин бус,

харин уг газрын орд өргөөний эзэгтэй байдаг бөгөөд эр нөхөр нь гэрийн гаднах үйл, арилжаа наймаа, аялал жуулчлал, аян дайны хэргийг гүйцэлдүүлэх бөлгөө.

Аттила тэр олон эхнэрүүдтэйгээ бүгдтэй нь Бледа юм уу, эсвэл итгэлт хүн Онегесиусын нэгэн адил харьцдаг байсан эсэх нь сонин юм. Прискүс энэ тухай ч өгүүлнэ.

„Маргааш нь би Аттилагийн морилох хашаагаар хүрээлүүлсэн орд өргөөний газар очиж хатан Крекад нь бэлэг барьсан билээ. Крека хатан Аттилагийн гурван хөвгүүнийг төрүүлсэн бөгөөд хамгийн ахмад нь акатцир (*Аттилагийн захиргаанд байсан нэг овог аймгийн нэр, ахмад хөвгүүн Эллак захирч байв. Орч.*)-үүдийг, бусад нь Хар тэнгис хавийн овог аймгуудыг захиран суух бүлгээ. Хашааны дотор талд олон байшин байна. Байшингууд нь заримыг зүсэж өнгөлсөн, нөгөө заримыг нь харуулдаж зассан урт урт модон хөндлөвч нуруутай, тэдгээр нь бие биеэс бага зэрэг зайтайгаар дээш эгнэж орой дээрх хагас дугуй модон тооныг өргөж байх ажээ. Тэрхүү тооно нь нэлээд өндөрт өргөгдсөн байна. Тэнд Аттилагийн эхнэр сууна. Үүдэнд зогсоо харуулын цэргүүд намайг дотогш оруулав. Намайг ороход Крека зөөлөн дэвсгэр дээр хажуулдан байх ажээ. Шаланд ноосон хивс дэвссэн байх бөгөөд дээгүүр нь алхах хэрэгтэй болов. Олон тооны шивэгчин бүсгүйчүүд Крекаг тойрон зогсоно. Өөр бусад зарц бүсгүйчүүд шалан дээр хүрээлэн сууж бөс даавууг элдэв эрээн мяраан хатгамалаар чимж оёх агаад дараа нь түүгээрээ зэрлэгүүдийн хувцсыг гоёдог байна. Би Крекагийн мэнд амрыг мэдэн бэлгээ бариад гарч, Аттилад бараалхлаар одсон Онегесиусын ирэхийг хүлээн өргөөний өмнө зогсов“.

Прискүс ийн Крека хатанд хоёр удаа бараалхажээ. Хэдэн долоо хоног үргэлжилсэн аяны дараа тэрбээр хүннүчүүдийн эзний ойр удтал сууж, харуулын хүмүүс бүгд түүнийг таньж мэддэг болсон учир орд өргөөгөөр нь сул чөлөөтэй хөдөлж явж байсан нь илэрхий ч түүний талаар ганц боловч үгээр дүрслэн бичсэн нь үгүй.

Гэрэг соёлын төлөөлөгч, эрдэм номтой, дэгжин хээнцэр Прискүс бол Балканаас гаралтай болохын хувьд гэрэг боловсролтой хамт хуучин гэрэгийн зарим нэг гэм согогийг өөртөө шингээсэн хүн байсан байж мэднэ. Тийм бол Визант үүнд нь шимтэй хөрс болсон нь эргэлзээгүй. Нөгөөтэйгүүр тэрбээр дипломат хүнийхээ хувьд хэт эвлэг даруу хүн байсан байж болно. Тэрбээр өөрийн өгүүллийг дүрслэн үзүүлсэн үйл явдлаас даруй хорин таван жилийн хойно туурвисныг бас бодолцох хэрэгтэй. Тэр Аттилатай уулзаж явах үедээ харьцангуй залуу, дөч ч хүрээгүй байсан агаад нас биед хүрч өөрсдөө засаглах болсон хөвгүүдийн эх хүн түүний хувьд хүндлэх бас эмээх сэтгэл төрүүлэхээс бус, сониучирхаж тачаадах сэтгэл төрүүлээгүй байж ч болно. Тухайн үед хүмүүс одоогийнхоос илүү эелдэг, илүү эв найртай байсан цаг тул өнөөгийнх шиг мадам Сукарно (*Индонезийн ерөнхийлөгч асан Сукарногийн гэргий, Наоко Немото*

хэмээгч япон бүсгүй, 19 настайдаа 57-той Индонезийн ерөнхийлөгчийн гэргий болсон. Сукарног Японд төрийн айлчлал хийж явах үед учирсан ажээ. Орч.) ч юм уу, аль эсвэл Тайландын дур булаам хатан хааны тухай дэлхийн зурагт сонин сэтгүүлүүдээс бидний уншдаг тийм утгаар аль нэг хатан хааны талаар хэзээ ч ярихгүй байсан ч биз.

Гэсэн хэдий ч Византийн элч Прискүс зэрлэгүүдийн хааны ордонд ийн биеэ барьсан байдалтай явсанд харамсахгүй байхын аргагүй. Мэдээж Крека хатны талаар, тэрээр ямархуу төрхтэй хүн байв гэхчлэн арай ихийг олж мэдвэл зүгээрсэн. Тухайлбал хатан хаан элч хоёр ямар хэлээр харилцаж байв, хатан хааны ойрын хүрээлэл ямар байв? Хувцасны хатгамал гоёл оёж байсан эмэгтэйчүүд ерийн боолууд байв уу, аль эсвэл улсын тэргүүн хатагтайн дэргэд сууж өргөн дэлхийн явдлаас бага ч болов таньж мэдэх ёстой байсан хүннү язгууртнуудын охид байв уу? Хаан эзний орд өргөөнд нүүдэлчдийн хэдэн мянган жилийн өмнөөс хадгалсаар ирсэн оёж хатгах хуучны урлагийг үргэлжлүүлж үйл мэтгэж байхад нөгөө талд нь Аттила, Прискүс болоод тэнд байсан Өрнөд Ромын дипломатууд үхэл амьдрал хийгээд энэ дэлхийн нэгээхэн хэсгийн энх тайван, эсвэл дайн тулаан, гамшиг зовлонгийн асуудлыг хэлэлцэж суусан байх гэсэн бидний хоёрдахь таавар л үнэнд ойртож очих болов уу даа.

IV. □лн

ЛсйиЛ□□□□ Лн □□□Ли □□ □□□□□□□□

Өгөө *

Аттилагийн амьдралын эхний дөчин жилийн талаар бидэнд мэдэх юм бараг байхгүй. Тэрбээр үл мэдэгдэхийн түнэр харанхуйгаас гарч ирэхийн цагтаа хэдийнээ эр бие боловсорч ухаан санаа жигдэрсэн эхнэр хүүхэдтэй өрхийн тэргүүн болсон хүн байв. Түүний дээр ноёлогч бодгалийн чанарыг эзэмшсэн хүнийх нь хувьд гоотууд өөрийн хэлний „атта“ буюу эцэг гэдэг үгнээс салбарласан „Аттила“ нэрийг өгсөн юм болов уу?

Ямар нэг аварга том юмыг багасгаж хэлэх, айж сүрдмээр зүйлийг зөөлрүүлж гоёчлох нь утгагүй балай юм биш, харин тэрхүү эрт балрын элдэв зүйл мухар сүсгийн хүлээсэнд баглаастай байсан тэр цаг үед бол хэвийн зүйл байлаа. Өнөөдөр ч бид зарим нэг зүйлийг ярих хэлэх дургүй, заримдаа ерөөс бүр ярьдаггүй, оронд нь загалмайж наманчлах буюу мод тогшдогийн учир бол зөвхөн нэг нэр ч болов багадахгүй алив гай зовлон дуудаж болно гэж өөрийн эрхгүй боддогтой холбоотой. Аттила бол өдий төдий ард түмнүүдийн хувьд өөрсдөө дуудаагүй, өөрөө л нэг л өглөө сэрэхэд хүрээд ирчихсэн гай зовлон байсан юм. Энэ их гай зовлон арианчууд (4-6 дугаар зуунд *христ шашны нэг урсгалыг дагагсад, үндэслэгч нь Александриа хотоос гаралтай Арий гэгч санваартан байсан, христийн албан ёсны сүм хийдийн үндсэн эцэг бурхан, хүү бурхны нэгдмэл мөн чанарын тухай номлолыг хүлээж аваагүйгээс сүм хийдийн их хурлаар буруушаагдаж донгодуулжээ. Орч.*) болоод католикуудын хувьд бурхны гэсгээл, Аттила бол „бурхны ташуур“ (*flagellum dei*) байсан бөгөөд хүннү нарын дайран ирэх цагт гоотуудаас илүү айхавтар хэлмэгдэж зовсон ард түмэн үгүй. Тиймээс ч айж эмээх, биширч сүсэглэх, сайныг мөргөж гуйх сэтгэлийн угаас „эцэгхэн“ хэмээх нэрийг өгчээ.

Ийн эцэгхэн хийгээд ах дүүс арав илүү жил мөр зэрэгцэн засаглаж бталтай. Бледа бол Прискүсийн тэмдэглэснээр ордны алай салбадайн аашилж аяглахыг хэдэн цагаар ч хамаагүй хараад суучихдаг, бас өдий төдий уян налархай зарц шивэгчин нараар хүрээлүүлсэн, эхнэр нь эелдэг найртай, өөрөө гэм хоргүй хүн гэдгийг нь Аттила сайн мэдэж байсны учир нэг их яараагүй мэт байдаг.

Харин ч наана нь Бледагаас хамаагүй илүү аюултай эрх засаг булаалдагчид, төрөл садангууд байсан бөгөөд Аттила тэднийг аюултай хүмүүс гэж үздэгийг тэд нь бас мэддэг байв. Баталж нотолно гэхээсээ илүүтэй эгэл хар ухаанаар бодоход л Аттила засгийн эрхийг гартаа авч байх үедээ Хүннүгийн олон овог аймгуудын аль хэдийнээс үнэлж хүндэлдэг хүн болсон байсан нь тодорхой байдаг. Октар, Ругила нарын үед

жаахан эмх замбараагүй, эрх дураар ч гэсэн хоорондоо эв найртай явсан боловч Ругилаг үхсэний дараа зарим овог аймаг тун удалгүй шинэ эзний хатуу гарын амтыг мэдрэх болжээ. Тиймээс зарим нь Ромын эзэнт гүрний хил даван өмнө зүг зайлах нь хэцүү биш байжээ. Хүннү нарыг хөлсний цэрэг болгож авах дуртай байсан нь тэд германчуудаас илүү үнэнч, бас хатуу чанга, дайнаас өөр юм мэддэггүй байсантай нь холбоотой.

Аттила Бледа хоёр анхны ялалт байгуулж Маргуст (*Өнөөгийн Сербийн Белград хотоос зүүн урагш 90 км-т орших хот.Орч.*) 435 оны анхны эвийн гэрээг хийж, түүгээр Дорнод Ромын эзэнт гүрэн хүннүчүүдэд барих албаа хоёр дахин нэмэгдүүлэхээр зогсохгүй, оргодол босуулуудыг буцаан тушаах үүрэг хүлээсэн ажээ.

*Аттила (Attila, германаар Etzel) нь эртний гоот хэлний үг бөгөөд „атта“ гэдэг нь эцэг гэсэн үг агаад „Аттила“ гэвэл багасгасан утга гарч „эцэгхэн“ гэхээр үг болно. Гэвч ийн хүчлэн орчуулж болохгүйн учир ойлгомжтой болгохын тулд зарим овор ихтэй, насандаа ахадсан хашир залуу хүнийг “өвөө” хэмээн хочилдог заншлыг санаж ийн “өвөө” хэмээн орчуулав.

Бид оргодлуудыг буцаан тушаах энэ шаардлагын тухай хятадын он дарааллын бичигт дурдсан байдгийг санах бөгөөд уулаас энэ асуудал үүнээс ч илүү эртний гарвалтай. Мисир улсын фараон II Рамзес болон хэтитүүдийн (*I Моисейгоос 10-15 жилийн дараах хэтүүдийн удам, эртний энэтхэг-герман хэлтэй ард түмэн, хоёр мянган жилийн өмнө Бага Азийн дорно этгээдэд сууж байсан.Орч.*) хооронд байгуулсан энхийн гэрээнд ч ийм заалт байжээ. Оргодол босуулууд бол дүрвэгчид, гадаад улсын нутагт суух тул дайраад устгачих аргагүй, тэд эсэргүүцэл тэмцлийн голомтууд бий болгож байнгын аюул занал учруулж байдаг учир ийн эгүүлэн авах шаардлага тавьдаг байж.

Позаревац хотыг урьд нэрийдэж асан Маргус хэмээх сайхан нэртэй хотод байгуулсан эвийн гэрээнд хүннү нарын сөрөг хүчний тухай зааж оруулсны учир нь тэд алсдаа хаан ширээнд санаархсан үйл ажиллагаандаа Ромд барьцаанд сууж асан хоёр ч жононг татан оруулсан явдал бөгөөд тэдгээр барьцааны хүмүүс нь Аттилагийн өөрийнх нь гэр бүлээс гаралтай хоёр хөвгүүн байсан юм. Тэдгээр нь Мама, Атакам хэмээгч хоёр ноёны хөвгүүд учир византийнхан тэдний үнэ хүндийг бодон Добружа цайзад Аттила, Бледа нар тэднийг буцаан авах хүртэл олзонд байлгаж байсан ажээ. Гэвч хоёр жонон орон гэртээ эгэж ирсний дараа л үхлийн шороо нь пүрхийжээ. Хэдийвээр тэд хэнтэй, хаашаа явахаа өөрсдөө шийдээгүй ч Аттила, Бледа нар тэднийг ихээхэн аюултайд тооцож “*summum supplicium*” (*Эртний Ромд хэрэглэж байсан цаазлах арга.Орч.*) буюу хамгийн хатуу шийтгэл ногдуулж загалмайд тэлж алжээ.

Бид хэдий хүннүчүүдийн ардын сүсэг бишрэл, Аттилагийн шашны талаарх ойлголт төсөөллийн талаар нэг их юм мэдэхгүй ч дээрх хоёр жононг бусад урвагчдын адилаар хурц гадсан дээр суулгаж алах юм уу, эсвэл толгойг нь авах шийтгэл ногдуулаагүй нь анхаарал татаж буй. Уг нь цаазлагдагсдын талынхныг айлгаж сүрдүүлэхийн тулд толгойг нь олны хөлийн газар өндөр багананд өлгөж харуулдаг байв. Загалмайд тэлүүлж үхэх болоход хэн ч хөндлөнгөөс оролцдох ёсгүй. Тэгээд ч хааны удмын хүний бие цогцост ямар хүннү хүн гар хүрч зүрхлэх билээ? Гагц өндөр хөх огторгуй мэлтийж хоёр хөвгүүний тэргүүнийг өршөөлгүй шарах үдийн наран л тэнгэр гаралт жононгуудыг нөгөө ертөнцөд илгээх ёстой.

Энэхүү тэлж алах цааз хийгээд Аттила бурханы адил хүндлэл илэрхий хүлээсэн байдал зэргээс хүннү нарын хаадын удам эгэл хүнээс өөр, жир бус гарал үүсэлтэй гэх домог руу хөтөлж аваачина. Нэгэн хаан шувуу, ид шидийн бүргэд шувуу хүчирхэг хаадын овгийн өнө эртний өвөг дээдэс нь байх ёстой байсан агаад үнэхээр ч бүргэдээс дээр зөвхөн ертөнцийг гийгүүлэгч наран байх билээ...

Энэ болоод өөр бусад олон нарийн ширийн зүйл хүчирхэг хаадын өлгий нутаг хүннү нарын хааны овогтой шөргөөлцөх хүн зөвхөн гэр бүлийн дотроос, өөрсдийнх нь эгнээнээс л гарна гэж Аттила тооцоолж байсныг илтгэж байдаг. Хаан ширээг булаан авагч ямар ч этгээд домгийн тэрхүү гайхамшигт шувууны нэр барих эрхгүй, ямар ч хүннү хүн жир нэгний уриалж дуудсанаар хааны удмын хүний эсрэг тэмцэлд дагаж орохгүй нь тодорхой байв.

Энэ овгийн залуу эрчүүд анхнаасаа л жононгийн онцгой эрх дарх эдэлж байсан бөгөөд хэзээ нэг цагт бүх гүрэн улсыг биш гэхэд зарим нэг овог аймаг юм уу, нутаг орныг удирдана гэдгээ мэддэг байв. Энэ бол эрт урьдын зохисгүй ч гэлээ өнөө өөрсдөд нь ойр дөт непотизмын (*Ураг төрлийн харьцааг бүхнээс дээгүүр тавих явдлыг хэлнэ, латин хэлний nepos буюу ураг төрөл, nepotis ач зээ гэсэн үгнээс гаралтай, Ромын гэгээн хутагтууд эрх засгаа бэхжүүлэхийн тулд сүм хийдийн ашиг орлого сайтай албан тушаал болон хэргэм зэргийг төрөл төрөгсөддөө хуваан өгч байсан бөгөөд энэ явдал XV-XVI зуунд ихээхэн газар авч байжээ. Орч.*) зарчим бөгөөд энэ зарчмын дагуу Чингис хааны гэр бүлээс гаралтай Монголын хаад Днепр мөрөн, Солонгосын хооронд орших өргөн уудам нутгийг дамнан тогтсон их гүрнийг ах дүүс, үеэлүүд, төрөл төрөгсөд хуваан захирч байсан ба нөгөөтэйгүүр бас ч цөөнгүй хутагт хамба нар гэгээн ширээт (*Ромын католик шашны тэргүүн гэгээн хутагтын улс буюу өнөөгийн Ватиканыг хэлж буй. Орч.*) улсын Чингисийн алтан ургийнхны эзэрхэн захирсан эзэнт гүрний нутагтай харьцуулшгүй өчүүхэн газар нутгийг үр ач нартаа мөн л хуваан өгч байсан билээ.

Ийм өндөр дээд үүсэл гарвалын сөрөг тал нь хүннү нарынх шиг том гүрэн хэзээд хангалттай тооны цэрэгтэй байхаасаа илүүтэй хэтэрхий олон жононтой байсан явдал болой. Аттила арав, арван хоёр юм уу, арван дөрөвтэйдөө Ромд барьцаанд сууж байснаар жононгуудын амийг егүүтгэх ийм заншил үйлээс мэнд мултарсан байж ч болно. Түүнийг ийнхүү сонгож барьцаанд илгээсэн авга, их авга нар нь энэхүү зожиг, бас айхавтар ухаалаг залуу жонон Ромд үе үе дэгдэх мөргөлдөөнөөр алагдах буюу хорлогдох юуны магад гэж найдсан байж ч магад.

Гэвч Аттилагийн урьдын төрөл садан гэдгээ гайхмаар илэрхий харуулсан Моодунтай тохиолдсон явдал энд давтагджээ. Ромд барьцаанд сууж байсан үе нь (энэ талаар бид бүрэн итгэлтэй байж бас боломгүй) хожмын Аттилад шийдвэрлэх нөлөө үзүүлсэн мэт санагддаг. “Адил” юм уу, “Оттла” гэсэн нэртэй ч байсан байж мэдэх тэрбээр сүүлд эзэрхэн дагуулсан харь ард түмнүүд нь шүүрч аваад өөрийн хэлний адил төстэй үг болгож орхисон аль нэг түвэгтэй нэртэй байсан байж магадгүй. Бидний хувьд бол тэрээр Аттила гэдгээрээ л үлдэх учиртай, учир нь энэхүү “nom de guerre” (*Улс төр, цэргийн том удирдагчид үүсгэсэн хөдөлгөөн тэмцлийнхээ чиг зорилгыг өөрийн бодгальтай нягт холбож адилсгахын учир авдаг нууц нэрийг хэлнэ. Тухайлбал Ленин, Сталин, Троцкий, Хо Ши Мин, Тито, Ким Ил Сун, Эль Че гэх мэт олон удирдагчийн нууц буюу тэмцлийн нэрийг дурдаж болно. Орч.*) нь түүний эцэг эхээс хайрласан нэрийг нь түрж орыг нь эзэлж мартагнуулахад хүргэсэн, нөгөө талаар хүннү нарт угийн бичиг байдаггүй гэдгийг хэлэх хэрэгтэй.

Аттилагийн барьцаанд суухаар очсон Ром нь сүүлчийнхээ зууны эхний арван жилд ороод байв. Энэ хотыг Аларих (*Вестгоотуудын их хаадын нэгл Аларих 370 оны орчимд төрж 410 онд нас барсан, 410 онд Ромыг эзэлж байв. Орч.*) 410 онд байлдан эзэлсэн ач холбогдлоороо эрэн зууныг дамнасан үйл явдал болоход хэдхэн жил үлдээд байв. Аттила энэ үйл явдлын гэрч болсон байж таарна. Магад энэ үйл явдал жаал хүүд эзэрхэж ноёрхох, цэрэг дайчид, хот орон, цайз бэхлэлтийг дураар эзэгнэн захирах давагдашгүй шунал хүслийн галыг сэтгэл зүрхний гүнд нь асаасан болов уу.

Төгсгөл рүүгээ дөхөж буй эрэн зууны алдар суу хийгээд уналт доройтол нь урван тэрсэлснээс болсон гэгддэг Ромын эзлэгдсэн үйл явдлаас хол илүү Аттилагийн сэтгэлийг гойд хөдөлгөсөн нь магад бөгөөд тэр нь Ромын соёл цэцэглэсэн хэвээр байсан цаг үе билээ. Тэр үе бол эзэн хаан Константин Миланы хэмээн алдаршсан түүхт зарлиг гарган хуучны бурхдын аугаа эрэн цаг төгсгөл болсныг зарлан тунхагласнаас хойш хааны хотын хуучны олон сурвалжит айл өрх өөрийн хөрөнгөөр онго шүтээний сүм дуганаа ажиллуулсаар байсны нэгэн адилаар Ромын засаг захиргаа, хууль цааз,

инститүцүүд нь байсан хэвээр, ажилласан хэвээр, хуучны Ромын үзэл санааг дагаж хэрэгжүүлсээр байсан цаг байв.

Гэхдээ гаднаас нь харвал Ромын бүх байгууллагуудад өнө мөнхөд үхэшгүй оршсоор байх мэт санагдаж байсан эрхэм дээд үзэл санаанаас өөр юмгүй, хүч чадал нь барагдаж туйлджээ гэдэг нь зэрлэг бүдүүлэг омгийн идэр залуу Аттилагийн сийрэг ухаанаас мултарсангүй ажээ. Түүнд улс төрийн чухал чухал үйл явдлуудын учир жанцанг тайлбарлаж зааж зурж байсан нь эргэлзээгүй. Аттилагийн мэндэлсэн гэх 395 он бол богино хугацаагаар Өрнөд болон Дорнод Ромыг нэгэн гарын дор байлгаж эртний Ромын нэгдлийг хадгалж асан мөнөөх Теодосиус үхсэн он бололтой.

401 онд Ромын герман гарлын жанжин Стилихо вестгоотын хаан Аларихтай тулалдан ялж явсан хүн бөгөөд түүнд нь хүннүчүүдийн хөлсний цэрэг ихээхэн тус хүргэсэн байдаг. 408 онд хүннү нараас бүрдсэн бие хамгаалах цэрэг нь амь хайргүй тулалдаж хамгаалсан авч энэхүү Стилихо Ромын эзэн хаан Хонориуст алагдсан билээ.

Өдий төдий байшин сав, гудамж зам, хүн амьтан, тэрэг чаргаар дүүрсэн энэ их хот хийгээд хөл толгойгоо алдсан их хөлийн амьдрал энэ бүхэн Аттилагийн хувьд гайхалтай сонин ертөнц байлаа. Энэ бол Аттилагийн хүүхэд насандаа морио усалж явсан Дунай мөрний газар буй ахуйгаас тэс ондоо ертөнц, тэс өмнөө амьдрал байсан агаад түүний хувьд учиргүй мөрөөдөж санаашраад байх амьдрал биш байв. Магад хот орон газар байдаггүйсэн бол энэ дэлхий ертөнц улам сайхан, хүн ард ч улам аз жаргалтай байхсан...Захирч ноёрхох тавилантай төрсөн, түүгээр ч үл барам энэ хувь тавилангаа өөрөө сайтар ухамсарлаж буй хүний хувьд бол ромчууд үлгэр дууриал болж чадахгүй. Чингэхлээр Аларих л байна. Тэрбээр тухайн цаг үеийн их байлдан дагуулагч байв. Аларих бол Аттилагийн идэр залуу цагийн Ромыг айлган чичрүүлж байсан хүн бөлгөө. Түүний нэр алдар бүх хүний амны уншлага болж, түүнийг хожим нь гагцхүү Аттилагийн цэргийн Ромд учруулж байсан аюул занал л орлох болсон юм.

Аларих их цэргээ Ромыг бүслүүлэн хэрхэн чадмаг хуваарилан байрлуулж сая, хоёр зуун тавин мянган хүнийг гарах газаргүй болгон хотын арван хоёр их дааман хаалгыг нь хэрхэн бэхлэн хааж байгааг хүннү нарын энэхүү залуу жонон биеэр үзэж мэдэхдээ сэтгэл нь ихэд догдолсон байх учиртай. Ихэрхэг баян чинээлэг ромчууд хотыг нь бүслэн хаасанд бус харин захын нэг зэрлэг амьтан чингэж зүрхэлсэнд хэрхэн хилэгнэн зэвүүцэж хашгиралдаж байгааг чихээрээ сонссон байж таарна. Ийн Аларихийг яаж ч чадахгүйгээ ойлгож уур хилэнгээ гэм зэмгүй, гартаа зэвсэггүй жанжин Стилиход гаргаж түүнийг алсны дараа бэлэвсэн гэргийг нь ч өршөөсөнгүй.

Үүний дараа хамгийн баян цатгалан энэ хотыг өлсгөлөн нөмөрч баячууд жинхэнэ нүүр царайгаа илчлэн харуулж, ядуучууд өлбөрч үхэж эхэлжээ. Хүний хүүрийн наймаа цэцэглэж, урьд хан хурмастын шувууны мах идэж тогосын өндөг зооглож байсан хүмүүс хутгалж алсан боол хүүхний гуяны туранхай махыг ухаангүй зулгаах болжээ.

Гоотууд бүслэлтээ зогсоосонгүй, бурхдаас өршөөл ивээлээ ч илгээсэнгүй тул ялагчийн нигүүлсэнгүй сэтгэл л цор ганц найдлага нь болж, Аларихтай хэлэлцээ хийж эхлэв. Аттила цаагуураа гоотуудын талд байсан нь магад, учир нь тэр гоотууд хийгээд хүннү нарын түр зуурын дайчин нөхөрлөлийг ч мэдэх агаад нөгөөтэйгүүр тэрээр өөрийнхөө ирээдүйн дайсан Ромыг дэндүү сайн таньж мэдсэн хэрэг билээ.

Аларих Ромын элчийг хүлээж авч уулзсан ч ялалтынхаа үр шимийг дэмий яриагаар тавиад туучихыг бодсонгүй нь илт байв. Тэрбээр их ч үгүй, бага ч үгүй, Ромын хэрмийн дотор буй, улсын, хувь хүний, аль эсвэл сүм хийдийн, ер хэнийх байх нь хамаагүй бүхий л алт, мөнгө, хөдөлгөж болох бүхий л үнэт зүйлс, түүнчлэн харь зэрлэг гарлын бүх боолыг өг гэж шаарджээ.

Ромын сенатын сүр сүлд нь зайлсан элч нарын ромчуудад өөрсдөд нь юу үлдэх болж байна хэмээсэн асуултад Аларих „амь нас“ гэж хүйтнээр хариулахад элчүүд өөрсдийнх нь амь амьдрал дээсэн дөрөөн дээр байгааг сайтар ухаарчээ. Хүннүгийн залуу жононд бага залуу насны мөрөөдөл гэж байсан бол тэр нь мөнөөхөн Аларих шиг нэг л өдөр Ромын өмнө ирээд гоотуудын хаан шиг л ромчуудтай харьцаж байхсан гэсэн бодол билээ. Тэгээд эцэст нь нөгөөх алтыг нь ромчуудын цуглуулахыг хүлээхийн оронд таван мянган фунт (*нэг фунт нь хагас килограммтай тэнцэнэ. Орч.*) алт, гучин мянган фунт мөнгө, дөрвөн мянган ширхэг торгон хувцас, мянган ширхэг тансаг улаан торгон алчуур тэргүүтнийг даруй гаргаж өг хэмээн шаардаж буй Аларихийн нэгэн адилаар Аттила ч ийн аяглаж байхсан...

Гэвч Равенна (*401 онд эзэн хаан Хонориус орд өргөөгөө Равеннад шилжүүлснээр 5-6 дугаар зуунд Ромын түүхэнд чухал үүрэг гүйцэтгэх болсон. Адриатын тэнгисийн эрэгт байрлана. Аттилагийн үед усан боомт хот байв. Өнөө Равенна нь Итали улсын нэг муж бөгөөд нийслэл нь Равенна хот болно. Орч.*)-гийн балчиг намгийн цаана их л итгэлтэй сууж асан эзэн хаан Аларихийг мэхэлж, амнаасаа буцсаны улмаас их тулалдаан болж 410 оны наймдугаар сард гоот, хүннүчүүдээс бүрдсэн гол цохилтын хүч Ромыг байлдан дагуулсан бөгөөд чухамхүү энэ л өдөр Аттилагийн барьцаанд байх сүүлчийн өдөр хийгээд хаан хүний ёсоор амьдрах эхний өдөр байсан нь магад.

Ийн жонон, цэргийн жанжин, гоотуудын анд нөхөр энэхүү хүннү хүний өмнө зөрчлөөр дүүрэн хоёрдмол дэлхий ертөнц үүд хаалгаа цэлийтэл нээжээ. Учир нь гоотууд Ромын гэгээн хутагтаас хараат байгаагүй хэдий ч анхны гэгээн хутагт Петрусийг дээдлэн сүсэглэдэг байсны учир христийн нэн эртний нийгэмлэгийн ариун сангийн бойпор, сав суулгыг нуусан газраас нь авч Ром хотын дундуур алт мөнгөөр урласан ч гэлээ найдвартай хадгалж болох Ватикан руу залж явахдаа зэр зэвсгээсээ ч ангид хол авч явжээ.

Нөгөө талаар өмнө нь гуч, дөчин мянган боолчууд ямар ч эрх мэдэл, хүч чадалгүй болсон ноёд, ноёгтой нарынхаа өөдөөс хүрхрэн боссон байсан бөгөөд эздийнхээ гэрийн өнцөг булан бүрийг арван хуруу шигээ мэдэхийн учир тэдний уур хилэн, өшөө хорслын дэргэд гоотууд хийгээд хүннү нар бараг л гэм зэмгүй зочид байлаа. Гоотуудын христ мөргөл эмэгтэйчүүд, охидыг хамгаалж чадсангүй, боолчууд гэрийн эздийн ихэрхэг бардам эхнэр, охидоор өшөө хорслоо тайлсны дараа байлдан дагуулагчид орж очжээ. Гоотуудын нутгийнханд ээлтэй хандаж байсны гайхалтай жишээ болох бараг л онигоо маягийн, цус асгаруулсан байлдаан тулааны дунд хааяа тохиолдож асан явдлын тухай олон домгийн нэг ийн өгүүлдэг. Идэр залуу сайхан бүсгүй гоотын цэргийн нэгэн ахмадыг улайран эсэргүүцэж түүний хацрыг маажиж шархлуулан уур хилэнг бадрааж улмаар тэмцэлдсээр байсан ч мөнөөх ахмад сэлмээ сугалж хүүхнийг хамгаалсаар ойрын сүмд аваачиж санваартанд нь хүргээд олзноосоо зургаан мөнгөн зоос өгч эр нөхрийг нь орон гэртээ эгэж ирэхээр хүүхнийг тушаагаарай хэмээн захисан гэдэг.

„Эр зориг, уужим сэтгэлийн ийм жишээ тийм ч элбэг тохиолдож байгаагүй ээ” хэмээн Ромын их мөхлийн ижилгүй түүхч Эдуард Гиббон өгүүлээд “Цэрэг дайчид адгуус мэт аяглаж олзны эмэгтэйчүүдийн хүсэл сонирхлыг үл хайхран мунаг тачаалаа хангаад эцэст нь тэдгээр эмзэг зөөлөн бүсгүйчүүд ариун нандин бие цогцсоо бузарлуулахаас хамгаалж үнэхээр эсэргүүцэж тэмцэв үү, хүчирхийлүүлсэн тэд үнэхээр онгон байв уу, үгүй юү гэх мэтээр энэ ярвигтай асуудлыг их л ноцтой хэлэлцэж байсан гэдэг. Үүнээс ч илүү чухаг, бүх нийтийг хамарсан хор хохирол асар их байсан нь тодорхой. Зэрлэг овог аймгийнхан цаг үргэлж янаг амрагийн ажлыг хүчирхийлэн үйлдэж байсан эсэх, Ромын эмэгтэйчүүдийн дийлэнх буюу нас шүдээр ахимаг, царай зүсээр ядмаг, ариун онгон биеэр гайхуулах юмгүй хүүхнүүд бузарлагдахаас аврагдаж байсан эсэх талаар тааварлах аргагүй. Гэхдээ бүх нийтээрээ эд хөрөнгөнд шунан тэмүүлж, ханаж цадахыг мэдэхгүй байв...Тиймээс ч Ромыг түйвээж сүйтгэх үед эн тэргүүнд алт эрдэнэс, үнэт чулуу руу хошуурч байсан нь ойлгомжтой” хэмээжээ.

Эдгээр нэг их зөвэргүү бус мөрүүдийн дээр Гиббон нэмж германчууд хийгээд испаничууд V Карлын удирдлагаар ариун хотыг (Ром) эзэлж аваад (1527 он) гоотууд,

хүннүүдээс ч долоон дор аашилж зэрлэгээр түйвээж сүйтгэсэн бөгөөд тэдний Ромд есөн сарын турш суух хугацаанд „цаг мөч бүр ямар нэг харгис бурангуй явдал, садар самууны үйл, хомхой шунал тэчъядлаар дүүрэн“ байсан юм хэмээн өгүүлжээ.

Хэрвээ л жонон Аттила, тухайн цаг үед тэрбээр өөр нэртэй ч байсан байж болох, оргилуун хүсэл сэтгэл, гэнэн хонгор аалиндаа хүлээстэй явж байсан бол тэр нь тэрхүү 410 оны 8 сарын сарын сүүлийн өдөр хоногуудад аажмаар алдарч, хүмүүс бол мал адгуус шиг аашилж аяглаж ч чадах амьтас агаад харин тэднийг эзэрхэн захирагч хаан эзэн нь л хүн хэвээрээ байж чадах цор ганц бодгаль юм байна хэмээх үзэл бодолд байраа тавьж өгсөн болов уу. Эндээс өвөг дээдсээс өвлөн авсан хувь тавилангаа овог аймаг, үндэстэн, ард түмэн, бүхэл бүтэн гүрэн улсуудаас дээгүүр тавьсан тэдгээр хаад эзэд бол үнэн хэрэгтээ өөр бусад хүн амьтнаас огт өөр, эгэл хүний жирийн ахуй амьдралаас хол ангид хүмүүс юм байна хэмээсэн нэгэн шинэ дүгнэлтэд хүрсэн биз ээ. Түүний энэ шинэ ойлголт, шинэ мэдлэгийг Ромын эзэнт гүрний мянга нэг зуун жилийн ноёрхлын дараа, хүннүүдийн хараахан байлдан эзэлж чадаагүй Ром хотыг их цэргийн эгнээндээ цөөнгүй хүннү нарыг жагсааж удирдсан хаан Аларих эзэрхэн дагуулж зургаан өдрийн турш түйвээн сүйтгэснээс сэтгэлд үлдсэн дурсамж тойрон эргэлдэж байлаа.

Аттила өөрөө тэр үед Ром хотод байсан эсэх хийгээд эсвэл хотоос гадагш явчихсан байсан ч ялгаагүй, тэрхүү зууны энэ том үйл явдлын тухай түүнд нагац буюу авга ах, багш, ер өөр хэн ч ярьж өгсөн байж хамаагүй, энэ нь залуу жононгийн дэврүүн сэтгэлд даль жигүүр ургуулж, аливаа оргилуун сэтгэгдэл хүний сэтгэлийн гүнд амархан тусч гүн гүнзгий ул мөрөө үлдээж асан тухайн тэр цаг үед магадгүй Аттилагийн амьдралын зорилгыг нь тодруулж, зам мөрийг нь зааж өгсөн байж мэднэ. Учир нь Аттила тэрхүү 410 онд арван дөрөв, арван найман насны хооронд, дээд тал нь хорьтой байсан гэж бодоход хаан ширээнд хүрэхээс нь наана түүнийг бүхэл бүтэн хорин дөрвөн жилийн тоо тоймгүй олон удаагийн байлдан тулалдаан хүлээж байлаа.

2.

□□□□□□ □□□□

Паули-Виссова (*Анх Германы эрдэмтэн Аугуст Фрийдрих Паули 1837 онд сонгомол эртний судлалын шинжлэх ухааны өргөн дэлгэр нэвтэрхий толь бичиг зохиох ажлыг санаачилжээ. Анхны толь бичгийг үсгийн дэс дарааллаар боловсруулж 6 ботиор гаргажээ. Яваандаа олон эрдэмтнийг хамарсан хамтын бүтээл болж 1864-1978 онд тогтмол хэвлэгдэж байв. Өнөө Pauly-Wissowa-Kroll-ийн толь ч гэж нэрлэнэ.Орч.*)-гийн сонгомол эртний судлалын нэрд гарсан нэвтэрхий толь бичиг „Мөхөж буй Өрнөд Ромын эзэнт гүрний сүүлчийн өмөг түшиг, баатар эр“ хэмээн элдэв

лавлахуудад тэр бүр тааралддаггүй уярангуй өнгө аястай нэрийдсэн Флавиус Аетиус тэр үед Аттилатай нас ойролцоо, магадгүй жаахан ах ч байсан байх. Тэрбээр наран жаргах ертөнцийн цог золбоо дүүрэн хожмын энэ цаг үеийн бүхий л билиг тэмдгийг тээж явсан хүн бөлгөө. Тэрбээр Ромын уугуул иргэн биш, Ромын эзэнт гүрний нэг муж болох Иллирт, өнөөгийн Булгаарын умард хилд Дунай мөрний дээрх Силистриа (*Дунай мөрний баруун эрэг дэх Булгаарын бэхлэлт бөгөөд Durostorum хэмээх нэртэй эртний Ромын хот энд байв. Өнөө Булгаарын аялал жуулчлалын чухал төв болой. Орч.*) хотод төрсөн хүн билээ. Тэрээр язгууртан юм уу сенатчийн гэр бүлээс гаралтай бус, Силистриа хотын жирийн иргэн ч гэлээ Италийн уугуул нутгаас гаралтай баян чинээлэг сурвалжит эмэгтэйтэй гэрлэсэн Гаудентиус хэмээгчийн хөвгүүн болж төржээ.

Гаудентиус хожим нь цэргийн дарга, түшмэлийн өндөр албан тушаалд хүргэсэн амьдралын замналаа Ромын мужуудад бие хамгаалах цэргийн ахлагчийн алба хааж эхэлсэн агаад 399 онд Африкт буруу номтнуудын сүм дуганыг сүйтгэх аян дайны үеэр гавьяа байгуулж дэвшсэн аж. Тэрээр 420 оны орчим, яг хэдийд нь тодорхой бус, Галлид цэргийн эргэлт гарах үеэр амь үрэгджээ.

Ийнхүү Гаудентиус алдар суугаар дүүрсэн бус ч гэлээ нэр хүндтэй амьдрал туулжээ. Сүүлд алдар хүндэд хүрсэн хүү нь байсан байгаагүй Гаудентиусын нэр он дарааллын түүх, сурвалж бичигт орж үлдэх л байсан байх. Гэсэн ч хөдөө хязгаар нутгийн залуу хөвгүүн Аетиус их нэр хүнд олж, эзэнт гүрний өндөр хариуцлагатай албан тушаалд хурдан дэвшсэн нь гайхал төрүүлэхийн учир нь Гаудентиус шиг олон эцгийн хэдэн зуун нягт нямбай хөвгүүд хөдөөгийн мужуудад яг адил нөхцөлд өсч торнин өөдөлж дэвшиж байсан хэрэг билээ. Тухайн үед Ром хот өөрөө ч урьд өмнийн, олон зууны туршид мандаж бадарч явсан үеэ нэгэнт өнгөрөөгөөд байв.

Дунай мөрний хязгаар газрын залуу хөвгүүний зэр зэвсэг эзэмших уран чадвар, агт моринд гойд эртэй сайн нь эрхтэн дархтнуудын нүдэнд эн тэргүүнд тусч байжээ. Хүний ийм ур чадварыг магтан сайшааж зарлаж сурталчилж байсны учир нь ромчууд зэрлэг овог аймгуудаас элдвийг сурч авсныг илтгэнэ. Гоотууд, хүннү нарын удирдагчид өөрийн захиргаанд байгаа хүмүүсээсээ моринд илүү эртэй сайн, харваж намнахдаа илүү мэргэн байх үүрэгтэй мэт байсан агаад тэд байнгын байлдаан тулалдааны үед бусдаас үнэхээр толгой илүү гэдгээ харуулах ёстой байсан бөгөөд үүний учир жононгуудаас үхэж үрэгдэх нь цөөнгүй байв.

Аетиус энэ завсар Ромын эзэнт гүрэнд мартагдах тийшээ хандаж байсан шаардлага буюу зэрлэгүүдийн тэрхүү заншилтай түвэггүй хөл нийлүүлж чаджээ. Тэр бол хязгаар газрын, эзэнт гүрний нутгийн манлай бэхлэлт газар төрж өссөн хүн байсан тул Тибр мөрний дээрх нийслэл хотын ямбалаг амгалан тайван амьдралыг ерөөс үзэж

мэдрээгүй нэгэн билээ. Гэвч эцгийн нэр хүнд, эхийн удам угсаа нь түүнд дайлж тулалдах урлагийн зэрэгцээ сайн гэр бүлээс гаралтай ром хүний эзэмшдэг боловсрол олж авахад дөхөм болсон байна. Харин нэг талаас Стилихо, нөгөө талаас Аттила буюу тухайн эрэн үеийн өөр хоёр чухал бодгальтай харьцуулбал гайхалтай зүйлс гарч ирнэ.

Стилихо бол Ромын цэрэгт алба хааж байсан вандал (*Вандалууд бол дорнод герман овгийн ард түмэн бөгөөд Висла, Одер мөрний завсар сууж байсан, христийн тооллын 406 оны хавьд франкуудтай тулалдаж явсаар Испанид тэмцэн хүрч, тэндээсээ Гайзерих хааныхаа удирдлагаар 429 онд Африкт хүрээд 439 онд Карфагенийг эзлэн авч эзэнт гүрнийхээ нийслэл болгож байв. Тэдний олз омог эрсэн аян дайны оргил нь 455 онд Ромыг эзлэн авч цөлбөсөн явдал бөгөөд тэдний энэ зэрлэг үйлээс нь „вандализм“ буюу эвдлэн сүйтгэх шунал тэчъядал хэмээх утгатай үг үүссэн. Гайзерих хаан 477 онд таалал төгссөнөөр вандалуудын эзэнт гүрэн мөхсөн. Орч.) хүний хөвгүүн, герман хүн байсан ч ромын боловсрол олсон гарамгай жанжин, нягт нямбай, бүтээлч санаачилгатай хүн байсан агаад тэрээр I Теодосиус (*Остгоотуудын хаан, 455 онд Паннон буюу өнөөгийн Мажаарын нутагт төрсөн, 471-526 онд амьдарч байсан, бага залуудаа Византид барьцаанд сууж байсан, 488 онд Дорнод Ромын эзэнт гүрний хаан Зеногийн даалгавраар Италид очиж Одоакерийн ноёрхлыг унагаж Италийг дангаар захирч байсан хүн. Орч.*) хаанд чин үнэнч зүтгэснийхээ хүчээр өөдөлж дэвшсэн хүн бөлгөө. Тиймээс ч эзэн хаан Стилиход зээ охиноо эхнэр болгон өгч, түүнийг хөвгүүн Хонориусынхаа асрамжлагч багш болгосон нь герман хүнийг бараг Ромын эзэнт гүрний толгойд тавьсан хэрэг байлаа. Энэхүү Стилихо бол Аларихыг удаа дараа ялж явсан ганц хүн агаад тэрээр нийт герман овогтны эсрэг ихээхэн харгис хэрцгий дайн байлдаан явуулж ялж байсан бөгөөд гагцхүү түүний үхэл л Аларих хаанд Ромыг эзлэх замыг нь чөлөөлж өгсөн хэрэг билээ.*

Ром ийнхүү харь улс, ард түмнээс төрж гарсан болон бас ромын хөдөө нутаг, мужуудаас тодорсон ч хуучин Ромын боловсролыг таашаан эзэмшиж, их цэргийг сургаж боловсруулах чадвар олсон эрчүүдийг албандаа зүтгүүлэх талаар сайн туршлага хуримтлуулсан байв. Ийн эзэнт гүрэн хүнд байдалд орохын цагт, улмаар бүр уруудаж доройтохын үед дээрх хүмүүсээс хамгийн чадварлаг нэгэнд нь түргэн ахиж дэвших боломж олддог байжээ.

Энэ бүлгийн гол баатар, Аттилагийн эсрэг этгээд болох Аетиус амьдралынхаа замналыг Стилихогийн нэгэн адилаар офицерын зиндаанд хааны нарийн бичгийн даргаас эхэлсэн хүн бөгөөд *comes domesticorum et cura palatii* (*Хааны ордны захирагч бөгөөд торгон цэргийн дарга. Орч.*) хэмээх зэрэгт хүрсэн ажээ. Стилихо ч мөн ийм хэргэмтэй байв. Аетиус эхнээсээ л улс төрийн том бодлогын тээрэмд шууд орж явчихсан хүн юм. 407 онд Аларихт ромын барьцааны хүмүүсийг явуулах болоход

Стилихо өөрөө Аетиус болон хол явахаар хэд хэдэн залуу офицерыг шилж авсан байна.

Барьцааны хүн хэмээх ойлголтод тайлбар хэрэгтэй, учир нь өнөөдөр сонин хэвлэлд өдөр тутам энэ үг гарч буй бөгөөд өнөөгийн барьцааны хүний үүргийг эрт урьдын эзэнт гүрнүүдийн хооронд гүйцэтгэж байсан үүрэгтэй бүхэлдээ харьцуулах аргагүй.

Барьцааны хүмүүсийг холбоотнууд ч, эсрэг этгээдүүд ч ялгаагүй бие биедээ явуулдаг байсан бөгөөд зөвхөн нэг л тал нь чингэх бус, харин солилцдог журамтай байжээ. Холбоотон буюу болзошгүй эсрэг этгээдийн хааны ордонд өсч бойжсон язгуур сайт залуу хүмүүс хоёр гүрнийг хооронд нь холбох, эв найрыг тогтоох, эвсэл холбоог хадгалж сахиж байх ёстой байв. Тэр үед барьцааны хүмүүс нь өнөөдрийн банк дээрэмдэх буюу нисэх онгоц булаах үеэр барьцаанд орж золиос болдог ядарсан хүмүүс шиг дур зоргоороо авирлагчдын золиос болох бус, харин очсон газраа яг л хунтайж, жонон юм уу ордны хүний амьдралаар амьдардаг байжээ. Тэд шаардлагатай үед холбоо баригч, хэлэлцээ хийгч, элч төлөөлөгчийн үүрэг гүйцэтгэж, энхийн элч, хоёр талын хүсэн хүлээсэн харилцан ойлголцолд зуучилж чадах хэмжээнд нөгөө орны хэл, соёл, ёс заншлыг эзэмших ёстой байв.

Хуучин ертөнцийн энэхүү барьцааны хүмүүс солилцох ёсон байгаагүйсэн бол талууд яриа хэлэлцээ явуулахдаа худалдаачдад л голчлон түшиглэх, хэлмэрчдийг ажиллуулах ёстой байсан юм. Хэлмэрчээр ажиллана гэдэг нь тухайн цаг үед ер нь л найдвар муутай (тийм ч учраас хуучин цагт зарим хэлмэрчдийн амь нас золгүй үхлээр төгсдөг байж) хэрэг байлаа. Барьцааны хүн бол энэхүү ойлголтын дээд утгаар янз бүрийн улс түмний хамтын ирээдүйн манлай элч байсан юм. Гэхдээ ийм ирээдүй мэдээж ирэхгүй ч байж бас болох байв.

Аетиусын хувьд таатай юм болсонгүйн учир нь өөрийг нь барьцааны хүнээр сонгож Аларих руу явуулсан жанжин Стилихо алагдсан явдал болой. Дорнод Ромыг өөртөө дагуулах аян дайнд Өрнөд Ромын эзэнт гүрэн гоотуудтай их эвсэл байгуулах гээд бүтсэнгүй, их Стилихогийн доожоогүй шавь Хонориус амласнаасаа хялбархаан буцаж, байдаг л нэг зүйл мэт гэрээгээ зөрчсөн нь Аетиус гоотуудын хааны дэргэд өнөөдрийн утгаар барьцаанд байсансан бол аль хэдийнээ хороогдох шалтаг болох байсан хэрэг. Аетиус 407-410 онд Аларихын хүрээлэлд барьцаанд гурван жил сууж, хэдийгээр гоотууд Хонориусыг дайлж, Италийг цөлбөн хоосолж, Ромыг түйвээн сүйтгэж байсан үе ч гэлээ Аетиусын толгойноос ширхэг ч үс үнасангүй. Нөгөөтэйгүүр тэр өөрөө ч бусдын анхааралд өртөх гэж нэг их чармайсангүй. Тэгээд дараагийн арван жилд нь Аетиус мөн л барьцаанд байсан нь илэрхий бөгөөд чингэхдээ гоотуудын дэргэд суухаа нэгэнт болиод хүннү нарын газар сууж байжээ. Тэхдээ зөвхөн хэрэг явдал ийм байжээ

хэмээн таамаглаж л болно. Хүннү нар нэг их бус ч янз бүрийн анги хэсгээрээ хөлсний цэрэг болж ромын талд байлдаж, Ромын мужуудад гарсан бослого дарах болон бусад зэрлэг бүдүүлэг овог аймгуудтай дайтахад оролцож явжээ. Магад Аетиус энэхүү туслах цэргийн хөлс мөнгийг ромын талаас баттай төлөх барьцаа нь болж байсан ч юм уу, эсвэл тэрхүү хөлсний хүннүчүүдийг Хүннү гүрний гол хүчний эсрэг байлдаанд оруулахгүй байх, аль эсвэл тэднийг ромын легионуудаар хүйс тэмтрүүлэхгүй байхын баталгаа болж байсан ч байж мэднэ.

Аларихын дэргэд анхны удаа барьцааны хүн болж очихдоо Аетиус идэрхэн, өнөөгийн утгаар офицер гэхээсээ илүү балчир хөвгүүн байсан бололтой. Харин хүннү нарын газар очихдоо тэрбээр нас биед хүрсэн байсан бөгөөд тиймийн учир тэнд өнгөрүүлсэн он жилүүд нь түүний амьдралын шийдвэрлэх үе байгаад зогсохгүй дараагийн хугас зуун жилийн Европын бодлогын хөгжил хөдөлгөөн, өрнөлт, эргэлтэд шийдвэрлэх ач холбогдолтой байжээ.

423 онд Стилихог хороосон Ромын хамгийн сул дорой хаадын нэг, эзэн хаан Хонориус наснаас нөгчив. Тэрбээр үндсэндээ насан туршдаа төлөвшиж боловсролгүй өнгөрсөн хүн билээ. Бусдын анхаарал татахаар, арай нэг бие даасан гэмээр үйл нь гэвэл охин дүү Галла Плачидиатайгаа хайр сэтгэлийн холбоотой байсан явдал болно.

Аетиусыг гуч шүргээд байх үед Хонориусийг залгамжлан гарч ирсэн Иоханнес хэмээх ром бус нэртэй эзэн хаан түүнийг ордны түшмэлийн албанд томилж бие хамгаалах торгон цэргийн дарга болгожээ. Ийн хурдан дэвшсний учир шалтгаан нь Аетиус хүннүчүүдтэй харилцаа холбоо сайтай, тэдний хэлийг мэддэг явдал байсан мэт агаад учир нь Дорнод Ромынхон Иоханнесын дөнгөж суугаад байсан хаан ширээнд санаархана гэдгийг тэр тооцож, бас Өрнөд Ром нь хүннү нартай холбоотны харилцаа тогтоосон нөхцөлд ямархан их хүчтэй байхыг тэрбээр сайтар мэдэж байв.

Ийнхүү Аетиус ихээхэн алт тээж Хүннүгийн газрыг зорьж очоод ажил явдлаа сайн бүтээжээ. Хүннүчүүд тэртэй тэргүй энд тэндгүй л байлдаж яваа хойно урьдын танил, өөрсдийнх нь хэлийг сайн мэдэх Аетиусын талд ахиухан шан харамжны төлөө байлдаж болохгүй нь юу байхав?

Гэвч шилдэг дипломатууд ч, хэрмэл худалдаачид ч ялгаагүй замд хамаг цагаа бардаг байсан тухайн цаг үед өнөө үе үе бидний үзэж буй лугаа адил тийм эв найрыг тогтоох гайхам үйлсийг бүтээх үнэхээр боломжгүй байв. Аетиус хүннү нарыг дагуулсаар Равенна дахь хааны өргөөнд хүрэлцэн ирэх үед Дорнод Ром нэгэнт ялалт байгуулчихсан, Дорнод Ромын жанжин Аспар Аетиусыг ирэхээс гурван хоногийн өмнө залуу хааны толгойг авч хөсөр хаяад байжээ.

Ийн Равеннад зэр зэвсэг хангинаж, цэрэг дайны уриа нижигнэж, Аетиус алагдсан хааны өшөөг авахыг завдсан ч эцсийн дүнд саруул ухаан ялж хоёр жанжин эвийн гэрээ байгуулав. Магад ч үгүй хал үзэж, дол цохисон Аспар жанжин хэдий ч баатарлаад үхсэн Иоханнесийн толгой их биеэсээ дахин ургахгүй гэдгийг Аетиуст ухааруулж чадаа биз.

Плачидус Валентинианус хэмээгч балчир хүүг эзэн хаанд өргөмжилсөн ч хааны засгийг түүний эх Галла Плачидиа эрхлэн явуулах болсон агаад хүннүчүүд олз омог олоогүйн учир шан харамж болгон Паннон (*өнөөгийн Мажаарын нутаг, Балканы хойгийн баруун хэсгийг хамарч байсан Ромын эзэнт гүрний муж. Орч.*) дахь Савиа мужийг авчээ. Аетиус ордны түшмэл, торгон цэргийн даргаараа үлдсэн ч энэ нь эн тэргүүнд ахиж дэвших чухал алба байлаа.

Хүннүчүүдтэй холбоогоо бэхжүүлж, тэдний талархлыг цаашид ч хүлээхийн тулд Аетиус хөвгүүн Карпилиогоо барьцаа болгон хүннүгийн газар илгээжээ.

Энэхүү 425 онд гаргасан шийдвэр ямархан жинтэй байсныг хялбархан ойлгож болно. Саве, Дунай хоёр мөрний завсрын нутаг, Сирмиум (*Өнөөгийн Сербийн Митровица хот.Орч.*), Сингидүнүм (*Өнөөгийн Сербийн нийслэл Белград хот.Орч.*) хотууд бүхүй Савиа муж нь хүннү нар хийгээд Ромын эзэнт гүрний хоорондын цаашдын сөргөлдөөн тэмцэлд маш чухал үүрэг гүйцэтгэх болно. Учир нь хүннүчүүд энд томоохон усан замын бэлчирт сууж, Европын цөм нутаг хийгээд Европын зүүн өмнөд хэсгийн хоорондын чухал ач холбогдол бүхий зах зээлийг хянаж байв. Ийнхүү Аетиус хүннү нарын саяхныг хүртэл зөвхөн дээрмийн дайнаар өөрийн болгосон зүйлийг тэдэнд өмч болгон өгч хууль ёсны болгох замыг нь нээснээр Аттила хожмын эзэнт гүрнийхээ голомтыг гардан авчээ.

Энэ бол Баруун Ромын эзэнт гүрний оновчтой нүүдэл байсны учир бол Савиа муж нь Өрнөд Ромын гүрний хамгийн зүүн хойд захын муж байсанд оршино. Тэнд ноёрхогч этгээд нь Ром руу бус, Византи руу хараа сунгах учиртай байсан юм. Дунай мөрний дунд, доод биений нутгийг хүннү нарт хууль ёсоор тавьж өгснөөр тэдэнд газар нутгаа тэлэх зүг чигийг нь заасан хэрэг байсан бөгөөд тэд ч энэхүү битүү дохио сануулгыг хүлээж авсан билээ. Дараагийн жилүүдэд хүннүчүүд Өрнөд Ромын гүрэнтэй үндсэндээ холбоотны харилцаатай байж Равенна дахь хааны өргөөнийхний өмнөөс гал усанд ч орохоос буцахгүй байсан бол Дорнод Ромын гүрэн эхлээд Ругила, дараа нь Бледа, Аттила нарын, сүүлдээ зөвхөн Аттилагийн толгойлсон хүннүчүүдийн догшин ширүүн дайралтын бай болж байсан бөлгөө. Аттилагийн улс төрийн анхны томоохон үйл ажиллагаа нь Дорнод Ромын эзэнт гүрэнтэй Маргус хотноо байгуулах нүд хуурсан төдий эвийн гэрээ, сүүлчийнх нь арван ёсөн жилийн хойно Дорнод Ромын эзэн хаан

Маркианосын эсрэг Аттилагийн таалал төгссөн жил буюу 453 онд хийсэн аян дайн байв.

Гэвч үүгээр хэрэг явдал дуусахгүй, энэхүү товч халилт нь Савиа хэмээх хэсэгхэн нутгийн талаарх тайлбар тойм төдий зүйл агаад энэ нутаг орныг хүннү нар Өрнөд Ромын гүрний талархлын хариу, нэгэн зүйл „Данайн бэлэг“ (*Хомер гэрэгүүдийг данайчууд хэмээн нэрлэсэн байдаг. „Данайн бэлэг“ хэмээх тогтсон хэллэг нь Хомэр, Вергил нарын дүрсэлсэн, нийтээр мэдэх „Трояны морь“-ны тухай домогтой холбоотой. Орч.*) хэмээн үзэж хүлээж авсан билээ. Өрнөд Ромынхон анхаарлыг нь өөрөөсөө зайлуулж байгааг нь тааварлахгүй, Аларих руу үхлийн сахиулсан тэнгэр илгээж байсан хүчирхэг санваартны сууж ахуй Ром руу дайлаар хөдлөхийг хүсэх ч үгүй байсан нь магад хүннүчүүд Ромын жанжин Аетиустай эерэг тааламжтай харилцаа барьсан хэвээр байсны учир буй заа. Аетиустай мөр зэрэгцэн байлдаж, туслах жанжин Литориусын удирдлага дор эрэлхэг баатарлагаар тулалдаж явсан хүннү нарыг тухайн үеийнхэн зууны шилдэг арми хэмээн үнэлэхэд хүрсэн билээ. Проспер, Хидатиус, Сидониус болон бусад он дарааллын бичээч нар Хүннүгийн морин цэргийг Хүннүгийн овог аймгууд Аттилагийн удирдлага дор их эзэнт гүрэн болж нэгдэхээс бүр өмнө тухайн үеийн цэргийн хамгийн шилдэг нь хэмээн үнэлсэн байдаг юм. Хүннү нарын цэрэг дайны амжилт нь хүний олонтой холбоотой гэж тэднээс хэн нь ч хэлээгүй. Тэд бол хөлсний цэрэг болохоос жинхэнэ утгаар байнгын арми байгаагүй агаад ромчуудын удирдлагаар, тухайлбал германчуудтай тулалдаж явсан, тэд хаа сайгүй, хэрэгтэй газар болгонд Нарбон, Түлүз (*өнөөгийн Франц.Орч.*), Райн мөрөн (*өнөөгийн Швейцарь, Германыг дамнан урсч Хойд тэнгист цутгадаг томоохон мөрөн. Орч.*), Францын голт зүрх хийгээд тэртээ холын Бретонд (*Баруун Францын далайн булан тохой ихтэй хагас арал, Ромын эзэнт гүрний үед Галли Лүдэнсис мужид багтаж байсан, британчууд (бретончууд) тавдугаар зуунд христ мөргөлд оруулж, Бага Британи буюу Bretagne хэмээн нэрлэсэн. Орч.*) хүртэл байлдаж л явжээ. Ийнхүү түүхийн олон бичиг туурвилд хүннү нарын зөвхөн цэрэг дайны ололт амжилтыг л гэхэд дарж бууруулан үзэх бараг бүх оролдлого нуран унаж буй. Бретанд л гэхэд тэдний дассан тал нутаг байхгүй учир хүчээ бүрэн дүүрэн дайчилж зохион байгуулах боломж муутай, Райн мөрний газар ч мөн л ялгаагүй, дарга нар нь тэднийг тулалдаанд оруулах гэж хэзээ ч албадаж шавхуурдаж байсангүй, ухрах цагт нь алах ялаар далайлгаж ч явсангүй. Хүннүчүүд хөлсний цэргийн хувиар цалин хөлс авдаг байж, швейцарь, германчууд шинэ үеийн (*Дундад зууны төгсгөлийн дараах үе буюу 1500 оны үеэс Францын 1789 оны хувьсгал хүртэлх үеийг шинэ үе хэмээн нэрлэж ирсэн. Орч.*) түрүүчээр, хэссэнчүүд (1780-аад онд Умард Америкт дэгдсэн бослогыг дарах хэрэгт Германы Хэссэн-Касселийн хөлсний цэргүүд олноор явсан. Үүнээс болж Германы даяар хаад ноёдод хандсан “хүний худалдаа” хийлээ хэмээх зэвүүцэл ихэд газар авч Шиллэр ч зохиол бүтээлээрээ шүүмжилж байсан. Гэхдээ Хэссэн-Касселийн хувьд энэ нь эрт урьдын уламжлалт үйл

байсан юм. Орч.) Америкт, Францын гадаад легионы дайчид Энэтхэг-Хятадад тулалдаж явсны нэгэн адилаар бүх фронтод тулалдаж явсан жинхэнэ мэргэжлийн цэрэг байсан юм. Мөхөл рүүгээ явж байсан Ромын эзэнт гүрэнд хүннүчүүдтэй эн зэрэгцэх хүч дахин гарч ирээгүй бөлгөө. Тэднийг удирдаж захирсан хүн л их эзэнт гүрэнд төрийн хэрэгт оролцох тавилантай байсны учир Аетиус хүннү нарын эрэлхэг зориг, хүч чадалд дулдуйдаж олон ялалт байгуулсны үрээр 429 онд Ромын цэргийн жанжин болсон ажгуу.

Энэ бол Өрнөд Ромын гүрний цэргийн даргын дээд албан тушаал байжээ. Цэргийн дарга нартаа ч итгэхээ больсон, ер нь л арга заль нь дэндсэн Византид энэ албан тушаалыг *Magister peditum*, *Magister equitum* буюу явган цэргийн генерал, морин цэргийн генерал хэмээн хоёр хуваасан ажээ. Харин Равеннад гавьяа зүтгэлт генералуудын хувьд иймэрхүү арга мэх хэрэглэх хэрэггүй гэж үзсэн бөгөөд ийн Аетиус бүх эрхийг гартаа авчээ. Замд нь хөндөлдөж асан нэгэн консулыг (*Эртний Ромын бүгд найрамдах улсад байсан хоёр дээд албан тушаалын нэг, сонгуулиар гарч ирдэг байв. Орч.*) тэрээр зориуд хурдавчлан зохион байгуулсан бослогоор алуулж (430) өөрөө 432 онд консул болж огцом дэвшсэнээр аюултай хүн гэдгээ харуулсны учир хатан хаан Галла Плачидиа яаравчлан Африкт байлдаж явсан нэгэн генералыг дуудуулж оронд нь тавиад Аетиусыг албанаас халжээ.

Энэ явдлын талаар их Моммзен (*Эртний судлалаар алдаршсан Германы нэрт түүхч.Орч.*) „Рыцарийн роман уншиж буй мэт“ хэмээсэн нь үнэнд ойрхон очих агаад үнэхээр ч огцорсон цэргийн жанжин Африкаас тэмцэн ирсэн Бонифациус хэмээгч мөнөөх өрсөлдөгчтэйгээ Равенна хотын дэргэд тулалдаж, генералыг ирүүл тулаанд дуудаж хүндээр шархдуулсан зэрэг нь үнэхээр ч баатарлаг тууль лугаа адил сонсдох ажгуу. Бонифациус амь тавихын өмнө гэргий Пелагиадаа захихдаа, өөрөөс нь хойш дахиад эрд гарах ахул авааль эрийнх нь аминд хүрсэн тэрхүү Аетиустай л суугаарай хэмээн захисан аж. Харин Аетиус яаравчлан зайлан одоход Бонифациусын хүргэн нэгнийг шинэ жанжнаар томилжээ.

Хуучны Ром хэт дэврүүн санаа бодолтой болсон мэт бөгөөд сахилга бат гээч юм бараг үгүй болсон ч эр зориг, гөжүүд зоримог ааш эрчүүдийн сайн үйл гэж тооцогдож байв. Тиймээс ч Аетиус хэдий албанаас халагдсан ч хөлсний алуурчны гараас мултрах бараг аргагүй Равенна, Ромд тоогдохгүй байсан ч эдгээр он жилүүдэд Ругилад захирагдаж асан үнэнч анд хүннү нарын хувьд их хүн хэвээр байв. Чухамхүү энэ үед Аетиус, Аттила хоёр учирч ярилцсан бололтой байдаг. Ругила ч Аетиуст алдсан юмаа эгүүлж авахад нь туслахаар цэрэг гаргаж өгсөн ажээ. Аетиус хүннүчүүдийн тусламжид түшиглэж өөрийгөө патриций (*Ромын эзэнт гүрний удам дамжсан язгууртан. Орч.*)

болго хэмээн Галла Плачидиа хатныг шахаж шаардаж байгаад 437 онд консул болов. Унах үйл нь ирсэн мөнөөх Бонифациусын хүргэн Визант руу зугтан оджээ.

Эдгээр үйл явдлын гол баатруудаас хамгийн эмгэнэлт хувь заяа амссан нь Византид зугтан очоод дажгүй амьдрах болсон мөнөөх эр бус, харин гуравдахь удаагаа бас нэгэн дарангуйлагчийг тэвчиж амьдрахаас аргагүй болсон хатан эх Галла Плачидиа байсан агаад тэрээр урьд өмнө нэр нөлөөтэй генералуудыг ор хөнжлийн явдлаар өөртөө татаж байдлыг арга эвээр зохицуулдаг байсан бол өдгөө өтөлж хөгширсний харгайгаар чингэж чадахаа больжээ. Хатан арваад хүүхэд төрүүлсэн ч дайснууд тэднээс нь сорчилж алсаар сул дорой нэгнийг нь үлдээхээр тэднийгээ өсгөж хүн болгох гэж үйлээ үздэг байжээ. Домгийн хатан Ниоб (*Тебанийн хаан Ампионы хатан Ниоб эр нөхөртөө долоон хүү, долоон охин төрүүлж өгөөд ихэд сагаж Аполлон, Артемис хэмээх хоёрхон хүүтэй Титан бурхныг басамжлан доромжилсны учир Титаны хөвгүүд Ниобын бүх хүүхдийг харван алснаас болж Ампион хаан амиа хорлож, уй гашууд автаж хөшсөн Ниобыг бурхад чулуу болгон хувиргасан тухай эртний Гэрэгийн домог өгүүлдэг.Орч.*)-ын адилаар айж балмагдан уй гашууд автсанаас хөшиж гөлийсөн хатан эх муу санааны үүр уурхай болж хоёрдахь нөхрөөс төрүүлсэн хөвүүндээ хаан ширээг өвлүүлэхээр сэтгэл шулуудсан байв. Хөвгүүн ч хатан эхийн ах бөгөөд нууц амраг болох Хонориус (Галла Плачидиагийн эцэг I Теодосиусын түрүүчийн хатнаас төрсөн хоёр хүүгийн нэг, өөрөөр хэлбэл Плачидиагийн эцэг нэхтэй, эх өөртэй ах.Орч.)-аас нэг их дээргүй амьтан байв. Ахтайгаа нөхцсөн нүглийнхээ гэм бурууг басамжлал доромжлол дүүрэн амьдралаараа цайруулж явна даа хэмээн хатан хаан бодож явсан нь магад. Аетиус ийнхүү эрх засагт дахин хүрэхэд ромчууд бус харин хүннүчүүд түүний төлөө зүтгэжээ. Аетиус урьдын адил хүннүчүүдийн гараар өөрийн хэргийг дахин дахин бүтээж байсан хэрэг. Бүргүндчүүдийн мөхөлд Аттила, Бледа нар бус, харин 435 онд хүннүчүүдийг хатгаж бүргүндчүүдийн эсрэг турхирсан Аетиус л буруутай. Хүннүчүүд Ромын тугийн дор олон цувраа ялалт байгуулсны дараа Аетиус 446 онд гуравдахь удаагаа консул болсон нь “урьд хожид үзэгдэж дуулдаагүй шан” (Моммзен) байжээ.

Аетиус найз Ругилагаа мөнх амьдрах мэт сэтгэж, найдаж ч явсан нь магад агаад хатан хаан Евдокиагийн тэнгэр бурханд мөргөн гуйж байгаад Ругилаг аянганд ниргүүлсэн явдал нь хүннүчүүдээс илүүтэй Өрнөд Ромын эзэнт гүрэнд сөргөөр тусч баахан базаахгүй үр дагавар дагуулжээ. Тэрхүү үр дагаврын өр төлөөс ч нэхэгдэх учиртай байв. Учир нь Ругилаг залгамжлах ах дүү хоёроос лав л бага Аттила нь цаашдаа Ромын хөлсний цэргийг захирах ямар ч хүсэлгүй, Равеннагийн төлөө, Галла Плачидиагийн төлөө, Аетиусын төлөө байлдаж ялж дийлж явахаасаа илүүтэй өөрөө алдар хүндийн оргилд хүрэхийг хүсч эрмэлзэж байсан юм. Райн мөрөн дээр

бүргүндчүүдийг мөхөөсөн тулалдаан хүннүчүүдийн хувьд ч ихээхэн хүнд сорилт байсан нь эргэлзээгүй, тиймээс харь газрын эрх ашгийн төлөө явж үхэж мөхсөнөөс өөрийнхөө зорилгыг мөрдөж явах нь хамаагүй дээр гэдгийг ухаарч ойлгосон нь лавтай.

Үй олон хүннү нар өөрийнх нь өмнөөс дайтаж, алдар хүндийнх нь төлөө нумаа татаж сумаа тавихаа больж, зогсолтгүй ахиж дэвших зам нь мухардаж, алдар хүнд нь буурч эхэлсэн мөчөөс Аетиусын дүр төрх, ажил үйл хачирхалтай байдлаар эргэв. Зориг баатарлаг, хайр найргүй дайчин маань шинэ холбоотон олж авахын тулд далдуур хутган үймүүлж нууц явууллагын тор нэхэх болжээ. Ард түмнүүдийн гарамгай гэгдсэн Аетиус ийнхүү Ромын ашиг сонирхлын төлөө эрээ цээрээ алдсан увайгүй наймаачин болжээ гэдгээ дороо л харуулжээ. “Дөрвөн арваны турш хэрэг дээрээ Өрнөд Ромын эзэнт гүрнийг захирч явсан... Аетиус ойроос харвал...тийм ч сүрхий хүн биш гэдэг нь харагджээ” (Моммзен). Үүнээс хойш дэлхийн түүхийн их гэрэл гэгээ нөгөө нэг барьцааны хүн болох Аттила дээр тусах болов.

3.

□□□ □ү□□□ □□□□ □□□□ □ө□□ө□ □□?

Ромчууд зэрлэг ард түмнүүдээс нэг л зүйлээр хол давуу хэвээр байв. Тэд аливаа юмыг тэднээс хамаагүй хурдан ухаарч ойлгодог байсан юм. Ругила аянганд цохиулж үхээд ах дүү Бледа, Аттила хоёр хүннүчүүдийг толгойлох болсноор Европт нэгэн шинэ эзэн гарч ирлээ гэдгийг Дунай мөрнөөс урагш орших нутгийн хүн ард тэр даруй ойлгосон мэт байдаг.

Хэрэг явдал чухам яаж өрнөсөн тухайд хуучны зохиогчдоос нэг нь ч мэдээ занги үлдээгээгүй. Хүннүгийн эзэнт гүрэнд Бледа, Аттила хоёрын явуулж байсан ажил үйлсийн талаар хааяа ганц нэг мөр үзэгддэг. Гэсэн ч Ругилагийн оронд Дорнод Ромын эзэнт гүрэнтэй хэлэлцээ явуулах болсон хүн (Аттила) өргөн хүрээнд сэтгэж алс хэтийг харж байжээ гэдэг нь ямар ч байсан мэдэгддэг. Энд тэндээс хөрөнгө мөнгө татаж, дээрэм тонуул хийж, халдаж довтлох ажил хүннү нарын бодлогын гол цөм нь болж байсан цаг улирч өнгөрсөн байв. Бледа Хүннүгийн дорнод мужуудын нэгийг захирч байхдаа тэр болгон улс төрийн тавцанд гарч ирдэггүй байсан бол Аттила шинэ эрэн эхэлснийг эхэндээ Дорнод Ромын эзэнт гүрэнд, улмаар Равеннад ч ойлгогдохоор илэрхий зарлаж байв.

Ромын эзэнт гүрэн, Хүннү гүрний хооронд хэлэлцээ Ругилаг амьд сэрүүн байхад эхэлжээ. Прискүсийн тэмдэглэснээр тэрбээр Визант руу “ромэйчууд хийгээд

хүннүүдийн хоорондын маргааныг зохицуулахад гаршиж туршлагажсан нэгэн хүнийг заржээ. Тэр нь Эсла гэдэг хүн байсан агаад тэрээр ром, германы аль нь ч биш гэдэг нь нэрнээс нь харагдана. Харин аль ч үед ямар ч ард түмний арга эвийг олж чаддаг эрчүүд байжээ гэж бодохоор сонирхолтой агаад зугаатай. Их Петрийн үед л гэхэд Европын гүрнүүд Петербүргэд архи сайн даадаг эрчүүдийг элчин сайдаар илгээдэг байсан бол Австрийн төрийн гэрээг байгуулахаар Москвад одсон, усан үзмийн дарсаараа алдартай Австрийн төлөөлөгчид архи гайгүй даадаг хүмүүс байгаагүйсэн бол тийм амжилтад хүрээ ч үү, үгүй ч үү хэмээн шивнэлдэж байсан билээ.

Тэгэхээр Эсла хүчиндээ эрдсэн зоргоороо зэрлэгүүд болон хутган үймүүлэх далд явууллагад гаршсан Византийн хооронд өөд сөөргөө явж хэлэлцээ хийж амжилт олж байсан гайхалтай дипломатуудын нэг байж таарна. Гэхдээ хүннү нартай сайн харилцаа тогтоож чадвал хэргээ бүтээж болох цаг байсан учир өөр бусад сүрхий хүмүүс ч байсан бололтой. Тухайн үед Равенна, Константинополь хоёр туйлдаж доройтож байв. Европын шинэ эзэн Дунай мөрнөөс хойш Паннонд хаа нэгтээ сууж байсан агаад түүнтэй уулзаж танилцах цаг хэдийнээ болоод байв.

“Византичууд хүннү нарт элч илгээхээр шийджээ. Элчээр явах саналыг хүлээж авахад бэлэн гэдгээ Тракийн Плинтас, скиф (хүннү) хүн Дионисиос нарын хоёр жанжин илэрхийлжээ. Гэвч Эсла Хүннүгийн газраас гарч замдаа явсан учир элч нар явахаа түр азнах болжээ. Плинтас цаг хожиж зөвхөн өөртэй нь л хэлэлцээ хийвэл дээр шүү гэдгийг хэлүүлэхээр итгэлт хүнийг Ругилад илгээв...”

Энэ явдлаас бид тухайн үеийн Византийн ааш араншин хийгээд Дорнод Ромын эзэнт гүрний дипломат ажиллагааны арга барилыг ойлгож болно. Элчид нэрээ дэвшүүлсэн хоёр хүн Хүннүгийн элчтэй хоёул зэрэг уулзахгүйн тулд ийнхүү түр хүлээзнэж байв. Тэгэхээр Прискүсийн скиф гээд байгаа хүн нь хүннү хүн байсан бололтой агаад тэрбээр анхны тохиролцоогоо баримталж байж. Нөгөөх эх газрын гэрэг хүн нь хараахан томилолт аваагүй, хүлээзнэж байсан хэдий ч илгээсэн хүн нь үнэтэй цайтай бэлэг бэлтгэж аваад Плинтасын өмнөөс хүннү нарт тал засахаар замд яваа байдаг. Гэвч Плинтасын баахан ажил болсон нь илүү явдал болжээ. Ругила нас барж, Аттила хүннүчүүдийн шинэ эзэн болсон учир оргодол хүннү хүн Аттилад элчээр очих аргагүй болсон байна. Ийнхүү Плинтас элчээр томилогдов. Шинэ ээдрээтэй нөхцөл байдал үүссэн тул элчид тус дэм болгохоор Эпигэнэс хэмээх ихээхэн нэр хүндтэй нэгэн түшмэлийг дагалдуулахдаа түүний хурц ухааны энд Аттила хараахан хүрэхгүй байж магад хэмээх санаа бодлыг агуулжээ.

“Ингээд элч нар замдаа гарч эхлээд Дунай мөрний Иллирийн эргийн Маргус хот хүрэв. Энэ хот Дунайн нөгөө эрэгт буй Констанцийн цайзын чанх эсрэг байрлана. Скиф (хүннү)-ийн хааны элч төлөөлөгчид ч тийшээ очив. Элчүүд хоёр талаасаа морьтой очиж хотын дэргэд уулзав. Зэрлэгүүд яриа хэлэлцээ хийхдээ мориноосоо буудаггүй заншилтай учир ромэйн элч нар ч скифүүд морин дээрээс, өөрсдөө явганаар хэлэлцээ хийх байдал үүсгэхгүйн тулд мөн мориноосоо буусангүй. Чингээд хэлэлцээ хийж скифийн бүх урвагч, оргодлуудыг буцааж өгөх, чингэхдээ Дорнод Ромын нутагт буцаж очсон ромэйн урьд өмнийн бүх дүрвэгсэд болон олзлогдогсдыг ч золиогүйгээр хүннү нарт буцаан тушаахаар тохиролцов”.

Энэ асуудал байнга яриа хэлэлцээний гол сэдэв болж байсны учир нь тэр үед хил гол мөрнөөр өнгөрч байлаа ч ялгаагүй л харж хамгаалахад хэцүү байжээ. Хүннү нар урвагч оргодлуудыг үзэн яддаг байв. Учир нь үүний улмаас нэг л өдөр хүннү нар бие биетэйгээ тулалдах болж, ромчуудад олз болох нөхцөл үүсч байв. Түүнчлэн олзны хүмүүс зугтан одвол золионы мөнгөгүй хоцроно гэсэн үг байв.

“Олзны хүн нэг бүрийн төлөө хүннүгийн талд найман алтан зоос төлөхөөр тохиролцов. Түүнчлэн хүннү нартай сөргөлдөж буй ямар ч зэрлэг овог аймагтай Дорнод Ромын эзэнт гүрэн холбоотны харилцаа тогтоохгүй байхаар тохиров. Ромэйчүүд хийгээд хүннү нар зах зээлийн газар адил тэгш эрхтэй байх, адилхан хамгаалагдаж байхаар тохиров”.

Зэр зэвсэг хангинасан тухайн үеийн нөхцөл байдалд явцуурсан түүх бичлэгийн байнга орхигдуулдаг зүйл болох аливаа тохиролцооны эдийн засгийн чанартай заалтууд нь хүннү нарын хувьд бол онцгой чухал ач холбогдолтой байсан юм. Томоохон зээлийн газрууд тухайн үед Дунайн доод биенд гурав юм уу, дөрөв байсан бололтой, тэдгээр нь хүннү нарт тун ч их хэрэг болж байсан бололтой. Хүннү нар тэнд л Дорнод Ромын гүрнээс алба барих үүргээ биелүүлж ирүүлсэн алт болон золионы мөнгийг бараагаар солих боломжтой байв. Өөрөөр хэлбэл цэргийн хүч чадалдаа дулдуйдаж олсон юмаа тансаг эд бараа болгоно гэсэн үг байв. Эдгээр зээлийн газрууд хөдөлбөргүй төвийг сахих асуудал нь нэн эрт үеэс шинэ үеийг хүртэл онцгой чухал ач холбогдолтой байсны учир нь хэрвээ дээрэм тонуул, аллага хядлагад өртөнө гэж худалдаачид үзэх л юм бол тийш очихгүй, нөгөөтэйгүүр хүннү нараас баян чинээлэг хүмүүс ч чөлөөтэй зорчих, худалдаж авсан бараагаа саадгүй авч явах сонирхолтой байсан нь мэдээж.

“Эдгээр тохиролцоог сахин биелүүлэх ёстой бөгөөд Дорнод Ромын эзэнт гүрэн Хүннүгийн хаадад жил бүр 700 фунт алтаар алба барих үүргээ биелүүлж буй цагт хүчин

төгөлдөр үйлчилсээр байх болно. Урьдын алба дөнгөж гурван зуун фунт алт байсан. Ромейчүүд хийгээд хүннү нар санал нэгдэж гэрээгээ хуучны заншлаар тангараг тавьж баталсны дараа тэд салж явцгаав...Эвийн гэрээ байгуулсны дараа Аттила, Бледа нарын цэрэг салж скифийн овог аймгуудыг дагуулах, сороскуудыг дайлахаар хөдлөв...”

Прискүсийн энэхүү гоотуудын түүхийн энэ хэсэгт буй хүмүүс төдийлөн бараг анзаарахгүй байгаа сүүлчийн өгүүлбэр онцгой чухал мэдээ өгч буй. Энэ нь Аттила, Бледа нар Ругилагийн эхэлсэн аян дайныг үргэлжлүүлэлгүй хэлэлцээ явуулах саналыг хүлээн авсан явдал болой. Тэдний хувьд хаан ширээ залгамжлагчийн асуудлыг шийдэх нь Византийтай толхилцохоос хамаагүй чухал байжээ. Тэгсэн хэдий ч хэлэлцээ хийхдээ тэд хүчээр түрий барьсан нь тов тодорхой байгаа нь оргодлуудыг буцааж авах, золионы мөнгө төлүүлэхээр зогсохгүй хэмжээг нэмэгдүүлэх, бас Византиас барих албаны хэмжээг хоёр дахин өсгөхөөр тохирсон нь Аттила тэр үед ямар их хүндлэл хүлээсэн байсныг бэлээхэн харуулж буй. Түүний байр суурь тэр цагт хүннү нарынхаа дунд тэгтлээ бат нот болоогүй байсан байж мэднэ. Харин ромчуудын хувьд Аттила үнэхээр айдас төрүүлэхээр дайсан байсан нь тодорхой байдаг. Хүннүгийн хаан ширээ шилжсэн хэрэг явдал хүннүчүүдтэй харилцахад нь огтхон ч түвэг учруулаагүй нэг л хүн байсан нь Аетиус юм. Тэрээр хэрэг дээрээ Өрнөд Ромын эзэнт гүрнийг захирч байсан юм.

Нэг бол тэр Аттилаг үнэхээр таньдаг байсан, эсвэл нөхцөл байдлыг маш хурдан үнэлж зөв хүнээ олж дэмжээд Ругилатай эвсч байсныхаа адилаар Аттилатай харилцах болсон байж мэднэ. Ямар ч байсан Визант Равеннагийн адилаар хэрэг явдалд шуурхай оролцож хурдан шийдэж хийсэн ажил нь эхэндээ зөв мэт байсан ч буруутав. Учир нь тэр жил Аттилаг шахан зайлуулж оронд нь Бледаг ч юм уу эсвэл цаазлагдсан хоёр жононгийн аль нэгийг тавих сүүлчийн боломж гарсан байна. Угсаат ноёдын хөвгүүдийг хүннүчүүдэд буцааж цаазын тавцанд гаргахын оронд тэдэнд туслаар Византийн цэргийг өгч явуулах байлаа. Тэгсэн бол хүннү нарын зарим овог Аттилагаас салж тусгаарлах ч байсан байж мэднэ. Эсвэл Аттилаг Ругилагийн залгамжлагч гэж зарим овог аймгуудад тулган хүлээлгэж чадахгүй ч байсан байж мэднэ. Хүннүгийн хүрээнд зөрчил байсан л байж таарна. Тиймгүйсэн бол Прискүсээс иш татсан хэсгийн сүүлчийн өгүүлбэр ойлгомжгүй.

Ромын эзэнт гүрний хоёр хэсэг хийгээд тэдний удирдагчдын төөрөгдөл бол нэг нь нөгөөгөө хүннүчүүдийн тусламжтайгаар бутцохиж их гүрнийг дахин нэгтгэнэ хэмээсэн найдлага байв. Салж тусгаарласнаас үүдэлтэй бас ч гэж магтууштай, ойлгож болохоор харуусал нь тэдний хоорондын хамгийн уршигт өрсөлдөөн, хүч тэнцүү хоёр

хүчний өрсөлдөөн тэмцэлтэй нийлэхээрээ тухайн үед ч, өнөө ч дэлхийн бодлогын учир утгыг ойлгоход түвэг учруулж буй.

Эхэлж нүүдэл хийсэн нь мэдээж Аетиус байсан агаад учир нь тэрээр байр сууриар давуу, өөрөөр хэлбэл хүннү нартай барьж байсан харилцаанд нь хараахан сүүдэр тусаагүй, магад ч үгүй Аттила, эсвэл Бледатай танилын харилцаа холбоотой байв. Тэрээр хүннү нарыг байнга ашиглаж олон хүннү хүнтэй харилцаж байсан бөгөөд учир нь хүннү нараас өөр германчуудтай үзэлцэх чадалтай хүч хараахан гарч ирээгүй байсан цаг юм. Зэрлэгүүд Ромын дохио зангаагаар бие биеэ хядаж буурч доройтож ирсэн эзэнт гүрний насыг ганц нэг жилээр ч болов уртасгавал аятай юу!

Хүннү нарыг бүргүндчүүдийн эсрэг турхирч бүргүнд аймгийг бүрмөсөн устгахаар Аетиусын бодож төлөвлөсөн байв. Бүргүндчүүд тэр үед нэрийг нь сонсмогц л санаанд гялсхийн буух үзэсгэлэнтэй сайхан нутаг орондоо хараахан сууж байгаагүй юм. Тэр үед Мулан-а-Воны толгод, Флөри болон Брүлли (*Францын Альпийн нутагт орших Рон мужийн усан үзмийн дарсаараа алдартай нутгууд.Орч.*)-д усан үзмийн дарс нэрэх үйл хараахан хөгжөөгүй, тэр үеийн германчуудын амьдрал хөгжүүн цэнгээнтэй гэхээсээ хавчигдмал хүнд байсан нь илүүтэй.

Бүргүндчүүд юуны өмнө Европын голт зүрх болох нутаг орноор нүүж сууж явахдаа олон аюул осол давсан улс билээ. Висла хэмээх их уст өргөн мөрний бэлчир дэх урьдын эх нутгаа дурсан санагалзах хүмүүс хараахан байсаар байжээ. Өнөөдөр таамаглаж байгаагаар бүргүндчүүд тэндээсээ хөдөлж хоёр их урсгал болж, нэг нь зүүн өмнө зүг, нөгөөх нь баруун өмнө зүгийг барин нүүжээ.

Хэдийгээр бүр өнө эртнийх нь нутаг биш ч гэлээ бүргүндчүүдийн энэхүү хуучин эх нутаг Нибэлүнгийн дуулал хийгээд хүннү нарын түүхэн дайн тулаанаас бидэнд бусдаас илүү сайн мэдэгдэж буй. Христийн тооллын 100 оны орчим тэд өнөөгийн Прүссийн Бранденбүргийн өрнө нутаг хүртэл тархан сууж байв. Птолемайос дэлхийн газар зүйн тухай бүтээлдээ бүргүндчүүдийг христийн тооллын 150 оны орчим семнонуудтай хаяа хатгаж Висла мөрнийг хүртэл нутаглаж байсан хэмээжээ. Зуун жилийн дараа тэд бууриа бага зэрэг сэлгэж Познань, Бранденбүрг, баруун хойд Силезийн завсар зассан байна.

Эхний гай гамшиг 284 онд Гэпидийн шаламгай дайчин Фастиды ноён ард түмнээ нүүлгэх замдаа бүргүндчүүдийн нутгаар дайрч хайр найргүй дайн тулаан хийж хүчээр зам гаргаж явах цагт тохиов. Тэрээр Даки буюу өнөөгийн Румынийг зорьж явжээ. Тэднийг өнгөрүүлээд тайван сууж байхын оронд үймж эх нутгаасаа дайжсан

бүргүндчүүд мөн л хөдөлж зүүн өмнөд зүгт аврал эрсэн бололтой. Тэд тэнд вандалуудтай нөхөрлөж 280 оны орчим сууж байсан нь мэдэгддэг. Энэхүү вандалуудын дайнч овог болон ромчууд хоорондоо Пробус хааны үед ихээхэн зөрчилдөн тэмцэлдэж байв.

Нутагтаа үлдсэн бүргүндчүүдэд өрнө зүг ард түмнүүдийн нүүдлээр гарсан зам нэгэнт нээлттэй байжээ. Гэвч тэднийг замд гарах үед зүүн өмнийн нутаг орноос хүйс тэмтрэн устгах их тулаан, гай гамшгийн тухай сураг чимээ Висла мөрөнд ирсээр байсан учир баруун өмнийг чиглэжээ. Тэдний нүүдэл хурдан шуурхай явсан бололтой бөгөөд нүүдлийн эхний хэсэг Трансильваанд очиж мөхсөнөөс хойш долоон жилийн дараа бүргүндчүүд Галлид, өөрөөр хэлбэл алс баруун зүг өнөөгийн Дорнод Францын нутагт гарч иржээ.

Бүргүндчүүд тэнд тун эвгүй хөршүүд болох алеманнуудтай хаяа хатгасан ажээ. Висла мөрөнд сууж байсан ард түмэн тэдэнтэй ам хэлээ ололцохгүй гэдэг нь тодорхой байв. Тиймээс бүргүндчүүд дахин ачаалж аваад тэнүүн сайхан нутаг ойр орчим байсан хэдий ч умар зүгийг барьж хэсэг яваад Майн мөрөн хүрч 359 онд Райн мөрний хавьд гарч ирээд Ромын эзэн хаан Валентинианд (364-375) хүчээ өгч алеманнуудын эсрэг байлдахад нь туслах болжээ. Гэвч өшөө хорслоо тайлах аян дайнд мордох мөрөөдөл нь талаар болжээ. Валентиниан хаан өөрөөр шийдэж, уур хилэндээ шатаж явсан бүргүндчүүд холбоотны харьцаа тогтоох хэлэлцээний дараа барьцаанд байлгахаар Ромоос ирүүлсэн бүх хүнийг хүйс тэмтэрч, цаашдаа Ромын хилийн цэрэгт тун эвгүй хөрш болохоо харуулжээ.

Хүннү нарын түүхэнд чухамхүү энэ үед германчуудын хувь заяатай холбоотой нэгэн хуудсыг оруулах ёстой гэж бодож байна. Ард түмнүүдийн их нүүдлийн бүхий л үед германчууд байнга л өөрсдийн мах цусны тасархай ах дүүстэйгээ хатуу ширүүнээр тэмцэлдэж, хүнд ялагдал хүлээлгэж байсан ч асар өргөн хүрээтэй, олон дүр төрхтэй түүхэн үйл явдлын хэлхээнд огт авцалдахгүй, огт ондоо онцгой нэгэн явдал бүргүндчүүд, хүннү нарын хооронд тохиолджээ. Тэр нь бүргүндчүүдийн дөрвөн зуун жилийн дараа ямар нэг байдлаар таньж мэдэж хүлээн зөвшөөрч зохицох тийшээ хандаж ирсэн холбоотон ромчууд нь ийн цагийн уртад зохицож ирсэн хамтын амьдралын хуулийг зөрчиж, дайтаж тулалдах огт өөр дайтах арга барил, нэр төрийн талаар огт өөр ойлголт бүхүй алан, хүннү нарын зэрэг харь ард түмэн, морьтон нүүдэлчдийг германчуудын (бүргүндчүүдийн) эсрэг турхирсан явдал болой.

Өнөөдрийн улс түмний хувьд хамгийн их гай гамшиг болох дайн тулаан бол германчуудын хувьд тэглээ дасаж дадаагүй үйл биш, тэд насан туршид хэзээ л бол

хэзээ босч дайтахад бэлэн явжээ. Тиймээс германчуудын байнга өдүүлэх бослого хөдөлгөөнтэй тэмцэхээсээ наана энхийг сахиулах үүрэг гүйцэтгэж, хэзээний зодоонч авиртай германчуудад илд бамбайгаа гэртээ хадгалж амгалан тайван амьдарсан нь дээр гэдгийг нь зэр зэвсгийн болхи толхи хэлээр ойлгуулах шаардлага ромчуудад тун удалгүй тулгарчээ. Тэдний ажиллагаа цус асгаруулахгүй өнгөрөх нь ховор, ромчууд НҮБ-ын цэнхэр дуулгатнууд шиг тохиромжтой байгууллагатай байгаад ч нэмэргүй байсан нь тодорхой, тулалдааны амтанд орж уугуул герман уур омог нь шатсан вандал мэтийн ард түмэн дуулганы өнгийг хайхрах байсан нь юу л бол.

Германчуул Ромын энэхүү хөндлөнгийн шүүгчийн үүргийг аргагүйн эрхэнд хүлээн зөвшөөрсний учир нь энэ нь эцсийн дүндээ өөрсдөд нь ашигтай гэдгийг олж харсных юм. Дандаа л ялж дийлээд байна гэх итгэл үнэмшил германы олон овгийн алинд нь ч байгаагүй юм. Ялагдаж дийлдсэн талын хувьд урц овоохой нь сүйдэж, эхнэр хүүхэд нь хядагдаж, эцэстээ ард түмэн нь хүйс тэмтрэгдэхээс өмнө Ромын легионууд амжин ирж салгах нь маш хэрэгтэй байсан нь мэдээж. Үндсэндээ амгалан тайван нүүдэллэн амьдарч явсан герман гарлын томоохон овог аймгуудыг Мариус, Стилихо нарын жанжнууд Акуае Секстиае (Экс-он-Провенсийн орчим) болон Фаезулае (Флоренцийн хавьд)-д болсон тулалдаанаар хядсаны балгийг ромчууд дээрх байдлаар бага боловч цайруулж байв.

Аетиус Равеннад байхдаа 434 онд бүргүндчүүд үймж самуурсан тухай сонсч бельгичүүдэд аюул учирлаа гэдгийг ойлгожээ. Гэвч энэ нь хэдий муу мэдээ байсан ч сүйрлийн дохио огт биш байв. Зодоонч азарган тахиануудыг зүгээр л зөнд нь хаяж хооронд нь үзэлцүүлэх хэрэгтэй гэж зөвлөх хүмүүс Өрнөд Ромын эзэн хааны ордонд бишгүй байсан бололтой, мэдээж герман хүн бүр ромчуудын болзошгүй дайсан нь байсан агаад герман хүн үхэх нь Ромын хойч үеийнхний дайсан этгээд нэгээр хорогдож буй гэсэн үг байсан юм.

Гэвч Аетиусыг өөр бодол эзэмдэж байлаа. Бүргүндчүүд, бельгичүүдийн хооронд үүссэн зөрчил нь Галли нутгийг бүхэлд нь хамарч гал авалцана гэдгийг тэр мэдэж байв. Райн мөрөнд болж буй дайн тулаан бүр худалдааны чухал чухал замуудыг тасалж худалдаачдыг өөр газраар явуулахад хүргэж байв. Ялсан бүргүндчүүд алеманнуудаас өшөө авах болно, тэгэхээр дайн Италийн хилд тулж ирнэ гэсэн үг. Тиймээс ийм мөргөлдөөн бүрийг тэр дор нь даруй дарж байх нь Цезарийн үеэс уламжлагдсан ухаан бөлгөө. Германы нутаг дэвсгэрт дүрэлзсэн их түймрийг Ромын хязгаарлагдмал хүч хэрэгслээр унтраах аргагүй байсанд хэргийн учир оршиж байв. Цезарь л гэхэд Ромын цэргийн хүч чадал оргилдоо хүрээд байх цагт эдгээр уугисаар байсан түймрүүдийг унтраах гэж суут ухаанаа зарж, хамаг легионоо барж байсан бөлгөө. Харин өдгөө

хуваагдмал Ромын эзэнт гүрэн ийм тэмцлийг амжилтад хүргэх чадал боломжоор хомс байв. Гэвч Гайус Юлиус Цезарьт байгаагүй тийм арга хэрэгсэл Аетиуст байсан юм. Тэр нь түймэр унтраах гаргууд хэрэгсэл болох хүннүгийн морин цэрэг байв. Энэ нь тун өвөрмөц “гал унтраагч” байсан агаад хэрэв хийх юмгүй зүгээр суух юм бол хамгийн аюултай хүч байсан юм. Хүннү цэргийн хүрээнээс энгийн ард иргэд хийгээд бусад холбоотны орон сууринг тусгаарлаж хамгаалах гэж Ромын шилдэг цэргийн хүчийг дайчилж байсан бөлгөө. Мөнөөх “гал унтраагчид” нь гар хумхин зүгээр суух цагтаа өөрсдөө цөөнгүй түймэр тавьж байсан нь харагддаг. Цалин хөлс чамгүй авдаг эдгээр хөлсний цэргүүд удтал юу ч хийхгүй зүгээр суух, эсвэл ноёдын хараа хяналтын дорх нүүдэлчний уйтгарт амьдрал хүлээж буй Паннон нутагт нь буцаах болбол үймээн дэгдээх нь бишгүй байв.

Ийнхүү Аетиус алгуурлалгүй даруй шийдэж Аттилад буухиа элч довтолгож бүргүндчүүдийг дайлахад хүннүчүүдийг хөдөлгөх зөвшөөрөл хүсчээ. Хүннүгийн хөлсний цэргийн удирдагч хэн гэгч ямар хүн байсныг бид мэдэхгүй. Гэхдээ Брентано (1282 оноос эхтэй Ломбардын удамт хур баячуудын овог.Орч.)-гийн “*Habebald*” (Эд хөрөнгө хурдан ав) “*Eilebeute*” (Олзондоо яар) зэрэг нэр хочийг тэдэнд өгөхөд хэлмэгдүүлсэн явдал болохгүй нь тодорхой. Хэрвээ л Аттила хааны алтны шунал оргилоод эхлэх юм бол түүний цэрэг эрсийг юу ч тогтоохгүй. Тэд хаа газар байдаг шорлож шарсан хурганы магнаас авахуулаад хонгор шар үстэй бүргүнд бүсгүй, өчүүхэн муу бүсний горхи, болхи хийцтэй бөгжөөс эхлээд Бүргүндийн хаадын ам дамжин яригддаг алт эрдэнэс гээд ер дайн тулаанаар олж болох ямар ч олз омогт сэтгэл ханана гэж үгүй.

Райн мөрөн дээр чухам юу болсон тухайд дөрвөн мөр бүхий түүхэн тэмдэглэл хийгээд түүнийг тодруулахад онцын нэмэргүй зарим мэдээ сэлт байх. Мөн манай ард түмний хамгийн алдартай баатарлаг туульс хийгээд тайлбар, таамаглал, тодотгол, мэтгэлцээнээр дүүрэн бүхэл бүтэн номын сан ч буй. Тэрхүү тэмдэглэлд дурдахдаа “Яг тэр үед Аетиус бүргүндийн хаан Гундикариусыг довтолж баахан хэмхээд түүнийг найрамдахыг гуйхаар нь зөвшөөрөөд удаагүй байтал хүннүчүүд түүнийг ард түмэнтэй нь хамт хүйс тэмтрэв.” Эдгээр мөрийг тэмдэглэн үлдээсэн хүн нь Аквитаниас гаралтай зохиолч Проспер Тиро агаад тэрээр 435 оныг хүртэл Марсельд гэгээн Аугустинусын сүмд шавилан сууж байжээ. Дараа нь тэрээр Ромд их гэгээн хутагт Леогийн бичиг хэргийн албанд ажиллаж байхдаа 412 оныг хүртэлх үйл явдлуудыг бидний мэдэх христ шашинт зохиолч, хамба лам Хиеронимусын бүтээлүүдээс иш татаж, түүнээс хойшхийг өөрийн мэдээ материалд тулгуурлан бүрдүүлж дэлхийн он дарааллын бичиг зохиосон байна.

Дээрх хомсхон мэдээг тодруулахад Проспер Тирогийн дараах үеийн зохиолч, Лионд галл-ромын дээд язгууртны гэр бүлд төрсөн Сидониус Аполлинарис маш чухал хувь нэмэр оруулжээ. Тэрбээр Арльд эзэн хаанд өргөмжлөгдсөн Овернет Авитусын хүргэн байсан учир жирийн хүнд хаалттай зарим мэдээ сэлтийг олсон ажээ. Сидониус цаашдаа өөр хоёр ч хаантай дотно нөхөрлөж явсан учир тэд нь түүний хөшөө дурсгалыг босгож язгууртны зэрэгт дэвшүүлж өндөр хэргэм шагнаж байжээ. Тэрээр Клермон-Феррандын хамба байхдаа 471-474 онд вестгоотуудаас хотоо хамгаалан тэмцэж байжээ. Ийнхүү тэрбээр христ шашинт удамт язгууртан, эрэлхэг дайчин, сүмийн эцэг явсан ажгуу. Аетиус яагаад бүргүндчүүдийг сүйтгэсний учрыг энэхүү Сидониус тайлбарлаж буй. Хэргийн учир нь бельгичүүдийг довтолсны учир бүргүндчүүдийг залхаан цээрлүүлсэн явдал байсан гэжээ. Бельгичүүд нь өнөөгийнх шиг фламанд-валлон хоёр язгуурын ард түмэн байгаагүй, тэр үед Баруун хойд Францын нутагт худалдаа хийгээд гол мөрний тээвэр эрхлэн суудаг ард түмэн байсан юм. Тэгээд эл ажил үйлийнхээ ачаар жаал жуул эд хөрөнгө хуримтлуулсан ажээ. Тиймээс бүргүндчүүд тэднийг довтолсон нь эв эвдсэн явдал байв. Бүргүндчүүдийг ромчуудын удирдсан хүннү цэргийн тусламжтайгаар, эсвэл Ромын легиончууд, Хүннүгийн морин цэргээс бүрдсэн тусгай цэрэг илгээж номхотгосон нь гарцаагүй, ингээд тэд найрамдахыг гуйжээ. Аетиус нэгэнт эвлэрүүлэгч, энхийг дархлагчийн үүрэг хүлээсний учир тэрхүү гуйлтыг нь ёсоор болгожээ. Ийн амгалан тайван байдал дахин тогтоод байтал хүннүчүүд дахин бүргүндчүүдийг довтолсон ирсэн нь Ромын тушаалгүйгээр хийсэн хэрэг бололтой агаад энэ удаа тэднийг бүрмөсөн бутниргэжээ. Тэхдээ бүргүндчүүд гүйцэд мөхөөгүй, амьд мэнд үлдсэн хэсэг нь өдгөө бүргүнд дарсаараа зүй ёсоор алдаршсан нутагт очиж, бас зарим нь өрнө зүг цаашлан Саонь хүрч ромчууд, өөрөөр хэлбэл Аетиусын зөвшөөрснөөр Женевийн нуураас зүүн өмнө, өмнө зүгт орших Сападиа гэгч газар, өнөөгийн Савоенд бууриа хатгаж суурьшсан ажгуу.

Түрүүчийн ялагдлаасаа хойш арай гэж амсхийж байсан ард түмнийг санаандгүй байтал нь дахин довтолж зүйл дуусгах нь сайхан юм яав ч биш гэдэг нь тодорхой. Энэ явдлыг Аетиус мэдэхгүй байх юм уу, түүний санаа зоригоос гадуур ийм үйлдэл хийнэ гэдэг төсөөлөхөд бэрх учир санаачилга нь түүнээс гараагүй, харин хүннүчүүдээс гарсан дүр зураг харагдана. Ард түмнүүдийн их нүүдлээс үүдсэн дайн тулааны хөлд улс түмэн үрэгдэж, цаг төр үймж самуурч байсан үе ч гэлээ дээрх үйлдэл ер бусын явдал болсон гэдгийг түүх ч гэрчилнэ. Чухамдаа энэхүү ер бусын үйл явдалтай холбогдож олон домог хууч үүссэн нь ямар учиртай болохыг сониучирхаж хорхойсох нь зүй. Тухайн үеийн Европын төв, Райн мөрний бэлчирт суух нэгэн ард түмнийг ийн хоёрын хоёр удаа довтолсон сөнөөсөн явдал мэдэгдэхгүй өнгөрөхгүй, мартагдах учиргүй байсан юм байна хэмээх таамаглал төрнө. Гэхдээ учир шалтгаан нь чухам юу байв?

Нэгд гэвэл юуны өмнө тонон дээрэмдэх шунал, үлдсэн жаал жуул юмыг нь булааж авахад хүрвэл бүргүндчүүд олигтой эсэргүүцэл үзүүлж чадахгүй гэх харьцангуй үнэнд ойртох санаа бодол давамгайлсан байж болно. Хоёрт, овог аймгуудын дунд төвийг сахиж хэний ч талд орохгүй байх үүрэг хүлээсэн Аетиус эхний удаа өөрөө үйлдэж зүрхлээгүй бохир үйлээ гүйцээлгэхээр хүннүчүүдийг турхирсан байж болно. Чингэхээр германчуудын хамаг уур хилэн ромчуудыг бус, хүннүчүүдийг онилох нь тодорхой. Тэгвэл Аетиусын хэрэг бүтэж байна гэсэн үг юм. Гуравт гэвэл урьд өмнийн тулгаралтуудаас үүдэлтэй хуучин тооцоо хүннүчүүдэд байсан, тэр нь бүргүндчүүд Ром, Хүннүгийн нэгдсэн хүчинд дарагдахад гүйцэд бодогдоогүй байсан байж болно.

Эхний хоёр таамаглалыг баримтаар нотлох бараг боломжгүй нь ойлгомжтой. Аетиус бузар муу үйлээ царан дээр тавиад түүхч туурвигсдад барихгүй нь ойлгомжтой. Харин хүннүчүүд бол бусадтай харилцаж барихгүйгээр байнга шалтагтай шалтаггүй дээрэм хийж явдаг улс байсан бөлгөө. Гуравдахь таамаглалын хувьд Сократ хэмээх цуутай нэр бүхий Сократес Схолостикос гэгч сүм хийдийн зохиолчийн бүтээлд хэдий маргаантай ч үгүйсгэх аргагүй баримт бий. Энэхүү Сократес Схолостикос бол тавдугаар зуунд Константинопольд өмгөөлөгчөөр ажиллаж, (Палестин дахь Цезареа хотын) Ойсебиус (260-340 онд амьдарч байсан, сүм хийдийн түүхийн эцэг хэмээгдсэн. Орч.)-ын сүм хийдийн түүхийг үргэлжлүүлгч болой. Тэрбээр бүргүндчүүдийн талаар өөр хаана ч байхгүй зарим баримтыг өгүүлж буй:

“Райн мөрний бэлчир газар нэгэн зэрлэг үндэстэн суух агаад тэднийг бүргүндчүүд хэмээнэ. Тэд амгалан тайван амьдрана. Тэд модоор элдэв зүйл хийхдээ тун чадамгай, энэ чадвар нь тэдний амьжиргаанд их нэмэр болно. Энэ ард түмнийг хүннүчүүд дахин дахин довтолж улс орныг нь сүйтгэж асар олон бүргүнд хүнийг амийг бүрэлгэжээ. Бүргүндчүүд ийм гамшигт автагдахын цагтаа ер нь нэг хүнд итгэж найдах бус харин хүн амьтнаас дээр орших бурханд хувь заяагаа даатгах хэрэгтэй юм гэж шийджээ. Ингээд ихээхэн бодож цэгнэсний эцэст ромчуудын бурхан л олон шавь нараа хамгаас илүү энэрч хамгаалдаг юм байна гэж хэлэлцээд Ромын (католик) шашин авахаар шийджээ.

Тэгээд энэ үйл хэргээ гүйцэлдүүлэхээр тэд (өмнөд) Галлийн нэгэн хотод хүрч тэндхийн хамба ламтнаас шашиндаа оруулж загалмайж өгөхийг гуйжээ. Хамба ламтан тэдэнд долоон хоног мацаг барихыг тушааж энэ хугацаанд христ-католик шашны үндсэн зарчим мэдэгдэхүүнийг заажээ. Найм дахь хоног дээр нь тэднийг загалмайлаад явуулжээ. Үүнээс хойш бүргүндчүүд өөртөө итгэх итгэл үнэмшлийг олоод дарлан зовоогчдыг эсэргүүцэн боссон байна. Тэдний итгэл найдвар талаар болсонгүй. Хүннүчүүдийн хаан Уптарос (Октар) нэг шөнө хэт их идэж ууснаас болоод амиа алдах

үед бүргүндчүүд удирдлагагүй болсон мөнөөх ард түмнийг дайран оржээ. Бүргүндчүүд цөөн, дайсан нь тоогоор давуутай байсан ч тэд их ялалт байгуулжээ. Гурван мянгахан хүнтэй тэд арван мянган хүннү нарыг бутцохив. Энэ үеэс эхлэн бүргүнд үндэстэн христ шашны хамгийн үнэнч хичээнгүй шавь нарын тоонд багтан оржээ.”

Сүм хийдийн түүхч үнэнхүү сүсэгт Сократес Схоластикос энэ түүхийг юуны учир өгүүлээд байгаагийн учир сүүлийн өгүүлбэрээс тодорхой болж буй. Чухам ийм л учраас уг түүх санаанаас зохиосон юм биш, гэрчтэй нотолгоотой зүйл гэдэг нь тодорхой байна. Үнэнийг тодруулахад л хэрэг болохгүй юм бол юуных нь нотолгоо байх билээ.* Октар, Ругила хоёр сүүлд гарч ирсэн Бледа, Аттила нарын нэгэн адил Хүннүгийн янз бүрийн овог аймгуудыг захирч, Европын янз бүрийн хэсэгт дайн хийж явсан бөлгөө. Ругила зүүн өмнө зүг Византийн эсрэг дайтаж явсныг бид мэднэ. Латин эх сурвалжид Уптарос ч гэх Октар нь алс өрнө зүг цөмөрч уулгалан довтолж явсан байдаг. Хүннүгийн хаад ноёд болгон эх сурвалжид Аттилагийн талаар дурдсан шиг тийм эгэл даруу амьдарч байгаагүй бололтой байдаг. Хүннүгийн хааны (Октар) гэдэс нь хагарч үхсэн гэж барим тавим дурдаж ханаж цадахаа мэдэхгүй хэтэртлээ идэж уух явдал тэнгэрийн гэсгээл заавал дагуулдаг тухай өгүүлэхдээ Византийн христ мөргөлт энэ хүний бах нь ханаж байжээ гэдэг нь ойлгогддог. Хүннүчүүд үхэгсдийнхээ хойноос ихэд эмгэнэн гашуудаж хүнд ёслол үйлддэгийг бид мэднэ. Тэгээд энэхүү ариун ёслол нь ид өрнөж тулалдаанд огт бэлэн бус, гэнэггүй байх цагт нь бүргүндчүүд довтолсныг хүннүчүүд мартаагүй нь тодорхой.

Эх сурвалжид дурдсанаар бүргүндчүүдийг дарсны дараа жил хүннүчүүд нэгэнт дарагдсан дайснаа онцын шалтгаангүйгээр дахин довтолж зүйл дуусгасан нь арав хүрэхгүй жилийн өмнө Октарыг нас барахад бүргүндчүүд гэнэт довтолсны хариуг авч өшөө хорслоо тайлсан хэрэг байж таарна. Нүүдэлчин ард түмнүүд тийм богино ой ухаантай улс биш бөлгөө.

*К.Стиве-Мюстер “Хуучин ертөнцийн толь бичиг”-т нийтлүүлсэн өгүүлэлдээ Сократес Схоластикосын тухай дурджээ “Түүний бүтээл 305-439 оны үйл явдлуудын тухай өгүүлж буй агаад үнэ цэнэтэй гэрч материал ашиглаж бодитой дүрслэн үзүүлснээрээ онцлог байна” хэмээн тэмдэглэсэн нь бий. Ийм хүн очиж очиж бүргүндчүүд хийгээд хүннүчүүдийн талаар худал дэгс зүйл өгүүлнэ гэж үү?

Ард түмнүүдийн их нүүдлийн талаар судалгаа шинжилгээ хийдэг ахмад үеийн судлаач, түүхчид түүнд итгээгүй байдаг. Бери болон Сийк нарын хамгийг мэдэгч их түүхчид эртний ертөнцийн мөхлийн талаар өргөн дэлгэр өгүүлсэн бүтээлүүдэд дээр иш татсан үйл явдал байхгүй. Томпсон 1948 онд дээрхийг найдвартай баримт хэмээсэн бол Отто Маенхен-Хэлфэн 1973 онд үнэний

хувь их байгааг тэмдэглэсэн. Ийн үгүйсгэх, зөвшөөрөхийн аль аль нь буй. Үүнийг нэг сэдэвт зохиолоор дүгнэж цэгнэх учиргүй, шийдэл гаргаж чадахгүй. Гэхдээ бүргүндчүүд хийгээд хүннүчүүд ийм эрт учрах нэг учир шалтгаан байсан л байж таарна. Хүннүчүүдийн анги нэгтгэлүүд хэдэн арван жилийн турш хөлсний цэргийн үүрэг гүйцэтгэж явах цагт тэрхүү учрал тохиосон байж болох юм. Эсвэл бидэнд бараг үл мэдэгдэх Октав хааны дээрмийн аян дайнуудын нэгнээр тохиосон ч байж болно.

Суурин суудаг бүргүндчүүд сэхээ авч өндийж чадах л юм бол нэхэн санаж ой ухаандаа хадгалж явах юм ихтэй байсан бөлгөө. Райн мөрөнд нутаглаж ахуйдаа алеманнууд, ромчууд, хүннүчүүдтэй тулалдаж явсан баатарлаг үе хийгээд Аттилагийн захирсан мөнөөх хүннүчүүдийн хорон санаат хэрцгий үйлдлийн тухай дурсамж тэдэнд хадгалагдсаар явсан ажгуу.

Чухам дээр өгүүлсэн үйл явдал л Понтиус Пилатус (*Понтиус Пилатус нь эзэн хаан Тиберийсийн үед Ромын Палестин дахь жүүдүүд амьдран суудаг Юдея мужийг захирч байхдаа Исүсийг загалмайд тэлж цаазалснаараа зард гарч христ шүтлэгийн ном судар, тухайлбал Кредод нэр орсон хүн болой. Орч.*) Кредод нэр орсны адилаар Аттила-Этцэлийг Германы баатарлаг тууль Нибэлүнгийн дуулалд орох үүд хаалгыг нь нээж өгсөн юм болов уу?

Ийн бид Гордийн зангилаа лугаа ээдрээтэй асуудалтай тулгарч буй. Нибэлүнгийн дуулал зэрэг хуучны алдарт туульс, Зийгфрийд, Гүнтэр, Хаген болон бусад баатруудын тухай яригдаад ирэхээр баахан герман эрчүүд үзэг бийрээ хурцалж, ширээ сандлаа хяхтнуулан санаа бодлоо илэрхийлэх гэж яарч, харь хүмүүс, тэр дундаа гадаадынхны санаа бодлыг улайран няцаахыг урьтал болгодог явдал бий. Ийнхүү улайрах нь бүр гаарч сүүлдээ Вормс хот (*Райн мөрний дээд биений зүүн талд, өнөөгийн Райнланд-Пфальц муж улсад орших хот. Орч.*) үнэхээр Бүргүнд гүрний нийслэл байсан эсэх, хэрвээ Вормс биш юм бол өөр ямар хот байв гэх мэт шалихгүй асуудлаар ч эрдмийн хүрээнд бөөн маргаан дэгдэх нь байв. Нөгөөтэйгүүр энэ бол ямар ч ард түмэн бахархахаар баатарлаг тэмцэл, үндэсний буянт үйлийн түүхтэй холбогдох асуудал учир тэгсхийгээд намдаж тайвширч байв.

Нибэлүнгийн дууллын шүлэг зохиол болон Аетиус, Аттила нарын дунд хавчигдаж явсан бүргүнд ард түмний хувь заяаг шимтэн сонирхох явдал огт буурсангүй, цагийн саалтанд огтхон ч хорогдож холторсонгүй явсаар эрдэм шинжилгээний олон зохиол бүтээл гарсны зэрэгцээ хялбаршуулсан хоёр ч зохиол шинээр гарсан болой. Эдгээрийг уг явдлын талбарын ойр орших Бонн хотын сэтгүүлч мэргэжлийн хүмүүс туурвисан нь тохиолдлын хэрэг биш болов уу. Рудольф Пөртнерсийн “Цахилгаанд шатаар Ромын үед зорчихуй” хэмээх зохиол райн-ромын орчин нөхцөлийг тодруулан тоймлосон бол Хельмут Берндт дээрхээс есөн жилийн хойно Нибэлүнгийн дуулалд

дүрсэлсэн гучин есөн зүйл адал явдалд дээр нэмж бүргүндчүүдтэй холбогдох түүхт газруудад хийсэн археологийн эрэл хайгуулын үр дүнгийн талаар өгүүлсэн “Дөчдүгээр адал явдал”-аа нийтлүүлжээ.

Үнэхээр ч наад зах нь Вормс хотын тухай, тухайн үед энэ хот ямар үүрэгтэй байсан тухай эхний бөгөөд эцсийн үгийг хуучны судлаачид л хэлэх ёстой биз ээ. Тэд ч чингэх дуртай байх болов уу. Гэхдээ булш ухлаа гэхэд тэр нь нийслэл байсан хотын дор байна гэж юугаар нь мэдэх вэ?

Бүргүндчүүдийн нутаглаж байсан газар орноос цөөнгүй гардаг олдворууд нь өвөрмөц байдал, ур хийцээрээ харьцангуй хялбар танигддаг. Өөрөөр хэлбэл эдгээр олдвор чухамхүү бүргүндчүүдийнх мөн байна гэж мэдэгддэг юм. Тухайлбал 1934 онд Фридрих Бээний хийсэн малтлагаас шарил, хүний араг яс, түүнчлэн аяга сав, бүсний горхи, гох, бөгж, илд гэх зэргийн гарал үүслийг нь тодорхойлж тогтооход нэмэр болох бусад зүйл олсноос үзвэл энд аялан явж байгаад дайралтад өртөж хядагдсан бүргүндчүүдийн булш бус, харин хот суурин газрын оршуулгын газар байсан, оршин суугчид нь үхэгсэдээ энд он удаан жилээр нутаглуулж байж гэдэг нь тогтоогджээ. Энэ нь Лампертхайм хотын наахна хуучин Райн нэртэй газар байгаа бөгөөд өргөө хот бус, жирийн нэг тосгон байсан бол Вормсын ойр байж яавч таарахгүй юм. Мөн гөпидүүд Висла мөрөнд, вандалууд Трансильваанд бүргүндчүүдэд хүнд цохилт өгч хөөн зайлуулснаас үзэхэд хүн ам төдийлөн ихгүй, багавтар овог аймаг байсан нь харагддаг. Эндээс тэд хааш хаашаа тавин километрээс (бүргүндчүүдийн орон суурин задгай тал газраас илүүтэй гол мөрний эргээр сунаж шигүү байрлаж байсан гэж үзвэл) илүүгүй хэмжээний газар нутаглаж байжээ гэж таамаглаж болно. Энэ газраас өмнө тийш нэлээд зайтай орших Ромын эзэнт гүрний харьяат нутгаас дээрх археологийн олдворуудыг гэрчлэх нэгэн үнэ цэнэтэй зүйл олдсон нь 411 онд Мундикум хэмээх хотноо Ромын эзэн хаантай өрсөлдөгч нэгнийг эзэн хаанд өргөмжилсөн тухай мэдээ занги болой. Энэ хэрэгт аланууд хийгээд бүргүндчүүд цэрэг зэвсгийн хүчээр тусалсан хэмээгээд аланы ноён Гоар, бүргүндийн Гунтиариус (Гундакар гэдэг нэрийг латинчилсан хэлбэр) нарын нэрийг дурдаж хүчин зүтгэсэн хэмээжээ. Энэхүү мэдээний уг сурвалж нь Египетийн Тебен хотоос гаралтай Гэрэгийн түүх туурвигч Олимпиодор гэгч онго шүтээнт хүн агаад тэрбээр Прискүсийн нэгэн адил өөрийн арвин мэдлэг туршлага, үзсэн харсан, дуулсан сонссонд дулдуйдаж явсан хүн юм. Жишээлбэл тэрээр 412-413 онд хүннүүдтэй явуулсан хэлэлцээнд өөрөө оролцож явжээ. Тиймээс өөрөө үйл явдлын дунд эргэлдэж явсны учир 411 онд болсон дээрх хэрэг явдлын хувьд алдаж осолдсон зүйлгүй нь тодорхой. Гагцхүү тэрхүү тэмдэглэл мянга мянган жилийн урт замыг туулсны учир хаан өргөмжилсөн дээрх хотын нэр бага зэрэг хувирсан мэт. Тэр үед ном хэвлэл гэж байгаагүй учир хэвлэлийн алдаа байж таарахгүй, харин хуулбарлах явцад гарсан

алдааны улмаас Майнц (*Майн мөрний хөвөөнөө орших Германы хот, өнөөгийн Райнланд Пфальц муж улсын нийслэл болой.*Орч.) хотын эртний нэр болох Могунтиакум хэн ч хэзээ ч сонсоогүй, өнөөдөр ч хаана байгааг нь мэдэхгүй Мундиакум болсон нь магад. Тэгвэл Майнц хот болон түүний ойр орчмоос бүргүнд гарлын цөөнгүй олдвор өнөө ч гарсаар буй. Тухайлбал зэр зэвсэг, бүргүндчүүдийн ид шидийн хүчтэй хэмээдэг бүсний толь, горхи, элдэв гоёл чимгийн зүйл олддог.

Онго шүтээнтэн, эсвэл лам хувраг хэн нэг бичмэрлэгч хуулбарламаар аядаж байтал нь ялаа шумуул дүнгэнэж яршиг удах юм уу, цонхны хажуугаар өнгөрөх бүсгүй хүн анхаарлыг нь сариниулснаас болж нэг үе алгассанаас Могунтиакум нь Мунтиакум болж “ог” нь гээгджээ хэмээн таамаглаж болно. Эсвэл Олимпиодорын эх бичвэр бүдэг бадаг, ойлгохын аргагүй зүйл Европт ирсэн байж ч болно. Учир нь уг бичвэрийг аварч бидэнд үлдээсэн Поттиос элчийн ажлаар Константинополиос Багдад руу явж байхдаа нарийн бичгийн даргаараа уг бичвэрийг хуулуулж авсан гэдгээ үнэнээр нь өчсөн байдаг. Есдүгээр зууны элчийн аян, бас тэгээд өнөөдөр ч нэг л эвгүй гэгддэг газраар өнгөрөхдөө ямар байдалд байсан нь ойлгомжтой.

Хуучны илгэн цаасан дээрх бичвэрүүд иймэрхүү хувь тохиол хийгээд аюул осол үзэж туулж байсны учир миний бие үсэг үсгээр нь нэгчбүрчлэн үзэж гэрэлд харж удтал шинжлэхийг үл түвдэнэ. Миний хувьд Ромын алдарт хот Майнц бүргүндчүүдийн өргөө хот Вормс хотын нэгэн адил хаан өргөмжлөхөд тохиромжтой газар байсан гэдэг нь тодорхой. Харин хөөрхий Гундакар тэртэй тэргүй өргөө хотоороо удаан бахархахгүй гэдэг нь тодорхой байсан бөлгөө.

Хүннүчүүд хурдан шаламгай, уурга бугуйл нь ончтой, олз омогт хэт шунамгай хэдий ч хэдэн мянган бүргүндчүүдээс цөөн ч болов хүн амьд үлдээх л учиртай байсан тул ийн тэд нь Райн мөрнийг өгсөн нүүдлийн цуваа хөдлөхөд ард түмэн гэхээр юмгүй ч ямар ч болов нэгэн овог байж Райн мөрний эрэг дагасан замдаа хүннүчүүдийн гол цохилтоос зайлж чаджээ. Гагцхүү эрчүүдийн олонхи тулалдаанд амиа алдсан энэхүү нүүдэл зовлон гачлангаар дүүрэн байжээ.

Женевийн нуурын эргэн тойрны уул нурууг дамнасан шинэ газар бууж дахин нэгдэж нягтарсан бүргүндчүүд үнэхээр гайхмаар, бараг л ер бусын ч гэхээр амьдрах чадвартай ард түмэн байсан ажгуу. Түүхийн тээрэмд хэмхчүүлж, аяны хөсгийн дугуйнд бараг л талхлуулаад дууссан олон ард түмний дундаас бүргүндчүүд л өөрийн онцгой эв дүй, арга чадлынхаа ачаар дахин өндийж сэргэсэн бөлгөө. Ийм гойд чадвар тэр бүр тохиодоггүй билээ.

Их сүйрлээс хойш хэдхэн арван жил өнгөрсний хойно бүргүндчүүд хууль цаазын бичигтэй болжээ. Чухамхүү энэхүү хууль цаазаас бүргүндчүүдийн сэргэн мандах үйл явц эх үндсээ авсан байдаг. Хууль цаазын бичиг бол ямар ч үндсэн хуулиас илүү ач холбогдолтой, энэ бол төр улсын бус, чухамхүү ард түмний амьдралыг тэр чигт нь багтаасан зүйл гэдгийг бид Моисейн үеэс мэдэх билээ. *Lex Burgundiorum* (Бүргүндийн хууль цааз)-д гар урчууд онцгой үүрэгтэй, тухайлбал эн тэргүүнд модоор дарх хийгсэд (Энэ талаар Сократес Схоластикос үнэнийг өгүүлсэн) болон төмрийн болон бусад дархчууд, урчуудыг онцгойлон авч үзжээ. Дархчууд дотроос бусад нь умрын дархан Вийланд (*Эртний германы Вийландын домгоос эхтэй Вийланд дархан нь Карл Симрок, Рихард Вагнер нарын баатарлаг туулийн нэг дүр болой.* Орч.) шиг бишрэн хүндэлж бас ч айж эмээдэг жинхэнэ мастерууд нь гайхалтай ид шидтэй бүсний горхи дархалдаг байсан аж. Эртний бүргүндчүүд ийм бүсийг хүнд ер бусын хүч өгдөг, ийм бүсгүй хүн ямар ч хамгаалалтгүй эмзэг байдаг хэмээн сүсэглэдэг байжээ. Энэ нь явсаар Нибэлүнгийн дуулал зохиогдох үеийг хүрч түүнд тусгагджээ. Хэдийгээр их Фридрих мэтийн зарим том судлаачид уран сайхны агуулгыг нь үл тоодог, урлагийн өөр хэв маягийг таашаадаг боловч чухамдаа бол эртний олон домог хуучийн нэг гол сэдэв болсоор ирсэн бүргүндчүүдийн дээрх сүсэг бишрэл нь энэхүү гайхамшигт найраглалын үнэ цэнийг улам өргөж байгаа зүйл мөн бөлгөө.

Бүргүндийн ард түмний аж амьдралтай холбоотой олон эд зүйл хадгалагдаж үлдсэнээс тэмдэглүүштэй нэг юм бол тэдний байшин хийгээд түүний хэлбэр дүрс болой. Тэд Райн мөрний сав газрын ой хөвчит нутагт сууж байхдаа модоор байшингаа барьдаг байсан бол харин шинэ эх орныхоо уул хөндийд (Женев нуур, Альпийн их уулсын нутаг) тэд хавийн уулсын чулуугаар (Ромчуудаас сурч авсан байж магад) байшин барьж суудаг болжээ. Байшингийн голд олон хүн нэгэн зэрэг суухаар төхөөрөмжлөгдсөн томоохон гал зуух байна. Бүргүндчүүдийн уугуул нутаг нь Балтийн тэнгисийн Борнхольм арал гэдэг нь лавтай болсон бөгөөд тэд өнө эртний тэрхүү үндэс язгуураасаа тасарч нүүж суун хаа холын газар ирсээр хагас мянган жил өнгөрсөн ч гал зах нь жинхэнэ герман маягийн том танхимын хэлбэрээ хадгалсаар байжээ. Зуухны дээр утааг тосч аваад дээш гаргах бүдүүн дүнзээр хийж чигжсэн яндан маягийн төхөөрөмж тасалгаа хийгээд байшингаас дээшээ тэнгэр рүү гардаг байжээ. Уг яндан маягийн төхөөрөмж нь хавхлагуудтай, шаардлагатай үед тэдгээрийг том багаар нээж хааж утаа гаргах, гэрэл оруулахыг зохицуулдаг байв. Энэ бүгд нь Ромын харьяанд орсон Герман оронд заншил болсон нарийн ширийн зүйлүүд байсан бөгөөд германчууд ромчуудын захиргаанд ороод удаагүй, хүний нэгэн үеийн амьдралын хугацаа л өнгөрч байсан хэдий ч тэднээс олон зүйл сурч авсан байв. Байшин барилгыг чулуугаар барьж байсан ч дархчууд нь модоор юм хийж байсан хуучин маягаараа сэтгэсээр байсныг

дээрх зуух яндангийн төхөөрөмж харуулна. Бүргүндчүүд хэдийгээр тэр чигээрээ шахам модчин, модны дархчууд байсан ч нэг л зүйлийг сурч аваагүй юм. Хэрвээ тэд Райн мөрний газар цайз шилтгээн барьж сууж байсан бол Гүнтэр, Зийгфрийд, Криймхильд нар хүннүчүүдийг дайран иртэл тэнд амьдарч байсныг нотлох үүднээс өнөө малтлага хийж болох байлаа...

4.

□□□□□□□□□□ □□□ □□□□□□ □□□□□□□□ □□□□□□□□ □□

Бүргүндчүүд хүннү нарын сүүлчийн аймшигт довтолгоонд өртөж хүйс тэмтрэгдэх үед Аттила хаан болоод наад зах нь хоёр жил болж байв. 434, 439 онууд түүний хаанчлалын хамгийн бүдэг жилүүдэд тооцогддог. Тэрээр энэ үеийн он дарааллын түүхэнд цухас тэмдэглэгдсэн зарим чухал шийдвэрээ чухам энэ үед гаргасан байх учиртай.

Тиймээс ийм нөхцөл байдалд тэрээр Вормсын бүргүндчүүдыг хэрхэх зэрэг жижиг асуудлаар хөөцөлдөхгүй нь тодорхой, тэднийг Райн мөрөнд бутцохисон тулалдааныг өөрөө удирдсан байж ч таарахгүй. Судлаачид “Аттила бүргүндчүүдийг дайлахад оролцоогүй, бүргүндчүүд ч түүний орд өргөө рүү дайраагүй” (Хомайер) хэмээн нэгэн дуугаар баталдаг ч бүрэн үгүйсгэж бас болохгүй.

Нибэлүнгийн дуулалд Аттила-Этцэль Вормс руу мордоогүй хэмээгээд харин бүргүндчүүдийг хүннү нартай уулзуулах учиртай байсан учир арай аятайхан хувилбарыг сонгож, бүргүндчүүдийг Дунай мөрнөөр дорно зүг явсан, тэнд чухамхүү түүхэнд тэмдэглэгдсэн Хүннүгийн хааны орд өргөө байсан, бүхий л улс орны элч төлөөлөгчид тийш явж байсан хэмээн дурджээ.

Европын голт зүрхийг дорно дахинтай холбож буй энэ их мөрнөөр хөлөг баатруудын хийсэн энэ аян дундад зууны Австрийн Бабенбергийнхний ордонд тэмдэглэгдсэн байх магадлалтай өгүүллийн гол үйл явдал бөлгөө. Тиймээс ч Вахау нутгийн алдарт дарсыг битүүхэн магталгүй өнгөрөөгүйг Пөхларнд (*Вахау нь Австрийн усан үзмийн дарсаараа алдартай газар агаад Дунай мөрний хөндийд байдаг. Пөхларн нь ч мөн адил. Орч.*) буудаллах үед хийсэн дайллага харуулна.

“Хатагтай Готелинде гурван ноёныг гурвуулыг үнсэв.

Охин нь ч мөн үнсэв. Хаген ноён ч тэнд байв.

Түүнийг ч мөн үнсэхийг эцэг нь тушаав. Охин түүний нүүр рүү харав.

Уг нь ч дуртайяа үнсмээр санж, даанч туйлгүй ичнэ.

Гэвч эцгийн тушаалыг биелүүлэхээс аргагүй болов.

Чингээд нүүр нь нэг цайж нэг улайв.

Дараа нь Данквартыг, эцэст нь дайнд алдраа дуурсгасан

Фолькер ноёныг ч хүндлэн мэндчилж үнсэв.

Ийн баатруудыг асар уужим танхимд урин залав.

Хөлөг баатрууд, хатагтай нар зоог барихаар сууцгаав.

Зочдод шилдэг сайн дарс бариулав.

Баатрууд үнэндээ ийм сайхан зочлолыг хэзээ ч үзээгүй бөлгөө.”

Эдгээр бадгууд бичигдэж байх үед Дунай мөрний өнө эртний учир холбогдол дахин тодорсон бөлгөө. Дунай мөрөн нь нэн эртнээс тэргүүн зэргийн ач холбогдол бүхий тээврийн зам байв. Энэхүү арвин уст өргөн цэлгэр мөрөн хөлөг онгоц явахад тун тохиромжтой учир Европын төвөөс Дорнод Ромын эзэнт гүрний төв хүрэх алс холын замыг харьцангуй хурдан, тав тухтай туулж болох байв. Дунай мөрнөөр явбал Альпийн уулсын асар их бартаа саадыг тойрон гарч чадна. Дунай мөрөн бол Райн-Аар-Рон мөрнүүдийг дамжих өрнийн тээврийн сүлжээг Оросын гол мөрнөөр дамжин Балтийн тэнгисийг Хар тэнгис, Газар дундын тэнгистэй холбосон дорнын тээврийн сүлжээтэй холбох ихээхэн хүчин чадалтай, хамгийн чухал зам байв.

Иймэрхүү зүйл нь зэрлэг зан заншил, байнгын цэрэг дайны үймээн самуун, их аян дайн, нүүдлийн тухай ханатлаа сонссон хүмүүст дэндүү хийсвэр, үл гүйцэлдэх зүйл мэт ойлгогдож болно. Гэвч худалдаа бол түүхийн хамгийн сонирхол агаад байнгын хэмжигдэхүүний нэг юм. Худалдаагаар амьдардаг хүмүүс бол манай төрөлтний дотроос хамгийн овсгоотой нь бөгөөд тэд морин цэрэг дайралт, ширүүн тулаанд ч үл ажран түйвээгдэж сүйтгэгдсэн тосгодын хооронд арилжаа наймаагаа тасралтгүй явуулж чаддаг улс болой.

Ямар ч болов ийм нөхцөл байдалд худалдаа саадгүй хөгжиж түүгээр ч барахгүй Ромын эзэнт гүрний нутагт арилжаа наймаа ихээхэн хэмжээнд хүрч байв. Тэр үед худалдаа өнөөгийнх шиг дэг журамтай явагдаж байгаагүй нь мэдээж. Худалдааны гэрээ хэлэлцээр голчлон худалдаа хийх нөхцөл, газар, аюулгүй байдлыг хангах заалтуудаар хязгаарлагдаж байсан агаад харин барааны тоо хэмжээ, төрөл зүйлийг зааж өгдөггүй байв. Бараа бүтээгдэхүүний солилцоог дайн үймээний үед ч хяналттай байлгах, тагнуул туршуулд ашиглуулахгүйн тулд зах зээл гаргах газар, цаг хугацааг зааж өгдөг байжээ. Гэвч өнөөгийн 633 сая хүн бус, их л бол хорин сая хүн амьдран сууж,

зогсолтгүй хөл хөдөлгөөнд өртөж, Ромын хилээс өөр тогтсон, хянах боломжтой хил хязгаар байгаагүй энэ тивд дээрх нь юу болох вэ дээ.

Ромын эзэнт гүрэн, ялангуяа түүний дорнод хэсэгт худалдаачин хүн өөрийн санаачилгаар томоохон талбарт үйл ажиллагаа явуулж, тухайлбал Сири зэрэг газарт томоохон худалдааны төвүүд ажиллаж байсан бол дорнодод, тухайлбал Хүннүгийн газар, Перст худалдаа нь чанд дүрэм журамтай байв. Перстэй явуулах худалдааны ажил үйлийг Нисибис, Артаксата юм уу Каллиникумаар дамжуулах журамтай, эхнээсээ чанд хяналттай явуулж байсан бол Хүннүгийн газар ноёдын гэр бүл алтны монополь эрх эзэмшиж, Аттила, Бледа нарын тушаал заавар, захиалгаас гадуурх улс хоорондын худалдааг хориглож байжээ.

Хувь хүний баяжиж хөлжих оролдлого, эсвэл дайны олз омгийг ашиг орлого олох зорилгод хэрэглэх явдлыг дамын наймаа хэмээн үздэг байсан агаад Аттила дамын наймаачид нь хүннү, алан, герман, тракий, ер хэн ч бай нэг их ёсорхоод байдаггүй байжээ. Гэсэн ч хүннүчүүд байнгын аюул ослыг үл тоон газар зүйн таатай байдлыг ашиглаж юуны өмнө агт морьд, мөн эр эм боолчуудыг нууцаар наймаалдаг байжээ. Боолчуудыг онцын бэрхшээлгүй олдог, мөн аян дайны үед олноор нь олзолдог байсан учир үнэ нь буурах, бүр унах ч явдал байжээ. Ийм цаг үед Ром, Византид найдвартай түнштэй хүн скифүүдийн шинэ бараа болох шар үст герман бүсгүйчүүд, халуун цуст черкесс хүүхнүүд, эсвэл уран гуалиг алануудыг хуваагдмал гүрний *(Ромын эзэнт гүрэн өрнөд, дорнод гүрэн болж хуваагдсаныг хэлж буй.Орч)* томоохон хотуудын боолын зах дээр гаргаж насныхаа хоолыг олоод авчих боломжтой байв. Ийм наймаанд зэрлэг овог аймгийн хүмүүсийг дол цохисон византи наймаачид хуурч шулах тохиолдол олонтаа гарч түүнийг нь бурхан багш нь өөгшүүлж сайшаах явдал байжээ. Тухайлбал гэгээн Амброзиус хуврагууддаа “Дайн тулаанаар давж барахгүй хүнийг мөнгө, ашиг орлогоор хууран давж өшөөгөө авч болно. Дайнд хүн алах нь гэмт явдал биш байдаг бол худалдаагаар шулж мөлжих нь ашиг л болохоос гэмт хэрэг биш” гэж тайлбарлаж байжээ. Миланы алдарт хамба шавь нартаа дээрх эргэлзээтэй удирдамжийг өгөхдөө юуны өмнө хүннүчүүдийг шулж мөлжихийг хэлсэн болов уу. Учир нь хүннүчүүдийн зарж борлуулж байсан эд бараа нь үндсэндээ бусдаас булааж авсан зүйл байсан агаад ийнхүү Дунайгаар дамжуулан тойруу замаар дамлан худалдаалсан хуучин ертөнцийн эд агуурс эзэддээ эргэн очиж байжээ гэж үзэж болох юм.

Аттила бэлэн мөнгө хийгээд алтны нааш цааш урсах хөдөлгөөныг өнөөдөр бараг төсөөлшгүй хэмжээгээр хянаж цагдаж чадсаны ачаар түүний захирсан хүннү үндэстэн онцгой байр байдалтай болсон байна. Иймээс ч хүннүчүүд улс оронд нь ирж буй элч төлөөлөгчдийн ая данг харьцангуй хялбар хянаж байх боломжтой болжээ. Хүннүгийн

бие хамгаалах цэрэгт хэн нэгэн алтан солидус атгуулах л юм бол хээл хахуулийн хэрэг мандахаар даруй түгшүүрийн харанга дэлддэг өнөөгийнхөөс ялгаагүй үйл явдал болдог байв. Мөнөөх цэрэг юуны төлөө, хэнээс мөнгө авав, өөр хэн ийм байдлаар худалдагдав гэх мэт бөөн юм болдог байв. Орчин үед ардчилал хийгээд хууль зүйн зарчмыг үнэнчээр мөрддөг цагдаагийн байгууллагын хувьд дээрх гурван асуудал шийдэхэд амаргүй байдаг бол хүннүчүүдээс хэн нэгэн ийм аминд халтай хэрэгт холбогдож ашиг орлого хөөцөлдсөн нь мэдэгдэх л юм бол Аттилагийн хувьд шийдэж ядах юмгүй, зандалчинд хурууны үзүүр юм уу харцаар дохиод л хангалттай байжээ. Аттилагийн амийг бусниулахыг завдаж Византийн засгийн газраас хийсэн зохион байгуулсан явууллага дээрхийн жишээ болж түүхэнд тэмдэглэгдэн үлджээ. Аттила авсаар тэртэй тэргүй олон дайсантай байсан Дорнод Ромын эзэнт гүрний нэг гол дайсан нь байсан юм. Аттила Дорнод Ром, Өрнөд Ромын алиныг эхэлж дайлахаа шийдэж ядан байсан тухай эртний ертөнцийн төгсгөлийн тухай Санто Маззариногийн хийсэн судалгаанаас уншиж болно. Дээд зэргээр иргэншиж соёлжсон дайснууд нь чухам хэн нь хэн болохыг маш нарийн судалж, хөдөх төрөлх мэдрэхүйдээ түшиглэн зөв үнэлж цэгнэж чаддаг зэрлэг овгийн удирдагчийн дүр төрх 435-449 оны үед нэлээд тодорч ирсэн байдаг. Ромын эзэнт гүрний цэрэг зэвсэг хийгээд хүн хүчний хувьд илүү сайн боловсорсон өрнөд хэсгийн аюулгүй байдлыг Хүннүгийн хөлсний цэрэг хангаж, бас тагнаж туршиж байв. Ромын эртнээс алдартай дайтаж тулалдах урлаг хийгээд арга барилыг ромын жанжнуудын удирдлага дор дасгал сургууль хийхээс илүү судалж мэднэ гэж юу байх вэ? Аймхай хулчгар левантинчуудын удирдаж, хоосон чалчаа яриа, цаг үргэлжийн хуйвалдаан явууллагаасаа болж эрч хүчээ алдаж доройтсон эзэнт гүрний дорнод хэсэг рүү хүннүчүүд үе үе шүдээ хавирч архирч сүрийг үзүүлэхэд л гоё ганган хувцас өмсч, ёслол хүндлэлийн журмыг бол нэвтэрхий мэдэх византийн бялангач этгээдүүд айн чичирч шинэ шинэ алба хийгээд бэлэг сэлт цуглуулах гэж тал тал тал тийшээ харайдаг байжээ.

Аттила 441-443 онд Дорнод Ромын гүрэнд ийн үе үе дээрмийн халдлага хийж ихээхэн сүр бадруулах бүрийд Босфорын дээрх Гэрэг-Сирийн саятнуудын хорооллынхон хүннүчүүдийн их довтолгоон эхэлж, өөрсдийнх нь мөхлийн цаг ирлээ хэмээн айж чичирч байв. 445 оны хавар өөр маягийн дохио византичуудыг ихэд айлгажээ. Аттила хамтран засаг баригч ах Бледагийн амийг өгүүтгүүлсэн бөгөөд чухам яаж гэдэг нь хэзээ ч тодорхой болоогүй юм. Тэгээд 447 онд хүннүчүүд дахин миегнэн хөдөлжээ. Тэр жил аймшигт үйл явдлаар эхэлсэн нь 1 сарын 27-ны шөнө дундаас хойхно газар асар хүчтэй хөдөлсөн явдал болой. Константинополийн их хэрэм цуурч зарим газраар нурж унажээ. Энэ хэрмийг нийслэл хотыг хуурай газраас халдан довтлох явдлаас хамгаалах зорилгоор 439 онд барьж дуусгасан байв.

Маргааш өдөр нь болоход хэдэн арван мянган хүн, түүнчлэн эзэн хаан өөрөө ард түмнийхээ нэгэн адил хөл, толгой нүцгэн нурж унасан хэрэм рүү очиж мөргөжээ. Дараа нь нэхүү баян чинээлэг хотынхон урьд хожид үзэгдэж дуулдаагүй ихээр хүчээ дайчилж нийтээр хүч хавсран их хэрмийг гуравхан сарын дотор сэргээн босгожээ.

Хэрвээ Аттилагийн туршуулууд Византид байсан бол тэд нь яг тэр үед ичээндээ унтаж хэвтсэн байж таарна. Гэхдээ хүннүчүүд тэнгэр бурханы таалал хийгээд газар хөдлөлтийн аль нь ч хэрэг болохгүй, зүгээр л ил задгай газар тулалдааны талбарт сурсан аргаараа үзэлцэх нь зүйтэй хэмээн тогтсон ажээ. Тийм учраас византичуудын тэрхүү ер бусын их чармайлт талаар өнгөрчээ. Ингээд шийдвэрлэх тулалдаан Константинополиос алсад тэр үеийн Үтүс, өнөөгийн Вит гол дээр болжээ. Энэ тулалданаар Дорнод Ромын цэргийн жанжин (Magister Militum) Арнегискуссын унасан хүлэг суманд оногдож, дараахан нь өөрөө алагджээ. Хүннүчүүд Ромын Балканыг нэлэнхүйд нь бүрэлгэж сүйтгэв.

“Хүннүгийн зэрлэг ард түмэн бүх хүчээрээ дайран ирж зуу гаруй хотыг булаан эзлэв. Константинополь ч өөрөө аюулд нэрвэгдэж, хүмүүс хотоос зугтан гарч эхлэв. Лам хуврагууд хүртэл Иерусалемыг зорьжээ. Хүн амьтныг олноор нь хядаж асар их цус урсгав. Алагдсан хүмүүсийн тоог гаргах хүн үлдсэнгүй. Тэд сүм дуганыг цөлмөн сүйтгэж лам, гэлэнмаа нарыг доромжлон хэлмэгдүүлж байлаа. Түүгээр ч барахгүй Дризиперагийн гэгээн Александрын сүмийг ч зүгээр орхисонгүй, үнэт эрдэнэс, эд зүйлийг дээрэмдэн авч явав. Урьд өмнө хүннүчүүд энэхүү ариун газрын ойр хавьд хэд хэдэн удаа үзэгдэж байсан ч ийм юм хараахан болж байгаагүй. Бурхны сүмд тэд хэзээ ч хөл тавьж зүрхэлдэггүй байсан юм. Тракий нутаг урьдын хөгжил цэцэглэлтээ дахин үзэхгүй, хэзээ ч сэргэхээргүйгээр айхавтар сүйджээ.”

Дорнод Ромын эзэнт гүрэн өнөөгийн Булгаарын нутагт Дунай мөрний урдаас цутгах Үтүс гол дээр хүннүчүүдэд бутцохигдсоноос хойш сэхэл авалгүй удаа дараалан ялагдсаар байсан тухай Каллиникус гашуудан тэмдэглэжээ. Хүннүчүүд ийнхүү Европын зүүн өмнөд үзүүрийг бүхэлд нь маш хурдан эзлэн авч зам харгүй бартаатай, уул нуруу ихтэй хэдий ч ажралгүй давж Газар дундын тэнгис болон Мармарын (*оросоор Мраморын тэнгис.Орч.*) тэнгисийн эрэг хүрчээ. Тэнгисийн эргийн Хераклеа хотоос Аркадианаполис орох зам дээр байдаг Александрын ариун газрыг сүйтгэсэн тухай мэдээ нь хүннүчүүд ромчуудын байгуулсан замыг даган явж байлдаж тулалдахыг илүүд үзэх болсныг харуулж буй. Каталауны тал нутагт болох улс түмний их тулалдааны талбар руу явах замд энэ нь онцгой үүрэг гүйцэтгэх болно.

Хуучин ертөнцийн Бабель (*Вавилон хотыг хэбрэй хэлээр ингэж нэрлэнэ.Орч.*) болох Визант (Константинополь) нөмрөн ирсэн мөхлийн аюулаас яаж ийгээд мултарч гараад алт эрдэнэсийн сангаа Аттилагаас мянган жилийн хойно ирсэн хүннүчүүдийн холын хамаатан түрэгүүдэд хадгалж үлдээсний учрыг хэрхэн ойлгох вэ? Венецийн өвгөн ноён Энрико Дандолого Константинополийг 1203, 1204 онуудад хоёр ч удаа байлдаж дагуулсан байхад Аттила өөрөө гол хүчээ удирдаж явсан атлаа амжилт ололгүй буцсаныг юу гэж ойлгох вэ?

Он дарааллын түүхчид үүний учрыг дээд тэнгэр болон далдын нууц хүчтэй холбон тайлбарлажээ. Газар хөдөлсөн нь нүгэл хилэнцдээ идэгдсэн хотод бурхнаас ногдуулсан гэсгээл байсан бол хүннүчүүдээс аврагдсан нь тэднийг дайран ирэхэд хотынхон эрэлхэгээр эсэргүүцэн тэмцсэний төлөөх шагнал юм. Византичууд мөнгөний шунал, чивэлт явдал, циркийн тоглоомонд хэт автаж их нүгэл үйлджээ. Харин хүннүчүүд Босфор орох замдаа христ мөргөлт ариун охид олныг бузарласны улмаас хүч чадлаа алдаж, бурхан тэднийг өвчин тахалд автуулсан гэх мэтээр тайлбарлажээ.

Мөнөөх өвчин тахал нь хүннүчүүдийн нутаг буцах шалтгаан болжээ. Аттилагийн удирдсан Хүннүгийн гол армийг гай гамшиг тойрон өнгөрсөн бололтой агаад учир нь хааны хараа хяналтын дор байсан болохоор сахилга сайтай, цэрэг дайчид сул чөлөөтэй хэсүүлчилж явдаггүй байсантай холбоотой байсан бололтой.

Хүннүчүүдийн эзэнт гүрэн тэр үед асар өргөн удам нутгийг эзлэн оршиж байв. Энэ гүрний нутаг үнэхээр Балтийн тэнгис хүрч байсан нь өнөөдөр тодорхой байгаа бөгөөд Британийн арлууд хүннүчүүдийн эрхшээлд байсан байж мэдэх, үгүй юм аа гэхэд алба барьж байсан гэж үзэх орчин үеийн түүхчид бий. Төв, Дорнод Европыг бүхэлд нь хамарч Кавказыг хүрч тогтсон энэхүү асар том эзэнт гүрэнд Византийн алтаар алба барих саналыг хүлээж авахад хүргэсэн маш олон үйл явдал тохиосон нь магад. Алтыг бол хурдхаан авчихаж болно, удтал бүслэн байлдаад ч алтнаас илүү юм олж авна гэж байхгүй. Константинополийг далайн талаас бүслэн усан замаар ирэх хүнс барааны хангамжийг нь таслах усан цэргийн флот хүннүчүүдэд байхгүй учир хотыг хурдан шуурхай эзэлж авна гэдэг нь огт бүтэхгүй ажил бөлгөө.

Константинополь бүслэлтээс гарахын тулд баахан мөнгө төлж, Аттила найман мянга гаруй фунт, өнөөгийнхөөр 2500 шахам кило алт аваад бүслэлтээ зогсоогоод нутгийн зүг жолоо залжээ. Тэгэхээр ийм их хохирол амсчихаад дахиад тавин фунт алт төлж Аттилаг алуулаад өгсөн бүх алтаа буцаагаад авчихаж болно хэмээсэн византийнхны наймаачны ухааныг буруутгаж болно гэж үү? Ийн мафич маягийн ухаан

сийлсэн хүн нь Хрисафиос хэмээгч тайган, энэ бүх түүхийг бидэнд өгүүлж буй хүн бол Византийн дипломат Прискүс болой.

“Эвийн гэрээ байгуулсны дараа Аттила дүрвэгсдийг буцааж өгөх шаардлага хүргүүлж Дорнод Ромын гүрэнд дахин элч заржээ. Ромейчууд элчийг хүлээж аваад бөөн бэлэг сэлт өгөөд дүрвэгсдээс үлдсэн хүн байхгүй хэмээн хариу өвөртлүүлээд буцаажээ. Тэгэхээр нь Аттила хоёрдахь элчийг илгээсэнд дорнод ромчууд түрүүчийнхээс дутуугүй бэлэг өгчээ. Аттила гуравдахь, дөрөвдэх элчийг явуулжээ. Аттила (эвийн) ийн ромейчүүдийн гэрээг зөрчигдөхөөс айхдаа арга ядсан өгөөмөр аашийг ханатлаа ашиглажээ. Тэгээд шинэ шинэ арга сэдэж элч илгээх шалтаг олж төрөл садан болон тал үзүүлдэг найз нөхдөөрөө элчүүдийг удирдуулдаг байв. Ромейчууд Аттилагийн хэлсэн болгоныг дагаж, хууль ёсны эзнийхээ тушаал лугаа адил хүлээн зөвшөөрч байв. Аттилад дахиад дайлаар ирэх шалтаг гаргачих вий гэхээс ихэд эмээж шившигтэйгээр бууж өгч байлаа. Дорнод Ромын гүрэнд өөр бусад бэрхшээл бишгүй байсан юм. Парфууд зэвсгээ хурцалж дайнд бэлтгэж байв. Вандалууд байсхийгээд л (хөлөг онгоцуудаараа) дайлаар ирж эрэг орчмын нутагт амар заяа үзүүлэхгүй байлаа. Изаурчууд (Өмнөд Анатолийн уулын ард түмэн) байнга дээрэм тонуул хийж, сарацинууд эзэнт гүрний дорнод нутгийг дахин дахин цөлмөж, этиопийн овог аймгууд дайнд бэлэн болчихоод аятай цагийг хүлээн сууж байв. Тиймээс зориг мохсон ромейчууд Аттилаг байдгаараа аргадаж тойлж байжээ. Харин бусад ард түмнүүдийг бол их цэрэг (шинэ) бэлэн болж, жанжин томилогдмогц дайлахыг бодож байв.”

Гэвч үе үе хэлэлцээ хийж шийдэх ноцтой асуудлууд гарч байсан учир энэ ажлыг хийх Европын хэмжээнд бодож сэтгэж ажиллах чадвартай хүмүүс ордондоо татаж авах шаардлага Аттилад тулгарсныг ойлгож болно. Ийм хүмүүсийн нэг нь Хүннүгийн язгууртан Эдекон байв.

“Дайнд алдраа дуурсгасан скиф (хүннү) хүн Эдекон шинэ элчүүдийг удирдаж ирэв. Түүнтэй хамт Саве голын Паннон нутгаас гаралтай ромей хүн болох Орестес мөн ирэв. Аетиус түүнийг зэрлэгүүдийн хаанд өгсөн юм. Энэхүү Эдекон эзэн хааны ордонд ирээд дүрвэгсдийн асуудлаар санал гомдлоо илэрхийлсэн Аттилагийн захидлыг гардуулав. Аттила дүрвэгсдийг даруй буцаан өгөхгүй, өөрийнх нь байлдан дагуулсан нутагт тариа ногоо тарихаа зогсоохгүй бол дайлаар ирнэ хэмээн заналхийлжээ. Аттилагийн хэлж буй тэрхүү зурвас газар нь таван өдөр явж туулах газар агаад Панноноос Тракийн Новае (Систоро) хот хүртэлх нутгийг эзлэн оршино.

Түүнчлэн Иллирийн зээлийн газрыг (*Худалдаачдын эд бараагаа дэлгэдэг жил бүрийн томоохон яармагийг хэлж буй.Орч.*) өнөө хүртэл Дунай мөрний эрэгт

ажиллуулж байсныг больж Аттилагийн байлдан дагуулж сүйтгэсэн Найссос (*өнөөгийн Сербийн Ниш хот.Орч.*) хотод гаргахыг хүсчээ. Энэ хот Дунайгаас урагш сайн аянчны хувьд таван өдөрчийн газар байдаг, хамгийн сүүлд байгуулсан гэрээгээр скиф (хүннүчүүд) хийгээд ромейчүүдын захиргааны нутгийг зааглах хилийн (шинэ) хот болгохоор заасан юм. Үүний зэрэгцээ маргаантай хэвээр байгаа асуудлуудыг хэлэлцэх элчийг илгээх, чингэхдээ түрүүчийн хүмүүсийг бус, харин консулын хэргэмтэй хүмүүс явуулахыг Аттила шаарджээ. Хэрэв Визант ийм хүмүүсийг хүннүчүүдийн гүрэнд илгээхээс болгоомжилж байгаа бол өөрөө тэднийг тосон очиж Сердик хотноо (Софи хот, Босфороос энэ хотод хүрэх сайн зам буй) хүлээн авч уулзаж болох байна гэжээ.

Эзэн хааныг Аттилагийн захидлыг уншиж дууссаны дараа Эдекон Вигиласын хамт гарч явав. Эдеконы эзнийхээ захидалд дурдсаныг нэмж тодруулан амаар тайлбарласан зүйлийг Вигилас орчуулжээ. Ингээд Эдекон ордны нөгөө хэсэгт эзэн хааны бамбай түшигч (хүндэт цол) Хрисафиост бараалхахаар явав. Хрисафиос бол хааны ордны хамгийн нөлөөтэй хүн бөлгөө. Ийн явж байхдаа тэрээр эзэн хааны ордны хээнцэр тансгийг гайхаж явжээ. Хрисафиостай уулзаж ярилцахад Вигилас Эдеконы тийн хааны ордны үзэсгэлэн төгс, гоёл чимэглэлийн сайхныг шагшин магтаж байгааг хэлмэрчлэн хүргэжээ. Хрисафиос хариуд нь хэрэв Эдекон хүннүчүүдээс салж ромейчуудтай нийлбэл өөрөө ч ийм баян тансаг ордон хийгээд их хөрөнгөний эзэн болж болно шүү хэмээжээ. Эдекон хариуд нь өөрөө хааны зарлагаас хэтрэхгүй, зөвхөн хааныхаа зөвшөөрлөөр л Византид ирж чадна хэмээн өгүүлжээ. Тэгэхээр нь мөнөөх тайган (Хрисафиос) Эдеконоос Аттила дээр ямар ч саадгүй орж чаддаг эсэх, өөрөө хэр зэрэг нөлөөтэй хүн болохыг нь асууж лавлажээ. Аттилагийн ойр дотнын итгэлт хүмүүсийн нэг гэдгээ Эдекон батлаад Хүннүгийн улсын хэд хэдэн сайн язгуурт хүмүүсийн хамт хааны биеийг хамгаалах үүрэг хүлээдэг тухайгаа ярьжээ. Тогтсон журмын дагуу хааны тухайн үед байрлаж буй өргөөний үүдэнд харуулд ээлжлэн гардаг тухайгаа ч дурджээ.

Чингээд мөнөөх тайган Эдеконд нэгэн маш чухал, тун ашигтай санал тавина, энэ тухай хэнд ч ярихгүй гэдгээ Эдекон андгайлах хэрэгтэй. Гэхдээ энэ тухай ярихад цаг, нөхцөл хэрэгтэй. Түүнийг Хрисафиосынд зоог барихаар ирэх үед энэ тухай ярилцъя. Гагцхүү Эдекон Орестес болон элч төлөөлөгчдийн бусад хүмүүсийг дагуулж ирэх хэрэггүй гэжээ. Ингээд тэд хэлмэрчийн туслалцаатайгаар харилцан үүрэг авч бие биедээ тангараг тавьж гар барьжээ. Тайган өөрийнх нь санал болгосон зүйл Эдеконд ямар ч аюул учруулахгүй, харин ч тун ашиг тустай болохыг, Эдекон эл саналыг зөвшөөрч хараахан чадахгүй байлаа ч бусдад задруулахгүй гэдгээ тус тус андгайлжээ.

Хрисафиос Эдеконд барьсан зоогийнхоо үеэр цаад санаагаа нээн ярилцжээ. Эдекон скиф орондоо буцаж очоод Аттилагийн амийг хорлоод Византид буцан ирж ромейчүүдтай нийлэх хэрэгтэй. Энэ үйлийг л бүтээх юм бол эд баялаг дүүрэн элбэг дэлбэг амьдралд умбах болно хэмээн Хрисафиос тайлбарлажээ. Эдекон түүний саналыг зөвшөөрч харин энэ хэргийг бүтээхэд мөнгө хэрэг болно. Эхлээд их биш, гэхдээ л уг хэрэгт туслуулах хүмүүст хувааж өгөх тавин фунт алт хэрэгтэй гэжээ. Тайган ч хэлсэн ёсоор мөнгийг даруй гардуулахыг завдсанд зэрлэгүүдийн элч (Эдекон) эхлээд өөрөө нутагтаа буцаж очоод элч төлөөлөгчдийн ажлынхаа талаар хаандаа тайлагнаж, тэгээд Вигиласаар дамжуулж алтаа хаагуур ямар замаар өгүүлэхийг хэлүүлье гэжээ. Аттила зарж явуулсан элч болгоноо буцаж ирснийх нь дараа ямар бэлэгтэй ирсэн, ромейчуудаас өөрт нь хэдий хэмжээний алт мөнгө явуулав гэдгийг сайтар лавлаж асуудаг заншилтай гэдгийг ч хэлжээ. Түүнчлэн ийм их хэмжээний алт авч яваагаа төлөөлөгчдийн бусад гишүүдээс нууж хааж авч явах аргагүй хэмээжээ.

Эдеконы тавьсан тайлбарыг тайган үндэстэй гэж үзэж зөвшөөрчээ. Зоогийн дараа тайган эзэн хаандаа даруй бараалхаж Аттилагийн аминд халдах асуудал хийгээд бодож төлөвлөсөн зүйлээ айлтгажээ. Эзэн хаан засгийн газрын дээд албаны түшмэлийг (*Magister officiorum*) мөн дуудуулж, зэрлэг аймгийн төлөөлөгчтэй тохиролцсон зүйлийн талаар дуулгажээ...Чингээд тэд удтал буурьтай хэлэлцэж ярилцсаны эцэст Вигиласаас гадна Эдеконыг дагуулж Максиминосыг явуулах нь зүйтэй гэж тогтжээ. Вигилас хэлмэрчийн дүрээр явж бүхий л нууц ажил явдал, үүрэг даалгаврыг гүйцэтгэхэд туслах үүрэг хүлээх бол Максиминос мөнөөх халдлагын тухай мэдэх ёсгүй, харин тэрээр сурвалжит гэр бүлээс гаралтай, эзэн хааны ойрын хүрээлэлд байдаг хүн учир элчийн маягаар явж эзэн хааны захидлыг Аттилад гардуулах нь зүйтэй гэж үзэв. Энэ тухай Аттилад бичгээр дуулгахаар (тэгээд ч Аттила консулын зиндааны хүн явуулахыг өөрөө шаардсан) болжээ.Тэгээд Максиминос ийнхүү элчээр явахдаа намайг (өөрөөр хэлбэл энэхүү тэмдэглэлийн эзэн Прискүсийг) хамт явахыг хүссэн юм. Ингээд бид зэрлэгүүдийн хамт замд гарч, газар мэдэх туршлагатай аянчин Константинополиос гараад арван гурван хоног явж хүрдэг Сердикад ирэв. Тэнд бид буудаллаад Эдеконыг дагуулуудтай нь оройн зоогонд урив. Нутгийн хүмүүс бидэнд хонь, үхэр өгсөн байв. Тэдгээрийг нядалж хоол унд бэлтгэж найрласан юм. Зоогийн үеэр зэрлэгүүд Аттила хаанаа магтаж, бид ч эзэн хаанаа алдаршуулж байлаа. Чингэж ахуйд Вигилас хүнийг бурхантай харьцуулж болохгүй, явж явж Аттила бол жир хүн, харин Теодосиус бол бурхан шүү дээ гэх ухааны юм хэлчихэв. Тэгтэл хүннүүд уурсан босон харайж байдал баахан эвгүй болов. Бид яриагаа тэр дор нь өөр зүйлд хандуулж тэднийг найртай үгээр тайвшруулж эвлэрэхийг хичээв.”

Прискүс энэ явдлын талаар дипломат маягаар ямар нэг дүгнэлт хийхээс зайлсхийсэн нь Ромыг бурхан заяат эзэнт гүрэн гэх нь хүннүчүүд овог аймгийн дээд удирдагчаа бурханчлан үзэх лүгээ адил ялгаагүй л төөрөгдөл гэдгийг гадарлаж байсных буй заа. Нарийн ярьвал эх нутгаасаа алс газар хүнд хэцүү дайн тулааны нөхцөлд зөвхөн хаандаа л найдахаас өөр аргагүй яваа хүннүчүүдийн ийнхүү Аттила хаанаа бурханчлан шүтэж буйг гүн ухааны гайхамшигт утга зохиол, боловсон сургууль соёл бий болгож, шашны төрөл бүрийн тогтолцооны асар их мэдлэг хуримтлуулсан Өрнө, Дорно гүрний ихэд иргэншиж соёлжсон ромчуудаас илүү буруутгах нь зүйд нийцэхгүй биз. Хүлээж аваад удаагүй байгаа христийн шашин нь ромчуудад II Теодосиусыг ч, ер энэ дэлхийн өөр хаан эзэн хэнийг ч бай бурхан гэж үзэх учиргүй гэдгийг сайтар ойлгуулсан байх учиртай байсан юм.

“Зоог өндөрлөх үеэр Максиминосоос Эдекон, Орестес нарт торгон хувцас хунар, энэтхэг газрын үнэт эрднийн чулуу зэрэг бэлгийн зүйл гардуулав. Ингээд Эдекон явж, Орестес бидэнтэй үлдсэний дараа Максиминос түүнийг ихэд магтаж, Эдеконыг Хрисафиосын зоогонд урьсан атлаа Орестесийг уриагүй эзэн хааны ордны түшмэлүүдийн алдааг өөрөө давтаагүйдээ ихэд сайрхаж байв. Энэ бүхний талаар бидэнд мэдэх юм байхгүй болохоор түүний эдгээр үгс сонин санагдаж асууж лавласан ч Орестес үг дуугүй босож явав. Маргааш нь бид энэ тухай Вигиласаас асуухад Орестест Эдеконтой яг адил шан хүртээхгүй гэдэг нь мэдээж. Орестес хэдий Аттилагийн нууцын бичээч ч гэлээ жирийн түшмэл хүн, харин Эдекон бол хүннүгийн язгууртан гарлын цуутай цэргийн жанжин, тиймээс Орестесаас дээгүүр зиндааны хүн гэдэг нь тодорхой шүү дээ хэмээн тайлбарлав. Дараа нь Эдеконд хэдэн үг хэлснийг бид ойлгоогүй. Өчигдрийн найрнаас Эдеконыг явсны дараа болсон ярианы талаар түүнд хэлэхэд тэрээр Орестест ихэд уурласан гэж Вигилас тайлбарлав.”

Энд дурдагдаж буй хоёр хүн сонин содон түүхтэй, хоёул эзэн хааны эцэг гэдгээрээ түүхэнд орсон хүмүүс бөлгөө. Орестес нь хүү Ромулус Аугустусыг Ромын эзэнт гүрний хаан ширээнд суулгасан бол Эдеконы хүү Одоакер түүнийг зайлуулж хаан ширээг нь булааж авсан хүн юм.

Прискүс өөрөө сайн мэдэхийн учир тов тодорхой түүх өгүүлж байгаа ч Германы түүхчид ард түмнүүдийн их нүүдлийн үеийн түүхэн гарамгай бодгалиудын нэг болох Одоакерыг Хүннүгийн үр сад байсан гэдгийг удтал хүлээн зөвшөөрөхгүй байсан юм. Эдекон хүннүгийн дээд язгууртнаас гаралтай, хаад ноёдын гэр бүлийн явцуу хүрээний хүн байсан гэдэг нь өдгөө ямар ч маргаангүй болсон агаад түүний гэргийн (нарын) тухай уламжлагдсан, Одоакерын эх нь чухам хэн байсныг тодорхойлоход түлхүүр болохоор мэдээ занги байхгүй учир Өрнөд Ромын эзэнт гүрнийг бутниргэсэн Германы

цэргийн жанжин энэ хүний судсаар ганц дусал ч болов герман цус гүйж байсан эсэх нь эргэлзээтэй хэвээр буй. Аттила Эдеконыг скирүүдийг захируулахаар тавьсан байдаг. Тиймээс тэрээр скирийн овгоос эхнэр авсан гэж таамаглаж болно. Скирүүд Эдеконы захиргаанд орсны дараа хэрүлчүүд, түрцилингүүдтэй нийлж хүчирхэгжсэн байдаг юм.

“Найссос (Ниш) хотноо ирэхэд (сүүлчийн дайнаар) дайсанд эзлэгдэж сүйдсэн учир эзгүйрсэн байв. Сүм хийдээс ажиллуулсан эмнэлэгт хэд хэдэн өвчтөн үлдсэн байв. Гол өгсөж жаахан цаашлахад хоосон газар тааралдаж эрэг дээр амь үрэгдсэн хүмүүсийн яс овоорч байхыг харав. Дараа өдөр нь бид Найссосоос холгүй ... Иллирт суулгасан цэргийн захирагчтай уулзав. Бид түүнд эзэн хааны захиа даалгаврыг уламжилж, олзогдсон арван долоон хүнээс (Аттила тэдгээрийг оргодлууд хэмээсэн) хүннүгийн талд тушаах таван хүнийг авч явав. Цэргийн захирагч тэдэнд сайныг ерөөгөөд бидэнд өгч явуулав.”

Элч төлөөлөгчид аяны хүчир замыг туулаад Хүннүгийн хааны гэр хүрээнд хүрэлцэн иржээ. Аттила Сердикад тосч уулзсангүй ажээ. Тэднийг Аттилагийн хүрээ харагдахааргүй газар буулгасан байна. Дорнод гүрний ромчууд оргодлуудыг бүгдийг буцааж өгөхгүй байгаагийн улмаас хүчээр гаргуулж авахаар шинэ аян дайнд бэлтгэж буй учир Аттилагийн хүрээ рүү ороход хэцүү болжээ. Хэрэг явдлын нарийн учрыг мэдэх ганц хүн Вигилас зорьсон хэргээ бүтээлгүй буцах болох нь гэж айж байв.

“Вигилас урьд Анатолиусын удирдсан элч нарын бүрэлдэхүүнд орж явахдаа Аттилатай сайн танилцсаны учир түүнтэй уулзаж ярилцах боломж гарсан бол ромейчуудын эсрэг аян дайн хийхийг нь ятган болиулж болох байсан юм хэмээж байв. Түүнчлэн Эдекон ч түүнд сайнаар ханддаг гэж ярьж байв. Үнэн хэрэгтээ тэрбээр элч төлөөлөгчид хийгээд жинхэнэ хийгээд хуурмаг яриа хэлэлцээгээр халхавчлан Аттилаг хорлох ажиллагааг аль болохоор шавдуулах, Эдеконы хахуульд хэрэглэх, хуйвалдагчдад хувааж өгөх алтыг авчруулах арга замыг олохыг хичээж байсан ажээ. Гэвч сэдсэн хэрэг нь аль хэдийнээ илэрч баригдсан гэдгийг Вигилас огт мэдсэнгүй. Эдекон Константинополиос ирэнгүүтээ хаандаа нууц хуйвалдааны төлөвлөгөөг дэлгэж, түүнийг хэрэгжүүлэхэд зориулж хойноос нь илгээх мөнөөх алтны тухай айлтгасан байна. Эдекон Византид байхдаа л тайганы саналыг зөвшөөрсөн дүр үзүүлсэн, аль эсвэл Аттилагийн нууцын бичээч (Орестес) нь Эдекон, тайган хоёр итгэмжлэн ярилцсаныг олж мэдсэн, тэгээд Аттилад хошуу хүргэж мэдэх нь гэдгийг зам зуур Орестестай маргалдаж байхдаа ойлгосны алин болохыг би өнөө хүртэл (дурсамжаа тэмдэглэх үе) баттай хэлж чадахгүй.”

Гэхдээ хойноос нь илгээх алтыг хэрхэн тээвэрлэх талаар Эдеконы өгсөн заавар зөвлөлгөө нь тэрээр Аттилагийн амь насанд халдах төлөвлөгөөг зөвшөөрсөн дүр эсгэснийг харуулж байгааг хэлэх хэрэгтэй. Хахуульд өгөх алтыг хүннүгийн газар аваачихын тулд огт шаардлагагүй атал зориуд түвэгтэй зам сонгосон нь Византийн энэхүү төлөвлөгөөг илчлэх баттай нотолгоо болгох л зорилго агуулсан мэт байна. Энэ нь юуны өмнө Аттилагийн авсан арга хэмжээнээс харагдаж буй.

“Бид ачаа бараагаа бөхлөөд замд гарахад бэлэн болоод байтал өнөөдөр цаг нэгэнт орой болсон учир замд гарах хэрэггүй хэмээсэн тушаалыг Аттилагийн элч хүргэж ирэв. Бас өөр хүннү хүмүүс Аттилагийн бидэнд илгээж буй шар үхэр болон баахан загасыг хүргэж ирэв. Бид хоол унд идээд унтахаар хэвтэв. Маргааш өглөө Аттила зөөлөрч аятай хандах байх гэж найдаж байлаа.”

Байдал ингэж эргэсэн учир Прискүс элчүүдийг ямар ч байсан Аттилад бараалхуулах хэрэгтэй гэж үзэж өөрөө нарийн арга сэджээ. Тэрээр Аттилагийн итгэлт хүн Скоттатай уулзаж түүгээр уламжлуулан зорьсноо бүтээсэн аж. Энэхүү Скоттагийн ахад II Теодосиус Элчин сайдын алба санал болгож байсан нь алдар нэр, эд баялагт хүрэх онцгой боломж олгож буй хэрэг байсан юм. Энэ байдал ромчуудыг Аттилад бараалхуулах Скоттагийн хүчээл зүтгэлд тус болжээ. Дараах мэдээ бол Хүннүгийн хааны тухай туурвигдсан нийт зохиол бүтээлээс Аттила уг хувь хүнийх нь мөн чанар, ажил үйлтэй нь холбон дүрслэн үзүүлсэн цорын ганц жинхэнэ эх сурвалж, боломжийн дэлгэрэнгүй тэмдэглэл болой.

“Би яаран буцаж ирээд Вигиласын хамт сэтгэл зовнин холхиж байсан Максиминост цаашид хэрхэхийг ятган таниулж Скоттатай ярьсан тухайгаа хэлэв. Тэгээд Хүннүгийн хаанд барих бэлгээ бэлтгэх, айлтгаж ярих зүйлээ цэгцлэхийг зөвлөв. Тэр хоёр өвсөн дээр хэвтэж байснаа тэр дороо босон харайж миний овсгоо гаргасныг сайшаагаад замд гарахыг завдаж байсан хөсгөө зогсоов. Тэгээд Аттилад яаж хандах, эзэн хааны бэлэг болон Максиминосын өөрийнх нь бэлгийг ямар дарааллаар барих талаар зөвлөлдөв. Ийнхүү бэлтгэж байх хооронд Аттила биднийг хүлээж авах болсон тухайгаа Скоттагаар дамжуулан хэлүүлжээ.

Бид зэрлэгүүдийн чанд харуул хамгаалалт бүхий Аттилагийн өргөөг зорив. Биднийг ороход Аттила модон сэнтийд морилж байв. Бид түүний өмнө жаахан зайтай зогсож байв. Максиминос урагш алхаж Хүннүгийн хааны амгаланг эрээд эзэн хааны захидлыг гардуулж мэндчилгээг уламжлаад сайны ерөөл айлтгав. Аттила хариу талархал хүргээд ромейчуудад мөн сайны ерөөл айлтгав. Тэгснээ шууд Вигиласыг элдэв муу үгээр дайрч ичгүүргүй мал хэмээгээд Хүннүгийн бүх урвагч оргодлыг буцааж

өгсөн цагт л элч ирүүлэх тухай Анатолиостой тохирсныг мэдсээр байж яах гэж ирэв хэмээн загнав. Ромейчуудад скифийн ганц ч оргодол үлдээгүй, бүгдийг буцааж өгсөн гэж Вигилас хариулав. Аттила улам ч хилэгнэн Вигиласыг хараалаар булж, элчийн халдашгүй эрх гэж байдаггүйсан бол түүнийг шазруун агаад ичгүүр сонжуургүй үг хэлснийх нь төлөө загалмайд тэлж нохой шувууны хоол болгохсон хэмээн занав. Тэгээд ромчуудын газар өдий төдий урвагч оргодлууд байгаа гээд нэрсийг нь уншихыг бичээчид тушаав. Дараа нь Эслатай хамт яаралтай хөдөлж ромчуудаас аль дээр Карпилиогийн үед ромейчуудад очсон скифийн бүх дүрвэгсэд оргодлуудыг нэн даруй буцааж өгөхийг шаард хэмээн Вигиласт тушаагаад өөрийнх нь харьяат албат нар бие биеийн эсрэг байлдахыг тэвчиж байж чадахгүй, та нар тэдэнд хил хамгаалах ажлаа даатгасан ч тэд нэмэр болохгүй ээ. Миний бие танай хил хязгаарыг бусниулж эвдлэн сүйтгэхээр нэгэнт шийдсэн л бол ямар ч хана хэрэм тус болохгүй хэмээв.”

Карпилио бол Хүннүгийн хааны ордонд хэдэн жил барьцаанд суусан, мөнөөх Аетиусын хүү мөн гэдгийг бид мэднэ. Энэ нь 440 оноос өмнөх явдал юм. Аттила найман жилийн өмнө оргож зайлсан хүмүүсээ захиргаандаа эгүүлэн оруулж асуудлыг бүрмөсөн шийдэхийг боджээ. Тэрээр Өрнөд Ромтой яг адил арга хэрэглэж сул дорой гүрнээ байлдах чадвар сайтай харийн цэргээр хамгаалуулах гэсэн Дорнод Ромын гүрний башир санааг тас цохихыг шийдсэн ажгуу. Оргож дүрвэсэн хүн их олон, эсвэл цэргийн дарга нар зэрэг чухал хүмүүс байгаагүйсэн бол Аттила ингэж өөрөө хөөцөлдөхгүй байсан нь лавтай. Атилагийн эзэнт гүрэн өнөө ч зарим хүний үзсээр байдгаас илүү сайн зохион байгуулалттай байсан агаад наад зах нь л гэхэд хээрийн цагдаагийн ангитай байжээ гэдэг нь хааны буцаан авах хүмүүсийн нэрсийг жагсаачихсан байсан явдал харуулна. Зэрлэг овог аймгуудын эмх замбараагүй сүрэг гэсэн ойлголт байж огт таарахгүй, нүүдэлчдийн болхи, салан задгай байдал ноёрхож байгаагүй, харин сайн зохион байгуулалт бүхүй хайр найргүй дарангуйллын дэглэм байсан нь харагдана.

“Дараа нь Аттила ямар бэлэг авчирсныг сонирхов. Бид түүнд бэлгээ бариад байрандаа буцаж ирээд үзсэн, сонссон зүйлээ хэлэлцэж ярилцав. Өмнөх элчийн айлчлалын үед өөрт нь найрсаг хандаж байсан Аттила энэ удаа түүнийг харааж загнасанд Вигилас тун эмзэглэж байв. Тэрээр надад бүүр сүүлд ярьснаас үзэхэд тэрээр Атилагийн аминд халдах хуйвалдаан илэрсэн байж яавч таарахгүй гэж бодож байсан, тиймээс яагаад ингэж харааж зүхсэний учрыг үнэхээр мэдэхгүй байсан бололтой. Учир нь Эдекон өөрөө үг алдахгүй гэдгээ андгайлсан, тэгээд ч Аттилаг алах хуйвалдаанд оролцсон нь илрэх юм бол тэр өрөө цаазын ял авна гэдгээ сайн мэдэж байсан ажгуу.

Ийн бид эргэлзэн тээнэгэлзэж зөвлөлдөж суух үед Эдекон орж ирээд далим гарган Вигиласыг хажуу тийш дуудаж аваачив. Тэгэхдээ хахуульд өгөхөөр бэлтгэсэн

алтаа авчруул гэж тушаасан ажээ. Дараа нь бид Эдекон юу ярьсныг Вигиласаас асуусанд өөрөө аль эрт хуурагдчихаад байсан тэр нөхөр дүйвүүлж өнгөрөөх гэж оролдов. Энэ хооронд өөр нэг элч ирж Вигилас ч, элч бид нар ч олзлогдсон ром хүмүүс болон боолчууд, мөн агт морь худалдан авахыг хориглосон Аттилагийн тушаалыг дамжуулав. Харин өдөр тутмын хэрэгцээний хоол хүнсний зардлыг өгнө гэв.”

Энэ бол Эдеконы Хрисафиосын өөдөөс хараад сууж байхдаа онц хурдан сэтгэж айхтар тооцоолсон мөнгө олох арга, гаргууд ажиллагаа байлаа. Харин уг ажиллагаа бүтэх эсэхээс Эдеконы гавьяа шагнал хүртэх үү, аль эсвэл Аттилагийн гойд дуртай цаазын арга болох загалмайд тэлэгдэж үхэх үү гэдэг нь шууд хамаарч байв. Ингээд Византийн элчүүдийг сайтар цагдаж манахыг чандлан тушааснаар занга бэлэн болжээ. Ингэхээр хааны өргөө буй хүрээний ойр орчим ямар ч харь хүн их хэмжээний алт авч явах нь Зүүн Берлиний Нева нэртэй уушны газар долларын дэвсгэрт гаргаж ирж төлбөр хийх юм уу, хэн нэг жуулчин Лениний бунханд орчихоод “Камель” янжуур гаргаж асаахын дайтай харагдах нь тодорхой. Ийнхүү хөөрхий Вигилас өөрийгөө алуурчинд барьж өгөх л гэж ийнхүү алс зам туулсан болж таарчээ.

“Вигилас Аттилагийн байгаа газар иртэл түүнийг харуулдаж байсан зэрлэгүүд бүслэн авч Эдеконд өгөхөөр авч явсан алтыг нь хурааж авчээ. Тэгээд Аттилагийн өмнө авчрахад тэрээр Вигиласаас яах гэж ийм их алт Хүннүгийн гүрэн улсад авчирсны учрыг асуув. Энэ алтыг хоол хүнс, агт мориор гачигдах юм уу, ачилгын морь мал хол замд эцэж туйлдсанаас болж элчийн үүрэгт ажлаа биелүүлж чадахгүй болуужин хэмээн болгоомжилж өөрт болон дагалдах хүмүүстээ зориулан авч гарсан юм. Түүнээс гадна энэ мөнгөний нэг хэсгээр нь олзлогдогсдыг зольж авах гэж байгаа юм. Хүннүчүүдын гарт орсон төрөл садны хүмүүсээ зольж авахыг маш олон ромчууд мөргөн гуйсан хэмээн Вигилас өчив. Тэгтэл Аттила айхавтар хилэгнэж Вигилас руу давшилж гарлаа. Муу ичих нүүрээ барсан мал чи бүр даварч гүйцэх шив. Арга залиараа шийтгэлээс мултарна гэж бодвол санасны чинь гарз. Авч яваа мөнгө чинь чиний болоод танай хүмүүсийн хоол унд, орон байрны зардал сүйтгэл болоод агт морь, уналга, ачлагын мал худалдаж авахад бардаагаар хүрэлцээд цаана хамаагүй илүү гарахаар байна. Олзны хүмүүсийг зольж авахад ч ялгаагүй. Тэгээд ч би тэр зольж авна барина гэдгийг чинь нэгэнт хориглосон гэдгийг чи мэдэхгүй л байна уу гэж загнав. Тэгээд Вигиласыг яах гэж ийм их алт авчирснаа хүлээхгүй бол бие хамгаалагчдаа тушаал өгч эцгийгээ дагаж зэрлэгүүдийн оронд анх удаа ирсэн хүүг нь (Дипломатын халдашгүй эрх ямба эдлэхгүй байсан бололтой) цавчин алуулах хуна гэв. Хүүд нь үхлийн аюул заналхийлж байгааг үзээд тэрбээр нулимс асгаруулан ямар ч гэм буруугүй хүүхдийг өршөөн соёрхож, оронд нь өөрийг нь цаазлахыг Аттилагаас гуйвж гувшив. Тэгээд Эдекон болон гол нь Хрисафиостай нийлж хуйвалдаан зохиосон, тэрнийг нь эзэн хаан хөхиүлж

сайшаасныг даруй нэгд нэггүй илчлээд хүүг нь суллан явуулж оронд нь өөрийг нь алахыг сөгдөн гуйж мөргөв. Хэргийн учир явдлыг Эдеконоос нэгэнт сонсч мэдсэн байсан болохоор Вигиласыг энэ удаа үнэнээ хэлж байгааг Аттила ойлгов. Тиймээс Вигиласыг гавлан хорих, хүүд нь эцгийгээ зольж авах тавин фүнт алт авчрахыг тушааж Визант руу явуулахаар болов. Мөн Орестес болон Эслаг ромейчууд руу элчээр илгээв. Хрисафиос болон эзэн хаантай уулзахдаа Вигиласын алт хийж ирсэн (хоосон) уутыг хүзүүндээ зүүж очихыг Орестест тушаав. Тэгээд Хрисафиосоос энэ уутыг таньж буй эсэхийг нь асуухыг мөн тушаав. Эслад тушаасан нь: Уг нь Дорнод Ромын гүрний эзэн хаан Теодосиус сурвалжит язгуур угсаатай нэгэн, Аттила ч мөн сайн язгууртай, эцэг Мүндзүхийн язгууртны хэргэм зэргийг залгаж өндөрт өргөн авч яваа хүн. Гагцхүү Теодосиус өөрийн хөнгөмсөг ааш, болчимгүй үйлээс болж өвлөж авсан язгууртны хэргэм зэргээ алдаж Аттилад алба барих үүрэг хүлээж түүний хараат болсон хүн. Гэтэл хараат албат нь байж хувь заяаны эрхээр эзэн нь болсон хүний амь насанд халдахыг завдаж, атгаг санаат урвагч боол лугаа адил аяглаж байгаа нь даанч жигшмээр хэрэг. Иймээс Хрисафиос тайганыг хийсэн хэргийнх нь зэмийг эдлүүлэхээр ирүүлж байж л өөрийнх нь амь насанд халдахыг завдсан гэмээ цагаатгах болно хэмээжээ. Хааныхаа ийм илгээлтийг өвөрлөн мөнөөх хоёр хүн Константинодолийг зорьжээ.”

Башир арга мэх зохиохдоо гаргууд византичууд энэ удаа зэрлэгүүдэд ийн айхавтар хууртагдсан явдал Дорнод Ромын улс төрийн бодлогын домог болсон эв дүй, уран чадварыг нотлон харуулах нь юу л бол. Аттила ийнхүү сэтгэл ханав. Барьцааны шинэ хүнтэй болж, зүй ёсоор хурааж авсан зуун фүнт алттай болов. Хрисафиос үүсгэсэн хэргээ бүтэлтэй болгох гэж ихэд хичээснээс тохирсон алтаа нэг нугалж явуулсан нь түүнд зол болжээ. Дээр нь Вигиласыг зольж авах тавин фүнт алт нэмэгдэнэ. Энэ нь алтны дон туссан Аттилагийн хувьд ч маш их алт байв. Гэвч мөнөөх хуйвалдаан Аттилаг голд нь ортол гомдоосон, хүнд доромжлол гэхээр явдал байв. Мөн хоёр талын дайнаа зогсоох тухай тохиролцоог зөрчсөнөөс ялгаагүй хэрэг байв. Гэхдээ Хүннүгийн эзний хувьд энэ явдал уур цухлыг нь хүргэхээсээ илүүтэй зугаатай байсан юм. Визант Аттилатай эвлэрэх гэж байдгаараа хичээх нь тодорхой байв.

Би энэхүү хожмын Византийн дипломат ажиллагааны “эрхэм дээж”-ийн тухай ийн нуршаад байгаагийн учир нь Прискүс бол энэхүү үйл явдлыг нүдээр үзсэн гэрчийн хувьд чухам юу болсон гэх мэтээр учрыг ухаж ойлгоход үнэлж баршгүй тус дэм болж буйд юм. Түүнээс бус хожмын үеийн эрдэмтэн мэргэд хэрхэн үзэж байсан, эсвэл юу гэж үзэхийг хүсч байсан нь бидэнд сонин биш юм. Нөгөөтэйгүүр дээр дурдсан үйл явдал ромчуудын зэрлэг бүдүүлэг хэмээн нэхэл хатуутай нэрлээд байгаа хүннүчүүдийн тухай хэд хэдэн нарийн нягт мэдээ өгч буй юм. Ромын хоёр эзэнт гүрний дотоодод ховордсон элдэв нүгэлт үйлийг хүннүчүүд үйлддэг байсан хэдий ч тэд зарим муу муухай гэхээр

юмыг огт хийдэггүй байсныг тэмдэглэх хэрэгтэй. Эдекон хорхой хүргэм их эд баялаг, материаллаг соёлын хээнцэр тансаг орчныг анх үзэж буй хүн гэхэд юм үзэж нүд тайлсан хүний байдлаар огт тоогоогүй, ов мэхт дайсан этгээдийг чулуу хөөлгөхдөө биширмээр тайван хандсан нь тэмдэглүүштэй явдал мөн. Хүннүгийн өөр нэг хэргэмтэн болох Эсла нь эмзэг нарийн хэрэг явдлыг зохицуулах үүрэг хүлээсэн элчээр ажиллаж байсан нь эх сурвалжаас мэдэгддэг бөгөөд бидний мэдэхээр тэрбээр Хүннүгийн хаан Ругилагийн үеэс наад зах нь арван долоон жилийн турш энэ албыг хашиж иржээ. Гуравдахь этгээд болох Скоттагийн ах византичуудаас Константинопольд Элчин сайдаар суухыг санал болгож, тэрээр тэнд суувал зөвхөн өөрийн эзэн, өөрөөр хэлбэл Аттилагийн тушаал зааврыг л зөвхөн биелүүлэх болно шүү дээ гэсэн санаа илэрхийлсэн ч тэрбээр татгалзаж, Хүннүгийн хааны ордонд зөвлөхийн албаа цаашид ч хаахыг илүүд үзнэ хэмээжээ. Түүнчлэн олзлогдоод хүннүгийн газар олон жил суусан гэрэг хүн (Орестес) яагаад Ромын эзэнт гүрэндээ буцаж очихыг хүсээгүй тухайгаа Прискуст ийн тайлбарлажээ.

“Би уг нь Гэрэгт төрсөн хүн. Дунай мөрний дээрх нэгэн хотод чинээлэг худалдаачин байлаа. Тэнд би баян эхнэр аваад он удаан жил амьдарч байгаад хүннүчүүдийг хотыг байлдан эзлэхэд хамаг юмаа алдсан хүн. Зэрлэгүүдийн заншлаар язгууртнууд олзны хүмүүсээс шилж авах эрхтэй байдаг. Тэгээд би байдаг юмтайгаа Онегесиуст (дээр дурдсан Скоттагийн ах) очлоо. Сүүлд би ромейчууд болон акацируудтай хийсэн тулалдаанд сайн байлдсан учир шагнагдаж, олзноос өөрт ногдсон хувийг эзэн Онегесиустаа өгсний хариуд тэрээр намайг суллаж эрх чөлөө олгосон юм. Тэгээд би зэрлэгүүдээс эхнэр авч хүүхэдтэй ч боллоо. (Хааны зөвлөх буюу сайд) Онегесиус аливаа найр хуримандаа намайг тогтмол урьдаг. Надад энэ амьдрал маань урьдынхаас илүү таашаагддаг. Хүннүчүүд бол дайн тулааны хамаг л хүнд хүчир хийгээд аюул ослыг давсны хойно бол юу ч хийхгүй, ямар ч яршиг түвэггүй, эрх чөлөөтэй амьдардаг улс. Тэгэхийн цагт хүн бүр эрэлхэг баатарлагаар байлдаж тулалдсаны үр шимээ үзэж тааваар амьдарна. Үүнд нь хэн ч саад хийхгүй, түвэг удахгүй. Ромейчуудын хувьд бол (өөрөөр хэлбэл ялагдсан тал) тэд дайнд хялбархан амиа алдана. Тэд хамаг итгэл найдвараа цаг үргэлж бусдад тохоож, өөрсдөө зэвсэг барин үзэлцэж зрхэлдэггүй улс шүү дээ. Тэд хэзээ нэгэн цагт зэвсэг барьж өөрсдийгөө хамгаалахаар үнэхээр тулалдах юм боллоо гэхэд бүтэлгүй туршлагагүй удирдагчдынхаа аймхай хулчгарын балгаар ноцтой аюул эрсдэлд ордог юм даа. Энх цагт бол (Дорнод Ромд) албан татварын бөөн дарамт болон увайгүй шаарнуудын цаг үргэлжийн элдэв явууллагаас болоод ажил явдал бүр ч тусгүй байдаг. Баян чинээлэг этгээд, нөлөө бүхүй хүчирхэг томчууд хууль зөрчлөө гэхэд шийтгэл хүлээж, төлбөр торгууль төлнө гэж байхгүй. Харин арчаа муутай ядуу хүн чингэвэл сунжирсан урт мөрдөн байцаалтын ажиллагааг даалгүй энэ хорвоог сайн дураараа орхидоггүй л юм

бол хуулинд заасан шийтгэлийг заавал хүлээнэ. Ромын эзэнт гүрэнд хууль цаазыг мөнгөөр худалдан авч байгаа нь хамгийн муухай явдал болой. Хэрвээ шүүгч болон шүүхийн түшмэлүүдэд авлига атгуулаагүй л бол хохирогсдод хуулийн зүгээс ямар ч хамгаалалт байхгүй.”

Тавдугаар зуунд амьдарч, харь улсын хааны хүрээний нэгэн мухар гудманд тохиолдлоор учирсан хүний өгүүлсэн дээрх зүйлийн учир холбогдлыг зөвөөр ойлгож, өөрөө Дорнод Ромын төрийн үнэнч түшээ явсны хувьд Дунайн хотын мөнөөх худалдаачнаас огт өөр санаа бодолтой байсан хэдий ч улс төрийн илтгэл айлтгалдаа дээрхийг зориуд дурдаж оруулсан Прискүст талархавч баршгүй, мэхийн хүндэтгэхгүй байх аргагүй. Тухайн үеийн гэрчийн дээрх үгс нь түүхийн хийгээд төрийн гүн ухааны ямар ч урт мэтгэлцээнээс илүүтэй Ромын гүрэн, түүний дорнод хэсэг яагаад тийм сул дорой байв, хүннүчүүд түүний дэргэд яагаад ийм хүчтэй байсан, византичууд өөрсдөө хойш сууж хамаг итгэл найдвараа түшмэг цэрэгт тавьж байхад хүннүчүүд юуны учир хаан эзнийхээ төлөө амь биеэ золиосолж байваа гэдгийн учир начрыг тодруулж өгч байна. Цагийн байдал үймж дайвж тодорхой бус болоход дайсагнагч улсуудаас зөвхөн удирдлага жолоодлого сайтай тал нь л ямар ч болов хүчиндээ илүү итгэлтэй байдаг. Энэ бол маргашгүй үнэн бол мөн өөр нэг үндсэн зарчим (максима) ч мөн л бултаж булзахын аргагүй үнэн болой. Энэ бол байлдан дагуулах их аян дайн явагдаж цэрэг армиуд нааш цааш зай завсаргүй цувж буй үед энх цагийн ажил үйл үүсгэж түүндээ хамгийгаа зориулж буй хүн бол тэнэг хүн, тэрээр хэзээ ямагт хохирч үлддэг. Учир нь түүний ажил үйл, амь насны аль нь ч баталгаагүй, харин цэрэг дайчин хэвээр байж, хэдийгээр амь нас нь хутганы ирмэгт явдаг ч мөнөөх худалдаачны насаараа зүтгээд олохгүй их олз омгийг нэг амиар олж дайн тулааны завсар сэтгэл хангалуун амьдарч явсан нь дээр гэх амьдралын философи болой.

Ийнхүү аливаа төөрөгдөл арилсан нь бидэнд тодорхой байна. Түрүү үеийн христ шашны ариун шүтээнд хамба хуврагууд зулайгаа цоортол мөргөвч тэд мөнөөх зууныг элээхгүй нь лавтай байлаа. Цэрэг дайчдын ертөнц эргэн ирж, хүннүчүүд хийгээд германчуудын үе эхлэв. Тэд бие биеийн эвийг олж хоорондоо гайхам нийцтэй явсны учир бол тэд нийтийн дайсан Ромыг үзэн ядах бус, үзэн ядахыг бол больж болно, харин жигшин үздэг байсных юм. Жигшил зэвүүцэл бол дэлхийн улс төрийн бодлого, улмаар дэлхийн түүхийн олон үеийг, эрэн зууныг дамнасан нэгэн байнгын хэмжүүр бөлгөө.

V.HOM

□□□□□ □□□□□ □□□□□
□□□ □□□□□□□□ □**Y**□□□□ □□□□□ □□

1.

□□□□□□ □□□□□ □□□□□□

Аттила хааны эзэнт гүрэн бол хааны өргөөлөх байнгын суурин хотгүй сонин улс байв. Хааны суух өргөө нь ч ил харагдахаар элдэв алба, эрх мэдэл бүхий түшмэл гэхээр юмгүй нь мөн л сонин. Аттилад зөвлөхүүд байсан ч засгийн гзар, тодорхой нэг салбар эрхэлсэн сайд гэж байгаагүй. Одоогийнхоор бол (тэргүүн) шадар зөвлөх хэмээгдэх хүн нь “Онегесиус” нэртэй байсан бололтой. Гэхдээ энэ нэр нь өөрийнх нь нэр мөн эсэх нь тодорхойгүй. Харин Аттила хааны байнгын “дугуй ширээний андууд” (*Артур хааны дугуй ширээний хөлөг баатруудын яриаг санах нь зүй. Орч.*)-ыг үргэлж инээлгэж баясгагч ордны алиа салбадай гэж байсан нь мэдэгддэг. Хааны найрын ширээ суудлын хуваарьтай, тэр нь Аттилагийн шадар хүмүүсийн зэрэг зиндааг илтгэж, энгийн, харахад л ойлгомжтой, бас өөрчлөхөд ч хялбар зүйл байсныг тухайн үеийн хүмүүс гэрчлэн үлдээжээ. Гэрт мэндэлсэн Хүннүгийн хаан германчуудын хаадад байдгийн адил их танхимд морилдог, зэрлэг аймгийн толгойлогч энэ хүн “Brain Trust” (*Англи хэлнээс үгчлэн орчуулбал “тархины трест” болно. Нарийвчилсан судалгаа хийж бодлогын үндэс суурь болох дүгнэлт гаргадаг өндөр IQ бүхүй хүмүүсийн хамтлагийг хэлнэ. Энд ойр дотнын зөвлөхүүдийн бүлэг гэдэг утгаар өгүүлжээ. Орч.*)-тай байсан тухай мэдээ баримт ч буй. Байнга болдог „Diner de tetes“ („Diner de tetes“ буюу Францын жүжгийн зохиолч Жан Аниулийн “Толгойтнуудын зоог” хэмээх хошин жүжгийн нэр. Орч.)-ийн үеэр Аттила тушаах л аваас хэн ч бай толгойгоо алдаж мэдэхээр байжээ...

Аттилагийн эзэнт гүрэн ямар улс байв? Түүний нутаг дэвсгэр хаана эхэлж хаана дуусч байв? Энэ гүрэн Чингис хаан, доголон Төмөрийн гүрэнтэй эн зэрэгцэхээр дэлхийн гүрэн байсан уу? Рене Грүссэ тал нутгийн ард түмнүүдийн тухай номондоо Аттила-Чингис хаан-Төмөр хэмээсэн давхар гарчиг зориудаар тавьж түүндээ Хүннүгийн гүрний тухай өгүүлэхдээ:

“Монгол гарлын Чингис хааны эзэнт гүрэн өөрийн тугийн дор монголчуудаар зогсохгүй Азийн цээжнээ нутаглах нийт түрэг, түнгүүс нүүдэлчдийг нэгтгэж байсны адилаар хүннү, өөрөөр хэлбэр түрэгүүд цөмийг нь бүрдүүлж байсан Аттилагийн гүрэн нь Урал, Райн мөрнүүдийн завсрын нутагт суух сармат, алан, остгоот, гэпид болон бусад бүх зэрлэг ард түмнүүдийг хамарч байв” хэмээжээ.

Улирч өнгөрсөн олон зууны түүхийг арван хуруу шигээ мэддэг, өөрийн салбарт Грүссэгээс дутуугүй нэр хүндтэй Теодор Моммзен эртний зохиогчдын дурдсан Аттилагийн захирч байсан “далайн арлууд” нь Британи мөн гэдэгт эргэлздэггүй бөгөөд үүнээс үүдэн британчууд наад зах нь Аттилад алба барьж байсан, хүннү нарын захиргаа Райн мөрний адаг лавтай хүрч байжээ хэмээн дүгнэж болно. Остгоотууд зэрэг германы овог аймгууд хоёр үеийн турш хүннү нарын эрхшээлд байж, хаад ноёд нь Аттилагийн хараат албат байдлаар амьдарч тэмцэж явжээ. Байлдаж тулалдахдаа гаргууд Трансильвааны гэпидүүд, Карпатын уулсын нумарсан хэсгийн зүүн хойд этгээдэд өргөн уудам нутагт тархан суух рүгичүүд Аттилагийн захиргаанд оржээ. Тюрингчүүд Аттилаг хүлцэн дагасан нь ч тодорхой байдаг. Хүннү нарын хурдан шаламгай цэргийн ангиуд Райн мөрний бэлчир газар үе үе гэнэт халдаж аюумшигт цохилт өгч байсныг бид бүргүндчүүдийн амссан хувь заяанаас мэднэ. Райн мөрний франкуудаас брүктэрэрүүд хэмээгч хамгийн хүчирхэг овог хүннү нартай ойр дотно холбоотой байжээ. Түүний дээр хэрүлүүд, түрцилингүүд, куадууд, маркоманнууд ч хүннү нартай холбоотой байсныг наймдугаар зууны лангобардуудын түүхийг туурвигч Паулус Диаконус гэрчилж буй. Тэрээр *Historia romana* (Ромын түүх)-даа эртний зохиогчдоос иш татсан бол Их Карл хааны ордонд үүргээ гялалзтал гүйцэтгээд өөрийн уугуул Монте Кассино сүмдээ буцаж ирээд *Historia langobardorum* (Лангорбардуудын түүх) хэмээх маш чухал бүтээлээ туурвисан бөлгөө.

Хүннүчүүдийн гүрний нутаг дорно талдаа хаа хүрч байсан талаар Аттилагийн үеийн түүхчдээс дурдаж өгүүлсэн зүйл үгүй, гэхдээ дорно зүгт алс хол суух нүүдэлчин ард түмнүүд болон хүннү нараас салж тусгаарласан овог аймгуудыг хуваан захирахад Аттилагийн хөвгүүдийн гүйцэтгэсэн үүргийн талаар дурссан зүйл бий. Түүнээс гадна Ираны эзэмшил нутгийг хүртэл дээрмийн аян дайн явуулж, эсэргүүцэлтэй тулгарч явсан Хүннүгийн ван ноёдын өгүүлсэн зүйлүүд бидэнд буй. Нүүдэллэн амьдрах олон овог аймгаас бүрдсэн Аттилагийн эзэнт гүрэнд тогтсон байнгын хил хязгаар байгаагүй ч Урал хүртэлх уудам тал нутаг, зүүн өмнөдөд Кавказ, Босфор, умардад Балтийн тэнгис, өрнөд, баруун хойд этгээдэд Райн мөрөн, Ла Маншийн хоолой зэрэг нутаг оронд Аттилагаас илүү хүчтэй, эрх засаг гартаа атгасан хүн байгаагүй бөлгөө.

Тиймээс Э.А.Томпсон хүннү нарын тухай нэрд гарсан гарамгай бүтээлдээ Аттилагийн гүрнийг их гүрэн хэмээн үзсэний нэгэн адил хүннү нарын ноёрхлоос үлдсэн түүх, соёлын дурсгалыг судлаач, хүннүгийн археологийн хошуучлагч эрдэмтэн Иоахим Вэрнэр ч ийн үзсэн байдгийг ойлгож болно. Харин өөрийн үнэлэлт дүгнэлтийг ихээхэн бодож цэгнэж байж хийдэг, буурь суурьтай Отто И.Маенхен-Хэлфэн дээрхийг үгүйсгэгчдийн талд орсон нь харамсалтай. Тэрбээр

амьд сэрүүн ахуйдаа хэвлүүлж амжаагүй, сүүлд эчнээ гарсан хүннү нарын талаарх гол бүтээлдээ зарим түүхчпийн Аттилагийн хаант гүрнийг дотоод Азийн Монголын эзэнт гүрнүүдтэй адилсгах адал зэхийдүү хандлага нь үнэн хэрэгтээ байхгүй юмыг эрэх гэж хорхойсч буй явдал лугаа адил хэмээн тэмдэглэсэн нь буй. “Хүннүгийн хааны зорилго ямар ч байсан байж болно. Гэхдээ тэр бүхэл бүтэн нэгэн ертөнцийг эзэмдэж байсан бус, зөвхөн нэг хэсгийг нь л захирч байсан юм. Түүний захирч байсан нутаг христийн тооллын өмнөх зууны дунд хэрд эрх засгаа Дунайн адгаас Словак хүртэл тэлж, Балканы хойгийн ихэнхийг байлдан дагуулсан Дачи гүрний хаан Бурбистагийн хураан захирсан нутгаас асар ихгүй байсан юм...Бледаг алсны дараа Аттила хүннү нарыг ганцаар захирах болсон агаад хүннү нар бол түүний харьяат ард түмэн, албат нь байв. Түүнээс гадна Аттила гоотууд, гэпидүүдийг захирч байсан бөгөөд гарамгай дайчин, Ромын хоёр эзэнт гүрний хувьд олон жилийн турш “нүдэнд орсон хог, шүдэнд орсон мах” л байснаас хэтрэхгүй. Харин тэрээр энэ хоёр гүрэнд хэзээ ч ноцтой аюул занал учруулж байгаагүй юм” хэмээн тэрээр дурджээ.

1969 онд нас барсан дээрх эрдэмтний 1973 онд хэвлэгдэж эрдмийн хүрээнийхэнд хүрсэн дээрх өгүүлбэрүүдийг хүннү судлал дахь хамгийн сүүлийн, хамгийн шинэ үзэл санаа гэж үзэх ёстой юм бол би түүнийг яаж ч сайн санаа гаргаад яагаад ч хүлээж авч чадахгүй. Хүннү нар, хамгийн гол нь Аттилагийн Хүннү гүрэн Ромын хоёр эзэнт гүрэнд ноцтой аюул занал учруулж байсан эсэхийн тухайд бид дараагийн бүлэгт тодруулна. Аттилагийн гүрэн хүннү нарын амьдарч байсан Паннон нутгаар хязгаарлагдаж байсан юм бол Герман үндэстний ариун Ромын эзэнт гүрэн герман хааны уугуул нутгаар мөн хязгаарлагдах л байсан юм даа. Учир нь Ромын эзэнт гүрний ноёд ихээхэн эрх дураараа явдаг, хаанаасаа бага хамааралтай байсан нь эргэлзээгүй байдаг. Тэгвэл Аттилад алба барих үүрэг хүлээж түүний захиргаанд явж байсан гэпид, остгоот болон бусад олон овог аймгийн ноёд тийм байгаагүйг бид Аттилагийн засаглалын талаар бидэнд мэдэгдэж буй зүйлд түшиглэн хэлж чадна. Ромын эзэнт гүрний ноёд үе үе сонгосон хаанаа эсэргүүцэж, Италид дайн хийж байх цагт нь цэрэг нийлүүлж хамжиж туслахаас татгалзаж, бослого дэгдээж байсныг бид мэднэ!

Аттилагийн зоогийн ширээний андууд эв санаа нэгтэй байсны учир нь түүний эрх засаг үнэхээр хүчтэй байсны шинж, хүннү нар Дундад, Дорнод Европт хаа сайгүй маш хурдан цохилт өгөх, эсэргүүцэн босч тэмцэх аливаа санаархлыг ургаж төлжихөөс нь өмнө амжиж тас цохих чадартай байсан бөлгөө. Аттила холбоотнууд нь хэмээн дээр нэрлэсэн ард түмнүүдийн дотор ихээхэн нэр хүндтэй байгаа нь түүний ордон хүрээнд очсон бүх харь хүмүүст илт харагдаж байжээ. Чухамхүү Аттилагийн энэхүү их нэр хүнд Ромын эзэнт гүрний хоёр хэсэгт аль ч үед асар их аюултай байсан юм. Мөргөлдөөн гарах тохиолдолд ромчууд ганц хүннү нар бус, харин Аттилагийн удирдсан зэрлэг ард түмнүүдийн их эвсэлтэй тулах аюул байв. Аттила үнэхээр тэдгээр ард түмний толгойлогч нь байсан болой. Хэрвээ Дорнод болон Өрнөд Ромын эзэнт гүрэн зэрлэг ард түмнүүдтэй тус тусад нь тулалдахдаа байнга ялдаг байсан гэдэг нь үнэн бол нэгдэж нягтарсан зэрлэг ард түмнүүдийн хамтын дайралтыг няцаахын тулд сүүлчийн хүчээ дайчлах хэрэгтэй байсан болой. Гэтэл тэр хүч нь Ромынх бус, Византийн өөрийнх нь бол бүр ч биш, харин Аттилаг хараахан дагаж захирагдаагүй германчуудын үлдэгдэл байсан юм. Хэрэв Вэрнэр шиг холын үр дагавартай дүгнэлт хийхийн оронд хүннүчүүд хийгээд зэрлэг ард түмнүүдийн нэгдсэн хүчийг зөв үнэлж, алс холын башкируудын орон ч Аттилагийн гүрэнд хамаарч байсныг харгалзан үзэх юм бол Ромын эзэнт гүрэн долоон зуун жил

оршин тогтнохдоо хүннү хүн Аттилагаас илүү аюултай дайсантай тулгарч байгаагүй гэдэг нь тодорхой болж буй.

Хожмын цаг үе, тухайлбал хүмүүс бядан явах нь их болсон барок, рококогийн зуунд энд тэндхийн дипломатуудын захидал бичиг, замын тэмдэглэлүүд нь ихээхэн баялаг, өнөөг хүртэл гүйцэд судлагдаагүй эх сурвалж болой. Галлиани гэгч ширээт ламын Неаполь хотоос Парис руу илгээсэн захидлууд хэчнээн амттай, Бэрнис хэмээгч гүнгийн өөрийгөө дөвийлгөж магтсан тэмдэглэлүүд хэчнээн инээдтэй, Нидерландад барон Кобенцлд тохиосон золгүй явдал гэнэн итгэмтгий язгууртнууд зарим зальхай этгээдүүдийн хаана нь ч хүрэхгүй гэдгийг ямархан тод харуулсныг санахад хангалттай.

Энэхүү тансаг “цуглуулга”-ын нэгэн хэлтэрхий нь мөнөөх Прискүс агаад тэрээр хүннү нарын гүрэнд очиж Аттилагийн ордонд бараалхсан тавин хүнтэй элч төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд орж явсныг бид мэдэх билээ. Элч төлөөлөгчдийн гишүүн тавь юм уу, түүнээс ч илүү хүн бүгд л дипломат яриа хэлэлцээнд гаршсан хүмүүс байжээ. Санаа оноогоо хэлж бичүүлэх нарийн бичгийн дарга нар нь ч хамт явж байв. Элч нар аян замын уртад замын буудлуудад хоноглож явахдаа нарийн бичгийн дарга түшмэлүүдээр юу л бол юуг бичүүлэх зүйл цаг зав байсан нь тодорхой. Гэвч элчүүд ч, тэдэнд замчилж хань бараа болж явсан худалдаачид ч хожмын үеийнхэнд ямар ч мэдээ үлдээгээгүй. Тиймээс бид Аттилагийн дугуй ширээний андуудтай танилцах үүднээс нүдээр үзсэн гэрчийн өгүүлэхийг сонсохын тулд мөнөөх Прискүстээ л хандах хэрэгтэй болж байна. Хүннүгийн хааны найранд зөвхөн Эдеконыг урьсан болохоор Византид тоогдсонгүй хэмээн гоморхож байсан ром хүн Орестес эцгийн хамт Аттилагийн ордонд мөн ирсэн байсныг бид эхлээд олж мэднэ. Энэхүү эцэг Татулуc нь эзэн хаан идэр залуу Ромулуc Аугустулусийн өвөг эцэг нь юм. Гэхдээ тэрээр Хүннүгийн хааны ордонд тэрээр зөвхөн элчийн үүрэгтэй ирсэн байжээ. “Биднийг асартаа буцаж ирсний дараа Орестесийн эцэг Татулуc орж ирээд Аттила, бид хоёрыг (Максиминос, Прискүс хоёр) есөн цагт товлосон зоогонд урьж байгааг мэдэгдэв. Товлосон цагт нь явж очсонд Өрнөд Ромын эзэнт гүрний элч нар ч мөн хүрэлцэн ирсэн байв. Их танхимын босгыг алхан оруут хойморт нь Аттила морилон буйг харав. Найрын сөн түшигч нар нутгийн заншлаар хүн бүрт цом дарс барив. Бид суудалд суухын өмнө хааны амгаланг айлтгаж энэхүү дарсыг тогтоох ёстой болов. Чингэсний эцэст л заасан суудалд суулаа”.

Эндээс хүннүгийн хааны өргөөнд өдрийн ажил үйлийн тогтсон дэг жаяг, зоог найрыг дэглэх уламжлалт ёслол, түүнчлэн ёслолын дэглээч, мөн суудлын хуваарь ч гэж байсныг мэдэж болно. Хүннү нар ромчуудын заншлаар найрлахдаа эгнүүлэн тавьсан намхан ширээнээ хэвтдэггүй, харин суудалд суудаг байж. Гэхдээ суудалд суух нь нь ромчууд, хүннүчүүдийн аль алиных нь хувьд харь гарлын ёс байсан бол их танхимд найрлах заншлыг хүннүчүүд германчуудаас зээлдэн авсан ажээ:

“Хоёр талын ханын дагуу сандал ярайтал өржээ. Хоймрын гол төвд нь Аттила жинтүү бүхүй буйданд морилно. Түүний ард шатны хэдэн гишгүүр өгсөөд гэрэг, ромчуудын хуримлагч хосуудад зориулж бэлтгэдэг орыг санагдуулах даавуун алчуур, эрээн бүтээлгээр гоёсон исэр ор байна”.

Энэ өдрүүдэд Аттила мэдээж хуучин эхнэрээс салалгүйгээр шинэ хатан буулгасан байсан болохоор Прискүс уг орыг хуримынх хэмээн зөв таамагласан ч аян данг бодож энэ тухай зориуд ёгтолсонгүй ажээ.

“Хамгийн хүндтэй суудал нь Аттилагийн баруун гарын эгнээний суудал болно. Удаах зэргийн суудал нь Аттилагийн зүүн гарын эгнээн дэх суудал гэж үзэгдэнэ. Бид тэрхүү эгнээнд сайн язгуурт скиф хүн Берихосын хажууд суув. Гэхдээ Берихос Аттилагийн сэнтийд биднээс илүү ойрхон сууж байв. Хааны баруун гар талд Онегесиусын (тэргүүн зөвлөх бололтой) суудал байна. Түүний өөдөөс хараад Аттилагийн хоёр хөвгүүн сууна. Ахмад хөвгүүн нь эцгийн яг хажууд бус, нэлээд зайтай Аттилагийн адилаар буйдан дээр хараа буулган суух нь эцгийг гүнээ хүндэтгэж буйн тэмдэг ажгуу.

Бүх хүн суудлаа эзэлсний дараа сөн түшигч Аттилад дөхөж дарс дүүргэсэн цом барина. Аттила тосон авч хажуугийн хүнд эрүүл энхийг ерөөж хундага өргөнө. Ийн хүндлэл хүлээсэн хүн суудлаас босч дарсыг амсах буюу тогтоогоод цомыг сөн түшигчид буцаасны дараа л эргэж сууна. Түүнийг суусны дараа бусад хүн мөн ийм байдлаар хундага өргөнө. Тэд дарстай цомоо өргөн хаанд сайн сайхныг ерөөгөөд тогтоосны дараа дээрхийн яг адил хүндлэл үзүүлнэ”.

Ийнхүү хундага өргөж дарсыг дуустал уух ёсон Их Петрийн үеийн Оросын эзэн хааны ордны найрын тухай мэдээ сэлтийг илт санагдуулна. Хүннү нарын хундага тулгадаггүй, хариу үг хэлж хундага өргөдөггүй зэрэг архи дарстай холбоотой бусад ёс заншил нь бүх ройсс (*эртний өрнө дахинд оросуудыг ийн нэрлэж байв. Орч.*)-ийн хаан болоод Прүссийн “цэрэг хаан” (*Прүссийн Их Фрийдрих хааныг хэлж буй. Орч.*)-ы ордны ёс горимтой адил төстэй байв.

“Зочин бүр өөрийн гэсэн сөн түшигтэй байх агаад тэд нь Аттилагийн сөн түшигч хааны цомыг дүүргэсний дараа л бусад зочны цомд дарс аягалах ажээ. Ийнхүү хэргэм зэргийн дагуу бүх хүний амгаланг дараалан айлтгаж хундага өргөж дууссаны дараа Аттила бидний элч нарт ч мөн суудлын хуваарийн дагуу хүн бүрт эрүүл энхийг ерөөж хундага өргөв. Ийнхүү мэндлэх ёслол өндөрлөсний дараа сөн түшигчид гарч явав. Үүний дараа хааны ширээний ойр гурав, дөрөв, түүнээс ч олон зочин тус бүрт ширээ засна. Зочид нэг их зиндаархахгүйгээр идэж ууж болно. Эхний үйлчлэгч мах овоолсон цар, дараах нь талх, хачир авчирч хааны ширээн дээр тавина. Зэрлэгүүд (*Эртний гэрээгүүд өөрийнх нь хэлийг мэдэхгүй, эсвэл муу мэдэх хүмүүсийг “бар бар хийсэн яриатай”, хэл мэддэггүй амьтас хэмээдэг байснаас “barbarian” гэдэг үг үүссэн агаад энэ үг яваандаа харь ард түмнүүдийг заах үг болон хувирч, улмаар гуйвуулж соёлгүй, зэрлэг бүдүүлэг хэмээх утгатай болгожээ. Орч.*) хийгээд харь газрын бидэнд мөнгөн цар дээр нарийн тансаг идээ ууш тавьсан байхад Аттила тун даруу байдал үзүүлэх агаад түүний өмнө өрсөн идээ ундаа ч тун эгэл жир ажээ. Эдэлж хэрэглэж байгаа сав суулга нь ч бидний өмнөх алт, мөнгөн цом, аяга тавгаас огт өөр, тэрээр модон хундаганаас дарс шимэх бөлгөө. Түүгээр ч барахгүй өмссөн зүүсэн нь маш даруу, харин цэвэр цэмцгэр ажээ. Бүсэндээ зүүсэн илд ньч, зэрлэгүүдийн заншлаар хөлдөө угласан сандааль шаахайн бүч нь ч, хөлөг мориных нь хөмөлдөрөг ч алт мөнгө, үнэт чулуу, өөр бусад чимэг сэлт гэх юмгүйг би нүдээрээ харсан билээ”.

Алт эрдэнэсийн төлөө нүдээ ухаж өгөхөөс ч буцахгүй шуналтай, өргөсөн тангараг, хэлсэн үгнээсээ алхам болгондоо ухардаг, Эмерих Шаффраны Аттилагийн түүхэн дүр төрхийн тухай товч өгүүлэлдээ дурдсанчлан “эрт урьдаас өвлөсөн юм уу, болхи толхи төсөөллөөс давсан уламжлал гэхээр юу ч үгүй бүдүүлэг зэрлэгүүдийн захирагч энэ хүний талаар дээр дурдсан дүрслэлд

итгэхэд бэрх. Ямар ч болов Паннонийн тал нутагт тавдугаар зуунд болсон дээрх найрын эзэн Аттила бидэнд хожмын Европын олонхи хаадаас дутуугүй сэтгэгдэл төрүүлнэ.

“Эхний хоолыг зооглосны дараа бид босч түрүүчийн дугараагаар ирсэн хундагатай дарсыг Аттилагийн эрүүл мэндийн төлөө дуустал тогтоож байж буцаж суух ёстой байв. Ийн хаанд ээлжит хүндлэл үзүүлсний дараа бид дахин суухад бүх ширээн дээр өөр бусад зууш шүүс бүхүй шинэ цар таваг тавигдав. Түүнийг ч мөн идэж барсны дараа өмнөхийн адил дахин босчхааны сайн сайхны төлөө уугаад буцаж суулаа.

Харуй бүрий болохын хэрд бамбар асаав. Зэрлэгүүдээс хоёр хүн Аттилагийн өмнө очиж хааны эрэлхэг зориг, өдий төдий ялалтыг нь магтан ая барив. Бүх зочдын хараа хоёр дуучныг чиглэж, зарим нь дуучдын хоолойг магтаж, зарим нь хаантайгаа хамт байлдаж тулалдаж явснаа дурсан хөөрч баясах агаад зарим нь насан өтөл болж доройтсоноос эр зоригго дахин харуулж чадалгүй болсондоо гутарч нулимс дуслуулах ч байна”.

Энэ хоёр өгүүлбэрт хоёр ч өлгөж авууштай баримт буй. Нэг нь хоол ундны, нөгөөх нь соёлын түүхийн шинжтэй буй. Зоогийн дундуур, хоёр гол хоолны хооронд дугараа барьдаг ёсон Германд байхгүй. Норманнууд бол гол хоолнуудын завсар зоогийг сайхан болгохын тулд “calvados” (*le trou normand*) дарс барьдаг бол Каталлауны тал нутгийн Шалон-сүр-Марне хотынхон өнөө ч *le trou champenois* буюу хундага усан үзмийн нэрмэл мөстэй барих нь бий.

Прискүсийн хоёрдахь мэдээ дээрх сонин заншлаас хавьгүй илүү учир холбогдолтой. Энэ мэдээ хүннү нарт дуучид, туульчид, улмаар яруу найрагтай байсныг нотолж буй. Хэдийгээр Прискүс хүннү хэлийг ойлгохгүй ч түүнд дууны утгыг орчуулж өгсөн бололтой. Тиймээс Прискүсийн өгүүлж буй зүйлд бүрнээ итгэж болно. Хүннү нарын уран зохиол цаас, илэг дээр буугаагүй ч цээжээр аялгуулан хэлдэг баатарлаг туулийн хэлбэртэй байсан. Гэтэл дуучны дуулахаар, туульчийн хайлахаар сонгосон дуу хийгээд тууль бол нэгэнтээ сүүл толгой холбосон байдаг, нөгөөтэйгүүр зохих хэмлэлтэй байдаг. Хүннүчүүд ийнхүү дуу дуулж, тууль хайлдаг хийгээд найрын зочид энэ урлагийг таашааж хөөрөн баясч үнэлж байгаа зэрэг нь Шаффран болон бусад судлаачдын өмнө дурдсан зүйлүүдтэй огт хавьтахгүй. Шаффран болон бусад нь Атиллагаар барахгүй түүний зөвлөхүүд ч соёл урлагийн үйлийг сонирхдоггүй, ойлгодоггүй хэмээн дүгнэсэн нь бий билээ.

“Хоёр дуучны дараа нэгэн ухаа муут (эсвэл зориуд ийм дүр эсгэдэг ч байж магад) скиф алиа салбадай гарч ирээд элдвээр аяглаж нийт хүнийг хөгжөөн баясгав. Түүний дараа мавр Зеркон гарч ирэв. Эдекон түүнийг Аттила руу явж очихыг ихэд ятгаж, чингэвэл эхнэрээ эргүүлж авахад нь байдгаараа туслана хэмээн амлажээ. Зеркон бол Бледад тал олсон хүн бөгөөд эхнэр аваад удаагүй байхад нь Аттила түүнийг Аетиуст бэлэг болгон барьж Равенна руу явуулсан байна. Ийн Зеркон эгэж ирээд эхнэрээ буцааж авах санаатай байсан ч үүгээрээ Аттилаг ихээхэн хилэгнүүлсэн ажээ. Сунжирсан найрын сүүл хэрд тэрээр орж ирээд улаан зээрд болсон зочдыг гадна төрх, этгээд хувцас хийгээд латин, хүннү, гоот хэлийг холилдуулан буруу хазгай дуудаж хэн нэгнийг элэглэн алиалж амьтны элгийг хөшөөж байхад гагц Аттила л инээж хөгжсөнгүй. Нүүр царай нь огт хувирахгүй хөшсөн мэт сууж асан тэрээр үгээр ч үйлээр ч сэтгэлийн хөдөлгөөнөө ил гаргасангүй, гагцхүү асарт орж ирээд эцгийн хажууд

дэгдэж очсон бага хүү Эрнакаа өхөөрдөж хайрласан янзтай харж хацрыг нь илж суув. Аттила бусад хөвгүүдээ ер тоохгүй, ганц бага хүүдээ л хамаг анхаарлаа тавьж буй нь ямар учиртайг латин хэл мэддэг болохоор нь миний хажууд суулгасан бололтой нэгэн хүннү хүнээс асуусанд тэрээр надад их л нууцлаг царай гарган тайлбрлахдаа төлөгч нар мэргэлж үзээд Аттилагийн удам урт насгүй, удахгүй тасрана, харин энэ хөвгүүн л сэргээж авч явна хэмээн айлдсан ажээ.

Найр сунжирч шөнө дөл болтол үргэлжлэх төлөвтэй болохоор нь бид архи уухыг больж талархал дэвшүүлж ёсыг гүйцэтгээд бусдаас түрүүлэн гарч явав”.

Найр өндөрлөснөөс хэдхэн цагийн хойно, өдөр болмогц Онегесиусыг олж очиход тэрээр элчүүдийг хүлээж авч уулзсан хэмээн Прискүс тэмдэглэлээ дуусгажээ. Хүннү нар архи сайн даадаг учир ууж наргисаар элч төлөөлөгчдөөс хэзээ хойно унтаж амарсан ч өдөр болоход яриа хэлэлцээ явуулахад бэлэн болсон байжээ. Энэ нөхцөлд Аттила болон түүний шалгарсан итгэлт хүмүүстэй яриа хэлэлцээ явуулна гэдэг амаргүй байсан бололтой.

Үүний учир бол Хүннүгийн хааны өргөө нь хэд хэдэн яам, тухайлбал Пентагоныг ч орлож байлаа гэхээр агаад тэнд хүннү нарын холбоотон ард түмэн, овог аймгуудын толгойлогч захирагчид хоног, сараар сууж өнөөгийн хэллэгээр бол хоёр талын зөвлөлдөөнийг ямар нэг байдлаар санагдуулсан яриа хэлэлцээ явуулдаг байжээ. Германы хаад ноёд олонхийг бүрдүүлж байсан эдгээр хүмүүсээс наад зах нь нэг нь л Хүннүгийн хааны ихээхэн нөлөөтэй зөвлөх, үнэнч анд байсан нь мэдэгддэг. Тэр бол тухайн үеийн түүхчдийн бусдаас нь онцолж Аттилаг залгамжилна хэмээж байсан хүн нь Гэпидийн хаан Ардарих болой. Тэрбээр скирүүдийг захирч байсан хүннү хүн Эдекон, Гоотын хаан Валамер нарын хамтаар ихээхэн ач холбогдолтой нөлөө бүхий зөвлөхүүдийн гурвалыг бүрдүүлж байжээ. Учир нь энэ гурван хүн үг хэлээрээ ч, үйл ажлаараа ч Аттилагийн дотнын хүмүүс байжээ. Аттилагийн албат хүннү хүн Эдекон элчин харилцаа гэх мэт хааны итгэж хариуцуулсан нарийн түвэгтэй үүрэг хүлээж байв. Ардарих 447 онд Иллир (*Балканы хойгийн баруун өмнөд хэсэг, өнөөгийн Албани, Монтенегро, Босни Херцеговиныг дамнан орших нутаг.Орч.*)-ийг дайлах хүннү нарын аян дайнд оролцож, Каталауны талд ард түмнүүдийн их тулааны наана франкуудтай цус асгаруулсан тулалдаанд холбоотны үүргээ сайн гүйцэтгэж, Аттилаг насан эцэслэтэл нь үнэнчээр зүтгээд, түүнийг тэнгэр хальсны дараа эзэнт гүрнийг нь мөхөх, хөвгүүдийн дунд хуваагдахаас сэргийлэн тэмцэж явсан хүн болой.

Гэхдээ гоотууд гэпидүүдээс ч илүү Аттилагийн үнэнч холбоотон явжээ. Хэрэв бид дээрхээс арай илүү зүйл мэддэгсэн бол Германы энэ хоёр ард түмэн л Аттилагийн Дундад болон Дорнод Европыг дамнуулан Борнхольм (*Балтийн тэнгисийн арал, өнөөгийн Данийн харьяат нутаг.Орч.*) хүртэл илэрхий давуу хүчээр эзэрхэн захирч байсны нууцыг тайлж чадах байсан буй заа. Гоотууд удтал хаангүй байж хүннү нартай хийсэн эхний тулалдаануудаар хүнд цохилт амсч, хүннү нарын шинэхэн эрх засгийн эхний түрэлтийг тэсч гарах ёстой байв. Өтөл болсон Эрманрих хаан жилийн өмнө амиа хорлосон, эсвэл дайсны халдлагад өртсөний улмаас үгүй болсны дараа Винитариус гэгч ноён 376 онд хүннү нартай тулалдаж амиа алдсан байдаг.

Хүннү нарын дайрлагаас болоод гоотуудын шинэ улс бүрэлдэн тогтох нөхцөлгүй болж хэдэн арван жил өнгөрсний хойно мөнөөхөн амальчуудын эртний хаадын удмын ах дүү гурав гарч ирэх бөгөөд гэхдээ тэд амальчуудын угсаатай яаж холбогдох нь бүрэн тодорхой бус. Тэдний эцэг Вандалариус гэгч Гоотын ноён байсан байж болзошгүй Вандалариус гэгч тэдний эцэг байсан нь магад ч яв цав гэрчлэх баримт хараахан үгүй, Видэрикус нэртэй ч байж мэднэ. Хатдын тухайд ямар ч мэдээ сэлт байхгүй. Дээрх гурван ноён Хүннүгийн хаан Баламбертай гэрлэсэн гоотын гүнж Вадамеркаас гаралтай гэх нь илүү магадлалтай. Энэ нь тэд гурвуул гурвуулаа хаангүй завсрын үеийг харьцангуй хурдан давж хэдэн арван жил эрх засаг барьж чадсаны тайлал ч байж болно. Тэд Эдекон, Одоакер хоёр шиг ч юм уу, эсвэл нэгэн үеийн дараа аланы язгууртны овгоос эхнэр авсан гоотын ноён Андагис лугаа адил улс төрийн талаар ч, садан төрлийн учир шалтгаанаар ч хүннү нар хийгээд германчуудыг өөр хооронд нь холбох тун чухал агаад үнэ цэнэтэй шижим болж байжээ. Иорданесын түүхэн судалгаагаар бол Андагис нь Каталауны талд болсон их тулалдаанаар Вестгоотын хаан Теодорихийг алж Аттилаг ялагдлаас аварсан дайчин мөн ажгуу.

Ураг барилдах ёсон, садан төрлийн холбоо дундад зууны түрүү үед ч дэлхийн түүхийг бүтээлцэж байсныг ийн харж болно. Харин садан төрлийн хэлхээ холбоог ялгаж салгахад хэцүү, зарим ноёд олон эхнэр авах заншилтай байсан нь харьцангуй бодитой дүр зураг гаргахад бэрхшээл учруулж буй. Аттила ч өөрийн хийгээд өрөөл бусад ойрын хүрээний хүмүүсийн гэрлэх, ураг барилдах үйлд ихээхэн анхаардаг, зуучийн үүргийг ч дуртайяа гүйцэтгэдэг байсан байдаг.

“Дараа өдөр нь Аттила биднийг дахин найранд урив. Бид ч дээр өгүүлсэн байдлаар түүнд бараалхалаа. Энэ удаа Аттилагийн хажууд ахмад хөвгүүн нь бус, харин эхийн талын хамаатан, нагац ах Оебарсиус нь суусан байв”.

Энэхүү өгүүлэмж буруу гэдэг нь магад. Оебарсиус нь ах дүүс Октар, Ругила, Мүндзүх нарын бага дүү нь байсан мэт агаад Аттилагийн эцгийн талын хамаатан, авга ах нь болой.

“Зоогийн үеэр Аттила бидэнд ихээхэн найрсаг хандаж, Аетиусаас өөрт нь нарийн бичгийн даргаа болго гэж явуулсан Константиуст эхнэр болгон өгөхөөр нь амласан бүсгүйг даруй ирүүлэхийг хаандаа уламжлаарай хэмээн дахин дахин сануулж байлаа. Константиус өмнө нь Аттилагийн элч нартай хамт эзэн хаан Теодосиуст бараалхахдаа хэрвээ баян чинээлэг эхнэр олж өгвөл ромчууд, хүннүчүүдийн хооронд эвийн сайн харилцаа өнө удаан жилээр тогтооход тус дөхөм үзүүлэх амлалт өгчээ. Эзэн хаан Теодосиус ч үүнийг нь зөвшөөрч Сатурнилоос гэгч сайн язгуурт баян хүний охиныг гэргий болгон өгөхөөр амласан ажээ.

Гэвч хааны амлалт биелэх боломжгүй болжээ. Учир нь нэгд гэвэл хатан хаан Евдокиа (Ругилад аянга цахилгаан илгээсэн гүн сүсэгт хатан) Сатурнилоосыг хороохыг тушаасан, хоёрт гэвэл Зенон жанжин ийн ураг барилдах санаархлыг эсэргүүцэж Сатурнилоосын охиныг нууцаар хулгайлж өөрийн анд Рүфүстэй гэрлүүлжээ”.

Хэрвээ энэ явдал Византид болоогүйсэн бол хуучны Ромд л ийм зүйл тохиодогсон хэмээн хүмүүс хэлэх байсан буй заа. Ард түмнүүд, гүрэн улсуудыг хураан захирсан хаан маань дайсныхаа нийслэлд баян чинээлэг өв

залгамжлагч бүсгүй ангуучлах ажилд хэрхэн оролцож байсан нь илүү сонирхолтой. Аттила хилэгнэн занаж нарийн бичгийн даргадаа түрүүчийн товлосон бүсгүйгээс дутуугүй баян хүүхэн ирүүлэхийг шаардаж, хэлсэн амнаасаа буцна гэдэг эзэн хааны нэр төрд харш, байж болшгүй явдал болохыг сануулж, бэрийн инжийг өгөхгүй хуурч мэхлэх юм бол хэзээ ч дайн эхэлж магадгүй шүү хэмээжээ. Ингээд Аттилатай эвлэрэхийн тулд баахан элч зарж, ихээхэн хэмжээний алтаар бэлэг барьсны эцэст Константиус баян бүсгүйн оронд ихээхэн чинээлэг, дээр нь сайн язгууртай нэгэн бэлэвсэн хүүхэнтэй гэрлэхийг Аттила зөвшөөрчээ. Теодосиус ч уг бэлэвсэн эхнэрийг Дорнод Ромын эзэнт гүрний тусын тулд өөрийгөө золиослохыг биечлэн ятгаж зөвшөөрүүлсэн байна. Энэ бүхнийг нуршихын учир нь энэ ажиллагаа Аттилагийн өөрийнх нь хатан буулгах гэж баахан явдал удсан арга ажиллагааны удиртгал болой. Тэр нь Дорнод Ромын эзэнт гүрний хааны дүү бүсгүй Хонориаг Хүннүгийн хаантай суулгахын тулд 300 000-400 000 хүний амь, хуучны Европын өдий төдий хотыг золиосонд гаргасан, өнөөгийн өндөрлөгөөс харахад бараг л инээдэмтэй гэмээр үйл явдал болой.

Юста Грата Хонориа бол Константиус, Плачидиа нарын дундаас төрсөн бүсгүй байв. Эцэг нь эзэн хааны удмын хүн биш, жирийн нэг генерал байсан бөгөөд Британи Ромын захиргаанаас гарахыг санаархаж (!) сөрөг хаан гаргаж ирэхэд тэрбээр ихээхэн ээдрээтэй нөхцөлд “хуучны Ромын эр зориг” ямар байдгийг харуулж (Паули Виссовагийн толь) бутцохисон ажээ. Ийм гялалзсан амжилт үзүүлсэн түүнийг өтлөх янз орсон Плачидиатай суулгахаас татгалзах арга байсангүй. Константиус нь ердөө долоохон сар төр барихдаа жонон, гүнж хоёртой болсон нь ихээхэн зөрчилтэй мэт байдгийг судлаачид өнөөдөр ч тэмдэглэдэг. Жонон Валентиниан, гүнж Хонориа хоёр ийн хорвоод мэндэлсэн бөлгөө. Гэхдээ энэхүү оньсго мэт явдлын тайлал нь Константиус үнэндээ хааны титэм, эзэн хааны хэргэм авахыг хүлээлгүйгээр Плачидиатай холбогдсон явдал амой...

Учир иймээс гүнж Юста Грата Хонориа жинхэнэ дээд язгууртны амьдралд умбаж өсч хүмүүжих ёстой байв. Энэ бүсгүй хар багаасаа дээдсийн (*Ромын эзэн хаад гэргий болон эмэг эх, эх, эгч, эмэгтэй дүү, охиндоо хүндэт цол буюу дээдсийн зэрэг хүртээх заншилтай байв. Орч.*) зэрэг хүртсэн учир түүнд ямар ч эр хүн ойртох ёсгүй байсан юм. Тиймээс тэрээр хааны ордонд язганах тайган нарын хүрээлэлд өсч хүмүүжсэн байна. Ингээд эр хүний мөрөөс болсон Хонориа бүсгүй ордны нэгэн шадар түшмэлтэй учир ургуулж удалгүй жирэмслээд хүүхэд төрүүлжээ.

Эх Плачидиа нь дуулгаваргүй зөрүүд охиноо эхлээд Равенна дахь хааны ордноос гадуур хөл хорьж байгаад ер нь элдэв эрсдлээс найдвартай хамгаалах газар олох хэрэгтэй юм гэж үзээд өрнөд Ромын хааны ордноос ч олон тайган бужигнаж байдаг Визант руу явуулахаар шийджээ. Юста Грата Хонориа Босфор дахь хааны ордонд найруулсан жүжгээс удалгүй залхжээ. Энд байхдаа тэрээр эргэн тойрны хүн амьтан Аттилагаас хэчнээн айж чичирч буйг нүдээр үзэж Дорнод Ромын эзэнт гүрнийг зорин ирэх Аттилагийн элчүүдийг харахдаа хүннүчүүд Хрисафиос хийгээд түүний өрөөсөн дугуйнуудтай харьцуулахад ямар золбоотой эрчүүд болохыг ойлгосон ажээ. Тэгээд Хонориа нэгэн найдвартай хүнийг элч болгон нууцаар Аттилад зарж үнэт эрдэнийн чулуун бөгжөө захианы хамт өгчилгөж явуулжээ. Тэрбээр захиандаа өөрөө эзэн хааны гүнж болох, хорь хол гарсан, ордны авга, нагац эгч нарын (эзэн хааны эгч дүүсийг хэлжээ) дунд уйтгарласаар хатаж хагсаж гүйцлээ. Одооноос эхлээд өөрийгөө Аттила хааны

сүйт бүсгүй болох ёстой гэж боддог боллоо. Түүнийг өөртөө эхнэр болгож өгөхийг шаардах, ийнхүү гэрлэх явдлыг Ромын хааны ордноор зөвшөөрүүлэх эрх засаг Хүннүгийн хаанд бий гэдэгт эрхбиш итгэнэ хэмээжээ.

Аттила бөгж хийгээд захиаг хүргэж очсон элч нь мөн л засуулсан тайган хүн болохыг мэдэж Юста Грата Хонориа византийн хааны ордонд ямархан ядруу байдалтай байгааг ойлгожээ. Цаг хугацааг нарийвчлан тооцоод үзэхээр Аттила хаан хэсэг зуур алгуурласан нь харагдана. Байдлыг тандаж тодруулахад цаг хэрэгтэй байсан нь ойлгомжтой. Хүннү нарын “архив”-ын сан хэчнээн баян байгаад ч тэнд Хонориагийн зураг байсан нь юу л бол. Дараа нь бий болсон нөхцөл байдлаас Хүннүгийн хаан Ромын хоёр гүрнийг бага зэрэг дарамтлах цаг боллоо гэж үзсэн мэт. Тэгээд ч Византийн зөөлөн агаад дуулгавартай хаан Теодосиус өөд болж орыг нь нэлээд чанга бололтой эр эзэлсэн ажээ. Урьдын генерал Маркианос эзэн хааны бүсгүй дүүтэй дэр нэгтгэснийхээ ачаар дээд зиндаанд дэвшиж, ийнхүү дотнын тайгануудтайгаа хамжин төр барьж асан дорой хааны орыг тун эвгүй хүн эзэлсэн байна.

Энэ бол Византийн түүх бичээчдийн хувьд дэндүү болхийн учир баахан гоёж чимсэн нэгэн хувилбар бөгөөд Аттилад Маркианосын талаар мөн л ийм байдлаар будаж шунхдаад танилцуулсан бололтой. Түүгээр бол Флавиус Юлиус Валериус Маркианос нь Балканы Тракийд төрж цэрэг дайчин болж хүмүүжсэн ажээ. Тэрбээр халаасандаа хүнээс зээлж авсан хоёр зуун алтан зоостой Константинопольд анхлан хөл тавьсан хүн бөлгөө. Тэрээр арван есөн жилийн турш эзэнт гүрний өмнөөс Африк, Перст тулалдаж, мөн нэлээд хугацаагаар олзонд сууж байжээ. Дараа нь дэвшиж трибүн (*Эртний Ромын бүгд найрамдах улсын ард түмнээс сонгогдсон улс төрийн албан тушаалтан. Орч.*), сенатч болж явжээ.

Тэрээр эзэн хааны дүү бүсгүй Пулхериатай үгсэн Теодосиус хааны амьдралын сүүлийн жилүүдэд ихээхэн жин нөлөөтэй болсон мэт. Эзэн хааныг насан өөд болсны дараа тэрээр хааны гэр бүлтэй ураг барилдсанаас үүдэх эрх ямбыг хэзээ ч урвуулан ашиглахгүй гэсэн нөхцөлтэйгээр Пулхериатай гэрлэсэн гэдэг. Хааныг нас барах үед Маркианос жар хүрч, Пулхериа тавин хоёртой байсан учир энэ ам тангарагаа мөрдөх нь Маркианост төдийлөн хэцүү байгаагүй бололтой. Гүн сүсэг бишрэлтэй Пулхериа шашин сүмийн талаас Маркианост ихээхэн нөлөөтэй байсан байдаг. Харин Аттилатай харилцахад нь Маркианост саад тотгор хийлгүй, өөрийн үзэмжээр хандах боломж олгосноор Византийн байдал хүннү нарын хувьд огт санаандгүй байдлаар эргэв. Урьд нь хүннү нарын хаанд бөхөлзөж зусарддаг байсан Византийн элч нар одоо их гүрний ихэмсэг авир гаргах болжээ. Византи алба барихаа зогсоов. Армийн хүчийг зузаатгаж, цайз бэхлэлтүүдийг байлдаанд бэлтгэж сэлбэж батжуулав. Гэтэл Хонориагийн бөгжийг аваад хааны гүнжийг талдаа татах төлөв бий болсонд сэтгэл ханасан Аттила дараагийн алхмыг хийх гэж яарсангүй. Тэрбээр дотор гаднаа зэвсэг хангинуулан дайнд бэлтгэж, авлигад идэгдсэн Византийн төрийг Маркианосын албан татварын шинэ хууль, хээл хахууль, албан тушаал худалдаж авах явдлын эсрэг явуулсан түүний тэмцэл засч залруулж эрүүлжүүлэхээс нь өмнө амжиж Дорнод Ромын эзэнт гүрнийг довтлоё гэсэнгүй, харин өрнө зүг хараа сунгажээ. Саяхныг хүртэл түүний анд нөхөд ноёлж элбэг баян олзноосоо үе үе хувь хүртээдэг байсан Равеннагийн нөлөөний хүрээний нутаг, Өрнөд Ромыг зүглэжээ.

Гэнэтийн ийм хэн ч санаагүй шийдвэрийг гаргах болсны учир шалтгааныг Прискүс мэдэж байсан бололтой. Тэрээр өөрийн аяллын тайландаа дурдахдаа:

“Теодосиусыг нас барсны дараа эзэн хаан Маркианос Дорнод Ромын гүрний засгийн эрхийг гартаа авсан болон Хонориагийн хувь заяа хэрхсэн тухай мэдээг Аттилад хүргэхэд тэрээр Өрнөд Ромын эзэн хаан Валентинианд элч зарж өөрийнх нь ханилан суухаар товлосон Хонориа бүсгүйтэй зүй бусаар харьцахыг тэвчихгүй, түүнийг эзэнт гүрний захиргаанаас зайлуулах аваас өс санах болно шүү хэмээн хэлүүлжээ. Мөн Дорнод Ромын эзэнт гүрэн тохиролцсон ёсоор алба барихгүй байгааг сануулж хэлэлцээ хийлгэхээр Константинополь руу төлөөлөгчид илгээжээ.

Гэтэл хоёр тийш илгээсэн элч төлөөлөгчид нь Аттилагийн захиа даалгаврыг биелүүлж чадалгүй гар хоосон буцаж иржээ. Өрнөд Ромын эзэн хаан өгсөн хариундаа Хонориа бүсгүйг өөр хүнд өгөхөөр нэгэнт сүй тавьсан учир Аттилатай суух боломжгүй хэмээжээ. Нөгөөтэйгүүр Хонориа нь эзэнт гүрний захиргаанд орох ёсгүй, учир нь Ромын эзэнт гүрний төрийг зөвхөн эрэгтэй хүн л өвлөн авч явах учиртай гэжээ”.

Юм бүхнийг зөвхөн хэлбэрийн хувьд зөв ч хэрэг дээрээ зориуд будлиулдаг нь жинхэнэ Ромын уламжлал билээ. Тиймээс шулуун шудрага зантай зэрлэгүүдийн хилэнг улам л бадраах бөлгөө. Мэдээж Равеннагийн хааны гэр бүл Хонориаг Аттилатай гэрлэхийг тэвчихгүй нь тодорхой байсан агаад ийн ураг барилдах нь ямар уршигтай болох нь ойлгомжтой байсан билээ. Хонориа нас нь явчихсан, гэр бүлийн бусад гишүүдээс хэнээс нь ч ухаанаар дор орохооргүй хүүхэн байсан ч түүнээс огтхон асуулгүйгээр нөхөр болох хүнийг хайж олоод шуудхан гэрлүүлжээ. Гэтэл Өрнөд Ромын гүрэнд Галла Плачидиа хэдэн арван жил төрж барьж, Византид Пулхериа эзэнт төрийн сэнтийд сууж сүүлд л Маркианосыг татаж авсан байхад хааны гүнж Хонориа төр барих ямар ч эрхгүй байна гэдэгт Аттила яаж ч итгэх билээ! Зорилгодоо нийцсэн, тод тодорхой улмжлалаар өсч хүмүүжсэн нүүдэлчдийн ноён Аттилад иймэрхүү бултаж булзааруулсан хариу нь европчуудын заль мэх хэмээн ойлгогдож дайнч омгийг нь бадраах нь аргагүй байв.

“Алба барих тухай Теодосиусын үед тохирсон зүйл өдгөө бидэнд хамаагүй хэмээн Дорнод Ромынхон Хүннүгийн хаанд хэлүүлсэн байна. Гэхдээ хэрвээ л Аттила Дорнод Ромын гүрнийг амгалан тайван байлгах юм бол тохиролцоотой тохиролцоогүй үе үе бэлэг явуулж байх болно. Харин Аттила дайлаар ирэх аваас адилхан л хүчээр үзэлцэх болно хэмээсэн ажээ.

Ийм нөхцөлд хэнийг нь эхэлж довтлохоо Аттила сайн мэдэхгүй байсан тул нэг хэсэгтээ эвийг сахихаар шийджээ. Өрнөдийн эсрэг аян дайн хийх нь удаан хугацааны бэлтгэл шаардах ажил байв. Учир нь тэрээр ганц италичуудаар зогсохгүй, бас вестгоотууд хийгээд франкуудтай дайтах ёстой байсан хэрэг. Италичуудтай Хонориа хийгээд түүнд ногдох өвийн төлөө, вестгоотуудтай Вандалын хаан Гайзерихад тус хүргэх үүднээс тус тус байлдах учиртай байсан юм”.

Үүгээр бидний түүхэнд ийнхүү нэгэн шинэ нэр гарч ирж буй нь туйлын баян хүчирхэг нэгэн агаад тайлагдашгүйг тайлж, Аттила “бүтэшгүй олон санаа тээж” Хонориаг авч суухын хэнээ туссан, сэтгэлийн хөөрлөөр шийдсэн, эрүүл ухааныг орхиж хэт бие тоож харалган санаанд хөтлөгдөв хэмээсэн зарим түүхчдийн зэмлэлээс Аттила хааныг өршөөн хэлтрүүлэх амой. Уг нь сая сая

хүнийг эзэгнэн захирсан их хаан эмс хүүхнүүдийн өмнө сайрхахдаа ирүүл тулааны үед нүүрийн халхавчаа хуулан хаях мэтээр аяглаж, цааш цаашаагаа саруул ухаан бус сэтгэлийн хөөрөлд захирагдах нь илүү болж явсан хөлөг баатруудаас илүү ухаангүй загнаагүй бөлгөө...

Хаан Гайзерихийг Аттилагийн дугуй ширээний “сурвалжлагч гишүүн” явсан хүн гэж хэлж болох юм. Тэрбээр Хүннүгийн хаантай нэгэн үед амьдарч тэмцэж явсан хүмүүсийн дотроос хамгийн нэрд гарсан нэгэн агаад мөн зуунд Аттилатай эн зэрэгцэх ганц хүн байсан юм. Аттила Ромын эзэнт гүрний умар этгээдээс нь заналхийлэгч хүчирхэг дайсан байсан бол Гайзерих Ромын гүрний өмнө этгээдэд буурьтай өрсөлдөгч болон гарч ирсэн бөлгөө. Тиймээс бид энэ хүнд цөөн мөрөө зориулж товч тодорхойлолт өгөх нь зүй. Үүгээр зарим нэг хүний санаанд орохооргүй зүйл гарч ирнэ.

Вандалууд (*вандалууд нэгэн удаа Ром хотыг эзлэн авч бараг л газартай тэгшилсэн гэдэг бөгөөд үүнээс үүдэн аливаа утга учиргүй эвдлэн сүйтгэх ажиллагааг вандализм хэмээх болсон ажгуу.Орч.*) нь дорнод германчуудын төрөл ард түмэн болой. Дорнод герман бусад ард түмнүүдтэй байнга олзлолдон булаалдаж тэмцсээр вандалууд Балтийн тэнгисийг гаталсны дараа бусад ард түмний нэгэн адил Висла мөрний сав газраас өмнө зүг нүүн явсаар эцэстээ дээрх ард түмнүүдийн ихээхэн хэсгийн хамтаар хүннү нарын захиргаанд оржээ. Хүннү нар эдгээр ард түмнүүдийг тэгтлээ дарлаж зовоогоод байгаагүй хэдий ч вандалууд тавдугаар зууны эхээр өрнө зүг нүүж Стилихогийн удирдсан ромчуудтай тулгарч байлдаж байв. Тэгээд ромчуудын зааж өгсөн нутагт сууж хэд гурван жил өнгөрөөсний эцэст Гайзерих хааны үед дэлхийн түүхийн ач холбогдол бүхий бие даасан хүч болон гарч иржээ. Хаан Гайзерих 428 онд буюу Аттилагаас ганц нэг жилийн өмнө засгийн эрхэнд оржээ. Тэгэхээр Аетиус, Гайзерих, Аттила нар бол нэгэн үеийн хүмүүс бөлгөө! Вандалуудад ч гоотууд, хүннүчүүдийн нэгэн адилаар хаадын овог гэж байсан бөгөөд Асдингер хэмээх овгоос хэдэн үеийн турш вандалуудын хаад төрөн гарсан юм. Энэхүү хаадын удмаас 170 оны үеэс Раус, Раптус нарын анхны хаадын нэрс мэдэгдэж буй. Бидний сонирхож буй эхний хаан бол Годегизел агаад тэрээр 406 оны 12 сард насан өөд болсон, их нүүдлийн үеийн хаан болой.

Годегизел, түүний ёсолж авсан авааль гэргий хоёрын дундаас төрсөн Гундарих 406 онд эцгийн орыг эзэлж вандалын ард түмнийг захирч 428 он хүртэл хаанчилжээ. Энэ үед Гундарихыг насан эцэслэсний хойно хурдан шаламгай, эцэж цуцахыг үл мэдэх Гайзерих түүний орыг залгах нь тодорхой байлаа. Годегизел хааны хүү, гарамгай жанжин Гайзерих ганц л дутагдалтай хүн байсны учир бол түүний эх хааны төрийн ёсоор авсан эхнэр нь бус, иран юм уу, түрэг цусны нууц амраг боол бүсгүй байжээ. Годегизел хаан вандалуудаа удирдан нүүж явахдаа Мажаар газар бууж хэсэг зуур саатахдаа энэхүү хөөрхөн бүсгүйг цацартаа урих нь олонтаа тохиосон ажээ.

Хаадын гэр бүлийн түүхэнд гарал нь тодорхойгүй хөвгүүд маш сонин намтар түүхтэй, ихийн зиндаанд хүрч байсан нь олонтаа тохиолдож байсны нэгэн адил 428-478 онд Вандалыг захирч явсан, хагас герман, хагас европ, дундад азийн нүүдэлчдийн зэрлэг өвөөс хагас хүртсэн хаан Гайзеих бол “гайхалтай овсгоотой, төмөр мэт хатуу зоригтой, эрс шийдмэг, зорилгодоо хүрэхийн төлөө нягт нямбай, тууштай тэмцэгч, бүхэлдээ Аттила лугаа адил дарангуйлан захирагч” (Вилхэльм Капелле) байжээ.

Евразийн энэхүү эзэн захирагч ард түмнийхээ хамтаар хүннү нарын захиргаа, Паннонийн тал нутгийг өлөн хоосон туулах зэрэг хүнд бэрх цагийг үзсээр явсан бөлгөө. Ийнхүү нүүж явсаар Испанийн нутгийг туулаад аяны зам далайн хоолой (*өнөөгийн Гибралтарын хоолой болой.Орч.*)-д тулахад ч тэрбээр морины амыг эргүүлсэнгүй. Харин бэрбэрүүдтэй ах дүүс бололцож, дөрвөн зуун хөлөг онгоц бүтээгээд бүх ард түмэн наян мянган хүнээ ачиж Өмнөд Испанийн хэд хэдэн боомтоос (Гайзерихийн хөлөг онгоцууд бүгд Юлиа Традукта буюу өнөөгийн Тарифагаас хөдөлсөн гэх таамнал магадлал багатай. Тийм олон хүнийг уг боомтын тэр үеийн нөхцөл байдал хийгээд хөлөг онгоцны хэмжээ дамжаа, даацаас шалтгаалан хэд хэдэн боомтод хуваарилж хөдөлгөсөн байх учиртай. Өмнө нь Юлиус Цезарь Англид халдан довтлохдоо чингэж байсан бөгөөд “байлдан дагуулагч” Вилхэльм ч чингэх байсан болой.) Африкийг зорин хөдөлжээ.

Гайзерих далайд гарсан хойноо умард Африкийн хамгийн ойрын боомтод буухыг бодсонгүй, зорьсон газраа нэг амиар хүрэхээр шийджээ. Эмэгтэйчүүд, хүүхэдтэй цөл газар хэдэн зуу, хэдэн мянган километр зам туулах аргагүй, өнөөгийн Тунис дэх Ромын эзэмшлийн цэрэг өлсч цангаж, туйлдаж ядарсан цөөн вандалуудыг хялбархан устгана гэдгийг тэрбээр сайн мэдэж байв. Тиймээс хүнд ачаа бүхүй дөрвөн зуун хөлөг онгоц дарвуул хийсгэн хориод мавр хөтөчөөр замчлуулан дорныг чиглэн Умард Африк дахь Ромын усан замын сүлжээний баруун хязгаарын цэг, тэр үед ад Фратрес хэмээн нэрлэгдэж асан өнөөгийн Нэмүрс боомт хотхонд буужээ. Ийн хад асга ихтэй онгон зэлүүд Рифийн нурууг давахад Ромын Умард Африк вандалуудын өмнө цэлийж байжээ. Нэгэн жил буюу арван гурван сар аялан байлдсаны эцэст Умард Африк вандалуудын гарт оржээ.

430 оны 6 сард хутагт Аугустинусын нутаг хэмээн дэлхийд зар нь түгсэн Хиппо Региүс хэмээх хуучны хот л вандалуудын гарт хараахан ороогүй, хамгаалан байлдаж байв. Хутагт Аугустинус вандалуудын бүслэлтээс амь гарсан ч мөнхүү золгүй оны 8 сард насан эцэслэсэн бөлгөө. Түүнийг асран халамжлагч, анд Поссидиусын туурвисан Аугустинусын намтрын сүүлчийн бүлэгт:

“Элдэв зүйл зэр зэвсэгтэй, дайн тулаанд гаршсан асар том хүн сүрэг аймшигт дайсан вандал, алануудын удирдлагаар... хөлөг онгоц хөлөглөн Африкт цөмрөн ирсэн нь бурханы таалал буй заа... Тэд зүйл бүрээр харгис хэрцгий авирлаж, чадах бүхнээ түйвээн сүйтгэж, алж хядаж, элдвээр тамлан зовоож өөр бусад өгүүлшгүй их зовлон гамшиг учруулав. Тэд өвгөд хөгшид, нялхас багачууд, эр эм хэнийг ч өршөөхгүй, бурханы олон шавь, хувраг зарц нарыг ч, ариун сүм хийдийг ч ялгахгүй эвдлэн сүйтгэж байлаа”. Поссидиус энэ бүхнийг нүдээр үзсэн гэрч ажгуу. Түүний үлдээсэн няцаагдашгүй мэдээ сэлтийг мөн өөр нэг санваартан зохиогч Витэнсисийн голчлон хувраг санваартан, гэлэнмаа нарыг тамлан зовоосон өдий төдий жишээ татсан баримт сэлт давхар нотолж буй. Вандалууд нь аричууд (*Арианизм нь эртний христийн теологийн сургааль агаад үндэслэгч Ариусын нэрээр нэрлэгдсэн, христийн сүм хийдээс тэрслүүд үзэл хэмээн зарласан сургааль байжээ.Орч.*) байсан учир Умард Африкт католик шашны үрийг таригч газруудыг гойд үзэн ядаж түйвээн сүйтгэж байжээ.

Гайзерих өөрөө католик шашинтай байгаад сүүлд Византиас үүсэлтэй, дорнод германчуудын дунд дэлгэрсэн христ шашны нэг хэлбэр болох Ариусын

сургаалийг дагах болсон учир урван тэрслэгчид хэмээгдсэн католик мөргөлтнүүд, тэдний ариун газруудыг онцгой харгислан сүйтгэж байв. Түүнийг Аттилатай харьцуулах нь цөөнгүй байдаг ч үүгээрээ тэрээр Хүннүгийн хаанаас ялгаатай. Аттила шашин мөргөлийн хувьд Чингис, Хубилай хаад болон их эзэнт гүрнүүдийн бусад олон хаадын адилаар төвч байр сууринаас ханддаг байсны учир нь олон шашин, олон үндэстэн ястан нь их эзэнт гүрнүүдийн мөн чанар байдаг явдал болой.

Виктор Витэнсисийн маш тодорхой дүрслэн бичсэн вандалуудын тэрхүү харгис бурангуй үйлдлүүд нь юуны өмнө католикчуудын нуусан мөнгө цаас, үнэтэй цайтай юмыг нь гаргуулж авах зорилго агуулсан бөгөөд үүгээрээ вандалууд хожим нь Дундад Америкт гаарч байсан далайн дээрэмчдээс ялгагдах юмгүй байв. Тэдэнд алт мөнгө л хэрэгтэй байснаас огт алтгүй хүнийг ч байхгүй гэхээр нь итгэхгүй баахан тамлан зовоож байсан ажээ.

Равеннад өргөөлөх хатан хаан Галла Плачидиа Умард Африкт томилогдон ажиллаж байсан чадварлаг агаад нэр хүндтэй генерал Бониатиусын өрсөлдөөнөөс айж, цэргийн жанжин хийгээд генералуудыг үргэлж өөр хооронд нь яс хаяж мөргөлдүүлж муудалцуулдаг байсан нь Гайзерих Умард Африкт ийнхүү ромчуудыг ялахад ташуур өгчээ. Гайзерих Хиппо Рэгиүсийг удтал бүслэн байлдаж авсан бол Картаго (Карфаген)-г ганцхан цохилтоор эзлэн дагуулсан нь гайхамшигтай гэхээр үйл байв. Вандалуудын хөлөг онгоцууд Газар дундын тэнгисийн эрэг орчмын нутгийг байнга довтлон түйвээж байсан учир энд байнга тайван бус байв.

Гайзерихаас өмнө нэг хүн энд ноёрхлоо тогтоож дураар авирлаж байсан нь гурвын холбоо (*Христийн тооллын өмнөх 60 онд Гайус Юлиус Цезарь, Гнаеус Помпеус Магнус, Маркус Ликиниус Крассус нар гурвын холбоо байгуулж эзэнт гүрнийг захирч байсан. Орч.*)-ны гишүүн Помпеус Магнусын хүү Сэкстус Помпеус байв. Тэрээр эзэнт гүрний хүнс тэжээл үр тариа ачсан хөлөг онгоцуудыг байнга дээрэмдэж Аугустус (*Гайус Октавиус Аугустус христийн тооллоос өмнө 63 онд төрж 14 онд нас нөгчсөн, Ромын эзэнт гүрний анхны хаан байв. Орч.*)-ын Ромын гүрнийг өлсгөлөнгийн ирмэгт аваачиж байсан билээ. Гайзерих үр тариа ачсан хөлөг онгоцуудыг Итали руу чөлөөтэй нэвтрүүлж буй үед Ром түүний эсрэг юу ч хийж чадахгүй байв. Галла Плачидиа, Аетиус нар ч энэ байдлыг хүлээн зөвшөөрч амгалан тайван байдлыг эрхэмлэж байжээ. Ром ийнхүү Гайзерих хийгээд түүний эд баялаг, Умард Африкийн газар нутгийг тэр чигээр эзэмшиж идээшиж дасаад эд бараагаар элбэг хангалуун учир ажил хийхгүй амар жимэр суух авай. Вандалууд гагцхүү вестгоотуудаас л сэрэмжилж байсан нь тэд үнэхээр тийм аюул учруулахаар байв уу, эсвэл вандалуудын хардлага сэрдлэг үү гэдэг нь тодорхойгүй. Ямар ч болов Гайзерихад ийн болгоомжлох үндэс байсан агаад үнэхээр ч вестгоотууд Өмнөд Испани руу түрэн ирсэн байв.

Дэлхийн бөмбөрцгийн нэгэн хэсгийг эрхэндээ оруулж түйвээн сүйтгэж, хөлөг онгоцууд нь Газар дундын тэнгисийн дорно эргийг бүхэлд нь хяналтандаа авч тонон дээрэмдэж асан Гайзерихаас илүү Аттилад алт эрдэнэс, мөнгө хөрөнгө амлах хүн үгүй байсан нь үнэнтэй. Хэрвээ Аттила эхлээд эрэлхэг генерал Маркианосыг залхаан цээрлүүлж Хонориаг булааж авах эсэхээ шийдэж ядан тээнэгэлзэж байсан ахул Гайзерихийн буурьтай бэлтгэж явуулсан элч төлөөлөгчид түүний эргэлзээг тайлж, Европын өрнөд нутаг руу аян дайн хийх шийдэх гаргахад хүргэсэн байж болно.

Аттилагийн санаа бодлоо хуваалцаж зөвлөлддөг олон ноёдын дотроос Гайзерих л Ромоос айж эмээдэггүй, Ромыг тоодоггүй байсан нь нөлөөлсөн ч байж магад. Аттила Дорнод Ромыг үзэж чаддаггүй атлаа Өрнөд гүрэнтэй нь он удаан жилээр эв зүйгээ олсоор ирсэн ч эзэн хааны элдэв хэргэм зэрэг, хэлхээ холбоог хялайн үздэг байсан бол Гайзерих Ромын гэсэн юм бүхнийг бараг л үзэн ядаж зориудаар хайхардаггүй, Ромын дэг журмыг бол бүр ч үзэж чаддаггүй байв. Сүм хийд Гайзерихийн харгис хэрцгий үйлийн золиос болоод зогссонгүй, эд хөрөнгийн бүртгэлээс эхлээд Ромын засаг захиргаатай холбоотой бүх зүйлийг зориуд устгаж өмчийн шинэ харилцаа хийгээд ромчуудад өмч эзэмшүүлэхгүй зарчим бий болгосноор хамаг юмыг эсрэгээр эргүүлж завхруулжээ. Гайзерих Ромыг хэрхэх бол хэмээн сэтгэл чилээсэнгүй, эмээж болгоомжилсонгүй, бүхэлд нь үзвэл хүчирхэг хэвээр байсан түүний цэргийн хүчээс айсангүй.

Тухайн үед хүннү нар зэвсэг хангинуулж, Аттила хаан хэрхэхээ шийдэж ядан алгуурласаар байсан тэр сар жилүүдэд Гайзерихийн үйл ажиллагаа Аттилад нөлөөлсөн байж болох юм. “Гайзерихийн бүхий л амьдрал үйлийг ажиглахад тэрээр цэргийн жанжин гэхээсээ илүүтэй хэлэлцэн зохицуулах үйлд ихээхэн гаршсан арга зальтай хүн байсан нь харагддаг” хэмээн Умард Африк дахь вандалуудын мөрийг мөшгөж судалгаа хийсэн Э.Ф.Готье бичсэн бол Капелле түүнийг нь тодруулж “Тухайн үед Хүннүгийн хаан Аттилаг эс тооцвол хамгийн хашир зальтай, хамгийн эрэмгий зоригтой хэрнээ туйлын нягт нямбай улс төрч бол Гайзеих байсан юм...Гайзерихийн хувь хүний мөн чанар гэвэл зарчим гэдэг юмыг огт мэддэггүй хүн байв. Түүний ганц зарчим гэвэл аливаа суртахуунаас ангид, аливаа дайсан этгээдийг даран сөнөөж эрх засгаа тогтоож өргөжүүлэх, ямар ч аргаар хамаагүй найз нөхөд, холбоотонтой болох явдал байсан юм” хэмээн тэмдэглэжээ.

Хүннү нар өрнө зүг Ромын эсрэг хөдлөх нь чухамдаа вандалуудын аз гийсэн хэрэг болох байв. Ингэснээр тэд өөрсдөө хөлөг онгоц хөлөглөн Сициль юм уу, Апулд бууж байлдах шаардлагыг үгүй болгожээ. Вандалуудаас өмнө Сэкстүс Помпеус ийм аян дайн явуулж байсан бол Гайзерихаас хойш норманнууд ч мөн ромчуудтай ийн байлдаж явсны сургамж байсан юм. Гайзерих Аттилаг сайн мэдэх хүний хувьд хувь заяаны ийм ивээлийг хэдэн хөлөг онгоц дүүрэн дээрэмдэж олсон эд бараагаар зольж авч болно гэдгийг мэдэж байв. Хүннүгийн хаан тэртэй тэргүй дайнд мордох нь тодорхой ч чухам хаашаа хандах вэ гэдгээ хараахан мэдэхгүй байсан билээ...

2.

□□□□□□ □□□□□ □□□□□□□ □□□□□□□□

Шалон-сүр-Марне хотоос эхлээд Реймсийн чигт гараад дараа нь зүүн хойш Сүпп рүү эргэж хэдхэн километр яваад нэгэн налгар тайван зогсоолд хүрнэ. Баруун гар талд цаашлах тусмаа бага зэрэг өгсүүр тал газар, зүүн гарт замын хажуугаар орохыг хориглосон заалт бүхий самбартай Францын армийн сургуулийн талбай цэлийнэ. Харин авто хөсгийн зогсоол дээр дэн буудлын хаяг лугаа төстэй, Виктор Хьюгогийн зохиолоос иш татсан “*Ici la Champagne devora les Huns*” (Энд Шампан нутаг хүннү нарыг залгисан болой) гэсэн үгс бичсэн тэгш өнцөгт самбар бидний амрыг эрэх мэт алаглана. Францын их зохиолч чухамхүү энэ талбайг хэлсэн эсэх нь бидэнд тодорхойгүй. Харин их тулалдааныг алаглуулан дүрсэлсэн самбар нь мянга мянган хүний хүүрийг залгиж үүрд

шингээсэн яг тэр газарт буй. Хавийн тосгодын оршин суугчид 451 оны 9 сард тэр олон хүний цогцсыг шатаасан эсвэл газар ухаад булчихсан байж таарна. Учир нь энэ нутагт 9 сард цаг агаар сүрхий дулаан байдаг учир ил задгай хөсөр хэвтэх мянга мянган хүний цогцсоос тахал дэгдэж улс даяар тархах нь ойлгомжтой учир цаг алдалгүй учрыг олох ёстой байжээ.

Гоотууд голдуу асар том түүдэг асааж үхэгсэдээ шатааж үнс болгодог байсан бол хүннү нарт тосгодын дунд хэрэн бэдэрч хүүр цуглуулах цаг байхгүйн учир амь үрэгдсэн хүмүүсээ тосгоныхонд даатгаж орхидог байжээ. Ийнхүү гавлаа хага цохиулсан, эсвэл цэгдэгээ хага яруулсан хэдэн мянган хүннү нарыг газар ухаж булах болдог байж. Тэдний ийм байдалтай байгааг нь харахад амьд сэрүүн үеийнхээсээ илүү аймаар, нүд хальтрам учир тэднийг чөтгөр шуламстай адилтгах нь бас ч аргагүй байжээ.

Тиймээс ч хүннү нарын хэрцгий догшин авирыг дэндүү сайн мэддэг тариачид тэднийг *les Diables* буюу чөтгөрүүд хэмээн нэрийдэж тэрхүү их оршуулгын үйлээ луувангийн үрийг хөрсөнд суулгахын тулд гар хумхилгүй ажиллах шаардлага гардагтай адилтган *l'ahan* хэмээж энэхүү өвс ногоо халиурсан газрыг *l'ahan des diables* хэмээн нэрлэжээ. Энэ газрыг Францын албан ёсны байрзүйн зурагт “Сүпп, Күперли, Ла Шепийн дунд дорнод уртрагийн 22 градус, 10 минут, умард өргөрөгийн 49 градус, 5 минут, 12 секүндэд орших газар” хэмээн тодорхойлжээ. Ийнхүү хүннүгийн ард түмний нэгээхэн хэсгийг оршуулсан газрыг эхний бөгөөд эцсийн удаа яв цав тогтоож чаджээ. Гагцхүү хүннү нар ямар замаар хаагуур яаж энэ газар цөмрөн ирсэн, замдаа юу хийж яаж явсан, Каталаунын талд төгсгөл болсон эмгэнэлт явдал хэрхэн эхэлсэн гэдгийг олж мэдэх ёстой болж байна...

Өрнөд Ромын Хонориа гүнж Херкулес Бассус хэмээх хачин нэртэй хөгийн амьтантай дэр нэгтгэх учиртай болжээ. Тэрхүү хачин хүнийг хармагц л жигшин зэвүүцэх сэтгэл бүсгүйг эзэмджээ. Хонориа Хүннүгийн хаанаас өөр бусад эр хүнийг үзэж чаддаггүй байсан хэмээдэг бөгөөд үнэхээр ч Аттила л түүний өшөөг авч өгч чадах ганц хүн нь байсан ажгуу.

Үнэн хэрэгтээ Аттилагийн хувьд Хонориаг авч суухыг гол зорилгоо болгосон явдал огт үгүй. Тэрбээр дайн хийх цагаа болохоор олон шалтаг шалтгаан олж чаддаг хүн байсан билээ. Өрнө зүгт томоохон аян дайн хийхэд Хонориагаас гадна вестгоотуудыг бутцохих учир шалтгаан бас байжээ. Энэ үед вестгоотуудад хаан ширээний төлөө тэмцэл, өөрөөр хэлбэл хаан ширээг хэн залгамжлах вэ гэдэг асуудлаар хурц маргаан өрнөсөн ажээ. Вестгоотын хааны ахмад хөвгүүн Аттилагад хандаж тусламж гуйсан байв. Харин бага хөвгүүнийг нь урьд өмнө Равеннад очих үед Аетиус үрчилж авсан учир ромчууд тэр бага хүүд туслах нь тодорхой байв.

Галлид дайлаар одох өөр нэг учир шалтгаан нь Итали орон өлсгөлөнд автсан явдал байсан агаад хоол унд хомсдож өвчин тахал дэлгэрснээс үүдсэн нөхцөл байдал Хүннүгийн цэргийг хүнд байдалд оруулах байв. Хүннүчүүд тахлаас ихээхэн айж эмээдэг байв.

Ийнхүү Аттила тухайн цаг мөчид Өрнөд Ромыг хараахан дайлах боломжгүй учир Галлид явуулах аян дайныхаа өмнөхөн Ромд эвлэрэнгүй аястай санал тавьсан бололтой. Хэрэвзээ Хонориаг өөрт нь эхнэр болгон өгөх юм бол аян дайнаа Галлигаар хязгаарлана. Эзэнт гүрний нөгөө хагас түүнд

хэрэггүй. Галлид Ромын эзэн хааны эрхэм сайн андын хувиар засаглах болно хэмээжээ.

Энэ бүх яриа хэлэлцээ хоёр тал өөрсдийн шилдэг дипломатуудынхаа хүчийг дайчлаад ч гай зовлонг зайлуулж чадахаасаа нэгэнт өнгөрсөн нь зарим томоохон дайны өмнө тохиолддогийн л адил явдал байв. Ингээд эзэнт гүрнээ аврахын тулд Аетиус хүү Карпилиогоо (энэ хөвгүүн урьд нь мөн нэлээд хугацаагаар Хүннүгийн хааны ордонд сууж байв) Аттилад илгээхээс ч буцсангүй. Тэрбээр хүү Карпилиогоо Их Теодерихийн нууцын бичээч явсан, өөртэй нь нэр нэгтэй хүүгийнхээ ачаар сүүлд дэлхийд нэрд гарсан Кассиодорын хамт илгээжээ. Гэвч тэд нь Ази хийгээд Европын хаадын засаглал үндсээрээ ялгаатай, Өрнөд Ромын гүрэн бол эзэн хааны хувийн өмч биш, харин дээдсийн өв, захиа даалгавартай хамт уламжлагдан ирсэн зүйл гэдгийг Аттилад ойлгуулж чадаагүй байна.

Аттила цэргийнхээ багахан хэсгийг Дорнод Ромын хүчийг саатуулан барьж байх үүрэгтэйгээр Византи руу илгээжээ. Энэ цэрэг хоёрдугаар зэргийн ач холбогдол бүхий фронт дээр Маркианостай 451 онд тулгаран байлдаж ялагдах хүлээж байв.

Дунай мөрнийг өгсөн өрнө зүг аялсан Хүннүгийн гол хүч нь хүннүчүүдээс бүрдсэн гол хүчний зэрэгцээ аль дээр үеэс Аттилагийн дугуй ширээний анд явсан зөвлөх, шадар стратегичдийн удирдсан германы олон овог аймгууд хийгээд бусад холбоотнуудаас бүрдэж байв. Тэд сүүлийн гурван жил гаруй хугацаанд дээрмийн аян дайнд мордоогүй ажээ. Холбоотнуудын цэргээс хамгийн дайчин хүчирхэг нь Ардарихийн удирдсан гæпидүүд байв. Аттила гæпидүүдэд машинд итгэх учир тэднийг бие даалган байлдуулдаг байсан агаад удалгүй толгойн сэргийлэх анги болгож, бас ар талаа ч хамгаалуулдаг болжээ. Аттилагийн энэхүү хязгааргүй итгэл түүхчдийг хааяа төөрөлдүүлдэг болох нь харагдаж байна. Тэдний дараа Валамир (хааяа Валамер ч гэж бичих нь бий) хааны удирдсан остгоотууд, тэдний дараа хүннү ноён Эдеконы толгойлсон скирүүд, мөн рүгичүүд, хэрүлүүд, куадууд, тэгээд алс баруун жигүүрт явах түрингчүүд тус тус ирж нийлжээ. Арай хойхно хааны ширээнд горилсны учир Аттилагийн дайнд хамжиж оролцохыг хүссэн ноёноороо удирдуулан рипаурууд, өөрөөр хэлбэл алс баруун жигүүрийн франкийн овог аймгууд ирж нийлжээ. Харин хүннү нарын дайралтад өртөж сүйрсэн бүргүндчүүд нь вестгоотууд хийгээд ромчуудтай нийлж Аттилагийн эсрэг байлдахаар шийдсэн нь хэнийг ч үл гайхуулмой.

Ийнхүү тавдугаар зуунд их дайн дэгдэхэд зэвсэг барьж дайтаж чадах бүх Европ тив тэр чигээрээ хамрагджээ. Дайсан зүүн этгээдээс дайран ирэхэд өрнийн хүн ард төдийлөн итгэхгүй шийдэж ядан алгуурласаар байв. Бүхэл бүтэн тивээрээ ийнхүү хөдөлгөөнд ороход хожмын Гэрэг, Ромын үеийн арга хэрэгслээр талуудын цэргийн хүч болон аялан явсан зам харгуйн талаар хойч үедээ яв цав биш юмаа гэхэд бүдүүн бараг тойм мэдээ сэлт үлдээнэ гэж ч юу байхав!. Ийн бидэнд баттай мэдээ сэлт үлдсэнгүй. Гэхдээ үнэнийг олж мэдэхийн тулд Аттилагийн зэвсэгт хүчин дээд тал нь 500 000, доод тал нь франц профессор Лүи Амбисын багцаалснаар 50 000-60 000 байсан байж мэдэхээр буй.

Алеманнууд завсрын гуравдахь хүч байж, тэр үеийн ойлголтоор төвийг сахиж байжээ. Хүннү, гæпидийн нэгдсэн хүч Дээд Райны (мөрөн) цувраа

бэхлэлтүүгийг сэтэлж чадаагүй. Шварцвальд, Вогесен автагдашгүй гэдэг нь тодорхой байсан учир Аттилагийн цэрэг хэдэн хэсэг болж хуваагдав. Хурдан шаламгай гэгчид өмнө зүг, Кайзераугст, өнөөгийн Швейцарийн Базель хавийн нутаг руу чиглэж Райн мөрнийг гатлаад Безаньсоноор дамжин гол хүчиндээ буцаж нийлжээ. Аттилагийн гол хүч умрыг чиглэж алеманнуудын дайралтад өртөхгүйн тулд Кобленцийн чиглэлийг сонгож мөрнийг уруудан цааш давшив.

Мозель голын хөндий өтгөн ой мод ихтэй, гол энэ хэсэгтээ тохой нугачаа олонтой учир ромчууд зам тавьж чадаагүй байсан аж. Тиймээс хүннү нар зөвхөн бүслэлтийн төхөөрөмж зэвсгээ мөрнийг өгсүүлэн чирэх боломж байв. Аттилагийн армиуд ромчуудын тавьсан нэг нь Андернах, нөгөөх нь Бингэнээс Трийр рүү хөтлөх хоёр замаар цувжээ. Харин алеманнуудыг төрөлх нутгийнх нь уул нуруу, ам хөндий аварч гарсан бол Трийр хот гашуун тавилан амсч сүйрчээ.

1939-1940 онд агаарын довтолгооноос хоргодох газар байгуулах болон археологийн малтлага хийх үед тэрхүү тавдугаар зууны их дайн байлдааны үед Трийр хот ямархан хувь тавилан амссан талаар зарим ойлголт төлөөлөл өгөх маш сонин эд өлгийн зүйл олджээ. Мозель голын Трийр хотын эргэн тойронд ширүүн байлдаан явагдаж байсан ч гэлээ Ромын үед үндэс нь тавигдсан христ шашин үлдэж хоцорсон ч гэлээ хотын хүн ам ямар зовлон гамшиг амссан нь тодорхойгүй. Тавдугаар зүүн эхний хагаст тохиосон хоёр их сүйрлийн учир шалтгаан хараахан яв цав тодроогүй болой. Ромд хөлсний цэргийн алба хааж явсан хүннүчүүдийн үйлдсэн хэрэг ч байж болно. Лав л энэ хотыг 451 оны хавар галдан шатаагсад нь хүннүчүүд болон тэдний холбоотнууд байсан гэдэг нь тодорхой байдаг бөгөөд энэ түймэрт уг хотод байсан ромчуудын христийн сүм өртөж үнсэн товрог болжээ. Гэхдээ тавдугаар зууны эцэс гэхэд Трийр хотноо ромчуудын соёл иргэншил давамгайлсаар байсан, наад зах нь хүн амын дээд давхрага эзэн хааны үеийн журам дүрмийг баримталсаар байсан тухай мэдээ бидний үед хүрч ирснээс үзэхэд оршин суугчдын нэлээд хэсэг хүннү нараас зугтаж амь гарсныг харуулж буй.

Ромчуудын байгуулсан замууд Трийр хотын дэргэд нийлж нэгэн том цэргийн зам болж Диводорүм (*өнөөгийн Францын Мэц хотыг тэр үед ийн нэрлэж байсан. Орч.*) хүрнэ. Эндээс эхлэн үйл явдал Түүрс хотын хамба ламтан Грегорын анхааралд өртөж түүний бийрийн үзүүрт түүх үргэлжилнэ. Түүхч Рудольф Бүхнэр бичихдээ “Түүрс хотын Грегорын түүхийн бүтээлүүд бол манай Европ тивийн хөгжлийн маш чухал гэрч болсон үнэлж баршгүй өв болой” хэмээжээ.

Алдарт авга Георгиусынхаа нэрийг өвлөж авсан Георгиус Флорентиус 538-595 оны хооронд амьдарч байсан. Тэрбээр энэ бүлэгт чадан ядан өгүүлэх үйл явдлаас даруй нэгэн үеийн дараа мэндэлсэн бололтой. Тэрбээр тухайн үед сенатчуудын гэр бүл хэмээгдсэн, өөрөөр хэлбэл Гэрэг, Ромын үе болон христ шашин ноёрхсон дундад зууны үеийн завсрын шилжилтийн үед хуучны ном журмыг хадгалан явж түүнийг шинэ шашны үзэл санаагаар баяжуулсан Галлийн хөдөөгийн язгууртны гэр бүлээс гаралтай хүн байв. Энэхүү жижиг элит бүлэг латин боловсролоо ихэд дээдэлдэг ч идэр залуу христ сургаальд гүн агаад гэнэхнээр сүсэглэж, христ шашныхаа төлөө зовж тарчилж амиа өргөгсдийн гүйцэтгэх үүрэг хийгээд гэгээн хутагтуудын хувилгаан чадалд гүнээ итгэдэг хүн байжээ. Георгиусын эцэг болон эхийн талын өвөг дээдсээс Клермон, Лион, Лонгре, Түүрс, Женев зэрэг нэрд гарсан хотуудын сенатч, гүн, бээс, хамбууд төрж гарчээ.

Грегор өөрийн “Франкийн түүх” номын хоёрдугаар ботийн тавдугаар бүлэгт христ шашны хэргэмтнүүд хүннүчүүдийн аюулыг хэрхэн угтсан тухай бичихдээ:

“Хүннүчүүд Галлид халдан довтлох нь гэсэн сураг гарав. Тэр үед Тонгерн хотод (Бельгийн хамгийн эртний хот болой) Араватиус гэгч гойд сүсэгтэй нэгэн хамба амьдарч байв. Тэрбээр байнга мацаг барьж, бурханаас аврал эрж энэхүү дэлхийд гишгэх газаргүй буруу номт ард түмнийг Галлид бүү хөл тавиулаач хэмээн хонон өнжин нулимс асгаруулж мөргөн гуйж байв. Гэвч Галлийн ард түмний элдэв буруу муу үйл нь хамбын аврал эрсэн энэхүү мөргөлд саад тотгор тавьж түүний гуйлтыг бурханд сонсгохгүй байна хэмээн ариун сүнс айлдсан ажээ. Чингэхээр хамба христ архадуудын зүгээс тусалбал бурханы аврал ершөөлийг эрхбиш авах биз хэмээн сэтгээд Ром явахаар шийджээ.

Ингээд тэрээр ном айлдагч архадуудын бунханд очиж тусламж хүсэхээр Ром руу бядан явах замдаа өөрийн бие махбодийг албаар зовоон ташуурдаж асар их зовлон зүдүүр үзжээ. Хоёр гурав хоногоор хоол ундгүй бэдэрч, замын турш тувт мөргөсөөр явжээ. Ийнхүү олон хоног зовж тарчилж явсаар архадад очиж хэрэг зоригоо хэлж тусалцаа дэмжлэг хүссэнд гэгээн архад ийн хариулсан гэжээ: Хувилгаан хүн та юунд надад амар заяа үзүүлэхгүй байна вэ? Бурхан хүннү нарыг Галлид оруулж энэ орныг гал мэсийн аюулд автуулж түйвээн сүйтгэхээр нэгэнт шийдсэн. Энэ шийдвэр өөрчлөгдөхгүй, заавал биелэгдэх ёстой. Харин би ганц л зөвлөлгөө өгье. Бушуухан эгэж хариад орон гэрээ бэлтгэ, амар амгалангийн оронд очиход хэрэгтэй цэвэр даавуугаа мөн бэлтгэ. Чиний сүнс энэ биенээсээ салж одох юм байна. Ертөнцийн эзэн, бурханы бошгоор болох хүннүчүүдийн аймшигт үйлдлийг чиний нүд үл үзнэ” гэжээ.

Хамба энэ бүхнийг архадын амнаас сонсоод яаран замд гарч, Галли нутаг руугаа яаралтай буцжээ. Тонгерн хотдоо ирээд өөрийнхөө оршуулгын ажилд хэрэгтэй бүхнийг бэлтгэсний эцэст хувраг санваартнууд болон хотынхондоо алс газар хэзээ ч эргэж ирэхээргүйгээр явлаа гэдгээ нулимс асгаруулан байж хэлээд сайны ерөөл тавиад замд гарчээ.”

Араватиус хамба Тонгернээс гараад зуун жилийн хойно энэ хотын оронд хамбын өргөөлөн суух хот болох тавилантай Маастрихтыг зорьсон ч хүрч чадалгүй замдаа халуунтай ханиадаар таалал төгсчээ. Хүмүүс түүнийг эртний Ромын заншлаар хөдөөгийн замын хажууханд оршуулаад улс оронд нь их гай гамшиг нөмрөн ирэх нь гарцаагүй боллоо хэмээн итгэж суужээ. Их аюул гамшиг Бельгид хараахан хүрч амжаагүй байсан хүннүчүүдээс бус, харин тэдний холбоотон тюрингчүүдээс ирэв. Гэвч тонгернчуудын бодож санаж, итгэж найдаж байснаас долоон дор юм болжээ. Хэдийгээр Тонгерн хийгээд ойр орчмын газрын оршин суугчид ойртон ирж буй дайсны санаа сэтгэлийг амирлуулж тал засах гэж байдгаараа хичээж дайлж цайлж, тайван амгаланг сахиж, цэрэг дайчдыг хооллож ундалж байхын баталгаа болгож барьцааны хүмүүс гаргаж өгье хэмээн гуйжээ.

“Гэвч дайсан этгээд барьцаанд явуулсан хүмүүсийг нь элдвээр тамлан зовоож алаад өвөг дээдсээс өвлөсөн гэр оронд нь дайран орж (Грегор өөрийн туулж өнгөрүүлсэн үйл явдлын талаар ярьж буй) хамаг эд хогшлыг нь дээрэмдэн авав. Нялх балчир хүүхдүүдийг борвиор нь модонд өлгөж, хоёр зуу гаруй бүсгүйг хэрцгийлэн алав. Бүсгүйчүүдийн гарыг хангал морьдын хүзүүнээс

бэхэлж уяад дараа нь морьдыг тас ороолгоход огло харайж хөөрхий бүсгүйчүүдийг тасар татан хаяв. Зарим нь бүсгүйчүүдийг хөдөө зам дээр хэвтүүлж гадаслаад дээр нь гуалин дэвсэж түүгээр хүнд ачаатай тэрэг гаргаж ясыг үйрүүлж алах ажээ. Амьгүй цогцсыг нь нохойд шувуунд хаяж өгнө”.

Хүний санаанд багтамгүйгээр харгислан тарчлаах аргыг ийн бодож олсон тухай тамлагдан зовж амиа алдсан үй олон хүний түүхийг мэдэх зохиогчдын ном зохиолд их гардаг билээ. Хүннүчүүд морьтон ард түмэн болохоор хурдан шалмаг байхыг машид эрхэмлэдэг, тэр нь тэдний гол зэвсэг учир дээр өгүүлсэн шиг баахан саатаж элдэв жүжиг тавих нь ховор байдаг. Зөвхөн Иранд суурин амьдрах болсон цагаан хүннү нар л иймэрхүү харгислал үйлддэг байсан тухай зарим зохиогчид өгүүлдэг. Ийм тохиолдол хааяа нэг гардаг байсан бололтой агаад дээрхэд Грегор зөвхөн тюрингчүүдийг буруутгаж байгаад итгэж болно. Харин ийм ганц нэг тохиолдол нь дэндүү харгис жигшүүртэй байдгийн улмаас хүний ой ухаанд удтал хадгалагдан үлддэг бөлгөө.

Их аюулын чимээ Мэц хотноо 451 оны улаан өндөгний баярын өмнөхөн дуулджээ. 451 оны 4 сарын 7-ны бямба гарагт хүннүчүүд хотод цөмрөн орж иржээ. “Тэд хотыг галдан шатааж, хүн ардыг цавчин алж, ертөнцийн эзний албат хувраг санваартныг сүмийн хоймрын бурхдынх нь өмнө хороохдоо ч сэтгэл түвдсэнгүй. Хотод тэдний гар хүрээгүй өнцөг булан үлдсэнгүй. Зөвхөн Христийн үзэл санааг амиараа хамгаалсан анхны сүмийн хэргэмтэн Гэгээн Стефаны (*Христийн мэндэлсний баярын хоёрдахь өдөр болох 12 сарын 26-ны өдөр бол Христийн ариун үзэл санаанд чин үнэнч байж түүний төлөө тамлагдан зовж амиа өргөсөн Гэгээн Стефаны өдөр болой.* Орч.) мөргөлийн байшинд л гар хүрсэнгүй. (Архадын түүх, 6, 3-8) Миний бие энэхүү мөргөлийн байшин бүтэн үлдсэн түүхийн тухай сонссон зүйлийнхээ талаар дуугүй өнгөрөхийг үл хүснэ. Дайснуудыг ирэхээс өмнө Стефан архад Петрус (Петр), Паулус (Павел) нарт Мэц хотын мөхөл ирж буй тухай айлтгаж, тэднээс аврал өршөөлөө хайрлахыг хэрхэн мөргөн гуйж буй дүр зураг нэгэн сүсэгтэн хүнд харагдсан тухай хүмүүс ярьцгааж байжээ (...) Архадууд түүнд хариулахдаа: ‘Сайн санаат дүү минь чи сэтгэлээ амирлуулж болно. Чиний мөргөлийн байшин галд автагдахгүй. Харин хотын чинь хувьд бурханы хүсэл зориг нэгэнт ийм учир бид юу ч хийж чадахгүй. Ард олны нүгэл ихдэж, элдэв муу үйлийнх нь тухай сураг чимээ бурханд хүрчээ. Тиймээс энэ хот галд шатаж сүйдэх болно гэжээ” хэмээн өгүүлнэ.

Мэц хотынхны удтал хэлцэж байсан нь энэхүү түүхээс Грегор дүгнэлт хийж “Иймээс тэрхүү мөргөлийн байшин хутагт архадуудын ивээлээр бүтэн үлдэж, хот түйвээгдэж сүйдсэн нь тун харамсалтай явдал болжээ” хэмээжээ. Галлийн ард түмэн нүгэл хилэнцийнхээ төлөө залхаан цээрлүүлэлт үзэхийн учир хүннүчүүдийн аюулд өртөх нь гарцаагүй байсан хэмээх санаа бодол Тонгерны тухай, Мэцийн тухай мэдээ зангид дүүрэн байдаг агаад тэдгээр нь өнөөгийн бидний хувьд үлгэр домог мэт сонсогдож байгаад гайхах хэрэггүй. Хүннүгийн их аюул гамшиг хол ойрын бүх газар орныг хамрах үед хүмүүст зөвхөн сүсэглэж мөргөхөөс өөр арга чарга үнэхээр байгаагүй нь харагддаг. Умард Францын тал нутгийн тариачид бартаа саад ихтэй даваа гүвээтэй уулсын оронд тэмцэн хүрч нуугдаж чадаагүй байдаг. Хэсэг бусаг ой хөвч л бага боловч хамгаалалт болж байжээ. Хүннүчүүд өршөөн хэлтрүүлэх, сүслэн бишрэх гэдгийг огт мэдэхгүй хүмүүс байжээ гэдэг нь бусад эх сурвалжууд, тухайлбал хүннүчүүдийн Реймст байх үеийн тухай өгүүлсэн *Breviaire ancien de Chalons* (Эртний Шалоны товч тойм)-аас ойлгогдоно. Эл хот өгүүлэн буй үйл явдлаас

дөчин гурван жилийн өмнө вандалуудын довтолгоонд өртөж сүйдсэн байсныг үндсэнд нь сэргээн босгоод байжээ. Араватиус хамба хотоосоо гарч явсан бол хамба Нисэйс хотоо орхин явж түвдээгүй нь үхэл түүнийг хаана ч гүйцэнэ гэж өөртөө итгүүлсний учир ажээ. Тэрбээр жанчаа нөмөрч, үзэсгэлэнт залуу санваартан бүсгүй Этропиаг дагуулан ариун сангийн бойпор тэргүүтнийг барьж хүннүчүүдийн өмнөөс тосч очжээ. Тэрбээр олз омогт шунаж, өлсч ундаассан хүннү дайчдыг шившлэг хийж хашаа саравчинд хоргодсон муу сүг сүнсийг үлдэн хөөх лугаа адил зайлуулна хэмээн итгэсэн нь арга ядсан хэрэг байжээ. Гэвч хамбыг псалм (*Христийн шашны мөргөлийн үед дуулах дуу.Орч.*) аялгуулан дуулж явах зуур нэгэн дайчин толгойг нь цавчин унагажээ. Ийм үйл явдлыг тойрон бүрэлдэх домог нь заншил ёсоор дурдсан хэрэг явдлыг цогчин дуганы өмнөх талбайд шилжүүлэх нь зүй, мөн энд таарч тохирох псалмыг бодож олох нь тодорхой. Ингээд Давидын псалмуудын нэг, библийн хамгийн сайхан шүлгүүдийн нэгэнд тооцогддог псалмыг уншиж аялж явсан хэмээн домог өгүүлнэ. Үүгээр бол хамба Нисээс дараах псалмыг аялгуулан уншиж явжээ:

“Эзэнтээн, дээшлэх ажаамуу,
Хүн бус, араатан ноёлж байна цаана чинь
Буруу номтнуудыг гэсгээн цээрлүүлж хайрла” (*Утгачилан орчуулав.Орч.*)

Хамба ламтны уншиж явсан тарнийн утгыг нэгэн дайчин ойлгоод хариулах санаагаар илдээ даруй сугалж хамбын толгойг цавчин хаяжээ. Гэтэл гайхамшигтай явдал болж хамбын толгой газарт өнхөрч явах зуур мөнөөх псалмыг дуустал хэлж амжсан ажээ:

“Эзэнтээн,
Тэдэнд аюул зовлон илгээж хайрла,
Буруу номтон ч гэлээ хүн л гэдгээ ухаарч аваг.”

Үүнээс илүү сайхан хэлнэ гэж юу байхав, хүннүчүүд энэхүү нарийн утгыг нь даруй ойлгоод мунхаг хилэндээ гэмшиж гэнэт ухаан орсон бололтой, амиа алдсан санваартны дэргэд ёслолын цав цагаан хувцастай зогсох Этропиа руу эргэжээ. Харин Меровинг (*V-VIII зууны дунд үе хүртэлх франкуудын хаадын хамгийн эртний овгийн нэр, тэдний дараа Каролингийн овог залгажээ.Орч.*)-ийн он дарааллын түүхчийн тэмдэглэснээр “үзэсгэлэн гоо бие цогцосныхоо улмаас ариун онгон биеэ бузарлуулах нь” хэмээн айсан бүсгүй алуурчин руу дайрч нүдийг нь маажиж сохолсонд мөнөөх хүннү цэрэг хөсөр унажээ. Ингээд бүсгүй ч алагдаж, хүннү нар хотынхныг толгой дараалан хядаж эхэлжээ.

Гэв гэнэт сүмийн хүнхэр орой чих дүлийрэм хүнгэнэж нээлттэй хаалгаар аймшигтай чанга дуу гарсанд хүннүчүүд тонож дээрэмдэж, алж хядахаа даруй больж хотоос зугтжээ. Тэд мухар сүсэгтээ баригдсаны учир ихэд айн цочиж дээрэмдсэн олз омгоо ч хаян оджээ хэмээн домог өгүүлнэ. Ийм гайхалтай сонин түүхийг уншиж буй хорьдугаар зууны уншигч хүннүчүүд аврага хонхны дууг ойроос сонсоогүй юм болов уу гэж асуух нь зүй. Хаалга нь онгорхой сүм хүнхийж харлаад сороод залгичих амьтан тэнд буй мэт, их биеэсээ таслагдсан толгой ярьсаар байсан зэрэг нь хүннүчүүдэд энэхүү Галли газар нутаг дээр нэгэн айхтар хүчирхэг бурхантай тулсан мэт сэтгэгдэл төрүүлсэн байж мэднэ. Эндээс Парис ойрхон учир өнөө цагт хөгжөөн наадам байнга бялхаж байдаг Монмартр уулан дээр ромчууд толгойг нь авсан хутагт Дениз Нисэйс хамбыг сугадан авч өнөө хуучин сүм нь хэвээрээ байгаа, хутагтын нэрийг хадгалсаар олон зууны турш Умард Франц дахь эргэл мөргөл, зах зээлийн чухал төв болж

байсан тэр газарт авчирсан, буруу номтны илд хувилгаан чадалтай үгсийг нь тасалж чадахгүйн учир гэгээн Нисэйс псалмаа уншиж дуусгасан хэмээнэ.

Хотын хэрмийн ард хоргодож суухын оронд хүннүчүүдийн өөдөөс тосон очдог хамба Нисэйс нь сүмийн тэргүүн гэхэд хэтэрхий гэнэн итгэмтгий хүн мэтээр Францын ардын ярианд гардаг нь бас ч аргагүй мэт. Өнөөдөр хэн ч бай Нисэйс гэдгийн герман нэрийн хувилбар нь ямар байхыг сурвалжилж үзэхэд “алмай амьтан”, “дүйнгэ хүн” гэж орчуулагдана.

Өнөөдөр Реймс хотоос Парис руу машинаар гарвал дороо хүрнэ. Тэр үед ч хүннүчүүдэд Парис ороход их цаг орохгүй байсан нь магад. Тэнд эсэргүүцэн хамгаалах хүч байгаагүй гэдгийг эх сурвалжууд өгүүлж буй. Ойр хавьд нь Ромын цэрэг ч байгаагүй. Хүн ам нь дэмий л хотын дарга нараасаа аврал эрж, сүсэглэж мөргөхөөс хэтрэхгүй байжээ. Гэгээн Женофева хатны намтар зохиолд “Парисын хүн ард Аттилагийн хэрцгий догшин цэргээс сүнсээ зайлтал айн сүрдэж эхнэр хүүхэд, эд хөрөнгөө Парисаас нүүлгэж аюул осолгүй газар аваачиж байхад гэгээн Женофева эхнэр хүүхнүүдэд хандаж төрж өссөн хотоо орхих бус, харин эрчүүддээ хүч нэмж дайсны дайралтыг сөрөн тулалдахыг уриалж зоригжуулах хэрэгтэй хэмээн ятган сэнхрүүлэв. Бурханы тусламжид түшиглэж аврагдана гэж итгэж найдах хэрэгтэй (...) гэж айлдав. Мөн тэрээр эрчүүдэд хандаж, сандарч мэгдэж эд хөрөнгөө Парисаас гаргах гэж яарахын оронд бурханд мөргөж итгэж найдах хэрэгтэй. Нөмрөн ирэх аюулаас бурхан л тэднийг аврана. Баттай хамгаалагдсан гэгдэж байсан хотууд хүннүчүүдийн хэт давуу хүчинд автагдаж сүйрсэн бол Парис л бурханы авралаар хөндөгдөлгүй үлдэнэ хэмээн айлдсан болой” хэмээжээ.

Нөгөөтэйгүүр Парис хот Иль де ла Сит (Парис хот тэр үед Сена мөрний дунд орших арал дээр байрлаж, хараахан тэлж өргөжөөгүй байсан үе болой. Орч.) дээр байрлах учир дайран эзлэхэд ихээхэн бэрх байжээ. Норманнууд хожмын зуунуудад хэдэн зуун хөлөг онгоцоор Сена мөрнийг өгсөн дайлаар ирсэн ч эзлэн авч чадаагүй билээ. Хотын оршин суугчдыг зэвсэглэж хотоо хамгаалахад босгох ажлыг эрчүүд юм уу, итгэл хүлээсэн цэргийн нараас илүү уур хилэндээ шатсан аль нэг эхнэр хүүхэн хийчих явдал байдаг. Тиймээс хүннүчүүд мэтийн хот бүслэн байлдах чадвар муутай дайснаас аврагдах боломж бас байжээ.

Хүннүчүүд аль нэг хотыг шууд эхний дайралтаар эзэлж чадахгүй бол хаяад явах юм уу, эсвэл багахан цэргийн ангиар бүслүүлж орхих явдал байсан. Хэрвээ л оршин суугчид нь сонор соргог, эв нэгтэй хамгаалан тэмцэж чадвал хот удтал тэсч, хүннүчүүд хаяад явах тохиолдол ч байжээ. Дунай мөрний цутгалан Осма голын хавьд орших Азимус хэмээх жижиг хотын жишээ үүнийг харуулна. Энэ хотыг хүннүчүүд 441-442 онд дайран эзлэх гээд бараагүй, Азимус хотын оршин суугчид үе үе хотоосоо гарч эрэлхэгээр дайрч хүннүчүүдэд ихээхэн хохирол учруулж байсан учир тэд эцэстээ бүслэлтээ зогсоожээ.

Ямар ч болов Парис эзлэгдсэнгүй, хүннүчүүд ромчуудын тавьсан дардан замаар Вестгоотын гүрэн, нарийн ярьвал түүний хамгийн хойд талын хот Орлеаныг чиглэжээ. Реймст хамгийн ойр Шалон-сүр-Марне дүрвэгсдээр дүүрсэн байв. Зөнд нь хаясан мал сүрэг хаа сайгүй, айлуудын байшингаас утаа ч гарахгүй, сүм хийд хаягдаж хоосорсон байв. Шаланоос гадна Монт-Арме хэмээх бэхлэлт дүрвэн ирэгсдийн орогнох газар болжээ. Хүннүчүүд бэхлэлтийг явуут дайран орж түр зуур тулалдсаны эцэст эзлэн авав. Хэдэн зуун хүн амь

үрэгдэж, хэдэн мянган хүн олзлогдов. Хүннүчүүд харьцангуй яаралгүй тайван давшиж явсан нь харагдана. Аетиус, вестгоот, меровингийн франкуудаас аль нь ч үзэгдэхгүй, сураг чимээ ч үгүй байв. Зөвхөн нутгийн оршин суугчид л эсэргүүцэл үзүүлж, бүх юм өнгөрсөн хойно үхэл тулж ирэхэд хялгасан чинээ амийнхаа төлөө үхэлдэн тэмцэлдэж байжээ.

Шалон хот харьцангуй гайгүй өнгөрөв. Тэндээс холгүй байрлах бэхлэлт хүннүчүүдэд Шалоныг гэм хоргүй амгалан тайван хот мэт санагдуулсан байж болно. Хотынхон Трое хотын гэгээн Лүпийн шавь уран цэцэн үгтэй Алпин хамбад хамаг итгэл найдвараа тавьж байжээ. Алпин хамба бол шившлиг хийх, тарнидах үйлд тун гаргууд, хүслийг биелүүлэх чадалтай хэмээн нэрд гарсан хүн байжээ. Аттила шашин мөргөл гэж мэдэхгүй, мухар сүсэгт итгэх нь илүүтэй хүн байсан учир залуу хамбын тэрхүү хүч чадлын талаар дуулсан байж болно.

Ийнхүү Алпин хамба хотоос гарч өнөөгийн Рү Балбатерын хавьд Аттила хааныг тосч уулзаад тайван амгалан Шалон хотыг эвдэлж галдсанаас зүгээр орхивол өөрт нь илүү ашигтай шүү дээ хэмээн ятган итгүүлсэн ажээ. Алпин хамба Аттила хаанд өнөөдөр “Аттилагийн хүрээ” (*Camp d'Attila*) хэмээн зочид жуулчдад үзүүлдэг шороон далан бэхлэлтийг харуулсан байж магад. Бяцхан хотын гүн сүсэгт хамба түүнд ямар их тус хүргэж буйг хаан тэр дороо ойлгосон байна. Тэрхүү бэхлэлт нь аян дайны асар их олз омгоо найдвартай хадгалж, шархадсан хүмүүсээ санаа амар орхиж, мөн удахгүй учрах вестгоотуудыг тосон байлдах байрлал болгож өргөжүүлэн бэхжүүлж болох газар байв. Аттила хаан Аетиуст итгэхээ аль хэдийн больсон байв. Тэр өөрийг нь тосч Лэх юм уу, Райнд хүрэлцэн ирж болох байв. Гэтэл тэгсэнгүй.

Алпин хамба ч тухайн цагийн байдлыг овжин ашиглав. Чөтгөр шулмын ангууч гэгдсэн энэ ламтан чөтгөртэй аймшиггүйгээр эвсэж түүнд дараах саналыг дэвшүүлжээ: Марнын иргэд бид бүгд хаан чамайг ч, чиний эхнэрүүд, цэргийн хүрээ, шархадсан хүмүүс, олз омгийг чинь ч хамгаална. Харин Монт Арме хотоос чиний цэргүүдийн олзлон авч урт сураар оосорлон чирч тамлан зовоож яваа манай тариачдын эхнэр хүүхдийг хаан чи суллаж тавь хэмээжээ.

Энэ нь Аттила мэтийн зоргоор дарангуйлагчийн хэрээс ч хэтэрсэн шаардлага байлаа. Бидний хувьд хүннү хүмүүс хоорондоо бүгд адилхан харагдахын нэгэн адил хүннүчүүдийн хувьд ч галлийн нэг тариачин бүсгүй нөгөөтэйгөө мөн л адилхан харагдах нь мэдээж. Тэгээд ч ноорхой хувцсыг нь шувт татаад хаячих юм уу, холбоотой чирэгдэж яваа олзны хүүхнүүд шиг хүннүчүүдийн өмсдөг салбархай хувцас хунар эгэлдрэглэсэн бол тэднийг өөр хооронд нь ялгах салгах ямар ч аргагүй. Тэгээд ч цэргүүд эрийн сайнаар олж авсан олз омгоо буцааж алдах дургүй учир эсэргүүцэн тэмцэлдэж байжээ. Тиймээс Аттила ч хэлсэн амнаасаа буцаж, баахан юм донгосч учир утгагүй санал тавьсан хамба Алпин мөнөөх Нисэйс хамбын тавиланг амсах нь гарцаагүй болох үес Монт Арме хотын оршин суугчдаас баахан хүн олзлон авч явсан хүннү цэргүүдийн бие аймшигтай өвдөж татаж татвалзаж эхэлжээ. Тэд цусан суулгаар өвдөөгүй нь лавтай ч өнөө бидний нэрлэдэг гэдэсний ханиад (гэдсэнд тусах ханиадны хэлбэр) буюу хоолны хордлогоор өвчилсөн байсан нь магад. Гэвч үүнийг чөтгөр шулмыг үлдэн хөөгч Шалоны хамбын хийсэн ажил гэж хүннүчүүд ойлгожээ. Ингээд Монт Арме хотын охид хүүхнүүд дараа өдөр нь бүгд эсэн мэнд Марндаа буцаж ирээд амь аврагдлаа гэдэгтээ итгэж ч чадахгүй байжээ. Хүннүчүүд Марн голыг олон газраар гатлаад өмнийг чиглэжээ. Үзэсгэлэнт сайхан Трое зэрэг зарим хот азаар эсэн мэнд өнгөрч их хамбатан

гэгээн Лүп жаран насны босгыг алхсан байсан хэдий ч эр зоригоороо шавь нараасаа дутахгүй гэдгээ харуулж удалгүй Аттилатай их л сонин байдлаар харгалджээ. Эсвэл Аттила өөрөө маргааш нь Реймсээс явахдаа шашны эдгээр өндөр хэргэмтнүүдийг өөрөөр үзэх болж, өндөр нэр хүндтэй номхон хүлцэнгүй санваартан эрхмүүд амьд мэнд байхаасаа илүү үхсэн хойноо аюултай, хувилгаан чадалтай юм байна гэж ухаарсан юм болов уу?

Хүннүчүүд тэр үеийн Агединкум, өнөөгийн Сонсоор дамжин Орлеаныг зүглэжээ. Тэд 4 сарын 7-ны өдөр Мэц хотыг эзэлснээс хойш тувт байлдан тулалдаж, түйвээж сүйтгэж явсаар таван зуун километр зам туулж, хот суурингууд эзлэн авч, хүрээлэн бууж, бэхлэлт хэрмүүд нурааж, гол мөрөн гаталж явжээ. Хүннүгийн арми бум орчим хүнтэй байсан, морин цэрэг нь зөвхөн хүннүчүүдээс бүрдэж, тэд нь илүү хурдан гавшгай ч явган цэрэг, хөсөг тэрэг, бүслэлтийн машин төхөөрөмж нь алгуур удаан давшиж явжээ.

Хүннүчүүд ийн явахдаа өдөрт арван километр зам туулж нийтдээ арван дөрвөн хоног л буудаллаж амарсан гэж үзвэл тэд нэлээд хурдан, бараг л өнөөгийн биднийхээс дутуугүй хурдтай явсан мэт. Ийм хурдтай яваад ч 6 сарын эхний хагаст Орлеаны дэргэд хүрч хотыг бүслэн авахад хоёр сар илүү хугацаа зарцуулсан агаад бүслэлтийн машин төхөөрөмж, хөсөг тэргээ татаж авахад цаг хэрэгтэй байжээ. Түүрс хотын хамба Грегор энэ тухай дор өгүүлнэ:

“Энэ хотод гойд ухаантай, хавь ойрдоо алдаршсан гэгээн Анианус гэгч хамба байсан бөгөөд түүний гайхамшигт үйлийн тухай баттай мэдээ баримт үлджээ. Хүннүгийн хаан бэхлэлт эвдэх хүнд төхөөрөмжөөр хотын хэрэм, хаалгыг эвдэлж дайран орохоор бэлтгэн ахуйд бүслэлтэд зовж зүдэрсэн ард түмэн Анианус хамбад хандаж аврал өршөөл эрсэнд тэрбээр хамаг итгэл найдвараа бурханд даатгаж сөгдөж мөргөн тусламж эрэх хэрэгтэй хэмээн айлджээ”

Уран илтгэгчид үгээ чангаруулж лавшруулсаар оргилд нь хүргэдэгийн адилаар Грегор хамба Орлеан хотын оршин суугчдыг уран үгээрээ ятган сэнхрүүлж бурханд гурван удаа мөргөн гуй, хотын хэрмэн дээр гурван удаа гарч аврал ирж буй эсэхийг хар гэж айлджээ. Гэвч хотынхон ёсоор хийж удтал хүлээгээд сүүлдээ эргэлзэж арга нь барагдаж эхлээд “өтөл хамбынхаа сургаснаар гуравдахь удаагаа хэрмэн дээр авиран гарч хөдөө тийш хараа сунгахуйд алсад тоос гарахыг харжээ. Тэгээд хамбадаа энэ тухай айлтгасанд тэрээр ‘Энэ бол дээд эзний тусламж ирж буй хэрэг’ хэмээжээ. Энэ завсар хотын хэрэм хүннүчүүдийн түншүүр машины хүчит цохилтод өртөж нурж унахын даваан дээр Аетиус хийгээд Вестгоотын хаан Теодерих, түүний хөвгүүн Торизмунд нар цэргээ удирдан ирж дайсныг бутцохин хөөжээ. Ийнхүү хот гэгээн хамбын бурханаас (тэнгэрээс) аврал эрсний ачаар чөлөөлөгдөж, туслаар ирэгсэд Аттилаг цохиж дутаалгав. Аттила Мауриакийн (*Хоёр этгээдийн их тулалдаан болсон Каталауны тал нутгийг тэр үед мөн Мауриак хэмээн нэрлэж байжээ. Орч.*)-ийн тал газар хүрээд цэргээ засч зэвсгээ хурцлан байлдаанд бэлтгэв. Тэд (ромчууд, вестгоотууд) ч энэ тухай сонсоод мөн л бүх хүчээрээ сөрөн байлдахаар бэлтгэжээ.” Түүрс хотын хамба Грегор ийн өгүүлжээ.

Орлеаны төлөөх өрсөлдөөн тэмцлийн түүхийг бусад хуучин, шинэ зохиолчид судалж зохиол бүтээл туурвисан нь бий. Тэр цагаас хойш Луар мөрний Орлеан хот Франц орны хувьд ноёлох байр суурьтай байснаар барахгүй ихээхэн чухал үүрэг гүйцэтгэж ирснийг түүх дахин давтан харуулсаар ирсэн

бөлгөө. Орлеан хот Вестгоотын гүрний хамгийн захын хот байсан бөгөөд Теодерих хааны зөвшөөрлөөр Аланы ноён Сангибанус захирч байжээ. Францын бусад нутгийг байлдан дагуулахын тулд Орлеаны ойр Луар мөрний дээгүүр тавьсан гүүрийг эзлэн авах, Вестгоотын гүрнийг дайлая гэвэл Орлеаныг эхлээд эзэлж авах учиртай байсан болой.

Луар, Марн хэмээх хоёр мөрний завсар өрнөсөн халуухан үйл явдлуудыг гэрчилж түүхэнд үлдээсэн хүн бол христ шашинд орж, бие дааж ном үзсэн Иорданес нэрт гоот хүн байлаа. Тэрээр тухайн үедээ хэн хүний учрыг нь сайн мэддэггүй гэрчлэгч (нотариатч)-ийн ажил хийдэг байжээ. Иорданис, мөн заримдаа Иорнандес хэмээгдэх энэ хүн түүхийн хоёр бүтээл туурвиж эхлээд 551 он буюу Каталауны талд болсон улс түмний их тулалдаанаас хойш яг зуун жилийн дараа дуусгажээ. Нэг түүх нь дэлхийн түүх маягийн бүтээл агаад тухайн үеийн заншлаар Адамаас эхэлж зохиогчийн амьдарч буй үе хүртэлх цагийг хамарсан бөгөөд түүнд Ромын эзэнт гүрэн гол байр суурьтай байсан нь ойлгомжтой.

Харин бидний хувьд *De origine actibusque Getarum* (Гоотуудын гарал үүсэл, амьдрал үйлийн тухай) хэмээх гоотуудын түүх нь илүү чухал ач холбогдолтой, уг түүх бусад зохиолчдын бүтээлээс авсан олон ишлэлтэй агаад мөн бидний хувьд ихээхэн сонирхолтой үйл явдлуудын гэрч болсон, маш үнэ цэнэтэй ч харамсалтай нь үрэгдэж алга болсон Кассиодорын түүхийн нэлээд хэсгийг агуулж буй. Флавиус Магнус Аурелиус Кассиодор бол Хүннүгийн хааны ордонд сууж байсан Өрнөд Ромын элчин Кассиодорын хүү бөгөөд Ромд өндөр алба хашиж ахиж дэвшсээр 507 онд куестор, 514 онд консул, сүүлд сенатч болжээ. Тэрбээр Их Теодерих хааны нууцын нарийн бичгийн дарга, зөвлөх нь байсан бөгөөд ромчууд, остгоотуудыг хооронд нь эвлэрүүлэхийн төлөө зүтгэж явсан хүн болой. Тиймээс Кассиодорын бүтээл нь Прискүсийн тэмдэглэлийг эс тооцвол түүхийн бусад аль ч бүтээлээс илүү чухал ач холбогдолтой эх сурвалж юм. Иорданес сүмд он удаан жилээр шавилан сууж ахуйдаа Кассиодорын бүтээлээс түүвэрлэн хуулж авсан нь бэрхшээлээс гарах аятай гарц болсон юм. Түүний латин хэл нэг их сайнгүй ч тоох хэрэггүй. Харин түүний аливааг гоёчлох, домгийг хэт шүтэх хандлага баахан эргэлзээ төрүүлдэг. Ийм хандлага одоо үдшийн орнуудын бүх сүм хийдэд давамгайлах байдалтай болжээ. Гэсэн хэдий ч Иорданесын гоотуудын түүх бидэнд уламжлагдан ирсэнд баярлах учиртай. Яагаад гэвэл зохиогч нь том зохиолч биш, харин тун нямбай зүйвэрлэн зохиогч байсан нь завшаантай хэрэг бөлгөө. Тийм болохоор уг түүх жинхэнэ эхээсээ ялгагдах юмгүй шахам, найдвартай эх булаг болж буй юм. Чухам үүний учир хүннүчүүдийн эсрэг ажиллагаа яагаад тийн оройтсон тухай асуултад хариу өгч чадахгүй. Яагаад захын нэг арми биш, чухамхүү Ромын эзэнт гүрний их арми Францын умард нутгийг тэр чигээр нь, өргөн уудам тариан талбай бүхий үржил шимт нутгийг зөнд нь хаяж дайсны идэш болгосны учрыг тайлж чадахгүй.

Гэхдээ ийм асуулт тавигдах нь зүй. Тэр тусмаа хорьдугаар зууны сүүлийн хугаст амьдарч буй хүмүүс энэ талаар сониучирхах нь зүй. Тэр үед Европын хил чухам хаагуур өнгөрч байв? Хүннүгийн их цэрэг хэдийнээ Дунайг өгсөж үерийн догшин ус мэт давалгаалан ирж замдаа таарсан болгоныг хаман залгисаар дөхөж ахуйд Аетиус аль нутгийн ямар газар ухарч очихоор төлөвлөж байв? Базель, Бельгийн хооронд болон Дорнод Францын Вогесен, Эфел хоёрын завсарт уулархаг газар элбэг учир түгшүүрээр босгосон багашаархан цэргийн хүчээр ч болов хүчээр давуу дайсныг саатуулж барих бүрэн боломжтой байжээ. Чингэж чадна гэдгийг алеманнууд харуулсан бөгөөд чухамхүү тэдний жишээ л

зэрлэг улс орнуудаас сэргийлэн хамгаалах Ромын систем яагаад ажилласангүй вэ гэдэг асуултыг хурцаар тавьж буй. Гэтэл Аетиус урьд өмнө тогтвор муутай бүргүндчүүдийн зүгээс багашаархан аюул үүсэх төдийд л ямар айхавтар, ямар хурдан арга хэмжээ авч байлаа даа! Тэднийг хүйс тэмтэрч, талын түймэр лугаа адил нам дарсан билээ. Гэтэл Аттилад Франц газар ийн дураараа тонгочих боломж олгосны учир нь тэдгээр зэрлэг овог аймгийнхан Галли нутгийн хаа нэгтээ хоорондоо хэмлэлдэж бие биенээ хядаж магадгүй хэмээсэн түүний атгаг санаанаас үүдсэн байх магадлалтай. Хэрэв чингэвэл урьдын ид хав, эр зоригоо үзүүлэх боломж Ромд гарч ирнэ.

Хэрвээ Аетиус үнэхээр ингэж бодож төлөвлөсөн нь үнэн бол тэрээр ёстой л шулмын санаа агуулж байсан гэж хэлж болно. Түүний ийм санаа хэрэг дээрээ үндсэндээ оносон гэдгийг бид мэднэ. Ромын цэрэг дангаараа тулалдааны талбарт гараад Аттилаг дийлж хүчрэхгүй гэж Аетиус үзсэнийг бид ойлгож болно. Их тулалдаанд Аттилатай ойролцоо хүчээр орохын тулд вестгоотуудыг талдаа татах хэрэгтэй байв. Ийнхүү хангалттай хүч хуримтлуулаад Галли нутагт хаа нэгтээ хүннүчүүдтэй тулах хэрэгтэй байжээ. Харин хүннүчүүдтэй Райн мөрний бэлчирт тулалдсан бол ромчууд хүйс тэмтрэгдэх байв.

Тэгээд Аетиус болон түүний дипломат туслахууд яриа хэлэлцээ хийж сахиулсан тэнгэрийн хэлээр уран сайхан үгээр ятгаж сэнхрүүлэх ажилдаа оржээ. Аетиус вестгоотуудыг хэдэн арван жилээр дайлж, хүннүчүүдийг ч тэдний эсрэг турхирч байсан учир тэд түүнийг үзэн яддаг байсан юм. Бүргүндчүүд бол Аетиусыг бүр ч үзэж чаддаггүй байсан. Аетиус бүргүнд ард түмнийг хүннүчүүдэд хялбархан олз болгон хаяж өгч байсан хүн болой. Ингээд хүннүчүүдийн давшилтын чиг тодорхой болж Аурелиана нутаг, Луар мөрний дээрх Орлеан хотыг эзлэх зорилго агуулсан нь тодорхой болсны хойно л вестгоотууд аюул нөмрөн ирж буйг ойлгожээ. Салийн франкуудын залуу ноён Меровех Рипуарын франкуудыг удирдан Хүннүгийн цэргийн бүрэлдэхүүнд орж Галлийг зорин ирж яваа Гундебаудтай тулалдахын хүслэн болж байв.

Хүннүчүүдийг сөрөн байлдах цэргийн гол цөм нь I Теодорихийн толгойлсон вестгоотууд, Аетиусын удирдсан хот сахих цэрэг болон Хойд Италийн цэргийн ангиудаас бүрдсэн Ромын анги нэгтгэлүүд, 448 онд таалал төгссөн хаан Хлогиогийн хөвгүүн Меровехийн манлайлсан Салийн франкуудаас бүрджээ. Ингээд энэхүү шийдвэрлэх тулалдааныг дүрслэхэд хэрэг болохоор дайн байлдааны өдрийн тэмдэглэл гэж байхгүйн учир Иорданес болон мөн түүний боловсруулсан Кассиодорын түүх юу өгүүлэхийг үзье.

“Аланы хаан Сангибанус нөмрөн буй аюулаас айж сүрдэхдээ Аттилад буун өгч өөрийн байрлаж байсан Салийн Аурелиана (Орлеан) хотыг тавьж өгье гэж амлажээ. Теодерих, Аетиус хоёр энэ тухай олж мэдээд Аттилаг тулалдааны талбарт хүрэлцэн ирэхээс өмнө амжиж хотыг өндөр ханаар бэхлэн хамгаалав. Тэгээд сэжиглэгдсэн Сангибанусыг цэрэгтэй нь хамт өөрсдийн цэргийн дунд байрлуулжээ. Үүний улмаас цочирдож, төлөвлөгөө нь нурсны улмаас итгэл алдарч эхэлсэн Аттила тулалдаан эхлэхээ алгуурлаж байв. Түүгээр ч үл барам зугтах санаа ч түүнд төрж байсан гэдэг.” Аливаа нэг хотыг бүслэн байлдаж буй армийн хувьд бүслэгдэгсдэд туслаар ирэх арми гэв гэнэт гарч ирэх шиг аюул гэж байдаггүй гэдэг. Ийнхүү хүннүчүүд Орлеаны дэргэд хоёр галын дунд оржээ. Домогт өгүүлснээр вестгоотууд, ромчуудын туслах арми давшин ирэх үед хүннүчүүд хотын дотор тулалдаж сүйтгэж байсан ажээ. Тиймээс хориглон хамгаалахад бэлэн бус байсан нь эргэлзээгүй. Дундад зууны үеийн ямар ч арми

ялгаагүй л ийм байдалд орох байсан нь гарцаагүй. Дундад зууны цэрэг дайны хэрэгт олз омог хэмээх зүйл өнөөдөр бидний төсөөлшгүй тийм чухал үүрэг гүйцэтгэж байсан юм. Арабчууд Түүрс, Пуатьегийн завсрын нутагт Карл Мартельтай байлдахдаа чухамхүү олзноосоо болж л бутцохигдож байлаа. Түрэгийн 200 000 цэрэг 1683 онд Вена хотыг бүслэн байлдаж байхдаа мөн л олз омгоосоо болж бүслэгдэгсдэд туслаар ирсэн 70 000 хүнтэй армид ялагдаж байсан болой.

Орлеаны дэргэдэх тулалдааны ялалт бол Аетиусын хувьд санамсаргүй явдал байлаа. Вестгоотууд байлдаанд шууд оролцсон уу, эсвэл давшин ирж явсан уу, хүннүчүүдээс Луар мөрний хотод цөөн зарим анги нь л байлдсан уу гэх зэрэг асуултад бид хариулж чадахгүй. Энэ тулалдаан бол эзэрхэг түрэмгий араатныг зүгээр л нэг хатгаад авахын дайтай үйл явдал байсан болой. Илүү ч үгүй, дутуу ч үгүй. Ухрах зам нэгэнт байхгүйн учир Луар мөрнийг гаталж чадаагүй ч гэсэн хориглон байлдсаар ухрах, тулалдалгүйгээр хурдан зугтах, эсвэл ил цагаан газар гарч их тулалдаан хийх зэрэг боломжууд Аттилад байсан юм.

Аттила дээрх гурван боломжоос хамгийн их эрсдэлтэйг нь сонгож авсан нь хоёр шалтгаантай. Нэгд гэвэл их тулалдаан хийж байж л эцсийн ялалтад хүрч чадах байв. Ялагдах юм бол ард нь асар их олз омог нь даллан дуудах Орлеан байв. Тэндээс яаж ийгээд дорно зүг зайлан одох ёстой байв. Ялах юм бол Европын төлөөх энэхүү аврага тулалдааны мөрий болох баян чинээлэг Галли нутаг, дээр нь Ромын эзэнт гүрэн тэр чигээрээ өмнө нь цэлийж байв. Хоёрдахь шалтгаан нь мөнөөхөн европчуудын хувьд огт ойлгомжгүй явдлууд (Аттила Европын зарим юмыг ойлгодоггүйн адил)-ын нэг болой.

“Аттилад зугтан одох санаа төрж байсан” хэмээн бид Иорданесын түүхээс уншсан. Иорданесын цааш өгүүлэх зүйл нь Ромын сэтгэлгээ бус, харин түүний төрөлх гоот араншинг илтгэнэ. “Гэхдээ энэ нь үхлээс ч илүү гутамшигтай. Тиймээс Аттила цаашдын ажил явдал нь ямар болох тухайд үзмэрчээс асуухаар шийджээ. Үзмэрч хуучны ёсоор амьтны гэдэс дотор, мөлжиж хуссан (дараа нь галд түлсэн) ясаар мэргэлээд хүннүчүүдэд их гай гамшиг тохиолдох юм байна хэмээжээ. Гэхдээ түүний өгүүлсэн нэг л зүйл Аттилагийн санааг тайвшруулсан аж. Дайсны цэргийн нэгэн их жанжин амиа алдана. Үүний улмаас дайсан этгээдэд нь ялсны ашиг тус гарахгүй юм байна гэж үзмэрч айлджээ. Аттила ялагдлын үнээр ч атугай тухайн үеийн (бас алс хэтийн) төлөвлөгөөгөө хэрэгжүүлэх замд нь хөндөлдөж буй Аетиусыг замаасаа зайлуулахыг ихэд хүсч байсан учир тун болгоомжтой байж (ер нь тэрбээр дайн байлдааны үйлд хэзээ ямагт маш хянуур болгоомжтой ханддаг байв) алгуурласаар нар гарснаас хойш есөн цаг өнгөрсний дараа тулалдаанаа эхэлжээ. Энэ нь хэрвээ хэрэг бишдэж ялагдвал шөнийн харанхуйгаар зугтан зайлна гэсэн санаанаас үүджээ...”

Эдгээр цөөн мөр чухамхүү түүний амьдралын хамгийн хүнд цаг мөчийг тольдон харуулах бөгөөд он удаан жилээр өрсөлдөж явсан ахыгаа удтал эрэгцүүлж цэгнэсний эцэст алах шийдвэрт хүрсэн явдал нь ч түүнд ийн хүнд тусаагүй буй заа. Харин Орлеаны нутгаас ийнхүү ухарч явахдаа хэдийгээр ялагдлаас зайлсхийж болох ч Аетиусыг л замаасаа зайлуулахын тулд “зөв харж инээж, буруу харж уйлж” байгаад ч болов ялагдах хүлээж болох юм гэсэн бодол Аттилаг эзэмдэж байжээ. Аетиусыг л үгүй хийж чадвал Ром залж чиглүүлж явдаг хүнээ алдаж, улмаар хүннүчүүдийн олз болох ёстой байв. Босфорын шинэ эзэн Маркианосын тухайд Аттила мэдэх юмаар хараахан бага байсан. Харин Галла Плачидиаг бол тэрээр байдаг л нэг эхнэр, эзэн хааныг эхийн банзалнаас

зуурсан эрх танхи, сул дорой амьтан гэж үздэг байсан юм. Түүний хувьд дэлхийд ноёрхлоо тогтоохын төлөөх их тулалдааны гол өрсөлдөгч нь гагцхүү Аетиус л байлаа. Тулалдаанд бүрмөсөн сүйрэхгүй л байвал, Аетиусыг л устгаж байвал ялагдах бол юу ч биш байв. Чухамхүү бүрмөсөн сүйрэхгүйн тулд л шөнийн харанхуйг ашиглах хэрэгтэй байжээ.

Арван таван зууны өмнөх үйл явдлыг эрэгцүүлж тойруулж, судалж үзээд Хүннүгийн хааныг их жанжны авьяас билигтэй, алсыг харсан ухаалаг хянуур бодлоготой хүн байсныг үгүйсгэсэн эрдэмтэд 451 оны зуны өдрүүдэд Луар мөрөн дээр чухам юу болсныг гүйцэд ухаарч ойлгоогүй байна. Гэвч энэ нь Хүннүгийн хааны мэргэ төлөгт дулдуйдаж шийдвэр гаргах чадварыг үгүйсгэж үл чадна. Аттила хааны хувьд галд түлэгдэж ан цав гарч мэргэ төлөг өгүүлэх мал амьтны яс бол наран жаргах зүгийн орнуудын цэрэг армийн хэдэн зууны турш тулалдаанд авч ордог байсан нандин шүтээнээс ялгаагүй утга учиртай зүйл байсан бөлгөө.

Нөгөө талд Аетиус, Теодерих нарын хувьд ч бүх асуудал хараахан бүрэн гүйцэд тодорхой болоогүй байв. Вестгоотын хааны хөвгүүн Торизмунд Орлеан хотыг бүслэлтээс чөлөөлөх байлдаанд хамжиж оролцжээ. Хүннүчүүдийн эсрэг нэгдсэн холбоотнуудын цэрэг Луар мөрнийг гатлаад нөгөө талд нь аажмаар цугларч эхэлж байв. Аетиус хүннүчүүдийн хойноос хөөцөлдөхийг яарахгүй байв.

Орлеаныг бүслэн байлдагсад дайсны зүгээс гавьтай шахалт үзэлгүйгээр зүүн хойд зүг Трое руу ухарч, алгуур тайван явсан нь Орлеаны байлдааны дараа цэргийн анги нэгтгэлүүдийг амрааж тайвшруулан урам зориг нь сэргэхэд тус болжээ. Тэр үед хүүхдүүдтэйгээ мөрний ус руу үсрэн орсон нэгэн бэлэвсэн эхнэрийг Аттила үйж үхэхээс нь өмнө амжиж өөрийн биеэр аварсан гэж домог өгүүлнэ. Энэ явдал бас л нэгийг өгүүлэх мэт. Аттила нэгэнт л энэ нутгийг дахин хөндлөн гулд туулах болж буй учраас нутгийн тариачид бослого дэгдээвэл бөөн түвэг удахаар барахгүй сүйрэлд ч хүргэж мэднэ. Тиймээс нутгийн хүн амыг дарамталж цөхрөөж хэрэггүй, амирлуулж тайвшруулах хэрэгтэй гэж үзсэн болов уу. Ийн хүннүчүүд Трое хотоор дайран өнгөрөхдөө хутагт Лүүгийн уугуул нутаг, урлагийн аугаа бүтээл дурсгалаар ихээхэн элбэг баян энэ хотоос ганц тахиа ч (*sans toucher meme a une poule*) булааж авсангүй хэмээн домог өгүүлнэ. Харин гэгээн Лүү өөрөө хүннүчүүдийн барьцаанд явсан тул ард түмэн гэнэггүй явсан хүннүчүүдийг гэнэдүүлэн дайрч цусанд хутгах ахул Шампан нутгийн хамгийн эрхэм хүн гэгээн Лүүгийн амь насанд аюул учрах нь гарцаагүй гэдгийг ойлгож байв.

Хэдийгээр Аттила ийнхүү ухаан зарж цэргээ амгалан тайван авч явсан ч мөн л цус асгаруулсан мөргөлдөөн гарсан ажээ. Үүнийг Гундебауд ноёны удирдсан Рипуарын франкуудын хамтаар их цэргийн толгойн ангийг бүрдүүлж Оове хэмээх жижиг голыг их цэрэг саадгүй гатлах нөхцөлийг хангах үүрэгтэй явсан гэпидүүд өдүүлсэн ажээ. Гэпидийн хаан Ардарих, Гундебауд нар өнөөгийн Сэн Мэсман, тухайн үед Бролиум хэмээгдэж байсан жижиг хотод штабаа буулгасан байв. Тэд дайсны нутагт, хэдэн сарын турш сүсэг бишрэл хийгээд хувраг санваартнуудаасаа тайлбарлашгүй хачин жигтэй хүчийг олдог христ мөргөлтнүүдийн дунд амьдарч яваагаа ойлгож байсан байдаг. Гэтэл христ сүмийн даамал Мемориус тэргүүтэй лам хуврагуудын төлөөлөгчид хийрхүү явсан морьтон гэпидүүдийн өөдөөс гарч ирсэнд тэд ихээхэн сандарч тэвджээ. Өршөөл эрэх төлөөлөгчдийн жагсаалын толгойд нэгэн хувраг өргөл барьцны зүйл барьж явжээ. Гэтэл Аттилагийн хамаатан болох нэгэн ндөр

хэргэмт офицерын омголон морь мөнөөх хуврагийн барьж явсан өргөл барьцны зүйл дээр нарны туяа туссанаас ойсон хурц гэрэлд гялбаж үргэн цовхчсонд мөнөөх офицер номхруулж чадсангүй, аянганд ниргүүлсэн мэт болсон морь улам ч догширч цовхорчээ. Санваартнууд хийгээд тэдний ариун эд уурс дээр хараа тусгаж явсан гэпидүүд тэдний ид шид Ардарих, Гундебауд нарт тусч хорлохоос нь өмнө амжихаар шийдэж илдээ сугалан дайрчээ. Ингээд зургаан хувраг алагдаж тоосон дунд хөсөр унахад долоо дахь нь шархдаж Трое хотын зүг амь зулбан зугтжээ.

Энэ бол 9 сарын 7-ны өдөр болсон хэрэг бөгөөд Мемориус ламын алагдсан газрыг Сэн Мэсман, сүүлд Сэн Мэман хэмээн нэрлэх болжээ. Энэхүү цус урсгасан үйл явдал энэ өдөр болсон анхны томоохон тулалдааны удиртгал болжээ.

Хүннүчүүд Орлеанаас гарч Трое орох замдаа чанх баруун зүгийг барьж хоёр зуун километр газрыг онцын саадгүй туулсан нь Аетиус болон түүний герман холбоотнууд хамгийн хурдан шуурхай ангиудаа авч Орлеанд дөнгөж хүрч цэргээ цуглуулан засч байсан үе таарсных бөлгөө. Холбоотнууд Орлеаны дэргэд харьцангуй жижиг орон зайд хүннүчүүдтэй тулалдаж ялсан нь ач холбогдол багатай байсан хэдий ч хэрхэхээ шийдэж ядан алгуурлаж байсан хүчнүүдийг зоригжуулж, ялагчдын талд ороход хүргэжээ. Хүннүчүүдийн довтолгооноос зугтан зайлж Луар мөрний ой шугуйд нуугдсан нутгийн хүн ардаас байлдах чадалтай хүн бүхэн Аетиусын армид ирж нэгдэх нь өдрөөс өдөрт нэмэгдсээр байв.

Хүннүчүүд аялж явсаар Трое хотын дэргэд ил цагаан газар гарч ирэв. Рипуарын франкууд болон тэдний ноён Гундебаудтай илд зөрүүлэхээр анаж явсан Салийн франкууд тооцоо бодох таатай цаг ирлээ гэж үзэв. Ийнхүү Франкийн хаадын өвийг залгамжлахын төлөөх тэмцлийн хувь заяа шийдэгдэх мөч тулгарч иржээ. Аттила Сена мөрнийг гатлаад баруун хойш эргэсэнд эсрэг тал тулалдаан эхлэх цаг боллоо гэж үзэв. Аттила наана нь Шалоны хамбын зааж өгсөн Мауриак (өнөөгийн Ла Шеп) тосгоны дэргэдэх бэхлэлтэд хүрэхээр шийдсэн учир алгуур явж байв. Өмнө нь Шампаны уудам тал цэлийх шороон далан, гуу суваг бүхүй бэхлэлт хүннүчүүдэд олз омгоо хадгалж хөсөг тэргээ байрлуулах боломжтой тун ашигтай тулалдааны талбар байв. Ачаа хөсөг ч хамгаалагдах, морин цэрэг ч чөлөөтэй хөдөлж байлдах боломжтой байжээ. Цэргийн манлайд явсан гэпид, франкууд эхний дайралтыг няцаах ёстой байв. Хоёр талын цэрэг галзуу догшин уухайлсаар хоёр талаас тулж тулалдаан санаанд оромгүй хатуу ширүүн өрнөсөн явдал Аттилад санасан хэрэг нь бүтэж ялалт ирэх нь гэх зөн совин төрүүлжээ. Гэпид, Салийн франкуудын тулгаралтад хамгийн багаар бодоход (Иорданесын тооцоогоор) 15 000, бусад эх сурвалжаар хоёр талаас 90 000 хүртэл хүн алагдсан хэмээн тэмдэглэсэн нь Иорданесийн бүтээлийн үнэн магад, түүний эх булгийн чанар чансааг илтгэж буй.

Улс түмний энэхүү тулгаралтаар лав л нэг асуудал шийдлээ олсон мэт байдаг. Нэр нь тодорхойгүй хааны удмын нэгэн франк хүн энэ тулалдаанаар амь үрэгдсэн гэдэг бөгөөд энэ хүн Рипуарын франкуудын толгойлогч Гундебауд байсан нь тодорхой. Ийнхүү Сали, Рипуарын франкуудын хоорондын өрсөлдөөнд Салийн франкуудын ноён Меровех ялж, үүнээс хойшхи найман зууны турш үргэлжилсэн меровингуудын ноёрхлын үндэс суурийг тавьжээ.

Мөргөлдөөн ийнхүү маш хатуу ширүүн болоход Ром, Вестгоотын армийн бүрэлдэхүүнд бүргүндчүүд анх удаа явж тулалдаанд оролцсон явдал нөлөөлжээ. Аетиусыг үзэж чаддаггүй байсан болохоор Вестгоотын залуу жонон Торизмундын цэргийн бүрэлдэхүүнд орж байлдсан бүргүндчүүд хүннү нартай хуучны өс хонзонтойг бид мэднэ. Тиймээс ч тэд асар их уур хилэн агуулсаар тулалдаанд оржээ. Тэдний догшин уур хилэн энэ удаа гэпидүүдэд тусч, тэд нь ч мөчөөгөө өгсөнгүй, адилхан хариу барьжээ. Их тулалдааны удиртгал болсон эхний тулгаралтаас л энэ тулалдаанаар чухамдаа германчууд өөр хоорондоо тэмцэлдэж, энэ их гэр бүлийн хамгийн дайчин овгууд бие биенээ хядах нь гэдэг нь тодорхой байсан юм. Харин хүннүчүүд болон ромчууд бие бүрэлдэхүүнийхээ нэлээд хэсгийг тулалдааны дараа буцаан татаж явсныг бид харах болно.

Домогт дурдсан Мемориусын амийг хороосноор эхэлж, Трое, Шалон хотуудын завсар нутагт өрнөсөн тэрхүү урт удаан тэмцлийн эхний өдөр үнэхээр 9 сарын 7-нд тохиосон эсэх нь эргэлзээтэй байдаг. Иорданес бол дээрх бүх үйл явдал 6 сарын 20-ны өдөр болсон гэдэг бол Томпсон мэтийн бие даасан үнэлгээ дүгнэлттэй, мэдээлэл судалгаа сайтай эрдэмтэд ч энэ огноог хүлээн зөвшөөрдөг. Ганц Альтхайм л он жил улирч өнгөрөх тусам эргэлзэж тээнэгэлзэх нь их болсон мэт. Тэрбээр Францад зориулж шинээр боловсруулан эмхэтгэсэн Аттилагийн тухай нэг сэдэвт зохиолдоо их тулалдаан 6 сарын 20-ны өдөр эхэлсэн нь ямар ч эргэлзээгүй (*sans dout*) хэмээн тэмдэглэсэн атлаа хүннүчүүдийн тухай таван боть томоохон бүтээлдээ (10 жилийн дараа эцэслэн хянан тохиолдуулсан) “6 сарын 20-ны орчим эхэлсэн болов уу...” хэмээн дээрх нотолгоогоо арай сулруулжээ.

Том эрдэмтдийг жижиг юмны төлөө буруутгах нь тэдний ач тусыг мэдэхгүй байгаа хэрэг болой. Гэхдээ дээр дурдсан цаг хугацаа үнэнд нийцэхгүй. Аттилагийн Галлигийн аян дайнд мордсонтой холбоотой эхний баттай огноо бол хүннүчүүдийг Мэц хотноо хүрэх үед тохиосон улаан өндөгний баярын бямба гараг болно. Хүннүчүүдийн довтолгоон улаан өндөгний баяртай давхцсан болохоор ард түмний ой ухаанд хадгалагдан үлдэж домог хууч энэ л хугацааг баттай баримталдаг. Үүнээс өмнө хүннү нар Панноноос гарч Өмнөд Германыг дамжин алеманнуудтай тулалдаж явж, Райн мөрнийг гаталж амжихгүй. Ингэхээр Аттила хамгийн эрт гэхэд 4 сарын 7-нд гараад Орлеан хүртэлх таван зуун километр газрыг жаран хоногт туулж, өөр мэдээ баримт байхгүйн учир хуучин эх сурвалжид дурдсанаар хотыг таван долоо хоногийн турш бүслэн байлджээ гэж бодъё. Тэгвэл Орлеаныг хамгийн эрт гэхэд 7 сарын 15-нд (Орлеаны хамбын амьдрал үйлийн тухай өгүүлсэн Анианусын намтар зохиол өнөө ч мөнөөх 6 сарын 15 гэдэг буруу огноог нэрлэсэн буй) орхин гарчээ.

Орлеанаас Трое хот хүртэл хоёр зуун километр, маршаар аялахад долоо хоногт туулна хэмээн Бери, Томпсон, Альтхайм (1951 он хүртэл) болон бусад судлаачид тооцсон бөгөөд тэд тулалдаан эхэлсэн газрыг Трое хот бус, Шалон хот гэж үздэг учир зам уртасч 300 километр ч болох учиртай. Дээрх хамбын намтар зохиолд дурдсан огноог үндэс болгож авлаа ч тулалдаан эхэлсэн өдөр 6 сарын 20 байж огт таарахгүй. Дундад зууны арми өдөрт дөчин километр замыг туулна гэдэг санашгүй хэрэг. Хүннүчүүд Орлеанаас Троег дайран Шалонд маш хурдан хүрэхийн тулд зугтаж буй мэт санд мэнд явсан болж таарах гээд байна. Хэрэв хүннүчүүд ингэж явсан юм бол эх сурвалжид дурдсан тулалдааны цэгцтэй эмх журманд хэрхэвч орж чадахгүй, эмх цэгцгүй бол Аетиус шиг цуут жанжны өөдөөс яаж ч сөрж үзэлцэх билээ. Энэ бүхнээс үзэхэд, мөн бусад зарим эх сурвалжид Аетиус ч онц яарахгүй байсан хэмээн

тэмдэглэсэн зэргийг иш үндэс болговол 9 сарын 7-ны өдөр анхны тулалдаан эхэлсэн гэдэг нь мэдээж илүү магадлалтай, тавдугаар зууны морь, шар хөллөсөн хөсөг тэрэг чирч яваа арми 1940 онд Франц улсад дайран орсон Германы танкийн дивизийн хурдаар аялахгүй л юм бол 6 сарын 20-ны өдөр байж таарахгүй болж байна.

Тулалдаан эхэлсэн цаг хугацааг тоймлож үзсэний дараа тулалдааны талбарыг ч мөн товч авч үзэх нь зүй. Энд яригдаж буй Трое, Шалон хотуудын завсрын Шампан нутаг өнөө үед мартагдсан хуучны нэр бүхий гурван хэсэгт хуваагдан оршино. Хамгийн баруун этгээдийн Кот Шампенуас нь далайтай хаяа залгасан, дов толгодтой нутаг агаад хойгуур, урдуураа Реймс, Сезаннтай хаяа хатгана. Энэ нутаг томоохон цэргийн анги аялж явахад Шампаны хамгийн зүүн талын Шампан үмид гэгддэг хэсгийн нэгэн адил тохиромж муутай газар болой. Учир нь Трое, Сэн Дезие хоёрын хооронд орших энэ нутаг тоо тоймгүй олон жижиг гол горхи, нуур цөөрөмтэй агаад ус чийг ихтэй энэ нутгийн төвд өтгөн ой сүглийх ажгуу.

Тэгэхээр Шампан нутгийн дээр дурдсан хоёр газрын дундын зурвас газар буюу Шампан пуаллиез л байна. Франц хэлний энэхүү хуучирсан үгийг орчуулбал “сийрэг суурьшилтай, хүн ам нь тархан суудаг” гэсэн утга гарна. Шампан пуаллиез нь цэрэг цуух явахад тохиромжтой зурвас газар гэдгийг Аттила Орлеаны зүг аялж явахдаа нэгэнт олж мэдсэн байв. Суассоны их ой, эсвэл Аргоннегийн ой хөвчид орж дайсанд бутцохигдохоос зайлсхийхийн тулд буцах хэрэг болж мэднэ, тэгвэл цэрэг явж өнгөрөхөд тохиромжтой энэ зам тун хэрэг болох юм байна гэдгийг Аттила тандаж мэдсэн байв.

Хүннүчүүд Сена мөрний нөгөө эрэгт гараад байв. Бүргүндчүүд болон вестгоотууд хүннүчүүдийг жигүүрээр нь дайран Марн руу шахаж, тулалдааныг Шампан пуаллиез-д эхлүүлэхээр төлөвлөжээ. Эндхийн байгалийн байдал ч тулалдаанд гойд тохиромжтой байв. Үүнийг Витригээс баруунш орших Камп де Маллигийн байдлаас өнөө ч харж болно. Гэвч гэпидүүд ихээхэн хохирол амсч байж дайралтыг няцааж чадав. Хүннүгийн гол хүч Марн голын гүүрүүдийг эзэлж аваад цаад талд нь гармагцаа тэдгээрийг устгажээ.

Эндээс Аттила тун ч шахамдаж, урт замыг туулахдаа бие биеэс салж сарнисан анги нэгтгэлүүдээ цуглуулж бүлэглэхийн тулд цаг хожих хэрэгтэй болсныг харж болно.

Жигүүрээс нь байнга заналхийлсээр байгаа нөхцөлд цааш ухарч болохгүй байв. Хориглон хамгаалж цэргээ журамлан байрлуулж тулалдаанд бэлтгэх цаг гарах эсэх нь тодорхойгүй. Тиймээс хэдийгээр мэргэ төлөг таагүй буусан ч их тулалдаанд орохоос өөр аргагүй. Марныг гаталсан нь өчүүхэн төдий ч болов амсхийх зай өгч, Аттила хүрээнийхээ ар талыг ямар нэг байдлаар халхалж чадав. Энд наад зах нь хөсөг тэрэг найдвартай хамгаалагдаж, дайсан этгээд гэнэт дайрвал багашаархан хүчээр няцааж чадахаар болжээ.

Аетиус болон түүний холбоотнууд Марн голыг нэлээд доогуур нэлээд цаг зарцуулан байж гатлаад хүннүчүүдийн баруун жигүүрээр гарч ирэх болов. Чингэвэл холбоотнууд Шалон, Реймс, Лаон хотууд хийгээд Парис орох замыг хамгаалж чадах байв. Энэ замаар Галли нутгийн дайсанд эзлэгдээгүй газруудаас туслах хүчин ирэх ёстой байсан юм. Харин хүннүчүүдийн ард ухран зугтах зам нь бэлээхэн байв. Хүннүчүүдийн баруун, баруун хойд зүгт чиглэсэн фронт зүүн жигүүрээрээ Аттилагийн хүрээ, Реймс-Түүль-Базелийн замаар

тохойлдон өнгөрч байв. Хүннүчүүд баруун жигүүртээ шороон бэхлэлт яаравчлан барьсан бөгөөд Редүүт-де-Нантиветын ойролцоо байдаг энэ бэхлэлтийг (Цэргийн сургуулийн талбайн голд байрлах учир зөвхөн тусгай зөвшөөрлөөр үзэж болно...) өнөөдөр ч үзэж болно.

Ромчууд, хүннүчүүд болон вестготууд, остготуудын дундуур баруун өмнөөс зүүн хойшоогоо чиглэн Шаланоос Сопиа хүрэх хөдөөгийн зам (өнөөгийн Шалон-Сүиппийн зам) өнгөрч байв. Хоёр талын армийн дунд намхан толгой байв. Шампан нутаг өндөр уулгүй газар бөлгөө. Энэ толгойг өнөөдөр үзье гэвэл мөнөөх толгойн оройд барьсан эрдэм шинжилгээний станцийн цагаан цамхагаар баримжаалж очино. Гэвч уг толгой тариачдын таван зуун жилийн хүч хөдөлмөр хийгээд Шампан нутагт байнга асгарах азарган борооны улмаас баахан намссаар нэрнээс цаашгүй болжээ.

“Ашигтай байрлал хэзээ ямагт давуу байдал олгодог учир хоёр тал тэр хавийн арай өндөрлөг газрыг нөгөөгөөсөө түрүүлж эзэлж авах гэж оролдов. Ийнхүү толгойн баруун гар тал буюу зүүн хэсгийг нь хүннүчүүд, зүүн гар тал буюу баруун хэсгийг нь ромчууд, вестготуудын туслах хүч эзэлж авчээ. Талууд эхлээд хараахан хоосон байгаа толгойн оройг эзэлж авах гэж тэмцэлдэв. Баруун жигүүрт (өмнөд) Теодерихийн удирдсан вестготууд, зүүн жигүүрт Аетиусын тэргүүлсэн ромчууд байрлажээ. Төвд нь өмнө дурдсан аланы ноён Сангибанусын цэрэг байлдааны журамд оров. Аетиус, Теодерих хоёр Сангибануст итгэл муутай байсан учир хаширлаж түүнийг найдвартай цэргийн ангиудаар бүслүүлжээ. Тулалдаанд орох гэж байсан хүн айж бэргээд зугтах гэтэл замыг нь хаачихаар хэн ч байсан ялгаагүй хувь заяагаа тэнгэрт даатгаад байлдахаас өөр аргагүй болох нь хууль бөлгөө.

Хүннүчүүдийн талд Аттила хамгийн хүчирхэг хүннү цэргээ удирдан их цэргийн төв хэсэгт байрлажээ. Аттила өөрийн итгэлт цэргээ гарын дор байлгаж, тэднээрээ хамгаалуулах санаа агуулж ийн байрлуулжээ. Хоёр жигүүрт нь бусад олон ард түмэн, хүннүчүүдийн захиргаанд орсон үндэстнүүдийн цэрэг байраа эзэлжээ. Тэдний дотроос Валамир, Теодемир, Видимир нарын тэргүүлсэн остготууд эрс ялгарч байлаа. Тэд амальчуудын хаадын үр удам учир энэ тулалдаанд хүчээ өгч буй Хүннүгийн хаанаас ч илүү өндөр язгуур угсаатай гэсэн үг байв. Цаашилбал эрэлхэг зориг, ид хаваа гайхуулж алдаршсан Ардарих хаан Гэпидийн их цэргийг удирдан хүннүгийн талд явлаа. Тэрбээр Аттилад нэгэн үзүүрт сэтгэлээр үнэнч зүтгэдэг хүний хувьд бүхий л хуралдай зөвлөлгөөнд тогтмол оролцдог байв. Ардарихийг ухаантай хүн болохоор нь Аттила үнэлж хүндэлж Остгоотын хаан Валамирийн хамт бусад холбоотон ноёдоос дээгүүр тавьдаг байжээ. Валамир олон таван үггүй зан, овсгоо самбаа, хурц ухаанаараа бусдаас эрс ялгарч байсан бол Ардарих найдвартай сайн зөвлөх байв. Аттила энэ хоёр хүнийг нэг овгийн садан төрөл болох вестготуудынха эсрэг байлдана гэдэгт огт эргэлзэхгүй байв. Бусад ард түмэн, ястан үндэстний толгойлогчид Аттилагийн дагуул, албатын байдалтай байж, түүний гар хурууны аясаар хөдөлж, бөхөлзөж сөгдөж Хүннүгийн хааны аливаа тушаал шийдвэрийг адайрч зөрүүдлэх юмгүйгээр бушуухан биелүүлэхийг л хичээж явдаг учир тэднийг хаад ноёд гэж нэрлэх нь баахан эргэлзээтэй. Аттила тэднийг нийтэд нь захирч, хувь заяаг нь атгаж байв.”

Дээр өгүүлсэн зүйл сонирхолтой Аттилагийн холбоотнуудын талаарх нарийн ширийн зүйлийг олж мэдэхэд тустай ч Иорданес энд гэнэтхэн олон үг урсгаад эхлэх нь зориуд чингэж байна уу гэх сэтгэгдэл төрүүлнэ. Тулалдааны

явцын талаар, хэрхэн өрнөсөн тухайд тэрээр бүдүүн барагхан төсөөлөлтэй байгаагаа булзааруулах гэж буй мэт. Түүний тэмдэглэсэн арай тодорхой гэхээр ганц зүйл нь зургаахан мөрт багтаж буй.

“Өмнө дурдсанаар тулалдаан эхэлж, эхлээд аль болох ашигтай байрлал эзэлж авахын төлөө тэмцэлдэв. Аттила толгойн оройг дайран эзлэхийг цэрэгтээ тушаасан ч Торизмунд (Вестгоотын хаан Теодерихийн хөвгүүн), Аетиус нар урьтаж толгойн оройг эзлээд дайран ирсэн хүннүчүүдийг өндөр дээрээс харван байлдаж ухраав.”

Үүгээр бол Ром-Вестгоотын армийн умард ба өмнөд жигүүрийн аль аль нь тулалдааны талбарын гол руу эргэн давшиж толгойн орой дээр нэгдсэн болох гээд байна. Гэтэл хүннүчүүдийг бүхэлд нь бүсэлж аваад бүрэн устгасны дараа л чингэх боломжтой байсан. Тиймээс ямар ч буурьтай судлаачид ромчууд хийгээд вестгоотууд ийм хурдан ялалт байгуулсан гэдэгт хараахан итгэж чадахгүй байгаа юм.

*“Each army succeeded in posting a force on part of the hill, but the summit was left unoccupied ...of the precise course of the fighting we know nothing” (Thompson)**

“Хоёр армийн дундах эгц толгой тулалдааны талбарын голд оршиж байв. Хоёр талын аль аль нь тэрхүү толгойд хөл тавьсан ч толгойн оройг эзлэн авч чадаагүй байна.” (Альтхайм)

*“At first, the Romans center was pierced and the full weight of the Huns directed against the Visigoths on the right wing.” (Gordon)*** (Иорданесийн өгүүлж байгаагийн яг эсрэг зүйлийг Гордон хэлж буй бөгөөд хааныгаа амь үрэгдсэний дараа л вестгоотуудын баруун жигүүр хөдөлгөөнд орсон, учир нь толгойг морин цэргийн дайралтаар эзлэн авах нь санахын гарз гэдэг нь ойлгомжтой.)

Үүнээс илүү будлиан гэж юу байхав. Иорданес өөрөө найдвартай баримт сэлт олж чадаагүй болохоор гол тоглогчдын амаар их л дориун үгсээр бөмбөгдөх аргыг сонгосон бололтой. Энэ бол эртний түүх бичлэгт ямар нэг байдлаар зөвшөөрөгдсөн мэт санагддаг арга болой. Аттила цэрэг дайчиддаа урьд өмнийн их ялалтуудыг нь сануулж зүрх зоригийг нь чангалж (Идрийн цогоо дүрэлзүүлж, ид хаваа гялалзуулж, хорсол хилэнгээ бадраагтун! Ухаанаа зарагтун! Зэр зэвсэг чинь юу чаддагийг харуулагтун! гэх мэт) уриалан дуудахаас өөрийг хийхгүй байна гэдэг нэг л санаанд буухгүй. Хүннүчүүд ч тэр их хатуу ширүүн тулалдааны дундуур хааныхаа үгийг олж сонсоно гэдэг ямар ч боломжгүй. Аттила уурсан хилэгнэж дайсныг занаж, олигтой дайрч довтлохгүй байна гэж өөрийн хүмүүсийг загнаж зандарч байсан нь мэдээж. Үүнээс өөр юу байхав. Гэтэл Иорданесын дээрх бичвэр үнэн гэхэд дэндүү гоёдох, Аттилагийн зан араншинд таарахгүй, бас үг нь олдоод байна. Хэн нэг этгээд тэрхүү аюумшигт тулалдааны дундуур тэмдэглэл хийжээ гэж бодоход дээрхээс илүү чухал мэдээлэх зүйл байлгүй яахав. Аттилагийн хэлсэн гэж буй дээрх өгүүлбэрүүд тулалдаан болгоны өмнө дуулддаг л зүйл шүү дээ.

Ингээд 660 оны орчим *Historia Francorum* (Франкийн түүх)-ийг туурвисан Бүргүндийн санваартан Фредегар, Севильягийн авьяаслаг эрдэмтэн Исидор зэрэг хуучны зарим зохиогчдын бичсэн зүйлээс тоймлож үзвэл тулалдааны дүр зураг тодрохгүй, улам будлина. Фредегар бичихдээ тулалдааны хувь заяа Орлеаны дэргэд нэгэнт шийдэгдсэн юм гээд Каталауны их тулалдааныг арын

сэргийлэх ангиуд тарж бутарсан хүннүүдийг хөөн цохисон байлдаан болгожээ. Исидор нь Аетиус ерөөсөө л төвийг сахиж байсан, харин вестгоот, франкууд хүннүүдийг дангаараа бутцохисон хэмээжээ...

*Хоёр арми толгой дээр цэргээ байрлуулах гэж өрсөлдөн тэмцэлдсэн ч толгойн оройг аль нь ч эзэлж авч чадсангүй...Тулалдаан чухам яаж өрнөсөн талаар бидэнд яв цав мэдэх юм үгүй." (Томпсон)

**Эхлээд Ромын байрлалын төв сэт цохигдож, хүннүүдийн хамаг хүч баруун жигүүрийн вестгоотуудыг онилжээ. (Гордон)

Эртний зохиогчдын ийм маргаан нь өнөөгийн К.Д.Гордон болон "их толгой" Альтхайм хоёрын маргаанаас дутуугүй хурц явагдаж байжээ. Ийм нөхцөлд ганц л гарц буй. Тэр нь нөр хичээнгүй, үнэнч шудрага судалгаа шинжилгээний эрэн цаг болох XIX зуунд хандах явдал агаад энэ нь түүхийн шинжлэх ухаанд ч ялгаагүй л хурц ухаан, эх сурвалжийн шүүмж, цэцэрхэх дур сонирхол хэтийдэж байсан үе бөлгөө. "Түүх бий болсноос хойш улс түмний хувь тавилан тулалдаанаар л шийдэгддэж иржээ" хэмээн их л хуучны маягаар сануулсан өнгө аястайгаар Х.Ф.Маурерын "Дэлхийн түүхийн шийдвэрлэх тулалдаанууд" хэмээх номын оршилд өгүүлжээ. "1870-1871 болон 1866 оны үйл явдлууд, эрх чөлөөний төлөөх дайнууд,, гээд олон дайн тулалдаан тохиосоор байсан хэдий ч олон герман хүн өнөөдөр ч сургамж авахгүй байгаа нь тун харамсалтай". Маурер германчуудад ойлгомжгүй байгаа зүйлээ ухаарч ойлгоход нь тус дөхөм үзүүлэхийн тулд англи хүн Е.Кризийн алдарт бүтээлийг герман уншигчдад зориулан дахин боловсруулжээ. Мөнөөх Криз бидэнд сонирхогдож буй тулалдааныг Шалоны тулалдаан гэсэн бол Маурер нь Троегийн тулалдаан хэмээжээ. Иорданесын түүхэнд вестгоотууд Аетиусын баруун жигүүрт тулалдсан хэмээдэг бол Маурерын боловсруулсан түүхэнд зүүн жигүүрт тулалдсан болжээ. Эндээс бидэнд олдсон хамгийн үнэтэй цайтай мэдээ нь хүннүүдийн цэргийн хүрээний тухай өгүүлбэр юм.

"Аюул ийнхүү нөмөрч ирэхэд Аттила гол хүчнээ хүрээ рүүгээ буцаав. Тэднийг бэхлэлт хийгээд хөсөг тэрэгнүүдийн ард орж хориглосны дараа хүннүүгийн харваачид өшөө хорсолдоо шатаж явсан вестгоотын морин цэргийн дайралтыг хялбархан няцаав". Эндээс хөсөг тэрэгнүүдээр байгуулсан бэхлэлтийн тухай яригдаж байгаагаар зогсохгүй, бэхлэлт хийгээд тэрэгний тухай дурдагдаж байгааг олж мэднэ.

Бреслау хотын түүхийн профессор, Вайцын шавь Георг Кауфманн "Германы түүхийн судалгаа" хэмээх бүтээлдээ толилуулсан туйлын нягт нямбай гаргалгаа дээрхээс илүү тодорхой болжээ. Кауфманн нь анхны томоохон ажлаа Аетиустай нэгэн цаг үед амьдарч асан түүх туурвигчдын нэг хэмээн бидний өмнө дурдаж байсан Сидониус Аполлинарист зориулсан буурьтай судлаач мэргэжилтэн юм. Кауфманн эхлээд янз бүрийн бичвэрүүдээс дээрх тулалдаантай холбогдсон хэсгүүд хийгээд тулалдаан болсон газрыг нэрлэхэд хэрэглсэн үгсийг шүүж аваад нэгбүрчлэн судалж шалгажээ. Ингээд *Campis Mauriacus* (Мауриакусын хүрээ) нь ямар нэг хот юм уу, ерөөс тодорхой нэг суурин газартай огт холбоогүй, харин "сүм хийд, эсвэл...өөр ямар нэг зүйл, үйл явдалтай холбоотой зам харгүй эсвэл газрын нэр юм" гэжээ. Ингэхээр Мауриакус гээд байгаа нь Аетиусын цэргийн бүрэлдэхүүнд явсан Тебагийн христ шашинт цэргүүдээс бүрдсэн легионы байрлаж байсан газрыг заасан нэр, өөрөөр хэлбэл энэ ангийг удирдаж явсан даргынх нь нэрээр (Мауритиус) байрлаж байсан газрыг нь нэрлэсэн хэрэг ажээ. Энэ легионы цэргүүдийг христ

шашнаасаа гарахаас татгалзсаны учир эзэн хаан Максимилиан Херкулиусын үед толгой дараалан устгасан хэмээн домог өгүүлэх амой. Шашин мөргөлийнхөө төлөө амиа золиосолсон христ шашинт легионы дарга нар Мауритиус, Эксүпериүс, Кандидус болон бусад хүмүүсийн дурсгал тухайн үед христ шашинд нэгэнт ороод байсан Галли газрын хүн ардын сэтгэл зүрхэнд удтал оршиж байсан ажгуу. Тиймээс ч Шалон, Сүиппийн завсрын нутагт Гэгээн Мауритиусын дурсгалд зориулсан цөөнгүй газар байжээ. Ромчуудын тавьсан Страсбург орох замын хажууд гэгээн Мауритиусын дурсгалд зориулан байгуулсан мөргөлийн гонхон билэгдэл хийгээд зам заагч болж олон нийтэд ихэд нэрд гарчээ. Ла Шеп нь Ла Шапел (гонхон)-аас үүссэн газрын нэр агаад Мауритиусаас үүссэн хуучны Мауриак(ус) нь Каталауны тулалдаан болсон газрын нэр болж эх сурвалжуудад хадгалагдан үлджээ.

Ийн бид тулалдаан болсон цаг хугацаа хийгээд газрыг ямар нэг байдлаар мэдэх болов. Их тулалдаан 451 оны зуны хуучаар Шаланоос зүүн тийш ромчуудын байгуулсан зам дээр өнөөгийн Ла Шеп тосгоны эргэн тойрны газар болж, *Camp d'Attila* (Аттилагийн хүрээ)-гийн байрлаж байсан газар ч хамрагджээ. Толгойн оройг хэн нь эцэстээ эзэлж авсан асуудлыг нэг их нарийвчилж нягтлахгүй. Гэхдээ энэ завсар Аттилагийн их үгсийн ард гарсан болохоор Иорданес цааш юу гэж өгүүлэхийг үзье.

“Нөхцөл байдал (хүннүчүүдийн хувьд) ноцтой байсан ч хүннүчүүдийн байдал хаанаа үзмэгц агшин зуурт өөрчлөгдөж тээнэгэлзэж эхэлсэн байж мэдэх зарим нэгний эргэлзээ хийсэн арилжээ. Ингээд гардан тулаанд орсноор хэмжээ хязгааргүй аймшигт алаан хядаан болж хоёр тал үхэх сэхэхээ нэгмөсөн үзэв. Хуучны ямар ч их тулалдаантай харьцуулшгүй ийм аймшигт тулалдааныг бид огт үзэж сонсоогүй билээ...Хуучнуудын өгүүлэх нь тэр хавиар урсах намхан эрэг бүхүй жижиг голд (Ла Ноблет) амь үрэгдэгсдийн шархнаас урссан цус цутган орж голын ус улаанаар эргэлдэж байсан ажээ. Их борооны дараа үерлэх нь байдаг энэ гол энэ удаа хүмүүний цус цутган орсноос эргээ халин оволзож байсан гэдэг(!). Шархны халуунаас болж цангаж амь тэмцэж байсан дайчид цусанд будагдсан ус ууж байсан ажгуу. Ийнхүү мөнөөх заяа муутнууд шархнаас урссан цусаа л ууж байсан хэрэг.”

Ийнхүү үндсэндээ тулалдаан болгоны дараа өгүүлж болох ч батлах аргагүй зүйлийн тухай яригдаж буй. Бартоломейн шөнийн (1572 оны 8 сарын 24-ний шөнө *Парист Катарина Медичийн тушаалаар хугенотуудын удирдагчид болон олон мянган протестант мөргөлтнүүдийг хядсан үйл явдлыг хэлж буй. Энэ үйл явдал католик шашинт Францын шашны реформацийн эсрэг явуулсан тэмцлийн оргил болой. Бусад Европ ч реформац, протестант урсгалтай мөн л тэмцэж байсан. Орч.)* маргаашийн Сена мөрөн, Бабенбергийнхний удмын дайчин хэмээгдсэн Фридрихийн (1211-1246, *Австри, Штирийн херцог байсан, 1146 онд Мажаарын IV Бела хаантай Лайта гол дээр тулалдаж алагдсан, Бабенбергийнхний эрчүүдийн удам түүгээр төгсгөл болсон.Орч.)* үхлийн дараах Лайта голын тухай ийм л зүйл яригддаг. Хоёрхон жишээ дурдахад ийм бөлгөө. Гэхдээ иймэрхүү үйл явдлууд л хүмүүний ой ухаанд удтал хадгалагдаг учир үнэн мөнөөрөө үлддэг, харин аугаа тулалдааны ээдрээ будлиантай нөхцөл байдал үрэгдэж үгүй болдог. Их хаад ноёдын хувь заяа нэр хаяггүй жирийн цэрэг дайчдынхаас хүмүүний ой санамжид илүү гүн хадагдах нь мэдээж. “Тулалдааны дундуур Теодерих (Вестгоотын хаан) дайчдаа зоригжуулахаар их цэргийнхээ дундуур довтолгон явах үед морь нь гэнэт булгисанд унаад шадар дагуулуудынхаа морины хөлд амь үрэгдэв. Ийнхүү тэрбээр өтөл насандаа амиа алдав.”

Теодерих эсвэл зугтаж явсан вестгоотуудынхаа өөдөөс тосч зогсоохыг оролдсон, эсвэл тулалдааны талбараас зайлан одохыг завдсан анги хэсгүүдийг хатуужин тэмцэхийг уриалж тогтоох гэсэн нөхцөлд л дээрх байдлаар амь үрэгдсэн байж болох талтай. Цэрэг байлдааны эгнээгээ чанд хадгалж, эсвэл урагш давшиж явсан нөхцөлд удирдагч нь ийнхүү морины хөлд гишгэгдэж үхэх учиргүй юм. Тиймээс гоот хүн Иорданес Теодерихийн түүхт үхлийн тухай өөр хувилбар даруй дэвшүүлжээ.

“Гэхдээ өөр бусад хүмүүсийн яриагаар Теодерих Амалийн хаадын удмын остгоот Андагисын суманд (шидсэн жаданд) оногдож алагдсан хэмээнэ. Үүгээр бол үзмэрчийн Аттилад айлдсан зүйл ёсоор болсон ажгуу. Гагцхүү Аттила үзмэрчийн төлөгийг Аетиуст хамааруулж ойлгоод байсан билээ. Үүний дараа вестгоотууд алануудаас (холбоотнуудын цэргийн төвд явсан) салж хүннүчүүдийг улангасан дайрчээ. Хэрвээ л Аттила тун сэргэмжтэй явж цагийг олон зайлж, шадар хүмүүсийнхээ хамтаар хүрээгээ тойруулж босгосон далангийн ард амжиж ороогүйсэн бол даруй амиа алдах байсан юм.”

Чухамхүү энэ далан л Шампан нутагт тэр жилийн зуны хуучаар тохиосон цуст үйл явдлын хамгийн тод томруун гэрч болон үлджээ. Харин хүн амьтны хүүрийг газар шороо нь залгиж, зэр зэвсэг нь тэр хавийн хүмүүсийн тоо тоймгүй олон цуглуулга хийгээд музейнүүдийн үзмэрийг баяжуулжээ. Тэр хавийн хөшөө дурсгалууд 1870-71, 1914-1918 онуудад амь үрэгдэгсдэд зориулагдсанаас бус, Аттила, Аетиус хоёрт зориулж босгосон юм байхгүй.

Агаараас харвал таван өнцөгтийн хэлбэртэй гэдэг нь сайн мэдэгдэх цэргийн бэхлэлт хүрээ Парис орох гол замаар яваа нэгэнд саатан зогсож үзүүштэй газар агаад олоход ч амархан. Германаас яваа бол Вэрдүн, Сэнт-Мэнээлдээр дайран өнгөрнө. Энд нутгийнхны дуртай хоол болох гахайн шарсан тагалцаг идээд нэг их ууж халамцаагүй л бол тосгоноос гарахад баруун гарт хөдөө аж ахуйн сургуулийн барилга байшингууд бий. Түүнийг өнгөрмөгц шув шулуун ч нарийхан хуучны ромчуудын зам салаалж баруун гар тийш эргэснээр нь явахад Ла Шеп орно. Замын уулзварыг Ла гранд Румани хэмээнэ. Энэ нэр Румынтай ямар ч хамаагүй, харин ромчуудтай холбогдох нь илэрхий. Ла Шеп орох нарийн зам мянга таван зуун жилийн хойно өнөөдөр ч огт аюулгүй гэж хэлмээргүй. Манжингийн талбайн бөөн бөөн шороо замын нарийн зурвас дээр энд тэндгүй хөглөрөх агаад ангийн хорхойтой францчууд туулай зурамхан буудахдаа хажуугаар үе үе өнгөрөх машинуудыг хайхрахгүй ажээ.

Ла Шепэд биднийг *Direction du Tourisme* (Жуулчны хэрэг эрхлэх газрын захиргаа)-наас тавьсан урьд харсан мөнөөх хөх өнгийн самбар, дээр нь дурайх албаны хянуур хэлээр:

*Enceinte prehistorique
dite Camp d'Attila*

хэмээн бичсэн үгс угтав. Ямар нэг тайлбар сэлтгүй. Аттилагийн хүрээ хэмээх түүхийн өмнөх үеийн бэхлэлт энд буй ажээ.

Хэдхэн мөчийн дараа бид тэв тэгш уужим талын тэг дунд зогсож байв. Эргэн тойрон замын хажуугийн далангаас өндөргүй шороон далан байна. Өвс ногоо битүү ургажээ. Таван нарийн хонгил (өнөөдөр) хийжээ. Далангийн дээгүүрх жимээр сургуулийн хүүхдүүд гүйлдэж, арчаа муутай жуулчид тариан

талбайн нойтон шороонд машинаа эргүүлэх гэж оролдож, Парисын бололтой нэгэн аятайхан хүүхэн Аттила гэж ямар хүн байсан юм бол хэмээн үл итгэх өнгөөр асуух ажээ.

Аттила хэн ч байсан ялгаагүй, Рөнер шиг мундаг уран барилгач байгаагүй нь л лав юмдаг, тиймээс жуулчны газрын төлөөлөгч, ганц нэг түүхч зэрэг бидний хэдэн хүн энэ бэхлэлт даланг Аттилагаас өмнө байсан зүйл гэдэгт санал нэгдэв. Тэгээд ч энд 406 онд германчуудын их цэрэг ромчуудтай хүч үзсэн байдаг юм. Гэхдээ бусад судлаачид мөнөөх хүрээг таван өнцөгтэй болохоор хүннүүд байгуулсан хэмээн итгэсээр байдаг юм. Орлеан руу явж байх замд л энэ бэхлэлтийг байгуулах цаг зав хүннүүдэд гарсан байж мэднэ. Харин тэндээс буцах замд бол чингэх зав зай гараагүй байх ёстой. Их цэрэг Орлеан руу явж байхад шархадсаны улмаас үлдэж хоцорсон офицеруудын хяналтанд олзны хүмүүс энэ бэхлэлтийг барьсан байж болох юм.

“Уг бэхлэлтийн хэлбэрийг үзэхэд галл-ромчуудын барьсан байгууламж байж таарахгүй. Байгууламжийн өвөрмөц хэв маяг нь ажлын голыг ийм үйлд дадлага туршлага муутай хүмүүс нугалжээ гэдгийг харуулж буй. Нөгөөтэйгүүр байршлыг сонгосон байдал, бүдүүн бараг ч гэсэн үүрэг зорилгодоо сайн зохицсон байдал болон өмнө нь ус гүйлгээд дүүргэчих суваг татсанаас үзэхэд дайн тулааны туршлагатай, ухаалаг хүмүүс уг хүрээг удирдаж бариулсан нь илэрхий.” (Х.Пулайн)

Хэлбэрийн хувьд таван мохоо өнцөг бүхүй хоёр километр орчим хэмжээний бараг л зууван эллипс гэхээр болой. Өмнө талаараа Ноблет хэмээх жижигхэн голд тулах учир цэрэг дайчид хийгээд агт морьд усаар гачигдахгүй. Нийт талбай нь 21 га учир олон хүн байрлах боломжтой учир ерөөсөө л армид зориулагдсан байж болохоор байгаа юм. Нутгийн оршин суугчдын нуугдаж хоргодох газар гэхэд хамгаалахаасаа илүү халгаатай байж мэдэхээр дэндүү өргөн цэлгэр ажээ.

Бэхлэлтийн тэгш талбайг өнөөдөр хөдөө аж ахуйн зориулалтаар ашиглаж буй нь тодорхой. Тиймээс далангийн нэг орц дээр нь нэмж шинээр дөрвийг хийжээ. Эргэн тойрны суваг шуудууг нь өнгөрсөн зуунд шороо дүүргэн тэгшилжээ. Тэр орчмын улсын мэдлийн нэг талбайгаас ойр байрлах цэргийн сургуулийн барилгачид гурван зуу гаруй зоос ухаж гаргасан нь бүгд 451 оноос өмнөх үеийнх байжээ. Хожмын үеийн ганц ч зоос олдоогүй байна. Малтлагын ажлыг бэхлэлтийн нийт талбайд системтэй хийвэл олон мянган зоос хийгээд өөр бусад зүйл олдох болов уу. Дээрэм тонуул их хийж явсан армийн дайчид халаасандаа ийм зоос өдий төдийг авч явж сүүлчийн их тулалдааны галын дунд заримыг алдаж гээсэн байж болно. Суваг шуудууг дүүргэж тэгшлэхээс өмнө политехникч Ле Түрне гэгч 1829-1833 онд тэнд судалгаа, хэмжилт хийсэн байна. Гучин жилийн дараа археологч Х.Летадин шороо дүүргэж тэгшилсэн газрыг ухаж эрэл хайгуул хийжээ. Үүгээр Аттила хаан хөсөг тэрэгнүүд хийгээд мөн ухран ирсэн цэрэг дайчдаа газрын түвшнээс хэмжихэд 7-10 метр гүн, ус дүүргэсэн сувгийн ард оруулж хамгаалж чаджээ гэдэг нь тогтоогджээ. Энэхүү тал газрын хүчирхэг бэхлэлт хийгээд Аттилагийн урьдчилан тооцоолсон нь зөв болж шөнийн харанхуйд үүссэн бөөн үймээн бужигнаан болон ялсан талын эмх замбараагүй байдал нь хүннүүд хэрхэн хүйс тэмтрэгдэх аюулаас аврагдаж амь гарав гэдэг асуултад тайлбар өгч буй юм. Үнэхээр ч шөнийн харанхуйд Аетиус төөрч ганцаараа бэдэрч, Торизмунд хүннүүдийн гарт золтой л орчихоогүй байдаг. Маргааш нь хэрхсэнийг үзье:

“Маргааш өглөө нь тэд хүний хүүр дүүрсэн тулалдааны талбарыг үзэж хүннүчүүд дахин дайраагүй учир ромчууд тулалдаанд ялжээ гэдгээ мэджээ. Гэхдээ тэд Аттила зөвхөн бүрмөсөн ялагдах л юм бол зугтан одох болно гэдгийг сайн мэдэж байв. Хаан Аттила (эхлээд) зугтах гэж байгаа гэдгээ огт харуулсангүй, харин ч бүр эсрэгээр их бүрээгээ татуулж зэвсгээ хангинуулж дахин дайрахаар заналхийлж байв. Тэрбээр агуйнхаа аман дээр нааш цааш алхах шархадсан арслан шиг л аяглаж байв. Дахин дайралт хийж зүрхлээгүй ч хилэгнэн хүрхэрч хавь ойрынхныг аюумшигт автуулж байв.

Бүслэгдсэн ч дайнч омог нь дарагдаагүй хаан ялагчдыг айлгасаар байжээ. Эцэст нь вестгоотууд болон ромчууд ялагдсан Аттилаг хэрхэхээ зөвлөлдөхөөр цугларав. Тэгээд нэг талаар хүннүчүүдийн гурил будааны нөөц нь барагдсан, нөгөөтэйгүүр суман мөндөр буулгасаар тэднийг хүрээнийхээ үүд хаалгаар орж гарах аргагүй болгосон учир бүсэлж байгаад доройтуулж туйлдуулахаар шийджээ. Харваачдыг бэхлэлтийн далангийн дотор суулгажээ. Ийнхүү тун ч ноцтой нөхцөл байдал үүссэн ч Хүннүгийн хаан сэтгэлийн хаттай хүн гэдгээ үзүүлжээ. Тэрээр морьдынхоо эмээлээр цуглуулж түүдэг асаахад бэлтгэхийг тушааж, хэрвээ дайсан этгээд дайран ирж хэрэг бишдвэл өөрөө галд харайн орохоор шийдэж сүүлд нь Аттила алсан гэж хэн ч биеэ бүү магтаг хэмээжээ. Асар олон ард түмнийг хураан захирсан хаан хүн амьдаар дайсны гарт орохыг бүр ч цээрлэнэ...”

Тэр үед эмээлийг дундад зууны түрүү үеийн *bastum* (дол, дурс) гэдэг үг хэрэглэснээс үзэхэд далдуу модны хальс, дурс юм уу мод, эсвэл ийм материал оруулан хийдэг байжээ. Хүрээний дотор өөр шатаачихаар материал байгаагүй гэдэг нь өнөө харахад ч илэрхий. 1793 онд хүрээний голд дөрвөн метрийн голчтой гүнзгий нүх тохиолдлоор олдсон байна. Түүнд эмээлээс гадна бусад шатах материал хийж түүдэг асаахад бэлтгэсэн байжээ. Гэвч Аттила түүдэгт харайж ороход хараахан хүрээгүй ажээ.

“Бүслэлтэд бэлтгэж байх завсар вестгоотын ард түмэн хааныхаа, хөвгүүд нь эцгийнхээ эрэлд морджээ. Дайны аз хийморь ийн ивээж ялалт авчирсан байхад хаан эцэг нь яагаад байхгүй байгаад тэд гайхжээ. Удтал эрсний эцэст Теодерих хаан нь эрэлхэг дайчин эрийн ёсоор амиа алдаж олон дайчны хүүрний дунд хэвтэж байхыг үзэв.

Гоотууд хааныхаа шарилыг өргөн алдар сууг нь магтан дуулсаар дайсны нүдэн дээр тулалдааны талбараас авч явлаа. Үй олон гоот хүн цаглашгүй уй гашууд автаж амь үрэгдсэн хаандаа сүүлчийн удаа хүндлэл үзүүлж байхад ч эргэн тойронд нь тулалдааны гал хараахан унтраагүй л байлаа. Гоотууд уйлж хайлан хатуужил ихт эрчүүд ч нулимс унагаж байв. Гоотууд ямархан алдарт дайчнаа алдсаныг хүннүчүүд ч нүдээр үзэв. Гоотууд алдар хүндийн оргилд хүрсэн их хааныхаа хүүрийг өргөн ийнхүү авч яваа байдал нь дайсных нь омгийг ч дарахаар явдал байсан ажгуу. Ийнхүү гоотууд алдарт Теодерих хаанаа сүүлчийн удаа гүнээ хүндэтгэн авч явлаа. Алдарт дайчин эрэлхэг Торизмунд ч хүүгийн ёсоор хайрт эцгийнхээ салан одсон сүнсэнд сүүлчийн удаа хүндэтгэл илэрхийлж ёсолжээ.”

Ийнхүү гоотууд өвгөн хаанаа, Аетиусын эвсэл нэгэн удирдагчаа алджээ. Ромын ашиг сонирхлыг эсэргүүцэн тэмцэж ч чадах, Аетиусын элдэв хорон муу санаархлыг нэвт шувт харж чадах ганц хүн бол Теодерих байсан юм. Аетиус нөхцөл байдлыг тэр даруй өөртөө, өөрөөр хэлбэл Равеннагийн ашиг сонирхлын

тусын тулд ашиглахаар шийджээ. Тэрээр Теодерихийн үхэл Ромын зүгээс цаашдаа Европын талаар явуулах бодлогод ямар боломж олгож буйг дор нь ойлгожээ. Тэрбээр суларч доройтсон ч гэсэн Өрнөд Ромын гүрнээ цаашид ч жинлүүрийн сум хэвээр нь байлгаж, хүннүчүүдийг өөрийн хүчний бодлогоо хэрэгжүүлэх хэрэгсэл болгон ашиглах санаа агуулжээ. Аетиусын заналт дайсан бүргүндчүүд Каталауны талд түүний талд орж тулалдаагүй гэж үү?! Аттила ч тэдний нэгэн адил маргааш гэхэд л дахиад холбоотон нь болж ялгуусан вестгоотууд хийгээд Византийн ихэмсэг хаан Маркианосын эсрэг тулалдаж болох л юм. Тэрээр Аттилаг олон жилийн өмнөөс мэдэх учир өшөө хорсолдоо шатаж уурсаж хилэгнэсэн вестгоотууд Шалоны энэ газар Аттилагийн хүрээг ларуй улангасан дайрч өөрийг нь үхэлд хүргэдэггүй л юм бол түүнтэй хэлэлцэж тохирч болно гэж боджээ.

“Ийн бүх зүйл дууссаны дараа Торизмунд эцгийн үхэлд ихэд гашуудсан болон бас ч нэр төрөө бодох сэтгэл нь шахамдуулаад байсан учир патриций (Ромын удамт язгууртан) Аетиусаас цаашид хэрхэх, Теодерих хааны өшөөг хэрхэн авах талаар асуужээ. Нас шүд хийгээд ухаан бодлоор Торизмундаас хол давуу Аетиус идэр залуу гоот эрд үлдсэн цэргүүдээ аваад даруйхан нутаг буцаж нас барсан хааны орыг залгамжлах хэрэгтэй гэж зөвлөв. Чингэхгүй бол ах дүү нар нь хааны өвийг булаалдаж нутгийнхантайгаа хатуу ширүүн тэмцэл явуулахад хүргэж мэднэ хэмээжээ.

Торизмунд Аетиусын цаад санааг ухаж мэдэхгүйн учир түүний зөвлөлгөөнийг сайн санаж хэлсэн зүйл хэмээн үзэж, мөн өөрийн эрх ашиг хийгээд эцгийн өвийг залгамжлах асуудлыг маш чухалчилж байсан учир дагахаар шийджээ. Тиймээс сайтар бэхлэн суусан хүннүчүүдтэй цаашид сунжирсан байлдаан хийх ч шаардлагатай болж мэдэх учир хэрхэх тухайд санаа бодлоо хэлээд Галли нутгийн гүн рүү хөдөлжээ. Ийн хүний сул тал, дээр нь хар хорын нөлөө орсон бол их үйлсийг бүтээх боломжоо алдахад хүргэдэг бөлгөө.”

Тэрхүү их үйлс нь Аттилаг устгаж, хүннүчүүдийг бүрмөсөн бутниргэх явдал байсан болой. Гэвч чухамхүү Аетиус л хүннүчүүдийг мөхөөх тэр их үйлсэд үнэхээр саад хийсэн нь тун учиртай хэрэг байсан юм. Аетиусын өөрийнх нь арми дангаараа давчуу газар хашигдсан хүннүчүүдийг бүсэлж байгаад өлсгөн тэнхэлдүүлж, ихээхэн гарз хохирол учруулж чадах, нутаг буцсан вестгоотуудын оронд Галлийн бусад нутгаас нэмэгдэл хүч татаж авч ч болох байсан нь магад. Дараа өдөр нь болсон богино хугацааны ширүүн тулалдааны явц үүнийг нотлон харуулжээ. Энэ асуудлаар Иорданесын дор өгүүлж буй зүйл үнэн гэдэг нь эргэлзээгүй. Тэгэхээр Аттилаг аварч, хүннүчүүдийг өөрийн цаашдын төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд ашиглах үүднээс дайнд шунамхай, догшин ширүүн гоотуудыг тулалдааны талбараас зайлуулах хэрэгтэй байжээ. Хүннүгийн цэргийн бэхэлсэн хүрээг дахин дайрахгүй болсонд Галли-Ромын цэргийн ахмад дайчид сэтгэл ихэд ханасан ажээ. Аетиус тэдэнд дайн энэ удаа ийнхүү дууссан тухай мэдэгдэж хүннүгийн цэргийн үлдсэн хэсэг Райн мөрнийг гаталж цаана нь гартал түр байзнаж байхыг тушаасны дараа тэд өөрсдийн цэргийн анги руугаа баяр хөөртэй явцгаажээ. Сүүлчийн дайралт хийсэн хийгээгүй тулалдаан хүмүүний цусыг асар ихээр асгаруулж үй олон хүний амийг авч одсон нь эргэлзээгүй. Иорданесын гаргасан тоо болох хоёр талаас 165 000 хүн амь үрэгдсэн, үүнээс гадна Трое хотын дэргэд 15 000 гэпид, франк хүн амиа алдсан гэдэгт ганц ч түүхч итгэдэггүй бөлгөө. Ялангуяа германчууд өөр хоорондоо эрэлхэг баатарлагаар тулалдаж бие биеэ хайр найргүй хядаж

байсан, хоёр талын цэрэг тус бүр 50 000-60 000 хүнтэй байсан гэж олонхиороо үздэг зэргийг иш үндэс болгож дөрвөн хүний нэг алагдсан гэж үзвэл хэтийдүүлсэн юм болохгүй. Тэгвэл 30 000 орчим хүн алагдсан болно. Энэ нь тэр үеийн хамгийн том хотуудын хүн амаас ч давсан тоо болой...

Шампаны үржил шимт газар шороо үхэгсэдийг өлгийдөн аваад ялзмаг болгон хувиргасан ч хөрсний онцгой шинж чанар болон бусад нөхцөлөөс шалтгаалан оочин цоочин хийсэн малтлага хийгээд замын ажлын явцад гайгүй хадгалагдаж үлдсэн нэлээд шарил олдож байжээ.

Хамгийн олон хүний амийг золиосолсон мөнөөх толгойн нэр ардын ярианд үлджээ. Харин мянга таван зуун жил улирч өнгөрсний хойно Мон-де-Питие буюу “гашуудлын уул”-ын нэр ле Пьемон болж, өндөр нь 179 метр агаад Женевьев Девинийн хэлснээр “уул гэхээсээ их талын дундах гүвээ гэвэл зохилтой ажээ. Уг гүвээ Шаланоос гарч N 77 (замын дугаар)-оор явахад зүүн гар талд харагдах бөгөөд дээр нь орчин үеийн өндөр цагаан цамхаг сүндэрлэнэ.

Энэхүү гүвээний эргэн тойрон цэлийх тариалангийн талбайд хэсэгчилсэн малтлага хийхэд тухай бүр л ямар нэг юм олдож байжээ. Хоёр зуу орчим хүний араг ясны янз бүрийн гэмтэл тодорхой харагдаж байсан, голдуу гавлын яс нь бяцарсан байсан хэмээнэ. Мон-де-Виннь (Пьемон хийгээд Аттилагийн хүрээний завсар орших)-ийн хавьд хүннүүдийн шарил илүүтэй олдоно. Олон хүннү хүн бүсэндээ жижиг шавар аяга зүүж явсан нь олджээ. Мөн шилбэнийх нь ясны хажууд урт хутга хэвтэж байхыг олжээ. Бодвол гутлынхаа түрийнд авч явдаг, эсвэл хуйтай нь хөлөндөө холбож уядаг байсан бололтой. Шарилын байдлаас үзэхэд цэрэг дайчдыг үхэл аваачих үед хэн нь ч хорин таваас илүүгүй настай байжээ. Каталауны талд ажилласан Будапештийн их сургуулийн судалгааны бүлгийн ахлагч Дебрецени түүхийн профессор Ференц Балог 1864 оны 7 сард шарилуудын шаантны ясны хажууд хутганууд хэвтэхийг үзээд ихээхэн гайхжээ. Тэрээр дагаж явсан францчуудад “унгарын ард түмэн францчууд шиг хөнгөмсөг, хувирамтгай аальтай хүмүүс биш. Бидний зан үйл Аттила манай хаан байх үеийнхтэй үндсэндээ адилхан хэвээр. Миний мэдэхээр энэ урт хутга унгарчуудын баруун хөлний гутлын түрийнд явдаг. Мах огтолж идэх болон биеэ хамгаалах зэрэг олон юманд хэрэглэгддэг юм” хэмээсэн нь хэдий үнэн боловч төдийлөн эелдэг бус үг байв.

Араг яснууд хүннүүдийн талаарх хүмүүсийн ерөнхийд нь төсөөлдгөөс илүү өндөр байсан нь санаандгүй зүйл байв. Харин морьдынх нь араг яс жижиг гэдэг нь илт байжээ. Энэ явдлаас цөөн жилийн өмнө 1860 оны 9 сарын 10-ны өдөр малтлагаар олдсон араг яс, гавлын яснаас бүрдсэн эрдэм шинжилгээний үзүүлэн таниулах арга хэмжээ зохиоход эзэн хаан III Наполеон болон хэд хэдэн генерал байлцаж, хүн судлаач Др.Конну гэдэг эрдэмтэн галл-ромчууд хийгээд хүннүүдийн шарилын ялгааг тайлбарлаж хорвоогийн үхэл хийгээд мөнх бусын тухай нээлттэй хичээл явуулсан нь хөхүүн баясгалант хаанд ер бусын сэтгэгдэл төрүүлж сэтгэлд нь удтал оршиж байсан нь магад.

Иймэрхүү илэрхий нотолгоо баримт материал байсаар байхад, Марс-ла-Түүрээс эхлээд Вэрдүн, Шеман-де-Дам хүртэл цэрэг дайчдын сайтар арчилж тордсон оршуулгын олон газар байхад Каталауны тулалдааны энэ гол газар огторгуйд тэмүүлсэн *Croix des-Batailles* (Тулалдааны загалмай) ч эрт урьдын үеийнх шигээ сүндэрлэхгүй, зууны эхээр энд харагддаг байсан хоёр хайлаас ч байхгүй болсон нь туйлаас харамсмаар явдал болой. Хэдийгээр энд амь

үрэгдэгсдийн шарил бусад аль ч газраас шигүү байрлаж, олноороо олддог ч Пьемон нь ийм олдвор ихтэй ганц газар биш юм. Эдгээр олдвор бүхий газруудаас хамгийн чухал ач холбогдолтой нь Ла Шепээс зүүн тийш хэдхэн километр орших Ла Кот Роберт бөгөөд тэнд амь үрэгдэгсдийг бөөнөөр нь оршуулсан хорин зургаан булш буй агаад ганц эндээс л гэхэд 76 ширхэг илд олджээ.

Хэрэв III Наполеон, түүний гэргий Эжени нарын аль аль нь энэхүү зурвас газрыг ихэд сонирхоогүйсэн бол энэ хавийн газар тийм эрчимтэй археологийн судалгаа явуулах байсан нь юу л бол. Эзэн хаан энд цэргийн сургуулийн томоохон талбай, сургалтын газар байгуулах ажлыг даруй эхлүүлсэн нь өнөөдөр ч ашиглагдаж байгаа бөлгөө. Эжени энд буй хааны эдлэн газарт ирэх тун дуртай байсан учир энэ газрыг тоглоом шоглоомоор ле Трианион де л'императрис (*les Trianons de l'impératrice*) хэмээн нэрлэдэг байсан нь заяа муут Мари-Антуанетта хатан Версалийн цэцэрлэгт хүрээлэн дэх зугаа цэнгэлийн шилтгээндээ тун хайртай байсныг ёгтолж сануулсан хэрэг байв.

Аттилагийн нэгмөсөн ялагдахаас ам мөлтөс мултарсан газрыг очиж үзэхэд гол нь дээр дурдсан цэргийн зориулалттай бүсийн уудам талбай гол саад тотгор болж байгаа болой. Учир нь Аттилагийн цэргийн баруун жигүүрийн байрлал, түшиц газар нь болж байсан Нативетын бэхлэлт Сүиппийн цэргийн сургуулийн талбайд (*Camp militaire de Suippes*) орж байгаа юм. Энд буй шилтгээн 1919/20 он хүртэл Буржуа Тиерри гэдэг айлын өмч байсныг удалгүй улсын мэдэлд шилжүүлжээ. Уг шилтгээний эздийн хамаатан болох Женевьев Девинь дурсамжиндаа “Биллиардын өрөөний шилэн шүүгээнд шилтгээний ойр орчмоос олдсон эртний олон зоос бүхий баялаг цулгуулга, мөн тэр хавийн маш сонин эд өлгийн зүйлүүд олон байдаг байв. Эдгээр нь Аттилагийн эсрэг тулалдсан таван ард түмэн (вестгоотууд, галл-ромчууд, бүргүндчүүд, франкууд, аланууд болой)-ий бүгдэд нь хамаарах эд өлгийн зүйлүүд байв. Мөн 1822 оны малтлагаар гарсан зэс дуулга байсан. Энэ бүх эд зүйл 1914 онд Марнд болсон тулалдааны үеэр алга болсон...Сайн мэдэгдэх зүйл гэвэл зуун тавь орчим метр урт, дэвүүр маягийн хэлбэртэй бэхлэлтийн төхөөрөмж бөгөөд барьсан хэлбэр маягаас нь үзвэл Аттилагийн цэргийн хүрээ мэт бөгөөд өнөөгийн шилтгээний цэцэрлэгт хүрээлэнгийн зүүн хойд захад байгаа болно.”

Хэдэн мянган хүний хүчээр барьсан нь эргэлзээгүй нэлээд бат бэх шороон бэхлэлт нь их тулалдаанаас хойш бүтэн хагас мянган жилийг дамнан оршсоноор барахгүй дэлхийн хоёр дайныг давж, нэгдүгээр дайны үед нуувчийн үүрэг гүйцэтгэж их бууны байнгын галыг, хоёрдугаар дайнаар байлдааны онгоцны бөмбөгдөлтийг ажралгүй өнгөрүүлсэн нь үнэхээр бат бөх барьсан гэдгийг харуулж буй. III Наполеоны цэргийн байгууламжийг НАТО-гийн цэргийн зорилгод нийцүүлж шинэчилсэн америк, францын шинэ төхөөрөмжүүд нь хүннүчүүдийн бэхлэлтэд шулуухан халдаж, зөвхөн нэг хэсгийг нь үлдээжээ.

“Каталаун буюу Шампаны (*Champagne blanche*) хуучны айлуудаас манай энэ нутгаас олддог дээр үеийн зоос, зэвсэг, металл, шилэн сав мэтийн юмгүй айл бараг байхгүй дээ. Хаа нэгтээ хүмүүс манжингаа хураах гэж явдаг шиг л энэ Сүип-а-Галуагийн айлууд малтлага хийхээр явдаг байсан юм.” гэж Женевьев Девинь ярьж байв.

Гэвч энэ бүх зүйлийг их самууны цаг үе хийгээд их армиуд тулалдааны талбарт авчирсан шигээ эргүүлээд аваад явчихжээ. Үхэгсэд нь байсан юмтайгаа үлдэж, амь гарагсад нь авч явж чадах юмаа л авч явжээ. Үй түмэн хүний амийг

авч одсон 451 оны тэрхүү зэрлэг тулалдаанаас амьд мэнд гарагсад нэлээдгүй байсан юм. Тийн Аттила хүннүчүүдийнхээ үлдэгдлийг, Валамир, Эдекон, Ардарих нар германчуудаасаа амьд үлдсэн хүмүүсийг тус тус авч Райн мөрнийг гатлан дорно зүг буцсан ажгуу. Гэвч хэдэн мянган хүннүчүүд хүнд шархдаж урт агаад аюултай аяны аяыг даахгүй болсон байв. Тэгээд ч энэ аян нь дараагийн тулалдаанд хөтлөн оруулж ч мэдэх байв. “Аттила вестгоотууд буцсаныг сонсоод дайснууд нь заль хэрэглэж байж мэднэ хэмээн хардаж хүрээндээ тайван суусаар байв. Хүн гэдэг амьтан хувь заяаны санаандгүй эргүүлгэнд орохоороо ийм болдог ажгуу. Гэтэл дайснууд нь эргэж ирсэнгүй, бүх юм нам тайван болохоор Аттилагийн дотор ялах найдлага дахин сүүмэлзэж эхэлжээ...”

Их түүх жижиг хүмүүсийн талаар хэзээ л өгүүлдэг байлаа. Иорданесын бидэнд өгүүлэхгүй байгаа зүйл бол хүннүчүүдийн ард үлдэж хоцорсон шархадсан хүмүүс болон ачаа хөсөг дагаж явсан тэдний эхнэр хүүхнүүдийн хувь заяа хэрхсэн тухай асуудал юм. Хавь ойрын оршин суугчид нь дан тариачид байсан болохоор тэдгээр хүннү нар өөрсдийгөө хамгаалах чадалтай байсан биз. Тэгээд ч тэдний амь насанд халдахыг хэн ч бодоогүй нь магад. Хөлөг онгоцны сүйрлээс амь гарсан хүмүүсийг хаанахын хэн ч бай, ямар санаатай ч бай ялгаагүй авардаг, хүлээж авдаг шиг л хандсан нь магад. Ингээд сүүлчийн эдгээр хүннү нар их цэргийн хүрээндээ гарч ромчуудын замыг даган гурав орчим километр яваад өмнө тийш эргэж өвс устай, тариа тариагүй сул чөлөөтэй газар ихтэй Веслийн тал газар хүрч очжээ.

Тэд цаашдаа цэрэг дайчин хэвээрээ байж болохгүй учир тариачид болцгоож, Францын нутгийн төвд нүүдэлчний маягаар амьдарч болохгүйн учир байшин барилга барьж суух болжээ. Ийнхүү бий болсон тосгон бүх Францын тосгодоос хамгийн сонин, бас хамгийн муухай нь байсан ажгуу. Бас хамгийн их сунаж тогтсон нь болой. Лэпиний гоёмсог сүм хийгээд Весль голын дээрх дээрх Сэн Жюльений хооронд уртаашаа бараг найман километр үргэлжилнэ. Эл тосгоны хэмжээ нь Алпин хамбын намтрыг туурвисан археологч Аббе Буателийг энд найман мянган хүннүчүүд бууж суурьшсан бололтой хэмээн таамаглахад хүргэжээ. Өнөөдөр эндхийн уртааш сунаж эгнэсэн байшингуудад хоёр мянга гаруй хүн амьдарч буй.

Энэ хачин тосгоны нэр Куртисоль (Courtisols) гэж бичигдэх ч Куртису гэж дуудна. Тосгоны хүмүүс айдас хүрмээр хачин хүннү аялгаар ярьдаг, түүнийг нь жинхэнэ христ мөргөлт хүн франц хүн ойлгодоггүй гэж Буатель мэтгэдэг. Шиллүгийн хэл шинжлэлч М.Гинард Куртисолийн Патуас (Patois) хэмээх нутгийн аялгыг өөрийн хүрээлэндээ тусгайлан судалж, харь язгуурын үгсийг тодруулж тэмдэглэжээ. Мөн тэдний заншил ч ер бус, харь маягтай, хурим найр, оршуулгын зан үйл нь ойр хавийн Шампаны тосгодтой хавьтах юмгүй шахам, байшин барих арга барил нь ч ялгаатай байжээ. Орчин тойрны тосгодод байшингуудаа их талын энгэрт бөөгнөрсөн сүрэг хонь мэт айж эмээсэн байдалтай бие биед нь шахаж барьсан байдаг бол хүннүчүүд тал газраас огт айж жийрхэх юмгүй учир анхны орон байраа ямар ч ажиг сэжиггүй хөдөө тал руу сунгаж барьжээ. Тэдэнд хэн хор хохирол учруулах вэ дээ? Хүннүчүүд үү? Гэтэл тэд өөрсдөө хүннүчүүд шүү дээ. Уудам тал нутаг бол тэдний өвгө дээдсийнхээ үеэс амьдран суусан эх орон нь билээ. Куртисолийн тэрхүү онцгой аялга, монгол, түрэг үг бүхий энэхүү хачин хэл өнгөрсөн зууны төгсгөл (XIX зууныг хэлжээ. Орч.) рүү томоохон орон зайд хадгалагдсаар байгааг тогтоожээ. Харин үүнээс хойш бүх нийтийн сургуулийн боловсрол нэвтрүүлээд нэгэнт зуун жил

өнгөрсөн, тосгодын оршин суугчид автомашинаар газар сайгүй чөлөөтэй аялах болсон зэрэг нь дээрх хэлийг бараг бүрэн алга болоход хүргэжээ.

Харин энэхүү багашаархан газар хүннүүдээс үлдсэн нэг л зүйл ул мөргүй арилж алга болоогүй байна. Энэ нь *tache mongole* буюу монгол толбо бөгөөд төрөлх тосгоныхоо өнгөрсөн үе хийгээд түүний хэрхэн яаж үүссэн түүхийг тэр бүр уншиж судалж яваагүй Куртисоль тосгоны оршин суугчдын хувьд энэ нь оньсого лугаа адил зүйл юм. Олон дахин цус холилдсоны дараа өнөөдөр монгол толбо ямар хэмжээнд байгааг бид мэдэхгүй, учир нь монгол толбо нь эрчүүдэд эмэгтэйчүүд, охидуудаас илүү байдаг байна. Эрдэм шинжилгээний нэг ч комисс Куртисоль тосгоны уугуул иргэдийн ууц бүсэлхийд үзлэг хийж зүрхлээгүй нь дээрхийн шалтгаан байж мэднэ.

3.

□□□□□□□ □ө□ө □□□□□□□□ ү□□□

Дайсны бүслэлтэд үхэж цогцос нь шатаагдсан Хитлэрийн хувь заяа Аттилад ногдоогүй. Мөн Оросоос зайлж нутагтаа хүрээд удирдаж явсан их арми нь байхгүй болсон хэмээн ард түмэндээ өчихөд хүрсэн Наполеон шиг хувь тавилан ч амсаагүй. Хаан Аттила тулалдааны өмнө тун хянамгай байрлуулсныхаа ачаар хүйс тэмтрэгдэх аюулаас гэтэлгэн авч явсан цэргийн хүч нь бас ч сүрдмээр их байсан учир Галлигаас Герман нутгийг дамжин Паннон руу буцах урт замд нь хэн ч довтолж зүрхлээгүй ажээ.

Тэрбээр дүн өвлөөр Корсикийн уугуул аугаа Наполеон шиг чарга хөлөглөж хүнд танигдахгүйн тулд дахаар битүү хучуулан Европыг туулсангүй. Тэрбээр цэргээ манлайлан хамгийн дөт, хамгийн сайн замыг сонгож **Troyes-□□□** дайран Базелийн хаалга хүрээд тэндээсээ хүннүчүүдийн гаргууд сайн мэдэх их мөрөн Дунайг зүглэж улс гүрнийхээ төв рүү хурдавчлан довтолгожээ.

Тэглээ ч олон мянган хүннү хүн Каталауны талд хүүр болон үлджээ. Хүннүчүүдийн хоёр үе амьдарч, шинэ эх орон нь болсон Тисса голын бэлчирт ахуй өргөн уудам тал нутгаа тэд дахин харахгүй. Их тулалдаанд амь эрсдэгсдийг өвөртөө шингээсэн энэхүү тал нутгаар өнөөдөр аялан явахуй дор энэ газар анжисны хошуу хэзээ ч шигдэхгүй, тариан талбай хэзээ ч болохгүй гэдгийг мэдрэх болно.

Шалон-сүр-Марныг дамжин өнгөрөх шөнийн буухиа галт тэрэг Францын нэг мужийн нийслэл болох энэхүү хотынхныг гүн нойроос нь сэрээхгүйн тулд дохиогоо хангинуулдаггүй. Шампааны газар шороонд амгалан нойрсох жар далан мянган хүннү, гоот, франк, бүргүндчүүдийг ямар ч чанга дохио өнөөдөр сэрээхгүй. Тэд бүтэн хагас мянган жилийн тэртээгээс ийн нойрсож буй бөлгөө. Чухамхүү үүнд тэр их тулалдааны үеийн хүмүүс итгээгүй, өнөөдөр ч Шампаан нутгийн Сүпп, ла Шепийн эргэн тойрны тосгодын оршин суугчид итгэдэггүй. “Хамгийн сонин юм нь дараах болой” хэмээн хожмын Гэрэгийн философч Дамаскиос (458-533) хутагт Исидорын амьдрал үйлийн тухай туурвилдаа өгүүлээд “Хоёр талын цэрэг дайчид хатгалдан байлдах ч чадалгүй болоод амиа алдсаны хойно тэдний сүнс гурван өдөр, гурван шөнө хоорондоо шаргуу тулалдаж хүч чадал, зүрх зоригоороо амьд үлдсэн дайчдаас огтхон ч дутсангүй. Тэдгээр сүнснүүд бие биеийг дайрч буй дүрс үзэгдэж, зэр зэвсэг харших чимээ сонсогдож байжээ. Өнөө хүртэл эрт урьдын энэ байлдааны дүр зураг үзэгдсээр байдаг гэх бөгөөд харин яг л амьд дайчид тулалдаж буй мэт харагддаг ч огт дуу чимээ гардаггүй ажгуу.”

Дамаскиос зөвхөн энэ тулалдааны тухай сонссоноос цаашгүй, чухам хаана болсныг мэддэггүй. Гэвч тэрбээр Иорданесын тэмдэглэснээр Аттилагийн нэг л өдөрт багтаахаар төлөвлөсөн тэрхүү тулалдаанаар Пьемонд амь үрэгдэгсэд, хоёр талаас алагдсан дайчдын их тулаан агаар тэнгэрт үргэлжилсэн хэмээн удтал хэлэлцэж, баттай итгэсээр ирсэн, өнөө ч итгэсээр буйг яв цав дүрслэн өгүүлсэн нь буй. Чингэхдээ үхэж үрэгдэгсэд амьд дайчид лугаа адил уухайлахгүй, хашгирахгүй, харин ёолон гаслах, шивнэж ярих чимээ л агаарт тарж замхрах ажгуу. Тулалдаан болсон Пьемонд дөхөж Мурмелон-ле-Гран орох зам заах тэмдэг харагдах үед бидний сэтгэлд мөнөөх шивнээ ярианы тухай яригддаг зүйл санаанд бууж байлаа. Франк язгуурын үг гэдэг нь ямар ч эргэлзээгүй нэртэй тэр газар дундад зууны баримт бичгүүдэд Мурмериум, Мурмерониум магнум ч байлуу, нэг иймэрхүү нэрээр дурдагддаг нь тохиолдлын хэрэг бус, уг нэр энэ нутгийн бусад газрын нэрнээс огт өөр байдаг нь хачирхалтай.

Тэнгэр агаарт явагддаг тэрхүү зэрлэг тулааны тухай домог нь германчуудын сүсэг бишрэлтэй холбоотой зүйл бөгөөд бид тавдугаар зууны Шампаанд очоод байгаа, өөрөөр хэлбэл тэр үеийн германы нутаг дээр байна гэсэн үг. Тэр үед Ромын элемент хараахан бэхжиж амжаагүй, сулхан байсан цаг бөлгөө. Гэвч эртний Гэрэг-Ромын үе, хожмын роман ард түмнүүдийн сүсэг бишрэл нэг л үндэстэй, тэр нь амь үрэгдсэн дайчдын сүнс хоорондоо үзэлцсээр байдаг хэмээн үздэг явдал болой. Тиймээс ч тулалдааны талбартай холбогдсон, хаана ямар том тулалдаан болсон тухай мэдээ сэлтээс үүссэн, мөн тулалдаан болсон газар онцгой увдистай гэдэгт хэзээд итгэхэд бэлэн байдаг субъектив хандлагаас үүдсэн маш олон домог бий. Гэвч Каталауны талд (*Өнөөгийн Францын зүүн хойд нутаг, Шампан-Арденн мужийн нийслэл Шалон эн Шампан нь 1998 он хүртэл Шалон-сүр-Марн, Ромын гүрний үед Каталаун хэмээгдэж байжээ.Орч.*) болсон тулалдаан хийгээд Шампан нутгийн шөнийн тэнгэрт сүнснүүд тэмцэлддэг гэдэгт хүмүүс итгэж үнэмшдэг тухай бас өөр домог бий. 451 оны тэрхүү зуны өдрийн талаар германы хамгийн сэтгэл догдлуулам домгуудын нэг өгүүлдэг. Тэр бол гоотуудаар уламжлагдан умар зүг герман эх оронд нь ирж өөр өөр хувилбараар өгүүлэгддэг домог хуучийн нэг болой.

“Энэ нь шинэ үед ч үзэгдэж харагдаагүй улс түмний их тулалдаан байсан юм. Энэ тулалдаан хүний ой ухаанд удтал амьдарсаар цаашдаа үлгэр домгийн хэлбэрт оржээ. Каталауны тулалдааны хэмжээ далайц, ач холбогдлыг давж гарах үйл явдал хойшид гараагүй ч энэ баримт нь дангаараа баатарлаг туулийн материал хараахан болж чадахгүй байсан юм. Хүний мөн чанар, түүний эмгэнэлт хувь заяаг илэрхийлсэн ямар нэг юм хэрэгтэй байсан хэрэг. Тэр нь уг тулалдаан олон ард түмнийг хамраад зогсоогүй нэгэн овгийн ах дүүс өөр хоорондоо цус асгаруулан тэмцэлдсэн явдал агаад чухамхүү энэ нь Каталауны талд болсон их тулалдааны эмгэнэлт учир холбогдол нь болой. Ийнхүү цус нэгтэй ах дүүс хоорондоо алалцаж, ард түмнээ толгойлж явсан нэгэн их хүнд тохиосон эмгэнэлт хувь тавилан яруу найрагчдын сэтгэлийн утсыг доргиож хөглөсөн ажгуу. Каталауны тулалдаанд вестгоотуудын хаан Теодорих остгоотын суманд оногдож амь үрэгдсэн агаад хааны амийг авч одсон тэрхүү сум нь зууралдан байлдсан дайчдын хэн нэгний тэнэсэн сум байгаагүй. Вестгоотын хааныг харвасан хүн нь гоотын дээд өвөг Амалийн хаадын удмын Андагис байсан юм.” (Вольфф)

Германчуудын энэхүү эмгэнэлт явдлыг Аттила ч, Аетиус ч нэг их тоогоогүй мэт агаад тэр хоёрын нэг нь ч юм уу, эсвэл хоёулаа тулалдааны

талбарт үхэж үрэгдэж болох л байсан. Ямар ч байсан Аттила өөрөө тэргүүн эгнээнд байлдаж явахдаа аюул осолд байнга өртөж, нэг удаа дайсан этгээдэд олзлогдох шахсан тухай мэдээлсэн байдаг. Энэ тухайд Аетиүс наад зах нь буруу тооцоолсон байдаг. Аттила ялагдсан ч түүний эрэлхэг зориг тулалдаанаар ч, ухарч явахдаа ч мохож шантраагүй бөлгөө. Харин ч эсрэгээрээ тэрбээр их армиа удирдаж Европыг хөндлөн туулсан туршлагадаа дулдуйдан олзныхоо ихэнхийг нутагтаа хүргэж чадсан нь түүнийг шинэ шинэ үйл хэрэгт жигүүрлэсэн мэт байдаг. Түүний овсгоо самбаа, зүрх зориг огт суларч мохоогүй. Тэрээр сэтгэлдээ шинээр цэрэг дайчлах санаа тээсээр нутагтаа буцаж иржээ. (Түүний Каталауны тулалдааны дараа шууд нутагтаа буцаж ирсэн эсэх нь маргаантай байдаг. Эртний он дарааллын зарим түүхчид түүнийг Шалоны дараа шууд Италийг дайлаар мордсон хэмээдэг)

Бутцохигдсон Наполеон ч гэсэн Оросоос буцаж ирснийхээ дараа Франц оронд урьд хожид үзэгдэж харагдаагүй их цэрэг дайчилж эхэлсэн байдаг билээ. Яагаад гэвэл корсик эр маань прүсс, австри, орос дайснууд нь таатай нөхцөл байдлыг ашиглахыг хичээнэ гэдгийг сайн мэдэж байсан хэрэг. Харин Аттилагийн хувьд өрнөөс ч, дорноос ч довтолх аюул байгаагүй гэдэг нь тодорхой байдаг. Византийн Маркианос өөрөө санаачилж хүннүчүүдийн эсрэг тэмцэж эхлэхгүй гэдэг нь тодорхой байсан, Аетиүсын хувьд бол тэрбээр цөөн хэдэн легион Шалонд аваачих гэж бөөн юм болсон байдаг юм даа.

Харин Аттила бол довтолгооноо шинээр эхлэн гэж цэрэг дайчилж зэрэвсгээ хурцалсан хэрэг. Тэрээр зориг мохоогүй, байлдаж тулалдах хорхой нь түүнийг хэзээ хэзээнээс илүү гижигдэж байсан агаад энэ удаа түүний сум Италийг онилох ёстой байв.

“Тэгэхэд манай Аетиүс жанжин өмнөх тулалдаанаар харуулсан ур чадвар хэрсүү ухаан, зөн билигээ нотлон харуулсангүй. Тэрээр ядаж л хүннүчүүдийн дайралтыг Альпийн даваануудад барьж саатуулахыг оролдсонгүй. Түүний ухаан санааг ганц л зүйл эзэмдэж байсан нь эзэн хааны хамтаар Италиас зугтан зайлах явдал байлаа.” хэмээн Ромын гэгээн хутагтын албанд зүтгэж явсан, тухайн үед жаран насны сүүдэр зэрэгцээд байсан он дарааллын түүхч Проспер Тиро бичиж үлдээжээ.

Эдгээр мөрийг уншаад Шалоны тулалдааны ялагч нь Аетиүс, ялагдсан этгээд нь Аттила гэж хэний ч санаанд буухгүй. Хэрвээ Проспер Тиро Юлийн Альпийн намхан даваанууд Аттилаг саатуулж зогсооно хэмээн сэтгэсэн бол ихээхэн эндүүрсэн хэрэг. Дунай мөрний дунд биенд эмхэлж зассан арми Хойд Италид цөмрөн орохын төлөө Альпийн хянга нурууг давах гэхгүй нь ойлгомжтой.

“Ийн зугтан одох нь олны хараал идэх дэндүү ичгүүртэй явдал, бас ч аюултай хэрэг учир Аетиүсын ичих нүүр айдас хүйдсийг нь дийлжээ. Чингээд дайсан этгээдийн хэрцгий авир, ханаж цадахгүй шунал олон үзэсгэлэнт мужийг эвдлэн сүйтгэж байгааг нийтээр сайн мэдэх учир Ромын засгийн газар, сенат, ард түмэн Аттилад элч төлөөлөгч илгээж эвлэрэхийг гуйхаас сайн юм байхгүй хэмээн шийджээ. Энэ үүргийг эрхэм дээд гэгээн хутагт Лео, консул Авениүс, префект (*Ромын эзэнт гүрний захиргаа хийгээд эзэн хааны өндөр албаны түшмэл. Орч.*) Тригэтиүсийн хамтаар хүлээж авчээ. Албат шавь нараа зөнд нь хаяхгүй, гай зовлонгоос заавал гэтэлгэнэ хэмээсэн гэгээн хутагт хамаг итгэл найдлагаа бурханд даатгасан бөлгөө. Тэрбээр итгэл бишрэл, зөн совингийнхоо хүчээр зорилгодоо хүрчээ. Хүннүчүүд Ромын элч төлөөлөгчдийг хүндэтгэлтэй хүлээн авч Аттила хаан өөрөө сүм хийдийн тэргүүн ийнхүү хүрэлцэн ирсэнд

ихэд баясч дайныг үргэлжлүүлэхээ больж эв найрыг сахихаа амлаад Дунай мөрөнд ахуй эх нутагтаа буцжээ.”

Дээр өгүүлсэн үйл явдал тун сонирхолтой агаад гэгээн хутагтуудын тухай Умард Галлийн домог хуучид өгүүлдэгтэй таарч буй. Энэхүү домогт өгүүлж буй зүйлийг гэгээн хутагтын он дараалын бичээч хийгээд түүх туурвигсад нотолж буй. Их гүрнийх нь түшиг тулгуур болох цэргийн хүч гэхээр юм тухайн үед байгаагүй учир Ромын нэр хүнд шалдаа буусан байв. Харин тухайн үед ид хүчирхэгжиж байсан шинэ хүч болох сүм хийд хувилгаан чадалд итгэмтгий мухар сүсэгт Аттилад Ромын легионуудаас хамаагүй илүү сэтгэгдэл төрүүлсэн ажгуу.

Ямар ч зэр зэвсэггүй, хачин сонин хувцастай, өөдөөс нь гар хоосон тосч ирсэн эрчүүд бол илбэч, шидтэн, чөтгөр шуламсын эзэн л байж таарна хэмээн хүннүүд итгэжээ. Ер нь Аттила хувраг санваартнуудын хүч чадалд итгэж явсан хүн юм. Тэднийг онцгой чадвартай хэмээн итгэж байсны нотолгоо нь Аттила Каталауны тулалдаанаас нутгийн зүг жолоо залахдаа Трое хотын хамба Лүпүсийг (хутагт Лүп) барьцаалж Райн мөрнийг гаталтал авч явсан хэрэг болой. Лүпүс нь Аттилагийн дэргэд нэлээд удсан бололтой агаад учир нь түүнийг нутагтаа эгэж ирэхэд Трое хотын сүсэгтнүүд итгэж өгдөггүй, хүннүүдэд олзлогдож яваад амьд мултарч ирнэ гэдэг ер бусын онцгой явдал хэмээн үзэж түүнийг хоёр жил цөллөгөд илгээж байжээ...

Аттила, гэгээн хутагт хоёрын уулзалтын байдлыг зураг хөрөгт олонтаа дүрсэлсэн, энэ нь мянган жилийн хойно Ацтекийн хаан Монтезума Кортесыг (*Монтезума 1502-1520 онд ацтекүүдийн хаан байв. Амьдралынхаа сүүлийн жилүүдэд Хернан Кортесын толгойлсон Испанийн байлдан дагуулагчдийн эсрэг тэмцэж байв. Орч.*) хүлээж авч уулзсаныг эс тооцвол үнэхээр хоёр өөр ертөнцийн уулзалт байсан юм. Гэгээн хутагтын гавьяат үйлийг бахдан биширсэн зарим зураач Лео, Аттила нарын уулзалтыг бидний сайн мэдэх Тибр мөрөн, германаар Энгельсбүрг, монголоор Сахиулсан тэнгэрийн цайз (*Ром хотноо сүндэрлэх энэхүү Castel Sant'Angelo нь Хадриан хаанд зориулж барьсан бунхан учир Mausoleo di Adriano ч хэмээнэ. Орч.*) болон Кампо Ваккино (*Английн нэрт зураач Уильям Төрнерийн алдарт зурагтаа дүрсэлсэн Ром хотын байгалийн үзэсгэлэн. Орч.*)-гийн дэвсгэр дээр дүрслэн үзүүлэх нь олонтаа байв. Гэвч энэ нь түүхэн үнэнд нийцэхгүй. Гэгээн хутагт Лео Аттилаг Умард Италид цөмрөн ирж түйвээж байх үед нь тосч очжээ. Аттила уг элч төлөөлөгчдийг Мантовагийн (*Өнөөгийн хойд Италийн Ломбард дахь Мантова мужийн төв. Орч.*) орчим Гарда нуур, По голын завсрын Минчио хэмээх жижигхэн гол дээр хүлээж авч уулзсан бололтой. Хүрэхэд амархан энэ газар тэр үед хүннүүдийн гарт орсон, мөн Милан хот ч хүннүүдэд эзлэгдсэн байв. Өмнийг зорих зам бартаа саадтай тул морин цэрэг туулахад хүндрэлтэй байжээ. Түүний дээр яг энэ үед Дорнод Ромын хаан Маркианос сиймхий ашиглан ар нуруугаар нь хүннүүдийн уугуул нутагт дайран орсон тухай мэдээ Аттила авсан байв. Харин энэ мэдээ чухам хэдийд ирсэн гэдэг нь тодорхойгүй. Ромын гэгээн хутагтын андгайлан байж гуйсныг Аттилаг санаа бодлоо өөрчлөхөд шийдвэрлэх нөлөө үзүүлсэн байж болно. Гэхдээ л Аттилагийн нутаг буцахаар шийдэхэд тэглээ айхтар нөлөөлсөн нь юу л бол. Дараагийн зуунуудад ч христ мөргөлт олон хаад Ромын гэгээн хутагтын санал хүсэлтийг огт тоодоггүй байсан түүх бий.

Тэгэхээр Хүннүгийн хааны Умард Италид хийсэн аян дайн амжилттай болсон ч гэлээ богино хугацаагаар хязгаарлагдмал хүрээнд явагдсан байна.

Энэ талаар бидэнд мэдэгдэж буй зүйл их биш. Нэг нь Аттилаг тодорхойлж буй, нөгөөх нь ихээхэн өвөрмөц онцлогтой нэгэн хотыг үүсч бий болоход хүргэсэн хоёр тохиолдлыг авч үзэж болох юм. Тэр хот бол далайгаас таслагдсан гүехэн устай буланд байгуулагдсан хот улс Венец болой.

Эхнийх нь үнэндээ бараг л онигоо маягийн явдал бөгөөд сонин инээдтэй хэдий ч баттай эх сурвалж болох 1000 оны орчим Византид гарч Суидас нэрээр танил болж эртний Гэрэг-Ромын маш олон зүйл материал, ойлголт цуглуулж хадгалсан нэвтэрхий толь бичигт буй.

“Аттила хүн амьтан бужигнасан Милан хотноо ирээд байхдаа Ромын эзэн хааныг алтан сэнтийдээ заларч, скифүүд (хүннүчүүд) хөлд нь сөгдөж буйгаар дүрсэлсэн нэгэн зураг байхыг харжээ. Аттила тэр дор нь тушаал өгч өөрийгөө эзэн хааны сэнтийд заларч буйгаар, харин Ромын эзэн хааныг шуудайтай алт үүрч ирээд өөрийнх нь хөлд асгаж буйгаар зурахыг тушаажээ.” Энэ бол Гордийн зангилааг илдээр цавчиж тайлсан (Македоны) Александр, эсвэл хивсэнд ороогдсон Клеопатрагийн түүх шиг нэг тиймэрхүү онигоо болой. Газар дундад тэнгисийн орнуудын хүн ард элдэв хачин сонин хууч ярианд дуртай, тэр нь ярихад хөгжөөнтэй, улс төрийн ээдрээтэй нарийн түүхээс илүү хөнгөн амар байдаг учир хүмүүсийн ой ухаанд удтал хадгалагдан үлддэг, харин илүү чухал ач холбогдолтой юм нь хаягдаж гээгддэг байж.

Альтхайм л гэхэд дээр дурдсан түүхийг судалгааны бүтээлдээ ашигласан бол Хелен Хомайер “энэ түүх үнэн гэдэгт эргэлзэх үндэсгүй” хэмээжээ. Миний хувь эргэлзэх шалтгаан нь Ромын эзэн хаадын сэнтий агаад түүнд Аттила де факто суух ч, сууж байгаагаар зуруулах ч учиргүй байсан юм. Түүх ч үүнийг нотолсон. Аттила мөнөөх зургийг хараад уурсан шүүрч аван урж хаяад шинийг зуруулахдаа өөрийгөө мэдээж хэрэг Хүннүгийн гүрнийхээ хаан ширээнд заларч буйгаар, харин Ромын хаад алт үүрч ирж буйгаар дүрслүүлсэн гэдэгт итгэлтэй байна. “Аттила мөнөөх зургийг өөрчлөн зуруулсан гэж хэлэлцдэг ажээ” хэмээн Альтхайм өгүүлсэн нь бий.

Нөгөөтэйгүүр Аттилагийн Миланд байсан тухай мэдээнд зарим зүйл авцалдахгүй байгаа бөгөөд жишээлбэл хүннүчүүдийн гарт орсон Тицинүм (Павиа), Медиоланум (Милан) хотуудыг тонож дээрэмдээгүй, эвдлэн сүйтгээгүй хэмээсэн нь гайхмаар явдал бөлгөө. Мэдээж хүннүчүүд зарим нэг хотыг тодорхой шалтгааны улмаас өршөөн хэлтрүүлсэн байж болох агаад тухайлбал Шалоныг өршөөж Troyes-д гар хүрээгүй нь магадтай. Харин Милан мэтийн том хотуудын хувьд ийн гар хүрэхгүй үлдээх нь юу л бол. Эртний түүхчид хэдийгээр бие биеийн бүтээлээс хуулдаг ч энэ тухайд санаа нэгтэй байдаггүй. Паулус Диаконус По голоос урагш орших хотуудыг Аттила өршөөн хэлтрүүлсэн тухай өгүүлдэг бол Акуилеа хотыг эзлэн авсан тухай Иорданес өгүүлэхдээ:

“Хүннүчүүд амжилтандаа зоригжиж ромчуудын цусанд улам ихээр шунаж Венецийн (Зүүн хойд Италийн бүс нутаг, нийслэл нь Венец хот болой. Орч.) бусад хотуудад дайран орж түйвээн сүйтгэв. Лигүрийн нийслэл, урьд эзэн хааны өргөө хот явсан Миланыг газрын хөрстэй тэгшилсэн (!) агаад Тицинүм (Павиа) ч мөн ийм тавилан амсав. Мохошгүй догшин хүннү нар хөрш зэргэлдээ орших бүх нутаг орныг хоослон сүйтгэв...”

Иорданес хүннүчүүд энэ аян дайнд Галлигаас буцаж ирэнгүүтээ л мордсон хэмээн нэг төөрөлдөж алдсан бол энэхүү аян дайны нарийн ширийн асуудлаар дахин алдах учиргүй байсан юм! Бидний хэзээ ч бүрэн гүйцэд таньж

мэдэх хувьгүй энэхүү ард түмний домог хуучид алдаж төөрөлдөх гэгч юу болохыг өгүүлэх юун. Харин азаар Отто И.Маенхен-Хэлфэн Жак Поль Мигнегийн хэвлэн гаргасан товчоор “Patrologia Latina” хэмээх алдарт эмхэтгэл (*Сүм хийдийн зохиолчдын Христ шашны сүм хийдийн түүхийн эхнээс гэгээн хутагт III Иннокентийг хүртэлх үеийг хамруулж латин хэлээр туурвисан тэмдэглэл ажээ. Зөвхөн гарчгийг нь дэлгэрэнгүй бичвэл бүтэн хуудас эзлэх аж.Орч.*)-ээс хэн зохиосон нь үл мэдэгдэх нэгэн айлдвар олсон агаад түүнд Миланы оршин суугчид хүннүчүүдээс зугтсан тухай өгүүлнэ. “Хот хийгээд орон гэрийг маань дайсны гарт өгөх нь бурханы таалал буй заа. Хамаг эд хөрөнгө маань дээрэмчдийн гарт орж, гал түймэрт шатан үгүй болж, бүх юм дайсны зэр зэвсэгт өртөж сүйтгэгдэв...Бид гагц устаж үгүй болсон орон гэртээ харамсаж гашуудах юу ч биш ээ.” Энэ үеэр мөн Гэгээн Амброзиусын цогчин дуганыг түймэрдэж, өдий төдий санваартан, лам нарыг алж хяджээ. Дээрх айлдварт цөөвтөр лам хувраг, сүмийн харьяат нар амь гарсан тухай өгүүлнэ. “Тэднийг хүннү нар өршөөн хэлтрүүлсэн хэрэг бус, харин олзолсон баахан ачаа тээшиндээ түүртсэн хүннүчүүд сэхээ авч мөрдөж хөөхөөс нь өмнө амжин тэд зугтсан зайлсан байна. (Маенхен-Хэлфэн)

Хүннүчүүд По голын бэлчир газрын хотуудыг дайран эзэлж шуугиан тарьсан нь нэгэнт нотлогдсон зүйл агаад харин Акуилеа хотыг бүслэн байлдаж эзлэн авсан нь Аттилагийн аян дайны хамгийн томоохон үйл явдал болно. Акуилеа (Өнөөгийн Италийн Удинэ мужид орших жижиг хот.Орч.) Адриатын тэнгисийн эрэг орчмын худалдааны томоохон хот, тэргүүн хамбын суурин суудаг, Фриаул, Кэрнтэн (*өнөөгийн Итали, Австрийн нутаг.Орч.*) болон Дунайн бэлчир хүртэлх нийт нутгийг христийн шашинд оруулахад ихээхэн үүрэгтэй газар байв. Акуилеа нь христийн шашны томоохон төв байсны гадна үдшийн (*Наран жаргах зүгийн улс орнуудыг хэлнэ.Орч.*) орон хийгээд Италийн чухал төвүүдийн нэг байсан бөгөөд хүннүчүүд хотын хэрмийг эвдлэхээр хүнд машинуудаа татаж ирэхэд Өрнөд хийгээд Дорнод Ромын эзэнт гүрэн мэгдэн чичирч байлаа.

Иорданес өгүүлэхдээ “Уг нь Аттила Ром руу давших бодолтой байсан юм. Гэвч Прискүсийн тэмдэглэснээр зөвлөхүүд нь түүнийг ятгаж болиулсан. Чингэхдээ хэзээнээсээ дайсагнан үздэг энэ хотыг хайрласандаа бус, харин тэд Ромыг түйвээж сүйтгэснийхээ дараа төдий л удалгүй таалал төгссөн Вестгоотын хаан Аларихийн хувь заяаг санаж (мухар сүсэгтэй болохоор) хааныхаа амь насанд санаа зовниж ийн зөвлөсөн хэрэг байв” гэжээ.

Хуучны түүхчид үйл явдлыг сонин хачин болгож үзүүлэхийн зэрэгцээ элдэв онигоо (Геродотын үеэс) маягийн юмыг хүчээнгүйлэн эрж хайдаг болохоор юмыг хэт хялбаршуулж ойлгох хандлагатай байсан гэдэгт эргэлзэх юмгүй. Гэвч хэргийн гол учир нь дайн хийх орчин үеийн арга барилын үүднээс үзвэл бараг ойлгомжгүй гэж үзэхээр Аттилагийн дээрх шийдвэрт л байгаа юм. Аль эсвэл бид Валленштайны (*Чехийн Бохэмээс гаралтай, Германы цэргийн жанжин, генералиссмүс цолтой эзэн хааны цэргийн дээд командлагчаар хоёр удаа гучин жилийн дайнд оролцсон. Орч.*) түүх болон XII Карл, Наполеон, Хитлэрийн хяналтгүй дураар авирладаг араншин зэргийг нэгэнт мэдэх учир хэт цаашлахгүйгээр Аттилагийн Ромд довтлохгүй алгуурлаад байсны учрыг зүгээр л хэвийн зүйл гэж үзэх ёстой юу? Учир нь удирдагч хүн яарч давчдалгүй тайван амгалан байж, шадар хүмүүс, үнэнч нөхдийнхөө зөвлөлгөөг сонсч байх ёстой! Аетиус Юлийн Альпийг бэхэлж хамгаалаагүйн учир нь тийш цэрэг илгээгээд ялагдвал Равенна, Ромыг хамгаалж чадахгүй болно хэмээн болгоомжилсноос

үүджээ. Аттилагийн хувьд гол саад тотгор нь Акуилеа орох замд таарах эхний хамгийн бат хүчирхэг цайз байв.

“Акуилеа нь Венецийн нийслэл бөгөөд Адриатын тэнгисийн буланд тэнгис рүү түрж орсон хошуун дээр оршино” хэмээн Иорданес цааш бичихдээ “Аттила уг хотыг ер бусын удаан бүслэн суусан ч амжилт олохгүй л байв. Хотыг хамгаалж байсан Ромын цэргүүд баатарлагаар эсэргүүцэн тулалдсан учир Хүннүгийн цэргийн санаа сэтгэл алдагдаж битүү дургүйцэх янзтай болохоор Аттила цэргээ татдаг ч юм уу гэж бодож байсан гэдэг. Аттила нэг удаа хэрмийг тойрон давхиж бүслэлтээ зогсоох эсэх тухай санааширч явахдаа байшингийн дээвэрт үүрээ зассан хоёр цагаан өрөвтас ангаахайнуудаа зөөн хотоос гаргаж байгааг харжээ. Тэрээр сүрхий ажигч хүн байсан учир дагуулууддаа хандаж “Шувуу хүртэл ирээдүйгээ зөгнөж байгааг харж байна уу! Тэд заналхийлж буй аюул ослыг мэдэрч, хана хэрмийг юман чинээ тоохгүй мөхөл нь ирсэн хотыг орхиж байна шүү дээ. Энэ бол зүгээр нэг утга учиргүй тохиолдол бус, харин нөмрөн айсуй гай зовлонг зөгнөж байгаагаас зайлахгүй. Зөвхөн асар их аюул занал л гүн бат үндэслэсэн дадал зуршлыг өөрчилж чадна” хэмээжээ.

Аттила дагуулууддаа адгуус амьтны зан авирын талаар ийн айлдаад өрөвтас шувууны тэрхүү зөгнөлийг үнэн бодит үйл явдал болгохоор зарим судлаачдын тэмдэглэснээр бүслэлтийн машинуудыг Ромын дүрвэгсэд, олзлогдсон хүмүүсээр хийлгэжээ.*

Гэвч Иорданес цааш өгүүлэхдээ “Аттила өөрийн хүмүүсийг Акуилеаг эзлэн авахад ийнхүү зоригжуулж (өрөвтас шувуудын зөгнөлийн гол утга учир үүнд оршино) чаджээ. Тэд хэрэм эвдэх машинууд хийгээд бүх төрлийн эвдлэн сүйтгэх зэвсэг хэрэглэсний эцэст амсхийлгүй хотод даруй дайран орж түйвээн сүйтгэж, тонож дээрэмдэн хамгийн харгис хэрцгийгээр цөлмөн хоосолсон учир хотоос бараг ул мөр үлдээгүй байна” гэжээ.

Гэвч бас ч бага сага юм үлдсэн бололтой агаад сүүлд лангобардууд Акуилеа хотыг мөн л баахан хүчилж байж эзэлж аваад гаргасан авир хүннүчүүдээс огтхон ч дээрдэх юм байгаагүй бөлгөө. Хүннүчүүд далайгаар аялдаггүй, далайчид байгаагүйг эрхбиш мэддэг байсан учраас хотын хүн амын дийлэнх нь завь хөлөглөн тэнгист гарсан хэмээдэг бөгөөд тэд тэнгисийн умард хөвөөнд нэгэн тийм завсрын улс байгуулсан агаад эндхийн гүехэн устай булан тохой, тоо тоймгүй олон хүзүүвч болон намаг бамбалзууртай газар Акуилеа болон дайсанд автагдсан бусад хотын хүн амаас ч давсан олон хүн нуугдаж хоргодох боломжтой байжээ.

Дайсанд түйвээгдсэн хотуудын оршин суугчдын зугтан очиж хоргодсон газар ойр төсөр байсан учир олохгүй байна гэдэг хүний санаанд багтахгүй. Арал, хүзүүвч, гүехэн булан тохой нь ой хөвч юм уу уул хадыг бодвол ямар ч байсан хоол хүнс олоход илүү боломжтой, хэрэг бишдвэл цааш зугтаж ч болно. Гүехэн усаар хүрээлэгдсэн олон арал нь тэр үед цөөн бүл хүн суурьшсан, загасчдын орон гэр ч болж байсан нь тодорхой байдаг. Ингэхээр Венец хот, өөрөөр хэлбэл Акуилеагаас зугтаж очсон дүрвэгсэд арлууд дээр шинэ хот үндэслэсэн тухай домгийн агуулга үнэн бодитой ажгуу. Гагцхүү тэрхүү үйл явдлыг дэндүү хялбаршуулсан байдаг.

*Хүннүчүүд Ираны хотуудын бүслэн байлдаж байсан нь эргэлзээгүй. Тэд Наиссус (Өнөөгийн Сербийн Ниш хот.Орч.) болон Азимус хотуудыг байлдан эзлэхдээ туршлага олсон, Орлеан

хотыг эзлэхдээ тусгай машинууд ашигласан зэргийн тухай өмнөх бүлгүүдэд дурдсан. Хэдэн арван жилээр ромчууд, галличуудтай нягт холбоотой явсан, Ромын жанжнуудын захиргаанд байлдаж байсан хүннү дайчдыг ийн басах ямар учир байв? Харин хойг дээр байрласан хотыг бүслэн байлдах нь хүннүчүүдэд хүндрэлтэй байсан байж болно. Наад зах нь иймэрхүү бэрхшээл хүндрэл Константинополь хотыг хүннүчүүдийн аюулаас аварч байсныг санах хэрэгтэй юм.

Бидний сайн мэдэх Венец шиг урлагийн бүтээл болсон хотыг нэг л гэгээн цагаан өдөр цогцлуулчихна, нэг л өглөө босоход бий болчихсон байна гэж байхгүй. Үүнийг тэнгисээс тасарсан гүехэн устай далайн буланд орших бусад хот, тухайлбал оршин суугчид нь зориг баатарлагаар хөдөлмөрлөсөн авч урьдын чухал ач холбогдлоо алдсан Чиожжиа хот (*Венец мужид орших, модон баганан дээр баригдсан, Венецтэй тун төстэй учир бага Венец хэмээгдэх хот, эх газартай чулуун гүүрээр холбогдоно. Орч.*), Лидо арлын өмнөх арал дээр оршиж байгаад есөн зуу орчим жилийн өмнө далайд газар хөдөлсний улмаас хүчит давалгаанд залгигдсан Метамауко хотын жишээ харуулдаг ажгуу.

Тиймээс венецчүүд хотоо үндэслэн байгуулсан тухай домогт өөрсдөө бат итгэдэг, түүнийгээ тууштай баримталдаг, тиймээс ч германчууд түүхэн үндэс нотолгоо муутайн улмаас уул домогт итгэдэггүйд ихээхэн эмзэглэдэг болой. Франческо Сансовино 1663 онд *Citta nobilissima et singolare* хэмээх Венецийн асар том он дарааллын түүхийг нийтлүүлсэн нь магтавч баршгүй үйл бөгөөд үүгээрээ тэрбээр жинхэнэ венец хүн гэдгийгээ илтгэн харуулсан болой. Тэр итали хэлний “е”-ийн оронд “et” хэмээн бичсэнээрээ Венец (Venezia) хэмээх нэрийн учрыг тодруулж өгч буй. Аттилагийн цэрэг аюумшигт автуулж гай гамшиг тарьсаар байснаас загасчдын сууринд нуугдаж хоргодох газар эрсэн баахан хүн хойно хойноосоо ирж байсан учир загасчид “*veni etiam*” буюу “бас л баахан хүн ирлээ” хэмээн ярьдаг байж. Хоноц хоноцдоо дургүй гэгчээр загасчдын хүлээж авахдаа дургүйлхэж байсан тэдгээр дүрвэгсдийг хожим нь *Veni-etiam*-хүмүүс хэмээн нэрлэж, тэр нь венецчүүд гэдэг үг болсон ажээ. Гэхдээ энэ хувилбар үнэнд нийцэхгүйн учир нь венецчүүд Аттилаг Европын өмнөд нутагт хөл тавихаас бүр өмнө байсан гэдэг нь тодорхой байдаг. Тиймээс энэ нь сайтар бодож олсон үлгэр, яагаад гэвэл Серениссима (*латинаар serenus нь амгалан тайван гэсэн утгатай үг болой. Орч.*) хэмээгдсэн Венецийн бүгд найрамдах улс (*бүтнээр нь La Serenissima Repubblica di San Marco буюу хутагт Маркогийн эрхэмсэг бүгд найраамдах улс хэмээдэг байжээ. Орч.*) тун ч нэр хүнд муутай, ихэмсэг дээрэнгүй авир араншингаасаа болоод эсэргүүцэл тэмцэл их үздэг байсан болой.

Венецийнхний зохиосон домогт итгэдэггүй, тэдний дургүйг ихэд хүргэдэг герман хүмүүс бол миний бие Вена хотноо лекцийг нь сонсож явсан эрдэмтэн профессор Аугуст Фридрих Гфрерэр (1803-1861), Хайнрих Кречмаир (1870-1939) хоёр бөлгөө. “*Ultramontan*” (*Герман хэлт орнууд, Нидерландад дэлгэрсэн католикчуудын улс төрийн байр суурь агаад зөвхөн Ромын гэгээн хутагтын сургааль номлолыг аливаад баримтлахыг шаарддаг. Ultramontan нь уулсын чанад гэсэн утгатай үг, өөрөөр хэлбэл Альпийн чанадын Ватиканы зааж зааварласныг л баримтлах байр суурь болой. Орч.*) байр суурь баримтлагч сүм хийдийн түүхч Гфрерэр “Византийн түүх” хэмээх ихээхэн уншууртай, ойлгомжтой хэлээр бичигдсэн гурамсан бүтээлээ Венецэд зориулсан бөлгөө. Кречмаир нь 1905 онд гучин таван насандаа “Улс орнуудын ерөнхий түүх” хэмээх хамтын гарамгай бүтээлийн хүрээнд Венецийн түүхийн гурван боть

номоо туурвисан хүн бөгөөд энэ бүтээл Венецийн түүх бичлэгт германчуудын оруулсан чухал хувь нэмэр болой.

Энэ хоёр эрдэмтэн эх сурвалжийг хайр найргүй шүүмжилж, баримт нотолгоогүй домог хуучийг үг дуугүй няцааж байсан эрэн зууны хүмүүс юм. Газар дундын тэнгисийн эрэг орчим оршин суух ард түмнүүд үлгэр домогт ихэд дуртай, уламжлалдаа үнэнч, тун ч яриа байдаг учир тэднээс сонин сонин мэдээ материал их олддог билээ. Венецийн хувьд хотыг үндэслэн байгуулсан тухай мэдээ баримт хадгалагдаж үлдээгүй нь хотын эрхтэй хотын тухай ярих хүнийг л төөрөгдүүлж самууруулах нь магад. Германы Балтийн тэнгисийн эрэг орчмын хотууд пүүс, компанийн маягаар үндэслэгдэн байгуулагдаж байсан юм. Хөрөнгө мөнгийг нь худалдаачид гаргаж, газрын тухайд Балтийн тэнгисийн эрэг газар сууж байсан славчуудаас булааж авсан эзэд нь болох гүн бээл, хаад ноёдтой тохиролцон гэрээ байгуулж байв. Тиймээс хотуудын үндэслэгдсэн түүх баримт нотолгоотой, заримдаа он дараалсан олон баримт байдгийг Любек хотын жишээнээс харж болно.

Ард түмнүүдийн их нүүдлийн үймээн самууны үе, ялангуяа Хүннүгийн үед хэн ч тэмдэглэл бичвэр хийж байгаагүй, эсвэл бичиж бүртгэсэн юмаа тэрхүү хатуу ширүүн цагт хадгалж хамгаалж чадаагүй нь тэр үеийн Венецийн тухай ярих үндэсгүй гэсэн үг хараахан биш болой. Тодорхой бичгийн эх сурвалж байхгүй байгаа нь Венец хот бий болсон, хүннүчүүдийн дайрч ирсэн хоёр үйл явдал хоорондоо холбоогүй гэсэн үг ч бас биш болой. Кречмаир өөрөө үүнийг хүлээн зөвшөөрч буй:

“Бүр өмнө Аларихийн довтолгооны үед эзэн хаан Хонориус өөрөө үлгэрлэсний дагуу эх газрын гүнд сууж байсан хүмүүс энэхүү тэнгисээс тасарсан гүехэн буланд шилжин ирсэн байж таарна. Тэгээд ч Аттила дайран ирж Акуилеаг сүйтгэж, бас Конкордиа, Альтиног цөлмөж хоослоход хотод суугаад ч олигтой хамгаалагдаж чадахгүйг хүмүүс нэгэнт ойлгосон байв.” *

“Тэр үеэс л Градо (*Адриатын умард эрэг, Венецийн булангийн адаг газар байх хот.Орч.*) янз бүрийн хөрөнгө чинээний хүмүүс шигүү суурьшсан газар болж, мөн Акуае Капрулае, Конкордиагийн боомт, Альтиногийн өмнө орших арлуудын амьдрал хөл хөдөлгөөн ихтэй болсон нь эргэлзээгүй”. Гучин жилийн өмнө Гфрерэр мөн л үүнтэй адил зүйл өгүүлж байв.

“450 оны орчим эрлэг номун хаан Аттила хийгээд хүннүчүүдийн дүрийг олж Венецийн газар оронд иржээ. Холимог түүх (*historia miscella*) хэмээх он дарааллын бичигт Аттила Италид цөмрөн ирээд Акуилеаг удтал бүслэн байлдаж эзлээд галдан шатаасны дараа Венецийн бусад хотууд: Конкордиа, Альтинум, Падова, Виченцаг сүйтгэн газрын хөрстэй тэгшилсэн тухай өгүүлнэ. Арван дөрөвдүгээр зуунаас эхлэн нэрд гарсан зохиолчид, тухайлбал миний мэдэхээр төрөлх хотынхоо он дарааллын түүхийг туурвисан Дандоло хүннү нарыг анх дайран ирэх үед Венецийн хөдөө нутгийн олон оршин суугчид зэргэлзээх арлууд уруу зугтан одсон, Аттила хөлөг онгоцгүй учир тэдгээр арлыг эзэлж авч чадаагүй, тэнд хожмын далайн Венец (тэнгисийн хот Венец)-ийн суурийг тавьсан гэж бичих болсон бөлгөө. Энэ нотолгоог гэрчилсэн зүйл надтай тааралдаагүй. Тэр үед эрэг орчмын нутгийн олон тариачид тэдгээр арлуудад аврал эрэн очиж өмнө нь тэнд суурьшсан байсан загасчид, усан цэргүүдтэй зэрэгцэн суух болсон гэдэгт итгэхийг миний бие хүснэ. Гэвч эх газрын баячууд, язгууртнууд, газрын эзэд, том худалдаачид арлууд уруу олноороо ийм маягаар

зугтан очсон гэдэгт баахан эргэлзэж буй. Учир нь нэгд, энэ тухайд эртний эх сурвалжид юу ч дурдаагүй, хоёрт гэхэд энэ талаарх хожмын баримт материал энэ тухай өгүүлж буй. Далайн Венец анх бий болоход далайчдын догшин ширүүн, тэсвэр хатуужил бүхүй өвөрмөц овог бий болж, харин гундаж зэвэрч, үрэгдэж мөхөж байсан хуучны соёлт ертөнцөөс ул мөр ч үлдээгүй ажгуу.”

*Тэгэхээр Аттила л холбогдож таарах гээд байна. Аттила бол Александр шиг олон хот үндэслэн байгуулж байгаагүй, харин нурааж устгаж байсан болохоор үүнээс илүү яаж ч холбогдох билээ.

Ex silentio буюу хоосноос дүгнэлт хийснээс үүдэх эрсдлийн тухай бид дээр өгүүлсэн. Дундад зууны түрүү үед хамгийн хичээнгүй бичээч ч илгэн цаасан дээр буулгаж чадахааргүй олон үйл явдал тэнгэр, газрын хооронд өрнөж байсан бөлгөө. Венецчүүд түүхийнхээ аль ч үед тийм ширүүн догшин юм уу, эрэмгий хатуужилтай хүмүүс байсан гэж санагддаггүй юм. Аль дивангарын энэ цаг үе, тавдугаар зууны сүүлийн хагаст тэрхүү далайгаас тасарсан булангийн буйд арал дээр хатуужиж догширсон далайчдаас гадна ихээхэн өвөрмөц сонин бүтэц бүрэлдэж байсан нь тодорхой болсон бөлгөө. Энэ тухай Хүннүгийн хааны ордонд сууж байсан Өрнөд Ромын элчин Кассиодорусын нэр нэгт хүү Кассиодорус гэрчлэн өгүүлсэн байдаг. Тэрбээр гоотуудын хамгийн гарамгай хаан Их Теодорихийн нууцын бичээч явсан тул түүний захидал, бичвэрүүд түүхч Иорданест гол эх сурвалж болж өгчээ. Кассиодорусын үнэлж баршгүй ач холбогдолтой захидлууд хойчийн бидэнд хадгалагдаж үлдсэн нь тохиолдлын хэрэг бус. Их хааны бичиг хэргийг эрхэлж байсан энэ гарамгай хүний хурц ухаан, өндөр боловсрол түүний улс төрийн авьяас чадвартай холбогдсон нь хойчийн ертөнцөд ч ховор тохиолдох үзэгдэл билээ. Тэрбээр Калабр дахь эдлэн газартаа томоохон сүм байгуулж гэлэнгүүд суулган баялаг номын сангаа ашиглуулжээ. Тэрээр өөрөө “Ном хуулбарлах ажлын тухай” хэмээх зохиол бичсэн нь бусдын бүтээлийг сэм хулгайлж хуулдаг хүмүүст удирдамж болгосон зүйл биш, харин ном судар хуулбарлан дэлгэрүүлэгчдийн гарын авлага байв. Түүнээс гадна тэр үеийн боловрол нимгэн лам хуврагуудад зориулж өөрийн номын санд хуримтлуулсан шашин сүм хийгээд иргэний зохиолчдын тухай нэгэн боть номыг бүтээжээ. (Харин нэмэр болоогүй нь харамсалтай, учир нь түүнийг таалал төгссөний дараа тэдгээр гэлэн хуврагуудыг номын сангаас нь хөөн зайлуулжээ)

Кассиодорусын бусад зохиол бүтээл Генуягаас хойш орших хөдөөгийн бяцхан хөөрхөн хот Боббиооор дамжин дундад зууны ном хуулбарлагчдад хүрсэн байдаг бөгөөд зарим нь Латераны (*Ромын гэгээн хутагтын ордныг ийн нэрлэх нь буй.Орч.*) номын санд очсон байна. Тавдугаар зуун шувтарч зургаадугаар зуун эхлэх зааг үеийн Италийн амьдралыг дүрслэн үзүүлснээрээ Кассиодорусын захидлууд хийгээд түүний ариутган шүүсэн Теодорих хааны зарлигуудтай эн зэрэгцэх өөр түүхэн гэрчлэл, туурвил байхгүй.

“Өнгөрсөн жил усан үзэм, чидүн жимс сайн ургасан Истрийн (*Тэр цагт Ромын эзэнт гүрний муж байсан, Италийн Триестийн булан, Хорватын Риека хотын өмнөх Кварнын булангийн завсрын Хорват, Словенийн нутаг болой. Орч.*) дарс, тосыг Равеннад нийлүүлэх зарлиг буулгаж байна. Та нар олон усан онгоцтойн учир урьдын адил шудрага үнэнчээр зүтгэж Истрийн тэр их нөөцийг нааш тээвэрлэн авчрахыг хүснэ. Худалдан авч бэлтгэх нь хангалттай бус, хөлөг

онгоцоор хурдан тээвэрлэх нь чухал байгаа юм. Та нар далай тэнгисээр холхи газрын замыг байнга туулж явдаг төрөлхийн далайчид, орон нутагтаа ч та нар нэг байшингаас нөгөөд мөн л усаар явдаг учир энүүхэнд буй Истрээс дээрх зүйлүүдийг ачиж ирэхэд юухан байхав. Гадаад далайд заримдаа салхи шуурга тавьж аяны замд чинь саад болбол аюул осолгүй өөр зам ч нээж болно шүү дээ. Бидгол мөрний замыг хэлж байна. Салхи шуурганы аюулгүй гол мөрнөөр та нар тээврийн онгоцоороо хуурай газрыг туулан явна гэсэн үг. Чингэвэл холоос харахад нуга талаар давхиж яваа мэт л санагдана шүү дээ...Чингэвээс хөлөг онгоцны хүмүүс та нарын гаргууд эзэмшсэн дарвуулаас чинь аргамж татлага илүү хэрэг болох биз. Ийн усан цэрэг явганаар хүнд ачаа бүхүй завь онгоцоо чирч явж чадна.”

Дээд хэргэмтний бичиг захиа гэхэд арай л гоёмсог гэхээр ч их л хичээнгүйлж бичсэн уг захиа очих хүний хэзээнээс мэдэх зүйлийг дурдсан ч гэсэн аль байдгаараа урлагтай сайхан найруулсан нь илэрхий. Далайн булангийн тасархай алгын чинээхэн тэр газрыг дүрслэн өгүүлсний дараа Кассиодорус цааш үргэлжлүүлж:

“Их далай, эх газар хоёрын өрсөлдөн тэмцэлдэх энэ газар та нар усны шувууд үүрээ засах лугаа адил байшин барилга, орон гэрээ барьжээ. Та нар гөрсөн мөчир, хиймэл далангаар орон байрнуудаа хооронд нь холбож, хуйлран ирэх хүчит давалгааны догшин хилэнг аядуулж тогтоох гэж эргийн элсээр хана босгосон чинь барагтайхан мэт харагдавч их усны хүчийг сөрөн зогсож чадна.” хэмээжээ.

Энэхүү захиа түрүү үеийн мөнөөх Венец холын орнуудтай худалдаа хийж байсныг гэрчилж буй агаад хэн ч зүгээр зугаалж цэнгэх гэж далай тэнгисийн аюул осол ихтэй “холхи газрын зам”-ыг туулдаггүй бөлгөө. Холын орнуудтай худалдаа хийх нь хөлөг онгоцны эздийг нийгмийн хувьд нэгдэж нягтарсан дээд давхрага болж зохион байгуулалтад орохыг шаардаж байсан нь магад. Сайтар зохион байгуулсан холын (өнөөгийнхөөр гадаад худалдаа) худалдаа явагдаж байжээ гэдэг нь Кассиодорын дурдсан эх газарт гүнзгий нэвтэрч салбарласан хэлхээ холбоогоор ч нотлогдож буй. Кассиодор өөрээр гол мөрөн, суваг хоолойгоор яваа чирүүл онгоцыг хааяа хардаг байсан бололтой. Тийм бишсэн бол тэрээр ийм дүр зургийг тийм сүрхий тодорхой дүрслэн өгүүлж чадахгүй байсан буй заа.

Барилга байшингуудыг хооронд нь далангаар холбосон, хиймэл давалгаа намдаагчийг элс овоолж хийсэн, Адриатын тэнгисээр ачаа тээвэрлэх захиалга өгч байсан зэрэг нь бүгд л хамт олноор нийлж гүйцэтгэх ажил үйлс агаад загасчид хийгээд чирүүл онгоцны эзэд дангаараа төлөвлөж ч, хийж бүтээж ч чадахааргүй ажил юм. Далан хийгээд суваг байгуулах зайлшгүй шаардлагаас үүдэн Мисирт хаант засаг, тэнгисийн тасархай буланд худалдааны ажил үйл эрхлэх өвөрмөц онцлогоос үүдэн Венецэд далайн бүгд найрамдах улс тогтсоныг бид бүгд мэднэ. Тэгвэл Акуилеагийн худалдаачид, эх газрын баячууд, тариачдыг бүгдийг нь ус, хуурай газрын завсрын тэрхүү ертөнцөд шахан оруулж, тэнгисийн тасархай буланд тэрхүү гайхамшигт хотыг бүтээн байгуулахад хүргэсэн хүн нь Хүннүгийн хаан Аттила байсан бөлгөө. Харин эхний хүрз шороог асгасан хүн биш ажгуу. Ромын уугуул нутгийн хотын элбэг баян соёлд цэг тавьсан Акуилеа хотын мөхөл нь шинэ эхлэл, шинэ хөгжлийн угтал болжээ. Ганц Акуилеа ч биш, хүннүчүүдийн гал мэсийн аюулд өртсөн хаа газрын олон овгийн хүмүүс далайн булангийн арлыг зорин ирснийг Венецийн түүхчид бараг нэрээр нь гаргаж чадна. Харин ийн ирэгсдийн сонсголонтой нэртэй төрөлх

хотууд Венецийн сайн язгуурт айлуудын угийн бичиг зохиогчдын хэзээ хойно бодож олсон зүйл байж таарна. Учир нь Мочениги юм уу, Гранзони (*Хожмын Венецийн нөлөө бүхий хүмүүс.Орч.*) гэх мэтийн хүчирхэг нөлөөтэй эрчүүдийг загасчдын тосгоноос гаралтай хүмүүс гэж шуудхан л нотолж болохгүй нь тодорхой. Стефанигийн "*Storia dell'aristocrazia di Venezia*" (*Венецийн язгууртнуудын түүх*) хэмээн зохиолдоо бичсэн нь үнэн бол өөр бусад хүмүүс, тухайлбал Виллиарени, Кремона нутгийн Калоприни зэргийн язгууртнууд бүх эд хогшил, түүгээр ч барахгүй алт, мөнгө, үнэт зүйлээ хүннүчүүдийн галын шугамын дундуур авран гарч арал дээр авчирсан ажээ. Адгийн муу хүмүүс ч Аттилагийн гараас мултарч ирсний учрыг хүмүүс тэр бүр ойлгоогүй аж. "Ухаангүй явдал, гэмт үйлээ сүм дуган барьж цайруулахыг оролдож байсан Эмилия нутгийн Мاستиличи (*Венецийг угсаа залгамжилсан хаант улс болгох хөдөлгөөнийг толгойлж байсан ихээхэн нөлөөтэй хүчирхэг гэр бүл байсан.Орч.*)-гийнхан, бас ихэмсэг дээрэнгүй Маги ч ирсэн бөлгөө." (Молменти)

Дурдагдаж буй газар орон бүгд Зүүн хойд Италийн нутагт оршино. Өнөөгийн Хойд Италийн мал аж ахуйн үйлдвэрлэлийн төв Эмилия мужийн зэрэгцээ мөн Карда, Бергамо, Парма, Кремона ч дурдагдаж буй. Зөвхөн Контарини гэгч л уугуул нутгаа гэж хүннүчүүд Акуилеаг эзэлж авахаасаа өмнө дайран өнгөрсөн Бага Конкордиаг нэрлэжээ.

Хүннүчүүд Галлид цөмрөн орохдоо фронтоор давшин байлдаагүй, харин энд тэнд үсчиж явсан нь Умард Италид тэр чигээрээ давтагдаж, тонуулч дээрэмчид хийгээд хааны зараалаар бусдын эд хөрөнгө, эдлэн газар хурааж явдаг цэрэг лугаа адил аашилж элбэг баян хотуудыг сонгож тонон дээрэмдэж явсныг дээр дурдсан баримт нотолж байна. Хүннүчүүдийн ард, тэдний эзлэн авсан нутаг оронд эмх цэгцтэй худалдаа арилжаа гэх юм үлдсэнгүй, гэвч урьд өмнө байлдаан тулаан бишгүй л үзэж явсан овсгоотой италичууд өөрсдийгөө ч, гэр бүл, үр хүүхдээ ч эсэн мэнд авч гарахыг хичээсэн нь тодорхой. Тэд хүннүчүүдийн нэгэнт дайраад өнгөрсөн, дахиад ирэхгүй гэсэн газар руу их л болгоомжтой зүтгэжээ. Тийм газар нь юуны өмнө Миланы ойр орчмын томоохон хотууд байв. Тэдгээр хотууд хоосорч эзэнгүйрэхэд хүннүчүүд хоол ундаар гачигдаж эхэлсэн агаад агт морьд нь өвч тэжээлгүй болжээ. Алдуул малыг ч хоол хүнсэндээ хэрэглэж дууссаны дараа эрт урьдын алс холын аян дайны үеийнх шигээ юм юмаар гачигдаж дутагдах осолтой байдал үүсчээ. Худгууд хүн малын хүүрээр дүүрч бохирдоод, голын ус ч дээрдэх юмгүй болсон байв. Үүнээс болж ходоод гэдэсний өвчин дэлгэрч цэргүүд гүйлгэж эхэлсэн нь их гэм хортой биш ч цэрэг дайчдын бие махбодийг сулруулж, удалгүй тэр нь цусан суулга болж хувирчээ. По голын намгархаг нам дор газар ямар ч армид тун таагүй газар бөгөөд 452 оны шувтрагаар цаг агаар их дулаан байгаагүй ч хүннүчүүдийн дунд удалгүй өвчин тахал дэгджээ. Энэхүү гай гамшгийг гэтлэн давах бэлтгэл, чадал чинээ хүннүчүүдэд байгаагүй юм.

Ийм нөхцөлд Ромыг байлдан дагуулах тухай бодох ч хэрэггүй болжээ. Эзгүй хооронд нь Маркианос гэнэдүүлж нутаг оронд нь халдахгүй байлаа ч Ромыг дайлах нь санахын гарз гэдэг нь тодорхой байв. Аттила Галлийн аян дайнаас эсэн мэнд гарсан ч хэдэн мянган цэргээ алдаж хүнд ялагдал хүлээсэн бол Умард Италид хийсэн цөмрөлт ийн бүтэлгүйтжээ. Аттила Италид зөвхөн түйвээж сүйтгэх, галдан шатаах бус, бас өөр зорилго агуулж явсан нь Ромын хоёр гүрний эзэн хаадад түүний илгээсэн ихэмсэг өнгө аястай захидлууд болон Ромын эзэнт гүрнүүдийн талаар түүний хэлсэн ярьсан зүйлүүдээс лавтайяа ойлгож болно. Гэвч Аттила зорилгоо биелүүлж чадаагүй байна. Тэрээр тонуулч

дээрэмчнээс дээрдэх юм байсангүй. Түүх түүнийг бүхий л үеийн хамгийн жигшүүрт дээрэмчин хэмээн хочлох нь тодорхой болжээ. Гэвч хамгийн ноцтой үр дагавар нь Равенна, Константинополь хоёрын аль аль нь хэрэг явдал Аттилагийн хувьд ийм болно гэдгийг тааварлаж байсан явдал болой. Тиймээс ч тэд алба барихаа зогсоож, элчүүд нь бэлэг сэлт өргөхөө больж, харин өөртэй нь шууд уулзаж яриа хэлэлцээ хийхийг шаардах болжээ. Мэдээж ромчуудыг ингэж аашлах болсны төлөө дайн хийлтэй биш, олз омог ийнхүү эрс багасч, Византид Теодосиус айн чичирч, Аетиус хүннүчүүдийн *frere et cochon* (дотнын найз) байж, германчууд олзоо хуваалцдаг цаг үе улирч өнгөрсөн мэт байв...

Сульдаж доройтсон хүннүчүүдийн Италиас Тисса гол руугаа авч явсан олз омгийн дийлэнх нь өөрсдөө гүйгээд явчих, өөрөөр хэлбэл олзны хүмүүс, эр эм боол олноор байжээ.

Христ шашны толгой лам нар тэдгээр золгүй хүмүүсийн төлөө санаа тавьж байсан тухай бид энэ номын эхэнд уншсан. Харин азаар тэдгээр лам нар зөвхөн мөргөл үйлдээд, идэр залуу бүсгүйчүүдийн санаа сэтгэлийг цэвэр ариун байлгахын төлөө санаа тавиад зогссонгүй. Тэднийг зольж авах ажил зохион байгуулахыг хичээж байжээ. Гэвч тэдгээр бүсгүйчүүдийг зольж авах ажил ар гэр нь мөнгө цаас, үнэт эдлэлээ хүннүчүүдээс нууж авч үлдсэн л бол бүтэх ажил байжээ. Жүүдүүд хийгээд онго шүтээнтнүүдийг хүннүчүүдээс салган авч байсныг хамба лам нар хийгээд Ромын гэгээн хутагтын энэ талаарх бичиг захидал гэрчилж буй.

Олзлогдсдын дотор алт мөнгөөр төлөөс төлж зольж авах хүнгүй үгээгүй ядуучуудын хувь заяа үнэхээр хөөрхийлөлтэй байсан нь тодорхой. Отто Маенхен-Хэлфэн хуучны захидлуудад дурдагдах өөр асуудлууд судалж байхдаа хүннү нарт олзлогдсон ядарсан хүмүүсийн хувь заяаны тухай асуудлыг ч азаар авч үзсэн байна. Тэрбээр дээрх захидлуудаас хачирхалтай гэхээр зүйл олсон нь хүннүчүүдэд олзлогдон явсан эрчүүд, хүүхэд шуухад гурав, дөрвөн жилийн дараа нутагтаа олноороо буцаж ирсэн тухай мэдээ бөгөөд тэдгээр хүмүүсийг хэрхэх талаар хамба лам нар Ромын гэгээн хутагтаас асууж байжээ. Нуугдаж хоцроод амь гарсан эхнэрүүд хэсэг хугацааны дараа дахин эрд гарчээ. Тэр үед Улаан загалмайн байгууллага гэж байгаагүй болохоор хүннүчүүдийн олзлон авч явсан эр нөхөр нь амьд яваа эсэхийг тэд яаж ч мэдэх билээ!

Гэгээн хутагт Лео хүннүгийн газраас буцаж ирсэн азтай эрчүүд авааль эхнэрээ буцаан авч болно хэмээн айлджээ. Ийн гэгээн хутагтын айлдвар салж сарнисан гэр бүлийг дахин нэгтгэжээ. Харин эхнэр нь эгэж ирээгүйн учир дахин гэрлэсэн эрчүүдийн хувьд дээрхийн адил тохиолдол гараагүй ажээ. Учир нь эхнэр хүүхнүүд хүннүгийн олзноос буцаж ирдэггүй байв. Тэд Хүннүгийн ноёдын олон эхнэрийн нэг болж, баян чинээлэг хүннү эрчүүдийн гэрт зарцлагдах нь байв. Хүннү газар олон эхнэр авах ёс ноёрхож байсан учир хэдий л бол хэдий эмс хүүхнүүд олзолж авч болох байв.

Хүннү нарыг Италиас буцтал Ром хийгээд Аетиусын талаас цохоод хэлчихмээр сөрөг үйл ажиллагаа явуулаагүй нь хачирхалтай явдал бөгөөд Равенна хот хүннүчүүдийн түйвээн сүйтгэж явсан Хойд Италийн нутгаас хэдхэн арван километрийн цаана оршдог газар бүлгээ. Тэгэхээр Өрнөд Ромын эзэн хаад хүннүгийн үед толгой дараалан баатар эрс байгаагүй хэрэг. Аттилаг засгийн эрхийг гартаа авахаас бүр өмнө тэд Равеннагийн намагдуу газрын гүнд хоргодохоор Ромоос зугтаж гарсан агаад өөрийн шилмэл цэргийг ч хүннүчүүдийн эсрэг хөдөлгөж зүрхлэхгүй байсан ажгуу.

Харин Маркианос бол огт өөр хүн байв. Тэрбээр өөрөө Балканд Дорнод Ромын эзэнт гүрний байр суурийг хамгаалан тэмцэж байсан хэдий ч Аетиуст туслах цэрэг илгээж байв. Энэ талаарх цорын ганц эх сурвалж бол Испанийн он дарааллын түүхч Хидатиусийн тэмдэглэл агаад тэрээр 427 оноос Акуае Флавиае (Өнөөгийн Португалийн хойд хязгаарын Чавесын орчим)-гийн сүмийн хамба байжээ. Хамбатан 427-468 оны заримыг нь өөрөө үзэж өнгөрүүлсэн үйл явдлуудыг үнэхээр сэтгэл гаргаж үнэмшилтэй өгүүлсэн байна. Гэвч түүний латин хэлээр бичсэн тэмдэглэл нь тухайн үеийн Ромын харьяанд байсан испаничуудын латин хэлийг байнга элэглэдэг байсан Цицероны шоглолыг санагдуулах ажгуу. Хидатиусын бичлэг ядаж л ойлгомж муутай:

“Хүннүчүүд Италийг сүйтгээд өөр хэдэн оронд халдан довтолсныхоо дараа бурхны тааллаар өлсгөлөнд нэрвэгдэж, мөн өвчин тахалд баригдаж үхэж үрэгдсэн болой. Бас эзэн хаан Маркиан туслах цэргийг Аетиус жанжнаар удирдуулан илгээжээ...”

Missis per Marcianum principem Aetio duce caeduntur auxiliis pariterque in sedibus suis et caelestibus plagis et per Marciani subiuguntur exercitum.

Энэхүү будлиантай өгүүлбэр, бас Хэлэн Хомайерын орчуулга ч утгын хувьд ээдрээтэй учир хоёр асуулт тавихад хүргэж буй.

1. Хэрэв эзэн хаан Маркианос цэрэг илгээсэн юм бол тэр нь туслах цэрэг биш, тэрээр өөрийн дайсан хүннү нарт туслах цэрэг илгээхгүй нь лавтай.

2. Хэрвээ эзэн хаан Маркианос жанжин Аетиус гэдэг хүнээр удирдуулсан цэрэг илгээсэн бол тэрхүү жанжин нь түүний албат, өөрөөр хэлбэл Дорнод Ромын хүн байж таарна. Энд нэг нэртэй хоёр жанжин гарч ирж буй. Хоёул хүннүчүүдийн эсрэг байлдсан болж байна уу?

Энд Аетиустай хамаатай “Өрнөд Ромын нэр нэгтэй жанжинтай хольж хутгаж болохгүй” (Хомайер) хэмээсэн жижиг тайлбар хийсэн ч тус болохгүй. Энэ өгүүлбэр нь өөрөө, мөн орчуулга нь ч эргэлзээ төрүүлээд байгаа юм. Маенхен-Хэлфэнд ч бас эргэлзээ төрсөн байна. Тэрээр Австрийн гимназийн латин хэлний буурьтай боловсролдоо түшиглэж хамба Хидатиусын оньсого шиг өгүүлбэртээ тавьсан тасалбарыг (сүүлчийн *et*-ийг) анхаарахыг санал болгосон. Тэгвэл Аетиус нь нэг л хүн юм байна, тэр нь бидний хэзээний мэдэх Аетиус бөгөөд тэрбээр Өрнөд Ромд яаралтай хэрэг болсон Дорнод Ромын туслах цэргийг хүлээж авчээ гэж ойлгогдоно. Тэр үед Балкан нь хүннүчүүдийн захиргаанд байсан учир туслах цэрэг далайгаар явж Гэрэгийг тойрон хүннүчүүдийн арын сэргийлэх ангийн сүүлч Сава голын чигт далдарч байх яг тэр цагийг олж Адриатын тэнгист орж очсон байна.

Хойд Италиас гадна Аттилагийн түйвээн сүйтгэсэн “бусад улс орон” гэдэг нь Тироль болон Альпийн уулсын бэлийн нутаг орон байв. Италиас гарч явсан хүннүчүүд гэдэг нь Хүннүгийн гол хүч биш байсан нь лавтай. Магад цөөн бүл германчууд оролцсон хүннүчүүдийн цэргийн анги Бреннерийг давж, Альпийн хэлхээ уулсыг хоёрдахь удаагаа туулсан бололтой бөгөөд учир нь Ромын хот Аугсбүргийг сүйтгэсэн нь тодорхой байна. Энэхүү томоохон хотыг дайрсан явдал Фернпасс (*Австрийн Тиролийн Альп дахь 1210 м. өндөр даваа. Орч.*) хүннүчүүдэд Европын гүн рүү нэвтрэх хоёрдахь гол үүд хаалга нь болж байжээ хэмээн таамаглахад хүргэж буй. Хүннүчүүд өндөр уулсаас огт эмээдэггүй

байсан нь эндээс харагдах бөгөөд ер нь тэд Лимэс (*Латинаар Limes нь зам харгуй, хилийн зам гэсэн утгатай, ромчуудын байгуулсан хилийн ханыг ийн нэрлэж байв.Орч.*)-ээс дотогш Ромын эзэнт гүрний нийт нутгийг хэнэггүй туулж явдаг байсныг ийн харж болно.

Хүннүчүүд ийнхүү тулалдааны талбар, дээрэм тонуулын газраасаа гүрэн улсынхаа томоохон усан зам болох Дунай руу буцах хамгийн дөт, шулуун зам сонгож, зарим нь Аугсбүргээр дайран Донаувөрт (*Германы Умард Швабад Дунай мөрний дээд биенд орших хот.Орч.*)-ийг чиглэлд, зарим нь Аквилеаг дайран Сава голын зүгт янз бүрийн замаар буцжээ. Энд тэндээс заналхийлэх ноцтой дайсан үгүй, цэргийн жижиг ангиудад учрах аюул байхгүй учир армия ийн хуваасан байж мэднэ.

Энэ бүхнийг зориуд тэмдэглэх учиртай. Яагаад гэвэл эдгээр бүх баримт нь Аттилаг ялагдал хүлээсэн хүн бус, энэ их хүний нэр алдарт огтхон ч сэв суугаагүй байжээ гэдгийг харуулж байгаа юм. Тэрбээр Төв Европт хаа л хаа явж сууж эрх дураар тарвалзаж байхад дайснууд нь өргөө хотоо л арай ядан хамгаалахаас бараг илүү гарсангүй, жижиг хотууд, ил цагаан газруудыг гаргуунд нь гаргаж Аттилагийн идэш болгосон байна. Ийн эрх дураараа, хэнээс айж эмээхгүй яваа хааныг нэг бол Шалонд хүлээсэн ялагдлаа огт тоогоогүй, эсвэл тэр ерөөс ялагдсангүй ажээ гэж үзвээс зохилтой.

Үдшийн орны нэгдмэл хүчинд ялагдаад ч, Хойд Италид өвчин тахалд нэрвэгдээд ч Аттила дийлдсэнгүй, өөрийгөө урьдын адил Европын эзэн гэж үзсээр байжээ. Он дуусах гэж байсан учир тэрээр нутагтаа буцаж ирэв. Аттила хийгээд хүннүчүүдийг сайн мэдэх хүн бол Византи 453 оны хавар гэхэд нурж унах юм байна гэж тооцоолж болох байв.

Ийм нөхцөл байдалд залуу насаа хэдийнээ үдсэн Маркианос Хүннү гүрэнд алба барихаас татгалзаж, Аттилад алтаар гүүр барьж өгөхийг огт бодохгүй байсан нь түүний эр зоригийг илтгэнэ. Аттила нэр нүүрээ бодож дайлаар мордохоос өөр аргагүй нөхцөл байдлыг ийнхүү Дорнод Ромын эзэнт гүрэн өөрөө бий болгожээ.

“Аттила нутагтаа буцаж ирсний дараахнаас алдар нэр, амгалан тайван амьдрал нь түүнийг байлгаж суулгахгүй болжээ. Тэгээд Дорнод Ромын эзэн хаан Маркианост элч илгээж, эзэн хаан II Теодосиусын өгсөн амлалт (Хүннү гүрэнд алба барих тухай)-ыг биелүүлээгүйн учир нутаг оронд нь халдан довтолж цөлмөн хоослоно хэмээн заналхийлжээ. Чингэхдээ урьд өмнөхөөс ч илүүтэй баллаж сүйдлэх болно шүү хэмээн сүрдүүлжээ” гэж Иорданес өгүүлсэн буй. Харин чухам хэдийд гэдэг нь Иорданесийн түүхэнд бүрхэг амой.

Шалоны тулалдааны хүнд хүчир үр дагаврыг амссаныхаа төлөө өшөө хорслоо тайлах, ялангуяа аланчуудад хатуу сургамж өгөхийн тулд Аттила нэгэн шуурхай армийг Галли руу дахин хөдөлгөжээ. Энэ бол тун зоримог ажиллагаа байсан бөгөөд энэ тухай бид Иорданесын түүхээс мэднэ. Харин энэ довтолгоон үнэхээр болсон эсэх тухайд Хүннүгийн түүхээр мэргэжсэн шинжээчид янз бүрийн санаа бодолтой байдаг. Иорданесын өгүүлснээр морин армийн богино хугацааны хурдавчилсан дайралт байсан байж мэднэ. Учир нь алануудыг залхаах нь Аттилагийн дотоод сэтгэлийн хэрэгцээ болсон байв. Чухамхүү Аланы ноён Сангибанус л Аттилагийн талд орно, Орлеаныг түүнд тавьж өгнө гэж амлаж байгаад хүннүчүүдийг Галлигийн нутагт хэт гүн оруулаад, дараа нь эмх замбараагүй их тулалдааны дундуур аланчуудаа авч Аттилагийн талд орох

арга чарга сүвэгчлээгүй хэргийн эзэн байсан бөлгөө. Тиймээс ч Сангибанус л тэр ихээхэн бүтэмжгүй хэргийн үрийг тарьж, өөрийг нь урхинд оруулсны улмаас Хүннүгийн арван тав, хорин мянган морин цэрэг амиа алдсан бөлгөө. Вестгоотууд сэхээ авч туслаар ирэхээс өмнө амжиж хүннүчүүдийн дээрх морин арми аланчуудыг цахилгаан мэт дайран орж бутцохисон эсэх, Сангибанусаас үнэхээр өшөө авч чадсан эсэх нь бүрхэг хэвээр үлджээ. Аттила өөрөө энэхүү залхаан цээрлүүлэх аяныг удирдсан байж таарахгүй, яг тэр үед жаран насны босго алхсан хаан эзэн маань сүйт бүсгүйн эрэлд мордсон байдаг юм.

Чухамхүү түүний энэ явдал нь морьтон ард түмний удирдагч өвгөн хааны хувьд Луар мөрөнд (*Францын баруун өмнөд нутгийн томоохон мөрөн, Атлантын далайд цутгана. Орч.*) уулгалан дайрахаас хамаагүй илүү аюултай хэрэг болсон бөлгөө...

Аттила болон түүний холбоотнуудын байр байдал тэрхүү 453 онд ямар байв, 451, 452 оны их аян дайны дараа Европт хүчний харьцаа ч ямар байсан тухай Иорданес өгүүлжээ.:

“Остгоотууд нэг овгийн садан төрөл вестгоотуудтай байлдахаас хойш суух аргагүй цаг байв. Тэд дээд эзэн нь садан төрлөө алж хядах тушаал буулгасан байлаа ч зарлигийг нь үг дуугүй дагадаг байв. Бүх скиф ард түмэн хийгээд ромчуудын өнө мөнхийн хүсэл мөрөөдөл эцсийн бүлэгт биелэгдэж, Аттилагийн үхэл ирээгүйсэн бол ямар ч скиф ард түмэн дур мэдэж Хүннүгийн захиргаанаас гарахыг зүрхлэхгүй нь мэдээжийн хэрэг байжээ. Аттила хааны үхэл түүний туулсан ер бусын амьдралын нэгэн адил ер бусын хүчирхэг үр нөлөөтэй байсан юм.

Түүхч Прискүсийн өгүүлснээр Аттила үхэхийнхээ өмнөхөн Ильдико хэмээх үзэсгэлэнтэй сайхан бүсгүйг эхнэрээ болгожээ. Тэрээр хүннүгийн заншлаар олон эхнэртэй (*post innumerabiles uxores*) байв. Хуриман дээрээ найр цэнгэлд хэт автсан Аттила дарс нойр хоёртоо дийлдэж орондоо орон унтаж ахуйдаа цус алдаж эхэлжээ. Хамраар нь гарах ёстой байсан цус уг ердийн зам нь хаагдсанаас багалзуурт нь цутган орж бөглөрснөөс болж Аттила цусандаа хахаж нас баржээ.

Олон аян дайнаараа нэрд гарч алдаршсан их хаан архидан согтуурснаасаа болж ийнхүү гутамшигтайгаар амиа алдсан ажгуу.

Маргааш өглөө нь, бараг өдөр болчихсон байхад хааны зарц хиа нар гай зовлон болсныг тааварлаж ордны хаалгыг нүдэж балбаж, эцэст нь эвдэн ороход хаан нь амьгүй, цусандаа будагдан хэвтэж байхыг харжээ. Түүний дэргэд залуу гэргий Ильдико нь орны хөлд сууж, алчуураар нүүрээ дарж уйлж суужээ.

Энэ мөчид эрчүүд үсээ үгтээж, жигшим муухай нүүр царайгаа сийчиж цусаа урсгаж уй гашуу болсон нь хүннүгийн ард түмний заншлаар гайхамшигт дайчин эрийг үхэхэд авгай хүүхний нус нулимс, уйлаан майлаанаар бус, харин эрчүүдийн цусаар эмгэнэл гашуудлаа илэрхийлэх ёсон ажээ.

Үхэл хагацал тохиосон энэ цаг мөчид тун хачирхалтай нэгэн үйл явдал болжээ. Аймшигт хүннү дайсныхаа сүрдүүлгээс болж ихээхэн сэтгэл түгшсэн Дорнод Ромын эзэн хаан Маркианосын зүүд нойронд бурхан морилон ирж нэгэн хугархай нумыг их л учиртай харуулсан гэдэг. Нум сум бол хүннүгийн ард түмний дайн тулаанд ялан дийлж явах гол зэвсэг нь бөлгөө. Түүхч Прискүсийн

гэрчилснээр энэ бүхэн үнэхээр болсон явдал гэх. Аюумшгийн эзэн Аттила томоохон бүх эзэнт гүрнийг үнэнхүү айлгаж явсан болохоор тэнгэр бурхан өөрөө өршөөл ивээлээ үзүүлж энэ дэлхийн эрх баригчдад түүний үхлээр бэлэг барьсан хэрэг болой”.

Прискүс Хүннүгийн хааны ордны амьдрал, Аттилагийн хувь хүний мөн чанар зэргийн талаар олон зүйлийг нүдээр үзсэн гэрчийн хувиар бидэнд бичиж үлдээсэн ч гэлээ Аттилаг тэнгэр халих үед тэрбээр Ромын цэрэг бослого дэгдээсэн овог аймгуудтай байлдаж байсан Мисир оронд Византийн дипломат элчээр томилогдон яваад эзгүй байсан учраас Аттилагийн хурим хийгээд түүний үхэл, Аттилагийн оршуулгын ёслолын талаар түүний бичиж үлдээсэн зүйл байхгүй учир энэ талаар бид мэдэх юмгүй. Гэхдээ Аттилаг амиа алдах яг тэр үед Византийн элчүүд Хүннүгийн хааны хүрээнд очсон байсан юм. Тиймээс Прискүс Босфорт буцаж ирснийхээ дараа Аттилагийн нас барсан шөнө чухам юу болсон, түүнээс хойш ямар үйл явдлууд өрнөсөн тухай тэдгээр элч нараас олж мэдсэн нь лавтай. Эдгээр нь Прискүсийн Византи болон Хүннү нарын тухай найман боть түүхийн бүтээлд орсон, тэдгээр нь эзэн хаан Константинос Порфигонетосын (905-969) томоохон гар бичмэлийн цуглуулгуудад ишлэл болж орсон агаад харин бүрэн бус, хэсэг бусгаар хадгалагдан үлдсэн нь харамсалтай. Иорданес, Кассиодор нар болон бусад олон зохиогч судлаач нар бүгдээрээ Прискүсийн олсон мэдээ, хэлсэн ярьсан зүйлд л түшиглэдэг нь нууц биш. Тиймээс Византийн энэхүү дипломатын туурвисан түүхэнд тулгуурлахгүй л юм бол бидний Аттилагийн талаар бичиж бүтээх зүйл олигтой юм болохгүй, Аттилагийн талаарх бидний мэдлэг Валамир, Ардарих ч юм уу, аль эсвэл өөр бусад хүмүүсийн тухай мэдэж байгаагаас маань илүү гарахгүй гэхэд хилсдэхгүй...

Прискүс өөрөө уран яруу илтгэгч хүн байсан ч зохиол бүтээлдээ тухайн үеийн хүмүүсийн ярьсан зүйлийг ч, мөн дипломат илтгэл айлтгалуудаас олсон зүйлээ түүхчлэн бичиж үлдээсэн байдаг. Оршуулах ёслолын тухай Иорданесын бичиж үлдээсэн зүйл нь гуравдахь этгээдийн үзсэн харсан зүйлд түшиглэсэн байж болох, бас ихээхэн товчилсон зүйл байх магадлалтай...

“Аттилагийн шарилыг цэргийн хүрээний голд барьсан задгай торгон цацрын дотор байрлуулжээ. Энэ ёслол үнэхээр гайхамшигтай сайхан, гүн хүндэтгэл бүхий арга хэмжээ байв. Шилдэг сайн морьтнууд талийгаачийн шарилыг байрлуулсан цацрыг хуй салхи лугаа адил хурднаар тойрон давхиж циркийн үзүүлбэр маягийн тоглолт үзүүлж дуулж явна. Чингэхдээ тэд талийгаач хааныхаа үйл хэргийг магтан дуулна. Дуу нь ойролцоогоор дор дурдсан агуулгатай:

„Praecipuus Hunnorum rex Attila
 Patre genitus Mundzucō
 Fortissimimarium genitium dominus,
 qui inaudita ante se potentia solus
 Scithica et Germanica regna possedit
 Nec non utraque Romani orbis imperia
 Captis civitatibus terruit et,
 ne praedae reliqua subderentur,
 placatur precibus annum vectigal accepit:
 cumque haec omnia proventu felicitates egerit,
 non vulnere hostium, non fraude sourum,
 sed gente incolume, inter gaudia laetus
 sine sensu doloris occubuit.
 Quis ergo exitum putet

Quem nullus aestimat vindicandum?"

Латин хэлээр бичсэн дээрх нэгэн хэмнэл бүхүй хүүрнэлийн урт ишлэлээс хүннү нар элдэв ёслол хийгээд их хаадынхаа оршуулах ёслолын үед латин хэл хэрэглэдэг, олон хаадыг латин хэлээр ёсолж сүүлчийн замд нь үджээ хэмээн шууд дүгнэх аргагүй. Ишлэл латин хэл дээр байгаа нь эзэн хаан VII Констанусын хуулбарлан бичигч нар энэ сайхан дууг тоогоогүй, эзэн хааных нь заналт дайсан явсан хүнийг магтаж сайшаахыг хүсээгүйн учир багаахан хэсгийг иш татаж бусдыг нь орхисон байж болох талтай. Нөр их хөдөлмөрөө зарсан Прискүсийн гэрэг хэл дээрх бичвэр бидэнд олдоогүй, харин Иорданесын дээрх латин орчуулга бидэнд байгаа, Иорданест Прискүсийн эх бичвэр бүрнээрээ байсан бололтой.

Өмнөх хоёр зууны зааг дээр хүннү нар төлөвшиж хөгжсөн яруу найрагтай байсан гэх нотолгоог “нүдэнд орсон хог, шүдэнд орсон мах” шиг үздэг зарим эрдэмтэд хүннү нарын энэхүү дуу харь латин хэлээр байгааг дор нь урвуулан ашиглаж гоотуудыг “тоглоом”-доо татан оруулахад ашиглахыг хичээжээ. Хүннү нарын найранд оролцохдоо Прискүсийн бусдын хамтаар сонссон дууг тэд гоотуудын дуу гэдэг нь гарцаагүй, мөн тэнгэр хальсан Аттилад зориулсан дээрх дуу ч ялгаагүй хэмээцгээж буй. Мажаарын эрдэмтэд (хүннү нар өвөг дээдэс нь болохоор мажаарууд тэднийгээ хамгаалцгааж байна хэмээн тэднийг ч бас буруутгасан), мөн англи эрдэмтэн Томпсон нар Фридрих Клүге болон бусад зарим эрдэмтдийн дээрх онолын эсрэг хэнд ч итгэл үнэмшил төрүүлэхээр баримт нотолгоо нэгэнт гаргаж тавьсан учир, асуудлын ач холбогдол ямар ч бай, үзэл санааны ийм маргааныг дахин гаргаж ирэх шаардлагагүй буй заа. Миний бие зөвхөн Томпсоны үнэхээр буурьтай агаад ухаалаг санаа бодлыг дахин давтан тэмдэглэх байна. Хүннү нарын талаар ямар ч санаа бодолтой бай, ямар ч л болов тэд орой үдшийн цагаар задгай галын дэргэд айраг ууж архи сөгнөж суухдаа очиж очиж гоотуудын баатарлаг туульсыг сонсоно гэдэг хэн бугайн ч санаанд багтахгүй, түүгээр ч барахгүй аугаа их хаанаа оршуулах ёслол дээр харь ард түмний, тэгээд ч өөрсдийнх нь байлдан дагуулж захиргаандаа оруулсан ард түмний хэлээр дуугаа дуулж, туульсаа хайлна гэдгийг төсөөлөх аргагүй.

Ямар ч дууг огт өөр авиа аялга бүхий хоёр өөр соёлын хэлээр яг адилхан буулгана гэдэг бүтэшгүй үйл билээ. Дээрх дууг хүннү хэлний өгүүлбэрүүд богино, хатуу авиа ихтэй зэргийг харгалзан герман хэлээр дорх байдлаар буух болов уу хэмээн сэтгэж хөрвүүлэв.: *(Тайлбар: Герман хэлнээс утгачилан хөрвүүлэв.Орч.)*

Мүндзүх эцгийн хөвгүүн
Мандсан төрийн тэргүүн
Хүннүгийн хаан АттилаТа!

Хүчирхэг Ромын гүрэн,
Сармат, герман хийгээд
Харь улс түмнийг эрхшээсэн
Хамгаас хүчирхэг хаан билээ!

Олон хотуудыг эзлэн чичрүүлэв
Олныг ч өршөөн хэлтрүүлэв.
Олсон олз омгоо тарааж
Олон хүннү нараа баярлуулав. Та!

Энэ их үйлсийг бүтээгээд
Эгэл бие шаналалгүй
Элдэв урвалт шарвалтгүй
Энгүй амьдрал чинь дуусав

Анд нөхөдтэйгөө найрлаж
Аз жаргалын дээдээр бялхаж
Алт эрдэнэс, амттан шимттэнийг
Амталж эдэлж явсаар
Хаан хүний ёсоор үрэгдэв Та!

Өнгөрсөн хүнийг яриад яхав!
Өшөө хорслын тухай ч бүү дурс!

Хааны архи дарс хийгээд хайр дурлалын манан дунд тохиосон энэ үхлийг Иорданес зэмлэн буруушаасан бол Прискүс төвч байдлаар дүрсэлжээ. Үнэ цэнэ, ач холбогдол нэн их энэ дуунаас үзэхэд Аттилагийн үхэл нь найр хурим, баяр баясгалангийн дундаас эрлэг номун хаанд дуудагдсан жинхэнэ хүннү хүний үхэл, хаан хүний үхэл ажээ. Хүннү хүн бол нэг талаас айхыг үл мэдэх эрэлхэг баатар ч гэлээ нөгөөтэйгүүр аз жаргал гэж юу болох, түүний үнэ цэнэ ямар байдгийг мэдэх, амьдралын мэргэн ухаан хийгээд амьдрах урлагийг эзэмшсэн байх учиртай хэмээн хүннүчүүд үздэг байжээ гэж ойлгогдоно. Хүннүчүүдийн ийм байр суурь нь Прискүсийн элчээр явж ирээд өргөсөн тайлан тэмдэглэлдээ хүннү нарын талаар дурдсан зүйлийн нотолгоо болсон бол хаан хүний талаарх германчуудын байр сууриас тэс өөр зүйл байсан нь тодорхой. Хэрвээ дээрх дуу зарим түүхч эрдэмтний үздэг шиг гоотуудын дуу мөн л юм Аттила хааныг тулалдааны талбарт эрэлхэгээр байлдаж яваад алагдсан тухай өгүүлэх байсан ба Ильдико бүсгүйтэй бус, харин Вотан бурханы илд агссан ариун онгон бүсгүйчүүд (*Рихард Вагнерын “Walkure” дуурийн Вотан бурхан хийгээд түүний илдэт бүсгүйчүүдийг хэлжээ. Энэ дуурь бол умрын домгоос сэдэвлэн “Нибэлүнгүүдийн бөгж”-өөр цуврал дөрвөн дуурь бүтээсний нэг болно.Орч.*)-ийн нэгтэй л учир ургуулах байсан буй заа.

Хүннүгийн ард түмэн хаан эзнээ ийм байдлаар үхэхийг анх удаа үзэж байгаа ч юм биш билээ. Ругилатай хамтран төр барьж байсан Аттилагийн эцэг Октар ч нэгэн тулалдааны дараа хийсэн хөлгүй их найрын дараа юм уу, эсвэл найр ид жигдэрч байхад гэнэтхэн нас нөгчсөн тухай өмнө өгүүлсэн билээ.

Хүннүчүүд хааны амийг хорлосон залуу бүсгүйг буруутгахгүй байгаа тухай дууны эцэст өгүүлдэг нь ч гайхал төрүүлдэг. Хүннү нарынхаас өөр ямар ч нийгэмд Ильдико бүсгүйн талаарх дээрх шийдвэрийг ерийн байдаг л зүйл хэмээж элдэв хэл яриагүй хүлээж авах нь юу л бол. Тэгээд мянган жилийн дараах нийгэмд бол Ильдиког илбэ жатга, ад зэтгэрийн хүчээр Аттилагийн үхлийг дуудсан шуламс гэдгээ хүлээн зөвшөөртөл нь яасан их тамлан зовоох байсан бол? Мөрдөн байцаах арга ажиллагаа дээд цэгтээ хүрч хөгжсөн өнөө цагт бол тэр золгүй хүүхэн хэрхэн зовж тарчлах байсныг төсөөлөхөд түвэггүй.

Тэхдээ түүнийг огт зүгээр өнгөрүүлээгүй биз ээ. Уг нь Ильдикогийн онгон биеийн гэрч болсон цусан толбыг л харуулах учиртай тэнгэр хальсан хааны цусанд нэл будагдсан орон дээр олон цагаар түүнийг лав л зүгээр суулгаад байгаагүй байх. Хүннү нарын хийгээгүй тэрхүү мөрдөн байцаах ажиллагааг домог хууч гүйцээх гэж оролдож, дараа нь гэзэг даран шинжлэх ухаан мөшгиж эрсээр амой...

Ильдико бүсгүйн талаар мэдэгдэж буй юм маш бага. Аттила түүнтэй гэрлэсэн, нэр нь Ильдико буюу Хильдико байсан, үзэсгэлэн төгс тэр бүсгүй үзсэн харсан хүмүүст ихэд таашаагдсан гэх мэт. Ильдико гэдэг нь герман нэр гэдгийн тухайд хүмүүс санал нэгддэг. Хүннү нар ч герман хүний нэр хэрэглэх явдал байсан. Гэхдээ герман бүсгүйн герман нэр гэдэг нь илүү магадлалтай. Ильдикогийн царай зүсний сайхан Аттилагийн ордныхонд ихэд таашаагдсаны учир нь тэрбээр цэвэр герман маягийн гоо үзэсгэлэн бүрдсэн бүсгүй байжээ. Хөөрхөн зүс царайтай хүннү бүсгүйчүүд энд тэнд цөөнгүй л гүйж явсан байж таарна. Тиймээс Аттилагийн үхлийн дараа их удалгүй Хүннүгийн хааныг алсан хүн нь хүннү гарлын янхан хүүхэн байжээ гэх цуу яриа Византид (тэнд гарахгүй бол өөр хаана гарахав!) дэгдсэн нь ор үндэсгүй яриа юм. Хэрэв тийм байсан бол тэр янхан хүүхнийг хамгийн сүүлд хэрэглэсэн хүн нь Аттила болж таарна. Учир нь тэр хүүхнийг хааны бие хамгаалах цэрэг мэдээж өршөөхгүй байсан нь лавтай. Аттила, Ильдико хоёрын хайр сэтгэл наад зах нь хааны ойрын анд нөхдийн хүрээнд илэрхий байсан, хааныг Ильдико алсан гэж хардаж сэрдсэн зүйл огт байгаагүй нь үүнийг харуулдаг.

Гэвч түүхэн домогт Ильдико Аттила хааныг алсан гэх сэжиг таавар гараад ирсэн байдаг. Энэ домог зургаадугаар зуунд лам нарын он дарааллын бичгээс эх аваад яруу найрагчдын сургааль шүлгээр дамжин түүх туурвигсдын бийрээс урсан гарч эцэстээ Германы баатарлаг туульст умрын хар бараан өнгө төрхийг олж өшөө хорсол тайлсан том үйл болж бидний үед хүрч иржээ. Хэрэвзээ нэгэн цагт хэн нэгний хуримын шөнө дэлхийн утга зохиолд тэгтлээ сүрхий нөлөөлөх байсан бол тэр нь Ильдико Аттила хоёрын хурим байх байсан биз.

Харин одоогоор энэ тухай бие даасан ном судар ч байхгүй, баталгаатай эх бичвэрүүд тарж дэлгэрсэн нь үгүй. Зөвхөн ам дамжуулан ярих, янз бүрийн эх сурвалжаас хуулбарлах, тайлбар хийхээс хэтрэхгүй л байна. Домог хууч яриа л гол үүрэг гүйцэтгэж, шүүмж судлал хөлд ороогүй байна. Бид нэг талаас герман ард түмнүүдийн амьдрах орон зайд домог хууч бий болох цаг үе, нөгөө талаас эртний Гэрэг-Ромын хийгээд христийн уламжлал нэгдэж нэгэн их урсгал бий болох эрэн зуунд амьдарч байна. Ийм нөхцөлд далайн хөлөг онгоцны хитэгт бяцхан дун хясаа мэтийн өчүүхэн биетнүүд наалдах лугаа адил их хүний үхэл мэтийн үйл явдалд элдэв янзын хувилбар, хэтрүүлэг, гоёчлох үзэгдлүүд наалдахаас ч аргагүй.

Жишээлбэл Малалас гэгч сири лам дэлхийн он дарааллын бичиг зохиож эхэлжээ. Тэрээр өөрийн бүтээлд “амь оруулах”-д хэрэг болох бүх зүйлийг цуглуулсны дотор мөнөөх Прискүсийн тэмдэглэл ч оржээ. Аттилагийн амь насанд халдах хуйвалдааны талаар Прискүсийн элчийн тэмдэглэлд нэлээд дэлгэрэнгүй дурдсаныг бид мэдэх мэдэх билээ. Чухамхүү византийнхны энэ санаархал л сири ламын хувьд Аттилагийн үхэл болж хувирсан аж. Түүнийхээр бол Хүннүгийн хааны амь биеийг хамгаалах хишигтэн цэргээс нэг нь хааны амийг бусниулах хэрэг үүсгэж, мэдээж нэгэн хүннү бүсгүй түүнтэй нам хуйвалдах ажээ. Малалас ламын гаргасан хувилбарт нэг л зүйл үнэнд нийцэж буйг анзаарч болно. Тухайлбал Аттилад дуртай цагтаа бараалхдаг эсэхийг нь Эдеконоос Хризафиос асуухад тогтсон нэг л өдөр харуулд гардаг тухайгаа хэлсэн байдаг. Харин Прискүс шудрага хүн болохоор бид энэ хэрэг явдал яаж төгссөн тухайд түүний тэмдэглэлд дурдсан зүйлд итгэх нь зүй.

Илгэн цаасан дээр хэвлэсэн сүмийн ном сударт тэмдэглэгдсэн зүйлс хойчийн ертөнцийн сонирхлыг ихэд татаж эрэгцүүлэн бодоход хүргэх нь бий.

Прискусийн жинхэнэ эх хэмээн Малаласын эндүүрсэн зүйл нь үнэн хэрэгтээ гар дамжсан хоёр буюу гуравдахь эх булгаас авсан ишлэл агаад түүний дээр өмнө дурдсан Аттилагийн амийг хорлох гэсэн Византийн дуулиант түүх ташуур өгч шашин сүмийн түүхэнд орж таржээ.

Булгаарын хаан Симеон Малаласын он дарааллын бичгийг хуулж авах зарлиг буулгаж байв. Энэ хуулбараас эртний Орос оронд мөн хэд хэдэн удаа дам хуулбарлаж авчээ. Ингээд эдгээр бичвэрүүдээс нэгийг (энэ хувилбар өнөө Оросын ортодокс шашны захиргааны номын санд буй) нь арван зургаадугаар зуунд Аттила хааны түүхтэй жишиж судалж үзсэнээс шинэ хувилбар урт зам туулсаар дараах түүх бий болжээ.

“Судар бичигт өгүүлснээр тэрхүү хаан Аттила умрын орноос ирсэн агаад асар их цэргийн хүчээр Ромын хотуудыг байлдан дагуулж Ромыг бүслэн авчээ. Ромын ноён (эзэн хаан) үзэсгэлэнтэй охинтой юмсанж. Охин нэг удаа хотын хэрмэн дээр гарчээ. Тэрбээр гучин насны сүүдэр зэрэгцсэн байсан амой. Ромын хааны охин үзэсгэлэн гоо бүсгүй гэдгийг хаан Аттила урьд нь сонссон байжээ. Ингээд түүнийг үзээд хаан Аттила өгүүлсэн нь. Хэрвээ та нар охиноо (хааны) өгөхгүй бол хотыг чинь эвдлэн сүйтгэнэ шүү хэмээжээ. Ингээд хотын бүхий л дээд хэргэмтнүүд хамба ширээтүүдийн хамтаар охинд очиж: Хаан Аттила хотыг маань сүйтгэнэ гээд байна. Хотоо үнсэн товрог болгуулахгүйн тулд чи хаан Аттилад очно уу хэмээн мөргөн гуйжээ. Чингээд уг бүсгүй хаан Аттилад очсон аж. Тэрээр хааны хөлд сууж ахуйд хэвтэж байсан хааны хамраас их цус гарч эхлээд удалгүй насан өөд болжээ. Тэгэхээр нь охин хааны нөмрөгийг авч эгэж ирээд Аттила хаан хэрхэн насан эцэслэсэн тухай хотынхондоо дуулгасан байна. Аттила хааны шадар хүмүүс хааныхаа шарилыг авч Итали, Герман орныг дайран Мажаарын оронд хүрэлцэн ирж оршуулсан байна”.

Дьюла Моравчик сүм хийдийн слав хэлнээс энэ түүхийг буулгасан агаад тэрээр түүхэн учир шалтгааныг боловсруулж дээрх хэлбэрт оруулж нэгэн шинэ домог бий болгосон болой. Бид бүгд энэхүү түүхэн учир шалтгааныг мэдэх билээ.

1.Аттила 452 онд Италийг дайлаар мордсон, Ромын гэгээн хутагт хотыг ершөөн хэлтрүүлэхийг Аттилагаас гуйсан.

2.Эзэн хааны дүү (охин биш) Хонориа гүнж Аттилатай гэрлэхийг хүссэн.

3.Хуримын шөнө Аттилагийн хамраас цус гоожсон, энд хуучин гэрээст гардаг дайсан этгээдийн цэргийн жанжин Холопернест (*Хуучин гэрээст дурдсанаар тэрхүү Холопернес нь Ассирийн жанжин агаад түүнийг Газар дундын тэнгис хийгээд Улаан тэнгисийн хавийн орнуудыг байлдан дагуулахаар Вавилоны Небукадезенар хаан илгээсэн хэмээнэ. Орч.*) очиж гоо үзэсгэлэнгийнхээ хүчээр илбэдэж амийг нь хорлож хотоо аварсан Юдитийн сэдвийг гаргаж ирсэн.

Тэгэхээр он дарааллын түүхч маань өөрөө хийсвэрлэж зохиосон зүйл огт үгүй.Түүгээр ч үл барам тэрээр Аттила Хонориаг эхнэр болгон авах санал тавьсан, аль эсвэл Хонориагийн өөртэй нь суух саналыг хүлээж авсан тэр үед Хонориа нас нь нэлээд явчихсан байсныг ч тооцож, тэрбээр хэдийгээр гоо үзэсгэлэн төгс бүсгүй ч гэлээ гучин нас гэдэг үлгэр домгийн гүнжийн хувьд ч тийм таатай зүйл биш гэдгийг тэмдэглэжээ. Аттилагийн амийг хорлодоггүйн учир хуучин гэрээсийн жүүдийн харгис гүнж Юдит Холопернес жанжны толгойг

авчирсан шиг Хонориа гүнж Хүннүгийн хааны толгойг авчирдаггүй, харин арай зөөлрүүлж билэгдэл маягаар хааны өмсгөлийг авчирсан болгожээ. Эцэст нь Аттилагийн шарилыг Хүннүгийн улсад бус, мажааруудын газар авчирсан хэмээн тэмдэглэсэн нь Мажаар орон тэр үед нэгэнт Хүннүгийн өв хэмээн үзэгдэх болсон байсантай холбоотой. Учир нь газар зүйн талаасаа мажаарууд тэр үед нэгэнт Дунай-Тиссагийн нам дор газрыг нэгэнт өөрийн болгож эзэмшсэн байсан үе, түүхийн талаасаа бол мажаарууд хүннү нараас хойш хэдэн зууны турш үе үе томоохон дээрмийн аян дайн хийж хавийн улс орныг аюумшигт автуулж байснаар домог хуучид байнга тааралддаг мажааруудыг хүннү нартай адилтган үздэг явдлаас үүджээ.

Гэсэн ч германы домог хуучийн ертөнцөд Аттила хийгээд түүний үхлийн тухай домог, өгүүлэл, он дараалын бичигт хараахан гардаггүй, их л бол Юдитийн тухай сэдвийн хэлбэрээр хааяа тааралддаг нэгэн чухал сэдэв хадгалагдан үлдсэн байдаг нь өшөө хорслын тухай сэдэв болой. Хүннүчүүдийн дээрх дуунд хааны үхлийг өшөө авагч байхгүй учир үхэл биш хэмээдэг. Хэрвээ хааны хуримласан тэрхүү бүсгүй өшөө авагч байсан бол яах вэ? Хэрэв тэрээр үнэхээр өшөө авагч байсан юм бол бүргүнд бүсгүй Ильдико нь Юдит, Шарлотте Кордай (*Францын энэхүү язгууртан эмэгтэй 1793 оны 7 сарын 13-нд Францын хувьсгалын нэрт зүтгэлтэн Жан Поль Маратын амийг бусниулж нэрд гарсан. Тэрээр эхлээд Францын хувьд баяр хүргэн дэмжиж байснаа хүчирхийлэх үйл ажиллагаа нь гаарсаар оргилдоо хүрэх үед нь соён гэгээрүүлэх үзэл санаанаасаа ухарлаа хэмээн ойлгож Ж.П.Маратыг гол буруутан хэмээн үзэж амийг нь хорлоод 4 хоногийн дараа цаазлагдсан болой.*Орч.) хоёрын дунд зохих байраа эзлэх учиртай!

Энэ нь хэтрүүлэг мэт санагдаж болно. Гэхдээ үнэн хэрэгтээ манай тивийн хуучны баатарлаг туульсуудад дурдагдаж буйгаар Аттила хаантай ямар нэг байдлаар холбогдоогүй европын үндэстэн бараг байхгүй гэхэд болно. “Умрын уламжлалт тууль, домог хуучид Аттила хаан Вальтер (*“Вальтер, Хильдегунд хоёр” хэмээх Германы туульд хар багаас нь сүй тавьсан Вальтер, Хильдегунд хоёр Хүннүгийн хааны ордонд барьцаанд суудаг тухай өгүүлнэ. Тэхдээ гол үйл явдал нь Вальтер нь Франкийн хаан Гүнтэрийн арван хоёр баатартай тулалдаж буй тухай юм. Гүнтэр нь Нийбэлүнгийн туульд гардаг Бүргүндийн хаан Гүнтэр болой.*Орч.) болон Бернийн Дийтрих (*Дийтрих фон Берн нь Германы дундад зууны туульсын хамгийн нэрд гарсан баатруудын нэг бөгөөд нэгэн удаа өөрийн авга Эрманарихт хөөгдөж Хүннүгийн хааны дэргэд хоргодон сууж байсан байдаг.*Орч.) нартай холбогдон дурдагдахаас гадна Бүргүндийн туулиудад мөн нэр гарна...Домог хуучийн түүхэн талаас үзвэл дээр дурдсан туулиуд Германы туулиудаас ч илүү өргөн хүрээг хамрана. Германы тууль, домгоос гадна Аттилагийн тухай Мажаар, эртний Франц, эртний Испани, Кимри (*Уэльсийн кельтүүд бөгөөд өөрийн хэл, утга зохиолтой байсан.* Орч.) болон бусад улс орны тууль, домогт дурдагддаг. Ингээд үзвэл Аттилагийн нэр гарч буй тууль домгийн материалын гарал үүсэл (генезис) нь өнөө хүртэл тайлахад бэрхтэй, судлаачдын анхаарлыг татсаар байгаа асуудал болой”. (Ханс Бек)

Тэгэхээр тэдгээр тууль, домогт түшиглэн хүннү нарын тухай өөр бусад ном зохиол туурвиж болох байсан, наад зах нь хувь хүний хувь заяаг дүрсэлсэн ном бичих нь илүү сонирхолтой байсан нь эргэлзээгүй. Учир нь баатарлаг туулиуд нь өөрийн гэсэн баатруудтай, тэд нь дан ганц байлдаж тулалдаад байсангүй, бас хайрлаж дурлаж, нэр төрөө, ард түмнээ хамгаалж, оргож зугтаж, харь нутаг оронд одож, эгэж ирж байгааг дүрслэн өгүүлдэг. Янз бүрийн улс

үндэстний нэр нь үл мэдэгдэх зохиогч, яруу найрагчдын бидэнд үлдээсэн эрт урьдын эдгээр түүхийн уран яруу, тэнүүн дэлгэр дүрслэл дотор хүннү нарын ерөнхийдөө нэг л янзын бараан, түүхэн дүр давтагдана. Магад ч үгүй чухамхүү энэхүү дүр төрх хийгээд түүх хоорондын зөрчил л Аттилаг тууль хийгээд домог хуучид удтал амьдруулаад байсан байж мэднэ. Түүний үхлийг хэн ч байдаг л нэг ердийн үйл явдал хэмээн ойлгон хүлээж авахыг хүсээгүй байж мэднэ. Тиймээс түүний үхлийн шалтгаан, утга учир, үр дагавар хэрэгтэй байсан хэрэг.

Ямар ч болов үүрд амьсгал хураасан Аттилагийн орны хөлд уйлж суугаа Ильдикогийн тухай сэдэв тэр цагаас хойш ерөөс устаж алга болсонгүй, ард түмнүүдийн ой санамжаас ч арчигдсангүй. Ингээд Ильдико-Хильде нь Криймхильд (*Аттила хааны гэргий болгон авсан Ильдико нь герман овгийн бүргүндчүүдийн хааны охин Криймхильд мөн гэж домог түүхэнд өгүүлдэг. Орч.*) болж, Аттилагийн үхлээс үүдсэн эмгэнэл нь амь үрэгдсэн бүргүндчүүдийн хойтохыг унших гашуудал болон хувирч, Аттилагийн амиа алдсан Мажаарын нутгийн гүнд ахуй нутаг нь газар зүйн ямар ч ойлголтоос хол илүү соронздон татах хүчийг олно. Бүргүндчүүд мөхлөө зөгнөж Дунайг уруудан Хүннүгийн нутагт ирэх болно! Эдгээр үйл явдал ээдрээтэй замаар явагдсан нь тодорхой. Түүхийн зам харгуй хэзээд даваа нугачаатай байдаг бол уран яруу бүтээл бүрэлдэх зам ч ялгаагүй л ээдрээтэй байдаг. Түүний дээр Иорданес, Прискүсийн бүтээлээс бага сага юм уншсан зарим эрдэмтэн зохиолч, яруу найрагчдын бүтээлийг будлиулж баллах явдал бий. Хэдийгээр зарим нэрийг зөв дурддаг ч гадаад нөхцөл байдлыг тэр бүр зөв тайлбарлаж чаддаггүй нь үүгээр тайлбарлагдана. Вальтер, Хильдегунд хоёрын тухай туулийн гол баатар нь Хүннүгийн хааны ордонд барьцаанд сууж байсан энэ залуу хос байдаг, мөн хүннүчүүдэд алба барьж байсан тухай дурдагддаг, зарим герман хүн Аттилагийн ордонд өндөр алба хааж байсан баримт тааралддаг бол энэ бүхэн нь жинхэнэ түүхэнд бэлээхэн байдаг баримтууд билээ. Тидрекс (Дийтрих)-ийн тухай туульд Аттила нэгэн бүсгүйг эхнэр болгон авдаг гардаг. Тэр бүсгүйн нэрийг Эрка (Дундад Германы төв герман хэлний аялгаар Хельхе, Эдда буюу эртний исланд хэлээр гарсан бүтээлүүдэд Херкиа хэмээнэ.) гэдэг нь зөв юм. Тэгэхээр Прискүсийн бүтээлдээ дурдсан Хүннүгийн хааны ордонд юм нэхэж суугаа хүүхнүүдийн дунд байдаг Эрка хэмээх бүсгүй Исланд хүртэл алдаршсан байдаг байна. Аттилагийн ах дахин төрөх нь нэг их онцгой сэтгэгдэл төрүүлэхгүй ч Бледа хэмээх нэрийг туулийн баатар Блодел, бүр Блоделин ч болгосон байх ба Аттилаг залгамжилсан хоёр их хаан болох хүннүгийн Одоакер, гоотын Теодорих нар туульд Аттилагийн зэрэгцээ Отахер, мөн Бернийн Дийтрих (Дийтрих фон Берн) гэж гарна. Аттилагийн хөвгүүдээс Эрнак, Эллак нар нь ч туульд гарах ба түүхэнд дурдагддаггүй бусад хөвгүүд нь Айтлел, Орте, Ортлиб болон Алдриан гэх ихээхэн сонин нэрээр гарна.

Огт санаанд орохооргүй нэг сонин зүйл бол Аттила эдгээр туульд ухаант мэргэн, сайн санаат хааны дүрээр гардаг явдал болой. Түүнийг асар хүчирхэг, ертөнцийн эрх засаг, эзэрхэн ноёрхогч, сайн үйл бүтээгчийн байдлаар дүрсэлсэн байдаг. Хааяа нэг насан өндөр болж ядарч доройтсоны улмаас хэтэрхий зөөлөн, өрөвч сэтгэлтэй байдлаар дүрсэлсэн байдаг нь дан магтаал бүхий тодорхойлолтыг мөлийлгөх тал буй. Түүгээр ч барахгүй Этцель (*Аттилаг герман хэлээр Этцель хэмээнэ. Орч.*) хаан цогчин дуганд мөргөл үйлдэхээр явж буйгаар дүрсэлсэн нь Реймс, Мэц хотуудын их цогчин дуганы өмнөх талбайд болсон үйл явдал хийгээд Трийр хотын Ойкариусын сүмийг эвдлэн сүйтгэсэнийг нь бодохоор этгээд сонин сэтгэгдэл төрүүлэх нь лавтай.

Аттилагийн ордон ч тэр үеийн туульчдад мөн л гойд сонин сэтгэгдэл төрүүлсэн байдаг. Хүннүгийн хааны орд өргөөний ерөнхий дүр төрх нь хөлөг баатруудын хайр дурлалын яруу найраг ид хөгжиж, хэрэн явагч туульчид урлагийн тэнгэр оршсон нутаг, уран яруу бүхнийг ивээн тэтгэгчдийг хайж хаад ноёдын ивээлд орж, нэг ордноос нөгөөд дамжин тууль хайлж явах үеийн (*Манай эрэний өмнөх тав, дөрөвдүгээр зуунд Гэрэгт тууль хайлах үйл сонгомол урлаг болж мэргэжлийн туульчид олноор төрж байв. Орч.*) туулиудад хадгалагдан үлджээ. Туульчид ийн хаадын ивээлд найдаж явах цагт Мажаарын тал нутаг Пуста дахь Аттилагийн өргөө тэдэнд гялалзсан өнгө төрхтэйгөөр төсөөлөгдсөн нь бий. Хүннүгийн хааны ордны найр наадмын талаар Прискүс бэлээхэн дүрслэн өгүүлснийг бид мэднэ. Түүгээр ч үл барам трубадорчууд (*Дундад зуунд ордны дууны яруу найрагчид, хөгжмийн зохиолчид, дуучдыг нийтэд нь ийн нэрлэдэг байв. Орч.*)-ын өмнөх үеийн төлөөлөгчид Аттилагийн хурим найрт оролцож явсан бололтой байдаг. Ямар ч болов эдгээр тууль Остгоотын нутагт анхны хэлбэр дүрсээ олсон мэт. Чухамхүү энд Аттилагийн өвийг түүний хөвгүүдтэй булаалдсан тэмцэл өрнөсөн хэдий ч, магад ч үгүй энэхүү тэмцлийн өнгөн дээр гоотуудын дунд Хүннүгийн хааны тухай эерэг дурсамж хадгалагдан үлдсэн байж мэднэ.

Аттила хэзээ ч Германы баатарлаг туулийн гол баатар болж байгаагүй, туулийн үйл явдалд харьцангуй бага гардаг байхад Мажаарт үндэсний баатар, түүний түүхийн анхны хамгийн аугаа хаан хэмээн хүндлэгддэг. Мажаарт хадгалагдан үлдсэн болон нээж олсон түүх домог, он дарааллын бичиг, туульст Аттилаг есдүгээр зуунд үндэслэгдсэн Мажаарын үндэсний төр улсын Арпадын угсааны хаадын түүхэн дээд өвөг хэмээн үзсэн байдаг бөгөөд түүний удам 1301 онд III Андреас хаанаар төгсгөл болсон бөлгөө.

Мажаарын нийслэлийн хуучин Будад өнөө ч буй Акуинкум хэмээх Ромын суурингийн балгас Аттилаг “мажарчлах” мажааруудын дээрх хүчин чармайлтад ташуур өгч өдгөө Аттилагийн цайз хэмээгдэх болжээ. Гран гол Дунай мөрөнд цутгах газар буюу их Дунайн баруун этгээдэд Аттилагийн өөр нэг цайз байсан хэмээдэг. Энэ нь Прискүсийн очсон Аттилагийн хүрээ байсан тэр газар биш болно. Аттилагийн тухай домог, хүннүчүүдийн түүхийн он дарааллын түүхийн нэр нь үл мэдэгдэх мажаар зохиогчид ес, аравдугаар зууны хооронд герман домгуудаас янз бүрийн түүхэн баримт, сэдвийг авч үндэснийхээ хэлбэрт оруулснаар жигтэй сонин ээдрээ үүсчээ. Энэ домогт Аттила, Криймхильд хоёр хүүтэй болж түүнийгээ христийн суртлаар хүмүүжүүлнэ. Мөн Криймхильд, Гизела нэртэй хүүхнүүд хүннүгийн газар ирж ихээхэн зовлон амсч буйн улмаас эцэстээ германчууд, мажааруудын (германчууд, хүннүчүүд биш!) хооронд цус асгаруулсан их тэмцэл өрнөж, түүнд мэдээж бүх германчууд, түүгээр ч барахгүй бүх христ мөргөлтнүүд алагдаж, эртний онго шүтээнтнүүд их ялалт байгуулна.

Энэхүү домгийг бий болгосон барил нь цор ганц тохиолдох зүйл биш юмаа гэхэд ямар ч байсан ер бусын шинжтэй. Энэ домог Европын түүхийн өөр аль ч бодгальд хамаарахгүй, зөвхөн Аттилагийн хувь хүний шинж чанар, учир холбогдол, түүхэнд гүйцэтгэсэн үүргийг товойлгож илэрхийлэх зорилго агуулсан хэмээн дүгнэж болно. Аттилагаас өмнөх алдартнууд болох Арминиус (*Хэрүскийн ван, манай эрэний 9 онд Варусын тулалдаанд Ромын цэргийг бутцохиж ихэд нэрд гарсан. Германыг чөлөөлөгч хэмээх алдрыг хүртэж явсан. Орч.*), Марбод (*Манай эрэний өмнө 8 онд Майн мөрний сав газар сууж байсан германчуудын нэгэн салаа сюб ясны маркоманчуудын ихэд нэрд гарсан хаан. Орч.*), Верцингеторикс (*Галл-кельтийн овгийн арвернерчүүдийн*

ван, манай тооллын 52 онд Галлийн дайны 7 дахь жил Галлийн бараг бүх овог аймгийг нэгтгэн босч ромчуудтай сүүлчийн томоохон тэмцэл явуулсан. Орч.), Аттилагаас хойшхи томчууд болох *le bon roi* (сайн хаан) Дагобер (Сайн хаан нэрт, франкуудын өвөг меровингийн хаан, мөн ромчуудтай тэмцэж нэрд гарсан. Орч.), Карл Мартель (Манай эрэний 717-739 оны хооронд голчлон Германы овог аймгуудын эсрэг олон удаагийн тулалдаанд ялж явсан гарамгай жанжин. Их Карл хааны өвөг. Орч.), Их Карл зэрэг түүхэн бодгалиуд тус тусдаа олон домогтой байдаг ч гэлээ Аттила шиг германы бүх домог хуучид дурдагдах хүчийг харахан олоогүй ажгуу. Эдгээр домог хууч яриа нь Европын төв, Альпийн уулс, Паннонийн тал хээр, Испани газраас Исланд хүртэлх өргөн уудам нутгийг хүрч уламжлагдаж, сүүлдээ Гэрэгийн баатруудын эрэн үеийн Хомерын аугаа туулиуд шиг хүний хорвоогоос халин гарч бурхдын ертөнцийг ч хамардаг болсон бөлгөө.

Барагтай юманд итгэдэггүй түүхчид бол бидний бараг дуулаагүй Азийн өдий төдий байлдан дагуулагчдыг иш татаж, тэд Аттилагаас дутуугүй үйлсийг бүтээж л явсан, гагцхүү ялгаа нь газар зүйн өөр орон зайд л юм биз дээ гэдэг. Тэд Аттилаг цагаа олж гарч ирсэн, германчууд дуу шүлэг тэрлэж дуулж эхлэх тэр цаг үед Аттила ирсэн, тухайн үеийн германчуудын ухамсар уран зохиол, урлагийн нөлөөг мэдэрч, зохих хэлбэрийг олж эхэлсэн үе Аттилад ихээхэн нөлөөлснөөр герман хэв шинжийг өөртөө шингээсэн хүн хэмээдэг. Харин зуун жилийн дараа Германы эрх зүй цаасан дээр бууж, Германы төр улсын бүтэц хэлбэр дүрсээ олж эхлэх үед бол Аттила германчуудын хувьд Тея (Остгоотын сүүлчийн хаан. Орч.), Гильдерих (Франкуудын хаан. Орч.) нараас нэг их ялгаагүй, тэднээс илүү сэтгэгдэл төрүүлж чадахгүй байсан хэмээх биз.

Гэвч энд дурдсан зүйлс их л итгэл үнэмшил төрүүлмээр дуулдавч би түүнд хэрхэвч итгэж чадахгүй ээ. Аттилагийн талаарх цөөн эх сурвалжид дүрслэн үзүүлж буй түүний хувийн төлөв байдал нь бийрийн үзүүрээс гарсан нарийн нягт дүрслэл бус, харин модоор зорсон бүдүүн бараг дүр болой. Түүнд гэрэл сүүдрийн хослол үгүй, элдэв янз төрх байхгүй, зүгээр л хар тал нь дийлсэн, бөөн хар бараан дүрслэл, гэрэл гэгээтэй зүйл тун өчүүхэн. Тэдгээрт Аттила гарамгай жанжин байсан гэдэг нь л түүний хувь хүний мөн чанараас хамгийн түрүүн нүдэнд тусдаг зүйл болой. Гэхдээ энэ чанар нь дангаараа түүнийг түүхэн их бодгаль болохыг бүрэн дүүрэн илтгэж хүрэлцэхгүй, зөвхөн Аттилагийн их хүний хэв шинжид байнгын тодотгол шинж болж явдаг учир бид аль алийг нь бараг л нэгэн цул зүйл болгон ойлгох ёстой. Энэ нь Александр, Ханнибал, хожмын Цезарь, Францын IV Хайнрих, Густав Адольф, Кромвель, Их Фрийдрих, Наполеонд ч нэгэн адил хамаарна. Энэхүү аугаа ихийн хэв шинжийг өөртөө шингээгээгүй атлаа илд сэлэм хангинуулах дуртай дээд эрх баригчид бол Нерогоос Хитлэр хүртэлх өөрийгөө хэт дөвийлгөгчдийн эгнээ бүрдүүлдэг бөлгөө.

Дэлхийн түүхийн ач холбогдол бүхий ноёлогч бодгалиудын эгнээнд Аттила багтаж чадна. Тухайн цаг үеийг бүхэлд нь, тухайн үеийн хүмүүсийг онцгойлж буруутгаж болохгүй зүйлээр ганц Аттилаг буруутгаж болохгүй. Ромын эзэн хаадын ёс суртахууны хэм хэмжээг уландaa гишгэсэн цадиггүй амьдрал Аттилагийн амьдрал үйлээс долоон дор байсан юм. Германчуудын захирагч Гайзерих, Ойрих нар бусдыг үл тэвчигч бурангуй үзэлтэй, өөр шашин мөргөл бүхий хүмүүсийг хатуу ширүүнээр мөрдөн хавчдаг байсан. Аетиус хийгээд Аттилагийн аминд халдах ажиллагааг төлөвлөж зохион байгуулсан Теодосиус нар Ромын хоёр эзэнт гүрний толгойд суухдаа хууран мэхлэх, муу арга заль

зохиоходоо Аттилагийн нэгэн адил гаргууд байсан бол Аттила шиг ам тангарагаасаа буцах нь тэдний хувьд мөн л хэвийн зүйл байв.

Харгис хэрцгий дайн байлдаан явуулах, өдий төдий ард түмнийг боол болгох, эзлэгдсэн хотуудыг хайр найргүй түйвээж сүйтгэх зэрэг нь Аттилагаас өмнө Аларих болон бусад дайнчдын үед ч, Аттилагаас хойш лангобардууд (*Лангобардууд нь Сьюбийн бүлэг омгийн бүрэлдэхүүн хэсэг, семнонуудтай ойр төрөл учир Эльбийн германчуудын овог агаад Эльбийн доод биенд нутаглаж байв.Орч.*), Аравийн байлдан дагуулагчид болон ландскнехтүүдийн (хөлсний цэрэг) армид ч хэвшил болсон хэвийн гэхээр үйл байсан болой. Эзэн хааны цэргийн жанжин Тилли Аттилагаас хойш хоёр зуун жилийн дараа Германы голт зүрх болсон Магдебүргэд германчуудынхаа эсрэг Аттила Бүргүнд болон Шампааныг яаж түйвээж сүйтгэж байсан яг л тэр маягаар харгислан хэрцгийлж байсан юм.

Нөгөөтэйгүүр заримыг нь Прискүсийн гэрчлэн үлдээсэн, заримыг нь сүүлд нээж олсон баримт материалаас үзэхэд Аттила эерэг сайн талтай хүн байсан нь харагддаг. Хүннүгийн хаан Ром, Византи болон бусад газраас барьж байсан албын хүчээр улам л баян чинээлэг, дэгжин тансаг болсоор байсан ордны амьдрал, эд баялаг, эрх ямбанд умбах болсон хэргэмтнүүд хийгээд зөвлөхүүдийн хүрээлэлд байсан ч өөрөө бол тун эгэл байдлаар амьдарч, биеэ тун даруу авч явдаг байсныг миний бие түүний зан чанар бус, харин оюуны их чадавхтайн илрэл, эзэлж буй ноёлогч байр суурь, эрх үүргээ сайтар ухамсарласны шинж гэж үзнэ. Аттила хааны хувьд Паннон нутагтаа Сарданапал (*Ассир гүрний сүүлчийн хаан бөгөөд Ассирийн Ашшурбанипал, Вавилоны Шамаш-шума-укин зэрэг хаадтай эн зэрэгцэх алдар суутай, баян тансаг амьдралд хэт автагдсан хүн байсан ажээ.Орч.*) шиг баян тансаг амьдралд тарвалзах нь ямар утга байх билээ! Тэрбээр тэртэй тэргүй Европын эзэн байсны учир түүнийгээ үзүүлэх гэж алтан цомоос сархад хүртэж, алтан утсаар нэхсэн хувцас хөдрөх хэрэг юун. Тэглээ гээд тэртэй тэргүй оргилдоо хүрсэн тэр хаачих ч юм билээ! Тиймээс ч тэрээр Паннон дахь өргөөндөө нүүдэлчний амьдралын олон заншил, шинж төрхийг хадгалж явсан биз, тиймээс ч орд өргөөнийхөө амьдралд тэрбээр хожмын Дорнод Ром, Өрнөд Ром хийгээд хүннүчүүдийн мэдэх Ойрын Азийн олон эзэнт гүрнийхээс илэрхий зай барьж өөрийнхөөрөө, нүүдэлчин маягаараа аж төрдөг байсан хэрэг.

Хүннүгийн гүрэнд зорчсон бядан явагчдын мэдээлж байсан элдэв адал зэхий хэрэг явдал, заналхийлэл, элчүүд хийгээд тэдний дагуулуудыг хүлээж авахдаа үзүүлдэг байсан элдэв аяглал, энэ бүхэн бол өнөө бид улс төрийн өдөр тутмын амьдралд үзэж өнгөрүүлдгийн адил сайтар цэгнэж найруулсан жүжиг байсан юм. Хорьдугаар зуунд ч эрх засаг нь өөрийн гэсэн атрибуттай, ном судартай байх нь бараг заншил болсон зүйл. Зүйрлэвээс Муссолинид индэрт гарч үг хэлэхэд нь буу зэвсаг хэрэг болдог, Хрущевт шаахай нь ширээ балбахад зориулагдаж байх жишээтэй. Гагцхүү жинхэнэ түүхэн том бодгаль л бусдын элэг доог болохгүйгээр тийн авирлаж чадах бөлгөө. Тиймээс ч Хитлэр хэзээ ч ингэж авирлахаар зүрхэлж байгаагүй.

Аттила ажил үйлсээ явуулах, яриа хэлцээ хийхдээ өөрт буй бүхий л чадвар, арга хэрэгслийг бүрэн дүүрэн ашигладаг байжээ. Энэ нь түүний бусдаас давуу байх гол хөшүүрэг нь байв. Германы олон овог аймгууд хийгээд тэдний янз бүрийн зан араншинтай удирдагчидтай он удаан жилээр хэл амаа ололцож холбоотны найдвартай харилцаатай байсан нь түүний хувь хүний

шаргуу тууштай зан чанар хийгээд дипломатын арга чадварыг нотлон харуулж буй. Илд сэлэм хийгээд хоосон яриа ятгалгаар Валамир, Ардарих нарын эрчүүдийг өөртөө хэдэн арван жилээр үнэнч зүтгүүлэх аргагүй нь тодорхой байсан. Харин өөрөө төөрөлдөх, хэн нэгэн этгээд түүнийг хууран мэхлэв гэж үзэх ахул тэрбээр ихээхэн эмзэглэж ханддаг, өнөөгийн хэн нэг улс төрийн зүтгэлтэн бол мушийгаад л өнгөрөх юман дээр ноцтой үр дагавар бүхий дүгнэлт хийдэг байв. Үүгээрээ тэрээр эрэн зууныхаа л бүтээгдэхүүн байсан хэрэг. Хувь хүний эмзэг сэтгэл, нэр төрөө эрхэмлэх араншин, Хүннүгийн хаант улсаа бүхнээс дээдлэх талаараа Аттила жинхэнэ харь зэрлэг ард түмний хөвгүүн гэдгээ харуулдаг байсан юм. Гэтэл III Валентиниан, II Теодосиус мэтийн хаад хийгээд Аетиусын хувьд ч улс төр, албан тушаал гэдэг юм тэр үед нэг их чухалчлаад байхаар ёс суртахууны агуулгатай зүйл байхаа нэгэнт больсон байв.

Хүннү гүрнийг тун хурдан нурж унахад хүргэсэн зүйл нь явж явж харь зэрлэг энэ ард түмний гэнэн итгэмтгий зан чанар байсан бөлгөө. Аттила эрт дээр үеийн өвөг дээдэс Моодун юм уу, хүннү нарын бусад хаад ноёдын адилаар үхэхээсээ өмнө амжиж үр хойчисынхаа дунд “их цэвэрлэгээ” явуулсансан бол хүннүгийн ард түмний үр үндэс үлдэж хоцроод цааш удам дамжин амьдрах жинхэнэ боломж гарах байсан. Иорданесын өгүүлж буй тоо тоймгүй олон эхнэрээс төрсөн хөвгүүд яваандаа нэг ард түмэн бий болгосон хэмээнэ. Харин тэдний талаар мэдэгдэх юм байхгүй, хөвгүүд нь эхчүүдээ мэдэхгүй, бутач хүүг хууль ёсныхоос ялгаж салгах аргагүй, эрлийз герман хүнийг скифийн өчүүхэн хувь цус судсаар нь гүйж буй хүнээс, эрлийз ром хүнээс ялгах аргагүй боллоо хэмээн халаглах болсон цаг байв. Энэхүү хөвгүүдийн ард түмэн юм болгоноос жаал жаалхан юм өөртөө шингээж авсан агаад чухамхүү энэ нь тэр ард түмний хэв шинж болжээ. Католик мөргөлт Стюартуудын алдаа дутагдал болгоныг уг үүсэл гарвалтай нь холбож бөөн шуугиан болгодог байсан хэмээн тэмдэглэгдсэн байдаг. Бид харцын гэр бүлээс төрж гарсан аугаа Монмаут (1100 оны орчим төрсөн, Английн санваартан, эрдэмтэн, анхны түүхчдийн нэг. *Эртний Гэрэг-Ромын жишгээр Британнийн хаадын үйл амьдралыг өгүүлсэн Historia Regum Britanniae-г туурвисан. Энэ бүтээлийг туурвисны учир язгууртны зэрэгт хүрсэн хүн болой. Орч.) хийгээд Бервик (Английн нэрт зураач. Орч.) нарыг албан ёсны мангуу нараас ялгаж салгаж дөнгөнө. Харин Аттилагийн хайртай хүү, эелдэг зөөлөн, тусархаг араншинтай хэмээгдсэн Эрнакийн эх нь хэн байв? Аттилатай эрэмгий дайчин чанараараа их адилхан хүү Эллак, Дэнгизик нар Аттилагийн аль эхнэрээс төрөв? Эсвэл Аттилагийн Гэпидийн хаан Ардарихийн дүү бүсгүйтэй учир ургуулснаар хорвоод мэндэлсэн хүү Гайзм нь яагаад онцын гойд үүрэг гүйцэтгэсэнгүй вэ? Гэтэл Ардарих хаан бол Аттилагийн ухаант зөвлөх, холбоотон хаад ноёдоос хамгийн эрэлхэг баатарлаг нь байсан, тэрбээр энэхүү хөвгүүн Гайзмыг хүннү-гэпидийн нийлмэл язгуур угсаатайн хувьд Аттилагийн залгамжлагчаар тодруулах ёстой байсан бус уу!*

Дэлхийг байлдан дагуулагч маань хуримын шөнө шал согтуу, сүүлчийн дурлалт хүүхнийхээ хажууд амьсгал хураах мөчид түүхэнд шийдвэрлэх биш гэлээ ч чухал үүрэгтэй байдаг учир зүй хийгээд шүтэн барилдлагын хууль огт үйлчлээгүй мэт байдаг. Хөөрхөн герман хүүхэн аймшиггүйгээр тэрхүү аймшигт хөгшин эрийн аминд халдаж цусыг нь урсгахад санамсаргүй тохиолдол л саад болсон мэт агаад цаашдаа иймэрхүү санамсаргүй явдлууд Дунай мөрөн хийгээд Босфорын хоолойн завсар нутаг дахь Аттилагийн эрх засагт ихээхэн чухал үүрэг гүйцэтгэх болно.

Аттилагийн өвийг залгамжилж түүний суурийг эзлэхийн төлөөх шийдвэрлэх тулалдаан нэгэн жижиг гол дээр болох бөгөөд энэ гол хаанаас эх авч хаашаа цутгадагийг өнөө хүртэл хэн ч хэлж мэдэхгүй. Байлдаан тулааны талаарх мэдээ баримт бүрхэг байдаг нь Аттилагийн залгамжлагчдын дотор гарч тухайн үеийн ажиглагчдын анхааралд өртсөн будлиан самуурлаас ч илүү хачирхалтай.

Иорданесын дутуу зэмдэг өгүүллээс эхлэх нь зүй. Хэдий дутуу гуцуу ч гэлээ энэ нь хамаг дүгнэлтийн гол цөм нь болох амой.

“Эдгээр үйл явдлын дараа мэдээж эрх засагт шунан тэмүүлэх халуун цустай идэр залуу хөвгүүдийн жишгээр Аттилаг залгамжлагчид ч засгийн эрхийг гартаа оруулж авахын төлөө тэмцэлдэж эхэлжээ. Тэд ноёрхож засаглахаас өөрийг өчүүхэн ч эрэгцүүлэн бодохгүй байсны учир эцэстээ эзэнт гүрнээ нураасан байна. Дэндүү олон өв залгамжлагчид их эзэнт гүрнүүдийг мөхөлд хүргэх нь байнга тохиолддог явдал бөлгөө. Эцэг Аттила нь янагийн явдал, шунал тачаалдаа жолоогүй хүн байсны учир өдий төдийгөөрөө мэндэлсэн хөвгүүд нь өөрийн ард түмнийг бүрдүүлж, бусад ястан үндэстнүүдийг шавга орхиж хоорондоо тэгш хувааж авъя хэмээн шаардаж, эрэлхэг баатарлаг хаадыг ч ард түмнийх нь хамтаар нь өөрийн гэр бүлийн өмч лугаа адил наймаалж байв.”

Гоот хүн Иорданес зориг баатарлаг хаад хэмээн ямар ч гэсэн баатар хэмээн нэрлэгдэх гавьяатай Маркианос, мөн эхийн гараас зүүгдэж дэлхийн түүхийн харгуйгаар шогшиж явсан Валентинианыг хэлээгүй нь ойлгомжтой. Харин Аттилагийн хараат албат гэхээсээ илүүтэй ард түмнүүдийн их нүүдлийн үед түүний анд, зөвлөх явсан, Аттилаг хорин жилийн өмнө дагаж захирагдсаныхаа төлөө хөвгүүдийнх нь албат болохыг хэрхэвч хүсээгүй Германы хаадыг хэлсэн нь лавтай.

Ийнхүү 451 оны ах дүүсээ хядсан дайн, Каталауны тал нутагт болсон их тулалдаанаас ихээхэн хохирол амсч хатуу ширүүн шалгуур туулсан остгоотууд эхлээд хүннү нараас салж явав. Дараа нь Ардарих Аттилагийн хөвгүүдэд захирагдахаас зайлж германчуудын талд орсноор даруй салан тусгаарлагчдын толгойлогч болжээ. Ийнхүү наян жилийн өмнөх түүх давтагдаж хүннү нар германчуудтай дайсан бололцож, Ардарих залуу насаа хэдийнээ ардаа орхисон, өөрөө Эрхманрихтай эн зэрэгцэхээр хүн байгаагүй хэдий ч босон тэмцэж ялжээ.

Хуучин холбоотнууд дайсан бололцож хоорондоо тэмцэлдэж буйд Константинополь мэдээж бах нь ханаж сэтгэл ихэд хангалуун байсан нь тодорхой. Иорданес энэхүү өрсөлдөөн тэмцлийн тухай “Толгойгүй болсон их биеийн мөчнүүд нэгдсэн удирдлагагүй болохоор өөр хоорондоо учир утгагүй тэмцэлдэх лугаа адил эрэлхэг баатарлаг үндэстнүүд өөртэйгөө эн зэрэгцэх хүчтэй дайсантай учрахгүй болохоороо бие биеийг ийн тасар татах ажгуу.” хэмээн дадал болсон сургамжилсан өнгөөрөө өгүүлсэн нь буй.

Өөрөөр хэлбэл Шалоны их тулалдаан Панноны бяцхан гол дээр давтагдсан ажгуу. Тухайн эрэн зууны хамгийн шилдэг дайчид болох германчууд болон хүннүчүүдийн хооронд хамгийн хатуу ширүүн тэмцэл өрнөсөн болой. Энэ нь ромчууд дэлхийн тавцнаас аль хэдийнээ буусан байсан цаг үе болой.

Аттилагийн хөвгүүд

Аттила

(395 онд мэндэлж
453 онд нас барсан)

Крека	Рекам	Ардари ханы дүү бүсгүй	Ильдико	Хонориа	Кримхильд
Эллак Дэнгизик 454 онд Недао-д Амиа алдсан	Эрнам Эмнезар 469 онд нас барсан	Үзэндүр	Гайзм*	Хаба	Алдариус

Мундо

533 оноос хойш
нас нөгчсөн
Византийн генерал,
Амбан захирагч

Домогт гардаг бусад үр
сад

Мауритиус

533 оноос хойш
нас барсан

*Зөвхөн Гайзмын эх л
баттай тогтоогдсон

“Уур хилэндээ шатаж илдээ чанга атгасан гоот, биеийг нь цоо хатгасан сумыг хуга татаж буй гэпид, явганаар байлдаж буй сюб, нумаа эвшээлгэн сумаа тавьж буй хүннү, хүнд зэвсэг бүхий дайчдынхаа эгнээг жигдрүүлж буй алан, хөнгөн зэвсэгтэй явган дайчдаа засч буй хэрүлчүүдийн эрэлхэг цогтой тулалдаж байгааг харахад гайхаж биширмээр ажгуу”.

Хүннүчүүдийн эрчимтэй ширүүн дайралт, гал цогтой уухай, харваачдын хэзээний давуу байдал нь гардан тулаан эхлэхээс өмнө тулалдааны хувь заяаг шийдэж ялалт байгуулах төлөвтэй байсан ч эцэстээ ээнэгшин дассан удирдагчдынхаа төлөө зүтгэх болсон германчуудын их тэсвэр хатуужил хийгээд суртахууны давуу тал дийлжээ. Гэпидүүд эхлэн хүннүчүүдийн эгнээ рүү шаантаглан орж сэт цохижээ. Энэ тулалдаанд Аттилагийн ахмад хөвгүүн, залгамжлагчаар товлогдсон хан хүү Эллак болон 40 000 хүннүчүүд амиа алдсан хэмээдэг бөгөөд Эллакийн амь насанд хэн ч санаа тавиагүй гэжээ.

“Эллак эрэлхэгээр тулалдаж алдар цуугаа дуурсгасаар амиа алдсан нь Аттила өөрөө ч атаархахаар үйл явдал” хэмээн Иорданес зэрлэг ард түмний заншлаар тулалдааны талбарт эрийн ёсоор амиа өргөөгүй Аттилаг дахиад л шүүмжилсэн бөлгөө. Аттилагийн бусад хөвгүүд зугтаж хүннүгийн ард түмний хамтаар зүүн өмнө зүгт одсон агаад Тисса, Дунайн үржил шимт тал нутаг германчуудын гарт оржээ. Ардари Аттилагийн орд өргөөг эзлэн суусан нь хэдийгээр хүннү нарт харамсалтай агаад хохиролтой хэрэг байсан ч Ардарикийн хувьд бараг л зүй ёсны гэхээр явдал байсан болой.

Энэхүү үнэхээр шийдвэрлэх асар их тулалдаан чухам хаана болсон нь түүхчдэд Каталауны тал нутгийн тулалдааны дараа бий болсон байдлаас илүү

сонирхогдохгүй байсан бололтой. Тулалдааны талбарыг Францад эрэх нь тэтгэврийн хурандаа нарын хувьд цаг нөгцөөхөөс өөргүй үйл хэмээгээд харин өөрсдөө тэрхүү Недад буюу Недао гэдэг жижиг гол чухам хаана урсдагийг ултай суурьтай судалж олон хуудас материал гаргасан судлаачид бий. Хүннүгийн судалгаанд юу ч гарч болохын жишээ энэ болой.

Бусдаас илүү боловсорсон ч аливаад эрүүл ухаан, егөөг хослуулж явдаг профессор Маенхен-Хэлфэний бүтээлээс дээрх авцалдаа муутай санаа бодлыг олж үзээд бараг л баярлах шиг болж түүний учир шалтгааныг хэрхэн тодорхойлсныг үзсэн юм. Мэдээж энэ нь түүний хувьд тун хүнд ажил байсан бөгөөд эхлээд Иорданес Паннон нутаг хаанаас хаа хүртэл үргэлжилдэг, хил хязгаар нь хаана байдгийг хэрхэн ойлгож (учир нь тэрхүү Недао гол нь чухамдаа Паннонд л урсдаг гэдгээс өөр юм бид мэдэхгүй) байсныг тодруулах шаардлага тулгарсан бололтой. Мөнхүү голын нэртэй нэгэн хот байсан мэт агаад уг хотын байрлалыг мөн тогтоох аргагүй байсан бөгөөд харин НАТО гэж дуулдахаар сонин нэртэй нэгэн хот Паннонд бус, Моези (*Гэрэг-Ромын үед Зүүн Өмнөд Европын эртний тракийчуудын нутаг байсан, Дунай мөрний доод биений өмнөд эрэгт баруунаас зүүн тийш хэдэн зуун километр газрыг эзэлж байжээ. Орч.*)-д оршиж байсан байдаг. Гол мөрөн ч нэрээ өөрчилж болох учир бид үүнийг гүнзгийрүүлж судлахгүй, судалсан зүйлээ ч нотолж чадахгүй.

Панноны гол гэж нарийвчилан үзвэл Дунай мөрөнд баруунаас цутгах голуудын нэг л байж таарах бөгөөд Таван сүмийн толгод (Өмнөд Мажаарын Пэч хотыг германаар ийн нэрлэнэ. Орч.) их тулалдаан хийхэд тохиромжгүй газар бол түүнээс умар тийш орших тавиу уужим талбар байлдаж тулалдахад зориулагдсан мэт. Хэрэвзээ голын Недао хэмээх нэр зөв бичигдэж үлдсэн бол Маенхен-Хэлфэн уг нэрийг кельт-иллирийн гарвалтай хэмээн тэмдэглэсэн нь зөв байж болно. Гэхдээ голын энэ нэр хадгалагдсаар ирсэн гэсэн үг биш. Хүннү гүрний төвд давшин хүрч хүннүчүүдийг зүүн өмнө зүг шахаж зайлуулах зорилго агуулсан арми Дунайд баруунаас цутган орох Капош гол, Драу гол (*Унгараар Драво, хорватаар Драва хэмээнэ. Италийн Өмнөд Тироль, Австрийн Дорнод Тироль, Кэрнтэн, Словен, Хорват, Унгарыг дамжин урсана. Дунайн нэгэн цутгалан. Орч.*), Дунай мөрний завсрын нутгийг бүхэлд нь туулах хэрэгтэй болно. Үүнийг баталж нотлох аргагүй ч Капош гол нь мөнөөх Недао байх бүрэн боломжтой. Ийм шийдэл байж болох магадлалтайг нотлох өөр нэг зүйл нь Капошварт хотын нэрэнд буй нэмэгдэл үе болох “вар” байж болно. Вар нь хүннү хэлний үг агаад бэхлэлт цайзыг хэлнэ. Капошвар нь өнөө ч энэхүү хүннү нэрээрээ тансаглан Капош гол дээр орших бэхлэлт бөгөөд түүнийг хүннүчүүдэд дуудахад эвгүй энэхүү иллир нэрийг хэзээ ч хэрэглэж заншаагүй байх магадлалтай.

Энэхүү газар зүй-стратегийн учир холбогдол бүхий санаа бодлын зэрэгцээ бас домог хуучийг ямар нэг байдлаар анхаарч харгалзах нь зүй. Нэг домог нь эртний Мажаарын хуучин домгийн маягаар уламжлагдан иржээ. Үүнд түүхэн хүмүүсийг туулийн хэлбэрээр нутгийн уламжлалтай холбон дүрсэлсэн нь буй. Бидэнд мэдэгдэж буй, түүхэнд тэмдэглэгдсэн германчуудын холбоо нь олон домогт гардаг Бернийн Дийтрих (Dietrich von Bern)-ийн удирдлага дор явж Аттилагийн хөвгүүдтэй бус, харин Аттилатай өөртэй нь тулалдсан тухай гардаг. Домогт мэдээж Аттила гол дүр болох нь тодорхой.

Энэхүү домогт мөнөөх Недао гол дээр болсон нууцлаг тулалдааны учир холбогдлыг тодруулахаар зарим тодорхой мэдээ буй. Дийтрих фон Бен их цэргээ Потентиана (*Фэрэнц Толди, Франц Толди, Гүстав Штайнакер нарын*

“Мажаарын шүлэг яруу найргийн ухааны түүх” хэмээх бүтээлд Мажаарын Тарнокийн хөндий дэх Потентиана хот хэмээн дурджээ. Орч.) хотын хэрмийн дор цуглуулан засч байх цагт хүннүүд Дунай мөрнийг үлээсэн тулмаар гатлаад германчуудын хоол хүнс тээсэн арын ангийг цахилгаан мэт хурдан дайрчээ. Үүнд шахамдаж цочирдсон Бернийн Дийтрих Штулвайссенбүргийн зүг зайлан одоод дараа нь Тарнок (Мажаарын Пештийн район дахь тосгон.Орч.)-ийн хавьд араас нь мөшгин ирсэн хүннү нарыг сөрөн байлджээ. Тулалдаан германчуудын ялалтаар өндөрлөхөд 125 000 хүннүүд тулалдааны талбарт алагдсан байв. Гэвч германчууд ч бас хүнд хохирол амссан байна. Өөр нэг нарийвч мэдээнд Хүннүгийн цэргийн жанжин Кэвэ дурдагдана. Тэрбээр тулалдааны талбарт амь үрэгдсэн бөгөөд тулалдааны дараа хүннү нар буцан ирж чулуугаар шарилын бунхан барьж оршуулснаар энэ газар хойшдоо Кэвэхаза (Кэвэгийн байшин) хэмээн нэрлэгдэх болжээ.

Тусгайлсан зураг дээрээс харахад Тарнок тосгон нь Будапештээс баруун өмнө зүгт 25 километр зайтай нэгэн жижиг гол дээр орших агаад тэрхүү голыг дээр дурдсан Недао гол байх хэмээн таамаглаж буй агаад энэ гол Дунай мөрний баруун цутгалан болой.

Тулалдаан болсон газраас илүүтэй чухал асуудал нь тулалдааны үр дүн агаад Каталауны талын тулалдаанаас ялгаатай нь хүннүүд ялагдал хүлээсэн нь тодорхой байдаг бөгөөд тэд бутцохигдсоноор барахгүй Аттилагийн ахмад хүү чухамхүү энд амь үрэгдсэн байна.

Энэ сүйрлийн дараа хүннүүдийн хувьд чухамдаа нөхцөл байдлаа ухамсарлаж эхлэх цаг ирсэн байна. Аттилагийн хөвгүүд хуралдай хийж зөвлөлдөөд ийм ноцтой хүнд үед хоорондоо эв найртай, нэгдэл нягтралтай байхаар тогтож андгай өргөсөн хэмээнэ. Гэхдээ энэ нь ер бусын үйл явдал байсан агаад хойшдоо уран зохиолын өвөрмөц сэдэв л болсноос хэтрээгүй бололтой. Хөвгүүд эхчүүдийнхээ нөлөөгөөр дахиад л өөр хоорондоо дайсагнаж, бүлэглэл үүсгэсэн ажгуу. Ер нь эхчүүдийнх нь нөлөө бүгдэд нь адилхан хамаарах эцгийн нийтлэг өвөөс илүү хүчтэй байжээ.

Хөвгүүдийн дунд хоёр бүлэг үүссэн нь харагддаг. Нэг бүлгийг нь Эллак Недао голын тулалдаанаар нэгэнт алагдсан болохоор Дэнгизик удирдсан ажээ. Тэрээр Эллакийг эс тооцвол хөвгүүдээс эцэгтэйгээ хамгийн адилхан нь байсан хэмээнэ. Нөгөө бүлгийг эцгийн хайртай хөвгүүн Эрнакийн удирдав. Түүний талаар Прискус тэмдэглэлдээ дурдсаныг бид мэднэ.Тэрээр өөрийн эх нэгтэй дүү нар болох Эмнезар, Үзэндүр хоёрыг талдаа татаж тайван амгалан сууж суурин амьдралд орохоор санал нэгджээ.

Дээрх зөвлөлдөөнд зохих үүрэг гүйцэтгэх учиртай өөр хоёр хөвгүүний талаар зөвхөн домог л өгүүлэх амой. Аттилагийн бүргүнд гэргий Криймхильдээс төрсөн Алдариус, Ромын эзэн хааны дүү бүсгүй Хонориагаас төрсөн Хаба хэмээх өөр хоёр хөвгүүн байсан тухай домог нэхэл хатуутай өгүүлэх ажгуу.

Зөвлөлгөөн яаж ч дууссан бай, ямар ч болов хөвгүүд амгалан сууж хамтаараа зэр зэвсгээ бэлтгэж байгаад 455 онд гэпидүүдийг бус, харин остгоотуудыг дайлаар морджээ. Тэд Ардарихийг (Гэпидийн эрэлхэг хаан) урван тэрслэгч юм уу, салан тусгаарлагч гэж үзээгүй, харин эцгийнх нь өвийг залгамжлахын төлөө зүй ёсны өрсөлдөгч гэж үзсэн байж болно. Ардарих мөн өөрийнхөө дүү бүсгүй, Аттила хоёрын дундаас төрсөн ач хөвгүүн Гайзмаар дамжиж Аттилатай ураг барилдсан, Хүннүгийн талийгаач хааны хадам ах

байсан болой. Жинхэнэ урван тэрслэгчид буюу хүннүүдийн өөрсдийнх нь нэрлэдэгээр оргодол боолууд нь остгоотууд байсан учир 455 оны довтолгоон чухамхүү тэдний эсрэг чиглэжээ.

Ромын манлай бэхлэлтүүдэд түгшүүр зарлаж сандарч мэгдэхэд хүннүүд энэ бол урван тэрсэлж оргож босогчдыг залхаан цээрлүүлэх л аян дайн хэмээн ромчуудыг тайвшруулжээ. Оргодол босуулын асуудал хүннүүдтэй ромчуудын явуулж ирсэн яриа хэлэлцээнд хэзээд чухал байр суурьтай байсан тул Ромын хилийн харуул хүннүүдийг нэвтрүүлж Дунайг гатлах боломж олгожээ. Дунайн өмнөд эрэгт хүннүүд цэргээ засч Саве (Сава), Драу (Драва) голуудын завсар ахуй остгоотуудын нутагт маш шаламгай дайран орсон учир хамгийн түрүүнд өртсөн Валамирт цэргээ даруй засч тосон байлдах цаг гарсангүй. Валамир ухрахаас өөр аргагүй болж замдаа цэрэг дайчдаа аажмаар татаж цуглуулж явахдаа өөрийн явган цэрэгт Хүннүгийн морин цэргийг эсэргүүцэн байлдахад ашигтай талбар хайж явжээ. Валамирийн байлдааны тактик нь Саве голын намаг бамбалзуур бүхүй ой шугуйд л хэрэг болох уран арга байв. Хүннүүдийн тулалдаанд зүдэрч туйлдсан морин цэрэг сандарч мэгдэн голын хөндийд байран дээрээ эргэлдэж ахуйд остгоотууд давшилтад орж жигд тайван эгнээгээр хөдөлгөөнгүй зогсох морьтнууд руу дайран ороход тэд бөөн бөөнөөрөө зугтжээ.

Остгоотуудыг он удаан жилээр удирдаж, Аттилагийн хүндлэл хүлээсэн зөвлөх Валамир ийнхүү түүний хөвгүүдэд хатуу сургамж өгөөд өөрийн ах дүүст нэрээ хугалахааргүй, хүч чадалтай хэвээр байгаа гэдгээ нотлон харуулжээ. Түүнийг хүннү нарыг ялсан сайхан мэдээтэй дүү Теодемир (*Теодемир нь Амалийн удмын хаан Эрманрихийн жич хүү Вандаларын отгон хөвгүүн агаад ах Валамир, Видэмирийн дараа Остгоотуудын хаан болсон. Орч.*)-ын өргөөлөн сууж асан Пелзод нуур (*Австри-Унгарын хилийн заагт Австрийн талд буй өнөөгийн Нойзийдлэр нуур болой. Орч.*)-т хүрэлцэн ирэх яг тэр мөчид нэгэн хөвгүүн ертөнцөд мэндэлж байжээ. Хөвгүүнийг Теодемирын хатан бус, харин татвар эм Эрелийва төрүүлсэн ажээ. Тэр нь сүүлд Их Теодорих хэмээх алдрыг олж хүннүгийн удмын Одоакерыг алж түүний дараа Ромд эзэрхэн засаглах хувьтай хөвгүүн байсан ажгуу.

Хүннүүдийн энэхүү хоёрдахь удаагийн ялагдал эцгийн өвийг эгүүлэн авах хөвгүүдийн найдлагыг бүрмөсөн булшилжээ. Энэ мөчөөс эхлэн зөвхөн амиа аргацаах хэрэгтэй болж хөвгүүд энэ асуудлыг хамсаж бус, хүн бүр өөрийнхөө болон дагуул хүмүүсийнхээ хувь заяаг толгой дааж шийдэх, шаардлагатай бол зохих гэрээ байгуулахаар тохирчээ.

Зан авираа дагаж амгалан тайван амьдрахыг илүүд үзсэн Эрнак болон түүний дүү нар Дорнод Ромын эзэнт гүрний өмгөөлөлд оржээ. Харин дайтаж тулалдахыг эрхэмлэгч тал болох эцэг нэг, эх өөртэй Дэнгизик Дунай мөрнөөс умар тийш орших нутаг хийгээд Бессарбийн мал сүрэг адуулах бэлчээр бүхүй тал нутагт дайнч нүүдэлчний амьдралаар амьдрахаар шийдсэн ажгуу. Энэ уудам тал нутаг Крым хүртэл үргэлжлэх агаад хүннү нар зуун жилийн өмнө чухамхүү эндээс өрнийг зорьсон бөлгөө.

Византи ч Эрнакийг тун найрсгаар хүлээж авчээ. Хүннүүд задарч бутарсан тухай мэдээг тэнд эмгэнэлт жүжгийн сүүлчийн үзэгдэл хэмээн ойлгон хүлээж авсан нь эргэлзээгүй. Ийн Византи амьсгаа авч Эрнакад удтал үймээн самууны хөлд дарагдаж бараг нэлэнхүйдээ хоосорсон Добружийн үржил шимт

нутгийг эзэмшил болгон өгчээ. Энэхүү Добружийн нутаг нь Дунай мөрөн, Хар тэнгисийн завсрын тал нутаг агаад умар хил нь Дунай мөрний бэлчир газар хүрнэ. Эрнак энэ нутгийг эзэмшихдээ хот суурин барьж газрыг эдэлгээнд оруулахаар зогсохгүй дайсан этгээдээс хамгаалах үүрэг хүлээжээ. Ийнхүү тэрээр өмнө нь зэрлэг ард түмний зарим ноёдын олж байсан “зочин хийгээд холбоотон”-ы статустай болсон бөгөөд үүнээс болж тэрээр хохирсон юмгүй.

Эрнакийн хамтаар аланууд бүгд бус, харин нэгэн томоохон овог нь Кандакс хэмээх ноёныхоо удирдлагаар Византийн талд орсон байна. Тэд Эрнакийн эзэмшилд очсон нутгийн баруун хязгаарт нь сууж түүний эрх засгийг Дунай мөрний Силистриа хавийн нутаг хүртэл тэлжээ. Дэнгизикийн захиргаанд аз нь харьсан хүннүчүүдийн үлдсэн хэсэг орж Хүннүгийн анх суурьшсан нутгийг тойрон хуучны цайз, өнөөгийн Булгаарын хилийн жижиг хот Никополь орчмын нутаг хүртэл нумран сууж байв.

Дорнод Ромын гүрний умард хязгаарын нутгийг эрх чөлөөтэй болоод үймээн самуун тарих нь их болсон гоотын овог аймгуудаас хамгаалахын тулд нухацтай колоничлох ажил дахин хийж эхэлжээ. Гэвч энэ нь хүннү тариачдын хэрээс хэтэрсэн ажил байсан бололтой. Остгоотууд 455 оны дайралтын хариуг авахаар 462 онд хүннүчүүдийн суурьшсан Дунай мөрний доод биений нутагт дайран ирэхэд Эрнакийн захиргаанд амгалан тайван амьдарч байсан хүннүчүүд болон Кандаксын захирч байсан аланууд дангаараа тэднийг дийлж бараагүй ажээ. Гэтэл Дэнгизик тэр даруй Бессарабаас довтолгон ирж олз омгоо аваад буцах гэж байсан гоотуудыг дайран орсон нь хэдий эх өөртэй ч ах дүүстээ үнэнч сэтгэлийн сайхан нотолгоо байсан ч ийнхүү хүннү нүүдэлчид хэрэг явдалд дахин татагдан орох болсны улмаас амгалан тайван байдлыг дахин сэргээхэд амаргүй байжээ.

Ийнхүү олон тоглогчид өөр хоорондоо тэмцэлдсэн дайн богино завсарлагаатайгаар үргэлжилж, өнөөгийн Румын-Булгаар-Югославын хил орчмын нутгийн байдал түгшүүртэй болсон учир эцэстээ эзэн хааны жанжнууд шийдвэртэй арга хэмжээ авч Визант тулалдааны талбарт гарахаар зүрхлэх болжээ. Энэ үед Эрнак ор сураггүй алга болж, харин Дэнгизик нь эмгэнэлт хувь заяатай баатар эр, Аттилагийн хөвгүүдээс байлдаан тулалдаанаа үргэлжлүүлсээр асан сүүлчийн ганц хүн, аймшиггүй дайчин, нугаршгүй тэмцэгч болж, дайн тулаангүйгээр амьдарч чадахгүй эрчүүд үнэхээр байсан бололтой хэмээн ажиглагчдыг таамаглахад хүргэсэн ажгуу. Дэнгизик энэ тухайд түүх туурвигсдын баталж байгаа шиг эцгийгээ үнэхээр дууриасан гэдэг нь үнэн гэж үзвэл харамсалтай нь тэрээр жанжин хүнд зайлшгүй хэрэгтэй бусад сайн чанаруудыг хамтад өвөлж аваагүй хүн байв. Дэнгизик 451 онд Орлеаны дэргэд их тулалдаанд ялагдаад байхдаа дайсны хурж бөөгнөрсөн цэргийн нүдэн дээр үлдсэн цэргээ цуглуулж юу ч болоогүй мэт тун ч ажиггүй тулалдааны талбарыг орхин явж товлосон газраа очиж байсан эцгийнхээ гайхамшигтай жишээг санахын оронд тулалдааны талбараас дайсныхаа албадлага шахалтаар арайхийн гардаг байсан нь Валамиртай хийсэн тулалдаанаас нь харагдана.

Дэнгизикийг намтрыг нь туурвигч дэврүүн сэтгэлт нэгэнд л гэхээс биш түүхчдэд бол бараг сонирхогдохгүй ялагдлууд нь түүнийг хүннү нарын эзэмшилд байсан Сердика (*өнөөгийн Булгаарын нийслэл Софи*) хотыг орхиход хүргэж, улмаар Балканы давчуу хөндийнүүдэд оруулан гарцгүй болгож, улмаар Жом Киппүрийн дайнаар (*Араб-Израилийн 1973 оны дөрөвдүгээр дайныг хэлж буй. Египет, Сири хоёр 1973 оны 10 сарын 6-нд жүүдүүдийн хамгийн том баяр Jom*

Кирриг-ийн баяраар Израильд гэнэтийн цохилт өгснөөр эхэлсэн дайн түүхэнд ийм нэрээр орсон. Израиль Сирийн армийг Голаны өндөрлөгөөс шахан гаргаад Египетийн армийн давшилтын шугамыг сэт цохин Сүэцийн сувгийг гаталж дайсны ард гарснаар Египетийн арми эх газраас таслагдаж хүнд байдалд оржээ. Орч.) Египетийн гуравдугаар арми дайсны идэш болсон лугаа адил нөхцөл байдалд оруулжээ. Энэ нь эцэстээ Дэнгизикийг зайлшгүй ялагдалд хүргэжээ. Бидний Анагастус хэмээх ром нэрээр нь мэдэх эзэн хааны гоот гарлын жанжин омголон догшин Дэнгизикийг оруулж авах урхийг онцын түвэггүйгээр бэлтгэжээ. Тагнаж турших, жигүүрээ бэхлэх зэргийг онцын тоодоггүй жанжин маань галзуу ширүүнээр дайрч мөнөөх урхинд оржээ.

“Chronikon Paschale” (Дорнод Ромын эзэнт гүрэнд нэр нь үл мэдэгдэх зохиогчийн гэрэг хэлээр зохиосон он дарааллын бичиг.Орч.)-д христийн тооллын 469 онд “Аттилагийн хөвгүүн ДинцирикүсТракийд байлдаж явсан эзэн хааны генерал Анагастуст алагдав. Тэрхүү хүннү хүний толгойг Константинопольд авчирч баярлаж хөөрсөн олон түмний жагсаалаар их гудамжаар авч явж үзүүлээд эцэст нь урт модонд өлгөж циркт (Константинополь хотноо цирк хэмээх олон нийтийн зугаа цэнгэл, уралдаан тэмцээн, найр наадам, хурал цуглаан хийдэг, ердийн циркийн дугуй барилгатай адилгүй, хоёр талдаа өндөр шулуун хана бүхүй аврага том байгууламж байсан. Орч.) тавив. Үүнийг үзэх гэж хотынхон тэр чигээрээ цирк рүү хуйларчээ” хэмээн тэмдэглэжээ.

Ийнхүү Хүннү гүрэн жижгэрч, задарч хуваагдах цагийг үзэж, дорно зүг рүү шахагдаж үндэслэн байгуулагч, аугаа удирдагч Аттилагаасаа бүтэн хагас арван жилээр илүү наслав. Харин хүннүчүүд цаашдаа ч байсан хэвээр тухайн үеийн соёлт ард түмнүүдийн хувьд аль хэдийнээ алдагдаж үгүй болсон цэрэг дайны өвөрмөц ур чадвар, эрч хүчийнхээ ачаар хэдэн зууныг туулжээ.

Хүннү гүрний тарж бутарсан ард түмэн энэ завсар мөнөөх хөлсний цэргийн албандаа эргэж оржээ. Тэд тариачин болж чадахгүй гэдгээ эелдэг зөөлөн Эрнакад батлан харуулж нэгэнтээ итгүүлсэн бөлгөө. Тэд дахин өөрийн төр улсыг байгуулж гоотууд, ромчуудаас хамгаалан авч явж чадахгүй гэдэг нь Эллак хийгээд Дэнгизикийн утгагүй тэмцлээс харагдсан ажгуу.

Ингээд тэд Аетиусын үед удтал мөрдөж ирсэн тэр л амьдралын хэв маягтаа буцаж оржээ. Тэд юу ч ухаарч, юу ч сураагүй өнөөгийн зарим хүн, зарим хүчнүүдийн нэгэн адилаар хэн хүний зараалаар энд тэнд байлдаж тулалдаж явжээ. Тэд ийнхүү зараалын морь шиг яв гэсэн газар явж, хүр гэсэн газар хүрч, улам цөөрч шингэрсээр, анжисны мөр гаргаагүй тэрхүү газар нутгаа цусаараа бордож тэндээ шингэж байв.

Хүннү гүрний элит хэсэг Европын өмнөдөд тарж бутарсан энэхүү нэргүй хүн сүргээс огт өөр хувь тавилантай учирч, Ромын гүрний сүүлчийн засагт үлгэрлэвээс үлбэгэрдүүхэн суффле (*Францаар Souffle буюу өндгөөр хийх хөнгөн хоол.Орч.)-г* амтлах хольц лугаа адил үүрэг гүйцэтгэж явжээ. Хэрцгий догшин авир, оргилсон эрч хүч, хатуу чанга зан чанараараа алдаршсан энэхүү зэрлэг ард түмнээс хамгийн ухаалаг төлөөлөгчид нь Дорнод Ромын эзэнт гүрний албанд элсч өндөр хэргэмтэн, жанжин, амбан захирагчийн зэрэгт хүрчээ. Босфорын дээрх их хотын “jeunesse doree” (*Франц хэлнээс үгчилж орчуулбал “алтан залуус” болой. Утга нь хаа газрын их хотын баян чинээлэг, найр наадамд дуртай, хөнгөмсөг залуучуудыг нийтэд нь нэрлэх оноосон нэр болжээ. Орч.)* хүннүчүүдийн заншлаар үсээ богинохон засч, Аттилагийн сайд

нарыг дууриан туник (*Эртний Ромд өмсч заншсан нэгэн зүйл цамц, тэгш өнцөгт хоёр хэсэг материалыг ар, өврөөс мөрөн дээрээ нийлүүлж бүч буюу горхиор тогтоож өмсөнө. Гар сул чөлөөтэй. Ромчууд мөрний хэсэг болон хоёр хажуугийн хэсгийг нийлүүлж оёсон туник өмсөх илүү дуртай байж. Гэрэгээр ийм цамцыг хитон хэмээдэг. Баяр ёслолын үед туник дээрээ “тога” хэмээх орхимж маягийн нөмрөг нөмрөх нь их байв. Орч.*), өмд юм уу банзалаар гоёдог болжээ. Энэ бол Константинополийн хүүхнүүд тайган хийгээд ижил хүйстэнтэйгээ явалдагчдын дунд байсаар байгаад уйдаж чихэр зажилж, амтлаг дарс шимсэн бүлэг хуурмаг лээзбийчүүд болж, хааны ордонд жинхэнэ эрчүүд орж ирээсэй хэмээн мөрөөддөг байсан цаг үе байлаа.

Византид ирж эрх ямбанд дассан хүннүүдийн дунд Аттилагийн нэг ач байсан ажээ. Аттилагийн хөвгүүд нийлж бараг нэг ард түмэн бүрдүүлсний учир үр ач нар нь ч бас нэгэн тивийн хүн амыг бүрдүүлж тархан нутаглах ёстой байсан юм. Гэвч Аттилагийн азгүй хөвгүүд айл болж өрхөө татаж галаа асаахын оронд эцгийн өвийн төлөө тэмцэлдэх нь илүү байсан болой. Гэтэл дээр дурдсан Аттилагийн тэр ач огт өөр хүн байжээ. Аттилагийн олон ач нараас энэ чухамхүү энэ ач хөвгүүнийг бид нэрээр нь мэдэх агаад хувь заяа нь хэрхэнийг ч олж мэднэ. Энэ бол Гэпидийн удмын (*Гэпидийн эрэлхэг хаан, Аттилагийн мэргэн зөвлөх Ардарихийн дүү бүсгүй, Аттила хоёрын дундаас гарсан нь түүхээр нотлогдсон Гайзмыг хэлж буй. Орч.*) Гайзмын хөвгүүн агаад тэрээр хаан өвөө, хатан эмээтэй, хоёр талаасаа хаан цустай, өвөг нь Ардарих хаан байсан бөлгөө. Түүний Мундо хэмээх нэр нь Аттилагийн эцэг Мүндзүхийн нэрнээс салаалжээ.

Аттила, Ардарихийн дүү бүсгүй хоёрын удам энэхүү Мундо нь Ардарихийг амьд сэрүүн ахуйд өөрийн овгийн хамтаар гэпидүүдийн дунд амьдарч жонон гэгдэж байгаад Тразерих Ардарихийн орыг залгаж гэпидүүдийг захирах болоход хуулиас гадуур хэмээгдэн хавчигдах болжээ. Ингээд Мундо оргон зугтаж дээрэмчин болж, оргодол босуул, тонуулч зэрэг болох бүтэхгүй хүмүүсийг цуглуулж олон газар довтолж, сүүлдээ бүр улс орнуудыг ч түйвээх болжээ. Ялагдаж дийлдэж эх оронгүй болсон овог аймгуудаас бүрэлдсэн скамарууд (*Уралын хүннүүдийн овог хэмээн тэмдэглэгджээ. Орч.*)-ын овог өөрсөдтэй нь адил болсон Мундог толгойлогчоороо сонгож, дээрэм тонуул нь дайн байлдаан болж өргөжиж, Аттилагийн ач хүү гэпидүүд, византичуудын аль алинтай байлдаж явжээ. Чингээд тэрбээр Балканд дэг журам тогтоохоор шийдсэн Их Теодорихийн талд цагаа олж оржээ. Ийн дээрэмчин Мундо өөрөө condottiere (хөлсний цэргийн жанжин), захирч явсан скамарүүд нь зэрлэг пандур цэрэг (*XVII зуунд Умард Балканы язгууртнууд эдлэн газар, эд хөрөнгөө хамгаалуулахаар гэрийн цэрэгтэй болж байсан нь харгис хэрцгий үйлээрээ нэрд гарсан пандурчүүд болно. Пандур гэдэг үг хаанаас гарсан нь тодорхойгүй. Эльзас, Бохэм, Силез, Баваарын хотуудын он дарааллын бичигт дурдагдан үлджээ. Орч.*) болж, Теодорихийг насан эцэслэсний дараа Аттилагийн ач Мундо Ромын эзэнт гүрний аугаа генералуудын нэг болно.

Хүннүгийн хааны ач хүү Теодорихийн охин Амаласунта эцгийн орыг залгамжлахад түүний албанд орно гэж хэн ч төсөөлж чадахгүй байсан биз. Адал зэхий явдлынх нь талаар Равенна болон Константинополийн дээдсийн хүрээнийхэн шивнэлдэж байсан эр Византид Юстинианы (*Дорнод Ромын эзэнт гүрний хаан, Гэрэг-Ромын хожмын үеийн хамгийн алдартай хаадын нэг. Орч.*) ордонд алба хаах болжээ. Өөрөө ч мөн генералаасаа дутуугүй алдар хүндтэй эзэн хаан Мундог хажуудаа авчээ. Хаан элдэв нууц явууллага, хуйвалдааны дунд Мундогийн хүч чадал, үнэнч зүтгэлийг мэдэрч өөртөө итгэлтэй явж, энэ хүн

цаг нь болохоор өөрийг нь аврана гэж таамаглаж байсан болов уу. 532 онд их бослого дэгдэж, шинэ хааныг ширээнд залж, Юстиниан хаан зугтахыг завдан ахуйд Белизар жанжин (*Дорнод Ромын генерал, Юстиниан хааны цэргийн жанжин.Орч.*) хаанд үнэнч явган цэргүүдийг, Мундо морин цэргийг тус тус удирдан үймээн самуунд автсан Константинополийг дайран эзэлж эзэн хааны орд өргөө, хаан ширээ, амь амьдралыг нь аварч байв.

Үймж самуурсан хүн амьтнаар дүүрсэн аврага том циркийн дундуур давхин өнгөрөх нь ганц илднээс өөр зэвсэггүй хүний хувьд үхлийн аюул дагуулсан үйл байсан бөгөөд зөвхөн хүннү хүн, тэр дундаа Аттилагийн удам л ийм үйлийг бүтээж чадах байсан нь магад. Мундо ийнхүү юунаас ч буцахгүй, аймшиггүй дайчин эр гэдгээ дахин харуулж шагналд нь Иллирийн нутгийг эзэмшин захирах болов. Үүнээс хойш тэрбээр өөрөө хүссэн, эс хүссэн ч Мундус хэмээгдэх болсон бөгөөд латинаар энэ нь (*Латинаар дэлхий, сансар гэсэн үг болно.Орч.*) түүний уугуул хүннү нэрнээс огт өөр утгатай үг бөлгөө.

Остгоотууд ийнхүү Аттилагийн ач хүүгийн захиргаанд орж, Аттилагийн хөвгүүдэд ихээхэн гай зовлон учруулсныхаа хариуд цусаа урсгах болов. Энэ үед залуу насаа хэдийнээ үдсэн Мундо остгоотуудаас өшөөгөө авахын тулд өөрөөсөө хамаарах бүхнийг хийж байжээ. Остгоотын чухал боомт хот Салонаг эзлэхийн тулд цус урсган тулалдаж байв. Мундо Далмацийг номхруулж, Салона (*Эртний Гэрэгийн хот, дараа нь Ромын эзэмшилд орсон, өнөөгийн Хорватын Сплит хотын ойролцоо орших хот болой.Орч.*) хотыг остгоотуудаас булааж аваад дайснаа дахин дахин дайран байлдаж байв. Мундо ганц хүүтэй, тэр нь христ мөргөлтөй, загалмай зүүхдээ Мауритиүс нэрийг авсан бололтой. Тэрхүү Маурициүс эцгээсээ ойртон ирж буй гоотын цэргийг ажиглаж байх даалгавар авчээ. Ажиглах шүү! Аттилагийн жич хүүг ийм тушаал барьж тогтоож чадна гэж үү?! Залуу хөвгүүн тэр даруй хуй салхи мэт дайрч дайсны жагсаалын төв рүү шааж орсонд гоотууд түүнийг бүслэн авч цавчин алжээ Мундо хүүгийнхээ үхсэн тухай мэдээ аваад өөрөө ч амьд явахыг үл хүсч, их өвөг Аттилагийн шазруун омголон авир зааж эзэн хааны генералын хуяг дуулга нөмрөг сэлтээ мулталж хаяад өөрийн бие хамгаалах цэргээ яаравчлан цуглуулж мориндоо алавхийн мордоод гоотуудыг дайлахаар явжээ. Ромчуудын жанжин энэхүү хүннү эрийн галзуу мэт дайралтад гоотууд тамирдаж туйлдаад зугтахад нэгэн гоот дайчин ухаан орж чухам хэнд ийнхүү дийлдсэнээ харвал Ромын цэргийн дээд командлагч, Иллирийн эзэн Мундус өөрөө байсан аж. Тэгэхээр нь мөнөөх гоот илдээ сугалан Мундо жанжныг нэвт сүлбэн алжээ. Ийнхүү Мундо үхлээ эрж яваад хүүгийнхээ амь үрэгдсэнээс хэдхэн хоногийн дараа түүнийгээ олсон ажгуу.

Үүгээр Аттила хаан ширээнд сууснаар эхэлсэн нэгэн зуун төгсгөлдөө хүрэв. Улиран өнгөрсөн тэр зуун бол хүннүчүүдийн зуун байв. Дараагийн зуун жилд ч хүннүчүүдийн нөлөө удтал хадгалагдсаар, зууны хөгжлийг удтал тодорхойлсоор байсан юм. Тэд сүм дуган, орд харш бариагүй, харин өдий төдийг эвдлэн нураасан нь маргашгүй үнэн болой. Тэд бидэнд хууль цаазын бичиг үлдээгээгүй, үлдээсэн цор ганц дуу нь эмгэнэл гашуудлын дуу гэдэг нь мөн үнэн. Гэвч ширүүн аадар бороо их хохирол учруулдаг ч агаарыг ариусгаж газар дэлхийг цэвэрлэдгийн адилаар хүннүчүүдийн аянга цахилгаан дагуулсан хүчит шуурга Европыг хаман авч ялзарч хөгцөрсөн, өмхөрч муудсан, “гаднаа гяланцаг, дотроо паланцаг” болгоныг хийсгэн зайлуулсан болой. Удтал амь нь давчдаж байсан ромчуудын эзэнт гүрний мөхөх цаг хугацааг ойртуулсан хүч нь германы ард түмнүүд бус, харин хүннүчүүд бөгөөд тэд л Ромын амь тавих

мөчийг ойртуулж мөхлийг дуудсан болой. Хуучны Газар дундын тэнгисийн ард түмнүүдийн тэнхээ тамиргүй болж арга ядсан байдал хүннүчүүдийн амьдрал тэмцлийн өнгөн дээр тод томруун харагдсан юм. Хүннүчүүд өөрсдөө эвдлэн бусниулагч хүч байсан нь эргэлзээгүй, тэд шинэ юм авчраагүй, авчирч чадах ч үгүй байсан. Гэхдээ тэд эртний соёлын өлгийн нутагт бүтээлч хүч, эрч далайц хүч түрэн орж ирэхийн сэтгэл догдлуулам жишээг үзүүлсэн болно. Германчууд ромчуудтай урт удаан хугацаанд шүргэлцэн оршиж, дахин дахин харгалдаж байсан хэдий ч ийм жишээ үзүүлж чадаагүй нь сонин, дараа нь удалгүй германчуудын хамгийн хүч нөлөөтэй овог аймгууд хүннүчүүдийг дагаж захирагдсан юм. Германчуудыг захирсан хүннүчүүдийн ноёрхол Эрманрихийн үед эхэлж зуун жилийн хойно Недаогийн тулалдаанаар дуусгавар болсон. Ийн хүннүчүүдийн захиргаа удтал үргэлжилж зуун жилийг элээсэн нь мэдээж тохиолдлын хэрэг бус, энэ бол гарцаагүй түүхэн шаардлага байсан бөлгөө.

Харин Аттила насан эцэслэж, түүний хөвгүүд үхэж үрэгдсэний дараа бүх юм өөрчлөгдөнө. Уулаасаа суурьшмал сууж асан германчууд хүннүчүүдийн талд байнга олз омогт шунаж үймж самуурч явсны эцэст эргээд хуучны дасал болсон амьдралдаа оржээ. Тэд германы ард түмнүүдээс үндэстнүүд бүрдэж, зохион байгуулалтын илүү өндөр хэлбэрийг бий болгосон юм. Харин хүннүчүүдийн өвөрмөц хүч, нэгэн их ард түмний үйл явдлаар баян, догшин ширүүн амьдрал эмх замбараагүй, засаг захиргаагүй хэвээр байсаар төр улс бий болоход хүргэсэнгүй. Хагас мянган жилийн дараа мажаарууд хүннүчүүдийн нэрийг барьж, домог туульдаа Аттилаг өөрийн гэмгүй номхон хаадын дээд өвөг хэмээн тунхагласан нь Европын улс түмний гэр бүлд ганцаардмал харь мажааруудад бага ч болов жин нэмэхээс хэтрэхгүй, өршөөж болох оролдлого хэмээн үзүүштэй. Мөн Хүннүгийн хаадын байлдан дагуулах эрмэлзэл тэмүүлэл, ноёрхож засаглах хүсэл мөрөөдөл Булгаарын зарим нэг хаад ноёдод уламжлагдаж, тэд хагас зэрлэг гүрнийхээ хил хязгаараас хальж Европын бусад газар оронд халдах санаархал агуулсаар байсан болой. Аттилагаас хойш бүтэн хагас мянган жил өнгөрөвч Европ нэгэн бүхэл цул болохгүй, Европ нэгэн гарын дор нэгдэхгүй. Энэ үйлийг бүтээхийг оролдож зүрхлээд Хүннүгийн хааны адилаар мөн л дөхүүлээд буцсан корсик хүн (Наполеон) өөрийг нь Аттилатай харьцуулахад баярлахгүй байх байсан нь мэдээж. Харин өөрийгөө Александр, Цезарь, Их Фридрихтэй зэрэгцүүлэхэд дуртай байх байсан болов уу. Аттилагийн шарил дээр бунхан цогцлоогүй, цогчин дуган баригдахгүй байсан нь тодорхой. Тэрбээр Паннонийн газар шороонд ор мөргүй шингэн алга болж, Шампаан нутаг, По гол, Райн, Дунай мөрөнд тулалдаж явсан түүний ард түмэн ч мартагдан зөвхөн илд жад, сэлэм чинжаалдаа эргэн төрөх ажгуу.

2011 оны 4 сарын 12-ны билэгт сайн өдөр орчуулж дуусгав.
Улаанбаатар

□□□□□□ □□□□□□ □□ □□□□□□

Абакан

Адриатын тэнгис

Аелиус Галлус (Ромын генерал)

Аетиус, Флавиус (Өрнөд Ромын цэргийн жанжин, төрийн зүтгэлтэн, Христийн тооллын 390 онд төрсөн)

Афганистан

Агамемнон

Агни (Энэтхэг-Арийн галын бурхан)

Египет

Ахура Mazda (Эртний Персийн бурхан)

Аикс (Христийн тооллоос өмнөх 102 онд их тулалдаан болсон газар)
Акатцирууд (Хүннүчүүдийн байлдан дагуулсан Хар тэнгис орчмын овог аймаг)
Алаг хөл нуур
Аланууд (Кавказын уулсын умар этгээдэд нутаглаж асан иран гарлын морьтон ард түмэн, хүннүчүүд алануудыг байлдан дагуулсан, сүүлд вестгоотуудын холбоотон болж хүннү нартай Каталауны талд тулалдсан)
Аларих (Христийн тооллын 410 он хүртэл Вестгоотын хаан байв)
Алдариус (Алдриан, Аттила, Криймхильд хоёрын хүү хэмээн домог өгүүлнэ)
Алеманнууд (Өрнөд герман овог аймаг)
Их Александр
Александриа
Алма Ата
Альпийн уулс, Альпийн хормой нутаг
Алпин, Шалон-сүр-Марн хотын хамба
Альт (жижиг гол)
Эртний Булгаар
Альтхайм, Франц
Альтино (Альтинум)
Альтлуссхайм/Райн, Хүннүчүүдийн булш олдсон газар
Альт-Ваймар (Өнөөгийн Старая Иванцовка)
Амаласунта (Их Теодерихийн охин, хаангы нас нөгчсөний дараа улсыг захирч байв)
Амальчууд (сүүлд амелунгууд, Гоотын хааны овог)
Миланы Амброзиус хамба
Аммианус Марчеллинуc (Антиохи хотын гэрэг хүн, Ромын түүх туурвигч)
Аммиус (Сунильдагийн ах)
Анагастус (Дорнод Ромын гоот гарлын жанжин)
Анатолиос (Хүннүгийн хааны ордонд сууж байсан Византийн элч)
Андагис (Остгоотын ноён)
Андернах
Андреас III (Мажаарын хаан)
Анианус, Орлеаны хамба лам
Антиохиа
Апуль (Зүүн Өмнөд Италийн түүхт нутаг)
Акуаеэ Флавиае
Акуае Секстиае (Аикс)

Акуилеа
Акуинкум –Хуучин Буда (Будапешт)
Акуитан (Пиреней, Гароны завсрын нутаг, Ромын үед Луар хүрч тогтсон байв)
Араб
Арал нуур
Араватиус, Тонгерны хамба лам
Аркандианаполис
Ардарих (Гэпидүүдийн хаан, Аттилагийн анд, түүний зөвлөх)
Аргоннерын ой
Аркад нутаг (Гэрэгийн Пеллепоннес дахь уулсын орон)
Арль
Ла Маншийн хоолой
Арминиус (Хэрүскийн ноён)
Эльба мөрний Арнебүрг цайз
Арнегисклус (Дорнод Ромын цэргийн жанжин)
Арпад (Мажаарын хаан)
Артаксата
Артемис (Гэрэгийн бурхан)
Асдингер (Вандалуудын хаадын удам)
Азимус
Аспар (Дорнод Ромын цэргийн жанжин)
Астрахань
Атакам (Хүннүгийн ноён)
Афин
Этиоп
Аттила, Хүннүчүүдийн хаан (395 онд төрж 453 онд нас барсан, 434-445 онд ах Бледагийн хамтаар төр барьж байсан, дараа нь дангаар хаанчилж байв)
Оове (жижиг гол)
Аугсбүрг (Аугуста Винделикорум)
Аугустинус, Аурелиус (Хиппо Региүсийн хамба, сүм хийдийн багш)
Аушвиц
Оверн (Дундад Францын түүхт нутаг)
Авиенус, Рүфүс Фестүс (Консул)
Аварууд (Азийн нүүдэлчин ард түмэн)
Ацтекууд (Мексикийн индианчуудын овог)
Бабенбергийнхан (Австрийн (Остмарк) маркграф)

Байгаль нуур

Бактри орон (Гэрэгүүдийн гүрэн)

Баламбер (Түүхэнд тэмдэглэгдсэн (Европын) Хүннүгийн анхны хаан)

Балкан

Балхаш нуур

Балог, Ференц

Балти орчмын нутаг

Башкирууд (нутаг) (Уралын нурууны өмнө этгээдэд оршино)

Базель, Базелийн хаалга

Бэк, Ханс

Бээн, Фридрих

Бельги улс

Бельгичүүд (Францын баруун хойд нутагт сууж байсан ард түмэн)

Белизар (Дорнод Ромын цэргийн жанжин, Аттилагийн хөвгүүн Гайзмын хүү

Мундо Дорнод Ромын албанд орж Юстиниан хаанд зүтгэж явахдаа түүнтэй мөр зэрэгцэн байлдаж явсан, дараа нь түүнийг залгамжилсан)

Бэлзэн

Бэрбэрүүд

Бергамо

Берихо (Хүннүгийн язгууртан)

Бэрндт, Хельмүт

Бэрнис, гүн

Бернштам, А.Н.

Бэрвик, херцог

Безаньсон

Бессараб нутаг (Днестр, Прут, Дунай мөрөн, Хар тэнгисийн завсрын нутаг)

Бингэн

Бледа (Аттилагийн ах, 434-445 онд түүнтэй хамт Хүннүгийг төрийг барьж байгаад Аттилад алагдсан)

Боедел, Блоеделин (Бледагийн германы домог, туульд орсон нэрс)

Боббио

Буатель, Аббе

Бонифациус (Африкт байлдаж явсан Ромын генерал)

Борнхолм (Балтийн тэнгисийн арал)

Бурбоныхон (Францын удам дамжсан хаад)

Буржуа Тиерри (Шампаны франц айл)

Марк Бранденбург, Хилийн муж (засаг захиргааны нэгж)
Брэхт, Бэрт
Брэннэр
Бреслау
Бретон (Францын баруун хойд нутаг, хойг)
Британи, Британы арлууд
Брүлли
Бролиум (Өнөөгийн Сэн Мэсман, Сэн Мэман)
Брүктэрчүүд (Райн мөрний франкуудын хошуучлагч овог аймаг)
Брунехаут (Меровингийн хатан хаан)
Брүнхильд (Нибэлүнгийн дууллын баатар)
Бүхнэр, Рудольф
Будапешт
Бурбиста (Дачи гүрний хаан)
Бүргүндчүүд (Уг нь Скандинавын Борнхолм арлаас гарсан, Висла, Одер мөрөнд сууж байгаад Галли руу нүүж, тэндээсээ Майн мөрөнд суурьшсан дорнод герман ард түмэн)
Бөри, Ж.Б.
Каллиникус (Он дарааллын түүх туурвигч, Үтүс гол дээр болсон тулалдааны тухай өгүүлсэн)
Каллиникум
Калоприни (Хуучны Венецийн гэр бүл)
Кэмп д'Аттила, Аттилагийн хүрээ (Мауриакус)
Камп-де-Малли
Кандакс (Алануудын ноён)
Кандидус (Тебагийн христ шашинт цэргийн ангийн захирагч)
Каорле (Аквае Капрулае)
Капелле, Вилхэльм
Каракалла (Маркус Аурелиус Антониус нэрээр христийн тооллын 211-217 онд төр барьж байсан Ромын эзэн хаан)
Карпилио (Аетиусын хүү)
Цезарь, Гайус Юлиус (Ромын цэргийн жанжин, төрийн зүтгэлтэн)
Цезареа
Кассиодор (Өрнөд Ромын элчингээр Хүннүгийн хааны дэргэд сууж байжээ)
Кассиодор, Флавиус Магнус Аурелиус (Элчин Кассиодорын хөвгүүн, Их Теодерих хааны нууцын нарийн бичгийн дарга, канцлер явсан)

Шалон-сүр-Марн
Шампан (Францын түүхт нутаг)
Харатон (Хүннүчүүдийн хаан)
Шарро, Роберт
Шеман-де-Дам
Херсонес (Дарданеллийн хоолойгоос хойш орших хагас арал Галлиполь)
Хятад (хятадууд) ба хүннүчүүд
Хятадын тэнгис
Хильдэрих (Меровингчуудын хаан)
Чиожжиа
Хлогио (Салийн франкуудын хаан, христийн тооллын 448 онд нас барсан)
Хорассан (Зүүн хойд Ираны тал нутаг)
I Хосроес Анушарван (Персийн хаан)
Шилли
Хрущев, Никита
Хрисафиос, тайган
Чөрчилль, Уинстон
Цицеро(н), Маркус Туллиус (Ромын төрийн зүтгэлтэн, алдарт уран илтгэгч)
Клермон-Ферранд (Аверны хамбын өргөөлөх газар)
Кобенцль, барон
Конкардиа
Конну, Др.
Константиус (Өрнөд Ромын цэргийн жанжин, 417 онд Галла Плачидиатай сууж
Өрнөд Ромыг 421 оноос хамтран захирах болсон)
Контарини (Хуучны Венецийн гэр бүл)
Корди, Шарлотте
Кортес, Хернандо
Куртисоль (Хүннүчүүдээс үлдэж хоцорсон дайчдын Францад суурьшсан тосгон)
Кот Шампенуас (Реймс, Сезанний завсар оршино)
Криз, Е.
Кремон
Кромвель, Оливер
Күперли
Их Сирус II (Персийн хаан)
I Дагоберт (Меровингийн хаан)
Даки, Дачи (өнөөгийн Румын)

Далмац (Адриатын тэнгисийн эрэг, Динарын Альпийн нутаг)
Дамаскиос (Хожмын Гэрэгийн философич)
Дамьен (Франц алуурчин)
Дандоло, Энрико
Данкварт (Нибэлүнгийн дууллын баатар)
Их Дариус I (Эртний Персийн их хаан)
Давид
Дэнгизик (Аттилагийн хөвгүүн)
Девинь, Женевьев
Дексиппос (Гэрэгийн түүхч)
Бернийн Дийтрих (Остгоотын хаан Их Теодерих, германы баатарлаг тууль, эртний мажаар туульд энэ нэрээр гарна)
Диоклетан, Гайус Аурелиус Валериус (Христийн тооллын 284-305 онд Ромын эзэн хаан байв)
Дионисиос (Дорнод Ромын албанд зүтгэж явсан хүннү хүн)
Днепр мөрөн
Днестр мөрөн
Добружа (Дунай мөрөн, Хар тэнгисийн завсрын тал нутаг)
Донатус (Хүннүчүүдийн хаан)
Дунай мөрөн
Дунайвөрт хот
Донец (Танаис)
Драу гол
Дрекон (Унгарын нам дор газраар урсах гол)
Чингис хаан (Монголчуудын дэлхийн эзэнт гүрнийг үндэслэгч, христийн тооллын 1227 онд нас барсан)
Зүүн гар (Хятадын баруун хойд нутаг), Зүүн гарын хаалга
Эвийн нуур
Эдекон (Хүннүгийн ноён, Византид элчээр явж байсан, Аттилагийн зөвлөх, скирүүдийг удирдаж хүннүчүүдийн олон тулалдаанд оролцож явсан)
Эфел
Эйтилль (Аттилагийн хүү гэж домог өгүүлнэ)
Эллак (Аттилагийн хөвгүүн, сүүлд германчуудтай хийсэн тулалдаанд амиа алдсан, домог хуучид нэрээ үлдээсэн хүн)
Эмнезар (Аттилагийн хөвгүүн)
Энгельс, Фрийдрих

Эпигэнэс (Дорнод Ромоос Аттилад илгээсэн элч, гэрэг хүн)
Эпирүс (Гэрэгийн нутаг)
Эрелива (Теодемирийн татвар эм, Их Теодерихийн эх)
Эрка (Хэльхе, Херкиа ч гэх, янз бүрийн тууль домогт Аттилагийн эхнэр гэж гардаг)
Эрманрих (Остгоотын хаан, Христийн тооллын 375 онд хүннүчүүдэд ялагдсан, баатарлаг туулиудад Дийтрих фон Бернийн эсрэг этгээд гэж гарна)
Эрнак (Аттилагийн хамгийн хайртай хөвгүүн, хүннүчүүдийн нэг хэсгийг авч Дорнод Ромд дагаар ороод Добруж орчмын нутгийг захиран суух болсон)
Эскам (Хүннү санваартан)
Эсла (Ругилагийн элчээр Дорнод Ромд очиж хэлэлцээ явуулж байсан хүн)
Евдокиа (хатан хаан, II Теодосиусын хатан)
Эжени (III Наполеоны хатан)
Евгениүс (Равенна дахь Ромын хааны ордны түшмэл)
Евфрат мөрөн
Ойрих (Германчуудын хаан)
Ойсибиус, Цезареа хотын хамба
Ойстохиум (Паулагийн охин)
Этропиа (Хамба Нисэйсийн дагуул бүсгүй)
Эвэрс, Ханнс Хайнц
Эксүпериүс (Тебагийн христ шашинт цэргийн ангийн захирагч)
Фаззулае (Физоль), Христийн тооллын 401 онд тулалдаан болсон газар
Фан Куай (Хатан хаан Као-Люгийн үеийн цэргийн жанжин)
Фастида (Гэпидийн ноён)
II Фердинанд, Арагоны хаан
Ферганы хөндий
Фернпас (Альпийн даваа)
Филимэр, (Гоотын хаан)
Филип (зохиогч)
Финнийн булан, Финланд
Флери
Франкууд, (Вэзэр-Райн-Германы бүлгийн герман овог аймаг)
Франке/Трауцеттель, зохиогчид
Франц улс
Фредегар (Бүргүндийн санваартан)
Фриаул (Зүүн хойд Италийн нутаг)

Их Фридрих

Бабенбергийн дайчин хочит Фридрих

Фюнфкирхэн (Германаар Таван сүм, өнөөгийн Унагарын Пэч хот)

Галла Плачидиа (Ромын эзэн хаан I Теодосиусын охин, эзэн хаан Хонориусын эгч, нууц амраг, 414 онд Вестгоотын хаан Атаулф, 414 онд цэргийн жанжин Константиустай тус тус ханилж явсан, Константиустай хамтран төр барьж байсан, мөн хүү III Валентинианыхаа өмнөөс засаглаж байв. Христийн тооллын 450 онд нас баржээ)

Галлиани, Аббе

Галли орон (Үндсэндээ өнөөгийн Франц, Бельги, далайн Альпийн нутгийг эзлэн оршиж байсан)

Ганга мөрөн

Гарда, Гарда нуур

Гаудентиус (Аетиусын эцэг)

Гаут (Амальчуудын удмын гоотуудын хаан)

Готье, Е.Ф.

Геер (жижиг гол)

Гайзерих (Годегизелийн хөвгүүн,Христийн тоолын 428-478 онд вандалуудын хаан, Испниас Умард Африк хүрч Хиппо Региүс, Карфагенийг эзлэн авч, Аттилатай нөхөрлөж холбоотон болж явав)

Женев, Женевийн нуур

Гэгээн Женофева (Парис хотын ивээн тэтгэгч)

Генуя (Генова)

Гэпидүүд (Дорнод герман ард түмэн, Иорданесын тэмдэглэснээр гоотуудын хамтаар Скандинаваас нүүж гарч яваад Хүннүгийн захиргаанд орсон,, Ардарихийн удирдлагаар хүннүгийн захиргаанаас гарсан, христийн тооллын 566 онд аварчуудад ялагдаж мөхсөн)

Германчууд (Олон овог аймаг, ард түмний нийтлэг нэр)

Гфрөрэр, Аугуст Фридрих

Гайзм (Аттила, Ардарихийн дүү бүсгүй хоёрын дундаас гарсан хөвгүүн)

Гиббон, Эдуард

Гоар (Алануудын ноён)

Гоаци (Түмэн шаньюйгийн үеийн нүүдэлчин овог аймаг)

Говь (Төв Азийн хагас цөл газар)

Годегизель (Христийн тооллын 406 он хүртэл вандалуудын хаан байв)

Гордон, Г.Д.

Гоотууд (Дорнод германчуудын гол ард түмэн, Скандинаваас гараад Висла мөрний доод биенд буусны дараа бүрэлдсэн, Христийн тооллын 150 оны үед гэрэг, Тракий, Бага Азид довтолж, Ромын Дачи мужийг эзлэн авч байв. Дараа нь остгоот, вестгоот болж хуваагджээ)

Готелинде, хатан (Нибэлүнгийн дуулалд гарна)

Граккен (Граккус, Эртний Ромд сууж байсан семпрончуудын суман ардаас үүссэн язгууртан овгийн хоч нэр)

Градо

Гран гол (Дунай мөрний цутгалан)

Гранзони (Эртний Венецийн гэр бүл)

Грегор (Георгиус Флорентинус), Түүрс хотын хамба

Гэрэг, гэрэгүүд

Гроот, Ж.Ж. де

Грүссэ, Рэнэ

Гинард, М.

Гундарих (Христийн тооллын 406-428 онд вандалуудын хаан байв)

Гундебауд (Рипуарын франкуудын ноён)

Гундикариус (Гундакар, Гунтиариус, бүргүндчүүдийн хаан)

Гүнтэр (Нибэлүнгийн дуулалд)

Густав Адольф, Шведийн хаан

Хадрамаут (Өмнөд Аравийн нутаг)

Хадриан, Публиус Аелиус (Христийн тооллын 117-138 онд Ромын хаан байв)

Троньегийн Хаген (Нибэлүнгийн дуулалд гарна)

Хамбис, Луй

Ханнибал (Нэн эртний хамгийн алдарт жанжнуудын нэг)

Хан гүрний хаад (Хятадын хаадын удам)

Герман үндэстний Ариун Ромын эзэнт гүрэн

IV Хайнрих, Францын хаан

Хелена (Гэрэгийн домгийн дүр)

Эфталитууд буюу цагаан хүннү нар (Хүннүчүүдийн нэг салаа, Персийг эрхшээн сууж байв)

Хераклеа

Херкулес Бассус (Хонориа гүнжийн эр нөхөр)

Херодот (Гэрэгийн түүх бичлэгийг үндэслэгч)

Хэрүлчүүд (Умард Европоос гаралтай герман ард түмэн)

Хэтитүүд (Бага Азийн дорно этгээдэд сууж байсан энэтхэг-герман гарлын ард түмэн)

Хиа (Хятадын удам дамжсан гүрэн)

Хиао Хуй (Као-Лю хатан хааны хөвгүүн)

Хиао-Вэн (Хятадын эзэн хаан)

Хиеронимус (Латин сүм хийдийн багш)

Хиппо Региүс

Хисарна (Амальчуудын удмын гоотын хаан буюу захирагч)

Хирт, Фрийдрих

Хитлэр, Адольф

Хиюнг-нү, Сиюнг-нү, Хүнг-но, Хү буюу Хү-гийн зэрлэгүүд (Христээс өмнөх үеийн Азийн ард түмэн)

Холопернес (Хуучин гэрээст тэмдэглэгдсэн цэргийн жанжин)

Хомер (Гэрэгийн яруу найрагч)

Хомайер, Хелене

Хонориа, Юста Грата (Галла Плачидиа, Константиус хоёрын охин)

Хонориус (Христийн тооллын 395-423 онд Өрнөд Ромын эзэн хаан байв)

Хюго, Виктор

Хүлмүл (Амаьлчуудын удмын гоотын хаан буюу захирагч)

Хүнүмүнд (Хүннүгийн Баламбер хаан болон германчуудын хаан Эрманрихийн ач охин хоёрын хөвгүүн)

Хүннүчүүд

Хидатиус, Акуае Флавиаегийн хамба

Ихизэ (Христийн тооллын өмнөх 127 оны орчим Хүннүгийн хаан байв)

Ильдико (Хильдико, Криймхильд?, Аттилагийн сүүлчийн эхнэр)

Иль де ла Сит (Сена мөрний арал, Парисын хуучин төв)

Или нутаг, Или гол

Иллир (Адриатын тэнгисийн зүүн эргийн дагуу Эпирүс хүрсэн нутаг)

Энэтхэг

Индра (Энэтхэгийн бурхан)

Инд мөрөн

Иран

Ирланд

Эрчис, Хар Эрчис

I Изабелла (Кастилийн католик)

Севильягийн Исидор, их хамба

Исланд

Истер (Дунай мөрний эртний нэр)

Истер нутаг (Триестийн булан болон Куарнерогийн тохойн завсрын нутаг)

Итали

Юлиа Традукта (өнөө Тарифа)

Иерусалем

Иоханнес (Христийн тооллын 423-425 онд Өрнөд Ромын эзэн хаан байв)

Иордан гол

Иорданес (Иорданис, Иорнандес ч гэх, гоотуудын он дарааллын түүхийг туурвигч)

Юдас Маккабеус (Жүүдийн цэргийн жанжин)

Юдит (Хуучин гэрээсийн дүр)

Юлийн Альп

Юпитер (Ромын бурхдын ертөнцийн эзэн)

I Юстиниан (Христийн тооллын 527-565 онд Дорнод Ромын эзэн хаан байв)

Кайзераугст

Калабр (Өмнөд Италийн түүхт нутаг)

Калган, Хаалган

Као (Хятадын Хан гүрний хаан)

Као-Лю (Хятадын хатан хаан)

Капош (Дунайд цутгах гол), Капошвар (Бэхлэлт)

Их Карл

Карл Мартель (Франкийн төрийн зүтгэлтэн)

V Карл (Герман үндэстний Ромын эзэнт гүрний хаан)

XII Карл, Шведийн хаан

Кэрнтэн

Карпат

Картаго, Карфаген

Казахстан

Каспийн тэнгис

Каталауны тал нутаг (Шампаны Шалон-сүр-Марн орчмын тал нутаг, шийдвэрлэх тулалдааны талбар)

Кауфманн, Георг

Кавказ

Керчь, хуурай газрын хүзүүвч

Кэвэ (Хүннүгийн цэргийн жанжин, эртний Мажаарын домогт гарна)

Хаба (Аттила, Хонориа хоёрын хөвгүүн гэж домог өгүүлнэ)
Күнз (Хятадын философич, шашин үндэслэгч)
Хайберын даваа
Кие (Хятадын эзэн хаан)
Ки Пү (Хатан хаан Као-Люгийн үеийн хэргэмтэн)
Бага Ази
Клеопатра (Мисирийн хатан хаан, Цезарийн амраг)
Клүгэ, Фрийдрих
Кобленц
Хаадын удмын хүннүчүүд, хүннүгийн ноёрхогч овог
I Константин (Константинус Порфирогенетос, Христийн тооллын 912-959 онд
Дорнод Ромын эзэн хаан байв)
Константиус (Аттилагийн нарийн бичгийн дарга)
Солонгос
Коринт
Краков
Крека (Аттилагийн эхнэр)
Кречмайер, Хайнрих
Криймхильд (Нибэлүнгийн дууллын гол баатар), мөн Гизела (Аттилагийн тухай
мажаарын домогт)
Крым (Хар тэнгисийн умард эргийн хагас арал)
Кубань
Хубилай хаан (Чингис хааны ач, 1259-1294 онд монголчуудын эзэн хаан байв)
Кызыл
Ла Шепп, Мауриакус
Ла Кот-Роберт
Лакедаимончууд (Гэрэгийн овог)
Лампертхайм (Хуучин Райн орчмын хот), бүргүндчүүдийн эд өлгийн зүйлс
олдсон газар
Лангобардууд (Герман ард түмэн, Скандинаваас гаралтай хэмээн өөрсдийнх нь
домог өгүүлнэ)
Лонгре
Лаон
Лао-Шан (Куюк; Хүннүгийн хаан, Моодуны хүү, түүнийг залгамжлагч)
Ласло, Дьюла
Лэх гол

Лайта гол

I Лео (Их Лео ч хэмээнэ. Ромын гэгээн хутагт, Христийн тооллын 452 онд Аттила хаантай эвийн хэлэлцээ хийсэн)

Л'Эпинь

Летадин, Х.

Ле Түрне (политехникч)

Лигниц

Лигүр нутаг (Умард Италийн нутаг)

Литориус (Аетиусын үеийн Ромын цэргийн жанжин, Хүннүгийн морин цэргийг удирдаж явсан)

Луар мөрөн

Любек

XV Лүдвиг, Францын хаан

Лүпүс (Гэгээн Лүп, Трое хотын хамба лам)

Лион

Маастрихт

Маенхен-Хэлфэн, Отто И.

Магдебүрг

Маги (Хуучны Венецийн гэр бүл)

Магнитогорск

Мажаарууд (Унгарууд, Дунай мөрний нам дор газар суух ард түмэн)

Милан (Медиоланун), Миланы зарлин

Майнц (Могунтиакум)

Македон (Зүүн Өмнөд Европын нутаг)

Малалас (Сири гарлын лам, Аттилагийн үхлийн тухай өгүүлсэн)

Мама, Хүннүгийн ноён

Маннхайм

Мантуя, Мантова

Маеогийн газар (Азовын тэнгисийн Маиогийн намаг газар)

Марбод (Маркоманны хаан)

Марчеллинуc Комес (I Юстиниан хааны канцлер, Иллирийн зохиолч)

Марко Поло

Маргус (Иллирийн нутагт Дунай мөрний дээр орших хот, өнөөгийн Позаревац. Христийн тооллын 435 онд Дорнод Ром, Хүннүгийн хооронд хэлэлцээ хийж эвийн гэрээ байгуулж байв)

Мари Антуанетта, Францын хатан хаан

Тирусын Маринус

Мариус, Гайус (Христийн өмнөх 156-86 онд амьдарч байсан Ромын жанжин)

Маркианос, Флавиус Юлиус Валериус (Дорнод Ромын генерал, Пулхериатай гэрлэснээр христийн тооллын 450-457 онд хаанчилж байв)

Маркоманнууд, Германы сюбуудтай төрөл ард түмэн

Мармарын (Мраморын) тэнгис

Марн, Шалон-сүр-Марн

Маруш (Тисса голын цутгалан)

Марс (Арес), Дайны бурхан

Марсель

Марс-ла-Түүр

Мастиличи (Хуучны Венецийн гэр бүл)

Маркс, Карл

Маврууд (бэрбэрийн овог аймаг)

Маурер, К.Ф.

Мауриакус, цэргийн хүрээ (Каталауны тулалдааны үед Мауриакус тосгоны дэргэд

Аттилагийн бэхэлсэн шивээ, өнөө Шампааны Ла Шепп)

Мауритиус (Тебагийн христ мөргөлт цэргийн ангийн захирагч)

Мауритиус (Гайзмын хөвгүүн Мундогийн хүү, Аттилагийн ач хүү)

Максиминиан Херкулес (Ромын эзэн хаан)

Максиминос (Византийн элч)

Маззарино, Санто

Макговщрн, Уильям Монтгомери

Мемориус, диакон

Меровех (Салийн франкуудын ноён)

Меровингчууд (Бага хаадын удмын ноёд)

Месопотам нутаг

Метамауко

Мэц

Мексик

Мики, Александр

Мигне, Ж.П.

Миникио (жижиг гол)

Митрас, Гэрлийн бурхан

Газар дундын тэнгис

Мочениги (Хуучны Венецийн гэр бүл)

Молменти (Он дарааллын түүх туурвигч)
Моммзен, Теодор
Монгол улс
Монт Арме (өнөөгийн Монт Эйм), цайз
Монт де Питие (ле Пьемон)
Монмаут, херцог
Монт Кассино
II Монтезума (Ацтекуудын хаан)
Монмартр, уул (Парис)
Моравчик, Дьюла
Мозель гол, Мозелийн хөндий
Москва
Моодун, шаньюй (Түмэн шаньюйгийн ахмад хөвгүүн, Хүннүгийн хаан, сурвалж бичигт Бордур, Маодун, Маудун ч гэх нэрээр тэмдэглэгджээ)
Мулан а Вон
Мурмелон-ле-Гран
Мундо (Латинаар Мундус, Гайзмын хөвгүүн, Аттилагийн ач хүү)
Мүндзүх (Хүннүгийн ноён, Аттилагийн эцэг, Ругилагийн ах/дүү)
Муссолини, Бенито
Нодьсентмиклуш (Унгар), Хүннүгийн алт эрдэнэс олдсон газар
Найссос (Сербийн Ниш хот)
Нантивет (Цайз)
I Наполеон
III Наполеон
Нарбонн
Нато
Неаполь
Недад, Недао (Байршлыг нь тогтоох боломжгүй байгаа гол, Иорданес түүхчийн бичсэнээр энэ гол дээр их тулалдаан болж хүннүчүүдийг бутцохисон хэмээнэ)
Немурс
Неро, Нерон (Христийн тооллын 54-58 онд Ромын эзэн хаан байв)
Нисэйс, Реймс хотын хамба
Нидерланд улс
Доод Австри
Никополь
Нисибис

Ноблет (Каталауны тулалдааны талбарын ойрх жижиг гол)
Умард Африк
Норманнууд (Эртний Скандинав, Данийн оршин суугчид)
Новае (Систоро)
Одер мөрөн
Одоакер (Хүннүгийн ноён Эдеконы хүү, хөлсний герман цэрэг толгойлж явсан, христийн тооллын 476 онд Өрнөд Ромын сүүлчийн эзэн хааныг унагаж Италийг захирч байгаад христийн тооллын 493 онд Их Теодерихт алагдсан)
Одиссей
Оебарсиус (Хүннүгийн ноён, Ругила, Октар нарын эцэг нэгтэй ах/дүү)
Хуучин Буда (Будапешт хотын дүүрэг, Ромын Акуинкум хэмээх суурин байсан)
Октар (Уптарос, Ругилагийн ах/дүү, хамтран төр барьж байсан)
Олимпиодор (Гэрэгийн түүх туурвигч, бүргүндчүүдийн тухай тэмдэглэн үлдээсэн)
Онегесиус (Аттилагийн шадар зөвлөх)
Орхон гол
Оренбург
Орестес (Панноны уугуул, Эдеконы бараа бологч)
Орлеан (Аурелиана, Луар мөрөн дээр орших, Вестгоотын хамгийн хойд талын хот байв)
Орте (Аттилагийн хөвгүүн хэмээн домог өгүүлнэ)
Ортлийб (Аттилагийн хөвгүүн хэмээн домог өгүүлнэ)
Осма (Дунай мөрний цутгалан)
Осмонууд (Түрүү үеийн Османы эзэнт гүрний түрэгүүд)
Австри улс
Остгоотууд (Герман ард түмэн, уг нь острогоот нэртэй явсан)
Дорнод Ром (Византийн эзэнт гүрэн)
Балтийн тэнгис
Отахер (Домогт гардаг Одоакерын нэр)
Падуй, Падова
Палестин
Паннон нутаг (Дунай мөрөн, Саве голын завсрын тал газар, христийн тооллын 9 оноос 400 он хүртэл Ромын нэг муж байгаад Хүннүгийн нутаг болсон)
Парис
Парма

Парфууд (Умард Ираны нүүдэлч ард түмнүүдийн бүлэг хамаарах овог христийн тоолын өмнөх 250 онд Парфийн селойкидийн мужийг эзлэн сууж байв)

Паула (Ромын нэгэн бэлэвсэн эхнэр)

Паулинус (Яруу найрагч санваартан)

Паулус Диаконус (Лангобардын түүхийг туурвигч)

Паули-Виссова (судлаач, зохиогчид)

Павиа (Тицинум)

Пелагиа (Бонифациусын эхнэр)

Пелзод нуур (Нойзидлер нуур)

Перс

Их Петр

Петербург

Петра (хот)

Петрус (архад, Антиохи хотын анхны хамба)

Потиос, тэргүүн хамба

Пинцинг

Питэшт

Плинтас (Тракийн гэрэг хүн, Дорнод Ромоос Аттилад илгээсэн элч)

По гол, Погийн тал нутаг

Пөхларн (Дунай мөрний хөндийд орших хот, Нибэлүнгийн дуулалд Бехеларэн гэдэг нэрээр гарна)

Пөртнэр, Рудольф

Пуатье, тулалдаан болсон газар

Позен (Познань)

Поссидиус (Аугустинусын намтрыг туурвигч, вандалууд Умард Африкт цөмрөн орсон тухай өгүүлсэн)

Потентиана, Ромын муж

Пулайн, Х.

Пробус, Маркус Аурелиус (Христийн тооллын 276-282 онд Ромын эзэн хаан байв)

Прискүс Ретор (Византийн элчингээр Аттилагийн дэргэд сууж байсан, хүннүчүүдийн талаар олон чухал түүх тэмдэглэн үлдээсэн хүн)

Проспер Тиро (Ромын гэгээн хутагтын он дараалын түүх туурвигч)

Птолемаеус (Птолемаус), Клаудиус (Гэрэгийн газар зүйч)

Пулхериа (Теодосиусын дүү бүсгүй)

Питеас (Газар зүйч, одон орон судлаач, далайчин)

Куадууд (Өрнөд герман овог аймаг)

Радагаисус (Германы нэгэн овог аймгийн удирдагч, Стилиход ялагдсан)

II Рамзес, Египетийн хаан

Раптус (Христийн тооллын 170 оны үед вандалуудын хаан байв)

Раус (Христийн тооллын 170 оны үед вандалуудын хаан байв)

Равенна (Христийн тооллын 403 оноос Өрнөд Ромын эзэн хаад өргөөлөн сууж байсан хот, христийн тооллын 476 оноос Одоакер, 493-552 онд остгоотын хаад тус тус энд сууж байв)

Реггио Эмилия

Реймс

Райн мөрөн

Райны франкууд

Райнхэссэн

Рон мөрөн

Рифийн нуруу

Ром хот (Христийн тооллын 395 он хүртэл Ромын эзэнт гүрний төв, дараа нь 403 он хүртэл Өрнөд Ромын эзэнт гүрний хаадын өргөө хот, 410 онд Аларихийн удирдсан вестгоотууд эзлэн авч сүйтгэсэн)

Ромын дэлхийн эзэнт гүрэн (Энэ номын үйл явдал өрнөж эхлэх үед нэгдмэл хүчирхэг гүрэн байгаад христийн тооллын 270 оны үеэс хүч чадал нь доройтож Дорно, Өрнө хоёр гүрэнд хуваагдсан)

Ромулус Аугустулус (Орестесын хөвгүүн, Өрнөд Ромын сүүлчийн эзэн хаан байгаад Одоакерт ялагдан хаан ширээгээ түүнд алдсан)

Розомонууд (Остгоотуудын байлдан дагуулсан ард түмэн)

II Рудольф (1576-1612 онд Германы эзэн хаан байв)

Рүфүс (Зеноны анд)

Рүгичүүд (Дорнод герман овог аймаг, хүннүчүүдийн захиргаанд орсон)

Ругила (Хүннүгийн хаан, ах Октартай хамтран төр барьж байсан, христийн тооллын 434 онд нас барсан)

Сэн Жульен

Сэн Менеүүлд

Салона

Сангибанус (Аланы ноён)

Шанкритияна Рахула

Сан Марино

Сансовино, Франческо

Сантонино, Паоло (Гэгээн хутагтын элч)

Саонь

Сападиа (Савоен, Женевийн нуурын зүүн, зүүн өмнө этгдээдийн нутаг)

Сарацинууд (Арабын нутаг, Синайн хойгийн баруун хойгуур нутаглаж байсан овог аймгууд)

Сарданапал (Ассирийн хаан)

Сарматууд (Өмнөд Оросын тал нутагт нүүдэллэн амьдарч байсан нүүдэлчин иран ард түмэн)

Сарус (Сунилдагийн ах)

Сатурниос (Византийн язгууртан)

Саве гол

Савиа (Өрнөд Ромын хамгийн зүүн хойд талын муж, Саве гол, Дунай мөрний завсрын нутаг)

Шаффран, Эмерих

Шилл, Фердинанд фон (Пруссийн офицер)

Силез

Шнайдер, Херманн

Шүн-юй, хунтайж (мөн Шүн-нүй ч хэмээх, Хиагийн угсааны хааны сүүлчийн хааны хөвгүүн)

Хар тэнгис

Шварцвальд

Сена мөрөн

Селойкидууд

I Селойкос Никатор (Сирид селойкидуудын удам дамжсан хаадын овгийг үндэслэгч)

Семипалатинск

Семнонууд (Өрнөд герман овог аймаг)

Сонс (Агединкум)

Сердика (Софи хот)

Сэкстус Помпейус

Сезаннь

Сибирь

Сидониус Аполлинарис (жинхэнэ нэр нь Соллиус Аполлинарис Модестус Сидониус агаад яруу найрагч, эрдэмтэн. Ромд өндөр алба хашиж байгаад Клермон-Ферраны хамба болсон)

Трансилваань (Румыны түүхт нутаг)

Долоон мөрний газар (Зөвлөлтийн Баруун Туркестаны нутаг)
Зийгфрийд (Нибэлүнгийн дууллын баатар)
Силистриа
Сингидунум (Белград хот)
Сирмиум (Митровица хот)
Сициль
Скамарууд (Эх оронгүй овгуудаас бүрдсэн аймаг)
Скандинав, арал
Скирүүд (Хүннүчүүдийн захиргаанд орсон дорнод герман овог аймаг)
Скотта (Аттилагийн ордонд сууж байсан хүннү хүн)
Скифүүдийн орон (Өмнөд Орос)
Скифүүд (Өмнөд Оросын тал нутгийн оршин суугчдын уугуул нэр, энд аланууд, хүннүчүүд, остгоотуудыг хэлж буй)
Словак улс
Суассон
Сократес Схоластикос (Сүм хийдийн зохиолч)
Сороскууд (Аттилад ялагдсан овог аймаг)
Зөвлөлт Холбоот улс
Испани, испаничууд
Шпайер
Стефани (Венецийн он дарааллын түүх туурвигч)
Стилихо, Флавиус (Вандал хүний хүү, христийн тооллын 365 онд төрсөн, Аларихийн вестгоотуудыг бутцохиж эзэнт гүрний өмнө их гавьяа байгуулж байсан цэргийн жанжин, 408 онд эзэн хаан Хонориуст алагдсан)
Страсбург
Стридон
Стюарт (Шотландын хаадын овог)
Штүүлвайссенбург
Сюбууд (герман ард түмний бүлэг)
Сүипп
Сулла, Луциус Корнелиус (Христийн тооллын өмнөх 138-78 онд Ромын цэргийн жанжин байв)
Суматра
Сунилда (Сванхильд, Шванхильд ч хэмээнэ. Розомон аймгийн бүсгүй, Эрманрих хааны амраг явжээ)
Сучау

Свитошт

Симеон (Булгаарын хаан)

Сири

Сэгэд Нодьседшош (Тисса голын доод биенд орших, Хүннүгийн булш олдсон газар)

Сэнтэш-Киштөк

Тамерлан (Төмөр, 1336-1405 он Ази дахиныг байлдан дагуулж байв)

Таримын сав газар

Тарнок

Татулус (Эдеконы эцэг)

Таурын нуруу

Тея (Остгоотын сүүлчийн хаан, христийн тооллын 552 онд Нарсестай хийсэн тулалдаанд амь үрэгдсэн)

Тэрэнц (Ромын инээдмийн зохиолч)

Тертуллиан (Эртний латин сүм хийдийн зохиолч)

Теба

Тисса гол

Теодемир (Остгоотын ноён, Их Теодерихийн эцэг)

Их Теодерих (Христийн тооллын 471-526 онд Остгоотын хаан байсан, 493 оноос Италийг захирч байв)

I Теодерих (Христийн тооллын 419-451 онд Вестгоотын хаан байв. Аетиусын холбоотон болж Каталауны тал нутагт хүннүчүүдтэй тулалдаж амиа алдсан)

I Теодосиус (Христийн тооллын 379-395 онд Ромын эзэн хаан байв)

II Теодосиус (Христийн тооллын 408-450 онд Дорнод Ромын эзэн хаан байв)

Тессаль (Эртний Гэрэгийн баруун хойд нутаг)

Томпсон Е.А.

Торизмунд (Вестгоотын жонон, Теодерихийн хөвгүүн)

Тракий орон (Балканы хойгийн зүүн хагас, Дунай мөрний өмнө этгээдийн нутаг)

Тразерих (Ардарихийг залгамжлагч, Гэпидийн хаан)

Тюрингчүүд (Герман овог аймаг, хермундурчуудын удам угсаа)

Тибр мөрөн

Тигас

Тилли (Гучин жмилийн дайнд оролцсон цэргийн жанжин)

Тифизас

Тироль

Тонгерн

Түүль
Түлүз
Түүрс
Трийр (Аугуста Треверорум; Христийн тооллын 284-400 онд Ромын эзэнт гүрний баруун хэсгийн нийслэл байв)
Троя
Троие
Тригетиус, Ромын албан тушаалтан
Цао-Цо (Хан гүрний эзэн хааны зөвлө)
Чан-Киен (У Ти-гийн үеийн хятдын эрдэмтэн)
Черкессүүд (Кавказын бүлэг ард түмэн)
Цэн-Пин (Хатан хаан Као-Люгийн үед эзэнт гүрний хэргийг эрхэлж байв)
Цин (Хятадын удам дамжсан гүрэн)
Цун-Хан-Жюе, тайган
Түрэгүүд
Түмэн шаньюй (Хүннү гүрний түүхэнд тэмдэглэгдсэн анхны шаньюй, христийн тооллын өмнөх 250 оны орчим мэндэлсэн)
Түнгүсүүд (Амар, Лена мөрнөөс Енисей мөрөн хүртэл тархан суух ард түмэн, овог аймгууд)
Тун-ху (Моодун шаньюйгийн үеийн нүүдэлчин ард түмэн)
Тунис
Түрцилингүүд
Туркестан
Түрэг ард түмнүүд
Тирүс
Өгөөдэй, их хаан
Улаанбаатар
Үлдин (Хүннүгийн хаан, Ругила, Октар нарын эцэг)
Унгар улс
Урал
Өргөө
Үтүс (Вит; Дунай мөрний цутгалан, их тулалдаан болсон газар)
Үзэндүр (Аттилагийн хүү)
Вадамерка (Гоотын гүнж, Хүннүгийн Баламбер хаантай суусан)
I Валентиниан (Христийн тооллын 364-375 онд Ромын эзэн хаан байв)

III Валентиниан (Плачидус Валентинианус; Галла Плачидиагийн хөвгүүн, христийн тооллын 425-455 онд Өрнөд Ромын эзэн хаан байв)

Вандалариус (Видэрикус; Остгоотын ноён)

Вандалууд (Дорнод герман ард түмэн)

Венец

Венец нутаг (Италийн зүүн хойд этгээдийн түүхт нутаг)

Вэнти (Хятадын эзэн хаан)

Вэрдүн

Верцингеторикс (Галлийн ноён)

Вэргил (Ромын яруу найрагч)

Версаль

Весль

Виченца

Вигилас (Византийн хэлмэрч)

Вилларени (Хуучны Византийн гэр бүл)

Виминациум (Өнөө Костолац)

Винитариус (Витимириус; Остгоотын хаан, Эрманрихийг залгамжлагч)

Витэнсис, Виктор

Вогесен

Фолькер (Нибэлүнгийн дууллын нэг баатар)

Ойрын Ази

Вулкан дархан (Вулканус; Эртний Италийн галын бурхан)

Вахау (Австрийн Крэмс, Мэлк хотуудын завсрын Дунай мөрний хөндий тал нутаг)

Валамер (Фаламир, Валамир; Остгоотын хаан, Аттилагийн анд, зөвлөх)

Валленштайн (Гучин жилийн дайнд оролцсон цэргийн жанжин)

Вальтер, Хильдегүнд хоёр (Баатарлаг тууль)

Ван-Цао-Киюн (Хятадын гүнж)

Варягууд (Дорнод Европын норманнууд)

Висла мөрөн

Вэрнэр, Иоахим

Вестгоотууд (Визиготууд; Готуудын овог)

Өрнөд Ром (I Теодосиус хааныг нас барсны дараа хоёр хуваагдсан Ромын гүрний баруун хагас, Одоакер христийн тооллын 476 онд эзэн хаан Ромулус Аугустусыг хаан ширээнээс буулгаж орыг нь эзэлснээр мөхсөн)

Видимир (Остгоотын ноён)

Вийланд дархан (Германы хамгийн эртний гэгддэг баатарлаг туулийн нэг баатар)

Вена хот

Вилхэльм

Вилхэльм Байлдан дагуулагч

Вишнү (ЭНэтхэгийн бурхан)

Вольфф, Ф.

Волфрам фон Эшэнбах

Волга мөрөн

Вормс

Вотан (Өмнөд германы салхины бурхан, умард германы Один болой)

Ү-Ти (Хятадын эзэн хаан)

Юе-чи (Моодуны хөөн зайлуулсан нэгэн ард түмний хятад нэр)

Төв Ази

Зенон (Дорнод Ромын цэргийн жанжин)

Зерко (Аттилагийн ордны алиа салбадай)

Зеркон, мавр хүн

Зевс (Гэрэгийн бурхдын эцэг)

Зосимос (Гэрэгийн түүхч)